

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

ПОЛИТОЛОГИ

№ (13)442



МУИС ПРЕСС ХЭВЛЭЛИЙН ГАЗАР

POLITOLOGY
SCIENTIFIC JOURNAL

№ 13 (442)

XIII

ISSN 2227-6904

Key title: Politology

EDITORIAL BOARD

Editor in chief:	Munkhbat.S
Associate Editor:	Turtogtokh.J
Secretary:	Batbold.Ts
Board members:	Ganbold.Ts
	Dovchin.Yo
	Bazarpurev.S
	Tsend-Ayush.G
	Ulziisaikhan.Ch
	Undrakh.D
Technical Editor	Ulziijargal.Ts

ПОЛИТОЛОГИ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№13 (442)

XIII

ISSN 2227-6904

Key title: Политологи

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ:

Эрхлэгч:	С.Мөнхбат
Орлогч эрхлэгч:	Ж.Төртогтох
Нарийн бичгийн дарга:	Ц.Батболд
Гишүүд:	Ц.Ганболд Ё.Довчин С.Базарпүрэв Г.Цэнд-Аюуш Ч.Өлзийсайхан Д.Ундрах
Техник редактор:	Ц.Өлзийжаргал

АГУУЛГА

Өмнөх үг	9
----------------	---

УЛС ТӨРИЙН ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ц.Ганболд, Э.Бат-Эрдэнэ

Улс төрийн сургаалийн түүхийн судалгаанд верификаци, фальсификацийн арга зүйг хэрэглэх асуудал	11
------------------------------------------------------------------------------------------------------	----

Д.Ундрах

Монгол дахь улс төрийн ёс зүйн төлөв байдал	15
---------------------------------------------------	----

И.Лхам, М.Мөнхзул

Монгол үндэстний хөгжил дэвшилд үндэсний ухамсрын үүрэг, ач холбогдол	19
-----------------------------------------------------------------------------	----

С.Базарпүрэв

Улс төрд иргэд оролцох, үл оролцох учир	25
-----------------------------------------------	----

С.Зүльфикар

Улс төрийг хэрхэн ойлгож, тайлбарлах вэ?.....	31
-----------------------------------------------	----

Д.Бумдарь, О.Пүрэвдорж

Улс төрийн үзэл суртал ноёрхлоос үүдэлтэй болох нь	37
----------------------------------------------------------	----

Ц.Батболд, Н.Ариунаа

Улс төрийн менежмент мэргэшил болох нь	43
----------------------------------------------	----

И.Лхам, Г.Уянга

Ардчиллын талаарх Ж.Дьюигийн үзэл санаа	47
-----------------------------------------------	----

УЛС ТӨРИЙН ИНСТИТУТ

Ч.Өлзийсайхан, Х.Золжаргал

Ерөнхийлөгчийн засаглалтай пост-коммунист улсуудын тогтолцоонд ажиглагдаж буй ерөнхий шинжүүд	53
-----------------------------------------------------------------------------------------------------	----

Г.Цэнд-Аюуш

Улс төрийн намын талаарх М.Дювержийн үзэл баримтлалыг эргэцүүлэхүй.....	61
-------------------------------------------------------------------------	----

Д.Болд-Эрдэнэ, М.Должин

Улс төрийн систем, намын харилцан хамаарал: онол-арга зүй.....	65
----------------------------------------------------------------	----

Ц.Батболд

Хөгжиж буй орнууд дахь бюрократ удирдлагын өнөөгийн төлөв, цаашдын хандлага	71
-----------------------------------------------------------------------------------	----

Ж.Төргөгтох, Ч.Хандулам

БНСУ-ын 2012 оны 18 дахь удаагийн ерөнхийлөгчийн сонгуулийн улс төр,
үр дүн 83

Ц.Батболд, Х.Гантулга

Хөгжиж буй орнуудын төрийн захиргааны шинэтгэл дэх практик зарчмууд..... 91

С.Зүльфикар

Орчин үеийн улс төрийн намуудын хөгжлийн хандлага..... 95

Э.Бат-Эрдэнэ

Монгол улсын парламентат ёсны төлөвшил, бэхжилтэнд тулгарч буй
түгээмэл асуудал, вестминистерийн загварын нөлөө..... 101

АРДЧИЛЛЫН ОНОЛ, ПРАКТИК**Ц.Батболд, Д.Отгончимэг**

Иргэдийн улс төрийн мэдлэг, боловсролын нийгэмд гүйцэтгэх үүрэг,
ач холбогдол..... 105

С.Базарпүрэв, Б.Нандин-Эрдэнэ

Гадаадын хөрөнгө оруулалтын талаар төрөөс баримтлах улс төрийн бодлого
боловсруулах нөхцөл байдал..... 115

Ц.Ганболд

Сонгууль ба кондорсегийн парадокс, эрроугийн теорем..... 121

Д.Оюунчимэг

Сонгуулийн сурталчилгааны арга зүй..... 125

Ч.Өлзийсайхан, Ц.Өлзийжаргал

Байгалийн баялаг ба улс төр..... 131

Г.Цэнд-Аюуш, Д.Сүхболд

Бүгд найрамдахчуудгүй бүгд найрамдах улс..... 137

Ё.Довчин, Г.Хосцэцэг

Нутгийн өөрөө удирдах ёс түүний хэрэгжилт..... 141

Б.Отгонбаяр

Улс төрийн соёлын ангилал зүйн асуудалд..... 145

ХАРЬЦУУЛСАН УЛС ТӨР, ЭМПИРИК СУДАЛГАА

С.Мөнхбат, Д.Галсандондог

Улс төрийн тогтолцооны тулгамдсан асуудлууд: сонгогчдын санаа бодол..... 149

С.Базарпүрэв, Д.Гоомарал

Ядуурлыг бууруулах төрийн бодлогод тулгамдаж буй асуудал..... 157

Ч.Өлзийсайхан, Мөнхгэрэл

Эрдэс баялгийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсронгуй болгох
чиглэлээр хийгдэж байгаа судалгааны болон
практик ажлуудын өнөөгийн байдал 163

Ж.Жаргал

XX зууны Монгол дахь улс төрийн дэглэмийн асуудлаарх
монголын эрдэмтдийн судалгаа 171

Ц.Ганболд, Л.Идэр

Цагаан түүхийн талаарх үзэл баримтлалыг судлах онол, арга зүй 179

Д.Бумдарь, Э.Базаррагчаа

Төрийн улс төрийн албан тушаалын томилгооны харьцуулсан судалгаа 185

С.Мөнхбат, Д.Бумдарь, Г.Мэндхүү

Монгол дахь ардчилал: иргэний улс төрийн оролцоо ба
хэвлэл мэдээллийн хэрэгсэл 191

У.Батцэрэн

“Төрийн албан хаагч”-ийн имиж бүрдүүлэлтийн үйл явцад
хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөө 197

CONTENTS

Foreword.....	9
---------------	---

POLITICAL THEORY, CONCEPTS

Ganbol.Ts, Bat-Erdene.E Issues of verification and falsification research methodologies in a survey of political thoughts' history	11
Undrakh.D The state of political ethics in Mongolia	15
Lkham.I, Munkhzul.M Role of national consciousness for the development of Mongol nationality	19
Bazarpurev.S Reasons of civic participation /involvement/interference-non-interference /contribution/.....	25
Zulifikari.S How to understand and explain politics?	31
Bumdari.D, Purevdorj.O As political ideology has roots of dictatorship	37
Batbold.Ts, Ariunaa.N Political management as a profession	43
Lkham. I, Uyanga.G J.Dewey concepts on democracy	47

POLITICAL INSTITUTION

Ulziisaikhan.Ch, Zoljargal.Kh Common features shown in post-communist states with presidential syste.....	53
Tsend-Ayush.G Cogitating/considering Maurice Duverger concepts on political party	61
Bold-Erdene.D, Doljin. M Interdependence of political system and party: theory-methodology	65
Batbold.Ts Current state and future tendency of bureaucratic governance in developing countries.....	71
Turtogtokh.J, Khanddulam.Ch Politics and its outcome of 18 th Presidential election of South Korea in 2012	83
Batbold.Ts, Gantulga.Kh Practical principles in public administration reform of developing countries.....	91
Zulifikari.S Development tendency of contemporary political parties	95
Bat-Erdene.E Common problems faced with Parliamentarianism in Mongolia, influence of West- Minster model.....	101

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг “Политологи” эрдэм шинжилгээний сэтгүүлийн ээлжит дугаар эрхэм уншигч та бүхний гар дээр очиж байна. Сэтгүүлийн маань энэхүү дугаар нь өмнө гарсан цувралуудын ололт, амжилт, туршлага дээр суурилсан болно.

Дэлхий дахины улс орнуудын харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр улс төрийн мөн чанар, агуулга улам бүр гүнзгийрч түүний үүрэг роль өсөн нэмэгдсээр байгаа билээ.

Ийм учраас улс төрийн мөн чанарыг ойлгон таниулах, энэ талаарх зөв үнэлэлт дүгнэлтийг өгөх улс төрийн мэдлэгийг бий болгодог улс төрийн шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг их юм. Эдүгээ улс төрийн шинжлэх ухааны онол-арга зүй, судалгааны арга хэрэгсэл, улам нарийсан хөгжиж онолын болон эмпирик судалгаа шинжилгээний мэдлэгүүд даяаршиж байна.

Улс төрийн мэдлэгийн даяарших үйл явц нь дэлхий дахин, бүс нутаг, улс орнуудад ардчилсан хөгжлийн ололт амжилтыг баталгаажуулах, түүнийг хөгжлийн шинэ шатанд гаргахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид ч гүйцэтгэсээр байх болно.

Монголд шинээр үүсэн төлөвшиж буй улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд энэ салбарын эрдэмтэн судлаачид ихээхэн хүчин чармайлт гаргаж байдгийн тодорхой нэг илрэл нь энэхүү сэтгүүл юм. Сэтгүүлийн эл дугаарт улс төрийн түүх онол, үзэл баримтлал, улс төрийн институт, байгууллага судлал, ардчиллын хөгжил, төрийн гадаад бодлого, олон улсын харилцаа, геополитик, гадаад орнуудын улс төрийн системийн харьцуулсан судалгаа зэрэг улс төрийн шинжлэх ухааны олон чухал сэдвүүдээр эрдэмтэн судлаачдын бичсэн өгүүллүүдийг нийтэллээ.

Манай сэтгүүл дугаар тус бүрдээ улс төр судлалын салбарт сурч буй магистрант, докторант, удирдагч багш нарын эрдэм шинжилгээний хамтарсан бүтээл, өгүүллэгүүдийг байнга нийтэлдэг. Мөн манай сэтгүүлд гадаад, дотоодын судлаачдын өгүүллийг байнга хэвлүүлдэг. Ийнхүү бид сэтгүүлийнхээ чанрыг сайжруулж олон улсын түвшинд хүргэх зорилт тавин ажиллаж байна.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

УЛС ТӨРИЙН ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**УЛС ТӨРИЙН СУРГААЛИЙН ТҮҮХИЙН СУДАЛГААНД ВЕРИФИКАЦИ,
ФАЛЬСИФИКАЦИЙН АРГА ЗҮЙГ ХЭРЭГЛЭХ АСУУДАЛ****Ц.ГАНБОЛД***Профессор, МУИС, ШУС, Ниймгийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхим***Э.БАТ-ЭРДЭНЭ***Улс төр судлалын тэнхимийн докторант*

Түлхүүр үг: Верификаци, фальсификаци, шинжлэх ухаан, арга зүй, арга, онол, Улс төрийн шинжлэх ухаан, Улс төрийн сургаалийн түүх, судалгаа, няцаагдах зарчим, шүүмжлэлт рационализм, онолын ил тод байдал, судалгааны үр дүн, хөгжил, төлөвшил

Товч агуулга: Тус өгүүлэлд нийгмийн шинжлэх ухааны судалгааны томоохон бие даасан чиглэл болтлоо хөгжсөн верификаци болон фальсификацийн арга зүйн зарчмын тухай, энэхүү арга зүйн зарчмыг Улс төрийн шинжлэх ухаан, Улс төрийн сургаалийн түүхийн судалгаанд хэрэглэх асуудал, түүний ач холбогдол, үр дүнгийн тухай авч үзсэн болно.

Abstract: This article reflects verification and falsification methodology that develops as a major independent direction of social science research methods, its research methodology application in the political science and political teachings history researches, importance and results of the research method.

Аливаа судалгааны ажил өөрийн гэсэн хүрэх үр дүн, зорьсон зорилготой байх, нөгөө талаар шинжлэх ухаанч чанар, шинжлэх ухааны шүүмж, маргаан өрнүүлэхүйц ил тод байх ёстой. Ил тод байдлыг хангах үндсийн нэг нь тухайн судалгааны ажлын гол мөн чанарыг илэрхийлж буй ойлголтуудыг мэргэжилийн түвшинд тайлбарлах, эрдэмтэн судлаачдын үзэл баримтлал, хандлага дээр өөрийн тайлбарыг нэмэн уралдуулах, зохиол, бүтээлээс нь иш татах, тухайн ойлголтуудын талаархи эрдэм шинжилгээний өгүүлэл, шинжлэх ухааны шүүмж, мэтгэлцээн ..., зэргээс иш татаж цогц байдлаар тусгах явдал юм. Энэхүү цогц байдлаар тусгах тухай асуудлыг шийдвэрлэхэд томоохон үүрэг гүйцэтгэх арга зүй, хандлага бол верификаци, фальсификацийн зарчмыг Улс төрийн шинжлэх ухаан болон Улс төрийн сургаалийн түүхийн судалгаанд хэрэглэх тухай асуудал юм. Өгүүллийн эхний хэсэгт верификаци болон фальсификацийн тухай ерөнхий ойлголтууд, хоёрдугаар хэсэгт энэхүү арга зүйн зарчмыг ерөнхий болон салбар шинжлэх ухаанд хэрэглэж ирсэн туршлага, гурав дахь хэсэгт Улс төрийн шинжлэх ухаан болон Улс төрийн сургаалийн түүхийн судалгаанд хэрхэн хэрэглэсэн тухай болон ач холбогдол, үр дүнгийн тухай бичсэн болно.

Верификаци, фальсификацийн арга зүйг ерөнхий шинжлэх ухаан, салбар шинжлэх ухааны арга, арга зүйд хэрэглэх талаарх томоохон бүтээлүүдийн дотор Английн судлаач Карл Раймунд Попперын бүтээлүүд томоохон байр суурийг эзэлдэг. Тэрээр энэ чиглэлийн үзэл баримтлал, сургаалиа “Нээлттэй нийгэм, түүний дайснууд” /I, II боть/, “Түүхчлэх үзлийн гуйланчлал”, “Диалектик гэж юу вэ?”, ..., зэрэг бүтээлдээ тусгасан байна. Түүний энэхүү онол, үзэл баримтлалыг нарийвчлан судалж, Унгарын философич Ч.Пирс шинжлэх ухааны эргэлтэнд оруулж, бие даасан томоохон арга зүйн хандлага болгон өргөжүүлсэн байна. Мөн К.Р.Попперын шавь И.Лакатос эдгээр ойлголтыг улам нарийвчлан судалж, энэ чиглэлийн бие даасан өгүүлэл, бүтээлүүдийг дагнан судалж бичсэн байна.

Верификаци хэмээх ойлголт нь үгийн утгийн хувьд *verificare* буюу “**үнэнийг нотлох**” гэсэн үгнээс үүдэлтэй юм. Энэхүү ойлголтыг цааш задлан нарийвчлан үзвэл шалгагдах зарчим бол аливаа шинжлэх ухааны тулгуур зарчмын нэг бөгөөд аливаа нотолгооны үнэн мөнийг тогтоохдоо уг нотолгоог өөр төрлийн баримттай жишиж тогтооно хэмээн үзсэн¹. Венийн дугуйланд² томъёолсоноор верификацийн зарчмын үндэс нь туршлагаас танин мэдэх тухай асуудал юм. Ингэхдээ туршлагын ололтыг бүртгэн өгүүлэх нотолгооны шууд шалгагдах чанар, мөн шууд шалгагдах нотолгоонд ямар нэг үндэслэлийг тохируулах шууд бус шалгагдах чанар гэж хоёр ангилснаар илүү үр дүнтэй, хялбар болно хэмээн үзсэн байна. Верификацийн тухай ойлголтыг аливаа шинжлэх ухааны агуулга бүхий ойлголтыг утга санаа, мөн чанар ойрхон өөр төрлийн ойлголттой харьцуулан жиших /эталон/, А ойлголтын мөн чанар, голлох ойлголтуудыг Б ойлголтын мөн чанартай харьцуулан тавьж, гарсан ялгаанд дүгнэлт хийх замаар тухайн ойлголтыг танин мэдэх, ялгааг олж харах, шинэ мэдлэг бүтээх үйл явц хэмээн тайлбарлаж болох юм. Дээрхи байдлаар олж авсан мэдлэг нь нэг

¹ Орос хэлнээс орчуулсан Г.Лувсанцэрэн, Са.Пүрэв, Д.Содномгомбо ..., зэрэг, “Философийн толь” 524-р тал., УБ 1990 он

² Венийн их сургуулийн индуктив шинжлэх ухааны тэнхимийн дэргэд 1922 онд байгуулагдсан бөгөөд логик позитивизмын үзэл санаа, верификацийн зарчмыг судлах үндсэн зорилготой үйл ажиллагаа явуулсан

талаас тухайн судлаачид аливаа асуудлыг олон талаас харах, бүтээлч хандлага төлөвших, өөрийн арга зүйг олоход тустай юм.

Фальсификацийн тухай ойлголт, мөн чанарыг Английн сэтгэгч К.Р.Поппер өөрийн философи, нийгэм судлалын үзэл баримтлалдаа шүүмжлэлт рационализм хэмээх логик позитивизмын эсрэг зохиосон боловч тухайн хандлагаасаа салж чадаагүй юм. Тэрээр “шалгагдах зарчим” буюу верификацийн оронд “үгүйсгэх зарчим” хэмээх ойлголтыг дэвшүүлж, эмпирик болон нэг үзэл, номлолоос татгалзсан юм. Түүний оронд шинжлэх ухааны ямар ч мэдлэг алдаатай байж болохоос гадна таамналын шинжтэй байна гэсэн баталгааг дэвшүүлсэн байна. Энэ зарчмыг хэрэгжүүлж, мөрдөж чадвал тухайн шинжлэх ухаанд их үнэ цэнэтэй, ач холбогдолтой гэж үзсэн нь түүний фальсификацийн арга зүйн зарчмыг боловсруулсан гол үндэслэл юм³.

Шүүмжлэлт рационализм буюу фальсификацийн арга зүйн зарчим 1920-иод оны эхээс хүч түрэн орж ирсэн бөгөөд Европ, Америкийн философийн голлох чиглэл болтлоо хүчийг авсан юм. Энэ чиглэлийг баримтлагч томоохон эрдэмтдийг дурдвал Карл Раймунд Поппер, У.Бартли, И.Лакатос, Дж.Агасси, Дж.Уоткинс, Г.Альберт, Х.Шпинер зэрэг эрдэмтэн, судлаачид байдаг. Шүүмжлэлт рационализмыг өөрөөр фальсификационизм хэмээн нэрлэдэг нь энэхүү ойлголтуудын мөн чанар, зарчим, арга зүй нь нэг гэсэн утгийг илтгэж байна. Шүүмжлэлт рационализм буюу фальсификаци нь онолын нотолгоог туршлагын үр дүнд олж авсан эмпирик ололттой харьцуулан түүнийг няцааж, үнэн мөнийг нь шалгах зарчим, арга зүй юм. Энэхүү судалгааны арга зүй, зарчимаа тэрээр шинжлэх ухааны нотолгооны чанарыг тодорхойлох арга бус, харин шинжлэх ухааныг шинжлэх ухаан бусаас тусгаарлах арга хэмээн ихэд үнэлэн тайлбалажээ. К.Р.Попперийн үзсэнээр гагцхүү гуйвуулж болох мэдлэг л шинжлэх ухааны мөн чанарыг өөртөө хадгалдаг ажээ.

Карл Поппер шинжлэх ухааны арга, арга зүйн судалгаанд верификаци, фальсификацийн арга зүйг хэрэглэх томоохон хувь нэмрийг оруулж, өөрийн үндэслэл, тодорхойлолтыг өгөхдөө “арга зүй” хэмээх ойлголт нь “арга” хэмээх ойлголтын үргэлжлэл, энэхүү хоёр ойлголт бие даан нэгээрээ оршин тогтнох боломжгүй хэмээн үзжээ. Харин арга хэмээх ойлголтыг тодорхойлохдоо “Арга гэдэг нь шинжлэх ухааны дүгнэлтүүдтэй тухайн судлаачийн ажиллах хэв маяг” гэж авч үзсэн байна. Энэ нь “арга” хэмээх ойлголтыг өмнөх үеийнхээ сэтгэгчдээс илүүтэйгээр плюралист утгатай болгосон юм. Гэхдээ дээрх тодорхойлолт нь “арга” хэмээх ойлголтыг ямар ч хяналтгүй, дур зоргын зүйл хэмээн тунхаглаагүй юм. Гэхдээ аливаа аргуудаас хамгийн түгээмэл төдийгүй судалгаа үр дүнд хүрэхэд баримжаалан чиглүүлдэг анхдагч арга бол “алдаж-онох” мөн болохыг К.Р.Поппер өөрийн бүтээлдээ үндэслэж, диалектик аргын сул болон буруу элементүүдийг тодорхой жишээгээр няцаасан байдаг⁴.

Шүүмжлэлт рационализмын эх үндэс нь “няцаах зарчим” хэмээн тэрээр үзжээ. Энэ нь фальсификаци буюу фаллибилизм⁵ хэмээх ухагдхуунаар нөхцөлдөнө гэж үзсэн байна. Нэг ёсондоо няцаах зарчим орших гол нөхцөл нь фальсификаци буюу “Fallibilism” хэмээх ухагдхуун ажээ. Энэ ойлголт нь аливаа онол алдаатай гэсэн гол утгатай бөгөөд, нэг ёсондоо алдаа дутагдлын тухай сургааль хэмээн үзэж болно. Энэхүү нэр томъёог анх Унгарын философич И.Лакатос /1922-1974/ хэрэглэж бие даасан бүтээл, өгүүлэл бичсэн байна. Харин К.Р.Поппер XX зууны 60-аад онд өөрийнхөө сургаалийг фаллибилизм болохын хувьд нь авч үзэн, үнэлсэн байдаг байна. “Няцаах зарчим” буюу фальсификаци хэмээх ойлголт нь үгийн утгийн хувьд Латин хэлний *Factus*-худал, *Facio*-хийх гэсэн үгнээс гаралтай бөгөөд аливаа онолыг нарийвчлан авч үзвэл уг онолд харшлах эмпирик баримттай жиших /зөрчилдүүлэх/ явдал юм. Нэг ёсондоо няцаагдах шинж гэдэг нь няцаалтын өмнө тууштай аливаа онол нээлттэй байх явдал юм.

Улс төрийн сургаалийн түүх судлалын салбарын үүсэл хөгжил нь төрт ёсны үүсэл, хөгжилтэй хамт тоологдохуйц хэдэн мянган жилийн арвин баялаг түүхийг өөртөө багтаасан Улс төрийн шинжлэх ухааны салбар юм. Хүн төрөлхтний төрт ёсны үүсэл мээ VI-III мянган жилийн заагт Эртний өрнө дахины Грек, Ром, дорно дахины Энэтхэг, Хятад зэрэг хүн амын томоохон төвлөрөлтэй, нэгдсэн хүчийг шаардахуйц бүс нутгуудад үүсэн бий болсон байдаг. Тэгвэл энэхүү төрт улсын үүсэл хөгжлийг эртнээс нааш эдүгээг хүртэл судалж ирсэн томоохон салбар бол Улс төрийн сургаалийн түүх судлалын салбар юм. Тиймээс Улс төрийн сургаалийн түүх судлалын судалгаанд ач холбогдол өгч арга зүйг нарийвчлах, боловсронгуй болгох энэ чиглэлийн эрэл хайгуулыг хийх зүй ёсны шаардлага байна.

Улс төрийн сургаалийн түүх судлалын салбарт багтах хэдэн мянганаар тоологдох түүхийг шинжлэх ухааны арга зүйгээр цаг хугацааны хувьд үечилж, сэтгэгчдийн онол, үзэл баримтлалын төсөөтөй талуудаар ангилж, өрнө болон дорнын сэтгэлгээ, газар нутгийн байршлаас хамаарсан сэтгэлгээний онцлогоор нь хуваан ангилж .., тус тус судалж байна. Гэсэн хэдий ч Улс төрийн сургаалийн түүхийн судалгааны арга зүйд ерөнхий шинжлэх ухаан болон бусад салбар шинжлэх ухаануудад хэрэглэгддэг арга зүйг хэрэглэж судалгаанд хэвшүүлэх, томоохон арга зүйн шинэчлэлийг нийгмийн хөгжил хөдөлгөөн, шинжлэх ухааны өөрчлөлт, хөгжил, хурдтай зэрэгцүүлэн хийх нь зүйтэй юм. Энэ чиглэлд ерөнхий шинжлэх ухааны арга зүйд голчлон хэрэглэгддэг верификацийн арга зүй болон фальсификацийн /шүүмжлэлт рационализм/ зарчмыг Улс төрийн сургаалийн түүхийн судалгаанд ашиглаж хэвших нь зүйтэй хэмээн үзэж байна.

Верификацийн зарчмыг Улс төрийн сургаалийн түүхийн судалгаанд ашигласнаар дараах үр дүн гарна хэмээн үзэж байна.

³ Орос хэлнээс орчуулсан Г.Лувсанцэрэн, Са.Пүрэв, Д.Содномгомбо зэрэг, “Философийн толь” 333-р тал ., УБ 1990 он

⁴ К.Р.Поппер, “Диалектик гэж юу вэ?”, 1995 ., 67-69-р тал

⁵ Fallibilismгэсэн Англи хэлний буулгавар бөгөөд Анх шинжлэх ухааны Философид Ч.Пирс авч үзсэн байна. Энэ нь Fallible-алдаанд эмзэг, найдваргүй гэсэн утгийг илтгэдэг байна.

Улс төрийн сургаалийн түүхэнд аливаа сэтгэгчийн сургааль, номлолыг судлахдаа өөр сэтгэгчийн онол, үзэл баримтлал, ерөнхий зарчим, үзэл баримтлал, номлолтой өрсөлдүүлэх, харьцуулсан судалгааг хийх замаар судлах нь үр дүнтэй юм. Верификацийн дээрх арга зүйг ашиглаж хэвшсэнээр тухайн судлаач аливаа онол, сургааль, үзэл баримтлалын чиглэлээр цогц мэдлэгийг бүтээх, сул, давуу тал, нэг нь нөгөөгөөсөө ялгарах гол онцлог, мөн чанаруудыг нарийн таних боломж бүрдэж байгаа болно. Нөгөө талаар Улс төрийн сургаалийн түүхийн судалгааны өөр хоорондоо адил төстэй олон ойлголтуудыг нарийвчлан танин мэдэж, ялгааг танин мэдэхэд чухал арга зүй болно.

Фальсификацийн арга зүйн зарчим нь шинжлэх ухаанч сэтгэлгээг бий болгох үндсэн нөхцөл юм. Учир нь аливаа онол хандлагад өөрийн үнэлэлт, дүгнэлтийг өгөх, тодорхой шалгуураар ангилах, шинжлэх ухааны шүүмжийг өгөх явдал нь аливаа судлаачид нэн тэргүүнд тавигдах шаардлага юм. Улс төрийн сургаалийн түүхийн салбар нь өөртөө олон мянган жилийн түүхийг багтаасан асар том салбар ухаан юм. Энэ утгаараа дээрх олон мянган жилийн хугацаанд болсон сайн муу, ач холбогдолтой болон ач холбогдолгүй бүхий л ойлголтуудыг өөртөө багтаадаг. Энэ нь тухайн салбар ухааны буруу биш бөгөөд түүхийн сайн муу бүхий л зүйлийг заах ёстой билээ. Гэвч өнөөгийн байдал дээр тухайлсан сэтгэгчийн онол хандлагыг ялгаж салгахгүйгээр, түүнд шинжлэх ухааны шүүмж дэвшүүлэхгүйгээр, онол сургаалийн сул талыг гаргах, судалгааны үндсэн дээр хайж олох тухай асуудал бараг үгүй гэж болохоор байна. Улс төрийн сургаалийн түүх судлалын энэхүү сул талыг бүрэн нөхөж чадвал энэ салбарын цаашдын хөгжил, төлөвшил, судалгааны арга зүй боловсронгуй болоход чухал ач холбогдолтой байх болно. Тиймээс энэхүү салбар ухааны арга зүйд фальсификацийн арга зүйн зарчмыг ашиглаж хэвших нь томоохон давуу тал болно хэмээн үзэж байна. Улс төрийн сургаалийн түүх судлалын судалгаанд фальсификацийн дараах шаардлагуудыг хэрэглэх нь зүйтэй юм. Үүнд:

- Тухайн сэтгэгчийн онол сургаалийг үзэл баримтлал төстэй боловсрогдсон өөр сэтгэгчийн үзэл баримтлалтай өрсөлдүүлэх, сул болон давуу талыг гаргах, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;
- Тухайлсан нэг сэтгэгчийн үзэл баримтлал, эх зохиол, эсвэл түүхийн нэг үеийг хамарсан сэтгэгчдийн /тухайлбал сэргэн мандалтын үеийн сэтгэгчид/ үзэл баримтлал, онол хандлага дээр шүүмж, эссэ бичүүлэх;
- Судлаачдын онол, үзэл баримтлал дээр няцаалт хийж, өөрийн үзэл баримтлалыг дэвшүүлэх, онолын мэтгэлцээнийг өрнүүлэх;
- Улс төрийн шинжлэх ухаан болон Улс төрийн сургаалийн түүхийг судлахдаа тухайн судлаач сэтгэгчидийн туурвисан эх зохиолд шүүмж бичих, бусад сэтгэгчидийн эх зохиолтой харьцуулалт хийлгэх, шүүмж дэвшүүлэх;
- Улс төрийн сургаалийн түүхэнд бүтээгдсэн тодорхой онол, үзэл баримтлал, үзэл суртлын цаашдын чиг хандлагын талаар гипотез дэвшүүлэх; .., зэрэг нь Улс төрийн сургаалийн түүхийн судалгааны арга зүйд тодорхой хувь нэмэр оруулна хэмээн үзэж байна.

Фальсификацийн арга зүйг Улс төрийн сургаалийн түүхийн судалгаанд ашигласнаар нэг талаас цэвэр шинжлэх ухааны арга зүй, нөгөө талаар практик талаас ач холбогдолтой. Дээрхи үйл явцаар дамжиж Улс төрийн сургаалийн түүх судлалын арга зүйд өөрчлөлт, дэвшил бий болно гэдэг нь онол, арга зүйн шинжтэй дэвшил юм. Энэ тухай К.Р.Поппер өөрийн онол хандлагыг дэвшүүлэхдээ шүүмжлэлт рационализм нь танин мэдэхүйн бүх онолын томоохон асуудлуудыг зарим талаар тодотгож байгаа гэж бодож байна. Бидний ингэж их, тэгсэн мөртлөө ингэж бага мэдэж байгаагийн учир юу вэ? бас бид өөрсдөөсөө чангаах замаар үл мэдэхийн балчгаас яаж зугуухан гарч чадаж байна вэ? бид таамаг дэвшүүлж, түүнийгээ шүүмжлэн сайжруулах замаар ажиллаж байгаа учраас тэгж чадаж байгаа юм⁶ хэмээн шүүмжлэлт рационализм, фальсификацийн арга зүйн талаархи үзэл баримтлалын ач холбогдлыг дүгнэн үзсэн байдаг. Мөн тэрээр шинжлэх ухааны судалгаанд хамгийн гол зүйл бол баримт хэмээн үзэж, бид өөрсдийн алдаанаас болон бусдын шүүмжлэлээс суралцаж чадаж байгаа явдал бол гайхамшигтай баримт, бас бид дэлхий дахины түүхийн хүрээний хэм хэмжээний ертөнцийн хүрээнд суралцаж байгаа маань ч гайхамшигтай баримт юм. Энэ бүхнийг үндэслэн дүгнэвэл аливаа шинжлэх ухаан өөр өөрийн судалгааны онцлогтой, харин түүнийг хэрхэн, яаж боловсронгуй болгох, баяжуулах тухай асуудлаас улбаалан тухайн шинжлэх ухааны хөгжил, төлөвшил, шалтгаалдаг хэмээн үзсэн байна.

Эдүгээ Улс төрийн шинжлэх ухааны үүрэг, хариуцлага улам нэмэгдэж, нийгмийн шинжлэх ухааны томоохон салбар болсон байна. Аливаа шинжлэх ухаан нийгмийн хөгжил, өөрийн салбарын хөгжлийг чиглүүлэх үүргээ биелүүлж буй эсэх нь тухайн шинжлэх ухааны арга, арга зүйн боловсронгуй байдалтай шууд холбоотой. Тиймээс Улс төрийн шинжлэх ухааны хөгжил эдүгээ салбар судлалын судалгааны амжилт, нөгөө талаас боловсронгуй арга, арга зүйтэй нягт холбоотой болж байна. Иймд Улс төрийн шинжлэх ухааны гол салбар болох Улс төрийн сургаалийн түүх судлалын арга, арга зүйд верификаци, фальсификацийн зарчмыг хэрэглэсэнээр дараах үр дүн гарна хэмээн дүгнэж байна.

- Верификаци, фальсификацийн зарчимд буй шүүмжлэлт үзэл санааг дэвшүүлэх, тухайн онол, сургаалийн сул талыг олж, няцаагдах шинжийг илрүүлэх, шинжлэх ухааны таамаг дэвшүүлсэнээр тухайн улс төрийн сургаалийн тухай цогц мэдлэгийг олгох;
- Улс төрийн сургаалийн түүхийг судлах судалгааны арга, арга зүйг шинэчлэх, боловсронгуй болгох нь энэ салбарын цаашдын чиг хандлагад чухал нөлөөг үзүүлэх учир шинэ арга, арга зүйг салбар судлалын судалгаанд хэрэглэх, дэлгэрүүлэх;

⁶ Карл Раймунд Поппер ., Нээлттэй нийгэм түүний дайснууд ., 439-р тал ., 1943 он

- Улс төрийн шинжлэх ухаан, Улс төрийн сургаалийн түүхийн судалгааг хийж буй бүх түвшиний судлаачид өөртөө бүтээлч хандлагыг төлөвшүүлэх нь чухал юм. Энэ чиглэлд тухайн судлаачийг бэлтгэх, бүтээлч арга зүйн хандлагыг эзэмшүүлэхэд верификаци, фальсификацийн зарчимд буй шалгуур, шаардлагуудыг хэрэглэх нь томоохон үр дүнд хүргэнэ.

Улс төрийн сургаалийн түүхийн судалгааны арга, арга зүйн асуудал, түүнд верификаци болон фальсификацийн арга зүйг хэрэглэх, хөгжүүлэх асуудлыг дүгнэж үзвэл дараах дүгнэлтүүд гарч байна. Нэгдүгээрт, шинжлэх ухааны ерөнхий болон тусгай аргуудын мөн чанар, онцлог, бусад аргаасаа ялгарах ялгааг нарийн танин мэдэх зайлшгүй шаардлагатай юм. Учир нь тухайн аргын мөн чанарыг нарийн танин мэдэх нь бусад аргаас ямар давуу болон сул талтайг нарийн танин мэдэхэд верификаци болон фальсификацийн арга зүйг хэрэглэх нь томоохон гарц, болно. Нөгөө талаар шинжлэх ухааны ерөнхий болон тусгай аргуудын талаар нарийвчилсан, системтэй мэдлэгийг бий болгоход чухал ач холбогдолтой. Хоёрдугаарт, дээрх арга, арга зүйг илүү нарийвчилж, Улс төрийн сургаалийн түүхийн судалгаанд хэрэглэгддэг аргуудын мөн чанар, онцлог, хоорондын ялгааг нарийн танин мэдэх нь чухал юм. Аливаа аргыг нарийн танин мэднэ гэдэг бол тухайн аргыг шинжлэх ухааны судалгаанд хэрхэн үр дүнтэй, бүтээлчээр ашиглах, нөгөө талаас тухайн судалгааны объектод нийцүүлэх тухай ойлголт юм. Судалгааны аргыг буруу сонгосноос тухайн судалгааны ажил мухардалд орох, үр дүн нь удаан гарах явдал түгээмэл байдаг. Тэгвэл энэхүү “аюулаас” хамгаалах арга зам нь тухайн салбарт түгээмэл хэрэглэгддэг судалгааны аргуудыг нарийн танин мэдсэн байх явдал юм. Гуравдугаарт, дээрх хоёр ойлголт ойлголт дээр нэмэгдээд арга зүй хэмээх ойлголт нэмэгдэж буй нь тухайн судалгааны ажил бүтээлч, үр дүнтэй болох үндэс юм. Энд арга зүй хэмээх ойлголтыг судлаач, хүнтэй холбоотойгоор авч үзэж байгаа болно. Учир нь арга зүй хэмээх ухагдхууныг тухайн судлаачийн судалгааны объектод хандаж буй хандлага, чадвар, судалгааны явцад баримтлах зарчим, зан чанарын цогц гэсэн утгаар авч үзэж байна.

Энэ бүхнээс үндэслэн аливаа шинжлэх ухааны судалгаа үр дүнтэй болох гол нөхцөл нь дээрх арга зүйг хэрэгжүүлэх, алхам тутамд хөгжүүлэн дэлгэрүүлэх тухай асуудал юм. Тиймээс Улс төрийн шинжлэх ухаан болон Улс төрийн сургаалийн түүхийн судалгааны арга зүйг шинэчлэх, хөгжүүлэх нэг гарц нь энэ чиглэлийн судалгаанд верификаци, фальсификацийн арга зүйг хэрэглэх явдал хэмээн үзэж байна. Нэг ёсондоо аливаа судалгааны объектыг судлахдаа шинжлэх ухааны аргуудын мөн чанар, онцлогыг нарийн мэдэх явдал, үүнээс шалтгаалсан аргыг тохируулан сонгох явдал, нэмэгдээд тухайн арга зүйг нийгмийн хөгжилд тохируулан улам боловсронгуй болгох холбоо бүхий гурван холбоо ойлголт, зарчмыг баримтлахад верификаци болон фальсификацийн арга зүйг хэрэглэх нь аливаа судалгааг үр дүнтэй болгоход чухал хувь нэмэр оруулах болно хэмээн үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. Ерөнхий ред Ц.Ганболд, “Улс төрийн Шинжлэх ухаан”, УБ. 2001
2. А.Жамбал, “Улс төрийн сургаалийн түүх”, УБ., 2000 он
3. Г.Чулуунбаатар, “Шинжлэх ухааны танин мэдэхүйн логик, судалгааны ажлын арга зүй”, УБ., 2001 он
4. Г.Лодой, “Философи ба шинжлэх ухааны арга зүй”, УБ., 2002 он
5. К.Р.Поппер, “Нээлттэй нийгэм ба түүний дайснууд”, 1,2-р боть, УБ., 2006 он
6. К.Р.Поппер, “Түүхчлэх үзлийн гуйланчлал”, УБ., 1995 он
7. К.Р.Поппер, “Диалектик гэж юу вэ”, УБ., 1995 он
8. А.Ж.Тойньби, “Түүх судлал”, УБ., 2007 он
9. Орос хэлнээс орчуулсан Са.Пүрэв, Д.Содномгомбо зэрэг, “Философийн толь”, УБ., 1990 он
10. А.К.Рогерс, “The Socratic problem”, 1933 он
11. МУИС-Улс төр судлалын тэнхим, “Политологи” сэтгүүл .,., “Монгол дахь орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны сургалт судалгааны зарим асуудал” өгүүлэл, УБ., 2007, № 281
12. УТБА, “Шинэ толь” сэтгүүл ., Х.Пүрэвгогтох “Шүүмжлэлт рационализм”, № 23, УБ., 1998 он
13. Сато, Ёжи нар, “Суутнуудын санаа бодолд хил хязгааргүй”, УБ., 2004 он

МОНГОЛ ДАХЬ УЛС ТӨРИЙН ЁС ЗҮЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Д.УНДРАХ

*Доктор, дэд профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхим*

Түлхүүр үг: ардчилсан нийгэм, парламентат ёс, ёс суртахууны зарчим хэм хэмжээ, ёс зүйн зохицуулалт, ёс зүйн доройтол, улс төрийн тогтворгүй байдал

Хураангуй: Монгол дахь улс төрийн ёс зүйн өнөөгийн төлөв байдлыг нэн түрүүн түүнд нөлөөлж буй дотоод хүчин зүйлсийн нөлөөлөлтэй нь уялдуулан тодруулах улмаар түүнийг хариуцлагын тогтолцоонд суурилсан хатуу чанд дүрэм журмаар зохицуулах шаардлагатай болохыг тодруулан гаргахыг зорилоо.

Abstract: While clarifying current state of political ethics in Mongolia with its ailing features of the authoritative few, unstable institutions, unknown legal acts, inactive electorates and impotent state, the author suggests hereby more responsible and ethically fundamental socio-political regulation.

XXI зууны босгон дээр ардчилал хөгжсөн улс орнуудад хүмүүсийг захиран удирдах бус харин олон нийтэд зохистой үйлчлэх зарчмыг хэрэгжүүлэх явдлын ач холбогдлыг ухаарах болж, хүн өөрийнхөө төлөө хөдөлмөрлөж, нийгмийг цогцлоох үйл ажиллагааг ашигтай үр дүнд хүргэх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах болжээ. Үүнтэй уялдан удирдлагын болон манлайллын арга барилд ч шинэ хандлага болох эрх баригч улс төрийн хүчин, албан тушаалтан удирдлагын үүргийг захиран тушаах аргаар бус харин ёс зүйн зарчмыг дээдлэн өөрийн манлайлал, нэр хүндийнхээ нөлөөгөөр гүйцэтгэхийг чухалчлах болжээ.

Өнөөгийн төр “хүний тоонд дулдуйдах бус” харин нийгэмд үйлчилдэг, боловсон хүчнийхээ чадавхийг нээн гаргахад анхаардаг байх шаардлагатай болж байна. Энэ нь нийгмийн амьдралын тухай шинжлэх ухааны шинэ мэдлэг, түүнд тулгуурласан чадвар, төрийн албаны мэргэжлийн ёс зүйд суурилах ёстой. Парист төвтэй Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ)-ын гишүүн орнууд төрийн албан хаагчид, тэр дундаа парламентын гишүүдийн ёс зүйн зөв зан суртахууныг дэмжих, хэвшүүлэх замаар удирдлагын хариуцлагыг өндөржүүлэх ажилд анхаарлаа хандуулж байна. Энэ хүрээнд ёс зүйн горимын тулгуур ангиллуудыг ч тогтоожээ. Ёс зүйн менежмент өөр өөр байдлаар хийгдэж байгаа талаарх чиг хандлагын судалгааг зарим эрдэмтдийн тодорхойлсноор авч үзвэл:

Нэгд, телологик буюу шударга, зарчимч байдалд тулгуурласан хандлага⁷. Энэ нь зөв, сайн, үнэнч зан суртахуунд ач холбогдол өгч, ёс зүйн зөрчил дутагдалд ширүүлдэггүй буюу хатуу хариуцлага хүлээлгэх гэж төдийлөн шахаж шаарддаггүй тул төрийн албан хаагчдад ёс зүйн нарийн чанд дүрэм мөрдүүлэх гэж тулгадаггүй. Энэ тохиолдолд хувь хүн өөрөө хариуцлагаа ухамсарлан, дүгнэлт хийх, гэм буруугаа өөртөө хүлээх зэргээр ёс зүйг ухамсарлах талыг баримтлах чиглэл юм.

Хоёрт, дэг журмыг мөрдөх буюу дүрэм, журамд тулгуурласан хандлага. Энэ нь төрийн албан хаагчид төдийгүй аливаа мэргэжлийн үйл ажиллагаанд ихэнхидээ хуульчилсан, албан ёсны дүрэм журмыг нарийн чанд баримтлахыг шаардана. Ингэснээр ямар үүрэг гүйцэтгэх, юуг хийж болох, юуг хийж эс болохыг тогтоох, буруу буюу зөрчил доголдлыг илрүүлэн хариуцлага тооцохыг чухалчилна.

Эдгээр чиг хандлагуудаас төрийн захиргааны арга барилыг голлон хэрэглэдэг улс орнууд дүрэм журмыг дагаж мөрдөхөд чиглэсэн ёс зүйн чиглэлийг сонгон хэрэглэх нь тохиромжтой бол, удирдлага, зохион байгуулалтын арга барилыг хэрэглэдэг орнуудад телологикийн арга илүү нийцтэй гэж үздэг.

Авлигын түвшин бага нөхцөлд шударга ёсны зарчимд тулгуурласан менежмент буюу албан хаагчид өөрсдийн үйл ажиллагаанд шинэчлэлт хийх зориг, эрмэлзэл их байгаа тохиолдолд энэ нь хамгийн их амжилт дагуулах магадлалтай.

Гэтэл авлига өндөр түвшинтэй байгаа бол ёс зүйн хэм хэмжээ, стандарт сул буйн дохио тул хяналт, хариуцлагын хатуу тогтолцоо шаардлагатай бөгөөд дүрэм журамд тулгуурласан менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай болно.

Америкийн Хойд Илинойн их сургуулийн профессор Мензел “төрийн албанд албан хаагчдын ёс зүй гол үнэт зүйл нь болж ирсэн”⁸-ийг тэмдэглэн хэлсэн байдаг бол, Их Британийн Ноттингхэмын Их сургуулийн профессор Хэйвүүд “ёс зүйгүй горим, авлига хоёр хөгжлөөр сул үндэстний шинж”⁹ гэж тодорхойлжээ. Тэгвэл ёс зүйн чиглэлээр дагнасан судлаачид (АНУ-ын төрийн захиргааны ёс зүйн албаны мэргэжилтэн Стюарт Гильман нар) эрх зүйн хүрээний тодорхой ёс зүйн дүрэм, ёс зүйн мэдлэг, ил тод мэдээлэл, нээлттэй шийдвэр, ёс зүйн зөрчилд тохирсон шийтгэл чухал болохыг цохон тэмдэглэж байна¹⁰.

⁷ OECD, *Ethics in the Public Service: Current Issues and Practice*. Public management occasional papers.#148 1966.p.59

⁸ Criag Johnson. *Meeting the ethical challenges of leadership; casting light or shadow*.SAGE Publications. 2012
Erskine May, *Parliamentary Practice*. London., Lexisnexis Butterworth, 2011

¹⁰ Gilman Stuart, *Ethics Codes and Codes of Conduct as a tool for promoting an ethical and professional public service: Comparative successes and lessons*, Washington DC., PREM/World Bank, 2005

Ийнхүү ёс зүйн хамааралыг үл тоомсорлон төрөөс нийгмийг удирдах боломж үндсэндээ үгүй болохыг хөгжингүй улс орнууд хэдийн ухамсарлаад эхэлчихсэнийг ажвал хөгжлийн төлөө, тунаж үлдэхийн төлөө тэмцэж буй манай мэт улс орнууд бусдын туулж өнгөрүүлсэн бартаат замыг дайралгүй тойрч, давталгүй алгасч гарахыг чармайх нь зүйтэй.

Нийгэмд нэн ялангуяа шилжилтийн нийгэмд дангаараа ноёрхсон ёс суртахуун гэж байдаггүй аж. Иймээс бие хүн бүр өөрийн гэсэн зан суртахууны тодорхой үнэлэмжээр л аливаа асуудалд ханддаг болжээ. Гэвч судлаачид хүмүүсийн үнэлэмж, баримжаалал нийгмийн хүрээнд буурч, бодгалийн үнэлэмжийн ач холбогдол улам бүр өсөх хандлагатай байгааг анхааруулах болжээ. Энэ үйл явцыг нэг талаар урьд өмнө нь хайхрахгүй явж ирсэн бие хүний өөрийн үнэлэмж, бусдаас хараат бус байдал дээшилсэн гэдгээр тайлбарлаж болох бөгөөд амьдрал дээр ч хүмүүсийн өөрсдийгөө илэрхийлэх байдал нээлттэй чөлөөтэй болж, хувийн хүч, нөөц боломжоо дайчлах оролдлого, эрмэлзэл өсч байгаа нь бодитой билээ. Гэвч нөгөө талаар Монголчуудын хийгээд дорнын ард түмний ёс суртахууны уламжлалт хандлага, үнэт зүйлд тооцогдож ирсэн хамтач үзэл, нийгмийн харилцааны тогтвортой үндэс болох бат бөх гэр бүлийн тухай үнэлэмжүүд орхигдох буюу арын эгнээ рүү шилжих болж зүгээр нэг тохитой сайхан амьдрал биш, эд зүйлсийг шүтэн биширсэн, амьдралын цор ганц зорилго болгосон хэв маяг рүү шилжих хандлага ажиглагдах боллоо. Эд зүйлсийг хэт шүтсэн хэрэглээний сэтгэл зүй улмаар хэрэглээний үзэл суртал болох талтайг ч умартаж болохгүй.

Орчин үеийн Монголын нийгэмд ёс зүйн үзэл баримжаалалд нөлөөлөх сөрөг хандлагууд гарах болсныг доорх сэдвүүдийн хүрээнд хөндөн гаргахыг оролдоё.

- Эрх мэдэлтэй цөөнх
- Тогтворгүй төр
- “Үл мэдэгдэх” хууль
- “Идэвхигүй” сонгогчид,
- “Чадамжгүй” төр засаг“

Эрх мэдэлтэй цөөнх

Бодит байдал дээр төрийн алба хашигчид, тэр дундаа улс төрийн албан тушаалтнууд нийгэмд эрх дархтай давхраа болж хувирдаг. Нийт хүн амын тоотой харьцуулахад төдийлөн их биш мэт боловч улс төрийн өндөр албан тушаалтнууд, тэдгээрийн хүрээлэл хийгээд асуудлын цар хүрээ нь нийгэмд хангалттай сенсаац дэгдээх, хямралд хүргэхүйц байдлыг бий болгож чаддаг ажээ. Тухайлбал, Монгол улсад Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүд буюу сайд нар, Дээд Шүүхийн гишүүн, прокурор болон түүний орлогчид, Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг хамруулан нийтдээ 130 орчим төрийн өндөр албан тушаалтан байдгаас 90 гаруй нь улс төрийн өндөр албан тушаалтан байгаа нь нийт 2984 улс төрийн албан хаагчдын тоо ба хүн амын тоотой харьцуулахад хангалттай үзүүлэлт.¹¹ Гэтэл харахад төдий их биш эдгээр хүмүүс улс орны хэмжээний бодлогыг тодорхойлж, шийдвэр гаргах тул тэдгээрийн үйл ажиллагаанаас гарах алдаатай шийдвэр, оновчгүй, ойлгомжгүй хуулийн заалт, үйл байдал ёс суртахууны зохисгүй үйлдэл нийгэмд тогтворгүй байдал, хямрал авчирч болдгийг хорьдугаар тогтоол, өмч хувьчлал, үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, уул уурхай, ашигт малтмалын талаар төрөөс явуулах бодлого, хөрөнгө оруулалтын гэрээ, тогтвортой байдлын гэрээ зэрэг нийгэмд асуудал дагуулсан, улс орны хөгжилд хямралт байдлыг бий болгосон олон үйлдлээс харж болно.

Аль ч нийгэмд нийтлэг шинжтэй байдаг эрх мэдэл бүхий улс төрийн дээд давхаргынхны үйл ажиллагаа, ёс суртахууны асуудалд эрх зүйн төдийгүй ёс зүйн талаас нь үнэлэлт дүгнэлт өгөх, буруу зөвийг нь олон нийт ялгаж таних боломжтой байх ёстой. Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлэг, сонирхолын зөрчлийн бүртгэл, тусгай хангамж, эрх мэдэлтэй холбоотой асуудал сөхөгдөхөд их л “даруухан мэдэлтэй, дундаж амьдралтай” энгийн нэгэн мэт харагдавч хэрэг дээрээ байдал огт өөр байх нь олонтаа. Хүссэн ч, эс хүссэн ч дэлхийн нийтээр төрд алба хаагчид нэн ялангуяа сонгуульт албан хаагчдад тавигдах нийтлэг шаардлага, стандартыг боловсруулан ил тод байдал, нээлттэй мэдээллийн давуу бөгөөд сайн талыг олж хэрэгжүүлээд эхэлсэн байхад бид ч мөн нийтийн жишгээр гэхдээ ололттой бөгөөд давуу талыг нь олж харсан тэр замаар хөгжих хэрэгтэй.

Ёс суртахууны аливаа үйлдлүүд нь хууль далайлган хүчлэх, төрөөс албадан захирах аргаар биш бие хүний ухамсар дээр тулгуурлан илэрдэг байвал зохилтой. Иймээс л төрийн албанд сонгон шалгаруулалтаар мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг шалгаж оруулахаас гадна хувийн зан төлөв, ёс суртахууны хэмжүүрийг ч оруулдаг байх нь зүйтэй. Гэтэл сонгуульт албан тушаалтанууд болон төрийн өндөр дээд албанд ажиллах хэнд ч энэ шалгуур хавьгүй өндөр байх ёстой атал үүнд анхаарал хандуулахгүй өдий хүрчээ.

Улс төрчид уг нь байнга олны шүүлт, шалгуур дор байж иргэд тэдэнд ёс зүйн өндөр шаардлага тавьдаг байх ёстой. Монголын нийгмийн харилцаанд өөрчлөлт авчирсан 1990 оноос хойш нийгмийн зүгээс өмч хувьчлал, банк санхүүгийн ноцтой зөрчлүүд, төрийн өмчийг завшин шамшигдуулсан, улс төрийн хүрээний авилга, нийгмийн хэмжээгээр гэмт хэрэг, халдлага өссөн зэрэг олон үйл явдлуудад ард иргэд дургүйцэл бухимдлаа илэрхийлэх болсон. Хүмүүс ядуу зүдүү амьдарч байгаагаасаа илүү нийгмийн гажуудсан ёс суртахуунд сэтгэл эмзэглэн, түүнийгээ Ерөнхийлөгч, засгийн газар, хууль тогтоогчдын хариуцлагатай холбон, тэвчишгүй тохиолдолд тэмцлийн олон хэлбэрийг сонгон эсэргүүцлээ илэрхийлэх болсны жишээг 2008 оны 7 сарын 1-ний үйл явдлаар тайлбарлаж болох байна.

¹¹ Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний талаарх статистик тойм. УБ., 2014 оны 1 сарын 1-ний байдлаар /МУ-ын төрийн албаны зөвлөл/

Тогтворгүй төр

Монгол Улсын Засгийн газар 1990 оноос хойшхи 25 жилийн хугацаанд 14 удаа солигдсоноос үзэхэд дөрвөн жилийн бүрэн эрхийн хугацаатай засгийн газрын дундаж нас 2 жил хүрэхгүй болж байна. Үүний цаад шалтгаан яахын аргагүй улс төрийн болон удирдлагын ёс суртахууны гажуудалтай холбоотой бөгөөд улмаар төр засгийн үйл ажиллагааны залгамж чанар, тогтвортой байдал алдагдахын үндэс болж буйг тэмдэглэн хэлэх шаардлагатай.

Хүснэгт 1.

Монгол Улсын Ерөнхий сайд нар

№	Ерөнхий сайд	Ажилласан хугацаа	Алба хашиж байх үедээ харьяалагдаж байсан нам
1	Шаравын Гунгаадорж	1990/3/21 - 1990/9/11 /6сар/	Монгол Ардын Хувьсгалт Нам
2	Дашийн Бямбасүрэн	1990/9/11 - 1992/7/21 /2 жил орчим/	Монгол Ардын Хувьсгалт Нам
3	Пунцагийн Жасрай	1992/7/21 - 1996/7/19 /4 жил орчим/	Монгол Ардын Хувьсгалт Нам
4	Мэндсайханы Энхсайхан	1996/7/19 - 1998/4/23 /2 жил орчим/	МҮАН-МСДН-ын Ардчилсан Холбоо Эвсэл
5	Цахиагийн Элбэгдорж	1998/4/23 - 1998/12/9 /8 сар орчим/	МҮАН-МСДН-ын Ардчилсан Холбоо Эвсэл
6	Жанлавын Наранцацралт Ням-Осорын Туяа /үүрэг гүйцэтгэгч/	1998/12/9 - 1999/7/22 /8 сар орчим/	МҮАН-МСДН-ын Ардчилсан Холбоо Эвсэл
		1999/7/22 - 1999/7/30	
7	Ринчиннямын Амаржаргал	1999/7/30 - 2000/7/26 /1 жил/	МҮАН-МСДН-ын Ардчилсан Холбоо Эвсэл
8	Намбарын Энхбаяр	2000/7/26 - 2004/8/20 /4 жил/	Монгол Ардын Хувьсгалт Нам
9	Цахиагийн Элбэгдорж	2004/8/20 - 2006/1/13 /1 жил гаруй/	Эх Орон Ардчилал эвсэл
10	Миеэгомбын Энхболд	2006/1/25 - 2007/11/22 /2 жил орчим/	Монгол Ардын Хувьсгалт Нам
11	Санжаагийн Баяр	2007/11/22 - 2009/10/28 /2 жил орчим/	Монгол Ардын Хувьсгалт Нам
12	Сүхбаатарын Батболд	2009/10/29 - 2012/8/9 /3 жил/	Монгол Ардын Хувьсгалт Нам
13	Норовын Алтанхуяг	2012/8/9 - 2014/11/5 /2 жил орчим/	Ардчилсан Нам
14	Чимидийн Сайханбилэг	2014/11/15 - /1 жил гаруй/	Ардчилсан Нам

“Үл мэдэгдэх” хууль эрх зүй

1992 онд Үндсэн хуулийг шинэчлэн баталж, ардчилал, зах зээлд шилжсэн нь улс төр, эдийн засгийн утгаараа дэвшил болсон хэдий ч шилжилтийн үе дууссан гэхийн аргагүй, харин ч нийгмийн хямралт байдал гүнзгийрэн үргэлжилсээр хориод жил боллоо. Хуулиа дээдлэхийг эрхэм болгон эрх зүйт төрийг төлөвшүүлэхээр олон тооны хууль баталсан боловч нийгмийн дэг журмын гажуудал, ёс зүйн уналт улам даамжирч, хүний эрх, эрх чөлөөг тунхаглан эдийн засаг, санхүүгийн байдлыг сайжруулах талаар олон арга хэмжээ авсан ч удирдлагын нэр хүнд унаж, төрд итгэх итгэл алдагдаж байгааг ёс зүйн асуудлыг ойшоож үзээгүй, орхигдуулсаны үр дагавар гэж болно. 1990 оноос өмнө 190 орчим хуулиар улс орны асуудал, иргэдийн амьдралыг зохицуулаад ирсэн болэдүгээ 570 гаруй хуультай болжээ¹². Гэтэл эдгээр хуулийн хичнээн заалт нь иргэн таны амьдралд, хичнээн хэсэг нь Их Хурлын эрхэм гишүүний эрх үүргийн зохицуулалт болж байдгыг хангалттай сайн мэдэх хэсэг нь энэ хоёр бүлгийн аль алинд хангалтгүй гэдэгтэй маргах хүн үгүй биз ээ. Төр хуулиа хэрэгжүүлж, түмэн олон нь түүнийг хүндэтгэн сахидаг байж эрх зүйт төр оршин тогтнох ёстой.

¹² Монгол улсын хууль-574. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <http://www.legalinfo.mn/>

“Идэвхигүй” сонгогчид

Засаглалын институциудийн үйл ажиллагааны уялдаа холбоо, үр дүнтэй байдалд өгөх иргэдийн үнэлгээ, төр засагт итгэл үзүүлэх иргэд сонгогчдын оролцоо, байр суурь “ёс зүйт төр”-ийг хэмжих нэг шалгуур юм. Тэгвэл сонгуулиас сонгуулийн хооронд иргэдийн оролцоо, улам бүр буурсаар байгаа бодит баримтыг бид бэлхэнээ мэднэ. 95,6 хувийн ирцтэй байсан 1992 оны Парламентын сонгуулиас хойш энэ үзүүлэлт тасралтгүй буурсаар 2012 оны сонгуульд иргэд 67,2 хувийн ирцтэй оролцсон. Энэ бол яахын аргагүй улс төрийн бодит оролцоог харуулдаг сонгуулийн идэвхи оролцоо буурч буйг харуулах үзүүлэлт мөн бөгөөд төрийн нэр хүнд унах, сонгуулийг булхай луйвар гэж үзэх иргэдийн хандлагын нэг илрэл гэж хэлэхээс өөр аргагүй.

“Чадамжгүй” төр засаг

Сант марал сангаас 2015 оны IV сард иргэдийн дунд явуулсан Политбарометрийн судалгаагаар Засгийн газрын үйл ажиллагаа сэтгэлд нийцэж буй талаар судлахад бараг нийцдэггүй-29,3%, огт нийцдэггүй 25,8 % буюу эдгээр эсрэг санал нийлээд 55,1 %, төр засгийн удирдлагын зүгээс нийгэм, улс төр, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадахгүй байгаа тохиолдлыг асуухад УБ хотоос санал асуулгад оролцсон иргэдийн 56,2% байнга, 28,6 олон удаа, 9,6 % нь заримдаа гэж хариулсныг нэгтгээд үзвэл төр засаг тулгамдсан асуудлыг шийдэж чадахгүй байна гэдэгт 94,4% нь санал нэгджээ¹³. Эндээс чадамжгүй төр засаг, ард түмний хүсэн хүлээсэн бодлого боловсруулж хэрэгжүүлж чадахгүй байна гэсэн тайлбар гарах бөгөөд засаглалын легитимчлэл алдагджээ гэдгийг харуулж байна. Төрд итгэх иргэдийн итгэл унаж, улс төрийн үйл явцад оролцох ард нийтийн идэвхи алдагдсан энэ цаг үеийг улс төрийн намуудын эрүүл бус өрсөлдөөн тэмцэл, жудаггүй үйлдэл, сонгуулийн бохир арга, технологи, хариуцлага-хяналтын тогтолцоо үгүй төрийн институциуд, эдийн засгийн хямрал, нийгэм-улс төрийн гацааг үүсгэж, төрийн албыг “төрлийн алба” болгож буртагласаны гор гэж үзэхээс өөр аргагүй.

Ийнхүү төрийн нэр хүнд унасан, төрийн үйл хэрэгт оролцох иргэдийн итгэл үнэмшил, бодит оролцоо буурсан, засаглалын институциуд тогтворгүй, авлига нийгмийг хамарсан хямралт шинж рүү шилжиж буй өнөөгийн нөхцөлд олон улсын жишигт буйтөрийн албан хаагчдын төдийгүй аливаа мэргэжлийн үйл ажиллагаанд хуульчилсан, албан ёсны дүрэм журмыг нарийн чанд баримтлахыг шаарддаг дүрэм, журамд тулгуурласан хандлагыг баримтлах зайлшгүй шаардлага нэгэнт бий болсон байна. Энэхүү шаардлагатай уялдуулан авч үзвэл төр шударга, ардчилсан, эрх зүйт төдийгүй ёс зүйтэй байх ёстой нь харагдаж байна. Үүний цаана төр нь ард түмнээ гэх нийгмийн баримжаалалтай байж, төрийн нэрээр ард түмнийг захирах бус байнга тэдний үгийг сонсож, ажлийн эцсийн үр дүнгээрээ иргэдийнхээ итгэл, дэмжлэгийг татдаг байх хэрэгтэй. Мөн төрийн бүтцэд нийгмийн хяналтыг бий болгох, төрийн болон улс төрийн эрх мэдлийг хөрөнгийн эрх мэдэлтэй нэгтгэхгүй байх зарчмыг хангаж ажиллах шаардлагатай. Төрийн өндөр албан тушаалтнуудын нийгэмдээ үйлчлэх үүргийг хуулиар тодорхойлдог төдийгүй ёс зүйн хэм хэмжээний хүрээнд багтаасан байх нь чухал. Төрийн албыг чиг үүргийн дагуу зүй зохистойгоор зохион байгуулах явдал төр, нийгмийн хоорондын, цаашлаад төрийн өөрийн дотоод олон зөрчлийг шийдвэрлэх боломжийг олгоно. Эцэстээ энэ нь төрийн ёс зүйн хэм хэмжээг зөв төлөвшүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой.

НОМ ЗҮЙ

1. Өлзийбаяр В. “Төрийн албаны манлайллын өөрчлөлт” И-гранд ХГ. УБ., 2009
2. П Рассель Б. “Эрх мэдэлтэн хийгээд бие хүмүүн”. УБ., 2012
3. Платон. “Төр Улс” Орч. Д.Отгонтуяа. УБ., 2005
4. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <http://www.legalinfo.mn/>
5. Сант Марал Сан. Политбарометр. 2015 оны 4 сар
6. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний талаарх статистик тойм. УБ., 2014
7. Criag Johnson. Meeting the ethical challenges of leadership; casting light or shadow. SAGE Publications. 2012
8. Erskine May: Parliamentary Practice. London., LexisNexis Butterworth, 2011
9. Gay Oonah. The Regulation of Parliamentary Standards-Comparative perspective. London. 2002
10. Gilman Stuart, Ethics Codes and Codes of Conduct as Tools for Promoting an Ethical and Professional Public Service: Comparative Successes and Lessons, Washington, DC., 2007
11. Inter-Parliamentary Union, and Office of the United Nations High Commissioner for Human Rights, “Human Rights: Handbook for Parliamentarians”, No.8, 2005
12. OECD, Ethics in the Public Service: Current Issues and Practice. Public management occasional papers. 1966

¹³ Сант Марал Сан. Политбарометр. 2015 оны 4 сар. <http://santmaral.mn/mn/publications/%D0%BF%D0%BE%D0%BB%D0%B8%D1%82%D0%B1%D0%B0%D1%80%D0%BE%D0%BC%D0%B5%D1%82%D0%B5%D1%80-2015-%D0%BE%D0%BD%D1%8B-4-%D1%81%D0%B0%D1%80>

МОНГОЛ ҮНДЭСТНИЙ ХӨГЖИЛ ДЭВШИЛД ҮНДЭСНИЙ УХАМСРЫН ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ

И.ЛХАМ

Доктор, дэд профессор ХААИС, ЭЗБС, ХЭЗТ

М.МӨНХЗУЛ

ХААИС, ЭЗБС, ХЭЗТ

Улс төр судлалын тэнхимийн докторант


Түлхүүр үг: Даяаршил, үндэсний ухамсар, үндэсний соёл, үндэстэн, угсаатан

Товч агуулга: Даяаршлын үйл явц нь Монгол улсын хувьд үндэстэн оршин тогтнох чадварыг сорьж байгаа сорилт болж байна. 1990 оны ардчилсан хувьсгалын үр дүнд нийгэм өөрчлөгдөж, түүхэн энэ хувьсгалын хамгийн чухал үзэгдэл нь монголчуудын үндэсний ухамсрын сэргэлт байлаа. Өнөөгийн нөхцөлд Монголын геополитик, эдийн засаг нь таатай бус байдалд орж, улс орны эрх ашиг, ирээдүй нь хөгжих үү эсвэл доройтох уу гэсэн ийм байдалд үндэсний ухамсар нь тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд нөлөөлөх хамгийн чухал зүйл гэж үзэж байна. Үндэсний ухамсрыг улс төрийн үзэл санааны түвшинд хэрэгжүүлэх нь манай улсын хувьд амин чухал асуудал билээ. Үндэсний ухамсрын уг болон мөн чанар, түүний үйл ажиллагааны хувьсамтгай шинжийн талаарх ойлголтыг тодорхой болгох нь Монгол орны өмнө тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэж, засаг төрөө төвхнүүлэхэд чухал ач холбогдолтой билээ. Үндэстний хувь заяаны хувьд түүхэн явцад бүрэлдэн тогтносон үндэсний ухамсар тодорхойлогч хүчин зүйл нь болдог. Үндэсний ухамсрын нэг чухал элемент бол үндэсний соёлын асуудал юм.

Резюме: То, что процесс глобализации создает для каждого народа различные последствия, является фактом. Для Монголии этот процесс порождает не возможности, а – испытания, точнее – испытания выживания. Поэтому в современных политологических исследованиях необходимо поднять вопрос национального сознания.

Даяаршлын үйл явц нь хөгжлийн өөр өөр түвшинд яваа улс орон бүрт харилцан адилгүй явагддаг. Эдгээрээс монгол үндэстэнг юу хүлээж байна вэ? бид хаашаа чиглэж байна гэсэн асуултууд гарч ирж байна. Хэдийгээр Монгол улс нь тусгаар тогтносон улс мөн хэдий ч үүнийгээ өнөөгийн эрин үед улам баталгаажуулах хэрэгтэй. Тусгаар тогтнол гэдэг бол үндэстний амьдралын баталгаа юм. Үндэсний ухамсрын ач холбогдол нь монголын нийгмийн нэгдлүүд, улс төрийн намууд, улс төрийн чиг баримжааг нягтруулах үндэс бөгөөд газарзүйн тодорхой бүс нутгийн хүн амын амьдралын үйл ажиллагааг зохицуулахаас гадна ирээдүйн чиг баримжааг гаргаж гаргаж өгдөг. Гэвч нөгөө талаас эдийн засаг болон нийгмийн амьдралд даяаршлах нь зарим талаар зайлшгүй зүй тогтол юм гэж хэлж болно. Хэт их үндэсний явцуурах оролдлого нь зөвхөн эдийн засгийн болон оюун санааны уналтанд л хүргэнэ. Орчин үеийн нөхцөлд бүс нутаг болгонд эдийн засаг, нийгмийн дэвшлийг оюун санааны дэвшил дагалдаж байх нь чухал билээ. Иймээс үндэстэн хоорондын зохицол нийцэлд хүрч болох үндсэн зарчмууд нь үндэсний тусгаар тогтнолын аюулгүй байдал, өөрийн үндэсний төрөө бэхжүүлэх, мөн бусад улс үндэстэнтэй эрх үүргийн дагуу эрх тэгш бодитой байх, үндэсний бодлого нь ардчилсан бөгөөд уян хатан байх нь зүйтэй болов уу.

Монголчуудын үндэсний ухамсрын илрэх байдлыг 200 хүнээс судлагаа авсан болно. «Өнөөгийн Монголын үндэсний ухамсар нь хүний үйлдэл, үйл ажиллагааны ямар хэлбэрээр илэрч байна вэ?» гэсэн асуултанд судалгаанд оролцсон хүмүүсийн 80% нь эх нутаг, ёс заншлаа дээдэлж, зарим мартагдсан уламжлалыг сэргээж байгаагаар, 10% нь бусад улсын иргэдэд дайсагнасан өнгө аясаар, 20% нь урлагийн бүтээлийн гол санаа болж байгаагаар гэж харилцан байна.



“Монголын үндэсний ухамсрыг тээгч, өвлүүлэгч, хэрэгжүүлэгч үүргийг хүлээдэг субъект нь аль нь вэ?” гэсэн асуултанд:

	Өнгөрсөн үед	Одоо үед	Ирээдүйд
Хувь хүн /ард түмэн, энгийн иргэд/	70%	50%	63%
Шийдвэр гаргагчид /өндөр албан тушаалтнууд/	27%	44%	8%
Гадаад оронд боловсрол эзэмшсэн иргэд		2%	20%

Дээрх судалгааны дүнгээс үзвэл үндэсний ухамсрыг тээн авч явагч нь аль ч үедээ хувь хүмүүс байдаг байна. Хэдийгээр өнөөгийн байдалд шийдвэр гаргагч нар үндэсний ухамсрыг хэрэгжүүлэгч субъектэд тодорхой хэмжээгээр оролцож байгаа хэдий ч тэднийг ирээдүйд үндэсний ухамсрыг тээгч гэж үзэхгүй байна. Энэ нь иргэдийн төрдөө итгэх итгэл маш муу байгааг харуулж байна.

Эдийн засгийн хөгжлийн явц дахь даяаршил ба үндэсний ухамсрын хоорондын эсрэгцэл нь судлаачид болон улс төрчдийн тулгамдсан асуудал болоод байна. “Манай улсын хоёр талын хөршүүд хоорондоо шөргөөцөлдөхгүй бол энэ шинэ зуунд асар хурдтай хөгжил суурь нь тавигдсаар байна¹⁴ гэжээ. Үүнтэй холбоотойгоор “энэхүү үйл явц дахь оросын үүрэг ролийн талаарх санал бодлоо “шинэчлэгдэн, нийгэм-эдийн засгийн хямралыг даван туулж, барууны улс орнуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэн бэхжүүлж байгаа өнөөгийн орос улс нь даяаршлын үйл явцын хөгжлийг илүү тэнцвэртэй, зохицолтой болгоход өөрийн жинтэй хувь нэмрийг оруулж чадах юм”¹⁵ гэжээ.

Юуны өмнө банк, санхүүгийн салбарт гадны нөлөөллийг бууруулах, үгүй болгохыг зорих нь үндэсний ухамсар маш их ач холбогдолтой. Улсын мөнгө санхүү бол дотоод хил хязгаар юм. Эдийн засгийн бүхий л салбартаа гадныхныг биш, өөрсдийн үндэсний хөрөнгөтнүүдийг дэмжих, ашигт малтмалын салбарт ч мөн адил дан өөрсдийн ноёрхлыг тогтоох бодлого баримталдаг хууль тогтоомжийг манай хууль санаачлагчид бий болгох хэрэгтэй. Хэрэв бодлого зөв байвал хөгжил ч шулуудана. Үр дүнд нь монгол үндэстэн хожино. Хэрэв тэгж чадахгүй бол энэ цаг үед эхэлж байгаа даяаршлын үйл явцын хүрээнд монгол үндэсний төр улс болон улмаар үндэсний ухамсар нь зөвхөн түүх болон үлдэх ажээ.

Даяаршлын үйл явц нь Монголын нийгмийн баруунд хандах хандлагад мөн нөлөөлж байна. Монголд олон нийт тэр дундаа залуу үеийнхэн нь баруун руу хандсан чиг баримжаатай болж ирж байна. Уг чиг баримжаа нь залуучууд монголын гэхээсээ илүүтэй барууны бүхий л зүйлс (тухайлбал хувцас, урлаг, кино, харилцаа, үнэт зүйлс)-ийг илүүд сонгож үзэж байгаагаар илэрч байна. Гадныхныг шүтэх үзэл монголд амь бөхтэй байна. Уг нь монголыг монголоор нь байлгаж, монгол нь монголдоо хайртай байлгах зүйл нь үндэсний ухамсар, үндэсний бахархал мөн. Тэгвэл Монгол улс түүхэн явцад хөгжиж ирснийхээ хувьд бидний өнгөрсөн цаг үе, хэв журам, ёс суртахуун, өвөг дээдэс зэрэг асуудлууд нь онцгой утга учрыг агуулсаар ирсэн.

Монгол улс уг нэгдэлд үндэсний ухамсраа хадгалан үлдэж, итгэл үнэмшлийн эрх чөлөөгөө бататган хангах ёстой. Учир нь “шинжлэх ухаан, шашин шүтлэг, ёс суртахуун болон бусад мэдлэг дээр үндэслэн мэдээллийн түвшинд олон улсын хамтын ажиллагаанууд хэрэгжиж эхлэх ба аж үйлдвэржсэн нийгэмд уламжлал болсон эдийн засаг болон нийгмийн институциудыг (хувийн өмч, үнэт зүйл гэх мэт) халах үйл ажиллагаа явагдаж, мэдлэг ба оюун ухаан дээр тулгуурлан аяндаа нийгмийн шинэ бодит ертөнц бүрэлдэн бий болдог”¹⁶ гэсэн тодорхойлолт байдаг. Хэрэв төгс хувилбараар даяаршлыг хэрэгжүүлж чаддаг бол энэ нь ядуурлыг устгах, хэв журмыг хангах, эв найрамдал, материаллаг бүрэн бүтэн байдал зэргээр илрэх байсан.

Монгол улсын уламжлал, түүхэн үндэс угсаа хэр чинээ гүн шингэсэн үндэсний ухамсартай байна төдий чинээ бид даяаршлын үйл явцад монголчуудыг тодорхойлж байдаг үнэт зүйлсээ хамгаалж чадна. Шотланд үндэсний хувцасны нэгэн хэсэг болох килт буюу шотланд эрчүүдийн банзалыг хуулиараа баталгаажуулсныг бид мэдэж байх ёстой.

Үндэсний ба угсаатны ухамсрыг буруу тайлбарлах нь орчин үеийн Монгол улсын гадаад, дотоод бодлогын хөгжлийн стратег, тактикийн шинжилгээнд буруу дүгнэлт хийхэд хүргэх аюултай. Үүний илрэл нь өнөөдөр нэг бол панмонголизм, эсвэл Чингис хаан, эсвэл хятадын эрлийз гэх мэт зүйлүүд яригдаад байгаа явдал. Энэ нь үндэсний ухамсар улс төрийн бодлогын түвшинд хүрч чадахгүй байгаагаар холбоотой. Ер нь бол үндэсний ухамсар нь биологийн биш, нийгмийн ойлголт юм. Монгол улс даяаршлах үйл явцын орон зай руу улам бүр гүнзгий орж байгаа бөгөөд энэ үйл явц нь эерэг нөлөөнөөс гадна ялангуяа үндэсний ухамсарт, тухайлбал, соёл-түүхийн үнэт зүйлсүүдийг усанд урсгах адил алга болгодог зэрэг олон сөрөг нөлөөг үзүүлдэг. Үүнтэй холбогдуулан Монголд үндэсний ухамсар төлөвших үйл явцад эдгээр хүчин зүйлүүдийн нөлөөлөх түвшинг тодорхойлоод үндэсний ухамсарт даяаршлах үйл явцын үзүүлэх сөрөг нөлөөг багасгах, эсвэл түүнээс сэргийлэхэд тохирсон нөхцлийг олох нь чухал. Өнөө цагт шарын шашныг Монгол үндэстний нэгдмэл соёлын цорын ганц эзэмнэгч гэж үзэх нь өрөөсгөл юм. Шашныг Монголын үндэсний ухамсрын бүтэц байгуулалтын гол багана гэж зарлах нь нийгмийн ухамсрын бусад хэлбэрүүдийн ач холбогдлыг зайлшгүй хязгаарлаж, ингэснээрээ түүний хүн хүндээ болон бусад хүмүүстэйгээ ертөнцөд зэрэгцэн амьдрах чадвартаа итгэж өв тэгш хөгжих боломжийг багасдаг.

¹⁴ Н.Бэгз.Глобальчлалын үеийн Монгол улсын хөгжлийн онол арга зүйн үндсэн асуудлууд. УБ.2001. х121

¹⁵ Дилигенский.Г.Г. Запад-враг или партнер? Россия в условиях трансформаций. М.,2002.х.69

¹⁶ Чемпиолли Э. Мировая политика в процессе перелома. Тб.,2003

Бид цаашдаа оршин тогтнохын тулд даяаршлагдаж адилсахын хэрээр үндэсний өвөрмөц байдлаа хадгалах ёстой. Үндэсний ухамсрын мөн чанар нь үүнд оршино. Энэ нөхцөл байдалд Монгол шиг бага буурай үндэстэн болгон өөрийн “соёлын нүүр царайгаа” авч хадгалах гэсэн эрмэлзэл нь түүхэн язгуур угсаагаа бэхжүүлэхэд нь тусална.

Даяаршлын үйл явц дахь монголчуудын үндэсний ухамсрыг эдийн засгийн утгаар ч мөн хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Жишээ нь: АНУ-д хамгийн сайн татвар төлөгчийг эх оронч хэмээн үздэг. Гэтэл манайд ийм бодлого байхгүй байна. Үндэсний ухамсрыг үндэсний соёл, морин хуур, монгол бичиг гэж үзэхээс гадна үндэсний үйлдвэрлэлийг бий болгох, ингэснээрээ Монголын тусгаар тогтнол цаашлаад Монгол үндэсний төр улс бэхжин хүчирхэгжихэд чухал. Бид өөрийн үндэсний соёл-түүхийн болон улс төрийн онцлогуудыг хадгалах, нөгөө талаас даяаршлаас гарч байгаа эерэг боломжуудыг өөртөө шингээж авах зорилгоор төрийн бодлого дахь үндэсний ба даяаршлын үйл явцын хоорондын тэнцвэрийг олох явдал юм. Энэ утгаараа нийгэм, соёл, эдийн засаг, улс төрийн орон зайд үндэсний ухамсар оршин тогтнох үндсэн нөхцлийг мэдсэнээр Монгол улсад даяаршлах үйл явцын сөрөг үр дагавараас зайлсхийх урьдчилсан нөхцлийг бий болох боломжийг олгоно. Үүнтэй холбогдуулан үндэсний ухамсар бүрэлдэн тогтох үйл явцыг судлахдаа түүнд тус дөхөм болдог оюун санаа, эдийн засаг болон нийгэм, улс төрийн хүчин зүйлсийг оролцуулан судалгааны хамгийн шинэлэг арга зүй, хэрэгслүүдийг ашиглах нь чухал. Ингэхдээ тэдгээрийг түүх, нийгэм, эдийн засаг, улс төрийн зохих хүрээлэлд нь тавьж үзэх хэрэгтэй. Гэтэл Монголын орон зайд онолын болон практикийн аль ч түвшинд оршиж байгаа үндэсний ухамсрын олон бүрдэл хэсгүүд онолын талаас одоо хүртэл бүтэц нь тодорхойлогдоогүй байгаа нь орчин үеийн Монголын нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд онош тавихад хүндрэл үүсгэж байж болох юм.

Ер нь үндэсний ухамсар, үндэсний эрх ашиг нь өөрийн үндэстний түүхийн суурин дээр тогтохгүй бол цаашдаа хөгжих боломжгүй байдаг. Учир нь үндэсний ухамсар нь улс үндэстнийхээ эх түүхийн мэдлэг дээр төлөвшдөг учраас түүхийн ухамсар нь чухал ач холбогдолтой. Үндэсний ухамсар нь түүхийн ухамсрын төлөвшлөөр тодорхойлогдоно. Тухайлбал бидний хийсэн судалгааны дүнгээр «Үндэсний ухамсар юугаар илэрхийлэгдэх вэ?» гэсэн асуултанд 73% нь эх түүхээр, 67,5% нь үндэсний бахархалаар, 9% нь улс төрийн үзэл суртлаар, 61,5% нь үндэсний эх хэлээр гэж хариулжээ.

Түүхийн ухамсрын эх сурвалж болох улс үндэстнийхээ түүхийг танин мэдэхгүйгээр үндэсний ухамсар хэзээ ч төлөвшихгүй. Үндэсний ухамсар түүхийн ухамсрыг уулзуулж буй цэг нь түүхийн мэдлэг билээ. «Аливаа үндэстнийг устгая гэвэл эх түүх рүү нь довтол, тэгсэн цагт тэднийг хааш нь ч хөтөлж болно» гэсэн үг байдаг. Чухам ийм учраас өөрийн төрийн байгуулалтын үйл явцад явагдаж байгаа олон үндэстнүүд өөрийн түүхийн соёлын үнэт зүйлсүүдэд ихээхэн анхаарал хандуулдаг.

Соёл ба шашин нь үндэсний ухамсрын “төв хэсэг” буюу түүний язгуурын түвшинг харуулдаг. Өнөөгийн Монгол үндэсний ухамсар нь гол төлөв соёл, уламжлал, шашинд түшиглэдэг. Хүний ухамсрын ихэнхдээ домгийн хэлбэрээр илэрхийлэгдсэн эхний суурь болох соёлын ерөнхий ойлголтын түвшинг давахгүйгээр үндэсний ухамсар нь ойлголтын түвшинд гарах боломжгүй байдаг. Энэ түвшинг угсаатны нийтлэг болгоны үндэс суурь, өөрөөр хэлбэл, үндэсний ухамсрын сэргэн мандалт явагддаг оюуны төв хэсгийн орон зай гэж хэлж болно. Тэгвэл Монголд үндэсний төслүүдийг анхлан нэвтрүүлэгчид нь манай зохиолчид, ардын аман зохиолчид, соёлын элитүүд байсан бөгөөд тэд соёлыг үндэсний ухамсрынхаа төвд тавьсаар ирсэн билээ. Гэтэл «үндэсний» гэдэг үг хамгийн түрүүнд соёлын, эсвэл шашны бус, харин улс төрийн зарчмыг илэрхийлдэг бөгөөд энэ нь үндэсний гэхээсээ илүү үндэстэн хоорондын төслийг тусгаж байна. Үндэсний ухамсар бүрэлдэн тогтох үе шаттай байдаг. Улс төрийн энэ онцгой үйл явц нь соёл, уламжлал, шашны обьектив нэгжээр байнга нөхцөлддөг. Нийгэм нарийн төвөгтэй замыг туулан үндэсний ухамсрыг түүхэндээ олж авах юм уу хөгжүүлдэг. 1990 оны ардчилсан хувьсгалын дараа Монгол улсын үндэсний ухамсрын хөгжилд шинэ үе шат бий болсон. Энэ үед монголын үндэсний соёлын иж бүрдлүүдийг бүрэлдүүлэх үйл явц шинээр эхэлсэн.

Харин өнөөгийн нөхцөлд үндэсний төр улсууд ба тусгаар тогтнолын хямрал улам бодит зүйл болж байна. Энэ хямралтай зэрэгцээд үндэсний ижил төстэй байдал өөрийн газар нутгийн хил хязгаарыг даван гарч байна. Хэрэв үндэсний төр улсуудад учрах энэ эсэргүүцлийн талаар бичсэн Фрэнсис Фукуяма өөрийн тусгаар тогтносон байдлыг хамгаалж чадахгүй бол гарч ирэх ноцтой асуудлыг анхааруулсан байдгийг бид мартаж ёсгүй. Энэ нөхцөл байдлын улмаас үндэсний ухамсарт нарийн төвөгтэй өөрчлөлтүүд учирдаг байна.

Үндэсний ухамсар бүрэлдэн тогтоход улс төрийн хүчин зүйл гол үүргийг гүйцэтгэдэг. Хэрэв бид улс төрийн ийм нэгжгүй байсаар байвал улс төрийн газрын зураг дээр угсаатны зүйн эртний үлдэцийн түвшинд л үлдэх болно. Угсаатан болгон улс төрийн түвшинд хүрч очиж чадахгүй нь мэдээж. Улс төрийн хүчин зүйлийн нэг чухал зүйл бол чухам энэ хэмжигдэхүүнд улс төрийн элит бүрэлдэн тогтож үйл ажиллагаа явагдаж, тэд өөрсдөө улс төрийн институтын зөвхөн агуулгыг төдийгүй бас хэлбэрийг бүрэлдүүлэх хариуцлагыг хүлээдэг¹⁷. Чухам тэд нарт л үндэсний улс төрийн билэг тэмдгийг бүтээж байгуулах нийгмийн хариуцлага оногддог. Гэхдээ энэ бол тухайн үйл явцад зөвхөн улс төрийн элитүүд оролцдог гэсэн үг биш. Үүнд мэдээж оюуны элитүүд, иргэд ч бас оролцдог. Гэвч соёлын үнэт зүйлийг сонгох үйл ажиллагаанд эцсийн шийдвэрийг улс төрийн элитүүд л гаргадаг гэдгийг онцлох хэрэгтэй. Үндэсний ухамсар нь улс төрийн ямар нэгэн томоохон шийдвэр, хуулийн төсөл, төрийн бодлогод маш ихээр нөлөөлдөг учраас манай улс төрийн элитүүд энэ асуудалд нухацтай хандах цаг нь нэгэнт болжээ. Үндэсний ухамсрын хувьд үндэсний эрх ашгийг мэдэрдэг улс төрийн элиттэй байх нь хангалттай биш. Харин эсрэгээр улс төрийн элит нь өөрийн

¹⁷ Нефедова.И.К. Проблемы национальной психологии. М.,1988.с.66.

улс төрийн үйлдлээр улс төрийн зорилгоо бодитой илэрхийлэн харуулах чадвартай байвал улс төрийн элит гэж хэлэгдэнэ. Мэдээж улс төрийн субъектүүдийн хувьд хувийн сонирхол нь эдийн засаг, улс төрийн сонирхолтой тэр бүр нийцээд байдаггүй. Гэхдээ хэрэв үндэстэн-улсын эрх ашгийг өөрийн ямар нэгэн үнэт зүйл, улс төрийн амбица гэх мэт эрх ашгаас дээгүүр тавьсан нөхцөлд энэ суурин дээр улс төрийн хүчнүүдийг, тэдэнтэй цуг нийгмийн янз бүрийн давхаргыг нэгтгэн нягтруулах боломжтой¹⁸. Үндэсний ухамсар бүрэлдэн тогтох үйл явцад манай улс төрийн элитүүдийн гүйцэтгэх үүрэг нь хамгийн их ач холбогдол бүхий үндэсний билэг тэмдгийг дотор нь бэхжүүлэх зорилгоор нийгмийн институтыг бий болгоход оршино.

Даяаршлах хандлага хүчтэй өрнөж буй энэ нөхцөлд ЮНЕСКО-гийн судалгаагаар жил тутам 18-20 хэл мөхөж байна гэсэн мэдээ байдаг. Хэл мөхөж байна гэдэг нь тэр тооны үндэстэн мөхөж байна гэсэн үг юм. УИХ үндэсний ухамсрын үзэл баримтлалыг үндсэн хуулийн заалтанд тусгаж өгөх хэрэгтэй байна. Үндэсний ухамсрыг залууст төлөвшүүлээгүйн улмаас гадаадад гарч амьдрах мөрөөдөлтэй, гадны хэлээр хагас хугас ярьдаг, монгол хэлээ төгс сайн мэдэхгүй бие хүмүүс болон төлөвшиж байна. Иймд боловсролын ба шинжлэх ухааны салбарууд энэ үүргийг гүйцэтгэх хэрэгтэй байна.

Мөн орчин үеийн Монгол улсын үндэсний төр улс болон үндэсний ухамсарт тулгарч буй шийдэх гол асуудал нь үндэсний ухамсар ба даяаршлах явцын хоорондох тэнцвэртэй байдлыг олоход оршино. Бидний үзэж байгаагаар мэдээллийн технологи, кибер орон зайн болон бусад хөгжлийн үр дүн чухал болохыг тэмдэглэж байна. Үндэсний төр улс болон үндэсний ухамсарт тулгардаг ноцтой зүйлийн нэг нь мэдээллийн нийгэм төрийн ялангуяа үндэсний институтын хувьд сөрөг хүчин болдог. Мэдээлэл ба мэдээллийн орон зай үндэсний ухамсар бүрэлдэн тогтоход чухал үүрэгтэй. Хэрэв мэдээллийн нөөцийг хайхрахгүй байвал энэ нь нийгэмд үндэсний ухамсрыг идэвхжүүлэх үйл явцад сөргөөр нөлөөлөх боломжтой. Мэдээллийн тархац ба үндэстэн, үндэсний ухамсар бий болохын хооронд шууд холбоо байдаг. Тэгвэл бид өөрийн орны алслагдсан асар уудам нутаг дэвсгэрийг маш ойрхон болгож байгаа мэдээллийн технологийг ашиглан нийгмийн болон үндэсний нийтлэгийн талаарх өөрсдийн төсөөллийг одоо өргөжүүлэх боломжтой болсон.

Мэдээллийн технологийн хурдацтай хөгжил нь даяаршлах үйл явцыг хөгжүүлэх боломжийг бий болгосон. Канадын философич М.Маклюэний хэлснээр даяаршлын эрин үе дэх бүх дэлхий “нэгэн тосгон” болж хувирсан. Үнэхээр харилцаа холбоо нь цаг хугацаа ба орон зайг мэдэгдэхүйц нарийсган орчлон ертөнцийг хүнд нүдэнд харж, гарт баригдахуйцаар ойртуулсан¹⁹.

Монголын хувьд глобалчлалын сорилтуудад дараах гарцууд байж болох юм. Үүнд:

Нэгдүгээрт, сэтгэлгээний тусгаар тогтнолыг бий болгох хэрэгтэй. Монголын эдийн засгийн хараат байдал нь сэтгэлгээний хувьд тусгаар тогтноогүйтэй холбоотой. Күнз, Бумбын үзэл, Нугаржунай төв үзэл, марксист үзэл, либерализм гэх мэт гадны үзэл суртлаар олон жил номлолоо хийсэн. Энэ асуудлыг шийдэх арга зам бол үндэсний ухамсрыг тэргүүн эгнээнд тавьж үздэг улс төрийн үзэл санааг бий болгох хэрэгтэй.

Хоёрдугаарт, Монголын тусгаар тогтнол маш эмзэг суурин дээр байна. Тусгаар тогтнолын баталгаа нь оюуны талаасаа үндэсний ухамсар, материаллаг талаасаа эдийн засгийн хараат бус байдал юм. Юуны өмнө бидэнд олон тулгуурт эдийн засгийн бодлого хэрэгтэй. (Эдийн засгийн жигд харилцаа) Энэхүү эдийн засгийн жигд харилцаа хэрэгжиж байж, нийгэм ил тод, шударга болж, далд эдийн засаг багасна. Төрийн оролцоо нь зохистой, хяналттай, татварын зөв бодлого явуулах ёстой болж байна.

Гуравдугаарт, эдийн засгийн ашиг сонирхлоо улам эрчимтэй хамгаалах шаардлагатай байна. Бидэнд бизнес эрхлэгчдээ дэмжих хэтийн бодлогод чиглэсэн зорилго, чин эрмэлзэл хэрэгтэй. Энэ нь төрийн бодлогын нэг бүрэлдэхүүн хэсэг учраас бодит үйл хөдлөлөөрөө хэрэгжүүлэх хэрэгтэй. Үндэсний санхүүгийн төсөл санаачлагыг бий болгох зэргээр нийгмийн дундаж түвшингийн хүмүүсийг өсөж дэвжихэд таатай нөхцлүүдийг бүрдүүлэх, мөн эрх чөлөөний байгууллагуудыг бэхжүүлэх хэрэгтэй.

Дөрөвдүгээрт, иргэд хэл, соёл, үндэсний өв уламжлалаа баяжуулан дэлгэрүүлэх нь зүй ёсны хэрэг. Өөрийгөө үнэлж хүндэтгэдэг хүн бүр бусдын өв баялагийг хүндэтгэж байх ёстой. Үндэснийхээ өв уламжлалыг хүндэтгэх нь чухал асуудал бөгөөд бид түүнийгээ бусдад таниулж дэлгэрүүлж, сурталчлан таниулах хэрэгтэй. Соёлын өв хөрөнгөө нээн илрүүлж баяжуулж байх нь дэлхийн соёлын өвд ач холбогдолтой зүйл гэдгийг мартаж өсгүй. Энэ нь хөрш зэргэлдээ орнуудынхаа соёлыг сонирхоод зогсохгүй, ямар авууштай тал байгааг олж мэдэх замаар эдийн засгийн, улс төрийн, соёлын амьдралын шинэ чанарыг хайх хэрэгтэй гэсэн үг юм.

Тавдугаарт, манай нийгэмд буй хууль тогтоомжуудын зөрчил, алдаа дутагдлыг арилгахыг хичээх ёстой. Нэг талаар энэ нь төр иргэддээ өөрийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаагаа нээлттэй ойр байлгах, өөрсдөдөө тулгамдсан асуудлууд тэр дундаа нэн яаралтай шийдэх хэрэгтэй байгаа төр иргэд хоёрын хоорондох хөндий байдлыг багасгах асуудлуудад анхаарал хандуулах гэсэн оролдлого хэрэгтэй байна. Нөгөө талаар иргэдийн хүсэл хэрэгцээ шаардлагад нийцсэн хуулийг бататгах гэсэн санаа юм. Ёс журамтай байдлын зэрэг тал нь иргэдийн улсаараа бахархах сэтгэлийг мөн өөрсдийн болон үр удмынхаа ирээдүйг гэрэлтэй сайхан байлгах хүслийг нэмэгдүүлэх болно.

Зургадугаарт, аливаа үндэсний төр улсын агуулга мөн чанар нь төр иргэндээ, иргэн төрдөө хандах ёсоор илэрхийлэгддэг. Төр нь иргэндээ хандах ёс нь үндэсний ухамсар, хүсэл зориг, үндэсний эрх ашиг сонирхлыг

¹⁸ Mead M, Metraux R. Aspects of the present. N.Y.,1980

¹⁹ Lerche Ch. The conflicts of globalization // Intern, j, of peace studies. Formosa,1998.p.59

илэрхийлсэн төрийн номлол, засаглах арга ухаан байдаг билээ²⁰. Тэр засаглал нь монголчуудын нийтлэг эрх ашгийг хамгаалахад чиглэгддэг байх ёстой. Нийтлэг эрх ашгийг хамгаалахдаа ямар хүсэл зоригт тулгуурлах нь тухайн төрийн хөгжлийн түвшин, түүхэн нөхцөл байдал, төрийн гүйцэтгэж буй үүрэг, иргэний нийгмийн төлөвшил зэрэг олон хүчин зүйлээс хамаарна. Жишээ нь өнөөгийн нөхцөлд иргэний нийгэм ардчилсан утгаараа төлөвшөөгүй, төрийн сөрөг хүчний статусаа эзэмшээгүй байгаа болон ардчилсан төр дөнгөж бүрэлдэж, төрийн албан тушаал нэр төр, ёс суртахууны үнэлэмжээ олоогүй яг л бизнесийн талбарт мэт байгаа үед ямар хүсэл зориг давамгайлах нь ойлгомжтой. Нийт үндэсний эрх ашгийг урьдал болгож, нийгмийн нийтлэг асуудлуудыг шүүн хэлэлцэж шийдвэрлэж байх нь хууль тогтоох байгууллагуудын нэн чухал үүрэг мөн²¹. Иймээс төр нь иргэдэд хандахдаа хэдийгээр янз бүрийн нөхцлийг ашигладаг ч гэсэн эцсийн эцэст төрийн бүрэн эрхт байдлаа бататгах хамгаалахад чиглэгдсэн төрийн бодлогод тулгуурлах нь чухал.

Долоодугаарт, бид харийн юм болгонд биширсэн, хүндэтгэлтэй хандсаар байтал Монголын үндэсний эрх ашиг, нийгмийн юм болгоныг юу ч биш болгоход хүргэх аюул заналхийлсээр байна. Гадаадаас орж ирэх хөрөнгө оруулалтууд, түүний эрх ашгийг тусгасан зэрэмдэг хууль, бодлогууд нь Монгол үндэсний төр улсыг устгаж магадгүй билээ. Манай улс төрийн элитүүдийн юун түрүүнд анхаарах ёстой зүйл бол үндэсний эрх ашгийг тусгасан, үндэсний ухамсраар номлолоо хийсэн үндэсний төр улсаа бэхжүүлэх явдал юм. Үндэсний ухамсрыг сэргээхийн тулд хамгийн түрүүнд түүнийг нэн тодорхой мэдэж, судалж, ялангуяа даяаршил нэрээр халхавчлагдсан том гүрнүүдийн колоничлолын бодлого, үйл ажиллагаанд автаад байгаа залуу үеийнхний оюун ухаанд суулгаж, амьдралынх нь хэвшил болгох хэрэгтэй. Ингэхийн тулд үндэсний ухамсрыг илэрхийлэгч бүрдлүүд болох үндэсний соёл, уламжлал, ёс заншлыг боловсролын тогтолцоонд системтэй оруулах нь шаардлагатай байна.

Наймдугаарт, Монгол хүнд монгол үндэсний үндэсний соёл, уламжлалыг амьдралд нь мөрдлөг болгох хэмжээний үйл ажиллагааг бий болгох хэрэгтэй. Өнөөдөр дэлхий дээр 30 сая гаруй хятад үндэсний цагаач иргэд хаана ч, юу ч хийж явсан хан үндэстэн гэдгээ мартаж өсгүй гэсэн тангарагтай явдаг юм билээ²². Үүний нэгэн адилаар монгол хүн Монгол үндэстэн гэдгээ санаж, үндэсний эрх ашгийг өмнөө тавьдаг тийм л үндэсний ухамсрыг төлөвшүүлэх хэрэгтэй. Хэдийгээр одоо хил нь байгаа ч хэл, соёл нь улам эрлийзжиж, хэрэглэгдэх, дэлгэрэх орон зай нь улам хумигдаж байна. ХХ зуунд монголчууд худам монгол бичгээ үгүй хийсэн нь Монголын үндэсний соёлыг устгах ажил болсон.

Мөн монгол хүний нэг бүдүүлэг авир бол нийгмийн шинэчлэлийн давалгаа бүхэнд өмнөх зүйлээ галдан шатаадаг зан юм. Ер нь аливаа шинэчлэлийг өөрийн үндэсний уламжлалд дулдуйдан хийхээс биш, бусдыг дуурайх нь угаас утгагүй, мөн явуургүй зүйл билээ. Ийм нөхцөл байдалд манай нийгэм дэх төрийн бус байгууллагууд, эсвэл холбоодын үйл ажиллагаа, төрийн байгууллагуудын бүхий л үйл ажиллагаанд үндэсний ухамсрыг сэргээх асуудлыг тодорхой нэгэн чиглэл, анхаарал тавих гол цэг болгон тогтмолжуулж, стратегийн зорилго болгох бодлогод шилжих хэрэгтэй. Энэ асуудалд өөрчлөлт шинэчлэх бодлогыг хэрэгжүүлдэг субъектүүд анхаарал хандуулах шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. Н.Бэгз. Глобальчлалын үеийн Монгол улсын хөгжлийн онол арга зүйн үндсэн асуудлууд. УБ., 2001.
2. Дилигенский.Г.Г. Запад-враг или партнер? Россия в условиях трансформаций. М., 2002.
3. Чемпиолли Э. Мировая политика в процессе перелома. Тб., 2003.
4. Нефедова.И.К. Проблемы национальной психологии. М., 1988.
5. Mead M, Metraux R. Aspects of the present. N.Y., 1980.
6. Lerche Ch. The conflicts of globalization // Intern, j, of peace studies. Formosa,1998.
7. Ц.Оюунбат. Монголын төрт ёсны уламжлал дахь түүх соёлын залгамж чанар. УБ., 2008.
8. Ё.Довчин. Харьцуулсан улс төр. УБ., 2006.
9. Ц.Оюунбат. Монголын төрт ёсны уламжлал дахь түүх соёлын залгамж чанар. УБ., 2008.
10. Д.Пүрэвдорж. Улаан гэрийн хоригдол. УБ., 2000.

²⁰ Ц.Оюунбат. Монголын төрт ёсны уламжлал дахь түүх соёлын залгамж чанар. УБ.,2008.х.15.

²¹ Ё.Довчин. Харьцуулсан улс төр. УБ 2006, х. 246.

²² Ц.Оюунбат. Монголын төрт ёсны уламжлал дахь түүх соёлын залгамж чанар. УБ.,2008.х.165

УЛС ТӨРД ИРГЭД ОРОЛЦОХ, ҮЛ ОРОЛЦОХ УЧИР

С.БАЗАРПҮРЭВ

*Профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхим*

Түлхүүр үг: улс төрийн оролцоо, сонгууль, улс төрийн үл оролцоо, абсентизм.

Abstract: Участие граждан в политике является неотъемлемым атрибутом современного общества. Оно дает людям возможность быть субъектами политики, влиять на решения важнейших общественных проблем и определять условия своего существования. Политическое участия представляет собой разновидность политической деятельности. Политическое участия-это деятельность граждан с целью влияния на принятие политических решений и их осуществление.

Иргэд улс төрд идэвхтэй оролцох нь нийгэмд тустай, улс төрийн соёл, зан үйл төлөвшихөд ач холбогдолтой хэмээн үзэх байр суурийг зарим нэг судлаачид хүлээн зөвшөөрдөг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Улс төрийн системийн үйл ажиллагаа, улс төрийн институтийн төлөвшил, улс төрийн шийдвэр боловсруулах үйл явцад иргэд нөлөөлөхийг улс төрийн оролцоо гэсэн ойлголтоор илэрхийлдэг.

Аль болох иргэдийг гэгээрүүлэн сэнхрүүлж улс төрийн шийдвэр гаргах процесст оролцуулах үйлсийг хэрэгжүүлэхэд улс төр судлаачид тодорхой хувь нэмэр оруулах учиртай болдог тул иргэдийн улс төрийн оролцоог шинжлэн судлах асуудал улс төрийн шинжлэх ухааны гол судлагдахуун болсоор ирсэн билээ. Гэвч огт судлахгүй байх эсхүл түүнд хайнга хандах байдал улс төр судлалд байгаа нь манай оронд улс төрийн абсентизм бүрэлдэх тодорхой нөхцөл болж байна.

Рационал сонголтын онол, улс төрийн оролцооны сэдлийг тайлбарлах онол, улс төрийн оролцоонд нөлөөлөх нийгмийн хүчин зүйлийн талаарх онол зэрэг нь иргэдийн улс төрийн оролцооны утга учирт тайлбар хийх оролдлогыг хийсэн байдаг.

Иргэд нь улс төрийн оролцооны гол субъект болдог. Өнөөдөр Монгол улсын иргэн сонголт хийх мөн хийхгүй байх бүрэн эрхтэй. Өөрийн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд идэвхтэй үйл ажиллагаа явуулж, сонирхлоо бүрэн гүйцэлдүүлэхийн төлөө хүч чармайлт гарган үр дүнд хүрэх нөхцөл манай нийгэмд бүрэлдсэн гэж үзэж болно. Иргэдийн дийлэнх нь улс төрд оролцох сонирхол нь тодорхой өөртөө хонжоо гаргах зорилгод захируулсан байдаг. Улс төрөөс дайжих нь мөн үүнтэй холбоотой. Улс төрийн шийдвэр гаргагч нь иргэдийн ашиг сонирхолд нийцэхгүй үйл ажиллагаа явуулах нь тодорхой болсон тохиолдолд хүмүүс улс төрөөс хөндийрч, оролцохоо больдог нь дэлхий олон улс гүрэнд түгээмэл түгсэн үзэгдэл юм.

Улс төрд оролцох олон янзын сэдэл байдгийг судлаачид нягтлан тодруулсан байна. Нийгэмд албан ёсоор ноёрхож буй үзэл суртлыг хүлээн зөвшөөрч, дэмжин улс төрийн амьдралд оролцох явдал нь хувь хүний улс төрийн үнэт зүйлс, нийгмийн улс төрийн үнэт зүйлстэй адилсах боломжийг хангадаг.

Хүний улс төрийн үнэлэмжийг үл ойшоож, улс төрийн системийн тулгасан дэг журмаар иргэдийн улс төрийн зан үйлийг зохицуулах хэм хэмжээгээр тодорхойлогдож байдаг сэдэл гэж байна. Засаглагчийг хүлээн зөвшөөрч түүнд захирагдсан зан үйлдэл юм.

Нийгэм, улс төрийн системд иргэн тодорхой нийгмийн үүрэг хүлээсэн байдаг. Нийгэмд ямар байр суурь эзэлж байгаа, өөрийн үнэлэмж зэргээс хүний улс төрийн зан үйл, оролцоо тодорхойлогдож байна. Хүмүүсийн нийгмийн байдал хэр доогуур байна төдий чинээ төр засагтай тэрсэлж байдаг үзэгдэл олон оронд илэрсэн.

Улс төрийн үйл явцад иргэд оролцоход нөлөөлж байдаг нийгмийн шинжтэй хүчин зүйлс бий. Институтжих үйл явц, нийгэм-эдийн засгийн тэгш байдлын төвшин, нийгмийн хөгжлийн эх сурвалж, нөөц, тогтвортой байдал зэрэг нь улс төрийн оролцоонд шууд ба дам нөлөөлдөг.

Нийгмийн амьдрал, мөн улс төрд оролцооноор иргэн хүн төлөвшиж, нийгмийн харилцаанд оролцон өөртөө ашиг гаргах боломж бүрддэг. Иргэн улс төрд оролцоход урьдчилсан нөхцөл шаардлагатай юм. Юуны өмнө улс төр сонирхох мөн улс төрийн үйл явц, үзэгдлийн талаар мэдээлэлтэй байх. Улс төрийн талаар мэдлэггүй, сонирхдоггүй хүмүүс нь улс төрийн бай-тоглоом болж байдаг төдийгүй, иргэд үл оролцсон улс төрийн шийдвэрийн хохирогч болдог. Иргэд өөрсдийн эрх ашигт нийцсэн төр засгийн зүгээс шийдвэр гаргах үйл явцад оролцохгүй тохиолдолд түүний өмнөөс эсхүл төлөөлөөд улс төрийн шийдвэрт нөлөөлөх гэсэн сонирхолтой “эрхэмүүд” төрдөг. Төлөөлөх гэдэг нь хуурмаг зүйл.

Улс төрийн үйл явцад иргэдийн тодорхой хэсэг нь оролцох гэсэн идэвхи ямагт байсан бөгөөд улс төрийн ямар ажиллагаа гэдгээсээ хамааран түүнд оролцох сонирхол харилцан адилгүй юм. Үүнтэй уялдан улс төрийн оролцоог тодорхойлох оролдлого барууны улс төр судлалд XX зууны 70 оны үеэс эхэлсэн.

Америкийн эрдэмтэд улс төрийн оролцоог тодорхойлох санаачлага гаргасан байдаг. Sidney Verba 1963 онд бичсэн “The Civic Culture” бүтээлдээ улс төрийн оролцооны асуудлыг хөндөж тавьсан байна. Төрийн удирдлагыг сонгож түүний үйл ажиллагаанд шууд болон дам нөлөөлөх зорилго бүхий хувь иргэний үйлдэл хэмээн улс төрийн оролцоог тодорхойлсон.

Орчин үеийн улс төр судлалын эх сурвалжид улс төр, удирдлагад оролцох нь хувь хүний хийх ёстой мэргэжлийн үйл ажиллагаа биш гэж тэмдэглэсэн байна.

Английн эрдэмтэн Geraint Pegg, америкийн судлаач Georgia Mazeri, австралийн Neil Day нар төрийн бодлогыг боловсруулан, батлан хэрэгжүүлэх үйл явцад иргэд оролцохыг улс төрийн оролцоо гэж санал нэгтэй үзсэн.

Нийгмийн баялаг ба нийгмийн үнэт зүйлсийг хуваарилах явцад нөлөөлөх үйл ажиллагааг улс төрийн оролцоо хэмээн америкийн улс төр судлаач Стивен Розенстоун, Жон Марк Хансен нар тодорхойлсон байдаг. Нийтээрээ харилцан ойлголцолд хүрэх үйл ажиллагааг улс төрийн оролцоо гэж америкийн судлаач Нейтан Теск үзсэн ажээ.

Дээрх судлаачид иргэдийн улс төрийн идэвхийг өргөн хүрээтэй тодорхойлжээ.

Үүний зэрэгцээ юунд чиглэсэнээр нь улс төрд оролцох үйлдлийг ангилах хандлага байна.

Засгийн газар, төрийн удирдлага руу чиглэсэн үйл ажиллагаа нь иргэдийн улс төрийн оролцоо болно гэж Л.Милбрат үзжээ.

Иргэн өөрийн нийгэм, эдийн засгийн эрх ашигт нийцсэн үйлдэл хийхийг засгийн газраас шаардаж тодорхой ажлын үр дүнг нэхэн улс төрийн идэвхи гаргадаг.

Б.Эпштейн зэрэг нь нийгэм-улс төрийн үнэт зүйлсийг өөрчлөх чиглэлтэй үйл ажиллагааны нэгээхэн хэсэг хэмээн иргэдийн улс төрийн оролцоог тодорхойлон уг үйл явцын үр дүнд төрийн түшмэлд нөлөөлөх таатай нийгэм улс төрийн үнэт зүйлс бүхий уур амьсгал зайлшгүй бий болдог гэжээ.

Иргэд улс төрд оролцоноор нийгэмд олон янзын ажил амжуулдаг байна. Бүлгийн болон хувь хүний сонирхлыг хамгаалах зэрэг тодорхой зорилгийг хэрэгжүүлэх хэрэгсэл болохын зэрэгцээ төрийн хүнд суртал, авторитар хандлагыг зогсоох үр дүнтэй арга барил болдог гэж Г.Перри үзсэн байна.

Хүний нийгэм, улс төрийн чадварыг хөгжүүлэхэд улс төрийн оролцоо нэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн иргэнд улс төр, ёс суртахууны боловсрол олгоход улс төрд оролцох хувь хүний идэвхи зайлшгүй хэрэгтэйг Г.Перри онцлон тэмдэглэсэн байдаг. Уг үзлийн хүрээнд иргэн хүн боловсролоор дамжуулан хариуцлага хүлээх ухамсар, сэтгэл төлөвшинө гэжээ. Хариуцлага нь “ажиллаж” байж л хөгжинө.

Элит-ардчиллын улс төрийн номлол боловсруулагчид улс төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийг өргөн хүрээтэй оролцуулах шаардлагагүй гэсэн байдаг. Сонгуульд санал өгөх төдий иргэдийг улс төрд оролцуулсанаар төлөөний ардчиллын системийн үр бүтээлтэй үйл ажиллагааг хангана гэж үзжээ.

Коммуникац болон боловсрол дээр тулгуурлан улс төрд иргэдийг оролцох бодит системийг бүтээх хэрэгтэйг тэмдэглэсэн тайлбарыг П.Бахрах, К.Пейтман, Б.Барбер нар хийсэн байдаг.

Улс төрийн лидерийг иргэдийн хяналтанд байлгах хэрэгсэл мэтээр улс төрийн оролцоог Р.Даль тайлбарлаж байв. Р.Даль 1971 онд бичсэн “Polyarchy: Participation and Opposition” бүтээлдээ улс төрийн оролцооны үр дүнд засгийн газар өөрийн иргэдийн эрэлт хэрэгцээг байнга мэдэрч хандах нь ардчиллын тулгуур ач холбогдолтой эх болсон үндэс гэж тэмдэглэсэн байна. Улс төрийн оролцоог хангахын тулд ардчиллын институцсэн баталгаа болох эрх (албан тушаалтныг сонгох эрх, сонгогдох эрх, сонгогчдын саналын төлөө тэмцэх эрх), эрх чөлөөн (үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн байгууллагын эрх чөлөө, мэдээллийн альтернатив эх сурвалжтай байх боломж) дээр тулгуурлах хэрэгтэйг Р.Даль сануулсан байна.

Р.Даль 1961 онд бичсэн “Who Governs? Democracy and Power in an American City” номондоо улс төрийн оролцооны идэвхийг хэмжих оролдлого хийж, улс төрийн оролцооны үндсэн аргыг тодорхойлсон байдаг. Юуны өмнө сонгуульд оролцож, санал өгөх. Улс төрийн кампант ажиллагаанд хамрагдах. Мөн орон нутгийн үйл ажиллагаанд оролцох. Америкийн улс төр судлаач Л.Милбрат улс төрийн идэвхийн төвшинг нэг хэмжүүрээр тодорхойлох хандлага дээр тулгуурлан хүмүүсийг улс төрд хамрагдах шатлалыг санал болгож, түүнд тохирсон иргэдийн гүйцэтгэж байдаг үүргийг ангилсан байдаг. Хүн амын гуравны хоёрыг хамардаг апат-идэвхгүй хэсэг байдаг. 60 хувь нь “ажиглагчид” (сонгуульд санал өгөгчдийг оролцуулаад). “Гладиатор” буюу улс төрд идэвхтэй оролцогсод 1-7 хувь байдаг.

Л.Милбратын дэвшүүлсэн улс төрийн оролцооны бүтцийн концепц нь судлаачдийн дунд хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүндтэй онолын баримтлал байв.

С.Верба, Н.Най, Ж.Ким зэрэг эрдэмтэд “Participation in America” (1972) бүтээл туурвиж, 1970 оны эхээр улс төрийн оролцооны бүтцийн талаарх мэдлэгийн санд шинэ уур амьсгал оруулсан билээ. Судалгааны үр дүнд дээрх эрдэмтэд улс төрийн оролцоог шинжлэх нэг хэмжүүрт хандлагыг олон хэмжүүрт хандлагаар солих шаардлагатай гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна. Улмаар 1978 онд улс төрийн оролцоог хэмжих шалгуур үзүүлэлтийг санал болгосон байдаг. Улс төрийн лидерт нөлөөлөх иргэдийн улс төрийн үйлдэл нь шахалт үзүүлэх, мэдээлэл дамжуулах аргаар хийгддэг. Засгийн газрын тогтоол, шийдвэр нийгэмд нөлөөлөх хэмжээний бодит үр дүн нь оролцооны цар хүрээг тодорхойлдог байна. Хүмүүсийн ашиг хонжоо гаргах сонирхлоос үүдэн гарах мөргөлдөөн, зөрчлөөс улс төрд оролцох иргэдийн тоо хамаардаг. Тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор бусадтай хамтрах ажиллах төвшинөөс болж иргэдийн улс төрд оролцох идэвхи шалтгаалдаг байна. Улс төрд оролцогчийн зүгээс хэр хэмжээний санаа санаачлага гаргаж байна гэдгээс улс төрийн оролцоог хэмжиж болно.

Дээрх хэмжүүрт тулгуурлан С.Верба улс төрд оролцох аргыг тодорхойлсон байна. Улс төрийн кампант ажилд хамрагдах, сонгуульд оролцож санал өгөх, орон нутгийн хэрэгт оролцож, нийгмийн ач холбогдолтой асуудлыг шийдвэрлэхэд төрийн албан хаагчтай иргэн холбогдож ажиллах мөн хувийн асуудлаа шийдвэрлэхийн тулд төрийн түшмэлтэй тодорхой иргэн харьцах явдал байдаг. Энэхүү аргууд дээр нэмэн улс төрийн оролцооны хоёр аргыг С.Верба, Н.Най тодорхойлсон байдаг. Судалгаанд хамрагдсан иргэдийн 22 хувь нь огт идэвхгүй буюу улс төрийн үйл явцад мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй хэсэг. Идэвхтэй бүлэг ба санал асуулганд оролцсон 11 хувь нь санал өгөх, улс төрийн кампант болон орон нутгийн үйл ажилгаанд идэвхтэй оролцохоо илэрхийлсэн байдаг.

С.Хантингтон, Ж.Нельсон нар нь нийгэм-эдийн засгийн шинэчлэл улс төрийн оролцоонд хэрхэн нөлөөлж буйг судлах явцад улс төрийн оролцооны хэлбэрийг нэрлэсэн байна. Сонгуульд санал өгөх, хандив өргөх, дэмжигчдийн эгнээг өргөжүүлэх зэрэг сонгуулийн үйл ажиллагаанд оролцох гэсэн хэлбэр байдаг.

Тодорхой хүмүүсийн сонирхлыг хөндсөн шийдвэр гаргах түшмэл, улс төрийн лидертэй холбоо тогтоож нөлөөлөх, лоббидох ажил нь улс төрийн оролцооны нэг хэлбэр гэж тодорхойлсон ажээ.

Төрийн шийдвэрт нөлөөлөх нийгэмлэгт гишүүнчлэх, зохион байгуулалтанд орж ажиллах нь улс төрийн оролцооны чухал хэлбэр юм.

Тодорхой ашиг гаргах зорилгоор төрийн түшмэлд нөлөөлөх санаа бүхий хувь хүний улс төрийн идэвхи ч гэсэн улс төрийн оролцоонд хамаардаг.

Төрийн эргэлт, улс төрийн аллага, бослого, самуун зэрэг хүчирхийллийн хэрэгсэл ашиглан засгийн шийдвэрт нөлөө үзүүлэх хэлбэр нь улс төрийн оролцоо болно гэж С.Хантингтон, Ж.Нельсон нар дүгэнсэн байна.

Иргэдийн зүгээс улс төрд оролцохдоо хүч хэрэглэх аргаас бусад хэлбэр нь хүлээн зөвшөөрөгдсөн, үл зөвшөөрөгдсөн байдаг. Электоратыг “худалдаж авах”, айлган сүрдүүлэх, сонгуулийн үр дүнг засварлах зэрэг “ажлыг” мэргэжлийн бус жирийн иргэн гүйцэтгэж байгаа тохиолдолд улс төрийн оролцоо хэмээн тооцож болно гэж дээрх судлаачид үзсэн байдаг.

Тайван бослого, цуглаан, шаардлага тавих зэрэг улс төрийн оролцооны хэлбэрүүд нь дэлхийн улсуудад харилцан адилгүй хүлээн зөвшөөрөгдөж байдаг. 1987 онд бичсэн “Gender differences in political participation” бүтээлдээ Кэрл Крист улс төрийн оролцооны таван хэлбэрийг тодорхойлсон байна. Эхний гурван хэлбэр нь С.Вербагийн дэвшүүлсэн хэлбэртэй утга нэг ажээ. Сонгуулийн үйл ажиллагаа, орон нутгийн нийгэмлэгт ажиллах, улс төрийн болон хувийн асуудлаар төрийн түшээдтэй холбогдон хамтран ажиллах зэрэг үйлдлүүд ордог.

Үлдсэн хоёр хэлбэрт үйл ажиллагаа ордог. Нэгд, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан улс төрийг ажиглах. Нэр дэвшигч эсхүл намын эрх ашигт нийцсэн зорилго чиглэлтэй итгэл үнэмшлийг бий болгох хэлэлцүүлгийг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан хийх жишээтэй. Хоёрт, улс төрийн оролцоо нь итгээд хэлбэртэй байдаг хэмээн тодорхойлон түүнд хоёр төрлийн үйл ажиллагааг багтаасан байдаг. Нэгд, шаардлага тавих, жагсаал цуглаан хийх, иргэний хөдөлгөө зэрэг “энгийн” хэлбэр ордог. Хоёрт, хууль бус бослого гаргах, хүч хэрэглэснээс үүссэн зөрчил, мөргөлдөөн үүсгэх, хувьсгалт хөдөлгөөнд оролцох иргэний үүргээ үл хэрэгжүүлэх гэх мэт түрэмгий шинжтэй үйлдэл байдаг гэж Кэрл Крист тэмдгэлсэн байна.

Улс төрийн оролцоог судлах явцад сонгууль судлал чухал ч улс төрд хэсэгчлэн оролцох хэлбэрийг шинжлэх нь бас л ач холбогдолтойг Перри онцлон тэмдэглээд тун бага судлагдсан гэдгийг анхааруулсан байдаг. Хотын даргад агаар бохирдолтын талаар гомдол гаргаж үр дүнд хүрэх нь хотын иргэдийн эрх ашигт парламентын сонгуулийн үр дүнгээс илүү нийцнэ гэжээ.

Улс төрийн оролцооны уламжлалт хэлбэрээс гадна улс төрд оролцох “шинэ хэлбэрийн” чиг хандлага давамгайлах болсныг тэмдэглэсэн байна. Тухайн оролцоо нь хэрэгжих бодит боломжтой гэдэг нь тодорхой болоод байна.

Орон нутгийн сайн дурын нэгдэлд иргэд хамрагдан орон нутгийн засаглалтай янз бүрийн харилцаанд орж байдаг. Зарим тохиолдолд дээрх хоёр субъект нь хоорондоо тэмцэлдэж байдаг. Мөн хамтран ажиллах тохиолдол ч гардаг. Нутгийн засаглагч шийдвэр гаргах эрхээ хуваалцаж, өөрт байгаа нөөц хэрэгслээ ашиглуулж хүн амын тодорхой хэсгийн сонирхолд нийцсэн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Перри болон түүний хамтрагчид Их Британ дахь улс төрийн оролцооны олон төрлийг шинжлэн хорь гаруй янзын үйл ажиллагааг тодорхойлон тогтоосон. Оролцооны арга хэлбэрээр нь адилтган нэгтгэж, санал өгөх, намын үйл ажиллагаа, хамтын нэгдэлд орж ажиллах, түшмэлтэй холбогдох, шууд үйлдэл, улс төрийн хүчирхийлэлд оролцох зэрэг зургаан бүлэгт хуваасан байдаг.

Орчин цагт оршин буй ихэнх улс орны иргэд нь улс төрийн үйл явцад оролцох боломж олгогдсон байдгийн нэг нь шийдвэр гаргагч төрийн засаглагч байгууллагыг сонгон шалгаруулж, бүрдүүлэх үйл ажиллагаанд оролцох явдал ч идэвхи муу байгаа төдийгүй өнөөдөр улс төрийн амьдралд оролцох иргэдийн тоо багасах чиг хандлага давамгайлах болов. Тухайн үзэгдэл нь иргэний нийгмийн бүтцийг төлөвшүүлэх, засаглалын үр ашигтай үйл ажиллагаанд нэмэр багатай учир абсентизмын асуудал нь улс төр судлаачид төдийгүй социумын олон субъектын сонирхлыг татаж түүнтэй “тэмцэх” арга хэрэгслийг хайх болжээ.

Манай оронд санал өгөхөөс санаатай зайлсхийх, сонгуульд оролцохгүй байх нь сонгуулийн явцад тогтмол тохиолдох, өргөн тархсан үзэгдэл болоод байна. Үүнийг Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн түүх гэрчилж байна. 1993 онд электоратын 92,7 хувь, 1997 онд 85,6 хувь, 2001 онд 82,9 хувь, 2005 онд 75 хувь, 2009 онд 73,6 хувь, 2013 онд 66,5 хувь ерөнхийлөгчийн сонгуульд санал өгсөн байдаг. Монгол Улсын Их Хуралын сонгууль ч гэсэн санал өгөгчдийн тоо буурсан үзүүлэлттэй байна. 1992 онд электоратын 95,6 хувь, 1996 онд 88,4 хувь, 2000 онд 82,4 хувь, 2004 онд 81,8 хувь, 2008 онд 76,5 хувь, 2012 онд 65,2 хувь нь сонгуульд нэр дэвшигчид саналаа өгчээ. Орон нутгийн сонгууль ч ийм үзүүлэлттэй байна.

Ямар нэгэн шалтгаанаар сонгуульд үл оролцох хүмүүсийн тоо ихсэх нь иргэний нийгмийн бүтэц төлөвших үйлд саад болж, сонгогдож гарч ирсэн засаглалын легитимт шинжинд эргэлзээ төрүүлэх шалтгаан болдог. Үүнийг залруулах санаа агуулан, олон оронд сонгуулийн хороо буюу сонгууль зохион байгуулагч итгээд нь толгойгоо гашилгаж, “аргаа бардаг”. Торгууль ноогдуулах эдийн засгийн аргаас гадна хууль цаазаар далайлган сүрдүүлж санал өгүүлэх ажлыг төр албадан хийдэг явдал олон оронд түгээмэл боловч үр дүн бага юм. Абсентизм нь засаглагч иргэдийн хооронд бий болсон улс төрийн зөрчлийн илрэл хэмээн ойлгож болно. Монголд сонгуульд оролцож санал өглөө хэмээн иргэдэд төрөөс ямар нэгэн урамшуулал ноогдуулдаггүй мөн санал өгсөнгүй гэж цээрлэл үзүүлдэггүй “эрх чөлөөтэй” байдаг нь сонгуулийн ирц бүрдэхэд нөлөөлдөг.

Абсентизмыг тойрсон зарим нэг асуудлыг шийдвэрлэх үйл явц нь төвөгтэй нарийн эдрээтэй юм. Санал өгөх эрхээсээ татгалзах шалтаг, шалтгаан нэн олон янзын байдаг ба улс төрийн шинжтэй ч байх нь бий.

Нийгэм дэх хамтын нэгдмэл санаа давамгайлсан тохиолдолд улс төрд, ялангуяа сонгуульд оролцох иргэдийн тоо нэмэгдэх боломжтой. Өөрийгөө бодох санаа нэмэгдэх үед амин хувийн ашиг хонжоо хайсан үйл ажиллагаа эрхлэж, улс төрийн асуудлыг шийдвэрлэх явц хойш тавигдаж байдаг.

Английн улс төрийн философич, социологич Zygmunt Bauman 2001 онд бичсэн “The Individualized Society” бүтээлдээ улс төрийн итгэл үнэмшил бүдгэрч, хамтын үйл хэрэгт сонирхол хөрсөнөөс улс төрийн оролцооны идэвхи сулардаг хэмээн дүгэнсэн. Их Британы социологич Giddens, Anthony “The Consequences of Modernity” (1990) зохиолдоо даяршил өргөжин тэлэх явцад үр ашиг нь буурсан засаглалыг хүлээн зөвшөөрөх хуучин хэлбэр мөхөж абсентистийн тоо нэмэгдэж байдаг гэжээ.

Америкийн эрдэмтэн Ronald Inglehart санал өгөх, сонгуульд оролцох зэрэг улс төрд оролцох энгийн хэлбэр нь ажил хэрэгч чанараа алдаж байгаа тул түүнийг улс төрийн оролцоог хангах илүү нарийвчлалтай системээр солих хэрэгтэй гэсэн байна. (Постмодерн: меняющиеся ценности и изменяющиеся общества // Полис. 1997. № 4.)

Нийгэмд буй абсентизмийн төвшин улс төрийн системийн нөхцөл байдлыг болон түүнд хандах иргэдийн хандлагыг тодорхойлдог байна.

Абсентизм нь нийгэм дэх хэлэлцэгдэх төвшинд төдийгүй шийдвэрлэгдэх арга хэмжээ авах цаг нь болсон гэдгийг өнөөдөр нүүрлэсэн бодит байдал илтгэж байна. Нийгмийн амьдралд ч абсентизм өргөн тархсан үзэгдэл. Бие хүн тодорхой цагт, тодорхой газарт байгаагүй тохиолдолд тодорхой нийгмийн үүргээ гүйцэтгэж чадахгүй байхыг абсентизм гэж ерөнхийд нь үздэг.

Төр, засгийн тэргүүн, засаглагч байгууллагын гишүүнийг сонгох үйл ажиллагаанд оролцож саналаа өгөхгүй байхыг улс төрийн абсентизм гэж ойлгож болно. Гэсэн хэдий ч иргэд татвараа төлж, хууль даган мөрдөж иргэний үүргээ биелүүлж байдаг тул саналаа өгөөгүй ч улс төрд хутгалдсан хэвээр л байдаг.

Улс төрийн үйл ажиллагаанд иргэдийг албадан оролцуулж, санал өгүүлэх хууль журам хүчингүй болгосон тэр цаг үеэс Монголд улс төрийн абсентизм үүсэж, газар авч байна. Иргэн өөрийн сонирхолд нийцүүлэн улс төрийн алив нэг зан үйлдэл хийх эрхтэй болсон өнөө цагт абсентизм нь нийгэмд байдаг л нэг энгийн үзэгдэл билээ. Нөгөө талаас сонгууль, улс төрийн үйл явдлыг хүмүүс тоохгүй байгаагийн илэрхийлэл гэж үзэх үндэстэй юм.

“Зан үйлийн хазайлт” буюу үйл ажиллагааны алдагдал хэмээн абсентизмыг үздэг ба нийгмийн жигд хөгжилд саад болж улс төрийн мөргөлдөөнийг өдөөх аюултай. Улс төрийн, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлийн нөлөөгөөр сонгуулийг зориуд эсэргүүцэж байгаа зан үйл юм.

Улс төрийн системтэй зөрчилдөхгүй хэмээн сонгуульд хандах сөрөг байр сууриа ил гаргадаггүй зан үйлтэй иргэд байна. Улс оронд болж буй үйл явцтай холбогдохгүй гэж сонгуульд үл оролцдог байна.

Төр улсын тогтворжуулах хүчин зүйл мэт абсентизмыг ойлгох байр суурь байдаг. Улс төрийн системд тавих шаардлага, түүнтэй заргалдах зүйлгүй гэдгийг илэрхийлэл хэмээн ойлгож болох хандлага юм. Одоо байгаа нөхцөл байдалд иргэд сэтгэл ханамжтай байж, улс төрийн маргалдаан, сөргөлдөөнд оролцохгүй зөвхөн өөртөө ашигтай зүйлээ хийх гэсэн бодлыг абсентизм гэдэг.

Сонгуульд оролцож санал өгөхгүй байх үйл явцад нөлөөлдөг бодит болон хүнээс хамаарах хүчин зүйл байж болдог.

Сонгуулийн систем, ямар төвшиний сонгууль, улс орны эдийн засгийн хөгжил, сонгогчийн нийгмийн байдал түүний хүн амын үзүүлэлт зэрэг нь бодит хүчин зүйлд хамаардаг бол субъектив хүчин зүйлд сонгогчийн хувийн болон психологийн чанар түүний соёл, санал өгөх үеийн улс төр, нийгэм, сэтгэл санааны нөхцөл байдал ордог.

Ямар төвшиний сонгууль явагдаж байна гэдгээс санал өгөгчдийн тоо тодорхойлогддог тал бий. Орон нутгийн болон улсын их хурал, ерөнхийлөгчийн сонгуульд иргэд харилцан адилгүй оролцдог. Эдийн засгийн өсөлт бууралт нь улс төрийн идэвхид нөлөөлдөг байдал ажиглагдсан байна. Иргэдийн насны бүлгээс хамааран сонгуулийн ирц тодорхойлогддог. Нас ахих тусам иргэд сонгуульд оролцох идэвхи нэмэгддэг хандлага олон оронд төдийгүй манай оронд ч байна.

Улс төрөөс хүнийсэх, санал өгөхгүй байх шалтгаан нь хувь хүний онцлогоос их хамааралтай байдаг. Нийгэм, улс төр-эдийн засгийн бодит байдлыг өөрчлөн өгөөжтэй болгоход хувь хүний оролцоо ямар ч үүрэггүй хэмээн ойлгосон тохиолдолд иргэд хүчгүйдэх сэтгэл төрж улс төрөөс жийрхэн хөндийрөн институционал бус улс төрийн идэвхи “амь” ордог.

Хүн амын дунд улс төр, эрх зүйн соёл доогуур байх тусам иргэд улс төрийн үйл явцыг үл ойшоож, хөндийрдөг гэсэн байр суурь судлаачдын дунд бий.

Эдийн засгийн хүндрэл сунжран удаашрах нь засаглагчид итгэх хувь багасаж улмаар сонгуулийн “нэр хүнд” унадаг байна. “Түүхий” сонгуулийн хууль, сонгуулийн хорооны хангалтгүй үйл ажиллагаа зэрэг нь сонгуульд оролцох “сонирхлыг” бууруулдаг. Сонгуулийн дараа сонгуулийн хуулийг засварлан сайжруулах “хөдөлгөөн” өрөндөг ч бүтэлтэй юм тун бага болдог. Сонгуулийн хуулинд электоратын “эрх ашиг” огт тусгагддаггүй.

Сонгуулийн кампант ажлын зохион байгуулалт, нэр дэвшигчийн “цариа”, сурталчилгаанаас хамааран түүнийг дэмжиж сонгогчдын тоо тодорхойлогддог байна. Таагүй цаг агаарын нөхцөл, сонгогчдийн эрүүл мэнд муудах зэрэг санамсаргүй зүйлээс болж санал өгөх ажилгаа боломжгүй болдог тал ч бий.

Сонгуульд үл оролцох, санал өгөх хүмүүсийн тоо бага байх нь цөөн тооны иргэд засаглагчийг сонгосон болж, нийгэмд эргэлзээ төрүүлдэг. Абсентизмтэй “тэмцэл” хийж түүнийг багасгах үр дүнтэй нийгэм-улс төр, эдийн засгийн арга бүтээх учиртайг эрдэмтэд сануулж байв. Иргэдийг ялангуяа нийгмийн ядуу хэсгийг халамжлан, тусламж дэмжлэг үзүүлэх ухаалаг зохистой улс төрийн бодлого баримтлахгүйгээр абсентизм даамжирч, идэвхгүй байдал олон түмнийг хамрах аюултай. Улс орны онцлогоос хамааран улс төрд оролцох иргэдийн тоо, идэвхи тодорхойлогддог. Монголд ч гэсэн өвөрмөц хүчин зүйл олон байгааг харгалзан судалгаа хийж улс төрийн оролцооны нарийн учрыг олох ажил нээлттэй байна.

НОМ ЗҮЙ

1. Sidney Verba “The Civic Culture” 1963
2. Robert Alan Dahl “Polyarchy: Participation and Opposition” 1971
3. Robert Alan Dahl “Who Governs? Democracy and Power in an American City” 1961
4. Carol Christ “Gender differences in political participation” 1987
5. Zygmunt Bauman “The Individualized Society” 2001
6. Giddens, Anthony “The Consequences of Modernity” 1990

УЛС ТӨРИЙГ ХЭРХЭН ОЙЛГОЖ, ТАЙЛБАРЛАХ ВЭ?

С.ЗУЛЬФИКАР

Доктор, дэд профессор, Удирдлагын академи

Улс төр судлал, нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч

Abstract: Politics, in its broadest sense, is the activity which people make, preserve and amend the general rules under which they live. Politics is thus inextricably linked to the phenomena of conflict and cooperation. On the one hand, the existence of rival opinions, different wants, competing needs and opposing interests guarantees disagreement about the rules under which people live. On the other hand, people recognize that, in order to influence these rules or ensure that are upheld, they must work with others.

Улс төр нь нийгмийн үзэгдэл болохын хувьд хүн төрөлхтний түүхтэй нас чацуу ойлголт гэж тайлбарлах нь бий. Тийм ч байж болно үгүй ч байж болно. Ямартай ч улс төр хүн төрөлхтний түүхийн бүхий л цаг үед хүмүүс нийгмийн харилцаанд оролцох, тэднийг чиглүүлэх арга хэрэгсэл болж байсан гэдэгтэй маргах зүйлгүй. Гагцхүү тухайн цаг үе, нийгмийн нөхцөл байдал, түүхэн өөрчлөлттэй зэрэгцэн харилцан адилгүй байдлаар ойлгогдож, харилцан адилгүй үйл явц, үр дүн дагуулж байв. Зарим тохиолдолд хүн төрөлхтний муу мухайн жишээ болж байсан бол зарим тохиолдолд сайн сайхан зүйлийн үр үндэс, улс орныг гэрэл гэгээтэй болгоход чиглэсэн урлаг хэмээн хэлэгдэж байжээ.²³ Үүний учир шалтгааныг хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад хүмүүсийн улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын хүрээн дэх харилцаа нарийн төвөгтэй, нийлмэл болж ирсэнтэй холбож ойлгож болох талтай.²⁴ Хүмүүс нийгмийн зохион байгуулалттай амьдарч байгаа нөхцөлд улс төрийн харилцаанд ямар нэг байдлаар оролцож байдаг.²⁵ Иймд тус өгүүллийн хүрээнд нийгмийн үзэгдэл, үйл явц болохын хувьд улс төрийг хэлэлцэж, тайлбарлахыг хичээсэн болно.

Хэл зүйн талаасаа улс төр гэсэн ойлголт *“Polis - полис”*²⁶ гэсэн Грек үгнээс гаралтай. Эртний Грект бие даасан хот улсуудыг полис гэж нэрлэдэг байсан бөгөөд тухайн хот улстай холбоотой аливаа асуудлыг шууд ардчиллын зарчмаар хэлэлцэж шийддэг байв. Тийнхүү хот улстай холбоотой ямарваа асуудлыг хэлэлцэж шийдэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл явцыг бүхэлд нь полис буюу одоогийн бидний ойлгож байгаагаар төрийн хэрэг буюу улс төр гэж томъёолох болжээ. Англи хэлэнд *“Politics”* гэсэн ойлголтоор төрийн институцууд, тэр тусмаа засгийн газрын бодлого, шийдвэр, үйл ажиллагааг бүхэлд нь ойлгоно гэсэн байна.²⁷ Түрэг хэлтэй угсаатны бүлгүүд улс төрийг *“Siyaset”* гэсэн Араб үгээр нэрлэдэг. Энэ үг нь “сургах, хөгжүүлэх, зохион байгуулах” гэсэн утга санаа илэрхийлдэг байна. Өөрөөр хэлбэл нийгмийн тогтолцоо, түүний бүрдэл болж байгаа нэгжүүдийг зохион байгуулах, шаардлагатай бол соён гэгээрүүлэх, сургах, эцсийн зорилго нь хөгжүүлэх үйлийг агуулдаг ажээ. Тийм ч учраас улс төр, улс төрчдийг тэрхүү хариуцлагатай үүргийг хэрэгжүүлэх чадвартай сонгомол хэсэг, нийгмийн бүлэг гэж ойлгох хандлага давамгайлдаг.

Тус өгүүллийг бичигч улс төрийг түүний хэл зүйн үндэс, агуулга, хамрах хүрээ, илрэх хэлбэр, шинж чанарыг баримтлал болгон тодорхойлж, тайлбарлахын зэрэгцээ нийгмийн амьдрал дахь тодорхой асуудалд хариулт өгч болох практик үйл явцаар жишээлэн ойлгох, үнэлэх дүгнэх боломжтой гэж үзэж байгаа болно. Тухайлбал, Улсын Их Хурлын Чуулганы хуралдаанаар Монгол улсын төсөв, төсвийн тодотгол хэлэлцэж байгаа үйл явц улс төр гэж чухам юу болохын ойлгомжтой жишээ юм. Төсөв хэлэлцэх явцад тодорхой салбар, орон нутгийн хүсэл сонирхол, хэтийн төлөвийн талаар УИХ дахь улс төрийн намуудын бүлэг, гишүүд байр сууриа илэрхийлж, хэлэлцэн, санал хурааж, шийдвэр гаргадаг. Тэрхүү хэлэлцүүлэг, шийдвэр нь улс төрийг маш тодорхой илэрхийлнэ. Гэтэл төсөв хэлэлцэх явцад иргэний нийгмийн төлөөлөл болсон төрийн бус байгууллагууд, бизнес эрхлэгчид төрийн ордоны гадаа жагсаал цуглаан зохион байгуулан төсвийн хэлэлцүүлэгт хүсэл сонирхол, ашиг сонирхлоо тусгах хүслэтэй байгаа бол үүнийг мөн адил улс төр хийж байна гэж ойлгоно. Үүнд тулгуурлан улс төр нь ямар үйл явц, ямар хүрээг, ямар цаг үед хэрхэн хамарч болохыг төсөөлөх боломжтой юм.

Үүний зэрэгцээ нийгмийн амьдралд өрнөж байгаа үйл явц, илэрч байгаа аливаа үзэгдлийн чухам аль нь улс төрийн шинж чанартай вэ? гэсэн асуулт тавигдах нь зүйн хэрэг. Учир нь нийгмийн амьдралд болж, өрнөж байгаа бүхий л юмс үзэгдэл улс төрийн шинж чанар, агуулгатай гэж үзвэл өрөөсгөл болох бизээ. Иймд улс төр гэсэн ойлголт, нэр томъёог нарийвчлан тодорхойлж, тайлбарлах шаардлагатай болж

²³ Daver, B. (1993). *Siyaset Bilimine Giriş*, Ankara: Siyasal Kitabevi, s.6

²⁴ Cam Esat (2000). *Siyaset Bilimine Giriş*, Itsanbul: Der Yay., s.23

²⁵ МУИС (2010), Улс төрийн шинжлэх ухаан, (ред. Ё.Довчин), 10 дахь тал

²⁶ Эртний Грекийн хот улс, төрийн зохион байгуулалтын хэлбэр. Нийгмийн зохион байгуулалтын хүсүүштэй буюу сайн хэлбэр гэж үзэж байв.

²⁷ The New Oxford Dictionary of English (2001), p. 1435

байна. Улс төрийг олон талаар, харилцан адилгүй байдлаар тодорхойлсон байх бөгөөд тэдгээрийг дараах хоёр хүрээнд авч үзжээ. Нэгдүгээрт: улс төрийн нам, нийгмийн тодорхой байгууллын түвшинд авч үзэх хандлага. Энэхүү хандлагын хүрээнд “Улс төр бол засгийн эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн, зөрчилдөөн бүхий үйл ажиллагаа” гэж үздэг. Тухайлбал, улс төрийн намууд сонгуульд өрсөлдөж байгаа нь засгийн эрх мэдлийн төлөөх өрсөлдөөний нэг хэлбэр бөгөөд энэ нь хэлбэр болон агуулга талаасаа улс төрийг бүрэн илэрхийлнэ. Хоёрдугаарт: төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх шат шатны байгууллага, хувь хүмүүс буюу улс төрийн субъект болохын хувьд улс төрийг тодорхойлох хандлага бий. Энэ хандлагын хүрээнд “Улс төр гэдэг нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх шат шатны байгууллагуудыг өөртөө агуулсан тогтолцоо юм.”²⁸ Иймд төрийн гадаад, дотоод бодлого, эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгох гэх мэт ойлголтууд нь бүхэлдээ улс төрийг илэрхийлнэ.

Ямартай ч нэгдүгээр хандлагын хүрээнд манай тооллын өмнөх үеийн Грекийн сэтгэгчид болон өнөө цагийн судлаачдын байр суурийг эсрэг тэсрэг шинж чанар, агуулга бүхий хоёр үндсэн бүлэгт авч үзэж болохоор байна. Улс төрийг тодорхойлох тэрхүү эсрэг тэсрэг үзэл хандлага нь улс төрийн харилцаа, үйл явц, тэдгээрийн үр дүн, үр нөлөөг өөртөө агуулсан гэдгийг тэмдэглэхгүй өнгөрч болохгүй. Эхний үзэл хандлагаар “Улс төр бол нийгэмд бий болсон зөрчил, тэмцэл, мөргөлдөөн” юм. Нийгмийн гишүүдийн ашиг сонирхол, хүсэл эрмэлзэл, үнэт зүйл, хандлага харилцан адилгүй байх бөгөөд энэ байдал нь нийгэмд зөрчил бүхий харилцааны үндсийг тавьж, басхүү өрнүүлж байдаг. Нийгэмд бий болсон аливаа оюуны болон материаллаг баялагийг эзэмших ашиг сонирхлын зөрчлүүд нь эрх мэдлийн төлөөх улс төрийн үйл явцын үндсийг тавьж, өрнүүлж байдаг. Улс төрийг энэхүү агуулга, мөн чанараар нь авч үзвэл улс төр бол нийгмийн харилцаанд бий болсон эрх мэдлийн төлөөх зөрчил, тэмцэл гэж ойлгогдож байна. Товчхондоо “улс төр хийхийн эцсийн зорилго нь эрх мэдлийг гартаа авах, түүнд тулгуурлан тодорхой ашиг сонирхлыг хэрэгжүүлэх”²⁹ явдал ажээ.

Харин үүний эсрэгээр зарим судлаачид улс төр бол эсрэг тэсрэг санаа үзэл бодол, ашиг сонирхлын зөрчлөөр хязгаарлагдах эсхүл хэмжигдэх төдий зүйл биш гэж үздэг. “Улс төрийн зорилго нь нийгмийн харилцаанд нэгдмэл байдал бий болгох, нийтийн ашиг сонирхлыг тодорхой субъектүүдийн ашиг сонирхлын дээр тавьсан бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх явдал юм.” Энэхүү тодорхойлолт нь идеалист эсхүл утопи шинж чанартай болохыг уншигч та эрх биш ойлгож байгаа болов уу. Үүнээс үзвэл улс төр гэдэг нь хүн бүрийн ашиг сонирхолд нийцсэн нийгмийн хэм хэмжээ, хэв журам тогтоох явдал болж байна.

Үүнээс үзвэл улс төрийг бүрэн төгс тодорхойлсон нэгдмэл ойлголт гаргах бэрхшээлтэй юм байна гэдгийг улс төр судлаачийн хувьд тэмдэглэх нь зүйтэй. Гэхдээ энэ нь улс төрийг нийтлэг байдлаар тодорхойлж, тайлбарлаж болдоггүй юм байна гэсэн санаа огт бишээ. Дээр сийрүүлсэн тодорхойлолтууд улс төрийн талаар нийтлэг ойлголт, чиг хандлага байгааг, өөрт нь тохирсон тодорхой хүрээ байгааг бэлхэнээ хэлээд өгч байна. Иймд дээрх хоёр үзэл хандлагын хүрээнд улс төр гэдэг нь “зөрчил, тэмцэл” хийгээд “нийгмийн зүй тогтол, эв нэгдэл, нэгдмэл байдал”³⁰ гэсэн нийтлэг ойлголтод хүрч болно.

Энэ бүгдэд тулгуурлан улс төр бол “Нийгмийн гишүүд (хүмүүс)-ийн амьдралыг зохицуулахад шаардлагатай хэм хэмжээ тогтоох, тэдний эрхийг хангах, хамгаалах зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаануудын цогц мөн” гэж тодорхойлж болохоор байна. Нийгмийн гишүүдийн олон талт хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлага бүрийг биелүүлэх гэхээсээ илүүтэй тэдгээрийн шийдлийг хайх олох үйл явц улс төрийг илүү тодорхой тайлбарлах юм. Хүмүүсийн хязгааргүй хэрэгцээг хангах шаардлага нь улс төрийг зайлшгүй болгож байдаг.³¹

Ийнхүү дээрх бичиглэлээр улс төрийг хоёр үндсэн хандлагын хүрээнд тайлбарлахыг хичээлээ. Харин улс төр, түүний хамрах хүрээг ойлгож мэдэх нь улс төрийн талаарх ойлголтоо илүү тодорхой болгоход тус дөхөм болох бизээ. Аливаа юмс үзэгдлийг тэдгээрийг агуулж байгаа хүрээгээр нь дүрслэн тайлбарлах нь тэдгээрийн талаар маш тодорхой төсөөлөл бий болгодог. Иймд улс төрийн хамрах хүрээг тайлбарлаж, зарим талаар дүн шинжилгээ хийх нь зүйтэй болов уу.

Үүнтэй уялдуулан “улс төрийн үндсэн үүрэг нь төрийн удирдлагыг хэрэгжүүлэх, нийтийн сайн сайхан, зүй зохистой байдлыг хангах явдал мөн” гэсэн ойлголтыг сэргээж сануулах нь зүйтэй болов уу. Улс төрийн эс бөгөөс улс төрийн институцуудын тухайд төрийн удирдлагыг хэрэгжүүлж, нийгмийн хэм хэмжээг зохистой байлгах үүрэг нь түүний түгээмэл, зайлшгүй хэрэгжүүлэх үүрэг гэж ойлгогдоно. Эртний Грект “Polis – хот улс” нь дан ганц нийгэм-улс төрийн зохион байгуулалт байхаар хязгаарлагдахгүй цэрэг арми, улс төрийн зохион байгуулалтыг өөртөө агуулж байжээ. Үүнээс үзвэл нийгмийн амьдралын бүхий л хүрээнд улс төрийн институцуудын үүрэг зайлшгүй байжээ. Гагцхүү улс төрийн хамрах хүрээг хүмүүс нийгмийн харилцаанд оролцох явцад нийтийн эсхүл хувь хүний өөрт нь хамаатай орчины алианаар нь дамжиж байгаагаар ялгах боломж бий. Тухайлбал, гэр бүл, найз нөхдийн ердийн харилцаа нь хувь хүнд өөрт нь хамаатай орчиныг тодорхойлох бол сонгуульд санал өгөх, төрийн байгууллагагай харилцах, татвар төлөх үйл ажиллагаа нь нийтийн буюу нийтлэг зохицуулалт шаардсан орчин бий болгож байдаг.

Нийгмийн тодорхой чиг үүрэг болохын хувьд улс төрийн хүрээг яг таг тогтоох зарим талаар боломжгүй юм. Хэдий тийм боловч энэ нь улс төрийн хүрээг тогтоох боломжгүй гэсэн үг бишээ. Учир нь нийгмийн амьдралд өрнөж байгаа мянга мянган харилцаа зарим тохиолдолд шууд улс төрийн хүрээний харилцааны шинж чанарыг агуулдаг бол зарим талаар улс төр-эдийн засгийн, нийгэм-улс төрийн гэх мэт шинж чанарыг

²⁸ Çztekin Ali (2010). Siyaset Bllimine Giriş, Ankara: Siyaset Kitabevi. S.23

²⁹ Kaplan Мьнци (2005). Politika Bilimine Giriş, Istanbul: Bilgi Yayınevi, s.17

³⁰ Duverger Maurice (1984), Politikaya Giriş. (çev. Semih Tiryakioglu), Istanbul: Varlık, s. 12

³¹ Heywood, Andrew (2007), Siyaset, (Ed. Bugra Kalkan), Ankara: Adres Yayınlar, s 2.

агуулна.³² Тухайн харилцааг хэрхэн ойлгож, тэрхүү асуудалд хэрхэн хандаж байгаагаас шалтгаалан улс төрийн агуулгатай юу? улс төрийн хүрээний юу? гэдгийг хэлэлцэх боломжтой. Хувь хүнд хамаарах асуудал нь зарим тохиолдолд дан ганц түүнд өөрт нь хамаатай байдаг бол зарим тохиолдолд улс төрийн шинж чанартай болох нь бий. Амьдрал ахуйгаа өөд татах гэсэн хувь хүний хүсэл сонирхол, эрх чөлөөнд хэн нэг нь хөндлөнгөөс хутгалдах эрхгүй боловч тухайн хүний эрхэлж байгаа бизнес захиргааны шийдвэр, татварын бодлогын улмаас түүний хувийн амьдралд хүндрэл бэрхшээл тулгарч, улмаар өрхийн орлогт нь нөлөөлөөд эхэлсэн бол хувь хүний асуудал байхаа больж улс төрийн шинж чанартай болж хувирна. Аристотелийн хэлсэнчлэн “Хүн бол угтаа улс төрийн амьтан” болж байгаа нь үүгээр илэрхий ойлгогдох бизээ.

Ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэлд хэрхэн хэлэлцэж байгааг тулгуур болгон улс төрийн хамрах хүрээг дараах байдлаар бүлэглэн авч үзлээ. Үүнд:

1. Улс төр бол төрийн эрх мэдэл, чиг үүрэг: Улс төр судлалын үндсэн сурах бичигт улс төрийн институцуудын эрх үүрэг, харилцааг эн түрүүнд авч үздэг. Тухайлбал, парламент, засгийн газар, шүүх, төрийн захиргааны байгууллагуудын эрх үүргийг, мөн түүнчлэн улс төрийн дэглэмээс шалтгаан тэдгээр нь ялгаатай эсхүл ижил төстэй байгаа эсэхийг өргөн хүрээнд хэлэлцэж тайлбарлажээ. Нийгмийн улс төрийн хүрээг маш тодорхой зааглаж болох, харж болох харилцаа яах араггүй улс төрийн институцуудад илэрч байдаг.³³ Иймд Монгол улсад засгийн газрын эрх үүргийг Үндсэн хуулиар хэрхэн тодорхойлсон, улс төрийн практикт хэрхэн илэрч байгааг хэлэлцэх аваас улс төрийн хүрээний асуудал хөндөгдөж байгааг бэлхэнээ ойлгох боломжтой. Энд төрийн эрх мэдэл гэсэн ойлголт бодит утгаараа мэдрэгдэнэ. Улс төрийн институцууд өөрт олгогдсон эрх мэдлийн хүрээнд нийгмийн олон талт харилцааг зохицуулах хууль баталж, бодлого тодорхойлж, шийдвэр гаргаж, тэдгээрийн гүйцэтгэлийг хангана. Шаардлагатай тохиолдолд төрөөс тогтоосон хууль дүрмийг зөрчсөн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх эрх эдэлж, чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Иргэн хүн өөр нэг иргэний өмчид халдсан, эсхүл түүний өмчийг дур мэдэн эзэмшсэн бол тэрхүү зөрчлийг төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх тодорхой байгууллага зохицуулах чиг үүрэг хүлээнэ. Үүнийг бид хуулийн байгууллагын эрх мэдэл, чиг үүргээс бэлхэнээ харж болно. Эрх мэдлээ хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай нөхцөлд албадлага хэрэглэх эрх гагцхүү төрийн эрх мэдэлд тулгуурлана. Шүүх байгууллага нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага болохын хувьд төрийн нэрийн өмнөөс шийдвэр гаргана. Шүүхийн шийдвэр нь тэрхүү эрх мэдлийг хэрэгжүүлэх чиг үүрэг хүлээсэн шүүгчийн хувь хүний хувьд гаргасан шийдвэр бус төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх зорилгоор шүүх байгууллагын нэрийн өмнөөс гаргасан шийдвэр гэж ойлгогддог. Иймд төрийн эрх мэдэл, чиг үүрэг яах араггүй улс төрийн хамрах хүрээний цөм нь болж байна. Үүнийг зарим талаар “улс төр бол засаг барих, засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх урлаг” гэж тодорхойлсон байдаг.

2. Улс төр бол нийгмийн үнэт зүйл, баялагийг хуваарилах үйл ажиллагаа: Тусгаар тогтносон, бие даасан, бүрэн эрхт улсад төрийн эрх мэдлийг төдийгүй материаллаг баялагийг зүй зохистой (шаардлагатай газар, хүмүүст, шаардлагатай түвшинд, хэрэгцээтэй цаг үед) хуваарилах шаардлага тулгарч байдаг. Учир нь улс төрийн институцууд нийгмийн баялагийг (нийтийн зориулалттай баялагийг) зохион байгуулах эрх мэдэл, чиг үүргийг өөртөө хадгална. Энэ тохиолдолд улс төрийг тэрхүү үнэт зүйлс, баялагийг зүй зохистой хуваарилах арга хэрэгсэл гэж үздэг. Нийгмийн баялагийн хуваарилалтыг улс төрийн хүрээний ямар байгууллагаар дамжуулж, хэрхэн, яаж хийх нь улс төрийн ач холбогдол, нийгмийн нөлөөг нэмэгдүүлдэг. Хамгийн гол нь нийтийн сайн сайхны тусын тул зориулагдах учиртай баялагийг зүй зохистой, шударга, үр ашигтай зохион байгуулах эрх мэдэл төрийн институцуудад олгогдоод зогсохгүй, нийгмийн зүгээс тийм хүлээлт үүссэн байдаг.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдээс, бизнес эрхлэгчдээс зарим нэг тулгамдаад байгаа асуудлыг хэрхэн талаар асууж тодруулахад дийлэнх нь төр анхаарахгүй байна, төр засаг шийдвэрлэх хэрэгтэй гэсэн хариулт өгдөг. Энэ нь нийгмийн гишүүд нийгмийн баялаг, үнэт зүйлийг хуваарилах, түгээн дэлгэрүүлэх чиг үүргийг төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа байгууллагууд угтаа бол улс төрийн хүрээний байгууллагууд хүлээнэ гэсэн ойлголттой байдгыг гэрчилнэ.³⁴ Иймд улс төрийн хамрах хүрээг тэрхүү баялагийг хуваарилах үйл явц, тэдгээрийн үр дүн, үр нөлөөгөөр төсөөлөх боломжтой. Гагцхүү нийгмийн баялагийг хуваарилах, дахин зохион байгуулах тухай ойлголт, үнэлэмж улс төрийн дэглэм, улс төрийн үзэл суртал, үзэл баримтлал, цаг хугацаа, орон зайнаас хамаарч ялгаатай байдаг гэдгийг тэмдэглэхгүй өнгөрч болохгүй.

3. Улс төр бол засгийн эрхийн төлөөх өрсөлдөөн: Энэхүү ойлголт нь улс төрийн хамгийн өргөн утга санаа, агуулга бүхий радикал шинж чанарыг илэрхийлнэ. Нийгмийн бүхий л хүрээнд эрх мэдэл хэрэгжүүлэх суурь нөхцөл нь засгийн эрхийг сонгуулийн болон сонгуулийн бус замаар авах явдал байдаг. Ардчилсан дэглэмтэй улсад засгийн эрхийг бүх нийтийн, чөлөөт сонгууль явуулах арга замаар шилжүүлдэг. Түүнчлэн засгийн эрхийн төлөөх өрсөлдөөн нь дан ганц сонгуулийн үр дүнд засгийн газар байгуулах эрх авсанаар хязгаарлагдахгүй. Засгийн эрхийг авсаны дараа ч энэхүү өрсөлдөөн нийгэм - эдийн засаг - улс төрийн хүрээнд идэвхтэй өрнөж байдаг. Тухайлбал, сонгуулийн үр дүнд олонх болж дангаар засгийн газар байгуулсан эсхүл, эвслийн засгийн газар байгуулах нөхцөл байдлын алнийг нь бий болгож байгаагаас шалтгаалж засгийн эрхийн төлөөх өрсөлдөөн харилцан адилгүй илэрнэ.

³² Türköne, Mьmtaz (2007) Siyaset, Istanbul: Lotus Yayinlari, s.5.

³³ Andrew Heywood, (2002), Politics: Second Edition, Palgrave Foundation, p.10

³⁴ Duverger, Maurice (1994), Siyaset Sosyolojisi: Siyasal Bilimin Iцgelerei, (Cev. Sirin Tekeli), Istanbul, Varlik, s.11

Дангаараа (олонхийн засгийн газар ч гэж нэрлэдэг) засаг барьж байгаа улс төрийн намын тухайд засгийн эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн нь харьцангуй тайван (тухайн улс төрийн нам дотор ямарваа зөрчил, бий болоогүй нөхцөлд) байдаг бол сонгуулийн үр дүн улс төрийн намдуудад эвслийн засгийн газар (цөөнхийн засгийн газар гэж нэрлэдэг) байгуулах нөхцөл бий болгосон бол засгийн эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн нарийн төвөгтэй болж хувирдаг. Учир нь эвслийн засгийн газарт улс төрийн сөрөг хүчний эсхүл эвсэлд орсон улс төрийн намуудын үйл ажиллагаа нь засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд сорилт, бэрхшээл, сул тал дагуулах нь түгээмэл ажиглагддаг. Үүнээс үүдэн цөөнхийн засгийн газар тогтворгүй, хэврэг байдаг бол олонхийн засгийн газар харьцангуй тогтвортой үйл ажиллагаа явуулж, засгийн эрх мэдлийг үр дүнтэй хэрэгжүүлдэг гэсэн нийтлэг ойлголт улс төрийн практикт тогтожээ. Ийм ч учраас засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх институтуудын эрх үүрэг, харилцааг судлах, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлст дүн шинжилгээ хийх судалгаа өргөн цар хүрээтэй хийгддэг. Үүнийг төрийн байгуулалтын хэлбэр, улс төрийн намын төлөвшил, улс төрийн соёл гэсэн ойлголт, үзэгдэл, үйл явцын хүрээнд судлах нь бий. Товчхондоо хэн, юуг, хэзээ, хэрхэн эзэмшиж, хэрэгжүүлэх вэ? гэсэн асуултын хариултыг засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх өрсөлдөөн гэсэн ойлголтын хүрээнд хэлэлцэх бүрэн боломжтой.

Нөгөө талаар дээрх тайлбар засгийн эрхийг хэрэгжүүлэх өрсөлдөөнд сөрөг хүчин бодит утгаараа идэвхтэй оролцогч субъект болохыг тодорхой харуулж байна. Сөрөг хүчин засгийн газрын бүрэлдэхүүнд ороогүй хэдий ч сүүдрийн засгийн газар байгуулах замаар улс төр – нийгэм - эдийн засгийн бодлогын хэлэлцүүлэг, хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж, өөрсдийн байр суурийг илэрхийлэх, шаардлагатай тохиолдолд чиглүүлэх боломж ардчилсан улс төрийн тогтолцоонд илэрхий ажиглагдаж байдаг.³⁵ Үүний сацуу засгийн эрх мэдлийг төрийн институтуудад хуваарилснаар харилцан хяналт тавих замаар засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх бололцоо бүрддэг.

Түүнчлэн засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх явдал нь дан ганц төрийн эрх бүхий байгууллагуудаар хязгаарлагдана гэж өрөөсгөл ойлгох аваас асуудлыг хэт явцуу хүрээнд авч үзэхэд хүргэх талтай. Монгол улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн нэгдүгээрт “Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж заасан нь засгийн эрх мэдлийг эзэмшигч, хэрэгжүүлэгч үндсэн субъект нь иргэд мөн гэдгийг, харин улс төрийн тодорхой субъектүүдэд тэдгээрийг төлөөлөх эрх үүргийг олгосон болохыг илтгэж байгаа хэрэг юм. Иймд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх өрсөлдөөнд сонгогчид, иргэний нийгмийн байгууллагууд цаашлаад эдүгээ дөрөв дэх засаглал гэж нэрлэгдэх болсон хэвлэл мэдээлэл чухал үүрэг оролцоотой болж байна.

4. Улс төр бол нийгмийн олон талт зөвшилцөлийг хангах зохион байгуулалт, үйл ажиллагаа: Улс төрийг тодорхойлж, тайлбарлах явцдаа миний бие улс төр бол нийгмийн олон талт сонирхлыг өөр хооронд нь уялдуулах үйл ажиллагаа гэдгийг тэмдэглэсэн. Иймээс улс төрийн хамрах хүрээг үүнээс салгаж ойлгох аргагүй юм. Нийгмийн олон талт ашиг сонирхлыг хүч хэрэглэх, цус асгаруулах арга замаар зохицуулах нь эцсийн дүндээ сайн үр дагавар дагуулдаггүй. Хүн төрөлхтний хийгээд дэлхийн улс орнуудын түүхч үүнийг гэрчилнэ. Талуудын сонирхлыг бүхэлд нь хангах боломжгүй байж болох хэдий ч нийтийн эрх ашигт нийцсэн шийдэл хайж олох нь улс төрийн үйл ажиллагаа явуулж байгаа эрх бүхий байгууллагын чиг үүрэг болж байдаг. Үүнээс улбаалан улс төр бол иргэншсэн нийгмийн, иргэншсэн тогтолцооны зохион байгуулалт, зүй зохистой харилцааны мөн чанарыг агуулна гэсэн гаргалгаа хийж болно. Иймд иргэншсэн, орчин үеийн нийгмийн зохион байгуулалт бүхий улс орнууд нийгмийн олон талт ашиг сонирхлыг уялдуулах, зөвшилцөлд хүргэх зохион байгуулалт, үйл ажиллагааг чухалчилдаг. Үүнийг хэрэгжүүлэхэд улс төр арга хэрэгсэл болохын зэрэгцээ тэдгээр зохион байгуулалт, үйл ажиллагаа нь улс төрийн хамрах хүрээг мөн адил тодотгоно. Францын философич, сэтгэгч Жан Жак Руссо нийгмийн тогтолцооны бүрдэл болж байгаа талуудын хооронд нийгмийн гэрээ үйлчилж байдаг, энэхүү гэрээний голлох субъект нь тэрхүү сонирхлыг илэрхийлэгч улс төрийн институтууд, хувь хүн, нийгмийн бүлгүүд гэсэн байдаг. Тухайбал, “Оюу Толгой” төслийн 2 дахь шатны хөрөнгө оруулалтын талаар талууд (улс төрийн нам, улс төрчид, үндэстэн дамнасан корпораци, иргэний нийгэм, хувь хүмүүс)-ын байр суурь харилцан адилгүй байгаа нь гайхах зүйл биш бөгөөд гагцхүү тэдгээр сонирхлыг хэрхэн уялдуулж, харилцан зөвшилцүүлж, шийдэлд хүрэх вэ? гэдэг нь чухал юм. Талуудын сонирхол ялгаатай байгаа бол улс төрийн хүрээний асуудал болох бөгөөд хэзээ нэгэн цагт дээрх сонирхлуудыг зөвшилцүүлж шийдэлд хүрч чадсан бол мөн адил улс төрийн хүрээний асуудал болно.

Эцэст нь тэмдэглэхэд дээр сийрүүлсэн тайлбар, улс төрийн хамрах хүрээг тодорхойлох оролдлого, жишээнүүд эрхэм уншигч танд улс төр гэж чухам юу болох талаар бага ч аугай төсөөлөл өгч чадсан болов уу гэж найдаж байна. Өөрийн бичсэн зүйлдээ тулгуурлан миний бие дараах дүгнэлтийг дэвшүүлж байна. Үүнд: Улс төр бол хүний нийгмийн зохион байгуулалтын салашгүй хэсэг мөн. Тийм ч учраас нийгмийг бүрдүүлж байгаа элементүүдэд улс төрөөс ангид байх боломж харьцангуй хязгаарлагдмал юм. Гагцхүү тодорхой асуудлын мөн чанар, хамрах хүрээ, ач холбогдол нь тодорхой цаг үе, орон зайд улс төрийн шинж чанартай эсэхийг тодорхойлдог байна.

³⁵ Rod Hague, Martin Harrop (2001), Comparative Government and Politics and Introduction, Palgrave, p.3

Улс төр нь нийгмийн харилцаанд бий болж байгаа олон талт ашиг сонирхлуудын зөрчлийн илрэл болж байдаг шигээ тэдгээрийг өөр хооронд нь зөвшилцүүлж, нийгмийн зүй зохистой зохион байгуулалт, харилцаа бий болгоход чиглэсэн үнэт зүйл, үнэлэмж, бүтэц, эрх мэдэл, чиг үүргийн нэгдэл болж байдаг. Энэ ч утгаараа улс төр бол хүн төрөлхтний нийгмийн амьдралын, нийгмийн тогтолцооны салшгүй хэсэг, нийгмийн хөгжлийг хангах зохион байгуулалт, харилцааны зайлшгүй нөхцөл болж, хүлээн зөвшөөрөгдсөн байна.

НОМ ЗҮЙ

1. Andrew Heywood, (2002), Politics: Second Edition, Palgrave Foundation
2. Andrew Heywood, (2007), Siyaset, (Ed. Bugra Kalkan), Ankara: Adres Yayinlar
3. Daver, Bülent (1993). Siyaset Bilimine Giriş, Ankara: Siyasal Kitabevi
4. Duverger Maurice (1984), Politikaya Giriş. (çev. Semih Tiryakioğlu), Istanbul
5. Duverger, Maurice (1994), Siyaset Sosyolojisi: Siyasal Bilimin Çgelerei, (Cev. Sirin Tekeli), Istanbul, Varlik
6. Cam Esat (2000). Siyaset Bilimine Giriş, Itsanbul
7. Kaplan Münci (2005). Politika Bilimine Giriş, Istanbul: Bilgi Yayınevi,
8. Rod Hague, Martin Harrop (2001), Comparative Government and Politics and Introduction, Palgrave
9. Тькөне, Мьmtaz (2007) Siyaset, Istanbul: Lotus Yayinlari
10. öztekin Ali (2010). Siyaset Bilimine Giriş, Ankara: Siyasal Kitabevi
11. МУИС (2010), Улс төрийн шинжлэх ухаан, (ред. Ё.Довчин)
12. The New Oxford Dictionary of English (2001),

УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ СУРТАЛ БА НОЁРХОЛ

Д.БУМДАРЬ

Доктор, дэд профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхим

О.ПҮРЭВДОРЖ

Улс төр судлалын тэнхимийн магистрант

Түлхүүр үг: Ноёрхол, улс төрийн үзэл суртал, хүч, ноёрхогч, эрх мэдэл

Товч агуулга: Энэхүү өгүүлэл улс төрийн үзэл суртал, ноёрхол хоорондын харилцан хамаарлыг улс төрийн антропологийн дагуу судлан шинжлэхэд чиглэсэн болно. Ингээд төрийн үзэл суртал ноёрхлоос үүдэлтэй юу үгүй юу гэх асуултад тулгуурлан улс төрийн үзэл суртал ноёрхлоос үүдэлтэй бий болдог нь тодорхой гэх нотолгоог гаргах зорилго тавьлаа. Доорхи өгүүллээр ноёрхлын шинж чанар, түүний үүсэл, цаашилбал ноёрхлыг бүрдүүлэгч ноёрхогч, ноёрхуулагч бүлгийн хоорондын харилцаа, шинж чанарыг тодруулах, эдгээрийг судалсан эрдэмтдийн бүтээлийг онцлон оруулсан. Мөнхүү ноёрхолтой холбоотойгоор түүнийг тогтоон барих, аль эсвэл олж авах гэсэн хүн төрөлхтөний түүхийн туршид үргэлжилсэн тэмцэл чухам ямар үр дүнд хүрч байсан талаар дурьдах бөгөөд эцэст нь улс төрийн аливаа үзэл суртал бүрийн үүсэл ноёрхолтой холбоотой бий болдогийг тодорхойлж дүгнэлт гарган судалсан болно.

Abstract: This article traces the domination and the political ideology, furthermore their relations and relativity according to political anthropological studies. It asks whether the origin of the political ideology is the domination or does not relate with the domination. This article surveys the origins and key features of the dominance, furthermore the relations and key features of the group which is under the dominance and the group which is have dominance. In that way it includes numerous works of scientists who are survey the domination and its relativity with other fields. Moreover this article concludes that give the answer the origin of the political ideology is the domination is proved by historical survey, human nature and the contradiction of the classes of society.

Английн Ливерпүүл (Liverpool) хотын рок-хөгжмийн Битлз (Beatles) домогт хамтлагийн гишүүд солгой гараараа ихэвчлэн тоглодог байсан. Тэдний хувьд солгой гар нь тоглолтод давамгайлах, тэргүүлэх үүрэгтэй байж. Хамтлагийн дууны үг, аяг зохиодог гол гишүүд нь ч мөн солгой гартнууд байсан бөгөөд тэд хамтлагтаа давамгайлах үүрэг гүйцэтгэж байж... Үүнийг анзаарч үзвэл давамгайлал (*Domination*) нь тоон болоод тоон бус хүчний ойлголт болох нь харагдана. Өөрөөр хэлбэл, тус хамтлагийн гишүүдийн дунд солгой гартан гитарчид, бөмбөрчин олонх нь байсан гэвэл тоон давамгайлал болох юм. Харин бодит байдал дээр хамтлагийн гишүүдийн дөнгөж хагас нь солгой гартнууд байсан гэх.

Нөгөөтэйгүүр, хамтлагийн дууны үг, аяг зохиоход давамгайлдаг гишүүд нь солгой гартан Пол Маккартни (Paul McCartney), баруун гартан Жон Леннон (John Lennon) нар л байсан. Энэ тохиолдолд давамгайлалын тоон биш хүч, тоон бус нөлөөллийн асуудал үүсэж байна. “Тоон” давамгайллын үед тоо хэмжээ нь гол хүчин зүйл байх бөгөөд харин “тоон бус” давамгайллын үед “хүч” хэмээх хүчин зүйл голлох үүрэгтэй. Хүч хэмээх нь эрдэм мэдлэг, авьяас чадвар, эрх мэдэл зэрэг олон зүйлийн цогц нэгдэл юм. Ийнхүү давамгайлал нь тоон болон тоон бус хүчин зүйлийн нөлөөллийг агуулдаг байна.

Энд бид давамгайллыг улс төрийн хувьд авч үзэх бөгөөд, улс төрийн үзэл суртал (*ideology*) нь давамгайллаас үүдэлтэй болохыг нээж харуулахыг зорьсон. Өмнөх жишээнээс дүгнэхэд, давамгайллыг нөхцөлдүүлэгч нь “тоон” хүчин зүйлийн зэрэгцээ “хүч” хэмээх хүчин зүйл байна гэж үзэж болох юм. Давамгайллын гол зүйл болох “хүч” хэмээх ойлголтыг задлан шинжилж тэр нь давамгайллыг хэрхэн нөхцөлдүүлж байдгийг нээн харуулах нь чухал юм.

Юуны өмнө хүч хэмээх ойлголтыг шинжилж үзье. Заяагдмал, олдмол хэлбэр бүхий эрх, эрх чөлөө, бяраа чадал, оюун ухаан, эрх мэдэл, нэр хүнд, албан тушаал, мэдлэг боловсрол, нийгмийн байр суурь болон мөнгө хөрөнгө зэрэг нь бүгд тухайн хувь хүний “өмч” юм. Эдгээр өмч бүр өөрт тохирсон тодорхой хэмжээний хүчийг агуулах бөгөөд ноёрхлын эх эс үүсвэр болдог хэмээн үзэж болох талтай. Өмч бүхий хүч, эсвэл хүч бүхий өмч нь нийгэм улс төрийн хүрээнд ноёрхлыг бий болгодог буюу хэнд өмч хуримтлагдана түүнд хүч бий болно, хэнд хүч хуримтлагдана түүнд өмч бий болох зүй тогтолтой байх. Иймээс энэ зүй тогтолын үүднээс авч үзвэл ноёрхлыг зайлшгүй үүсгэж болох юм.

Улс төрийн үзэл суртал ноёрхлоос үүдэлтэй бий болж байгаа гэж үзвэл ноёрхлын өөрийнх нь үүслийг танин мэдэх шаардлагатай болно. Хүн бүр байгалиас тэгш хүч буюу өмчтэй заяагдаагүй тохиолдолд хүмүүсийн хоорондын харилцаа хүч буюу өмчийн тэгш бус байдлаас шалтгаалж нийгэмд ноёлогч, ноёрхуулагч гэсэн

хоёр бүлэг үүсдэг. Эдгээр бүлгийн хооронд тэгш бус заяагдсан хүч буюу өмчийг олж авахын төлөө ноёлогч өөрийн байр сууриа хадгалах, ноёрхуулагч ноёлогчийн байр сууринд очих гэсэн зөрчилдөөнт харилцаа бий болдог. Энэ тохиолдолд зайлшгүй ноёрхол үүсэн гарч байгаа юм.

Харин хүн бүр байгалиас тэгш хүч буюу өмчтэй заяагдсан бол ноёрхол гэсэн ойлголт хүмүүсийн харилцаа, нийгэмд үүсэхгүй байх бололцоотой юу гэх асуулт урган гарч ирнэ. Өөрөөр хэлбэл хүн бүр бүгд адилхан хүч буюу өмчийн эзэн учраас бусдын хүч буюу өмчийг өөрийн болгох, түүнийг ашиглах, эсвэл түүнийг эзэмшигчийг өөрийн эрхшээлдээ оруулахгүй байх бололцоотой болов уу гэсэн далд санааг илэрхийлж байгаа юм. Энэ асуултанд хариулт өгөхөөр К.Маркс өөрийн онолын үндэстэй үзэл суртлыг ч гаргаж байсныг санахад ноёрхолтой холбоотой асуудал хичнээн чухал болох нь харагдана.

Эхний тохиолдолд хүн бүр байгалиас тэгш хүч буюу өмчтэй заяагдаагүй буюу эзэмшигч нарт өгөгдсөн өгөгдөлтэй шууд хамааралтай байсан бол хоёр дахь тохиолдолд мөн эзэмшигч нарт өгөгдсөн өгөгдөл байгаа боловч тэд бүгд адил тэгш эрхгүй байвал, байгалийн нөөц хязгаарлагдмал байвал гэсэн гадаад өгөгдөл нэмэгдэж байгаа юм. Үүнээс дүгнэхэд тохиолдол бүрийн үр дүнд ноёрхол үүсэж байна. Нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхол, зорилгыг илэрхийлэн нийгмийн оршин буй харилцаануудыг хадгалах буюу өөрчлөхөд чиглэгдсэн онолын үзэл, үзэл санааны системийг үзэл суртал хэмээн ойлгодог нь ноёрхлын үед мөн л нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхол нийгмийн бүлгүүдийн харилцаанд нөлөөлж байгаагай адил төстэй байдаг.

Нэгэнт энэхүү өгүүллээр улс төрийн үзэл суртал ноёрхлоос үүдэлтэйг тодруулах тул ноёрхол зөрчилдөөнт харилцаанд тулгуурлан үүсдэг гэдэгт үндэслэн энэхүү харилцаанд оролцогч ноёлогч, ноёрхуулагч бүлгүүдийн хоорондын харилцаа, онцлогийн талаарх зарим эрдэмдтийн судалгаа, дүгнэлтийг орууллаа.

Ноёрхуулагч бүлэг яагаад ноёлогч бүлгийн эрхшээлд байгаад байдаг вэ гэсэн асуултыг Америкийн улс төр судлаач, социологич, түүхч Чарлез Тилли (Charles Tilly) тавьжээ. Тэрээр өөрийн бичсэн **“Ноёрхол, Эсэргүүцэл, Зөвшөөрлийн тухай”** (Domination, resistance, compliance ... discourse) нийтлэлдээ “Ердийн ноёрхол нь дарлагдагч бүлгийн тодорхойлогдсон сонирхлыг байнга боомилж байдаг юм бол дарлагдагчид яагаад хүлцэн дагадаг юм бэ? Тэд яагаад тууштай тэмцэж, ядаж эсэргүүцдэггүй юм бэ? хэмээн асуугаад түүнд тохирсон хариултыг санал болгосон байна. Үүнд: Ноёрхуулагчид яг үнэн хэрэгтэй тууштай тэмцдэг хэдий ч тэр нь далд хэлбэрээр байдаг. Ноёрхуулагчид хүлцэнгүй байсныхаа төлөөсөнд ямар нэгэн зүйлийг авдаг. Тэр зүйл нь тэднийг аялдан дагагч болоход хангалттай зүйл байдаг. Үзэл суртлын өөр сонголтгүй, хавчлаганд байсан зэргээс шалтгаалж дарлагдагчид өөрийн жинхэнэ сонирхлыг ухамсарладаггүй. Хүч дарлагдагч бүлгийг байр сууринд нь хадгалдаг. Эсэргүүцэл, бослого тэмцэл нь их үнээр олдоно. Ихэнх тохиолдолд дарлагдагчид энэ шаардлагийн утга учрыг мэддэггүй” гэх зэргийг оруулж энэ бүгд тодорхой хэмжээнд нөлөөлдөг гэж үзсэн.

Мөнхүү ноёрхлын талаар өөр нэгэн өнгцөөс авч үзсэн жишээ байна. Йел (Yale)-н их сургуулийн антропологи, улс судлалын профессор Жэймс Скотт (James Scott) өөрийн **“Ноёлох байдал ба эсэргүүцлийн үйлдлүүд”** (Domination and The Arts of Resistance) бүтээлдээ өнгөлөн далдлах, бялдуучлах зэрэг сул дорой болон хүчтэй хүмүүсийн хооронд үүсэх харилцааг ойлгох нь ноёлогч болон захирагдагч шинжтэй хүмүүсийн ерөнхий онцлогийг ойлгоход тус болно хэмээсэн байдаг.

Тэрээр бүтээлдээ “хүчийг эзэмшигч хүн зөрүүлээд мастерийн тоглолтыг хийх бөгөөд дарлагдагчийн багны цаана юу оршиж байна, дарлагдагчийн жинхэнэ санаа зорилго юу байна гэдгийг танддаг. Ноёлогч нар үргэлжид тайзыг туйлын байдлаар удирддаггүй хэдий ч тэдний хүсэл ерөнхийдөө давамгайлдаг. Ноёрхуулагч ноёлогчийн өмнө өнгөн илрэлийг үзүүлдэг бол, ноёлогчийн ард буюу тайзны гадна далд илрэлийг өөртөө бий болгодог. Далд илрэл нь тайзны гаднах үг яриа, дохио зангаа, өнгөн илрэлийн үед үүсэх үзэгдэлтэй зөрчилдсөн зөрчилдөөн зэргээс бүрддэг” гэж ноёрхуулагчийн ноёлогчдоо хандах илрэлийн хэлбэрийг тодорхойлж, эдгээр хэлбэр нь хоорондоо эсрэг тэсрэг байдгийг онцолжээ.

Ноёрхуулагч өөрийн далд илрэлээ ил болгосон нэгэн жишээг бүтээлдээ оруулжээ. “Хатагтай Poyser George Eliot-ийн Adam Bede далд илрэлээ ил болгодог. Poyser газрын эзэн нь түүнийг яг нэг өт хорхой байгаа мэтээр харж байгааг анзаарсан хэдий ч түүнтэй ёсчлон мэндэлж хүндэтгэсэн уур амьсгалыг гаргадаг. Газрын эзэн түүний газар болон шинэ газар түрээслэгчийн хооронд үр тариа, бэлчээр газрыг солилцох санал тавьж түүний саналыг хатагтай хүлээж аваагүй тул газраасаа хөөнө хэмээн сүрдүүлдэг. Энэ нь Хатагтайг далд илрэлээ үзүүлэхэд хүргэдэг. Ийнхүү газрын эзэндээ тийм сул дорой дүйнгэ амьтад биш болохоо хэлж, ийм бодолтой хүн ганц би биш, ижил бодолтой хүмүүс байгаа хэмээдэг. Тиймд газрын эзний тухай далдуур яригддаг зүйлс үнэн болохыг хатагтай гэрчилж байгаа юм. Энэ бол эрх мэдэлтэнд үнэнийг хэлсэн жишээ юм” хэмээн далд илрэлээ илчилсэн тодорхой жишээг тайлбарлан оруулжээ.

Цаашлаад энэхүү ил далд илрэлийн дүнд үүсэх тэмцэл, тэмцлээс үүсэх үрдүнг тодорхойлохдоо “Доромжлол амссан хувь хүн өөртөө өшөө хорсол болон зөрчил тэмцлийн төсөөллийг бий болгодог боловч анги, давхарга, арьс өнгөний доромжлол зэргээс үүссэн төсөөлөл яваандаа нэгдсэн соёлын бүтээгдэхүүн болж болно” гэжээ.

“Далд илрэл нь дан ганц үг хэллэгээр илрэхгүй бөгөөд ихэнх тариачдын хувьд газрын эзэнд чанаргүй ажил хийж өгөх, татвараас зайлсхийх, хулгай хийх, хулгайн ан хийх зэргээр илэрдэг. Ноёлогч элитүүдийн хувьд далд илрэл нь нууц эд хөрөнгө хадгалах, дээрэмчдийг нууцаар хөлслөх, хээл хахууль авах зэргээр мөн илэрч болно” хэмээн далд илрэлээ илчлэхдээ гаргадаг хэлбэрүүдийн талаар тодорхой бичсэн байна.

Энэ мэтээр түүхэн хөгжлийн явцад ноёрхол хувьсан өөрчлөгдөж хэрхэн амьдрах талаар зарим зүйлсийг мэдэж тэрхүү мэдлэгтээ физиологийн давуу чанараа нэгтгэж чадсанаар балар эртнээс эхлээд өнөөг хүртэл бусдыг ноёрхох хүчийг хүн төрөлхтөн хуримтлуулсаар ирсэн байна. Тухайлбал, домог, шашны хүн төрөлхтөний сэтгэлгээнд ноёрхсон үед ноёрхогч бүлэг өөрсдийгөө бурхан тэнгэрээс заяасан ид шид, тодорхой чадвартай хэмээн зарим зан үйл, шүтээн зэргийг ашиглан дарлагдагч бүлэгт итгүүлэн үнэмшүүлж ноёрхлоо тогтоон барьж байлаа. Энэ байдал энэтхэгийн кастын систем, эзэн хаан(тэнгэрийн хүү гэх ойлголт)-ыг тахин шүтэх үзэл зэргээр олон зуун мянган үргэлжилсэн билээ. Хүн төрөлхтөний хөгжлийн түүх хүч, өмчийг өөртөө эзэмшиж ноёрхолд тэмүүлсэн онцлог шинжтэй байна.

Тэгвэл хүн төрөлхтөний хөгжил хүчийг олж авахдаа, хүчний харилцаанд орохдоо, хүчний харилцааг зохицуулах байдал зэрэг нь хувьсан өөрчлөгдөж ирсэн бөгөөд дотроос гадагш чиглэлтэй болохыг антропологич Эрик Вольф (Eric Wolf)-ын хүчийг дөрөв “(нэг дэх нь хүнд хамааралтай чадвар, чадамж бүхий хүч, хоёр дахь нэг нь нөгөөгөө давах, ноёрхолдоо автуулах хүч, гурав дахь нь хүмүүсийн чадвар чадамжаараа өрсөлддөг харилцааг зохицуулах хүч, дөрөв дэх нь бүтцийн хүч)” ангилсан ангиллаас дүгнэж болохоор байна.

Дундад зууны үед шашны томоохон мяндагтангууд ноёрхлыг өөрсдийн талд хадгалж байлаа. Аливаад шинжлэх ухаанчаар хандах гэсэн хүмүүсийг шашинд тэрсэлсэн этгээд хэмээн цалхаан цээрлүүлж цаазалж байлаа. Учир нь шашны талынхан өөрсдийн ноёрхлыг алдахгүйн тулд бусдад ноёрхлыг бий болгогч хүч буюу өмч (заяагдмал ба олдмол) хуримтлагдахаас сэргийлэх үйл ажиллагаа явуулж, нэгэнт ноёрхлыг ганхуулах хүч буюу өмч хэн нэгэнд бүрэлдсэн тохиолдолд түүнийг нухчин дарах сонирхолтой байжээ. Энэ үе бол консерватив үзэл суртлын эхлэлийн төдийгүй идэвхжлийн үе юм. Өөрөөр хэлбэл феодалууд, сүм хийдийн мяндагтангуудын ашиг сонирхолд нийцтэй үзэл суртал нь консерватизм болж уламжлалт феодалын нийгмийн байгууллаа буюу ноёрхлоо хадгалан үлдэхэд нь туслаж байсан.

Ийнхүү идеологийн хүрээнд ч тэр, нийгмийн анги давхаргын хүрээнд ч тэр нийцэлгүй олон зүйл гарч эхэлсэнээр Сэргэн Мандлын үеийг авчирч XVII зуунд баруун Европт хувьсгал гарч энэхүү феодалын байгууллыг үгүй хийхээр тэмцэх болсон юм. Энэхүү тэмцэл энэ үеэс өмнө эхлэлээ тавьжээ. Тодруулбал Италийн төрийн албанд олон жил зүтгэсэн Николо Макиавелли Италийн Маккиавелли “Принц хэмээх зохиолыг 1514 онд бичээд тухайн үеийн захирагч Лоренц Медичид өгсөн бөгөөд уг зохиол төрийг хэрхэн тогтноох, бэхжүүлэх, өргөтгөх, улс төрийн эрх мэдлийг хэрхэн байлдан олох ба тогтоон барих талаар өгч буй зөвлөгөө, зааварчлагыг агуулсан байдаг”. Ерөнхийдөө эзэн захирагч буюу нэг хүн (монарх эсвэл тиран) төр улсыг удирдах бүрэн эрхийг авах хэрэгтэй бөгөөд эзэн захирагчийн төр улсыг удирдан залах арга ухаанд төр улсын ирээдүйн дүр төрх оршино хэмээн үзсэн. Өөрөөр хэлбэл эзэн захирагч буюу нийгмийн дээд оройн давхарга төрийг удирдах ёстой гэсэн санааг тусгаад түүнд зориулан зөвлөгөө гаргажээ.

Үүний дараа францад Этьен де Ла Боэти (Etienne de La Boetie) хэмээх шүүгч, дипломатч Макиавеллийн уг зохиолд тусгасан санааг шүүмжлэн эсрэгцүүлсэн бүтээл болох Дуулгавартай байдал: Сайн дурын боолчлолын тухай (Politics of Obedience: The discourse of Voluntary Servitude)-ийг бичжээ. Уг зохиолд Ла Боэти Принцийг хэрхэн эрх мэдлээс нь түлхэн унагаах талаар мөн хувь хүний эрх чөлөөг хэрхэн хадгалж үлдэх талаар бичсэн юм. Мөн тэрээр ноёрхуулагч бүлэг ягаад ноёлогч бүлгийн эрхшээлд байгаад байдал вэ гэсэн асуултыг Америкийн улс төр судлаач, социологич, түүхч Чарлез Тилли-тэй адилаар дэвшүүлжээ.

Уг зохиолд Ла Боэти Принцийг хэрхэн эрх мэдлээс нь түлхэн унагаах талаар мөн хувь хүний эрх чөлөөг хэрхэн хадгалж үлдэх талаар бичсэн юм. Байгалийн хууль, байгалиас заяагдсан эрхийн дагуу тиран засгийн эсрэг тэмцэх тухай бичсэн хэдий ч дан ганц тоот тираны тухай бус төрийн тухай бүхэлд нь тэрээр өгүүлжээ. Тэрээр “Би өөрөөс нь хүч багатай нэг тиранд захирагдаж, удирдлаган дор нь зовж зүдэрч байгаа олон хүмүүс, олон хот тосгод, улс орныг ойлгохыг хүсч байна” хэмээн хүний ноёрхолд ягаад автдаг талаар эргэцүүлсэн байна. Ийнхүү “хүний сул дорой чанар үргэлжид хүчтэй байдлыг бий болгож чаддаггүй тул бид зөвшилцөл хийх, хүчийг дагах хэрэгтэй болдог. Сайн сайхан, сайн хувь заяанд тэмүүлэх зэргээр сайн гэсэн зүйлээ ямар эх сурвалжаас авч байгаагаа үл тоон бид өөрсдийн аятай байдлаа хэн нэгэн хайрлан, талархдаг хүнийхээ нэр хүнд, давуу талыг өсгөхийн тулд хөсөр хаядаг” гэсэн хариултыг олсон байна. Цаашлаад тэд (дарлагдагч бүлэг) хулгай зэлгий, харгислал зэргээс шалтгаалан зовж шаналж байна. Энэ нь цэрэг армийн зүгээс ч биш, зэрлэг омгуудаас ч биш ч, харин ганцхан ‘бяцхан хүн’-ээс болж байгаа юм, Геркулэсээс ч биш, Самсоноос ч биш, гэвч нэг л хүнээс болж байгаа юм. Энэ ‘бяцхан хүн’ улсын хамгийн хулчгар, хамгийн тунай муутай, дайны дарийн талаар огт төсөөлөлгүй нэгэн” гэх зэргээр ноёлогчийн чадварын талаарх үнэлэлт дүгнэлтээ гаргажээ.

Ла Боэтигийн хүссэн зүйл Бирмд тохиолдсон байна. Скотт бичихдээ “Бирмд болсон бослогын талаар Орвел бичжээ. Буддист лам нарын толгойлсон уг бослого Британийн колончлол, тэдний татвар зэргээс ангижирч утопи маягийн нийгэм байгуулна хэмээн амлаж хаан ширээг авахаар тэмцсэн байна. Бослогыг хэрцгий байдлаар дарж, амьд үлдсэн хуйвалдагчдийг цаазын тавцанд аваачив. Бирмийн энэхүү далд илрэл ил болсон гэнэтийн төдийгүй өөрийгөө нээлттэйгээр илэрхийлсэн жишээ юм” гэжээ.

Мөн олон түмний хүлээн зөвшөөрлийг хадгалж үлдэх нь тираны сонирхол бөгөөд гладиатор, жүжиг зэргээр олон түмнийг хөгжөөн баясах аргыг болон өөрийгөө өгөөмөр, саруул удирдагч хэмээн бахархуулж, хайрлуулах замаар олон түмнийг өөрийн ноёрхол дор тогтоон барьдаг гэж үзсэн.

Тэрээр “Ганцхан тираны эсрэг тулалдан тэмцэх огтоос шаардлагагүй, харин бид өөрсдийгөө боолчлолд оруулсангэрээнээсэтатгалзахюмболтиранавтоматаардийлдэнэ.Түүнээсйочсалгаадхэрэггүй,түүндгагцхүү юу ч өгөхгүй байх хэрэгтэй...Би тираныг нухчин дараад өгөөч гэж хүсэхгүй ээ, зүгээр л түүнд туслахаа болиоч” гээд хүлцэнгүй байдлаас гарах олон түмний хүч үл хэрэглэх эсэргүүцлийг тираны ноёрхлыг зогсоох арга зам хэмээн үзжээ.

Ла Боэти, Тилли, Скотт нарын дэвшүүлсэн санаанууд нь нийгмийн бүлгүүдийн аль хэсэгт ноёрхол төвлөрөөд байгаа талаар, ноёрхлыг нийгмийн бүлгүүдийн ноёрхлын туйл өөрчлөгдөж болох болон ноёрхол эсэргүүлэл хоёрын хооронд зөрчил үүсч болох зэргийг хамарсан байдаг.

Энэ мэтээр ноёрхлоор ангижирах, ноёрхлын туйлыг өөрчлөх гэсэн тэмцэл, үйл явдлууд болж, хөрөнгөтөн, ажилчин, тариачин зэрэг нийгмийн бүлгүүд феодалын нийгмийн байгууллын эсрэг идэвхийлэн тэмцэж байлаа. Зарим тохиолдолд хөрөнгөтний бүлэг феодалын нийгмийн байгууллын эсрэг тэмцэх хувьсгалт тэмцэлдээ хүчин мөхөсдөх үедээ нийгмийн бусад хэсгийн буюу ажилчин, тариачдыг уриалан татан оролцуулж, феодалууд, сүм хийдийн мяндагтангуудын мөлжлөгийг ухуулан таниулж хамтдаа тэмцэх болж эерэг үр дүнд хүрч байв. 1642-1649 оны Английн хөрөнгөтний хувьсгал, 1789-1794 онд өрнөсөн Францын Их хувьсгал зэрэг нь ноёрхлыг бүрдүүлэгч хүчийг эзэмших, ноёрхлоос ангижирах, тэнцвэржилтийг бий болгохын төлөөх тэмцлийн тод жишээ болсон бөгөөд эдгээр хувьсгал тэмцлүүд жам ёсны эрх зэрэг тухайн үеийн дэвшилтэд онолууд дээр үндэслэж байв. Энэ үед утопи үзэл, социалист үзлүүд идэвхжсэн бөгөөд дундад зууны зогсмол байдлаас хүн төрөлхтөн ангижирч аль үзэл суртлыг даган цаашлах вэ гэсэн асуулт тулгарсантай холбоотой.

Иймд нийгмийн хөрөнгөтөн ангийнхан либерализмын (либерализмын үзэл суртал нь аж үйлдвэр хөгжиж, анхны хөрөнгөтөн анги үүссэн үетэй зэрэгцэн үүссэн бөгөөд амьдрах, эрх чөлөөтэй байх, хувийн өмчтэй байх зэрэг нь хүний жам ёсны эрх гэсэн гол үнэт зүйлсийг баримталдаг) үзэл суртлыг дэмжиж байсан бол нийгмийн ажилчин, тариачны ангийнхан коммунизмын (коммунизмын үзэл суртал нь боол эзэмшил, феодал, капиталист формацууд хувийн өмчин дээр тулгуурладаг тул ангийн тэмцэл нь эвлэршгүй байдаг. Харин коммунист формац нийтийн өмчинд тулгуурладаг тул зөрчил тэмцэлгүй гэж үздэг) үзэл суртлыг дэмжиж байлаа. Тухайлбал францын хувьсгалын өмнөх социалист үзэл сурталчид нийгмийн анги давхрааны ялгарлыг эдийн засагтай холбон хувийн өмчийг нийтийн өмчөөр солин нийгмийн тэгш байдлыг хадгалан нийтийн сайн сайхан байдалд хүрч болно хэмээн үзэж байсан. Энэ нь цаашдын социалист, коммунист үзэл сурталчдад нөлөөлж уг үзэл суртлыг улс төрийн бодлого болгон хэрэгжүүлж байсан билээ.

Эдгээр үзэл суртал нь өөрөө бас ноёлох шинж чанарыг бий болгодог. Тодруулбал, дэлхийн хоёрдугаар дайны дараах хоёр системийн үзэл сурталын тэмцэл нь гадаад, дотоод аль ч талбарт ноёрхлыг тогтоохыг оролдож байсан юм. Марксын хэлснээр хүн төрөлхтөний түүх бол ангийн тэмцлийн түүх юм бол ангийн тэмцэл нь хүчний буюу өмчийн цаашлаад ноёрхлын төлөө тэмцэл юм. Өөрөөр хэлбэл хэт мөлжигч ноёрхлыг үгүй хийх, ноёрхлын тэнцвэржилт (сонгуулийн зарчим засаглал хуваарилах зарчмыг үүнд дурьдаж болно)-ийг тогтоох, бүр цаашилбал өөрсдийн ноёрхлыг тогтоох тэмцэл байнга явагддаг бөгөөд энэ нь улс төрийн янз бүрийн үзэл суртлыг бий болгох эх үндэс болдог байна. Нэг талаар Дэвид Саллах-н “**Ангийн ноёрхол ба Идеологийн Жанчлал**” (Class Domination and Ideological Hegemony) эсээнд гарсан “Марксист байр суурийн дагуу улс төр болон эдийн засгийн нийгмийн харилцааны дарамтаг байдалд оршин байгаа нийгмийн бүтэц нь идеологиос үүдэлтэй” гэдэг нь үүнийг баталж байгаа юм.

Ноёрхлыг тэнцвэржүүлэх нэг хэлбэр болсон сонгуулийн үйл явц нь ноёрхлыг бүрдүүлэгч гол шинж болсон хүчний харилцаан дээр явагдаж байна. Тодруулбал, сонгогч нэр дэвшигчид саналаа өгч байна гэдэг нь нэг талаар хүчээ өгч байна гэж ойлгогдох бөгөөд нэр дэвшигч сонгогчдод сонгуульд ялсны дараах өөрийн хүч (эрх мэдэл)-ний хүрээнд хийж гүйцэтгэх ажлуудыг санал болгодог нь нөгөө талаар ирээдүйд үүсэх хүчний харилцаа болж болох юм. Тиймд “хүчний харилцаа зөвхөн дээрээс доошоо чиглэсэн бус доороос дээшээ чиглэдэг байж болох тухай жишээ болно.”

Орчин үед улс төрийн үзэл суртлаар дамжуулан ноёрхлоо хэрэгжүүлэхээс гадна бодитоор буюу эдийн засгаар дамжуулан ноёрхлоо тогтоох неокOLONIZM-ын үзэл санаа юм. Энэ нь урьд аль нэг улсад колончлогдсон улсууд улс төрийн хувьд албан ёсоор бие даасан байдлаа олж сэргээсэн хэдий ч эдгээр улс орныг колончлолын өөр аргаар буюу эдийн засгийн колончлолын загвараар дахин колончлох гэсэн эзэрхэг орнуудын бодлого юм. Эдийн засгийн ашиг сонирхлоор хөгжил буурай улс орныг эзэрхэн ноёрхож өөрсдийн улс орнуудын (хөгжингүй улс орнууд) хөгжлийг нэмэгдүүлэн хурдасгах гэсэн бодлогын үргэлжлэл одоо ч мөн адил үргэлжилсээр байгааг олон жишээ харуулна. Тухайлбал үндэстэн дамнасан томоохон корпорациуд нь мөнгө олох, илүү их ашиг олох зорилгоор олонхийг мөлжих бодлогоо баримталсаар байна.

Эцэст нь дүгнэхэд Марксын онолын дагуу боловсрогдсон коммунизмын үзэл сурталын хувьд өмчид харъяалагдах хэв маягуудаас эдийн засгийн буюу материаллаг хэв маяг ач холбогдол өгч ноёрхлоос ангижирах арга замыг заадаг бол консерватизмын үзэл суртал өмчид харъяалагдах хэв маягуудаас нийгмийн байр суурьт ач холбогдол өгч ноёрхлыг хадгалахад чиглэдэг. Харин либерализмын үзэл сурталын хувьд өмчид харъяалагдах хэв маягуудаас эрх, эрх чөлөөнд ач холбогдол өгч ноёрхлоос ангижирах, ноёрхлыг тэнцвэржүүлэхэд чиглэдэг байна.

Улс төрийн үзэл суртал нийгмийн бүлэг хоорондын ашиг сонирхол, хүч буюу өмчийн төлөөх тэмцэлд тулгуурлан ноёрхолтой салшгүй холбоотойгоор бий болдог бөгөөд ерөнхийдөө ноёрхлыг олж авах, нэгэнт бий болсон ноёрхлоо тогтоон барих ашиг сонирхолд бүрэн нийцсэн хэрэглүүр болж улс төрийн үзэл суртал үүссэн хэмээн үзэж болох талтай.

НОМ ЗҮЙ

1. Д.Бум-Очир, “Улс төрийн хүн судлалын онолын үүд”, (Бемби сан хэвлэлийн газар; УБ, 2009)
2. Э.Тамир, Д.Биндэръяа, “Дундад зууны үеийн өрнөдийн улс төрийн сэтгэлгээний түүх”, нэгдүгээр дэвтэр, (Эрдэм номын дэлгүүр; УБ, 2009)
3. David L. Sallach, Class Domination and Ideological Hegemony, (The Sociological Quarterly, Vol. 15, No. 1, 1974)
4. Charles Tilly, Domination, resistance, compliance ... discourse, (Sociological Forum, Volume 6, Issue 3, September 1991)
5. Eric wolf, Distinguished lectures: Facing power- old insight, New Questions, (American Anthropologist, Vol. 92, NO 3, 1990)
6. Etienne de La Boetie, The Politics of Obedience: The Discourse of Voluntary Servitude, translated by Harry Kurz and with an introduction by Murray Rothbard, (The Mises Institute, Auburn, Alabama, 2008)
7. James C. Scott, Domination and the Arts of Resistance, (Yale University Press, 1990)

УЛС ТӨРИЙН МЕНЕЖМЕНТ МЭРГЭШИЛ БОЛОХ НЬ

Ц.БАТБОЛД

*Доктор, дэд профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхим*

Н.АРИУНАА

Улс төр судлалын тэнхимийн докторант

Түлхүүр үг: Улс төрийн кампани, улс төрийн менежмент, улс төрийн имиж

Краткий обзор: Политический менеджмент является одним из важнейших инструментов целенаправленного, сознательного, планомерного регулирования системы общественных отношений, а также поиска новых способов включения людей и их интересов в процесс преобразования жизни. Современный политический менеджер, должен не только организовывать и координировать деятельность различных государственных, политических или общественных организационных структур для реализации их миссии. Настоящее время по мере возрастания роли политического менеджмента в политической жизни в Монголии требуется подготовка молодых специалистов в этой области.

XX зууны дунд үе хүртэл сонгуулийн болон өөр бусад улс төрийн кампаниуд гол төлөв намын идэвхтнүүд, нэр дэвшигчдийн найз нөхөд, талархан дэмжигч иргэдийн хүчээр хийгддэг байсан ба тэд тухайн улс төрчдөд үнэн сэтгэлээсээ, сайн дураар тусалдаг байсан байна. Тэдний үйлдэл хувийн эрч хүч, санаачлага, өөрийн нэр дэвшигчээ ялахад нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх хүсэл тэмүүлэл дээр тогтдог байв. Тийм хүмүүсийн дотроос улс төрийн кампанийг гайгүй сайн зохион байгуулагчид бий болж, энэ салбарын шинжлэх ухааны мэдлэгт гэхээсээ өөрсдийн зөн бэлэг, туршлагад илүүтэй найдаж үйл ажиллагаагаа хэрэгжүүлж иржээ. Улс төрийн кампаны салбарт тэр үед мэргэшлийн хүмүүс байгаагүй юм.

Английн колончлолын эсрэг эрх чөлөөний тэмцлийг зохион байгуулагчдын нэг, “америкийн хувьсгалын хэвлэлийн төлөөлөгч” Самюэль Адамс /1722-1803/ улс төрийн кампанийг удирдаж хөглөх хэд хэдэн зарчим боловруулсан ба түүний ач холбогдол өнөө хэр алдраагүй байна. Үүнд:

1. Кампанийг удирдах чадвар бүхий байгууллагатай байх.
2. Хялбархан танигдах сэтгэл хөдөлгөсөн бэлэг тэмдэг ашиглах.
3. Сэтгэл хөдөлгөсөн бэлэг тэмдэг болон хялбархан тогтоогдох үг хэллэг бүхий зурагт хуудас ашиглах.
4. Олон нийтийн санаа бодлыг тодорхойлоход тустай үзэгч, сонсогч түмний анхаарал татсан мэтгэлцээн, бусад арга хэмжээ зохион байгуулах.
5. Нөхцөл байдлыг өрсөлдөгчөөсөө урьтаж тайлбарлаж, хяналтаа тогтоох
6. Мэдээлийн хэрэгслийн боломжтой бүхий л суваг ашиглаж байнгын нөлөөлөл үзүүлэх шаардлага

Мэргэжилтэн бол тухайн салбарын тусгай мэдлэг эзэмшиж бэлтгэгдсэн хүн, тэр хүрэн дэх ажил төрөл нь санхүүгийн хөрөнгө босгоход ач холбогдол бүхий эх үүсвэр болдог байна. Улс төрийн менежментийг мэргэшил болгон хувиргахад дараах гурван нөхцөл тавигддаг байна. Нэгд, улс төрийн менежментийн ач холбогдлыг ухамсарласан энэ салбарын үйлчилгээнд /социал хэрэгцээ гэж/ төлбөр хийхэд бэлэн улс төрчид, төрийн зүтгэлтнүүд бүрэлдсэн байх, Хоёрт, тодорхой нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх чадвартай, бодит хүмүүсийн санаа сэтгэлийг ойлгох, социал нөлөөллийн механизмыг харах, тэрчлэн улс төрийн удирдлагын зорилтуудын шийдвэрийн арга, технологийн тухай цогц мэдлэгтэй /шинжлэх ухаан дахь эмпирик хувьсгал/ чадварлаг улс төрийн менежерүүдийг тусгай мэдлэгээр зэвсэглэх шинжлэх ухаан байх, Гуравт, улс төрийн менежментийн салбарт үйлчилгээ үзүүлдэг төрийн бүтцийн агенлагаас хараат бус, бие даасан улс төрийн консалтингийн үйлчилгээний өрсөлдөөнт зах зээл хөгжих боломж бүрдсэн байх явдал зэрэг болно.

Тиймээс улс төрийн менежментийг мэргэшил болгон хувиргахад ийм төрлийн мэргэжилтнүүдийн социал хэрэгцээ нийгэм-улс төрийн шинжлэх ухаанууд дахь “эмпирик хувьсгалтай” давхацсан ба орчин үеийн нийгэм дэх нөхцөл байдал тэдний /мэргэжилтнүүдийн - Н.А/ өөрсдийнх нь чөлөөт мэргэшлийн боловсролтод саад учруулаагүй юм.

Одоо социал шинжлэх ухаануудад гарсан “эмпирик хувьсгалын” тухай ярих боломж олгосон шинжлэх ухааны мэдлэг дэх гурван чухал өөрчлөлтийн тухай өгүүлье.

Нэгд, Хавсрага социологийн хөгжилт. Энэ салбарын анхдагч нь Чикагогийн сургуулийн /1915-1935 онууд/ социологийн факультетийн бааз суурь дээр бүрэлдсэн. Энэ сургуулийнхан онолын дүгнэлтийг эмпирик судалгаануудтай нэгтгэх саналыг эрдэм шинжигээний олон нийтэд тавьсан явдал эрдэмтэн

судлаачдад социал бодит байдлыг судлах тодорхой хөтөлбөр боловсруулах шинэ чиглэлд хөтөлсөн юм. Энэ зорилтыг шийдвэрлэх нь хүн амын үнэт зүйлсийн хандлага, тэдний өрнөж буй нөхцөл байдал, улс төрийн лидерүүдтэй харилцах харилцаа зэргийг үнэн магадтай тодорхойлох боломжийг бүрдүүлэх арга зүйн хэрэгслийг бүрдүүлсэн нөхцөлд л боломжтой болсон.

Чикагогийн сургуулийнхан эмпирик судалгаанд түлхэц өгөөд зогсоогүй, нийгэмд эдгээр судалгаанд анхаарал хандуулах сонирхлыг өсгөж, түүний практик ач холбогдлыг улс төрчдөд үнэмшүүлж чадсан юм. Ерөнхийлөгч Ф.Рузвельт америкчуудын дунд өөрийн нэр алдрыг хэмжихийн тулд олон нийтийн санаа бодлын асуулгыг ашигласан анхны хүний нэг билээ. Ийнхүү улс төрийн кампаниудад эрдэмтэн- мэргэшилтнүүдийг татан оролцуулах анхны алхамууд хийгдсэн байдаг.

Хоёрт, XX зуунд хүмүүсийн үйл байдлыг тайлбарлахыг эрмэлзсэн сэтгэл судлалын шинжлэх ухаанд томоохон өөрчлөлтүүд гарсан явдал юм. Сэтгэл судлаачид улс төрийн үйлдлүүдэд сэдлийг төрүүлэгч социал нөлөөллүүдийн механизмыг олж, хүний хүрээлэн буй ертөнцийг танин мэдэх нууцад нэвтэрчадсан билээ. Хамгийн гол нь энэ мэдлэг практикаар дэвшигдсэн хэрэгцээ байсан. Бие хүний янз бүрийн асуудлыг шийдвэрлэхэд хүмүүст туслах зорилготой сэтгэл зүйн зөвлөгөөний хөгжил практик амьдрал дээр онолын мэдлэгийг үр дүнтэй хэрэглэх боломж олгосон байна. Чухамдаа сэтгэл зүйч- зөвлөгч нар улс төрийн лидерүүдийн имижийг бүрдүүлдэг анхны мэргэшлийн зөвлөхүүд болсон байна.

Гуравт, Анхнаасаа удирдлагын үйл явцын судалгааны чиглэлтэй төдийгүй мөн удирдлагын зоригыг хангах тодорхой загвар, технологи, практик зарчмуудыг санал болгодог удирдлагын тухай шинжлэх ухааны эрчимтэй хөгжил ажиглагдах болсон явдал юм.

XX зуунд шинжлэх ухаанд гарсан эмпирик хувьсгалын үр дүнг ганцхан улс төрчдөөс гадна үйлдвэр худалдаа эрхлэгчид, бизнесийн бүлгийнхэн хүртсэн билээ. Тэд “олон нийттэй холбогч” мэргэжилтэн, маркетингүүд, зар сурталчилгааны агентлагуудын үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих болжээ. Эдийн засгийн өрсөлдөөн хурцдах болсон нь зах зээл дээр бараа таваараа хөдөлгөх үйл ажиллагаагаа илүү өндөр төвшинд зохион байгуулах зорилгоор илүү санаачлагатай, овсгоо самбаатай нь шинжлэх ухааны судалгаанд хандах хэрэгцээ шаардлагыг нөхцөлдүүлсэн байна. Олон үйлдвэр худалдаа эрхлэгчид энэ салбарын эрдэмтдийн үйл ажиллагааг ивээн тэтгэж, тэр чанараараа энэ чиглэлийн үйл ажиллагааг мэргэшүүлэх явдалд томоохо хөрөнгө оруулалт хийж иржээ. Улс төрчдөд үр ашгийг харах чухал байдаг. Жишээ нь, хэрэглэгчид хандажмэргэшлийн өндөр төвшинд хийсэн зар сурталчилгаа сонгуулийн өмнөх кампанийн явцад өргөн олон түмний итгэл олж авахад нөлөөлөх боломжит хувилбаруудын сонголтыг бүрдүүлдэг юм.

1933 онд АНУ-д PR –ийн салбарт мэргэжилтнүүд Хойд Калифорнийд усжуулах “Төвийн хөндийн Төсөл” нэртэй төрийн хөтөлбөрийг дэмжих улс төрийн кампанит ажлыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Энд дурдахад өөрийнх нь бизнест усжуулах арга хэмжээ сөрөг үр дагавар авчрах магадлалтай гэж болгоомжилсон томоохон фирм болох “Пасифик газ & Электрик компани”-ий эсэргүүцэлтэй тулгараад байжээ. 1936 онд Цагаан ордонд PR-аар мэргэшсэн 146 мэргэжилтэн бүтэн цалинтайгаар, 124 мэргэжилтэн хагас урамшуулалтайгаар ажиллаж байжээ

Яг энэ цаг үед АНУ-ын үндсэн улс төрийн намуудын дэргэд PR-ийн албууд байгуулагдсан байдаг. 1936 онд Бүгд найрамдах нам PR эрхэлсэн захирлын албан тушаал баталсан байх жишээтэй. Ардчилсан намын төв байранд 1920-иод оны дунд үеэс PR асуудал эрхэлсэн өөрийн зөвлөхтэй байсан байна.

1968 онд Парис хотноо улс төрийн кампаны асуудлаарх зөвлөхүүдийн Олон улсын холбоо байгуулагдсан байна. Улс төрийн намууд болон бие даасан нэр дэвшигчидтэй байгуулсан гэрээний дагуу үйлчилгээ үзүүлдэг зар сурталчилгааны, PR, консалтингийн агентлагууд дэлхийн олон орнуудад үйл ажиллагаа явуулсаар иржээ.

Ийнхүү XX-XXI зуунд улс төрийн амьдралд гарсан олон чухал онцлогуудын нэг нь төрийн болон улс төрийн зүтгэлтнүүдийн нэр хүндийг өсгөхөд чиглэгдсэн зорилтыг шийдвэрлэх, олон нийтийн санаа бодолд улс төрийн байгууллагуудын эерэг дүр төрхийг бүрдүүлэх, мөргөлдөөн бий болох нөхцөл байдлаас гарах гарц, улс төрийн холбоодын ажил хэрэгч амжилтын үр дүнг хангах тусгай мэдлэгийг эзэмшсэн, эв дүй, чадвартай мэргэшлийн улс төрийн менежерүүдийн арми бүрэлдэн бий болсон явдал билээ.

Улс төрийн менежментийн эзлэх байр суурь улс төрийн социологи, сэтгэл судлал, удирдлагын тухай болон улс төрийн шинжлэх ухааны системд өссөөр байна.



Эцэст нь дүгнэж бичихэд энэ салбарын мэргэшсэн мэргэжилтэн, буйгууллага газар Монголын улс төрийн практик амьдралд зүй ёсны бодит хэрэгцээ болж байгаатай холбогдож улс төр судлалын салбарын сургалтын хөтөлбөрт тухайн чиглэлээр дагнасан мэргэжилтэн бэлтгэх ажлыг эрчимжүүлэх шаардлага тавигдаж байна.

НОМ ЗҮЙ

1. Г.В. Пушкарева. Политический менеджмент. М., 2002
2. Связи с общественностью в политике и государственном управлении. Под ред. В.С. Комаровского. М., 2001.
3. Dennis W. Johnson, ed., The Routledge Handbook on Political Management /Routledge, 2008/ USA
4. Douglas Lathrop, "Political Consultants, Interest Groups, and Issue Advocacy Work: A Lasting Relationship," in Johnson, Routledge Handbook on Political Management. USA

АРДЧИЛЛЫН ТАЛААРХ Ж.ДЬЮИГИЙН ҮЗЭЛ САНАА

И.ЛХАМ

Доктор, дэд профессор ХААИС, ЭЗБС, ХЭЗТ

Г.УЯНГА

ХААИС, ЭЗБС, ХЭЗТ докторант

Түлхүүр үг: нийгэм, ардчилал, боловсрол, иргэн, сургууль. Ардчиллын талаарх Ж.Дьюигийн үзэл нь түүний философи дахь инструментализмтай салшгүй холбоотой юм. Ж.Дьюигийн улс төрийн үзлийн үндэс, суурь нь философи, улс төрийн бодлого, ёс зүй гурвын нэгдэл юм. Өөрөөр хэлбэл тэрбээр философи, улс төрийн бодлого ба ёс зүйг салшгүй харилцан холбоотой авч үзснээрээ уламжлалт либераль үзлээс онцлог бөгөөд ялгаатай юм.

Товч агуулга: XX зууны Америкийн нэр нөлөө бүхий прагматист философич Ж.Дьюигийн ардчиллын талаарх үзэл нь түүний философи дахь инструментализмтай нь салшгүй холбоотой юм. Ж.Дьюигийн улс төрийн үзлийн үндэс, суурь нь философи, улс төрийн бодлого, ёс зүйн зорилгын нэгдэл юм. Өөрөөр хэлбэл тэрбээр философи, улс төрийн бодлого ба ёс зүйг салшгүй харилцан холбоотой авч үзснээрээ уламжлалт либераль үзлээс онцлог бөгөөд ялгаатай юм.

Ж.Дьюигийн улс төрийн үзлийн гол цөм нь ардчиллын тухай асуудал юм. Тэрбээр ардчиллын тухай уламжлалт ойлголтоос татгалзаж, ардчиллын талаарх либераль үзэл баримтлалд өөрийн гэсэн өвөрмөц, шинэ хандлагыг бий болгожээ. Ж.Дьюи ардчилал гэдгийг улс төрийн онцгой хэлбэр, төрийн байгууламжийн хэлбэр гэдгээс илүү өргөн утгаар, амьдралын хэв маяг болохынх нь хувьд ёс зүйн утгаар хэрэглэсэн байна. Тэрбээр неолиберализмын судлах, анхаарах гол асуудал нь боловсрол хэмээн үзэж, улмаар боловсрол бол нийгмийн хөгжлийг хангах гол хүчин зүйл, сургууль нь хүүхдийг ардчиллын соёлд сургах гол орчин болохыг нотлон харуулахыг зорьжээ. Тиймээс ч өнөөдөр Ж.Дьюиг сонирхон судлах хандлага дахин сэргээд байна.

Резюме: Джон Дьюи - самая крупная фигура в американской философии XX столетия. Он попытался обосновать свою теорию демократического общества. Свою важнейшую цель Дьюи видел в обосновании, защите и расширении демократии. Дьюи отстаивал более широкую трактовку демократии, считая ее преимущественно формой жизни, а не просто формой правления. Понятие «демократия» в работах Дьюи несет не политический и управленческий, а этический смысл. Трактовка демократии как личного образа жизни человека он придает особую значимость образованию и соответствующей подготовке подрастающих поколений к жизни в демократическом обществе. Дьюи рассматривал школу в качестве главного фактора укрепления и развития демократии и посвятил много работ вопросам реорганизации школы. В последние годы интерес к Дьюи возродился.

Ж.Дьюи ардчиллыг үндэслэгээтэй болгох, түүнийг хамгаалах ба дэлгэрүүлэх явдлыг өөрийнхөө гол зорилгоо болгон тавьжээ. Тиймээс тэрбээр «Ардчиллын ёс зүй» (1888 он), «Сургууль ба нийгэм» (1899 он), «Ёс зүй» (1908 он), «Ирээдүйн сургууль» (1915 он), «Ардчилал ба боловсрол» (1916 он), «Сургууль ба хүүхэд» (1923 он), «Туршлага ба байгаль» (1925 он), «Олон нийт ба түүний асуудлууд» (1927 он), «Либерализм ба нийгмийн үйлдэл» (1935 он), «Туршлага ба боловсрол» (1938 он), «Логик: судалгааны онол» (1938 он), «Эрх чөлөө ба соёл» (1939 он) зэрэг бүтээлүүдийг туурвиж, ардчиллын тухай асуудлыг нягтлан авч үзсэн байна.

Энэхүү өгүүлэлд ардчиллын талаарх Ж.Дьюигийн үзлийг авч үзэхдээ: түүний үзлээр ардчилал гэж юу вэ? ардчилсан нийгмийн давуу талууд юунд орших вэ? ардчиллыг хэрхэн хөгжүүлэх вэ? гэсэн дэд хэсгээр тайлбарлахыг зорилоо.

Ардчилал гэж юу вэ? Ж.Дьюи нь либераль үзэл баримтлал дахь ардчиллын тухай уламжлалт ойлголтоос татгалзаж, улмаар ардчиллын талаар өөрийн гэсэн өвөрмөц, шинэ хандлагыг бий болгожээ. Тэрбээр ардчиллыг авч үзэхдээ «хүн ба нийгэм», «хүн ба ардчилал», «ардчилал ба боловсрол», «боловсрол ба туршлага» зэрэг хос ойлголтуудаар дамжуулан тайлбарласан байна. Ж.Дьюи амьдралынхаа туршид ардчиллын талаар олон янзын тодорхойлолт өгсөн бөгөөд ардчилал гэдгийг улс төрийн онцгой хэлбэр, төрийн байгууламжийн хэлбэр гэдгээс илүү өргөн утгаар авч үзснээрээ онцлог юм. Тэрбээр ардчиллыг ертөнцөд хандах эмпирик, прагматик хандлагын улс төрийн илэрхийлэл гэж үзсэн байна. Түүний үзлээр ардчилал нь хүний амьдралын арга, хүмүүсийн нэгдлийн тодорхой хэлбэр мөн.

Ардчилал нь ёс суртахууны болон оюун санааны харилцааны тодорхой хэлбэр болдгийн хувьд төрийн тодорхой хэлбэрийг илэрхийлнэ гэж Ж.Дьюи үзсэн. Ингэхдээ тэрбээр «ардчилал» гэсэн ойлголтыг улс төрийн болон удирдлагын утгаар биш, ёс зүйн утгаар хэрэглэжээ. Тэрбээр хэлэхдээ ардчилал нь нийгмийн

ойлголт болохынхоо хувьд ёс зүйн утгатай. Хүн төрөлхтний ёс суртахууны нэгдмэл, туйлын зорилго бол ардчилал билээ. Ж.Дьюигийн үзлээр ардчилал нь хүний нийгмийн хамгийн тогтвортой, нэгдмэл хэлбэр учраас иргэд нь өөрийн идэвх санаачлагаар амьдрах боломжтой болдог. Ардчиллын мөн чанар нь зөвхөн улс төрийн бодлоготой холбоотой биш юм. Түүний үзлээр ардчиллын мөн чанар нь засаглалын хэлбэрээр илэрдэггүй, харин иргэнд олгож буй боломжуудаар тодорхойлогддог байна. Ардчилал бол хүн бүрийн хүсэл сонирхлыг зөвхөн харгалзах төдий зүйл биш, харин иргэний «ухаалгаар хийх» чадварт нь тус дэм болж байдаг амьдралын хэв маяг юм. Хувь хүн нь нийгмийн болон улс төрийн хөтөлбөрүүд боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэнд хяналт тавихад оролцсоор бусадтай харилцдаг, өөрийн үйлдлээ бусдын үйлдэлтэй харьцуулдаг бөгөөд тэр хэрээр нийгэм улам бүр ардчилсан болж байдаг.

Ардчилсан нийгмийн давуу талууд юунд орших вэ? Улс төрийн үйл хэргийн хувьд Ж.Дьюи бол Америкийн либераль ардчилсан үзэл санааны гол төлөөлөгч мөн. Тэрбээр төрийн удирдлагын тухай асуудлыг авч үзэхдээ аристократ ба ардчилсан төрийн ялгааг гаргахыг зорьжээ. Түүний үзлээр аристократ болон ардчилсан төр нь зорилгын хувьд ялгаагүй, харин зорилгодоо хүрэх арга хэрэгслийн хувьд ялгагдаж байдаг бөгөөд энэ ялгаанаас үүдэн өөр өөр үр дүнд хүрдэг гэж Ж.Дьюи үзсэн. Аристократ төрийн удирдлагын арга нь удирдлагад шууд чиглэдэг учраас хүчирхийлэлд хүргэдэг. Харин ардчилал нь хувь хүний идэвх санаачлага, хариуцлага, хувийн идэвх сонирхолд тулгуурладаг, нөгөө талаас ардчиллын чухал зарчим бол ямар нэгэн хүчирхийллээс бүрмөсөн татгалзах, тайван хэрэгслийг ашиглах явдал юм. Тэрбээр «Ардчилсан зорилтууд нь тэдгээрийг хэрэгжүүлэх ардчилсан аргуудыг шаарддаг» гээд тоталитаризмын аливаа хэлбэрийг үгүйсгэсэн юм.

Ж.Дьюигийн үзлээр автократ нийгэмд өөрчлөлтүүд нь мэдэгдэхгүй шахам удаан явагддаг бөгөөд ийм нийгэмд хүмүүс өөрсдийнхөө үйлдэлд болон зан байдалдаа нийгмийн уламжлалаар нөхцөлдсөн инстинктийг удирдлага болгодог байна. Автократ нийгэмд хүнээс дуулгавартай байх, тушаал зааврыг дагаж мөрдөх, сүслэн дагахыг шаарддаг. Ийнхүү хатуу чанга үзэл сурталжсан нийгэмд хүн идэвхгүй сул, нэгэн хэвийн байдлаар аж төрдөг бол харин ардчилсан нийгэмд байдал үүнээс огт өөр байна. Ардчилсан нийгэмд амьдарна гэдэг бол байнга тулгарах шинэ нөхцөл байдлын шийдлийг олох тухай асуудал юм гэж Ж.Дьюи үзсэн. Ардчиллын нөхцөлд л хувь хүний амьдрал шинэ утга агуулгаар баяжиж, амьдралаа судлах, таньж мэдэх бололцоотой болдог. Иймд ардчилсан нийгэм бол байнга хувирч өөрчлөгдөж, өсөлт дэвшлийг бий болгож байдаг нийгэм юм.

Ж.Дьюигийн үзлээр ардчилсан нийгэм нь индивидуализмыг чухалчилж эрх чөлөө, тэгш эрхийг эдлүүлдэг нийгэм юм. Эрх чөлөө гэдэг бол хязгаарыг давна гэсэн зүйл биш, хязгаарлах зарчимд захирагдана. Харин тэгш эрх гэдэг бол хүн төрөхтний чин эрмэлзлэл юм. Үүнд л хүрэхийн тулд ардчиллыг хөгжүүлэх хэрэгтэй болдог байна.

Ардчилсан нийгэмд бүгд, эсвэл олонх нь санаачлага гаргах, шинийг бүтээх боломж болон эрх чөлөөг эдэлдэг. Ж.Дьюигийн үзлээр ардчилсан нийгэмд “хувь хүн нь нийгмийн сайн сайхны төлөөх зорилго бүхий нийгмийн гишүүн “би” гэдгээ тасралтгүй нээж, бүтээж, өөрчилж байдаг ажээ”³⁶. Нөгээтэйгүүр ардчилсан нийгэм иргэдийнхээ үйл хэргийн дүнд байнга, хурдтайгаар хувьсан өөрчлөгдөж байдаг. Тиймээс иргэд нь түүнд тохирсон сэтгэлгээ, ёс суртахуунтай байх ёстой гэж үзсний үндсэн дээр Ж.Дьюи “Бид хэрхэн сэтгэдэг вэ” номондоо (1910 он) “рефлексив ёс суртахуун”, “рефлексив сэтгэлгээ” гэсэн ойлголтуудыг боловсруулсан юм. Рефлексив ёс суртахуун” гэдэг ойлголтын мөн чанар нь зан байдлаа өөрөө зохицуулах хүний чадвар юм. Амьдралын тодорхой нөхцөл бүрт хүн болгон шийдвэр гаргах, үйлдэл болон зан байдлынхаа шинж чанарыг тодорхойлох шаардлагатай тулгардаг. Ж.Дьюигийн үзлээр ардчилсан нийгэм бол хувь хүнд эрх чөлөөг олгохын зэрэгцээ мөн түүнд өөрийнхөө хийсэн үйлдлийн төлөө хүлээх хариуцлагыг ч давхар ноогдуулдаг. Иймд ардчилсан нийгэм нь өөрийнхөө үйлдлийг бие даан тодорхойлох ухаан, чадварыг хувь хүнээс шаарддаг нийгэм юм. Ардчилсан нийгэм дэх чөлөөт санаачлага, үйлдэл бүхий хүн нь бие дааж хөгжсөн байхаас гадна рефлексив сэтгэлгээтэй байх ёстой гэж Ж.Дьюи үзжээ. Түүний үзлээр рефлексив сэтгэлгээ нь хүний амьдралын явцад тохиолддог асуудлуудыг зайлшгүй шийдвэрлэх, бэрхшээлээс гарах гарцыг хайж олох зэрэгтэй холбоотой юм. Рефлексив сэтгэлгээ нь “тодорхой эрэмбэ дараалалтайгаар үндэслэлийг боловсруулдаг, үр дүнг чухалчилан үзэхийн зэрэгцээ өөртөө дүгнэлт хийдэг, субъектийн хувийн итгэл үнэмшил ба тухайн баримтын мэдээллийг хамтад нь авч үздэг, асуудлыг олон талаас нь авч үздэг сэтгэлгээ мөн”³⁷. Энэхүү сэтгэлгээг бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээний нийлбэр гэж маш энгийнээр тодорхойлж болно. Рефлексив сэтгэлгээ нь асуудлыг шийдэхэд хамгийн тууштай, идэвхтэй шинжтэй”³⁸ байдаг. Ж.Дьюигийн үзлээр асуудлыг шийдвэрлэх үндсэн арга, рефлексив сэтгэлгээний арга нь шинжлэх ухааны арга юм. Хүн амьдралынхаа янз бүрийн нөхцөлд амжилтанд хүрэхийн тулд шинжлэх ухааны аргыг эзэмшиж, түүнийг ашиглах ёстой болж байдаг. Ийнхүү нийгмийн төгс байгуулал бол зөвхөн улс төрийн институтуудын цогц төдий биш, мөн тодорхой философи, сэтгэлгээний хэв маяг, ертөнцөд хандах “ёс зүйн” илэрхийллийн цогц гэж Ж.Дьюи үзсэн байна.

Ардчилал нь амьдралын хэлбэр болохынхоо хувьд нэг байрандаа зогсож болохгүй, нийгмийн өөрчлөлттэй уялдан байнга урагш хөгжиж байх ёстой. Эс хөгжвөөс ардчилал нь ухралтанд орж, улмаар мөхөх аюулд хүргэхийг Ж.Дьюи анхааруулж байсан юм.

³⁶ Dewey J. Ethics. N.Y., 1908. p. 71.

³⁷ Dewey, J. “How We Think”, New York: Dover Publications. 1997. p.2-3

³⁸ Мөн тэнд. p.6

Ардчиллыг хэрхэн хөгжүүлэх вэ? Энэ асуулт бол Ж.Дьюигийн судалгааны ажлын хамгийн чухал хэсэг нь юм. Түүний үзлээр ардчилал бэхжин хөгжих хамгийн чухал хүчин зүйл бол боловсрол юм. Тэрбээр неолиберализмын судлах, анхаарах гол асуудал нь нийгмийн тэгш байдал, хүний эрхийн асуудал биш, харин боловсролын тухай асуудал болохыг онцлон тавьжээ. Мөн Дьюи ардчилсан боловсрол нь зөвхөн дунд сургууль, их дээд сургуулиудад хамаарах төдий зүйл биш, нийгмийн болон улс төрийн институтуудын ч анхаарах асуудал гэж үзсэн.

Боловсрол гэж юу вэ? гэсэн асуултанд Ж.Дьюи «Ардчилал ба боловсрол» номондоо хариулт өгчээ. Боловсролын талаарх түүний үзлийг дараах байдлаар ерөнхийлөн үзэж болох юм. Үүнд:

Ж.Дьюигийн тодорхойлсноор хүн төрөлхөөсөө хамтын амьдралд татагддаг ба энэ нь түүнийг өөрийн оршигч нийгмийг сайжруулж, өөрчлөн шинэчлэхэд хүргэдэг байна. Хүн бол байнгын өсөлтийн процессын үр дүн бөгөөд тэрхүү өсөлтийг хангах үндсэн хэрэгсэл нь боловсрол юм. “Боловсрол бол хүний нийгэмших үйл явцын гол тулгуур юм”³⁹. Боловсрол бол ямар нэгэн дээд цэгт хүрнэ гэсэн ойлголт биш, харин байнга сайжрах, өөрчлөгдөх процесс юм. Боловсрох үйл явц нь заавал хэн нэгнээр хатуу удирдуулж, зааврыг ягштал баримтласны үр дүн биш, харин суралцагч асуудлыг өөрөө хайж олоод, өөрийн болгож байдаг туршлагын өөрчлөлт юм. Энэ утгаар боловсрол бол туршлагыг өөрчлөн зохион байгуулах, хуучин туршлагыг шинэ нөхцөлд хувирган өөрчлөх, сайжруулах үйл явц болж байдаг.

Боловсрол бол нийгмийн хөгжлийг хангах гол хүчин зүйл мөн. Аливаа нийгэм тасралтгүй өөрийгөө шүүн шинжлэх замаар хөгждөг бөгөөд тэрхүү хөгжил нь нийгмийн гишүүдийн боловсролын байдалтай шууд хамааралтай байдаг. Ж.Дьюигийн үзснээр нийгмийг өөрчлөн шинэчлэх ажлыг аядуу тайван аргаар зохион байгуулах нь илүү үр дүнтэй ажээ. Тийм аажим хувьслыг боловсролын салбараар дамжуулан хийх нь ардчилсан нийгмийг урагшлуулах гарц нь мөн болохыг Ж.Дьюи олон талаас нь батлан харуулахыг хичээжээ. Нийгмийн болон хамт олны өмнө хүлээх үүргээ биелүүлэхэд шаардлагатай чадваруудыг иргэн хүнд төлөвшүүлдэг тийм боловсролыг ардчилсан боловсрол гэж Дьюи үзсэн. Ийнхүү тэрбээр боловсролын тухай асуудлыг ардчиллын хөгжлийн асуудалтай холбон өргөн хүрээнд тайлбарласны зэрэгцээ боловсролын зорилгыг тодорхойлох асуудалд нухацтай хандсан байна.

Боловсролын зорилго юунд чиглэдэг вэ? Ж.Дьюи боловсролын зорилгыг ардчилсан нийгмийн өөрчлөн сайжруулахад чиглүүлж, улмаар боловсрол олгох арга зүй, үйл явц нь уг зорилготойгоо уялдсан үзэл санааг дэвшүүлсэн нь түүний ардчиллын талаарх үзэл санааны онцлог тал юм.

Тэрбээр боловсролын зорилго бол тухайн нийгмийн зохион байгуулалтаас хамаардаг. Ардчилсан нийгэмд боловсролын нийгмийн үүрэг нэн чухал байдаг. Боловсролын зорилго дан ганц мэдлэг олгоход чиглэдэг юм биш, харин нийгмийн практикийг сайжруулахад чиглэх ёстой. Ардчилсан нийгэмд боловсролын эрхэм дээд зорилго бол нийгмийн өөрчлөн сайжруулж, улмаар сайн сайхан байлгах явдал мөн⁴⁰ гэж үзжээ.

Харин боловсролын зорилт бол нэг талаас хүмүүжил, нийгмийн шаардлага, нөгөө талаас хүүхдийн хэрэгцээ, сонирхол хоёрын тэнцвэрийг хадгалах явдал юм. Ж.Дьюи “Боловсролын зорилт бол суралцагч өөрийн зорилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болоход чиглэх ёстой”⁴¹ гээд дараах үзэл баримтлалыг удирдлага болгосон байна. Үүнд:

- Боловсролын зорилт нь суралцагчийн үйл ажиллагаа, хэрэгцээ шаардлагад суурилах,
- сургалт нь багш болон суралцагчдын хамтын оролцоонд тулгуурласан байх,
- боловсролын зорилгыг сонголтоор өөрчлөгдөж болохуйцаар уян хатан тодорхойлох зэрэг юм.

Энэ нь нийт улс орны хэмжээнд боловсролын зорилгыг нийгмийн амьдралыг сайжруулах, ардчиллыг хөгжүүлэхэд чиглүүлж, харин хувь хүний хэрэгцээнд тохирсон сургалтын үйл ажиллагаа явуулах ёстой гэсэн гэсэн баримтлалд хүргэдэг.

Ардчилсан нийгэмд боловсролыг хэрхэн олгох вэ? гэсэн асуултанд Ж.Дьюи боловсрол олгох үйл явц нь өөрөө мөн ардчилсан шинжтэй байх ёстой гэж үзсэн. Тэрбээр боловсролыг ардчилах асуудлыг үндсэн хоёр хандлагын үүднээс тайлбарласан. Үүнд:

1. Эгалитаризм. Энэ нь бүхнийг тэгшитгэх ба ерөнхий боловсрол ижил байх.
2. Хүмүүсийн хэрэгцээ, сонирхол, чадвар зэргийг харгалзан боловсролыг олон янз болгох дифференциачлах хандлага юм⁴².

Ж.Дьюи ардчилсан улс ирээдүйн иргэдээ хэрхэн сургах асуудалд онцгой анхаарах ёстой гэж үзэж байсан учир сургуулийн талаарх үзэл баримтлалыг шинэчилжээ. Түүнийхээр сургууль бол залуу үеийг нийгмийн амьдралд бие даан оролцох чадвартай, нийгмийн сайн сайхны төлөө хариуцлага хүлээдэг “иргэн” болоход туслах ёстой. Ингэхдээ сургуулийн амьдрал, сургууль дээрх туршлагын үйл явц нь бодит амьдралын туршлага, үйл явцаас ангид байж болохгүй. Амьдрал ба боловсрол хоёр салшгүй холбоотой гэдгийг

³⁹ Dewey, J. “Democracy and Education /Free Press, NY,1997.

⁴⁰ Dewey, J “Democracy and Education /Free Press, NY,1997, chapter eight, p. 117-129.

⁴¹ Dr.Sharma, Principles of education. India. 1992.p.205.

⁴² М.Саулегул. “Ж.Дьюигийн “Ардчилал ба боловсрол” зохиол дахь боловсролын философийн асуудал” магистрын зэрэг горилсон бүтээл. УБ.,2012 он. 33 дахь тал.

онцолжээ⁴³. Энэ санаандаа тулгуурлан Ж.Дьюи сургуулийн зохион байгуулалтын талаар дараах үндсэн санаануудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

Нэгдүгээрт, сургууль бол хүүхдийг ардчиллын соёлд сургах гол орчин мөн. Тэрбээр ардчилсан нийгмийн сургууль нь «хүүхэд бол бүхний эхлэх цэг, төв, бас төгсгөл»⁴⁴ гэж үзэх ёстой гэжээ. Хүүхдийг нийгэмд оролцуулах, амьдралд сургах гол орчин бол сургууль юм. Суралцагч сургуулийн амьдралын алхам бүртээ ардчилсан уур амьсгалын дунд байж, өөрийн зорилгыг хэрэгжүүлэх бүрэн бололцоо нөхцлөөр хангагдах ёстой. Сургууль бол нийгмийн институт төдийгүй олон нийтийн төв юм. Энэ утгаар нь сургуулийг нийгмийн амьдралын үр хөврөл, ардчилсан нийгмийг хэд дахин жижигрүүлсэн түүний бодит загвар гэж Ж.Дьюи үзсэн байна. Ардчилсан нийгэм ямар байдаг, тийм л туршлагыг сургуульд хөгжүүлж, олж авдаг учраас сургууль дээр бодит амьдрал өрнөж байдаг. Энэ нь дараах үзүүлэлтүүдээр илэрнэ. Үүнд:

- Сургуулийг удирдах хийгээд сургуулийн өдөр тутмын амьдралын бүхий л үйл ажиллагаанд ардчилсан уур амьсгалыг бүрдүүлсэн байх,
- Сургалтын хөтөлбөр уян хатан шинжтэй байж суралцагчдын хэрэгцээ сонирхолд тулгуурласан байх, хөтөлбөр боловсруулах үйл явц хамтын оролцоотой байх,
- Сургуульд сурагчдын зөвлөл ажилладаг байх, мөн зөвлөлийн гишүүн сонгох, ангийн дарга сонгох зэрэг хурал нь ардчилсан сонгуулийн зарчмаар явагддаг байх,
- Суралцагчид өөрсдөө эрхлэн гаргадаг сонинтой, мөн радиотой байж өөрсдийн үзэл бодлоо илэрхийлдэг байх,
- Хүүхдүүд өөрсдийн сонирхлоороо нэгдсэн клуб байгуулан үйл ажиллагаа явуулдаг байх,
- Суралцагчид сургууль дээр зохион байгуулах ажлын талаар санал гаргахад болон ажил зохион байгуулахад сайн дураар оролцох,
- Сургууль зөвхөн өөрийн суралцагч хүүхдүүдэд үйл ажиллагаа явуулах биш, тухайн орон нутагт амьдарч буй хүмүүст зориулсан олон нийтийн үйл ажиллагааг явуулдаг байх явдал юм.

Хоёрдугаарт, Ж.Дьюигийн үзлээр сургууль бол сонсдог биш, үйлдэл хийдэг газар мөн. Түүний үзлээр сургууль бол урлан, лаборатори юм. Хүүхдийг нар гэж үзвэл хичээл сургалтын хэрэгслүүд түүнийг тойрон эргэлдэх мэт гарын дор нь байх ёстой⁴⁵. Хүүхэд бол судалгааны бэлэн үр дүнг цээжлэх биш, харин тухайн үр дүнг эрэл хайгуулын явцад нээн илрүүлэх нь хамгийн чухал зүйл гэж тэрбээр үзжээ. Үүний тулд:

- Сургалтууд хамтын судалгаанд суурилсан байх /хичээл бүрийн кабинет, лаборатори/,
- Сургалтанд тоглоомын аргыг сонгон хэрэглэх,
- Спортын талбай, спортын хэрэгсэлүүдтэй байх,
- Уран сайхны, сайн дурын үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдүүлсэн байх хэрэгтэй.

Гуравдугаарт, Ж.Дьюигийн үзлээр сургууль нь хүүхдэд мэдлэг өгөхөөс гадна хүмүүжил олгох ёстой. Мэдлэг болон хүмүүжил нь тусгайлан бэлтгэсэн хөтөлбөрийг дагаж мөрдсөний дүнд бий болохгүй, харин хүүхдийн өөрийн сонирхол, идэвхтэй үйл ажиллагаа /туршлагыг сайжруулах явцад/ өрнөж буй үед бий болно гэж Ж.Дьюи үзсэн. Түүний үзлээр сургууль бол нийгмийн туршлагыг сайжруулах, өөрчлөн шинэчлэх гол арга зам юм. Хүүхдийн сургуулиас олж авч буй хүмүүжил бол нийгмийн дэвшлийн үндсэн хүч мөн. Сургууль бол хүүхэд өөрийгөө нийгмийн гишүүн гэдгээ ухамсарлаж, эргэн тойрныхоо өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа мэдэрч, түүнийгээ биелүүлэх, мөн **нийгмийн үйл явцад дасан зохицоход** суралцдаг гол орчин юм. Ардчилсан нийгмийн хүмүүжлийн үндсэн элемент нь хүүхэд өөрийн зан үйлийн төлөө хүлээх хариуцлагаа ухамсарлах явдал юм. Үүний тулд хүүхдэд дараах үйл ажиллагаа чиглэх ёстой гэж Ж.Дьюи үзсэн. Үүнд:

- Суралцагчид сургуулийн цайны газар, номын сан, хувцас өлгүүр зэрэг газарт өөрийн хүсэлтээр ажиллах боломжтой байх,
- Сайн дурын шинжтэй олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулж, оролцдог байх /гудамж цэвэрлэх, цэцэгжүүлэх, ахмад хүмүүст туслах, сургуулийн орчинд өөрийн бүтээлээр тохижилт хийх гэх мэт/,
- Сургууль өөрийн гэсэн аж ахуйтай, үүнийгээ туршилтын судалгаанд ашиглахын зэрэгцээ хүүхдийн оролцоонд түшиглэн нийгэмд хандсан үйл ажиллагааг эрхлэх, хүүхдийг хөдөлмөрт сургах явдал юм.

Ийнхүү Ж.Дьюигийн боловсролын философи үзэл бол ардчилсан нийгэмд хэрэгтэй ухаалаг иргэнийг бэлтгэх тулгуур зарчим, онол, арга зүй мөн⁴⁶. Хүн төрөлхтөн цаашид ардчилсан нийгмийг хөгжүүлж гэвэл боловсролын үйл ажиллагааг ардчилсан шинжтэй болгох шаардлагатай байна.

⁴³ Dewey, J “Democracy and Education /Free Press, NY,1997, chapter one, p.3-11.

⁴⁴ Дьюи Дж. Школа и ребенок. М., 1923. с. 7.

⁴⁵ Дьюи Дж. Школа и общество. Пер. с англ. М., Работник просвещения, 1925. с.77.

⁴⁶ Г.Эрдэнэбаяр, Г.Уянга “Боловсролын тухай Ж.Дьюигийн прагматист үзэл ба орчин үе”. МУИС. “Философи, социологи, шашин судлал” эрдэм шинжилгээний сэтгүүл. №407.

Орчин үед Ж.Дьюиг сонирхох судлаачдын сонирхол дахин сэргэж байна. Энэхүү өгүүллийг Английн улс төр судлаач Алан Райан «Жон Дьюи ба америкийн либерализмын оргил» (1997 он) бүтээлдээ тавьсан асуултуудаар төгсгөө.

Яагаад орчин үед Ж.Дьюиг сонирхох болов? Үүнийг орчин үеийн философи болон улс төрийн бодлогод хэрхэн тусгах вэ?⁴⁷.

НОМ ЗҮЙ

1. Dewey J. Ethics. N.Y., 1908.
2. Dewey, J. “How We Think”, New York: Dover Publications. 1997.
3. Dewey, J “Democracy and Education /Free Press, NY,1997.
4. Ryan A. John Dewey and the High Tide of American Liberalism, N.Y., 1997.
5. Dr.Sharma, Principles of education. India. 1992.
6. Дьюи Дж. Школа и ребенок. М., 1923.
7. Дьюи Дж. Школа и общество. Пер. с англ. М., Работник просвещения, 1925.
8. Г.Эрдэнэбаяр, Г.Уянга “Боловсролын тухай Ж.Дьюигийн прагматист үзэл ба орчин үе“. МУИС. “Философи, социологи, шашин судлал” эрдэм шинжилгээний сэтгүүл. №407.
9. М.Саулегүл. “Ж.Дьюигийн “Ардчилал ба боловсрол” зохиол дахь боловсролын философийн асуудал” магистрын зэрэг горилсон бүтээл. УБ.,2012 он.

⁴⁷ J Ryan A. John Dewey and the High Tide of American Liberalism, N.Y., 1997. p.35.

УЛС ТӨРИЙН ИНСТИТУТ**ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАСАГЛАЛТАЙ ПОСТ-КОММУНИСТ УЛСУУДЫН
ТОГТОЛЦООНД АЖИГЛАГДАЖ БУЙ ЕРӨНХИЙ ШИНЖҮҮД****Ч.ӨЛЗИЙСАЙХАН***Доктор, дэд профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхим***Х.ЗОЛЖАРГАЛ***Улс төр судлалын тэнхимийн магистрант***Түлхүүр үг:** Засаглал, ерөнхийлөгчийн засаглал, пост-коммунист улсууд, перестройка, төрийн тогтолцоо

Abstract: Post-communism is the period of political and economic transformation or transition in former communist states located in parts of Europe and Asia, in which new governments aimed to create free market oriented capitalist economies. Presidentialism, where there is a directly elected fixed term president, where cabinet members are not collectively responsible to the legislature and where there legislature serves for a fixed term. Parliamentarism, where there is either a monarch or an indirectly elected president and where the prime minister and cabinet are collectively responsible to the legislature. Semi-presidentialism, where there is a directly elected fixed term president and a prime minister and cabinet who are collectively responsible to the legislature.

Хорьдугаар зууны сүүлийн хагаст олон улсын харилцаанд гарсан зарим нэг эерэг өөрчлөлтийн нөлөөгөөр социалист системд багтаж байсан орнуудын нийгэм эдийн засагт ихээхэн өөрчлөлт авчирсан томоохон үйл явдал болсон бөгөөд энэ зурвас үеийг дэлхий нийтийн хэмжээгээр “Перестройка” (Өөрчлөн байгуулалт) гэж нэрлэх болсон билээ. Энэ нэр томъёог Зөвлөлт Холбоот Улсын удирдагч М.С Горбачёв анх хэрэглэж, түүнийг социалист орнуудын эрх баригч улс төрийн намууд, улс төрчид, судлаачид дэлгэрүүлэн түгээжээ. Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс задарч, социалист орнуудад засгийн эрх баригчид болон улс төрийн систем үндсээрээ өөрчлөгдөж, энэ системд хамрагдаж байсан улс орнуудын дийлэнхи олонхид нь хувьсгалт үйл явц өрнөсөн билээ. 1989 онд Польш, Болгар, Чехословакт коммунист нам ялагдаж, Унгарт эрх баригч нам байр сууриа алдаж, Румынд ард түмэн засгийн газрын хооронд зэвсэгт мөргөлдөөн болж, 1990 оны 10-р сарын 2-3-ны хооронд хоёр Герман улс нэгдсэн билээ. Монгол улсад “Өөрчлөн байгуулалт” эхлэн өрнөхдөө үзэл санааны, улс төрийн, эдийн засгийн өөрчлөлтийг хооронд нь уялдуулж зэрэгцүүлэн хэрэгжүүлсэн.⁴⁸

Монгол улсад энэ өөрчлөлт шилжилтийн үйл явц хэрхэн явагдсан талаар улс төр судлаачид, түүхчид, эдийн засагчид олон талын судалгаануудыг хийсээр байна. Тухайлбал, улс төрийн эрх баригчид болон, сөрөг хүчний хоорондын харилцаа энэ үйл явцад хэрхэн нөлөөлсөн болохыг зарим судлаачид дараахь байдлаар тайлбарласан байна. “Засаглал бол үзэл санаа, итгэл үнэмшил, нийгмийн төлөөлөл, эрх зүйн зохицуулалттай нарийн учир холбогдолтой зүйл юм. Улс төрийн дэглэмүүдийн өөр хоорондоо ялгаатай байдал нь эрх мэдлийн хэм хэмжээний асуудлыг тодруулах, төрийн эрх баригчид, нийгмийн бүлгийн удирдагчдын үйл байдлыг харьцуулан үзэх боломжтой болгож байна. Улс оронд оршин тогтнож байгаа засаглал нь хууль эрх зүйн зохицуулалтын хэлбэрээр хэрэгждэг тул дэглэмүүдийг харьцуулан үзэхийн тулд юуны өмнө нийгэм, төрийн үйл ажиллагааг зохицуулж байдаг эрх зүйн байдлыг харьцуулан үзэх зайлшгүй шаардлага гарч ирнэ.

Профессор С.Хантингтон ардчиллын гурав дахь давалгааны үеийн ардчилалд шилжсэн улсуудын шилжилтийг харьцуулсан байдлыг авч үзэхэд Монголын энэхүү шилжилтийн үйл явц нь шинээр бий болсон сөрөг хүчнийхний хүчтэй шахалтаар хуучин эрх баригчид буулт хийснээр ардчилал тогтож эхэлсэн хэв маягт Монгол улс хамаарах юм⁴⁹ гэжээ. Манай судлаачдын анхаарлаа хандуулаад байгаа эдгээр асуудлууд нь улс төрийн шинжлэх ухаанд бие даан хөгжиж байгаа транзитологийн судалгааны чиглэлд хамаарагдаж байгаа юм. Транзитологи бол тоталитар болон авторитар дэглэмээс ардчилалд шилжиж буй улс орнууд дахь улс төрийн үйл явцыг судалдаг улс төрийн шинжлэх ухааны салбар юм. 1970 оны дунд үеэс дэлхийн бараг бүх тив, бүс нутгийг хамарч байсан ардчилсан бус дэглэм нуран унах үйл явц эрч хүчээ авч глобал шинжтэй болсон. Харин 1980-аад оны дунд үеэс өөрчлөн байгуулалттай зэрэгцэн социалист системийн задрал болон пост-коммунист хөгжлийн үйл явц нь транзитологийн судалгааны гол объект болсоор байна.

⁴⁸ Г.Чулуунбаатар. Өөрчлөн байгуулалт Төв Азийн орнуудын нийгмийн амьдралд нөлөөлсөн нь. УБ., 2013. 13 дахь тал.

⁴⁹ Ч. Өлзийсайхан, Ц. Өлзийжаргал. Улс төрийн дэглэмийн шилжилт ба Монголын улс төрийн элит. Политологи. 2013 №388 /X/ 114 дэх тал.

Барууны транзитологичдын үзэж буйгаар пост-коммунист олон оронд ардчилсан ирээдүйнхээ талаар пессимист үнэлэмж давамгайлж байна. Энэ нь шинээр сонгон авсан төрийн тогтолцоо нь улс орны хөгжлийг баталгаатай хангах үндэслэл болж чадахгүй, ихээхэн асуудлуудыг бий болгож, энэ нь нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж байгааг харуулж байж болох талтай. Ийм учраас төрийн тогтолцоог харьцуулж, алдаа оноог нь дэнслэн үзэж ирээдүйн чиг хандлагаа зөв тодорхойлох сонирхол судлаачдын дунд ихээхэн байгаа нь анзаарагдаж байна.

Ерөнхийлөгчийн ба парламентын засаглалыг харьцуулсан судалгаа орчин үеийн улс төрийн шинжлэх ухаанд онолын болон эмпирик түвшинд олон хийгдсэн. Эдгээрээс хамгийн үндэслэл сайтай онолын суурь судалгааг Америкийн Нэгдсэн Улсын Йэль Их Сургуулийн профессор Хуан Линц хийсэн байдаг. Ерөнхийлөгчийн ба парламентын засаглал пост-коммунист улс орнуудад ардчиллын түвшний хувьд ялгаатай үр дагаврыг бий болгожээ. Америкийн Нэгдсэн Улсын “Freedom House”⁵⁰ байгууллагын 2015 оны дэлхий дахины эрх чөлөөний байдал судалгаанд дэлхийн улсуудыг эрх чөлөөт, хагас эрх чөлөөт болон эрх чөлөөт бус гэж ангилан үзсэн бөгөөд пост-коммунист 28 улс дараахь байдалтай байна.

/Хүснэгт 1/

Эрх чөлөөт	Хагас Эрх чөлөөт	Эрх чөлөөгүй
Бүгд Найрамдах Чех Улс	Бүгд Найрамдах Албани Улс	Бүгд Найрамдах Азербайджан Улс
Бүгд Найрамдах Эстони Улс	Бүгд Найрамдах Македони Улс	Бүгд Найрамдах Казакстан Улс
Бүгд Найрамдах Унгар Улс	Босни Герцеговин Улс	Бүгд Найрамдах Беларусь Улс
Бүгд Найрамдах Литва Улс	Гүрж Улс	Оросын Холбооны Улс
Бүгд Найрамдах Польш Улс	Бүгд Найрамдах Молдав Улс	Бүгд Найрамдах Тажикстан Улс
Бүгд Найрамдах Словени Улс	Украин Улс	Бүгд Найрамдах Узбекистан Улс
Бүгд Найрамдах Словак Улс	Бүгд Найрамдах Армени Улс	Туркменистан Улс
Бүгд Найрамдах Латви Улс	Бүгд Найрамдах Кыргызстан Улс	
Бүгд Найрамдах Болгар Улс		
Монгол Улс		
Румын Улс		
Бүгд Найрамдах Серби Улс		
Бүгд Найрамдах Хорват Улс		

Өнөөдөр пост-коммунист шилжилтийн үйл явцыг судалж буй барууны улс төр судлаачдын дунд үзэл баримтлалын зарим ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал А. Лейпхарт, Ф. Шмиттер нарын эрдэмтэд Дорнод Европын орнууд болон пост-коммунист орон зайд өнөөдөр явагдаж байгаа үйл явц хичнээн онцлогтой байлаа ч тэр нь ардчиллын гурав дахь давалгаанд татагдан орсон бүс нутгууд дахь үйл явц, үзэгдлүүдтэй адил юм гэж үзэж байна. Харин Америкийн судлаач В. Барнс, С. Терри нар Дорнод Европ дахь үйл явц Латин Америкийнхаас ч ялгаатай, тэнд ардчиллыг сэргээн тогтоох тухай асуудал яригдахгүй.

Пост-коммунист орнуудад эрх зүйт төр болон ардчиллын бусад институтуудыг сэргээн тогтоож байгаа биш харин цоо шинээр бий болгож байна. Эдийн засгийн хүрээнд ч мөн адил эдийн засгийн өмнөх тогтолцоог засч сайжруулах биш харин зах зээлийн эдийн засгийн шинэ тогтолцоог бүрдүүлж байна гэжээ. Америкийн судлаач Л. Шин пост-коммунист нийгмийн шилжилтийн 4 үе шатыг нэрлэсэн байна. Үүнд:

1. Тоталитар тогтолцоог эвдэн нураах
2. Ардчилсан тогтолцоонд шилжих
3. Ардчилсан тогтолцоог бататган бэхжүүлэх
4. Ардчилсан институтууд төгс боловсронгуй болох үе шатууд байна гэжээ.

Пост-коммунист 28 улсын төрийн засаглалын хэлбэрийг харьцуулан үзвэл өөр өөр төрийн тогтолцоонуудыг сонгон авсан болох нь харагдаж байна.

/Хүснэгт 2/

№	Улсууд	Дэглэмийн шинж	Төрийн засаглалын хэлбэр	Ерөнхийлөгч
1.	Чех	Эрх чөлөөт	Парламентын	Милош Земан
2.	Хорват	Эрх чөлөөт	Парламентын	Грабар-Китарович
3.	Эстони	Эрх чөлөөт	Парламентын	Ильвес Тоомас
4.	Унгар	Эрх чөлөөт	Парламентын	Янош Адер

⁵⁰ Эрх чөлөөний ордон. 1941 онд Америкийн Нэгдсэн Улсад үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бөгөөд дэлхийн ардчиллын хөгжилд хяналт тавьдаг бие даасан байгууллага юм.

5.	Латви	Эрх чөлөөт	Парламентын	Раймондс Вейонис
6.	Литва	Эрх чөлөөт	Парламентын	Грибаускайте
7.	Польш	Эрх чөлөөт	Хагас ерөнхийлөгч	Анджей Дуда
8.	Словени	Эрх чөлөөт	Парламентын	Борут Пахор
9.	Словак	Эрх чөлөөт	Парламентын	Андрей Киска
10.	Болгар	Эрх чөлөөт	Парламентын	Росен Плевнелиев
11.	Монгол	Эрх чөлөөт	Парламентын	Цахиагийн Элбэгдорж
12.	Румын	Эрх чөлөөт	Хагас ерөнхийлөгч	Клаус Йоханнис
13.	Серби	Эрх чөлөөт	Хагас ерөнхийлөгч	Томислав Николич
14.	Албани	Хагас эрх чөлөөт	Парламентын	Бужар Нишани
15.	Македони	Хагас эрх чөлөөт	Парламентын	Георге Иванов
16.	Босни-Херцеговин	Хагас эрх чөлөөт	Парламентын	Драган Чович
17.	Гүрж	Хагас эрх чөлөөт	Хагас ерөнхийлөгч	Георгий Маргвелашвили
18.	Молдав	Хагас эрх чөлөөт	Парламентын	Николай Тимофти
19.	Украин	Хагас эрх чөлөөт	Хагас ерөнхийлөгч	Пётр Порошенко
20.	Армени	Хагас эрх чөлөөт	Хагас ерөнхийлөгч	Серж Саргсян
21.	Таджикстан	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгчийн	Эмомали Рахмон
22.	Туркменистан	Эрх чөлөөгүй	Авторитари Ерөнхийлөгчийн дэглэм	Бердымухамедов
23.	Азербайджан	Эрх чөлөөгүй	Хагас ерөнхийлөгч	Илхам Алиев
24.	Казакстан	Эрх чөлөөгүй	Авторитари Ерөнхийлөгчийн дэглэм	Нурсултан Назарбаев
25.	Кыргизстан	Хагас эрх чөлөөт	Хагас ерөнхийлөгч	Алмазбек Атамбаев
26.	Белорусь	Эрх чөлөөгүй	Авторитари Ерөнхийлөгчийн дэглэм	Александр Лукашенко
27.	ОХУ	Эрх чөлөөгүй	Хагас ерөнхийлөгч	Владимир Путин
28.	Узбекстан	Эрх чөлөөгүй	Авторитари Ерөнхийлөгчийн дэглэм	Ислам Каримов

Улс орнуудын талаархи мэдээллийн эх сурвалж: CIA. World Fact Book 2015

/Хүснэгт 3/

№	Улсууд	Нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүн /Америк доллар/		
		2012 он	2013 он	2014 он
1.	Чех	19,670	19,858	19,553
2.	Хорват	13,236	13,597	13,507
3.	Эстони	17,132	18,877	19,719
4.	Унгар	12,784	13,486	13,902
5.	Латви	14,031	15,357	16,037
6.	Литва	14,333	15,689	16,444
7.	Польш	13,036	13,829	14,422
8.	Словени	22,488	23,296	23,962
9.	Словак	17,151	18,050	18,416
10.	Болгар	7,198	7,498	7,712
11.	Монгол	4,377	4,387	4,129
12.	Румын	8,445	9,489	9,996

13.	Серби	5,659	6,353	6,152
14.	Албани	4,256	4,458	4,619
15.	Македони	4,709	5,195	5,455
16.	Босни-Херцеговин	4,415	4,668	4,805
17.	Гүрж	3,528	3,596	3,670
18.	Молдав	2,046	2,244	2,233
19.	Украин	3,855	4,029	3,082
20.	Армени	3,343	3,486	3,619
21.	Таджикстан	962	1,042	1,114
22.	Туркменистан	6,797	7,826	9,031
23.	Азербайджан	7,393	7,811	7,884
24.	Казакстан	12,120	13,611	12,276
25.	Кыргизстан	1,178	1,282	1,269
26.	Белорусь	6,721	7,722	8,040
27.	ОХУ	14,078	14,487	12,735
28.	Узбекстан	1,719	1,878	2,037

Улс орнуудын талаархи мэдээллийн эх сурвалж: <http://data.worldbank.org>

Дээрх хүснэгтүүдээс харвал улс орнуудын төрийн тогтолцоо, эдийн засгийн хүч чадал, хөгжлийн өнөөгийн байдал нь янз бүр байгаа тал харагдаж байна. Энэ судалгааны ажлаараа бид дээрх улсуудаас зөвхөн ерөнхийлөгчийн тогтолцоотой улсуудыг ялган авч онцлог шинжүүдийг нь гаргахыг зорьж байна.

Английн колоничлол байсны улмаас улс төр эдийн засгийн хувьд америкчуудын эрх ашигт нийцэхгүй бодлого шийдвэрийн золиос болж байгааг эсэргүүцэж өвөг дээдсийнхээ эх орны эсрэг босч ялан дийлсэн америкчууд 1787 онд Америкийн үндсэн хуулийг батлахдаа Их Британий урьд өмнөх улс төрийн байгууламжийг нилээд хуулбарласан боловч хэмжээт хаант засгийн зарчмыг бүгд найрамдах хөрсөнд шилжүүлэн суулгаснаар засаглалын хуваарилалтын тогтолцоо ерөнхийлөгчийн засаглалын эх сурвалж болсон байна.

Америкийн Нэгдсэн Улсын улс төрийн дэглэмийг аль нэг хэмжээгээр хуулбарласан ерөнхийлөгчийн засаглалын тогтолцоо Америк тивд бараг бүхэлд нь зонхилох бөгөөд эрх мэдлийг хуваарилах тогтолцооны дагуу засгийн газар нь бүх нийтээр сонгогдох ерөнхийлөгчийн мэдэлд орж, сайдуудыг ерөнхийлөгч туслахаа болгон хэзээ л бол хэзээ огцруулах эрхтэй, тэгэхдээ сайд нар парламентын өмнө хариуцлага хүлээхгүй байхаар зохион байгуулагдах болжээ. Хууль тогтоох эрх мэдэл эдэлдэг парламентын хажуугаар гүйцэтгэх эрх мэдэл нь бүх ард түмний санал асуулгаар сонгогддог, ерөнхийлөгчийн бүрдүүлдэг, парламентаас бие даасан засгийн газарт шилжжээ. Ерөнхийлөгчийн дэглэмийг тодорхойлдог үндсэн хоёр шинж байдаг.

1. Төрийн тэргүүн парламентаар томилогдохгүй, харин бүх ард түмнээр сонгогдоно. Ийм учраас хамгийн их нэр хүндтэй хүн л ард түмнээсээ санал авч сонгогдох магадлал ихтэй.
2. Ерөнхийлөгч болоод түүний томилсон сайд нарыг парламент “итгэл үл хүлээлгэх” санал хураалтаар засгийн эрхээс зайлуулж чаддаггүй.

Энэхүү хоёр арга замаар хууль тогтоох засаглалаас гүйцэтгэх засаглалын хүч чадлыг хамгаалж байдаг. Гэхдээ энэ тохиолдолд Ерөнхийлөгч хязгааргүй эрх мэдэлтэй субъект биш бөгөөд түүний аугаа их эрх мэдлийг төр-улсын холбооны тогтолцоо нь хязгаарлаж өгч байдаг.⁵¹

1960-аад оноос хойш Хуан Линц тоталитаризм, авторитаризм, ардчиллын тухай ойлголтонд чухал хувь нэмэр оруулсан томоохон эрдэмтний нэг байсаар ирсэн.

Түүний бичсэн олон бүтээлүүд чухал асуудлуудыг хөндөж гаргаж байсан ч 1985 онд туурвисан “Ерөнхийлөгчийн ба парламентын ардчилал. Үүнд ялгаа бий юу?” зэрэг цөөн хэдэн бүтээл нь онцгой ач холбогдолтой бүтээлүүд болсон юм. Түүний дээрх өгүүлэлд тогтвортой ардчилсан дэглэмүүдийг дэмжихэд ерөнхийлөгчийн засаглал парламентын засаглалаас харьцангуй бага үр дүн үзүүлдэг хэмээн дүгнэжээ. Түүний энэ санаа нь хэвлэгдэж гараагүй байхдаа ч ихээхэн анхаарал татаж эхэлсэн бөгөөд бодлого боловсруулагчид болон эрдэмтдийн дунд уг өгүүлэл ерөнхийлөгчийн засаглалын үр өгөөж, давуу талын тухай өргөн хүрээтэй маргааныг өрнүүлсэн.

Улс төрийн шинжлэх ухаанд засаглалын янз бүрийн хэлбэрүүдийг дэглэм гэсэн ойлголтонд хамруулж үздэг. Энэ утгаараа ерөнхийлөгчийн засаглал ч бас нэг дэглэмийн хэлбэр юм. Энэ дэглэмийн онцлог шинжүүдэд:

Нэгдүгээрт, ерөнхийлөгч ихэнхдээ гүйцэтгэх засаглалын тэргүүн бөгөөд бүх нийтээр сонгогддог.

⁵¹ Морис Дюверже. Улс төрийн байгууламж. Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007, 159 дэх тал.

Хоёрдугаарт, ерөнхийлөгч болон ассамблейн бүрэн эрхийн хугацаа нь тогтмол байдаг. Ерөнхийлөгчийн засаглал жинхэнэ утгаараа байгаа тохиолдолд ерөнхийлөгч конгрессын бүрэлдэхүүнээс үл хамааран өөрийн сонголтоор сайд нарыг томилох, хамтран ажиллах эрхтэй байдаг.

Линц парламентын тогтолцоог давуу талтай гэж үзсэн бөгөөд уг дүгнэлтээ ерөнхийлөгчийн засаглалтай хэд хэдэн улсуудыг судалсан судалгаандаа үндэслэн хийсэн. Ингэхдээ ерөнхийлөгчийн тогтолцоонд байх хэд хэдэн тулгамдсан асуудлуудыг шинжилсэн байна.

1. Ерөнхийлөгч, ассамблей хоёр легитим байдал буюу ард нийтийн дэмжлэгийг олж авах гэж өрсөлдөж байдаг. Хоёулаа бүх нийтээр сонгогддог бөгөөд тус бүрийнх нь үүсэл гарал, оршин тогтнол нь бие биенээсээ хамааралгүй. Ерөнхийлөгч, хууль тогтоох байгууллага хоёрын эрх мэдэл ард түмний саналаас үүсэлтэй учир зөрчил нь үргэлж нуугдмал байдаг бөгөөд заримдаа хурцаар илрэн гарах шинжтэй байдаг. Үүнийг шийдэх ямар ч ардчилсан зарчим байдаггүй. Тэгвэл, Линц гүйцэтгэх засаглал ассамблейгаас хамааралтай байдаг учир парламентын засаглал бол уг аюулаас сэргийлж чадна гэж үзсэн. Хэрэв ассамблейн дийлэнх хэсэг бодлогын чиглэлд өөрчлөлт оруулахыг дэмжвэл ассамблей итгэл үл үзүүлэх саналаа хэрэгжүүлж засгийн газрыг сольж өөрчлөх боломжтой байдаг.
2. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа тогтмол байдаг нь ассамблейн байнгын итгэлцлээс хамаарч байдаг засгийн газартай парламентын тогтолцоотой харьцуулахад ардчиллын хөгжилд тийм ч таатай нөлөө үзүүлдэггүй. Кабинет, засгийн газрын өөрчлөлтийг дэмжих илүү их чадамжийн ачаар парламентын тогтолцоо зөрчлийг шийдвэрлэх илүү өргөн боломжуудыг бий болгож байна. Иймэрхүү аюулгүй хамгаалалт дэглэмийн тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ.⁵²
3. Ерөнхийлөгчийн засаглал “ялагч бүхнийг авдаг” үр дүнд хүргэхэд чиглэгддэг. Үүний эсрэг парламентын тогтолцоонд “эрх мэдэл-хуваах, эвсэл-байгуулах” нь нийтлэг байдаг бөгөөд албан тушаалтнууд жижиг намуудын ашиг сонирхол, шаардлагыг анхааралтай сонсдог. Ерөнхийлөгчийн тогтолцоонд бүх нийтийн шууд сонгууль нь ерөнхийлөгчид сөрөг хүчинтэйгээ зөвшилцөх, эвсэл байгуулах гэх мэт төвөгтэй үйл явцад анхаарах шаардлагагүй мэт мэдрэмжийг ерөнхийлөгчид төрүүлж, зоригжуулдаг.
4. Ерөнхийлөгчийн засаглал бүхий дэглэм нь парламентын засаглалын дэглэмтэй харьцуулахад ардчиллын хөгжилд тийм ч таатай нөлөө үзүүлдэггүй. Бүхэл бүтэн улс үндэстний бүрэн эрхт төлөөлөгч байх мэдрэмж нь ерөнхийлөгчид эрх мэдэлтэй байх мэдрэмжийг төрүүлж, түүнийг сөрөг хүчнээ үл ойшоогч болгож хувиргадаг. Энэ нь эцсийн дүнд ерөнхийлөгчийн тогтолцоонд таагүй үр дүн үзүүлж, мэргэжлийн бус улс төрчид гүйцэтгэх засаглалын тэргүүний албан тушаалд сонгогдох илүү хандлагатай байдаг. Бүх нийтийн шууд сонгуулиар сонгогдсон хувь хүмүүс улс төрийн намуудаас үүрэг хүлээж, хамаарах нь харьцангуй бага болж иймэрхүү хүмүүс ихэвчлэн популист, институционалист бус хэв маягаар удирдах шинж давамгайлдаг байна.

Линзийн эдгээр үндэслэлүүдээс гадна дэлхийн улсуудын практикаас харахад ерөнхийлөгчийн засаглалын сул талууд олон зүйл дээр илэрч байна. Ерөнхийлөгчийн засаглалын үед сонгуульд ялсан тал дараагийн сонгууль хүртэл дангаар ашиг сонирхлоо хэрэгжүүлэх боломжтой болж гүйцэтгэх засаглалд дан ганц нэг хүчний манлайлал хүчтэй болдог юм. Хэрэв парламентын сонгуульд ерөнхийлөгчийн нам мөн олонхийн суудал авсан байвал улс төрд нэг намын онцгой нөлөө бүхий олигархи бүлэглэл үүсдэг нь өнөөгийн Оросын Холбооны Улсын жишээн дээрээс харагдаж байна.

Үндэстэн, угсаатан шашны гүнзгий ялгарал бүхий нийгмийн хувьд дээрх зарчимд үндэслэгдсэн ерөнхийлөгчийн засаглал нь маш аюултай үр дагаварт хүрч болно. Учир нь ерөнхийлөгч өөрөө аль нэгэн угсаатан, шашны төлөөлөгч байх агаад үүнээс үүдэлтэй нийгмийн бусад хэсгийг ялгаварлах хандлага бий болдог байна. Гэтэл танхимын зохион байгуулалт бүхий парламентын засаглал нь нийгмийн олон янзын бүлэг давхрааг төлөөлөх чадвар өндөртэй байдаг.⁵³

Ерөнхийлөгчийн засаглалын бас нэгэн сөрөг үр дагавар бол улс төрийн намын төлөвшилд сөргөөр нөлөөлж, хувь хүний үүргийг улс төрийн амьдралд чухал болгон хувиргадаг явдал юм. Ялангуяа улс төрийн нам, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл зэрэг нийгмийн үндсэн институтуудын төлөвшилт сул байгаа нөхцөлд дээрх ерөнхийлөгчийн хувийн үүрэг нийгэмд хүчтэй болдог. Гэтэл судлаачдын үзэж буйгаар улс төрийн нам бол ардчиллын нэн чухал институт байх ёстой бөгөөд төлөвшиж тогтсон намгүйгээр орчин үеийн ардчиллыг төсөөлөх боломжгүй болжээ. 1990-ээд оноос хойш пост-коммунист орнуудын ардчилалд шилжих үйл явц өрнөсөнтэй холбогдуулан ерөнхийлөгчийн ба парламентын засаглалын талаархи харьцуулсан судалгаанууд нэлээд олноор хийгдсэн бөгөөд ихэнхи нь Линзийн дэвшүүлсэн үндэслэлийг дэмжсэн дүгнэлтүүд гаргажээ. Өөрөөр хэлбэл парламентын засаглал нь ардчилсан тогтолцоо болохын хувьд илүү дархлаа сайтай, оршин тогтнох илүү чадвартай гэсэн үг юм. Гэхдээ парламентын тогтолцоонд хариуцлага тооцох механизм сул байвал нийтийн дундаас шийдвэр гардаг тул ард түмний эрх ашгийг зөрчсөн шийдвэрүүд гарсан ч түүний буруутанг тогтоох боломж муу болж нийгэм бүхэлдээ ихээхэн хохирол амсч болохыг бас тооцож үзэх хэрэгтэй юм.

⁵² [http://www.jstor.org/Juan Linz, Presidentialism and Democracy](http://www.jstor.org/Juan%20Lin%20Presidentialism%20and%20Democracy).

⁵³ Д. Бямбажав, Ц. Мөнхцэцэг. Ерөнхийлөгчийн засаглалын сүүдэр. Нээлттэй нийгэм форум. УБ., 2005.

Дээр дурдсан “Freedom House”⁵⁴ байгууллагын судалгааг харуулсан Хүснэгт 1-ээс үзэхэд дээрх улсуудын 15 нь буюу 53 хувь нь хагас эрх чөлөөт болон эрх чөлөөт бус хэмээн тооцогджээ. Ялангуяа тэдгээрийн 7 нь эрх чөлөөгүй буюу авторитари улс гэж тооцогдох болж ардчиллаас хол ухарчээ. Ардчиллаас ухрах хийгээд ардчиллаас авторитари дэглэм рүү хийх шилжилтийн шалтгааныг судлаачид эдийн засгийн хөгжил, тухайн улсын газар нутгийн хэмжээ, соёл, дайн дажин, харийн түрэмгийлэл, үзэл суртлын ялгарал, сонгуулийн тогтолцоо зэрэг олон хүчин зүйлтэй холбон тайлбарлаж ирсэн хэдий ч пост-коммунист улсуудад ажиглагдаж буй ухралтын үндсэн шалтгаан нь ерөнхийлөгчийн засаглал, түүний эрх мэдлийн хэтийдэл болжээ.

Судлаачдын ангиллаар хагас ардчилал болон авторитари дэглэм гэж тооцогдож буй пост-коммунист зарим улсуудад ерөнхийлөгчийн засаглалын дараах шинжүүд ажиглагдаж байна. Албанийн парламентын систем нь ерөнхийлөгчид маш их эрх мэдлийг олгосон байх жишээтэй. Армэнд мөн адил үндсэн хуулийн дагуу ерөнхийлөгч ихээхэн эрх мэдэл бүхий байж ирсэн. Беларусийн хувьд тусгаар улс болсны дараагаар хуучин дээд зөвлөлд гол эрх мэдэл хадгалагдаж байсан боловч 1994 онд парламентын засаглалыг ард нийтээс шууд сонгогддог ерөнхийлөгчийн засаглалаар сольсон.

Казакстан болон Киргизстаны хувьд тусгаар тогтносон эхний жилүүдээс л ерөнхийлөгчийн хүчтэй засаглалыг бий болгосон түүхтэй. Оросын хувьд эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэрийг хэдий хоёрдмол утгатай боловч үндсэн хуулиндаа тусгасан. Гэхдээ хууль тогтоох байгууллага дээд эрх мэдэлтэй боловч бодит байдалд ерөнхийлөгчийн шийдвэрт парламент хориг тавьж чаддаггүй байна. Цаашлаад Оросын Холбооны Улс ерөнхийлөгчид хүчтэй эрх мэдлийг олгосон шинэ үндсэн хуулиа баталсан. Украины хувьд 1996 оныг хүртэл үндсэн хуулиа батлаагүй байсан бөгөөд хуулийг батлахаас өмнө болон хойно ч адил ерөнхийлөгч маш их эрх мэдэлтэй байж ирсэн юм. “Суперпрезидентизм” буюу ерөнхийлөгчид хэт их эрх мэдэл олгосон явдал Туркменистан, Узбекистан, Казакстан, Кыргызстан, Беларусь улсуудад нийтлэг байна.

Төрийн бусад институтээс эрх мэдлийн хэмжээ, нөөцийн хувьд маш давуу ерөнхийлөгчийн институт, захирамж нь хуулийн адил үйлчлэлтэй, төсвийг зарцуулах эрх үндсэндээ ерөнхийлөгчид төвлөрсөн, хууль тогтоох байгууллага нь ерөнхийлөгчийн шийдвэрт хориг тавих боломж маш бага, ерөнхийлөгчийн импичментийн асуудлыг хөндөхөд саад бэрхшээл ихтэй буюу ерөөсөө боломжгүй, шүүх эрх мэдэл ерөнхийлөгчөөс бүрэн хараат байдалтай түүний үйл ажиллагаанд хяналт тавих чадваргүй болсон байна. Пост-коммунист улсуудын парламент, бүрэн эрхийн хугацаа, гишүүдийн тоог доорхи хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

/Хүснэгт 4/

№	Улсын нэр	Парламент	Дээд ба доод танхим	Гишүүний тоо
1.	Чех	Парламент	Сенат	81 (6 жил)
			Депутатуудын танхим	200 (4 жил)
2.	Хорват	Ассамблей	1 танхимтай	151 (4 жил)
3.	Эстони	Рийгикогу	1 танхимтай	101 (4 жил)
4.	Унгар	Үндэсний Ассамблей	1 танхимтай	199 (4 жил)
5.	Латви	Сейм	1 танхимтай	100 (4 жил)
6.	Литва	Сейм	1 танхимтай	141 (4 жил)
7.	Польш	Парламент	Сенат	100 (4 жил)
			Сейм	460 (4 жил)
8.	Словени	Парламент	Үндэсний зөвлөл	40 (5 жил)
			Үндэсний ассамблей	90 (4 жил)
9.	Словак	Үндэсний зөвлөл	1 танхимтай	150 (4 жил)
10.	Болгар	Үндэсний ассамблей	1 танхимтай	240 (4 жил)
11.	Монгол	Улсын Их Хурал	1 танхимтай	76 (4 жил)
12.	Румын	Парламент	Сенат	176 (4 жил)
			Депутатуудын танхим	412 (4 жил)
13.	Серби	Үндэсний ассамблей	1 танхимтай	250 (4 жил)
14.	Албани	Ассамблей	1 танхимтай	140 (4 жил)
15.	Македони	Ассамблей	1 танхимтай	123 (4 жил)
16.	Босни-Херцеговин	Скупстина	Ардын танхим	15 (4 жил)
			Төлөөлөгчдийн танхим	42 (4 жил)
17.	Гүрж	Парламент	1 танхимтай	150 (4 жил)
18.	Молдав	Парламент	1 танхимтай	101 (4 жил)
19.	Украин	Дээд Рада	1 танхимтай	450 (5 жил)

⁵⁴ Freedom house-1941 онд АНУ-д үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бөгөөд дэлхийн ардчиллын хөгжилд хяналт тавьдаг бие даасан байгууллага юм.

20.	Армени	Үндэсний ассамблей	1 танхимтай	131 (5 жил)
21.	Таджикстан	Дээд ассамблей	Үндэсний ассамблей	34 (5 жил)
			Төлөөлөгчдийн ассамблей	63 (5 жил)
22.	Туркменистан	Үндэсний ассамблей	1 танхимтай	125 (5 жил)
23.	Азербайджан	Милли Межлис	1 танхимтай	125 (5 жил)
24.	Казакстан	Парламент	Сенат	47 (6 жил)
			Мажилис	107 (5 жил)
25.	Кыргызстан	Дээд зөвлөл	1 танхимтай	120 (5 жил)
26.	Белорусь	Үндэсний ассамблей	Бүгд Найрамдах Зөвлөл	64 (4 жил)
			Төлөөлөгчдийн танхим	110 (4 жил)
27.	ОХУ	Холбооны Ассамблей	Холбооны зөвлөл	166 (4 жил)
			Төрийн дум	450 (5 жил)
28.	Узбекстан	Дээд ассамблей	Сенат	100 (5 жил)
			Хууль тогтоох танхим	150 (5 жил)
<i>Улс орнуудын талаархи мэдээллийн эх сурвалж: CIA. World Fact Book 2015</i>				

Ирландын Дублины Их сургуулийн харьцуулсан улс төр судлалын профессор Роберт Элжи ерөнхийлөгчийн засаглалтай улсуудыг судлаад хагас ерөнхийлөгчийн засаглалтай болон ерөнхийлөгчийн засаглалтай улс гэж хоёр үндсэн хэсэг болгон хуваасан байна. Түүний ангиллаар Евразийн бүс нутагт багтсан ерөнхийлөгчийн засаглалтай болон хагас ерөнхийлөгчийн засаглалтай улсуудыг дараах хүснэгтэнд нэгтгэн үзүүлээ.

/Хүснэгт 5/

№	Улсууд	Дэглэмийн шинж	Төрийн засаглалын хэлбэр	Ерөнхийлөгч	Ерөнхий сайд
1.	Армени	Хагас эрх чөлөөт	Хагас ерөнхийлөгч (1995)	Серж Саргсян (5 жил)	Овик Абрамян
2.	Азербайджан	Эрх чөлөөгүй	Хагас ерөнхийлөгч (1995)	Илхам Алиев (5 жил)	Артуур Расзаде
3.	Белорусь	Эрх чөлөөгүй	Хагас ерөнхийлөгч (1996)	Александр Лукашенко (5 жил)	Андрей Кобяков
4.	Гүрж	Хагас эрх чөлөөт	Хагас ерөнхийлөгч (2004)	Георгий Маргвелашвили (5 жил)	Ираклий Гарибашвили
5.	Казакстан	Эрх чөлөөгүй	Хагас ерөнхийлөгч	Нурсултан Назарбаев (5 жил)	Карим Масимов
6.	Кыргызстан	Хагас эрх чөлөөт	Хагас ерөнхийлөгч (1993)	Алмазбек Атамбаев (6 жил)	Темир Сариев
7.	Молдав	Хагас эрх чөлөөт	Парламентын Бүгд Найрамдах	Николай Тимофти (4 жил)	Кирилл Габурич
8.	Орос	Эрх чөлөөгүй	Хагас ерөнхийлөгч (1993)	Владимир Путин (6 жил)	Дмитрий Медведев
9.	Тажикстан	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгчийн	Эмомали Рахмон (7 жил)	Кохир Расулзада
10	Туркменистан	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгчийн	Бердымухамедов (5 жил)	Бердымухамедов
11	Украин	Хагас эрх чөлөөт	Хагас ерөнхийлөгч (1996)	Пётр Порошенко (5 жил)	Арсений Яценюк
12	Узбекистан	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгчийн	Ислам Каримов (5 жил)	Шавкат Мирзиёев

Улс орнуудын талаархи мэдээллийн эх сурвалж: www.semipresidentialism.com

Хүснэгтээс үзэхэд Евразийн бүс нутагт багтаж буй дээрх 12 улсын 8 улс нь хагас ерөнхийлөгчийн засаглалтай улсын ангилалд багтаж байгаа бөгөөд 3 улс ерөнхийлөгчийн засаглалтай улсад тооцогдож 1 улс нь парламентын засаглалтай улс байна. Дээрх улсуудад ажиглагдаж буй нийтлэг шинж бол ерөнхийлөгч ард түмнээсээ бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдож буюу ерөнхий сайдыг ерөнхийлөгч парламентын батламжилсныг үндэслэж томилдог байна.

Ийнхүү гүйцэтгэх засаглалын тэргүүнийг төрийн тэргүүний санал болгосноор хууль тогтоох байгууллага баталдаг. Зарим тохиолдолд ерөнхийлөгч парламентаас хамааралгүйгээр өөрөө биеэ дааж томилдог жишиг байна. Харин ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 5 жил буюу түүнээс дээш хугацаатай байна. Тажикстан улсын хувьд ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дээрх улсуудаас хамгийн урт хугацаатай буюу 7 жил байна. Мөн хагас ерөнхийлөгчийн засаглалтай улсуудын хувьд тухайн улсын үндсэн хуулийн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн оныг тэмдэглэж орууллаа. Ерөнхийлөгчийн засаглал, хагас ерөнхийлөгчийн засаглалтай дэглэмүүдэд судлаачид төдийлөн нааштай хандахгүй байгаа тал ажиглагдаж байгаа боловч парламентын тогтолцооны оновчтой байгаа эсэхэд судлаачид, олон нийт бас л эргэлзээтэй байгааг өнөөгийн монголын нийгэмд төрийн тогтолцооны талаар ихээхэн санал зөрөлдөөнтэй байр сууриуд гарах болсноос харж болно. Энэ олон талын байр суурийг харгалзан үзэх зайлшгүй шаардлага гарч байгаа бөгөөд энэ нь ерөнхийлөгчийн болон парламентын засаглалын давуу болон сул талыг харьцуулан үзэх ихээхэн боломжуудыг нээн өгч болох юм.

ДҮГНЭЛТ

Пост-коммунист буюу Евразийн эдгээр улсуудад үндсэн хуулийн дагуу ерөнхийлөгчид эрх мэдлийн төвлөрлийг бий болгосон явдал нь тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөн, хувьсгалыг удирдан манлайлсан хүмүүсийн харизм болон тухайн үеийн улс төрийн элитийн дэмжлэг, мөн олон нийтийн чиг хандлагатай холбоотой юм. Хуучин дэглэмийг халж ардчиллыг цогцлуулан хөгжүүлэх эрмэлзлэлээр ийм системийг сонгосон нь дамжиггүй. Зарим улсад тухайлбал, Беларусьт бүх нийтийн санал асуулгаар дийлэнх иргэд хүчтэй ерөнхийлөгчийн төлөө санал өгсөн байх бөгөөд энэ нь номенклатур элитийн эрх мэдлийг хязгаарлаж, авлигыг багасгаж чадна гэдэг итгэлд хөтлөгдөж байсныг харуулж байна. Харин үндсэн хуулиар олгосон эрх мэдлийн төвлөрөл нь эргээд ардчиллын хөгжилд сөрөг үр дагавар үзүүлж буй нь харамсалтай. Энэ төвлөрөлд дээрх улсууд дахь сөрөг хүчний нэгдмэл бус, сул дорой байдал таатай боломжийг бүрдүүлж, мөн геополитикийн гадаад хүчин зүйлс нэмэр болсон гэж үзэж болно. Монгол улсын хувьд ерөнхийлөгч болон парламентыг аль алиныг нь ард түмнээс шууд сонгодог, хэлбэрийн хувьд холимог засаглалтай мэт боловч ерөнхийлөгчийн сонгуульд олонхийн санал авсан нэр дэвшигчийн бүрэн эрхийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн тогтоол гаргагдаараа үндсэндээ хууль тогтоох байгууллагаас хамааралтайгаар сонгогддог ерөнхийлөгч бүхий парламентын системтэй улс юм. Монгол улсын ерөнхийлөгч бусад улсын ерөнхийлөгчийн эрх зүйн байдлаас ялгагдах нэг онцлог бол хэдийгээр улс төрийн аль нэг намаас сонгогддог боловч албан тушаалдаа орсон хойноо намаасаа татгалздаг явдал юм. Ингэснээрээ улс төрийн өөр өөр ашиг сонирхол, улс төрийн тэмцлийн дүнд боловсруулсан хууль, бодлогод хараат бус, төвийг сахисан байр сууриар асуудалд хандах боломжийг өгдгөөрөө давуу талтай байж болох юм.

НОМ ЗҮЙ

1. М. Дюверже “Улс төрийн байгууламж: Үндсэн хуулийн эрх зүй”. УБ., 2007
2. Өөрчлөн байгуулалт төв Азийн орнуудын нийгмийн амьдралд нөлөөлсөн нь. УБ., 2013.
3. Ч. Өлзийсайхан, Ц. Өлзийжаргал. Улс төрийн дэглэмийн шилжилт ба Монголын улс төрийн элит. Политологи. 2013 №388 /X/
4. Д. Бямбажав, Ц. Мөнхцэцэг. Ерөнхийлөгчийн засаглалын сүүдэр. Нээлттэй нийгэм форум. УБ., 2005.
5. Scott Mainwaring and Matthew S. Shugart. 1997. Juan Linz, Presidentialism, and Democracy: A Critical Appraisal
6. <http://www.freedomhouse.org/regions/eurasia>
7. <http://www.jstor.org/Juan Linz, Presidentialism and Democracy>.
8. <http://www.cia.gov/library/publications>

УЛС ТӨРИЙН НАМЫН ТАЛААРХ М.ДЮВЕРЖИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ЭРГЭЦҮҮЛЭХҮЙ

Г.ЦЭНД-АЮУШ

*Доктор, дэд профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхим*

Түлхүүр үг: Улс төрийн нам, намын хэв маяг, намын бүтэц, зохион байгуулалт, намын гишүүнчлэл ба намын систем.

Краткий обзор: С тех пор, когда М.Дюверже провел свое исследование в мире многое изменилось. Институты, нормы и ценности демократии становятся атрибутами не только национальных государств, но и межгосударственных образований. И, конечно, одним из самых значительных событий современной истории стало вступление Монголии на путь демократического развития.

Хотя концепция Дюверже пришла к нам с опозданием и все же вовремя. И не просто потому, что классика актуальна всегда. В силу определенных исторических причин страна заново переживает период формирования гражданского общества и демократического государства. Наша далеко еще не сложившаяся демократия с особой силой искушается всякого рода политическими и технологическими иллюзиями. И пожалуй, самая опасная среди них это иллюзия, будто бы для Монголии возможен некий сокращенный путь к демократии, миновавших формирование настоящих политических партий. Некоторые наши политики рассуждают об устарелости классических теорий о политических партиях и уверяют нас, что теперь наступает время господства «партийных машин», больших денег, избирательных технологий, когда главным орудием борьбы за голоса избирателей становится «административный ресурс». Надо ли говорить, что в обществе с огромным грузом нерешенных экономических, социальных, политико-правовых и других проблем все это может не только задержать становление демократии, но и привести к накоплению взрывоопасных явлений. В стране, где с такими трудностями, а порой и просто заходя в тупик, идет процесс становления политических партий современного толка и органического включения их в политическую систему общества.

Хураангуй: Монгол орон ардчилсан өөрчлөлтийн замаар даруй 25 жил замнаж ирлээ. Өнгөрсөн хугацаанд ардчиллын үнэт зүйлсийг улс орныхоо нөхцөл байдалд тохируулан нутагшуулах тал дээр чамлахааргүй ололт амжилтыг агуулга, хэлбэрийн хувьд олсон хэдий ч чанарын үзүүлэлт, үр дүнгийн хувьд монголын нийгмийн амьдралын бүх хүрээнд хямралт байдал лавширсаар байгааг хэн хүнгүй хүлээн зөвшөөрнө гэдэгтэй маргах хүн гарахгүй биз ээ. Энэ бүхний учир шалтгааныг зарим хүмүүс “үндсэн хуулиас” үүүдэлтэй гэж улс төрийн тогтолцоо руу түлхэж байхад зарим нь увайгүй улс төрчдийн буруутай үйлдэл ба шийдлүүдтэй холбож тайлбарлаж байна. Нөгөө хэсэг нөхдүүд гадаад хүчин зүйлээс хамааралтай гэж үзэж байх юм. Хамгийн сонин нь улс орныг эдийн засаг болоод нийгмийн хүндрэл бэрхшээлд чирсэн буруутан, хариуцлага тооцох эзэн тодорхойгүй, шийдвэр гаргагчид өөр хоорондоо хол ойроос чулуу шидэлцээр 2016 оны сонгуультай золгох нь бараг тодорхой боллоо. Энэ асуудлыг бид эхлээд намуудын улмаар парламентын төлөвшилийн асуудалтай /магадгүй энэ нь олон төрлийн учир шалтгааны учиг болох учиртай болов уу хэмээн үзэв- Г.Ц/ холбож үзэв. Учир нь нам хэмээх институтээр бэлтгэгдэж, дэмжигдэж эрх барих нэр дэвшигчид тодорч сонгуулийн дүнгээр эрхэм гишүүд болдог. Хэдийгээр бие даагчид нэрээ дэвшүүлж төрийн өндөрлөгт гарах боломж нээлттэй байдаг хэдий ч магадлалын хувьд тун ховор үзэгдэл. Нам бол парламентын бүтцийг бүрдүүлдэг гол институт. Мөн нам иргэд засгийн газрын хооронд зуучлагч, бас хариуцлага хүлээх ёстой чухал этгээд. Ингэхлээр намуудын төлөвшил, түүний чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт болон гишүүнчлэлийн асуудалд улс төрийн шинжлэх ухааны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр цуутай эрдэмтний нэг болох М.Дювержийн улс төрийн намын тухай үзэл баримтлалыг хамаатуулан толилуулахыг хичээв.

Морис Дювержийн 1951 онд хэвлэгдсэн “Улс төрийн намууд” хэмээх бүтээл нь 1976 онд ёс дэх удаагаа хэвлэгдэн гарч англи, испани, герман, итали, португал, солонгос гээд олон хэлнээ орчуулагдсан бөгөөд францын улс төр судлаачид түүнийг сонгодог судалгаа хэмээн хүлээн зөвшөөрдөг байна. Мөн 1974 онд “Улс төрийн байгууламж”, “Нам ба шахалтын бүлэг” нэртэй бүтээлүүд хэвлэгдэн гарсан юм.

Морис Дюверже намыг хэв маягчлахдаа намын зохион байгуулалтын ерөнхий бүтэц, гишүүнчлэл, удирдах байгууллагын систем гээд бүтцийн тодорхойлолыг үндэс болгосон байдаг. Тэрбээр намуудыг өрнөдийн нийгэм судлалд өргөн тархсан гурван бүлэгт: XIX зууны хөрөнгөтний намууд, социалист, коммунист ба фашист гэж хуваан авч үзсэн юм. Хэдийгээр энэ ангилал намуудын хандлагыг илтгэхэд их дөхүү ч гэсэн зарим намууд энэ ангилалын гадна үлдсэн гэдгийг тэр өөрөө тэмдэглэсэн байдаг. Коммунист ба фашист намууд өөр хоорондоо зохион байгуулалтын бүтэц, социал бүрэлдүүн, номлол, философиороо

гүнзгий ялгаатай хэдий ч бие бүтцийн /анатоми/ хувьд төстэй тал байдгийг тэмдэглэсэн юм. Тухайлбал:

1. Нийгэм, төрд монополий эрхийг тогтоох оролдлогыг хийдэг.
2. Хатуу гишүүнчлэл, зохион байгуулалтын болон дайчилгааны нягт сүлжээтэй.
3. Нэг үзэл суртлыг хөдөлбөргүй мөрддөг.
4. Зохион байгуулалтын бүтэц нь дээрээсээ доош босоо чиглэсэн байдаг зэрэг шинжүүд юм.

Мөн тэрбээр хувийн /индивидуал/, хамтын /коллективный/ гишүүнчлэлд үндэслэсэн намууд гэж ангилсан. Дараачийн ангилалын төрөл гэвэл, анхан шатны байгууллагын шинж чанараас хамааралтай ангилал бөгөөд намуудыг: хороодын нам /партии- комитеты/, секцийн /партии- секции/, үүрийн /партии- ячейки/ ба довтлогч баг хэсгийн /партии-штурмовые отряды/ гэж ангилсан байна. Түүний намын ангилалын гурав дахь төрлийг анхан шатны байгууллагуудын хоорондын харилцаа холбооны /хэвтээ систем/ ба анхан шатны байгууллагууд, удирдах дээд байгууллагын хоорондын харилцах системд/ босоо систем/ тохируулжээ. “Системийн нягт холбоотой намууд” ба “системийн сул холбоотой намууд” гэж бүх намуудыг хуваасан байдаг. Орчин үеийн улс төрийн ном зохиолд хамгийн илүүтэйгээр хүлээн зөвшөөрөгдсөн М.Дювержийн намын ангилал нь “боловсон хүчний” ба “олон түмний” гэж авч үзсэн явдал юм. “Боловсон хүчний ба олон түмний намуудын ялгаа нь тэдний хэмжээ, гишүүдийн тоонд бус, гадаад ялгааны тухай бус, бүтцийн тухай өгүүлж байна гэж тэрбээр тэмдэглэсэн байдаг. Олон түмний намын жишээ болгож францын социалист намыг авч үзсэн байна. “Шинэ гишүүдийг татаж оролцуулах нь намд улс төрийн болон санхүүгийн талаасаа тулгуур хэрэгцээ болдог. Намын гишүүд чухамдаа түүний тулгуур үндэс, үйл ажиллагааны эх суурь юм. Гишүүнгүй намыг сурагчгүй багштай зүйрлэн төсөөлж болно. Нам санхүүгийн тал дээр юуны түрүүн гишүүдийн төлөх татварт тулгуурладаг.

Боловсон хүчний намууд улс төр судлаачийн бодлоор намын өөр ойлголтод тохирч байгаа юм. Энд сонгуульд бэлтгэх болон депутатуудтай тогтоосон харилцаагаа хадгалах зорилгоор нотабуудыг /XIV-XXVII зууны үед францын хааны зарлигаар санхүү, засаг захиргааны чухал асуудлыг хэлэлцдэг онцгой хуралдааны гишүүдийг хэлж байна. Тэр гишүүдэд язгуур угсаа, эрх ямба хамаатахгүй, гагцхүү эрдэм мэдлэг, чадвар чансаа гол үзүүлэлт нь болдог байна- Г.Ц / нэгтгэх тухай өгүүлж байна. М.Дюверже нотаблийн хэд хэдэн категорийг ялгаж үзжээ. Нэгд, өөрийн нэр, алдраараа депутатад нэр дэвшигчийн нэр хүндийг өсгөж, түүний төлөө өгөх саналыг олж авахад тусалдаг нотабалууд. Хоёрт, сонгуулийн кампанийг зохион байгуулж чадах нотабал. Эцэст нь, санхүүчдийн нотабал юм. Тиймч учраас, нэр алдар, зохион байгуулах чадвар, хамрах хүрээний байдал намын ажилд татан оролцуулахад чухал шалгуур болдог байна. “Олон түмний нам тоогоор амжилт олдог бол боловсон хүчний намууд шилж сонгох чадварын замаар амжилт олдог. Хэрэв гишүүнчлэлийг ойлгоход хүрвэл намын өмнө үүрэг хүлээх шинж, цаашлаад гишүүний татварыг тогтмол төлөх явдлыг олж харна. Тэгвэл боловсон хүчний намууд гишүүнчлэлгүйг” М.Дюверже тэмдэглэсэн байдаг.

Олон түмний намуудын үүсэл хязгаарлагдмал сонгуулийг бүх нийтийн сонгуулиар сольсон цаг үетэй давхацсан гэж тэрбээр нотолдог. “Хязгаарлалттай сонгуулийн дэглэмийн үед /XIX зуунаас эхлэлтэй дүрмээр- Г.Ц/ намууд боловсон хүчний намын хэлбэрийг авч байсан нь зүйн хэрэг, тэр үед олон түмэн улс төрийн нөлөөллийг эзэмшээгүй байсан тул намуудын өмнө олон түмнийг татаж оролцуулах зорилт гол биш байв. Нөгөө талаар, капиталистууд сонгуулийг санхүүжүүлэх явдлыг зүй ёсны хэрэг гэж үзэж байжээ”.

Аливаа нам нь олон түмний дэмжлэгийг авахын зэрэгцээ сонгуульд бэлтгэх ажлыг зохион байгуулах, нэр дэвшигчийг шилж сонгох, нэр дэвшигчийн нэр хүнд, туршлага, чадварыг дээшлүүлэх, намын болон сонгуулийн кампанийг санхүүжүүлэх технологийг боловсронгуй болгох, нийгэмд тухайн намын байр суурийг өргөх зэрэг жинхэнэ улс төрийн системд ажиллагч утгаар нь “боловсон хүчний” нам хэмээн ангилжээ.

Зарим намуудыг М.Дюверже хагас олон түмний намууд гэж авч үзсэн байдаг. Тийм намуудад завсрын шинж чанартай бөгөөд тэдгээрийг боловсон хүчний болон олон түмний намуудыг сөрсөн бие даасан бүлэг гэж үзэж болохгүйг тэрбээр онцолсон байдаг. Хагас олон түмний намуудад шууд биш, өөрөөр хэлбэл зөвхөн хамт олны гишүүдээс бүрдсэн намуудыг хамаатуулж үзсэн байна. Жишээ нь, ангийн лейборист нам өөрийн оршин тогтнолын эхний жилүүддээ тийм шинжийг агуулж байжээ. Санхүүжилтийн талаасаа олон түмний нам байсан. Сонгуулийн зардлыг нь үйлдвэрчний эвлэлүүд /нэг үгээр, эдгээр ҮЭ-үүдийн гишүүд, хөдөлмөрчин олон - Г.Ц/ хариуцаж байжээ.

Хагас олон түмний нам нь бусад намуудтай, сонирхлын бүлгүүдтэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг байна. Сонгуулийн үеэр социалист намыг ялахад маш том дэмжлэгийг сонирхлын бүлгүүд /францын үйлдвэрчний эвлэл/ үзүүлсэн байдаг. Намын онолын хөгжилд М.Дювержийн оруулсан том хувь нэмэр бол тэрбээр намын үйл ажиллагаанд дахь “оролцооны дүрсүүдийг” ангилсан явдал юм.

Боловсон хүчний буюу формал /албан ёсны-Г.Ц/ гишүүнчлэлгүй намуудад тэрбээр гурван “оролцооны хүрээг” ялгаж гаргасан. Хамгийн өргөн хүрээг намын төлөө саналаа өгдөг сонгогчид бүрдүүлдэг ба энэ хүрээнд “талархагчдын” /симпатизирующий/ хүрээг багтаасан байна. Эцэст нь, намын идэвхтнүүдийг нэгтгэсэн дотоод хүрээ.

М.Дюверже бичихдээ: “эдгээр янз бүрийн хүрээний хоорондын харилцааг тодорхойлох нь тулгуур асуудлын нэг” мөн. Дээрх харилцааг шинжилсэний үндсэн дээр намын мөн чанарыг тодорхойлж болох юм. Дотоод хүрээ гадаад хүрээнд түлхээс-тэмүүлэл өгч хөтөлдөг.

Боловсон хүчний намуудын хувьд сонгогчдын тоо намын хүчтэй эсхүл сул чанарыг тодорхойлох боломжийг өгдөг цор ганц үзүүлэлт юм. Түүний удирдах байгууллагын бүрэлдэхүүнийг сонгогчдын социал бүрэлдэхүүнтэй харьцуулж аль нэг намын байгууллагын ардчиллагдсан төвшний талаар дүгнэлт гаргаж болно. Мөн олон түмний намын сонгогчдын тухай мэдээ, мэдээллийг судалгааны үндсэн дээр гаргах өргөн боломж байдаг. М.Дюверже “гишүүнчлэлийн индекс”-ийг /намын гишүүдийн тоо ба сонгогчдын тооны хоорондын харьцаа-Г.Ц/ ашиглахыг санал болгосон байдаг. Улс төр судлаачийн үзэж байгаагаар адил төрлийн намуудын /түүний хувьслын янз бүрийн үеүүдийн, газар зүйн төрөл бүрийн байршил дахь дүүргийн, олон янзын социал болон насны бүлгүүдэд/ “гишүүнчлэлийн индекс” харьцуулалт хийх нь ихээхэн сонирхол татаж байна. Мөн янз бүрийн орнуудын ижил төрлийн намуудын, тэрчлэн нэг орны бие биесдээ төстэй ойролцоо намын “гишүүнчлэлийн индексийг” бүрдүүлж болно. Энэхүү индекс М.Дювержийн өөрийнх нь судалгаанд нэлээд өргөн хэрэглэгдсэн төдийгүй, францын бусад улс төр судлаачдын бүтээлүүдэд мөн ашиглагдсан байдаг.

М.Дювержийн үзэж буйгаар “дэмжигч” түвэгтэй ойлголт. Сонгогч өөрийн саналаа намд өгч болохоос гадна тэр нь үүгээр хязгаарлагдахгүй. Сонгогч өөрийнх нь санаа бодол намынхтай нийцэж байгаа эсэхээ мөн улс төрийн эрхэмлэл, чин хүслээ янз бүрийн төвшинд, төрөл бүрийн хэлбэрээр харуулж болно. Санал өгч нууцаа нээсэн сонгогч нар “дэмжигчдэд” тооцогдоно. Дараагийн төвшин нь намын төлөө байнга, баттай саналаа өгөх явдал. Нэлээдгүй “дэмжигчид” намд ач тустай үйлдэл хийдэг: намын хэвлэл тогтмол захиалж унших, жагсаал, цуглаан, улс төрийн хурал, ухуулгын ажилд оролцох, мөнгөн хандив намдаа өгөх г.м. Гэхдээ “дэмжигч” бол намын гишүүн биш. М.Дювержийн үзсэнээр, формал гишүүнчлэлгүй, боловсон хүчний намуудад өөрсдийн санаа бодол нь намынхтай нийцэж байгаагаа нээлттэй мэдэгдсэн хэн бүхэн /хороодоос бусад-Г.Ц/ “дэмжигчдийн” категорт хамаарагдана.

Гурав дахь хүрээнийхэн бол намын гишүүд. Намд гишүүнээр элсэж байгаа хэн бүхэн намын сахилгыг сахиж, намын үзэл номлолыг сурталчилж байх үүргийг журамласан баримт бичгийг /акт/ бөглөж гарын үсгээ зурсан байх ба тийм журам аль ч намын дүрэмд байдаг. М.Дюверже энэ баримт бичиг зайлшгүй байхнь хоёр талтай гэж үзсэн юм. Нэгд, намд элсэгчдэд сэтгэл зүйн маш хүчтэй нөлөөлөл энэ баримт үзүүлдэг байна. “Манай соёл иргэншлийн хүрээнд бичгээр үүрэг хүлээх нь хэл амаар хүлээхээс илүү хүчтэй, гарын үсэг бүдүүлэг системд зарим төрлийн зан үйлд ид шидийн шинж чанарыг олж байсан” Хоёрт, тийм баримт бичиг ямар нэг байдлаар намд элсэгчдийн тодорхой биеийн байцаалт /анкет-Г.Ц/ болдог байна.

М.Дюверже гишүүнчлэлийн: нээлттэй ба дүрэмт гэсэн хоёр хэв маягыг ялгаж үзсэн байна. Нээлттэй гишүүнчлэл зохих баримт бичгүүдэд гарын үсэг зурахад л хангалттай. Дүрэмт гишүүнчлэлд нам элсэх хүсэлтээ илтгэсэн өргөдөл өгөх шаардлагатай бөгөөд тэр нь намын аль нэг байгууллагаар хэлэлцэгддэг. Зарим тохиолдолд намд элсэгчдэд намын гишүүний багламж /рекомендаци/ гаргах шаардлага гардаг.

Дараагийн хүрээнд идэвхтнүүд багтдаг ба боловсон хүчний намын идэвхтний ойлголт олон түмний намын идэвхний ойлголтоос эрс ялгаатай болохыг М.Дюверже тэмдэглэсэн байдаг. Олон түмний намд идэвхтнүүд бааз суурь нь болсон бүлэг бүхний цөм байдаг. Идэвхнийг удирдагч нартай хольж хутгаж болохгүй эхнийх нь зөвхөн гүйцэтгэгчид, гэхдээ тэдэнгүйгээр намын аливаа үйл ажиллагаа гүйцэлдэх боломжгүй. Боловсон хүчний намд идэвхтнүүдийг М.Дюверже хороодын гишүүд гэж нэрлэсэн байдаг.

Олон түмний намуудын хувьд “идэвхтнүүдийн индекс”-ийг тэрбээр идэвхнүүдийн ба намын гишүүдийн тооны харьцаа гэж үзсэн. Түүнийхээр, “гишүүнчлэлийн индекс”-ийг “идэвхтнүүдийн индекс”-тэй харьцуулах нь улс төрийн намын бодит хүч чадамжийн илүү бүрэн дүүрэн дүр зураг тодруулах боломж олгодог байна. Тийм харьцуулалт хийхэд шаардлагатай баримт мэдээ, мэдээлэл хэрэгтэй болох нь хэнд ч ойлгомжтой.

Францын улс төр судлаачид намын системийг судлах явдалд ихээхэн анхаарал хандуулж ирсэн байдаг. “Намын систем” хэмээх ойлголтын агуулгыг задлан шинжлэхэд М.Дюверже хоёр зүйлийг анхааралдаа авахыг санал болгосон байдаг.

Нэгд, нам бүрийн дотоод онцлогыг харгалзах хэрэгтэй. Тэгж байж, төвлөрсөн ба төвлөрөөгүй, уян хатан ба уян биш намуудыг ялгах боломжтой.

Хоёрт, намуудыг тодорхойлоход улс оронд үйл ажиллагаа явуулж буй намуудын тоо, тэдний үйл ажиллагааны харьцангуй цар хэмжээ, улс төрийн амьдралд эзлэх хувийн жин, газар зүйн байршил г.м.

“Намын систем дээрх тодорхойлолтуудын хоорондын харилцаагаар тодорхойлогдох нь” мэдээжийн хэрэг гэж тэрбээр нотолдог. Намын системийг М.Дюверже хэв маяглахдаа: нэг намын, хоёр намын /англисаксон хэв маягийн Г.Ц/ ба олон намын гэжээ. Түүнийхээр намын систем бол олон төрлийн хүчин зүйлсийн үйлчлэлийн үр дүн. Тэрбээр тухайн орны хувьд төдийгүй бүх орнуудад байх өвөрмөц ба нийтлэг хүчин зүйлсийг ялгаж үзсэн байдаг. Эхнийхэд нь тухайн улс орны түүх, уламжлал, түүний эдийн засгийн болон социал бүтэц, шашин, сүслэл, угсаатны бүтэц гэх мэт хамаарагдаж байна. Нийтлэг хүчин зүйлсийн дотроос хамгийн чухал нь намуудын тоо, хэмжээ, тэрчлэн намуудын эвсэл бүрэлдэх, парламентэд намын төлөөллийн хэмжээнд гол нөлөөлөгч болдог сонгуулийн дэглэм гэж үзсэн юм. М.Дюверже “Улс төрийн намууд” бүтээлдээ намын системд нөлөөлөх сонгуулийн дэглэмийн тухай өөрийн бодомждоо гурван гол томъёоллыг санал болгосон байдаг.

1. Пропорционал буюу хувь тэнцүүлсэн төлөөлөл намын системд олон тооны, уян хатан биш, хараат бус, харьцангуй тогтвортой намын төлөөллийг бүрдүүлэхэд хүргэдэг байна.
2. Мажоритар систем /хоёр шатны / олон тооны, уян хатан, хараат бус, харьцангуй тогтвортой системд хүргэдэг/ бүх тохиолдолд-Г.Ц/ байна.
3. Мажоритар систем /нэг шатны/ хараат бус намуудыг алгассан дуалист /халз өрсөлдөгч хоёр хүчний-Г.Ц/ системд хүргэх талтай байдаг.

Намын систем юуны түрүүн, сонгуулийн дэглэм бүрэлдэн тогтоход чухал үүрэгтэй бөгөөд хоёр намын систем нэг шаттай сонгуулийн мажоритар систем тогтоход нөлөөлдөг байна. “Намын систем ба сонгуулийн систем нь шинжилгээ хийх явцад ялгаж салгахад бэрхтэй өөр хоорондоо нягт холбоотой хоёр бодит байдлын мөн чанар /суть/ юм” гэж тэрбээр онцолсон байдаг. Мөн дээрх томъёолдоо тэрбээр маш их ач холбогдол өгч “социологийн гурван тулгуур хуулиуд” гэж нэрлэсэн байдаг. М.Дювержийн энэхүү үзэл баримтлалыг францын төдийгүй америкийн олонх улс төр судлаачид талархан хүлээдэг юм.

НОМ ЗҮЙ

1. Антология мировой политической мысли. 5-томах. М.,1997
2. Современная политическая наука. М., 1982
3. М. Дюверже. Политические партии. Парис., 1951

УЛС ТӨРИЙН СИСТЕМ, НАМЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ: ОНОЛ-АРГА ЗҮЙ

Д.БОЛД-ЭРДЭНЭ

*Доктор, профессор, ШУА-ийн Философийн хүрээлэн,
Улс төр судлалын салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан*

М.ДОЛЖИН

Доктор, профессор, МУИС, Бизнесийн сургуулийн дэд захирал

Түлхүүр үг: Улс төрийн тогтолцоо, улс төрийн нам, харилцан хамааралын механизм, систем, бүтэц, элемент, бүтэц бүрдэлжилт, үүрэг-үйл ажиллагаа, эрх зүй зохицуулалт, мэдээлэл солилцооны механизм

Abstract: The issue of political system and parties correlation has been an independent and biggest theory of political and studies methodology. Political science has been considering political system and parties correlation in the sphere of combined structure of such specific phenomena as political environment process, political system, parties system and political parties, but in their interdependency and distinction. The point is that political environment has been main sphere of parties activities, and the process of party's forming in this sphere has been inseparable part of whole social political process, but parties and their system have been a main structure of the whole social political system.

Улс төрийн систем, намын харилцан хамаарлын асуудал нь улс төрийн онол, шинжлэлийн арга зүйн бие даасан томоохон судлагдахууны нэг юм. Улс төрийн шинжлэх ухаан улс төрийн систем, намын харилцааны асуудлыг авч үзэхдээ улс төрийн орчин, үйл явц, улс төрийн систем, намын систем, улс төрийн нам гэсэн өвөрмөц үзэгдлүүдийн хосолмол бүтцийн хүрээнд харилцан хамааралтай тэгэхдээ учир ялгавартайгаар шинжлэн үздэг. Учир нь улс төрийн орчин нь намын үйл ажиллагааны үндсэн хүрээ болдог бөгөөд энэ хүрээн дэх намын төлөвшилтийн үйл явц нь нийгмийн улс төрийн бүхэл үйл явцын салшгүй хэсэг, харин нам, намын тогтолцоо нь улс төрийн нийтлэг системийн нэг үндсэн бүрдэл нь болдог.

Орчин үед улс төрийн намыг онолын олон янзын арга хандлагын үүднээс судалдаг ч түүнийг нийгмийн улс төрийн бүхэл системийн салшгүй бүрэлдэхүүн, бүтэцлэг бие даасан өвөрмөц систем талаас нь авч үзэж судлах нь нилээд түгээмэл шинжтэй болжээ. Түгээмэл шалтгаацилал, харилцан хамаарлын философийн жам ёс нийгэм улс төрийн үзэгдлийн хүрээнд ч бодитой илэрч үйлчилдэг. Улс төрийн аливаа үзэгдлүүд өөр хоорондоо харилцан нөхцөлдөж, бие биенээ нөхөн сэлбэж байдаг. Энэ онцлог зүй тогтол улс төрийн өвөрмөц үзэгдэл болох намд ч бүрэн хамаатай. Улс төрийн нам нь дотооддоо зуршмал үйлчлэх обьектив хууль, жам ёс бүхий ямагт хөгжиж, хөдлөж байдаг нийгмийн харьцангуй бие даасан өвөрмөц улс төрийн “амьд организм” мөн билээ. Гэхдээ ингэлээ гээд нам нь нийгмийн тухайн бодит орчин нөхцөл, үйл явц, улс төрийн системээс ангид гадуур оршин хөгжинө гэж үгүй. Харин ч тэрээр түүний дотоод агуулга, бүтцийн бүрдэл хэсгүүдтэй нягт нарийн харилцан шүтэлцээнд оршдог. Иймд аливаа улс төрийн нам, намын системийг шинжлэн үзэхдээ нийгмийн улс төрийн системийн нийтлэг бүтцийн хүрээнд түүнтэй хамаатуулан авч үзэх хэрэгтэй болдог. Харин энэ шинжилгээ нь системийн болон бүтэц-үүргийн (Л.Берталанфи, Т.Парсонс, Ч.Бернард, Р.Мертон, М.Дюверже, У.Берихэм, К.Байже, К.Дойч, Д.Истон, Г.Алмонд, В.Пауэлл, Р.Арон, Т.Шилз, Дж.Деннис, С.Верба, Р.Хесс) арга зүйд суурилдаг.

Улс төрийн систем, намын тогтолцоо, намын хоорондын харилцаа нь нийгмийн улс төрийн хүрээний нэгэн онцлог дэд систем, түүний үйл ажиллагааны өвөрмөц механизм мөн билээ. Улс төрийн систем, намын харилцан хамаарлын асуудлыг систем, бүтцийн арга зүйн үүднээс “*нийгмийн улс төрийн систем-намын тогтолцоо-улс төрийн нам*” гэсэн улс төрийн үзэгдлүүдийн гурвал бүтэцтэй холбон үздэг бөгөөд энэ нь тодорхой утгаараа тогтолцоо\ систем\, бүхэл\ целое, под систем \, хэсэг\ часть\ - ийн харилцан шүтэлцэлийн тухай асуудал юм. Нийгмийн улс төрийн тогтолцоон дахь дээрх гурвал бүтцийн нийтлэг харилцаа холбооны хүрээнд *нийгмийн улс төрийн систем нь ерөнхий систем, уг системийн хүрээн дэх намын тогтолцоо нь бүхэл буюу дэд систем, намын системийг бүрдүүлж буй тодорхой намууд хэсэг* нь болдог байна.


Улс төрийн системийг намтай холбогч гол механизм нь намын систем болдог. Учир нь намын системээр дамжин улс төрийн намуудын нийгэмд эзлэх байр суурь, статус, гүйцэтгэх үүрэг тодорхойлогдож байдаг. Ингэхлээр намын системийн бүтцийн үндсэн элемент нь түүнийг бүрдүүлэгч нэгж хэсэг, тусгай үзэгдэл болох улс төрийн намууд болдог. Тэдгээр нь өөр хоорондоо харилцааны төвөгтэй сүлжээнд орсноор зохион байгуулалтын түвшинд эрэмбэлэгдсэн, цэгцтэй бүтцийг бий болгодог. **Бүтэц** бол намын системийн гол

шинж, түүнийг бүрдүүлэгч элементүүдийн (намуудын) харилцаа, зохион байгуулалт юм. Ингэж улс төрийн систем, намын тогтолцоо, намуудын системлэг харилцаа хэрэгжиж байдаг.

Улс төрч, улс төр судлаачид улс төрийн систем, намуудын хоорондын харилцан хамаарлын асуудлыг олон талаас нь үзэж судлаж ирсэн. Тухайлбал тэдгээрийн хоорондын харилцааны механизмыг тайлбарлахдаа институт, байгууллага, үүрэг, үйл ажиллагаа, засаглалын болон эрх зүйн харилцаа, үзэл, ухамсар, сэтгэл зүйн зэрэг хандлагууд нилээд түлхүү хэрэглэгддэг.

Улс төрийн систем, намын харилцан хамаарлын механизм нь олон талтай өргөн хүрээт шинжтэй. Энэхүү харилцан үйлчлэлийн механизмын агуулгыг дараах байдлаар томъёолон тодорхойлж болох байна. Энэ нь: нэгд, бүтэц-бүрдэлжилтийн институциональ механзм; хоёрт, үүрэг-үйл ажиллагааны функциональ механизм; гуравт, мэдээлэл солилцооны коммуникатив механизм; дөрөвт эрх зүй-зохицуулалтын регулятив механизм зэрэг болно. \ Бүдүүвч №1 \

Бүдүүвч №1 Улс төрийн систем, намын харилцан хамаарлын механизм



Бүтэц-бүрдэлжилтийн институциональ механизм. Намууд бүтэц бүрдэлжилтийн буюу институциональ механизмгаар дамжин улс төрийн системтэй холбогддог. Ингэхдээ улс төрийн системийн иргэний нийгмийн байгууллагын бүтцээс төрийн институт болох урт замналыг туулдаг. Энэ нь бүхэлдээ намын институтжих үйл явц мөн бөгөөд намууд ингэж институтжих хэлбэрших явцдаа улс төрийн системийн салшгүй бүрдэл, институт болдог. Намын институтжих үйл явцыг Италийн судлаач А.Панебианко “намын зорилго болон үнэлэмжүүд тодорхой үндэслэлтэйгээр нэгтгэгдэж байгаа үйл явц юм” гэж үзсэн бол Ф. Селзник “намын институтжилт гэдэг бол нам дахь зохион байгуулалтын зайлшгүй байдлыг ухаарч түүнийг бодит зорилгод нийцүүлэн институциональ хийгээд функциональ бүтэц бий болгоход чиглэсэн түрэлт бүхий үйл явц юм” гэж тодорхойлсон байна. Эндээс үзвэл намуудын институтжих үйл явц нь нэг талаас намын дотоод бүтэц зохион байгуулалтын, нөгөө талаас төрийн засаглалын гэсэн хоёр үндсэн түвшинд явагддаг нь илэрхий байна. Үүнтэй холбогдуулан “институт” хэмээх ойлголтын тухайд зарим зүйлийг товч боловч тодруулах нь зүйтэй байх.

Улс төрийн шинжлэх ухаанд “институт” гэдэг ойлголтыг сонирхолд суурилсан нийгмийн бүлгүүдийн зохион байгуулалтын түвшинд бүрдсэн бүтэц гэж тайлбарладаг. Институт гэдэг нь “institutum” хэмээх латин үгнээс гаралтай нэр томъёо. “Britanica” нэвтрэхий толь бичигт түүнийг үүсгэх, байгуулах, тогтолцоо, юмны бүтэц, хэлбэр гэж тайлбарласан байна. Институтийн онолын суурь анхлан Америкт тавигдан улмаар Өрнөдийн бусад орнуудад дэлгэрэн, Франц, Англи, Германд хөгжсөн байна. Институтын онолын гол төлөөлөгчдийн тоонд М.Прело, Ж.Бюрдо, М.Дюверже зэрэг судлаачдыг зүй ёсоор оруулдаг. М.Прело институт гэдгийг тодорхойлохдоо “институт бол сонголт байдаг, институт бол бие хүмүүсийн нэгдэл байдаг, институт бол хамтын үйл ажиллагаа байдаг, институт бол механизм байдаг, эцэст нь институт нь дээрх бүгдийг багтаасан организм юм” гэсэн сонирхолтой санааг дэвшүүлсэн байдаг. М.Прелогийн үзсэнээр “Институт-организм” болдог утгаараа хуулиар тогтоосон засаг захиргаатай, нийтлэг хэрэгцээ, үзэл суртлын нэгдэлд суурилсан зохион байгуулалтын нэгдэл” болж байдаг бол М.Дюверже институт гэдгийг зорилго, үйл ажиллагаагаараа нэгдсэн тогтворт шинжтэй, хүмүүсийн харилцааны хамгийн бодитой, сайн загвар, хэлбэр гэж үзсэн байна. Ингэж тэрээр институт хэмээх ойлголт бүтцийн хийгээд итгэл үнэмшил дээр суурилсан нэгдлийн гэсэн хоёр элементийг өөртөө агуулж байдаг гэж үзсэн байна. Бүтэц гэдгээ тэрээр бодит харилцааны институтжсэн загвар гэж тодорхойлсон байна.

Энэ үүднээс авч үзвэл институт гэдгийг М.Дювержегийн томъёолсоноор зохион байгуулалттай, зохицолдолгоотой цогц бүтцийг үүсгэгч үзэл санаа, итгэл үнэмшил, зан үйлийн нэгдэл хэмээн ойлгож болох байна.

Нам бол институт, тэгэхдээ улс төрийн институт юм. Нам нь улс төрийн институт гэдэг утгаараа улс төрийн системтэй холбогддог. Намууд нь нэг талаас иргэний нийгмийн, нөгөө талаас төрийн институт болдог. Намууд нийгмийн төлөөллөө бүрдүүлж, зохион байгуулалтын бүтцээ бий болгон, улс төрийн үзэл, үнэт

зүйлсээ томъёолсоны дараа улсын бүртгэлд бүртгүүлэн, үйл ажиллагаагаа хууль ёсоор баталгаажуулсанаар иргэний нийгмийн институт болдог. Тэд энэ үед төрийн засаглалыг хэрэгжүүлэгч институт хараахан биш, харин иргэний нийгмийн бусад байгууллагын тусламж, оролцоотойгоор болон өөрөө бие даан нийгэм дэх олон янзын ашиг сонирхолыг илрүүлж, түүнийг улс төрийн үзэл баримтлал, хөтөлбөрийнхөө суурь үндэс болгон нэгтгэн томъёолж, бодлого зорилгоо нийгэмд санал болгогч улс төрийн хэв шинж бүхий сонирхолын бүлэг байдаг.

Намын бодлого хөтөлбөрийг олон түмэнд танилцуулан сурталчлах боломжийг бүрдүүлж, намыг улс төрийн систем тэр дундаа төрийн засаглалын тогтолцоотой холбогч үндсэн механизм нь сонгууль юм. Намууд хөтөлбөр, зорилго, бодлогоо сонгуулийн өмнөх тэмцлийн явцад дэлгэн тавьж, сонгогч олон түмний дэмжлэг итгэлийг олж авахын төлөө өөр хоорондоо өрсөлддөг. Энэ өрсөлдөөнд амжилт гарган, сонгогч олон түмний итгэл дэмжлэгийн олж авч чадсан намууд нь төрийн засаглалын тогтолцоонд зохих ёсны байр сууриа эзлэн, төрийн институт болсоноор тэдгээр нь тус тусын үзэл баримтлал, зорилго бодлогоо хэрэгжүүлэх боломжтой болдог. Энэ үеэс намууд төрийн засаглалын төдийгүй нийгмийн улс төрийн системийн онцгой нэгэн институт болдог. Ингэснээр намууд нь төрийн институт болж, улс төрийн систем дэх хууль ёсны чиг үүргээ хэрэгжүүлдэг байна. Энэ агуулгаараа нам нь олон түмнийг улс төрийн систем, төрийн засаглалтай холбогч “гүүр” болж байдаг.

Үүрэг-үйл ажиллагааны функциональ механизм. Аливаа нийгмийн систем тодорхой чиг үүрэгтэй байдаг. Хэрвээ систем зорилго, чиг үүрэггүй бол уг систем оршин үйлчлэх боломжгүй болж, систем шинжээ алдахад хүрдэг. Харин энэ чиг үүрэг нь системийн бүрдэл хэсэг болох элементүүдийн үүргээр нөхцөлддөг. Тэгэхдээ ингэлээ гээд улс төрийн системийн өөрийнх нь чиг үүрэг, түүний бүрдэл элементийн чиг үүрэг хоёрыг шууд давхцуулан ойлгож буй хэрэг биш юм. Ингэж үзэхийн үндэс нь систем бол элементүүдийн энгийн нийлбэр бус. Харин чанарын өөр түвшний цогцлол байдаг, системийн чиг үүргийг системийн элемент бүрдэл хэсгүүд дангаараа хэрэгжүүлж чаддаггүйтэй холбоотой. Хэдий тийм боловч системийн бүрдэл элементүүдийн чиг үүрэг нь нэг талаас тухайн системийн тогтвортой оршин үйлчлэх нөхцөл, нөгөө талаас системийн бүхэллэг шинж буюу систем-элемент болон элемент хоорондын харилцааг холбогч чухал механизм болдог.

Нам бол улс төрийн системийн бүрдэл элемент мөн. Намын нэг үндсэн онцлог нь улс төрийн системийн хүрээнд тодорхой зорилго, чиг үүрэгтэй байдаг оршдог. Нам нь улс төрийн системийн ерөнхий чиг үүргийг онцлог байдлаар хэрэгжүүлж байдаг ч түүнд улс төрийн систем дэх өөрийн жам ёсны өвөрмөц чиг үүрэг гэж байдаг. Энэ нь сонирхолыг нэгтгэх \сонирхолын агрегаци\ чиг үүрэг юм. \Бүдүүвч №2\ Сонирхолын агрегаци хийх үүрэг нь түүний улс төрийн систем дэх хамгийн гол чиг үүрэг нь болдог. Үүнтэй холбогдуулан зарим улс төр судлаачид улс төрийн нам болон түүний системийг сонирхол нэгтгэх үйл ажиллагааны бүрдэлжилтийн үр дүнд бий болсон улс төрийн дүр гэж үздэг нь санамсаргүй хэрэг биш юм. Эндээс үзвэл намын улс төрийн систем дэх үндсэн чиг үүрэг нь олон янзын сонирхол, үзэл санааг тодорхой бодлого, хөтөлбөрийн хэлбэрээр нэгтгэн боловсруулж, төрийн шийдвэрт тусгуулах явдал юм. Үүнийг улс төрийн шинжлэх ухаанд сонирхолын агрегаци хийх үйл явц гэж оноон томъёолдог. Г.Алмонд энэ тухай бичихдээ: “ашиг сонирхолын агрегаци бол иргэд бүлгүүдийн улс төрийн шаардлага нэгтгэгдэж, улс төрийн бодлогын хөтөлбөр болох үйл ажиллагаа юм.Орчин үеийн олон улс төрийн системд ашиг сонирхолын агрегаци хийдэг гол бүтэц бол намууд болжээ” гэж бичсэн нь дээрхийг давхар нотлож байна.

Намууд улс төрийн системтэй чиг үүргийн хоёр үндсэн хэв маягаар холбогддог. Үүнд: улс төрийн систем дэх төрийн засаглалын харилцаагаар нөхцөлдсөн бүлэг чиг үүрэг, нөгөөх нь улс төрийн систем дэх нийгмийн харилцаагаар нөхцөлдсөн бүлэг чиг үүрэг юм. Эхний бүлэг чиг үүргийн системд сонгуульд өрсөлдөх хүнийг нэр дэвшүүлэх, сонгогчдыг сонгуульд дайчлах, сонгуулийн сурталчилгаа явуулах, парламент, засгийн газрыг бүрдүүлэхэд оролцох, нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллагатай харилцах, тэдгээрийн үйл ажиллагааг хангах, асуудлыг бүтэцжүүлэх, бодлого боловсруулах \хууль тогтоох\, шийдвэр гаргах, хяналт тавих, зэрэг багтдаг. Түүнчлэн энд бас засаглалын систем дэх олонхи хийгээд цөөнхийн намуудын харилцаа, парламентын гишүүд удирдлагуудын харилцаа, парламентын гишүүн намын гишүүдийн хоорондын болон тэдний төр засгийн үндсэн аппараттай тогтоосон харилцаагаар нөхцөлдсөн чиг үүргүүд багтдаг. Тэгвэл хоёр дахь бүлэг чиг үүрэгт нийгмийн төлөөллийг хангах, нийгэмшүүлэх, ашиг сонирхолыг нэгтгэх, улс төрийн соёл, хариуцлагыг хэрэгжүүлэх, иргэний нийгмийн байгууллагуудтай харилцахтай холбоотой чиг үүрэг хамаарагддаг. Ингэж намууд улс төрийн системийн бие даасан институтын хувьд өөрт онгодсон жам ёсны чиг үүргээр дамжуулан улс төрийн бүхэл системтэй гүн гүнзгий холбоо харилцаанд оршдог байна.

Мэдээлэл-солилцооны коммуникатив механизм. Намыг улс төрийн системтэй холбогч нэг чухал механизм нь коммуникаци юм. Коммуникаци \communication\ гэдэг нэр томъёог толь бичгүүдэд харилцах, мэдээ мэдээлэл гэсэн агуулгаар тайлбарладаг. Америкийн судлаач К.Дойч мэдээлэл солилцох үйл явцыг коммуникаци гэж үзсэн байдаг. Х.Лассуэлл коммуникацийн үйл явцын агуулгыг “Хэн юуг, ямар сувгаар, хэнд, ямар үр нөлөөтэйгээр хэлж байна вэ?” гэж товч тодорхой томъёолсон нь ихээхэн алдаршиж, коммуникацийн судалгааны үндсэн загвар болсон билээ. Нийгмийн системд коммуникац нь өргөн хүрээтэй үзэгдэл бөгөөд улс төрийн амьдралын хүрээний коммуникацийг судлаачид улс төрийн коммуникаци /Political communication\ хэмээдэг.

Улс төрийн коммуникаци гэдэг нь улс төрийн бодлогын үндсэн оролцогчдын өөр хоорондын харилцан үйлчлэл, мэдээлэл дамжуулах үйл явц билээ. Системийн онолын дагуу улс төрийн коммуникаци хэмээх нэр томъёоны “улс төр” ба “коммуникаци” хэмээх хоёр хэсэг нь тус бүр нийгмийн системийн томоохон дэд

системүүдийг илэрхийлж байгаа юм. Улс төрийн систем нь нийгэмд бодлого боловсруулах, шийдвэр гаргах, харин коммуникацийн систем нь нийгмийн систем дэх бүх дэд системүүдийг өөр хооронд нь холбох үүрэг гүйцэтгэдэг билээ.

Нам нь улс төрийн коммуникацийн нэг үндсэн субъект болдог. Нам, улс төрийн системийн хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагааны тасралтгүй орчил явагдаж байдаг. Германы судлаач Н.Люман коммуникацийн үйл явцыг аман хэлбэрийн ухуулга сурталчилгаанаас эхлэн бичгэн хэлбэрийг дамжиж өнөөгийн электрон хэвлэл мэдээллийн үе хүрсэн “хувьсал” гэж үзсэн. Эндээс үзвэл нам, улс төрийн системийн хоорондох коммуникацийн үйл ажиллагааны дамжих суваг нь олон талтай болох нь ойлгогдож байна. Үнэхээрч энэхүү коммуникацийн хэрэгжих гол суваг нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, улс төрчдийн албан ба албан бус харилцаа, сонгуулийн кампани, мэдээлэл сурталчилгаа, олон нийтэд хандсан төрөл бүрийн арга хэмжээ, мэтгэлцээн, хэлэлцүүлэг, уулзалт, мэдээлэл солилцооны орчин үеийн хэрэгсэл, интернет, гар утас, дохио тэмдэг гэх зэрэг болдог. Нам, улс төрийн системийн хоорондын коммуникацийн үйл явцыг микро, макро гэсэн үндсэн хоёр түвшинд ялган зааглаж болох юм.

Нам, системийн хоорондын микро түвшний коммуникацийн үйл явцад намын улс төрч, лидерүүдийн хоорондын болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон түмний хоорондын албан ба албан бус харилцаа, хувь хүний үйл байдал, улс төрийн соёл, санаа бодол, сонгуулийн үеийн ухуулга сурталчилгаа, нэр дэвшигчдийн имиж, манипуляци гэх зэрэг улс төрч, олон түмний нийгэм сэтгэл зүйн болон ердийн ухамсарын түвшин дэх өргөн хүрээтэй коммуникацийг багтаадаг бол макро түвшний гэдэгт нийтэд хамаатай асуудлын талаарх шийдвэрийг томъёолох, нэгтгэх, хэрэгжүүлэхэд чиглэсэн коммуникацийн цогц үйл явцыг ойлгодог.

Германы судлаач У.Захсер улс төрийн коммуникацийг “хамтын шийдвэрийг илрүүлэн гаргах, томъёолох, хэрэгжүүлэх үндсэн механизм” гэж тодорхойлсон бол судлаач Д.Ярен “төрийн бодлогыг хэрэгжүүлэх асуудлаар улс орны удирдагчид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэдийн хооронд мэдээлэл солилцож буй үйл явц” гэсэн байдаг. Энэхүү улс төрийн коммуникацийг хэрэгжүүлэгч гол институт нь намууд юм. Орчин үед нийтийн боловсролын түвшин нэмэгдэж, мэдээлэл хүртээмжтэй болохын хэрээр иргэд улс төрд санаа бодол, дуу хоолойгоо хүргэх, ашиг сонирхолоо чөлөөтэй өргөнөөр илэрхийлэх хандлагатай болжээ. Тэд улс төрийн оролцоогоо зөвхөн сонгуульд оролцож саналаа өгөх явдлаар хязгаарлахаа больж, сонгуулийн болон сонгуулийн бус үед ч улс төрийн идэвх нь өндөр байж, тэдгээрийн хоорондын коммуникацийн хүрээ боломж өргөжих болсон байна.

Ийм нөхцөлд намуудад шаардлага, тулгалт, дэмжлэгийн хэлбэрээр дамжин ирэх коммуникацийн нөлөөлөл хурдацтай нэмэгдэх болсон билээ. Тэр бүхнийг намууд сонгуулийн сурталчилгаа, бодлого, хөтөлбөртөө нэгтгэн томъёолж, түүнийгээ тээн төрийн шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцон нөлөөлдөг. Үүний үр дүнд улс орны хөгжлийн бодлого концепци боловсрогдон, ард түмний амьдрал ахуйд нөлөө тусгаа үзүүлдэг. Энэ бол нам, улс төрийн систем тэр дундаа нам, төрийн засаглалын институт хоорондын коммуникацийн үйл явцын илэрхийлэл мөн билээ.

Эрх зүй- зохицуулалтын регулятив механизм. Намууд улс төрийн системтэй эрх зүй -зохицуулалтын механизмаар дамжин холбогддог. Эрх зүй зохицуулалтын нийтлэг хэм хэмжээ нь улс төрийн системийн бүрдэл элементүүдийг хооронд нь холбон уялдуулахаас гадна тэдгээрийн харилцааны легитимтийг ханган, тогтвортой оршин үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж байдаг.

Нам бол улс төрийн систем дэх хууль эрх зүйн нэг үндсэн субъект болдог. Намуудын дотоод, гадаад үүргийн хэрэгжилт, улс төрийн бусад институттэй харилцах харилцаа, төрийн засаглалын систем дэх үйл ажиллагаа зэрэг түүний үйл байдал, харилцааны бүхий л хүрээ нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль, эрх зүйн нийтлэг хэм хэмжээгээр зохицуулагдаж байдаг. Хэрвээ ийм зохицуулалтаас намууд ангид байх аваас түүнийг улс төрийн системийн легитимыг хангасан институт, системийн хууль ёсны бүрдэл элемент гэж үзэх аргагүй юм. Улс төрийн шинжлэх ухаанд намын легитимт шинжийг түүний бодлого, үйл ажиллагааг нийгэм, олон түмний зүгээс нийтээр хүлээн зөвшөөрч, улс төрийн хууль ёсны субъект болсоны илэрхийлэл гэж үздэг. Нам нь өөрийн легитимт шинжээр дамжуулан нийгмийн улс төрийн системийн хууль ёсны бүрэлдэхүүн хэсэг, түүний онцгой нэгэн институт болдог.

Улс төрийн намын хэм хэмжээ нь намын үйл ажиллагаа, дотоод ардчилал, бүтэц зохион байгуулалт, намууд хоорондын болон нам, төрийн засаглалын хоорондын харилцааг тус зохицуулахад чиглэгддэг бөгөөд ингэхдээ тэр нь эрх зүйн зохицуулалтын бүхэл цогц механизмаар дамжин хэрэгждэг. Энэ нь үндсэндээ намын бүхий л үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдсэн хууль эрх зүйн актууд юм. Улс төр, эрх зүйн шинжлэх ухаанд намын хууль эрх зүйн актыг ерөнхийд нь нэгд, ерөнхий эрх зүйн; хоёрт, корпоратив; гуравт, ёс зүйн гэсэн хэв маягт хуваан ангилж болно. Ерөнхий эрх зүйн акт гэдэгт улс төрийн намуудын харилцаа, хамтын ажиллагааг зохицуулж байгаа Үндсэн хууль, улс төрийн намуудын хууль болон бусад хуулиудыг багтааж байгаа бол харин корпоратив эрх зүйн акт нь намын дотоод үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, дотоод ардчиллын хэм хэмжээг зохицуулахад чиглэгдсэн дүрэм, журам, намын эрх бүхий дээд байгууллагаас гаргасан бусад эрх зүйн актуудыг ойлгодог. Тэгвэл ёс зүйн гэдэг нь намын гишүүд, улс төрчдийн үйл ажиллагаатай холбоотой бичигдээгүй ёс зүйн үнэт зүйлс түүгээр тодорхойлогдож байдаг хэм хэмжээг хэлдэг. Ийнхүү намууд нийгмийн улс төрийн системтэй дээрх механизмаар холбогдсоноор улс төрийн системийн салшгүй бүрдэл нь болоод зогсохгүй мөн өөрөө бүхэл бүтэн амьд бие даасан систем болон оршин үйлчлэх нөхцөл бүрддэг.

Систем ба нам. Нам бол улс төрийн системийн салшгүй нэгэн бие даасан дэд систем мөн. Намыг систем гэдэг агуулгаар авч үзэх тохиолдолд түүнийг Д.Истоны улс төрийн системийн онолын загварт оруулан шинжлэн үзэхэд сонирхолтой дүр зураг харагддаг юм. \Бүдүүвч №2 \

Бүдүүвч № 2. Улс төрийн систем, нам, намын тогтолцооны харилцан хамаарал\ Д.Истоны загвараар\



Намыг Д.Истоны улс төрийн эмпирик онол ёсоор нийгэмд үнэт зүйлсийг эрх мэдлийн тусламжтай хуваарилан байршуулах үйл ажиллагааны тасралтгүй явагдах орчил гэж үзэж болно. Энэ нь оролт, хувиргалт, гаралт гэсэн циклээр хэрэгждэг. Намын системийн “оролт”-нд нийгэмд байдаг олон янзын ашиг сонирхол, үзэл бодол, байр суурь түүгээр дамжин илрэх олон түмний гадаад, дотоод шаардлага, хүсэлт, итгэл дэмжлэг \ санал өгөх, татвар, хандив, дэмжлэгийн оролцооны бусад хэлбэр \ -ийг багтаан үзэж болно. Системийн “оролт” дээр нам нь сонгуульд нэр дэвшүүлэх, хүний нөөцийн бааз сууриа бэхжүүлэх, улс төрийн сонирхолын артикуляци хийх, тэдгээрийг ялган нэгтгэж тодруулах, үйл ажиллагааны хөтөлбөр, бодлогоо цэгцлэх, түүнийг түгээн сурталчлах, нийгмийн төлөөллөө бэхжүүлэх, сонгуулийн кампанийн бэлтгэлийг хангах, сонгуулийн өмнөх тэмцэлд оролцох, сонгогчдыг талдаа татаж, дэмжлэг итгэлийг хүлээх гэх зэрэг гол төлөв дотоод чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Харин системийн “хувиргалт” дээр намууд оролтоос шаардлага, дэмжлэгээр орж ирсэн мэдээллийг боловсруулан нэгтгэн томъёолж, сонирхол, үзлийн агрегаци хийж, тэдгээрийг төрийн бодлогод тусгуулах зорилгоор шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцон нөлөөлж ажилладаг. Үүнийг хэрэгжүүлэх гол механизм нь парламентад бүрдсэн түүний үйл ажиллагааны гол бүтэц болох намын бүлэг, тэдгээрийн цогц болох намын систем \ хоёр намын, олон намын, эвслийн \, засгийн газар дахь намуудын оролцоо юм. Энэ хүрээнд түүний төлөөлөх, нийгэмшүүлэх чиг үүрэг давхар хэрэгжиж байдаг.

Системийн “гаралт” дээр намын төрийн засаглалын хүрээн дэх үйл ажиллагааны үр дүн гардаг. Энэ нь тухайн намын идэвхтэй оролцоо, дэмжлэгтэйгээр боловсруулан гаргасан хууль, тогтоомж, шийдвэр, санал дүгнэлт \ шийдвэр \, түүнийг хэрэгжүүлэх идэвхтэй үйл ажиллагаа \ үйлдэл \ юм. Нам нь гаргасан шийдвэрийн биелэлтэнд хяналт тавьж, хэрэгжилтийн үр дүнг тооцон ажилладаг. Хэрвээ гаргасан шийдвэр түүнийг дагаж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь зөв зүйтэй байвал “эргэх холбоо”-гоор дамжин системийн оролтын дэмжлэг дээр мэдээлэл буюу сигнал очих учиртай. Харин буруу, амьдрал дээр нийцэмжгүй байвал мөн эргэх холбоогоор оролтын шаардлага дээр сигнал очдог. Энэхүү хоёр хэлбэрийн сигнал нь намын цаашдын бодлого, үйл ажиллагааных нь циклийн эхлэл болдог. Намын системийн үйл ажиллагааны энэ орчил тасралтгүй байнга тогтвортой явагдаж байх ёстой юм.

НОМ ЗҮЙ

1. Д.Болд-Эрдэнэ. “Монголын нийгмийн улс төр ба нам” Улс төрийн шинжлэх ухааны доктор (Sc.D) зэрэг горилсон бүтээл. УБ.,2016
2. Д.Болд-Эрдэнэ. “Нийгэм улс төрийн систем дэх олон намын тогтолцоо: онол, арга зүй.” Бодрол, бясалгал” 1992 №4, 3 тал.
3. Angelo Panebianco. Political parties: organization and Power. Cambridge., 1988
4. Philip Selznick. Leadership in Administration. London.,1986
5. Х.Шахназарова. Современная буржуазная политическая наука: проблемы государства и демократии.М.,1982
6. М.Дюверже. Улс төрийн байгууламж. УБ., 2007.
7. Г..Алмонд, Дж.Пауэлл, К.Стром, Р.Далтон. Харьцуулсан улс төр: онолын хүрээ. УБ., 2005
8. Ц.Мөнхцэцэг. Сонгуулийн кампанийн коммуникаци. \ Монгол улсын жишээн дээр. Улс төрийн ухааны доктор \ Ph.D\ зэрэг горилсон бүтээл. УБ., 2009

ХӨГЖИЖ БУЙ ОРНУУД ДАХЬ БЮРОКРАТ УДИРДЛАГЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ, ЦААШДЫН ХАНДЛАГА

Ц.БАТБОЛД

*Доктор, дэд профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхим*

Түлхүүр үг: Нөлөөлөл, мерит зарчим, тайлагнах чанар, хүртэх боломж, ил тод байдал, практик болон судалгааны дүгнэлт

Товч агуулга: Олон шинжээчид өнөөгийн эрх баригчдын удирдах үйл ажиллагааг хангалтгүй төвшинд байна гэж үздэг. Мэргэжилтнүүд дэлхийн нийт хүн амын 51 хувьтай тэнцэх хэмжээний, шилжилтийн нийгэм бүхий хөгжиж буй 16 оронд судалгаа хийжээ. Дэлхий дээрх Засаглалын Судалгааны (WSG) төвөөс гаргасан энэхүү судалгааны гол зорилго нь шинэ тогтолцоог нэвтрүүлэх явдал юм. Бюрократ ёс нь зөвхөн хувь хүний хэмжээнд бус засаглалын хүрээнд судлагдах учиртай. Хүнд суртлыг бий болгож буй албан болон албан бус дүрэм журмууд нь төр хэрхэн үйл ажиллагаа явуулж буйд чухал нөлөөтэй. Засгийн газар болон иргэдийн хооронд байгуулсан олон гэрээ, санал хүсэлт, тусламж хүссэн хүсэлтийн хэрэгжилтийн үйл явц нь хүлээлт зэргээс үүдэн хүнд суртлыг бий болгосоор байгааг судалсан.

Abstract: The framework for implementing policy is very important. Day-to-day management of government operations affects the impression citizens have not only of individual departments but often the regime (deglem) as a whole. In other words, how policy-implementation is structured constitutes an important aspect of governance. The specific questions we used in the WGS were: a) To what extent are higher civil servants a part of the policy-making process? (the influence. indicator); b) To what extent is there a merit-based system for recruitment into the civil service? (the meritocracy. indicator.); c) To what extent are civil servants accountable for their actions? (the accountability. indicator); d) To what extent are there clear decision-making processes in the civil service? (the transparency. indicator); e) To what extent is there equal access to public services? (the .access. indicator);

As reported in Working Paper 3, there is clearly much discontent (durguitsel) about the bureaucracy in many countries. The aggregate scores (niit onoo) are among the lowest of all the different arenas. The bureaucracy also records relatively modest improvement over time. There are plenty of references in the commentaries (tailbar) that nepotism (tanil talaa dewshuuleh) and various forms of corruption continue to affect the civil services in many countries. This section looks at two issues: (i) the aggregate scores for the countries, and (ii) the changes over time and some of the reasons behind these changes.

НҮБ-н Ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Аннан НҮБ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн 1998 оны тайланд өгүүлэхдээ “...зөв удирдлага гэдэг бол ядуурлыг үгүй хийж, хөгжлийн гарцыг нээх томоохон үндэс суурь юм”⁵⁵ гэж онцлон тэмдэглэжээ. Удирдлагын төвшинд ямар ч асуудал бий боллоо гэсэн түүний үйл ажиллагаанд илүү хариуцлагатай хандах хэрэгтэй. Олон шинжээчид өнөөгийн эрх баригчдын удирдах үйл ажиллагааг хангалтгүй төвшинд байна гэж үздэг. Мэргэжилтнүүд дэлхийн нийт хүн амын 51 хувьтай тэнцэх хэмжээний, шилжилтийн нийгэм бүхий хөгжиж буй 16 оронд судалгаа хийжээ. Дэлхий дээрх Засаглалын Судалгааны (WSG) төвөөс гаргасан энэхүү судалгааны гол зорилго нь шинэ тогтолцоог нэвтрүүлэх явдал юм. Тэд хийсэн судалгааны ажлаа илүү хөнгөвчлөх зорилгоор удирдлагын салбарыг доорх зургаан чиглэлд хувааж үзсэн байна. Үүнд:

1. Иргэний нийгэм – Иргэд улс төрийн асуудалд илүү оролцоотой болгох;
2. Улс төр – Нийгмийн сонирхол улс төр лүү чиглэж ирэх;
3. Гүйцэтгэх засаглал – Бүхий л нэгдсэн тогтолцооны дүрэм журам;
4. Бюрократ – Хэрхэн бодлого хэрэгжүүлэхэд чиглэл өгөх;
5. Эдийн засаг – Төр, зах зээлийн хоорондын холбоо хамаарлын бүтэц болон бусад;
6. Шүүх салбар - Маргаан зөрчлийг хэрхэн зохицуулах талаар;

Төслийн хүрээнд шударга ёс, ёс журам, хариуцлагын тогтолцоо, ил тод байдал, үр ашигт чанар зэрэгт үндэслэн тус бүрдээ таван хэсэгт салбарласан 30 нэр төрлийн шинж чанарыг тогтоосон байна. Улс орон бүрт үнэлэмжийг тогтоох үйл ажиллагааг гүйцэтгэхээр 35-40 хүний бүрэлдэхүүнтэй шинжээчдийн хэсгийг байгуулсан. Бүрэлдэхүүнд нь төрийн албан хаагчид, улс төрчид, бизнес эрхлэгчид, судлаачид, төрийн бус байгууллагын төлөөлөгчид, хуульчид, нийгмийн ажилтнуудын төлөөллийг багтаасан аж. Тэдэнд тус бүрт нь 1-5 гэсэн үнэлгээ өгөх асуулт тавьсан юм. Мөн түүнчлэн, хариуцагчид үнэн бодит санаа бодлоо илэрхийлэх

⁵⁵ Кофи Аннан-Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг: Жил бүрийн тайлан НҮБ-1998

боломжтой. Үүнээс өмнөх хэлэлцээрүүдэд “Удирдлага болон Хөгжил”⁵⁶, “Удирдлагыг тодорхойлох”, “Арга зүйн сорилтууд”⁵⁷ зэрэг асуудалд анхаарлаа хандуулсан байна. Энд зөвхөн бюрократ гэдэг сэдэв дээр төвлөрөн авч үзэе.

Бюрократ удирдлагын асуудал нь бодлого боловсруулалт болон хэрэгжилтийн төвшинд яригдахаас гадна төрийн үйлчилгээг зохицуулахад ч хамааралтай. Удирдлагын бюрократ загвар нь дан ганц хөгжлийн мөн чанар бус, харин тухайн улсын нийгэм эдийн засаг нь дэвшилд хүрэх үү үгүй юу гэдгийн томоохон шийдвэрлэх хүчин зүйл болдог. Энэ асуудал нь төвлөрсөн засаглал бий болсноос хойш гарч ирэн хэдэн зуун жил М.Веберийн⁵⁸ онол ёсоор амьдрал, практикт мөн л хэрэглэгдэж байжээ. Сүүлийн үеийн социологийн болон бүх нийтийг хамарсан эмпирик судалгаанаас үзэхэд бюракратын мөн чанар нь хөгжлийн биелэлтэнд чухал гэдэг нь баглагдах болсон.⁵⁹ Бюрократ нь Зүүн Өмнөд Азийн эрчимтэй хөгжлийн нэгээхэн шалтгаан болсон.⁶⁰ Субстанци уран зохиолд Африк тивийн олон орон дахь бюрократ удирдлагын эмзэг байдлыг тусгасан байдаг. Бюрократуудын хүрээнд удирдлагын асуудал нь сүүлийн жилүүдэд илүү үр өгөөжтэй, хүмүүст хүрэхдээ хялбар болсоор байна.⁶¹ Нийтийн захиргааны агентлагуудад сүүлийн жилүүдэд дарамт шахалт ихээр үзүүлэх болсноос үүдэн үйл ажиллагааны чанар сайжирч байгаа нь давуу талтай.⁶² Хөгжиж буй орнуудад нэн ялангуяа бүтцийн зохицуулалтанд хамрагдаж буй орнуудад энэ нь зах зээл дэх төрийн болон иргэний үүргийг эрс багасгаж байна. Эдгээр орнууд дахь эдийн засаг нийгмийн эмзэг байдал нь бюракратын зохион байгуулалтын үр нөлөөг сайжруулах гэх мэт олон асуудлыг ар араасаа дагуулж байдаг.

Бюрократ ёс нь зөвхөн хувь хүний хэмжээнд бус засаглалын хүрээнд судлагдах учиртай. Хүнд суртлыг бий болгож буй албан болон албан бус дүрэм журмууд нь төр хэрхэн үйл ажиллагаа явуулж буйд чухал нөлөөтэй. Засгийн газар болон иргэдийн хооронд байгуулсан олон гэрээ, санал хүсэлт, тусламж хүссэн хүсэлтийн хэрэгжилтийн үйл явц нь хүлээлт зэргээс үүдэн хүнд суртлыг бий болгосоор байна.⁶³ Саяхан гаргасан “Voices of the Poor” судалгаанаас үзэхэд амьдралын төвшин доогуур хүмүүсийн хүнд суртлын талаарх ойлголт ихэвчлэн таагүй байдаг ажээ.⁶⁴ Улс орнуудын олон нийт (ард түмний)-ийн дотор бюрократ удирдлагын зохицуулт хэрхэн хэрэгжиж байгаа арга нь тухайн улсын бодлого хэрэгжилтүүдийн бодит ялгааг гарган харуулдаг. Нөгөө талаас хүмүүс ихэнхдээ түүний хүнд сурталт сөрөг талыг нь шүүмжлэн гаргаж тавьдаг. Хууль ёсны дүрэм журмыг бодит хэрэгжилттэй нэгтгэснээс үүдэн бюракрат нь сөрөг талаасаа илүү ойлгогддог. Үүний ихэнх нотолгоо нь социологийн судалгаагаар хязгаарлагдаж байна. Дэлхийн улс орнуудын хооронд системчлэгдсэн мэдээлэл дутмаг байдаг.⁶⁵

Ямар дүрэм журмууд хамгийн үр дүнтэй, хууль ёсных байж болох вэ? Хөгжлийн өөр өөр төвшинд одоогийн асуудлууд чухал уу? Эдгээр болон бусад олон асуудлуудад хангалттай хариулт өгөх боломжгүй гэж үзсэн байна. Харин гагцхүү бодлого боловсруулалтын төвшинд яригдаж болохуйц чухал дүрмүүдийг бий болгох боломжтой. Юуны түрүүнд бюрократ ба хөгжлийн асуудалтай холбогдох түлхүүр асуудлуудыг олох хэрэгтэй гэж үзсэн. Үүний тулд бюракратын зарчим, гүйцэтгэл, түүнчлэн хөгжлийн асуудалд анхаарлаа хандуулсан байна. Дараах дүгнэлтийг хийхийн тулд өмнөх хэлэлцүүлгийн үр дүнг хавсарган, судалгаа дадлагын талаар ярилцана.

Засаглал, удирдлагын сэдэвтэй судалгаа, шинжилгээний бүтээлүүд олширч байна. Үүний ихэнх хувь нь улс төрийн засаглал, нийтийн захиргааны удирдлага, иргэний нийгэм болон зах зээлийн тулгамдсан асуудлууд болж байгаа бөгөөд тэдгээрийг төлөөлөгчдийн хамтын ажиллагаа гол төв нь болж буй. Судалгаа, шинжилгээний үр дүн чухал байр суурьтай ч түүнийг шийдвэр гаргах үйл ажиллагаанд тэр бүр ашиглахгүй байгаа нь хөгжиж буй орнуудад ихээхэн нөлөөлж, тэдний удирдлагын алдаа, ононд хувь нэмрээ оруулж буйг анхааран үзэх хэрэгтэй юм. Төрийн эсхүл нийтийн захиргааны бюрократ удирдлагын үйл ажиллагаа нь эдийн засгийн өсөлт, хөгжлийн үр дүнтэй хэрхэн харилцан уялдаж буй нь олон улсын хөгжлийн хамтын нийгэмлэг зэрэг судалгааны байгууллага, судлаачдын анхаарлыг татсаар ирсэн юм. Өдгөөгөөс 40-өөд

⁵⁶ Даниель Кауфман, Аарт Края, болон Пабло Зойдо-Лобатон . Засаглалын тухай 2. Шинэчилсэн. 2000/01 Дэлхийн банкны бодлого судалгааны төв. № 2772, 2002.

⁵⁷ Горан Хайдн , Жулиус Корт, 2002 он, Удирдлага болон Хөгжил, Дэлхийн Удирдлага судлалын хэлэлцээр, 1-р хуудас ,Токио, НҮБ Жулиус Корт, Горан Хайдн , Кеннэт Мийз, 2002 он, Удирдлагын үнэлэмж : Арга зүйн арга барил, Токио

58 Жулиус Корт, Горан Хайдн , Кеннэт Мийз, 2002 он, Удирдлагын үнэлэмж : Арга зүйн арга барил, Токио

59 М.Вебер , Нийгэм эдийн засгийн байгууллагын онол. Нью-Йорк. Чөлөөт хэвлэл 1947.

⁶⁰ Д.Кауфман , А.Края, болон П.Зойдо-Лобатон. Удирдлагын асуудал. Бодлого судлалын сонин № 2195. Вашингтон ДС: Дэлхийн банк, 10 дугаар сар. 1999: П.Эванс болон Ж.Э.Рауч, Хүнд суртал ба түүний өсөлт: М.Веберийн судалгаа. Эдийн засгийн өсөлтийн судалгаа, Америкын Социологийн судалгаа №64, №5 , хуудас 748-765, П.Эванс болон Ж.Э.Рауч, Буурай хөгжилтэй орон дахь хүнд суртлын бүтэц, тоглолт, Олон нийтийн сэтгүүл, 75, хуудас 49-71.

⁶¹ Петер Эванс, Автономит, Улс орны аж үйлдвэрийн хувьсгал, Принсетон Их Сургуулийн хэвлэл 1995, ба Дэлхийн банк. Зүүн Азийн Шинэчлэл: Эдийн засгийн өсөлт ба бодлого, Нью-Йорк: Оксфордын Их Сургуулийн хэвлэл 1993

П.Блант. Байгууллагын онол ба хандлага. Африкийн хэтийн төлөв. Лондон. Лонгман 1983. Горан Хайдн . Африкийн хөгжил дэвшил. Беркли , Калифорнийн Их Сургууль, Хейнэмман хэвлэл 1983

62 П.Блант. Байгууллагын онол ба хандлага. Африкийн хэтийн төлөв. Лондон. Лонгман 1983. Горан Хайдн . Африкийн хөгжил дэвшил. Беркли , Калифорнийн Их Сургууль, Хейнэмман хэвлэл 1983

⁶³ Судалгааны ажлын хүрээнд хүнд суртлын хэмжээг шууд гаргаагүй болно. Бюракратын сул байдал ба хөгжлийн хооронд холбоо хамаарал байхгүй болно. А. Гоулдсмит. Африка. Дэлхийн улс төр. 51. 1999 оны 7 дугаар сар,

64 Д.Нараян, Р.Пател, К.Шаффт, А.Радемашер болон С.Кош-Шалте. Ядуусын дуу хоолой. Биднийг сонсож байна уу? Вашингтон ДС, Дэлхийн банк 2000.

⁶⁵ Майкл Крозьер, Хүнд суртлын үзэгдлүүд. Чикаго, Чикагогийн Их Сургуулийн хэвлэл 1964 он.

жилийн тэртээ энэ асуудал хөгжлийн гол төв нь болсон юм.⁶⁶ Сүүлийн үед зарим нэг талаараа тэр үетэй төсөөтэй таамаглалууд, нэмэлт ойлголтын хамт бий болсон бөгөөд энэ нь бюрократ ёсны зарчим хөгжилд хэрхэн нөлөөлдгийг харуулж байна.

Дэлхийн банк, Эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ОЕСД) зэргийн үйл ажиллагаа нь засаглалын тоглолт, хөгжлийн үр дүн хоёрын харилцан холбоог бий болгоход чиглэгдэж байна. Өмнө нь хэрэглэж байсан анализ шинжилгээ, удирдлагын ухагдахуун нь Кауфман болон түүний хамтран зүтгэгчдийн⁶⁷ гарган боловсруулсан 6 хэмжээст - 6 огтлоос бүхий “Удирдлагын үр ашиг” гэсэн нэртэй сэдвийн гол утга санааг илэрхийлэх боломжтой аж. Энэ хэмжээс нь бюрократ түүний хүнд суртал байдлын чанар, нийгмийн үйлчилгээ үзүүлэх байдал зэргийг өөртөө багтаасан байна. Тэдний үзсэнээр удирдлагын үр ашиг нь хөрөнгийн орлого, насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт зэрэгт эерэг нөлөө үзүүлдэг бол, нөгөө талаас нялхсын эндэгдэл зэрэг нийгмийн нөхцөлд сөрөг нөлөөтэй болох нь ажиглагджээ. Кауфманы үзсэнээр энэ нотолгоогоор эдийн засгийн хөгжил нь сайн засаглалд хүргэж чаддаггүй, гагцхүү түүнийг бага зэрэг сайжруулдаг гэжээ.

Энд Дэлхийн банк цорын ганц оролцогч биш бөгөөд сүүлийн жилүүдэд олон тоглогчид хүнд суртлын тоглолтыг ялган ангилахад оролцож байна. Тухайлбал, “Эдийн засгийн чадамжийн төв” (EIU) зэрэг байгууллагаас бүс нутгийн хэмжээгээр чанар, хуулийн зарчим, глобал сүлжээний гажуудал зэргийг гаргаж ирсэн. Олон улсын ил тод байдлын газар (Transparency International)-аас авлигын жил бүрийн индексийг гаргадаг. Ер нь бол иймэрхүү агентлаг, судалгааны байгууллагууд нь бюрократ үйл ажиллагаа, түүний дэг журам, түүнчлэн засгийн газрын байр суурь, нийтийн гажуудал зэрэгт субъектив байр суурьтай оролцдог. Хөгжлийн төлөө бюрократын чанарын талаар олон туршилтын судалгаа хийгдэж байсан ажээ. Тухайлбал, “Эдийн засгийн чадамжийн төв” (EIU)-өөс бюрократын ашигт чанар нь хөрөнгө оруулалт, түүний өсөлттэй холбогдож байна гэж үзжээ. Гэтэл нөгөө талаас гажуудал бий болоод П.Мауро нарын судлаачид үзсэн байна.⁶⁸ ICRG, Transparency International-ын гаргасан тоо баримтанд тулгуурлан Накк болон Кифер нар “Удирдлагын индекс томоохон байр суурьтай гэж болох бюрократ үйл ажиллагааны чанар нь хөрөнгө оруулалт, түүний өсөлтөд эерэг нөлөөтэй” гэж үзсэн⁶⁹ байна. А.Чун, Ц.Калдерон нар байгууллын чанар, эдийн засгийн харилцан холбоог мөн энэ мэт тайлбарласан боловч энэхүү урвуу хамаарал нь эдийн засгийн өсөлтийг бий болгодог гэж дүгнэжээ.⁷⁰

Орчин үеийн судлаачдын хандлага тэдгээрийн зохиол бүтээл нь өмнөх үеийнхний хөгжлийн талаар хийсэн хувь нэмэр, тэр дундаа Макс Вебер болон түүний үеийнхний энэ асуудал дээр хандсан зарим зарчмын талаар эсрэг байр суурьтай байсан юм. Тухайлбал, Кауфманы багийн бүрэлдэхүүн энэхүү тоо баримтыг нэгтгэн дүгнэж, хөгжлийн статистик бодлогод хувь нэмэртэй оролцсон байна. Нөгөө талаас энэ төрлийн тоо баримтууд нь хөгжлийн үйл явц дахь удирдлагыг дүгнэх гол түлхүүр мөн гэдэгт бид итгэдэг. Гэвч орлогыг бүрдүүлэх, олон нийтэд үйлчилгээ үзүүлэх, эдийн засгийг зохицуулах зэрэг асуудлууд нь зөвхөн статистикаар хэмжигдэх боломжгүй юм. М.Леви, М.Мур нарын судлаачид “...тэр дундаа, обьектив талаасаа үйлдлийг сайжруулдаг тохиолдолд статистик хэмжилт бүр боломжгүй”⁷¹ гэж үзжээ. Энэ мэт асуултанд хариулт өгөхөд илүү өргөн, өндөр чанарт хэмжээгээр сэтгэх шаардлагатай болно. Эванс болон Рауч нарынхаар улс орон дамнасан статистик нотолгоо нь засгийн газар эдийн засгийн өсөлтөд нөлөөтэй гэдгийг улам баталгаажуулж байна. Бид үүнээс байгууллын онцгой шинж хэрхэн гажуудал бий болгодог талаар бага ч атугай мэдэх боломжтой⁷² гэжээ.

М.Веберийнхээр орчин үеийн онол ёсоор бюрократад тогтолцоонд олон тооны бүтэц зохион байгуулалт шаардлагатай гэж үздэг. Үүний гол маргааныг нь Эванс болон Рауч нар боловсруулсан бөгөөд улс орны хөгжилд мэргэжлийн бюрократуудын үйл ажиллагаа “тоглолт” хэрэгтэй байдаг гэжээ.⁷³ Олон нийттэй харилцагчид нийтийн анхаарлын төвд байдаг. М.Вебер үзэхдээ гол асуудал нь нийтийн мөнгө, түүний хэрэглээ болон албан хаагчдын хувийн өмчийн хоорондох ялгаа юм гэжээ.⁷⁴ Зүүн Азийн орнуудын алтан үеийн түүхээс үзвэл бюрократ ёсны гүнзгий уламжлал ёс заншил нь хөгжлийн гарцыг нээж байжээ.⁷⁵ Гэтэл нөгөө талаас Африкийн улсуудад төрийн албан хаагчид өөрийн эрх ашгаа бусдынхаас өмнө тавьдаг гэх байдал нь ямагт анхаарлын төвд байдаг.⁷⁶ Африкийн улсуудын засгийн газрууд ажилгүйдэл болон бусад олон нийгмийн асуудалд анхаарал хандуулахгүй байна гэж шүүмжлэгддэг. Хэдийгээр санхүүгийн шахалтын дор олон нийтийн ажил эрхлэлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж байсан ч байдал хэвээрээ байсан аж. Энэ талаар Дэлхийн банк Африкын орнуудын засгийн газрууд нь гэр бүл, найз нөхөд, дэмжигчдэд ажлын байр олгодог гэж дурджээ.⁷⁷

⁶⁶ Барнард Шаффер, Хөгжлийн гарц дахь мухардал. Хөгжиж буй орнуудын улс төрийн хувьсгал, Лондон. Лонгман 1969

⁶⁷ Кауфман, Аарт Краая болон Массимо Матруцци 2003. Удирдлагын асуудал 3. Удирдлагын шинэчлэл 1996-2002. Вашингтон ДС. Дэлхийн банк. 5-дугаар сар

⁶⁸ Паоло Мауро. Хээл хахууль ба өсөлт. Эдийн засгийн сэтгүүл. № 110. 1995 он, хуудас 681-712.

⁶⁹ Стефен Накк болон Филипп. Байгууллагын болон эдийн засгийн байдал. Улс дамнасан судалгаа.

⁷⁰ Алберто Чун болон Цесар Калдерон., Эдийн засгийн өсөлт, Эдийн засаг болон улс төр. №1. 2000 он. Хуудас 69-81

⁷¹ Маргарет Леви, Хууль дүрэм ба орлого. Беркли. Калифорнийн Их Сургуулийн хэвлэл. 1988 он: Мик Мур: Татваргүй үхэл. Оксфордын Их Сургуулийн хэвлэл. 1997 он.

⁷² Эванс болон Рауч нар, 1999 он

⁷³ Эванс болон Рауч нар, 1999 он.

⁷⁴ М.Вебер, 1947 он

⁷⁵ Дэлхийн банк, 1993 он

⁷⁶ Хайдн 1983 он, мөн Ричард Жозеф. Нью-Йорк хот. Кембрижийн Их Сургуулийн хэвлэл 1987 он.

⁷⁷ Дэлхийн банк, Дэлхий ертөнц хувьсан өөрчлөгдөж байна. Дэлхийн хөгжлийн тайлан. 1997 он. Нью-Йорк хот. Оксфордын Их Сургуулийн хэвлэл, 1997 он. Хуудас 1995.

Чадварлаг хүмүүст боломжийн цалин олгох нь төрийн албанд орж, түүндээ тууштай ажиллах урам зориг өгдөг. Зүүн Азид өндөр нөхөн төлбөр олгодог нь төрийн албан хаагчдад таатай нөхцөл олгодог. Гэвч өндөр цалин олгох нь гажуудлыг үгүй хийж, илүү сайн үйл ажиллагааг бий болгодог гэх баталгаа биш юм. Ихэнх судалгаагаас үзэхэд өндөр цалин хийгээд, хээл хахуулийн бага төвшин хоёрт эерэг харилцаа үгүй байна гэж үздэг. Үүний нэг нь Ван Рижкегэм болон Б.Ведер нарын тодорхойлолт юм.⁷⁸ Хүнд суртлын талаар яригдах ёстой бас нэгэн сэдэв бол төрийн албан хаагчдын дүрэм журмаа хэрхэн даган мөрдөж буй явдал. Эдгээр дүрэм журам нь шийдвэр хэрхэн гардаг, нийгмийн албан хаагчид хэрхэн өөрсдийгөө удирдан чиглүүлдэг вэ гэх асуудлуудтай зайлшгүй холбогдоно.⁷⁹ Нэг талаар дүрэм журмын биелэлт нь олон нийтийн бюрократад хэрхэн ханддаг байдалтай холбогдох боловч хамгийн чухал нь үр дүн юм. Шийдвэр гаргалт нь үр дүнг илүүтэй бэхжүүлдэг. Нийтийн өмчийг буруугаар ашиглах, буруу шийдвэр гаргах зэрэг нь дүрэм журмын ил тод байдлаас илүүтэйгээр өндөр хувьтай байдаг.⁸⁰

Дүрэм журмыг баримтлах нь төрийн албадад маш чухал. Хяналтын тогтолцооны байгууллага байхгүй бол бюрократын дотоод журмыг хүчлэн шахаж болдоггүй. Аудитын газрынхан, иргэдийн төлөөлөгчид, авлигатай тэмцэх газрынхан олон нийтийн үйлчилгээнд чухал байр суурьтай оролцдог. Гэсэн ч тэд дотоод асуудлын нарийн ширийнд хүрч чадахгүй. Нийгэм дэх бодлогын асуудал нь ерөнхийдөө нэгдмэл, олон талын чанартай. Засгийн газрын бодлого боловсруулалт болон хэрэгжүүлэх үйл явц нь өндөр мэргэжилтнүүдийн зөвлөгөө дэмжлэгээр явагддаг бөгөөд энэ нь бюрократын үйл ажиллагаа, түүний үйлчилгээ үзүүлэхэд томоохон нөлөөтэй. Зүүн Азид улс төрийн албанд томилох явдал нь бүс нутгийн амжилтын нэг томоохон шалтгаан болдог.⁸¹ Бюрократ удирдлагын шийдвэр гаргалтад оролцогчдын хүрээ хэдийгээр олон янз байдаг боловч үүнд улс төр болон олон нийтийн аль алиных нь нөлөө их хэрэгтэй.⁸² Солонгос Япон жишээгээр бол бюрократууд болон хувиараа ажиллагсад өөр хоорондоо харилцаатай болохын тулд их урт хугацаа шаардлагатай байдаг⁸³ ажээ.

Веберийн талыг баримтлагчид, тодруулбал Рауч болон Эванс нар тэдгээр хоёр орны үйл явцад бюрократын бие даасан (автономи) байдал нь сайнгүй оролцоотой гэж үзжээ. Ази болон Латин Америкын 35 орныг харьцуулан үзэхэд Веберийн талынхан бюрократ нь эдийн засгийн өсөлтөд сайнаар нөлөөлж байна гэж дүгнэжээ. Мөн Ж.Корт, П.Кристэн, Б.Ведер нар Азийн бюрократын төвшин Африкийнхаас илүү байна гэж үзжээ.⁸⁴ Үүний үр дүнд бюрократын сайн тоглолт нь хүчирхэг байдаг бөгөөд тэд бодлого боловсруулалт, нийтийн үйлчилгээтэй зайлшгүй холбогдоно. Олны анхаарлыг бюрократ автономийн асуудалд ихээхэн хандуулж байна. Бюрократад бие даасан үйл ажиллагаа нь чухал байдаг. Хууль дүрмийн бус байдал нь энэ асуудлыг илүү эргэлзээтэй болгож байна. Зарим нийгмийн бүлэглэлүүд бие биенээсээ илүү хүчирхэг байдаг нь үүнээс улбаатай.

WSG судалгааны байгууллагабюрократын талаарх тоон баримтуудад тулгуурлан хөгжиж буй улс орнуудын захиргааны байгууллагуудын хичээл зүтгэлийн цар хүрээ олон нийтэд хэрхэн үйлчилж буйг сонирхож үзжээ. Тэд улс төрийн бодлого хэрэгжүүлэх нь их чухал зүйл. Тиймээс өдрөөс өдөрт засгийн газрын үйл ажиллагааны гүйцэтгэл нь дан ганц иргэдийн санаа бодол, хувийн салбарт төдийгүй улс төрийн дэглэмд нөлөөлдөг болсон. Иймд хэрхэн бодлого хэрэгжүүлж буй аргаар нь засаглалын шинж төрхийг тодорхойлох боломжтой гэж үзсэн байна. WSG судалгаандаа дараах хэд хэдэн асуултуудыг хөндсөн байна.

Үүнд:

1. Өндөр тушаалын төрийн албан хаагч улс төрийн бодлого боловсруулалтад хэр хэмжээгээр оролцож байна вэ? (нөлөөлөл, үзүүлэлт)
2. Төрийн албанд томилогдоход мерит зарчимд хэр хэмжээгээр суурилж байна вэ? (мерит зарчим, үзүүлэлт)
3. Төрийн албан хаагчид өөрсдийн үйл ажиллагааг тайлагнах чанар хэр хэмжээнд байна вэ? (ил тод байдал, үзүүлэлт)
4. Төрийн албанд шийдвэр гаргалт хэр тодорхой, ойлгомжтой байдаг вэ? (ил тод байдал, үзүүлэлт)
5. Төрийн халамж, үйлчилгээнээс хүртэх ижил боломж хэр их байна вэ? (хүртэх боломж, үзүүлэлт)

Тэдний албан ёсны баримтуудын 3-рт үзүүлсэнчлэн, бюрократ түүний хүнд сурталд дургүйцах байдал олон оронд байна. Нийт онооны төвшингээр доогуур жагссан орнууд дэлхийн өнцөг булан бүрт байдаг аж. Бюрократ дахь сөрөг үр дагаварын илрэл нь орчин үежиж байна. Тухайлбал, маш олон оронд танил талаа албан тушаалд дэвшүүлэх, болон бусад олон хахуулийн хэлбэрүүд төрийн албанд янз бүрээр нөлөөлсөөр байна. Энэхүү судалгаа нь: а. Улсуудын авсан нийт оноо б. Өөрчлөлт болон түүний цаадах шалтгаан дээр төвлөрнө.

⁷⁸ Каролина Ван Рижкегэм болон Битрис Ведер нар. Хээл хахуулийн урхи, түүний төвшин. Төрийн албаны бага цалин хээл хахуулийн шалтгаан уу? Олон улсын валютын сан. №97.73. Вашингтон ДС. Олон улсын валютын сан 1997 он.

⁷⁹ М.Вебер, 1947.

⁸⁰ Роберт Клитгард- Хээл хахуульд хяналт тавих нь. Беркли Лос Анжелосийн хэвлэл. 1988 он

⁸¹ Дэлхийн банк. 1993 он

⁸² Шауффер 1969-г үз.

⁸³ Силвиа Чан. Либерализм, Ардчилал ба Хөгжил. Кембрижийн Их Сургуулийн хэвлэл 2002 он. Мөн Эванс 1995.

⁸⁴ Ж.Корт, П.Кристэн, Б.Ведер нар. Хүнд суртлын бүтэц ба тоглолт. Шинэ нотолгоо Африк, НҮБ-н хэвлэл, Токио, НҮБ. 1999 он

Бюрократын нийт оноог орнуудаар ангилсан нь

Улс орнууд	Шинжээч д и й н зөвлөгөө	Мерит зарчим	Тайлагнах чанар	Ил тод байдал	Хүртэх боломж	Дундаж оноо
Өндөр оноотой орнууд						
Чили	3.00	2.47	2.83	2.93	3.37	2.92
Энэтхэг	4.00	4.06	2.92	2.94	2.83	3.35
Иордан	3.03	2.50	2.95	3.03	3.48	3.00
Монгол	3.38	2.67	2.41	2.82	2.67	2.79
Танзани	3.42	3.18	3.03	3.15	2.61	3.08
Тайланд	3.59	2.98	3.07	3.10	3.20	3.19
Дундаж оноотой орнууд						
Аргентин	2.94	1.70	2.11	1.86	2.77	2.28
Болгар	3.61	2.17	2.05	2.34	2.54	2.54
Хятад	2.58	2.73	2.39	2.09	2.45	2.45
Индонез	2.57	2.17	1.97	2.03	2.46	2.24
Перу	3.00	2.16	2.54	2.14	2.65	2.50
Доогуур оноотой орнууд						
Киргизтан	2.85	2.03	2.08	2.05	2.10	2.22
Пакистан	3.85	2.94	2.48	2.39	1.94	2.72
Филиппин	2.57	2.37	2.14	2.37	2.03	2.30
ОХУ	3.68	2.39	2.16	2.11	2.58	2.58
Того	2.79	1.98	1.95	2.02	2.29	2.20
Дундаж	3.18	2.53	2.44	2.46	2.62	2.65

Эх сурвалж: Goran Hyden, Julius Court and Ken Mease. *The Bureaucracy and Governance in 16 Developing Countries.*

Нийт дүгнэлт нь: Энэхүү ажиглалтаас харагдаж буй хамгийн чухал зүйл бол гүйцэтгэх засаглал болон төрийн алба нь бусдаасаа хамгийн бага онооны үзүүлэлтээр доогуур байсан явдал юм. Хүснэгт 8-д үзүүлсэнчлэн, өндөр оноотой орнууд дөнгөж 15 оноо (эсхүл 3% үзүүлэлттэй) цуглуулсан байна. Мөн эдгээр өндөр оноо бүхий орнууд бие биеэсээ их ялгаатай. 2000 онд эдгээр орнуудын тоонд удаан хугацаанд ардчилал оршин тогтносон улсууд болох Энэтхэг, Азийн бар орнууд, маш ядуу Танзани, Исламын Иордан улс, дундаж орлоготой Чили улсууд багтаж байна. Энэ нь бюрократын төвшин бол дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ), дэглэмийн төрөл эсхүл онцгой нэг соёлын хэлбэр дээр биш, харин эдийн засаг болон соёлын ялгаатай байдлаар тодорхойлогддог болохыг харуулж байна. Того, Киргизтан, Индонез, Филиппин. Аргентин улсуудад намууд сонгуулийн дараа албан тушаал амлах байдал, ил тод байдал болон тайлагнах чанар дутмагаас болж ихээхэн хүндрэлтэй тулгарч буй. Өндөр болон бага оноо авсан орнуудын оноог илүү дэлгэрэнгүй үзэх шаардлагатай.

Энэтхэг улсын засгийн газрын нэр хүндийг үүрэгч гол зүйл нь төрийн албаны нэр хүнд гэдэг нь нэгэнт батлагдсан. Асуулганд оролцогчид бодлогод оролцох болон албан тушаалд томилогдох нь меритийн зарчимд тулгуурласан (гэхдээ энэхүү үзүүлэлт нь 1996-2000 оны хооронд бага зэрэг буурсан) байна. Олон улстай болон бусадтай харьцуулахад Энэтхэг улс бюрократын төвшингээр харьцангуй өндөр оноо авсан байна.

Монгол улсын хувьд асуулгын дүн нь тусгай агентлагуудад олгогдсон эрх мэдэл бодлого боловсруулалтанд нөлөөлдөггүйг харуулсан. Монголын хариуцлага хүлээх чадварыг илэрхийлэх зүйл бол мэргэжилтэний агентлагууд бөгөөд тэд бодлогыг боловсруулдаг ч хүч нь маш хязгаарлагдмал байдаг. Улс төрийн намууд бүхий л төвшинд төрийн захиргааны албан тушаалыг эзэмшиж, төрийн албанд хүрэх тэгш боломж, төрийн үйлчилгээнээс хүртэх ижил боломж болон томилогдох мерит зарчмыг няцааж байдаг байна. Бюрократын төв дахь улс төрийн намуудын хэтэрсэн үүрэг, бүх төвшний олон нийтийн удирдлагууд нь бюрократуудын олон нийтийн үйлчилгээний тэгш үйл ажиллагаа болон нэмэлт давуу талын үндсэн системийг эсэргүүцдэг байна. Бүхий л төвшинд тайлагнах чанар дутмаг, хариуцлагийн бүтцээс эхлээд төрийн удирдлагын хариуцлагын тогтолцоо сулчраас төрийн захиргааны хариу мэдрэмж болон ил тод байдал доогуур төвшинтэй байна.

Болгар улс зах зээлийн эдийн засагт шилжин бюрократ талбарыг шинэчлэх алхам хийсэн нь сонирхолтой хэрэг болсон байна. Тайлбарлагчийн үзсэнчлэн дундаж оноо багатай энэ талбар бол шинэчлэхэд хамгийн ярвигтай. 2000 онд засгийн газар “Төрийн албан хаагчийн тухай хууль”-ийг боловсронгуй болгосноор бага зэргийн дэвшилт гарсан гэж болно. Энэ хуулиар улс төрийн томилогооны тоог багасгаж мөн тодорхой хугацаанд төрийн албаныханы ямар үүрэгтэй болон эрхтэйг тодорхойлсон. Хэдий тийм боловч хуучин коммунист дэг журам нь зарим хэсэгтээ одоо хүртэл хэвээрээ байгаа. Авлигал өргөн дэлгэрсэн бөгөөд тайлагнах чанар үгүйлэгдэж, хариуцлага нь бүр алга болсон байна.


Энэхүү судалгааг Аргентиний санхүүгийн хямралаас өмнө авсан учраас дундаж оноо бага байгаа нь их гэнэтийн хэрэг болж байна. Аргентин улс нь гадны санхүүгийн байгууллагуудын тусламжтайгаар төрийн албыг шинэчлэх туршилт явуулсан. Ингэж тусламж авсан хэдий ч маш бага дэвшилт гарч байгааг судалгааны дүн харуулсан байна. Тус орны хууль нь төрийн албанд дутагддаг гол зүйлс болох томилох, ил тод байдал, тайлагнах чанар зэргээр дутмаг байсан аж. Аргентинд олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламжаар олон нийтийн гүйцэтгэл нь аажмаар явагддаг байсан. Хариуцлага хүлээх чадварыг илэрхийлэх зүйл нь их хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн явц бөгөөд түүний сайжрал нь жаахан ч гэсэн хариуцлагын дээшлэлтийг гэрчилнэ. Бюрократын сайн засаглалд хамаарах үүргүүд маш их шүүмжлэгдэж байгаа бөгөөд энэ тал дээр хөлслөх хандлага, ил тод байдал болон хариуцлагатай байдал зэрэг нь илүү өртөж байгаа юм.

Судлаачдыг эерэг талаараа гайхшируулсан улс бол Пакистан байв. Гэвч Пакистан нь бослогын шалтгаантай. Пакистаны засгийн газар нь ерөнхий төвшинг доогуур барьж, бюрократ дахь хүнд суртлын бүсийг хөндсөн үүргийг илүү их сайшаан үзэж хариуцлага тооцож байна. Үүнээс үзэхэд бусад бүсүүдээс тусгал нь доогуур байгаа юм. Пакистаны засгийн газар доогуур оноо авсан ч, санал асуулганд оролцогчид бюрократад үйлчилж буй хуульд сэтгэл хангалуун байсан. 1990-ээд онд улс төрийн намууд маш эмх замбараагүй, мөн хахуульд идэгдсэн байсан бөгөөд улмаар цэргийн хүчээр засгийн эрх мэдлийг авахад хүргэсэн. Энэ нөхцөлд төрийн алба нь бусад байгууллагуудын хийж чадахгүйг хийх чадвартай бат бөх суурь болох нь харагдсан. Пакистаны хувьд төрийн алба ихээхэн тааламжтай болж байгаа бол Того улсын хувьд байдал эсрэгээрээ байна.

Того улсын ерөнхийлөгч төрийн эрхийг удаан барьж байгаа бөгөөд нэг дор цэргийн командлагч, төрийн бодлого боловсруулагч байв. Бодлого боловсруулалтанд мэргэжилтгүүд өмнөх шигээ үнэлэгдэхээ больсон. Нэгэн тайлбарлагчийн өгүүлсэнчлэн, эдгээр бодлогуудад эрх баригч хүчний сонирхол тусдаг. Төрийн албаны чадавхи сул, хахуульд идэгдсэн нөхцөлд доогуур оноо авахад нь гайхах зүйлгүй юм.

Индонезийн бага оноо авсан шалтгаан бол 1996 болон 2000 оны өөрчлөлтүүд юм. 1996 ерөнхийлөгч Сухарто төрийн гол цөм байсан бөгөөд түүний шуурхай хамтран зүтгэгчид төрийн албанаас дээгүүр төвшинд байсан. Хахууль их газар авсан, үүнийг зохицуулах гэж оролдлоо гэхэд арбитрын шүүхээр орж ард нийтийг маш олон зүйлсэд сэтгэл хангалуун бус үлдээдэг байв. 2000 онд тодорхойгүй байдлаар Сухартогийн эрин үеэс шилжсэн нь доогуур онооны шалтгаан бөгөөд тогтворгүй байдалтай холбоотой юм. Түүнийг огцорсоны дараа эмх замбараагүй байдал бий болсоныг манай асуулга харуулж байна. Хуучны хууль, дүрмүүд хэрэглэгдэж байгаа ч ихэнхи нь итгэл даах чанараа нэгэнт алдсан. Шинэ хууль, дүрмүүд арай л хүлээн зөвшөөрөгдөж амжаагүй байна.

Хүснэгт 9. Бюрократын нийт оноонд 1996-2000 онуудад гарсан өөрчлөлтүүд



Эх сурвалж: Goran Hyden, Julius Court and Ken Mease. *The Bureaucracy and Governance in 16 Developing Countries.*

Дээрх хүснэгтэд цаг хугацааны явц дахь өөрчлөлттэй холбоотой мэдээллүүд цуглуулан дүгнэлт гаргасан байна. Перу, Хятад, Тайланд, Танзани, Индонез зэрэг таван улсын төрийн алба 2000 онд 1996 онд байснаас илүү өндөр үзүүлэлттэй гарсан ажээ. Эдгээрийн өсөлтийн шалтгаанууд өөр өөр байсан юм.

Индонез болон Перуд ерөнхийлөгч Сухарто, Фүжимару нар унан, дэглэмийн том өөрчлөлт гарсан байна. Нөгөө гурван улсын хувьд улсын үйлдвэрийн үйл ажиллагаа улам өссөн бөгөөд үүргийн биелэлт бодитой байсан бөгөөд Тайланд өндөр оноотой болсон байна. Тайланд улсын бюрократ аппаратууд “бар” орны статусыг аль хэдийн сахих болсон бөгөөд эдийн засгийн өсөлтийн гол өдөөгч нь засгийн газар юм гэсэн ойлголт бий болжээ. Тайланд орны хувьд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалыг тэнцвэржүүлэх зорилго бүхий 5 жилийн төлөвлөгөөний үрээр бүтцийн томоохон өөрчлөлтөд орж байсан туршлагатай. Гэхдээ энэ нь өндөр оноо авсан ганц шалтгаан биш ч асуулгаар энэ асуудлаар засгийн газарт их ахиц гарсныг харуулсан байна.

Танзанид 1995 онд ерөнхийлөгч Мкапа засгийн эрхийг авсны дараа шинэчлэл явуулсан нь их ач холбогдолтой үйл явдал болж мэдэгдэхүйц өсөлт гарсан байна. Энэхүү үйл ажиллагаа нь дэлхий дахинд танигдаж, нөлөөтэй, бүтээлч төрийн байгууллагатай болж эхэлсэн. Сүүлийн жилүүдэд Танзанид олон нийтийн санхүү болон үйл ажиллагааны дэг журам сайжирч байгаа нь түүхэн дэх хамгийн амжилттай үзүүлэлт юм. Танзани улс дараах хүрээнд шинэчлэл явуулжээ. Үүнд: албан байгууллага ба үр бүтээмжийн шинэчлэл, боловсон хүчин ба менежментийн шинэчлэл, чадавхи бүрдүүлэлт, орон нутгийн удирдлага, бүсийн засаг захиргааны шинэчлэлт, засгийн газар дахь хөдөлмөр эрхлэлтийг оновчтой болгох талаарх шинэчлэлт зэрэг юм. Эдгээрийг амжилттай хэрэгжүүлсэн нь Танзани улсад ил тод байдал, тайлагнах чанар улам өсч, ижил боломжоор хангагдан, меритийн зарчмаар томилогдох, мэргэжилтнүүдийг улам идэвхтэй оролцуулж байгаа тухай өгүүлсэн мэдээллүүд гарах болсон байна.

Хятад улсын төрийн албад багахан хэмжээний автономи эрхтэй байсан бөгөөд бюрократ нь тэдний толгойн өвчин байв. 1970-1980 онд Мао болон түүнийг залгамжлагч Хуа Го Пиний эрх барьж байсан үед намын удирдагч нар мэргэжилтнүүдийг үл тоомсорлон, удирдлагын үр ашиг болон үр дүнг үл хайхран шийдвэр гаргадаг байсан. Энэ нь аажмаар өөрчлөгдсөн хэдий ч одоог хүртэл Хятадын коммунист нам улс төрийн шийдвэр гаргагч гол хүчин хэвээр байна. Гэсэн хэдий ч 1979 оны эдийн засгийн шинэчлэлээс хойшхи урт хугацааны өөрчлөлтөөр төрийн албан хаагчид улсынхаа хөгжлийг бүтээн байгуулагч нь болсон байна. Дан ганц пүүс, компаниуд бус мөн төрийн байгууллагууд илүү бие даасан байдалтай болж байна. Төрийн байгууллагын хяналтыг бууруулахыг их удаан хичээж байгаа бөгөөд бага зэргийн ахиц дэвшил ажиглагдах болжээ. Тэдний үзсэнээр засгийн газарт нь гарч буй өөрчлөлтүүд зөв зүгтээ явж байгаа аж.

Перу улсын ерөнхийлөгч Фүжиморигийн дэглэмийн сүүл үетэй холбоотойгоор үед ард түмний ихэнх хэсэг сэтгэл хангалуун байсан бөгөөд үүний дараа гарч болох хэтийн төлөвийг дурдахгүй өнгөрч болохгүй. Фүжиморигийн үед төрийн албаныхан бодлого боловсруулалтанд тэр бүр оролцдоггүй байсныг асуулга харуулсан аж. Төрийн албаныханыг хуулийн үндэслэлгүйгээр томилох, халах болон тушаал дэвшүүлдэг байсан. Үүнд өөрчлөлт гарсан хэдий ч 2000 онд зарим зүйл мөн адил тодорхой бус хэвээр үлдсэн байна. Гэхдээ асуулганд оролцогчид захиргааны байгууллага, төрийн албанд ахиц гарсан хэмээн мэдээлсэн. Ялангуяа мэргэжилтнүүдийн төвшин нэмэгдсэн. Өөр нэг чухал ахиц бол төрийн албаныхны хариуцлагын чанарын өсөлт юм. Фүжиморигийн үед төрийн алба ажлаа тайлагнах асуудал нь засгийн газрын гарт байсан. Одоо энэ нь бие даасан шүүх засаглалын хэрэг болсон байна.

Улсуудын 1996 болон 2000 онд буурсан орнуудыг бүртгэхэд хамгийн их буурсан орон нь Филиппин байсан. Асуулгад оролцогчид үүнийг өмнөх ерөнхийлөгч Эстрадагийн авилгалч байдалтай холбон үздэг. Нэгэн асуулганд оролцогчийн хэлсэнчлэн, тайлагнах чанар бүхий механизмын хүч нь шоронд илгээгдсэн төрийн дээд албан тушаалтнуудын тоогоор илэрхийлэгдэнэ. Гэтэл Филиппинд огт ийм зүйл болдоггүй байв. Эдгээр нь эргээд системийн үр дүнтэй байдалд эсрэгээр нөлөөлж байдаг ажээ.

Киргизтан улсын хувьд бюрократын талаар авсан дундаж оноо мөн хамгийн доогуур байсан бөгөөд энэ оноо нь 1996 оноос хойш буурсаар байв. Энэхүү уналтыг бүх үзүүлэлтээс харж болох бөгөөд ялангуяа үүнийг мерит зарчим ба төрийн үйлчилгээнээс тэгш хүртэх асуудалд илүү тод харагдана. Ийм байдалд орсон гол шалтгаан нь удирдах байгууллага төвлөрөөгүйтэй холбоотой байж магад гэж судлаачид үзсэн байна. Төрийн алба нь орон нутгийн улс төрийн эрхтэнүүдийн гарт амархан ордог. Төвийн хяналтыг нэмэгдүүлэх, ил тод байдлыг дээшлүүлэх, засгийн газар дахь мэргэжилтнүүдийн хоорондын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилго бүхий төрийн албаны шинэчлэлийг явуулсан ч үүнийг засгийн газрын дотоодод үүссэн маргаан саатуулах болжээ.

Хувийн үзүүлэлтүүдийн дүгнэлт

Бюрократын үйл ажиллагаанд албан хаагчдын хувийн үзүүлэлтийг авч үзэх нь түүний гүйцэтгэлд ихээхэн хамааралтай байдаг. Үүнийг нөлөөлөл, мерит зарчим, хариуцлага хүлээх чадвар, ил тод байдал, хүртэх боломжоор нь тус бүрд нь жишээгээр авч танилцах хэрэгтэй.

Нөлөөлөл

Судлаачид бодлого боловсруулах ажиллагаанд төрийн өндөр тушаалтнуудын нөлөөлөл нөлөө хэр байдгийг тодруулах асуултыг судалгаанд оруулсан байна. Тэд гурван гол зүйлд анхаарал тавьсан байна. Нэгд, бараг бүх орны асуулгад оролцогчид өндөр албан тушаалтнууд улс төрд нөлөөлдөг, гэхдээ энэ нь зөвхөн мэргэжилтнүүд биш юм. Пакистан болон Энэтхэг нь энэ хандлагаараа ялгардаг байна. Энэ хоёр оронд төрийн алба нь хүч хэрэглэх талдаа нийлээд чиглэсэн байдаг бөгөөд төрийн өндөр албан тушаалтнууд бодлого боловсруулалтын чухал хэсэг болдог. Үүний нэгэн адил бусад орнуудад, ялангуяа ОХУ-д цөөн тооны өндөр тушаалтнуудын нөлөө их байдаг тухай асуулгад оролцогчид хэлсэн байна. Ялангуяа Ерөнхийлөгчийн

тамгын газар үнэхээр их нөлөөтэй. Бусад салбарын яамдын өндөр тушаалтнууд арай бага нөлөөтэй байсан.

Хоёрт, олон асуулгад оролцогчидын үзсэнчилэн бюрократ дахь өндөр албан тушаалтнууд өөрчлөгдөшгүй, аюулгүй байдаг ажээ. Тайланд, Чили улсын асуулгад оролцогчидын хэлсэн санаагаар бол нэн тэргүүнд технократ нь бюрократад бага мэдрэгдэх бөгөөд ард түмний сонирхлыг бага хүлээн авдаг, үйл ажиллагааны ил тод байдал, тайлагнах чанар зэргийг бараг хайхардаггүй. Энд томилогдсон болон сонгогдсон түшмэдийн хариуцлагын заагийг хаана тавих асуудал гарч иржээ. Индонез улсад өөрчлөлтийн эгзэгтэй мөн түвэгтэй байдал үүссэн байна. Сухартогийн дэглэмийн төгсгөл үед улс төрийн бодлого боловсруулалт төвлөрсөн маягтай байсан аж. Түүний засгийн газрын дотоод тойргийг бүрдүүлж байсан өндөр тушаалтнуудын бодлого дахь нөлөө их байсан байна. Сангийн яам, Эрүүл мэндийн яам зэрэг бусад асуудлууд дээр Сухарто сайд нартаа эрх мэдлээ өгсөн байв. Гэсэн хэдий ч улс төрийн зарим салбар дахь өндөр тушаалтнуудын бодлогод нөлөөлөх нөлөөлөл баталгаатай, түгээмэл биш байдаг. Энэ нь ерөнхийлөгчид хэр үнэнчээс хамаардаг байжээ. Нэг сонирхолтой зүйл гэвэл Сухартогийн уналт төрийн албаныхны нөлөөг өсгөсөнгүй. Харин эсрэгээр өмнөхөөсөө олон намтай болж, сонгогдсон улс төрчид төрийн албанд шинжээчдээс илүү мэдэлтэй болохыг шаардах болсон байна.

Гурав дахь асуудал бол улсууд дахь асуулгад оролцогчид бодлого томъёолохоос илүүтэй бюрократуудын хэрэгжүүлэлтэд итгэх нь илүү шууд нөлөөлөх хариуцлагыг тодруулсан. Орон нутгийн бюрократууд төр засгийн шийдвэрийг өөр зүг хөтлөх хангалттай боломжтой байдаг. Липскигийн хэлсэнээр улс төрийн бодлогын хэрэгжилт нь эцэстээ “гудамжны төвшин”-д бюрократуудын юуг хэрхэн шийдэх хүртэл доошилдог.⁸⁵ Дүгнэж хэлэхэд дээд төвшний бюрократууд нь үйл ажиллагааны эцэст нь тэгж их нөлөөлдөггүй ажээ.

Мерит зарчим

Бодлого хэрэгжүүлэх, төрийн хэв журам сахиулах ажлыг амжилттай хэрэгжүүлэхэд албан хаагчийг ажилд авах журам чухал байдаг. Зөвхөн төрийн албаны шалгалтаар асуудал шийдэгдэх бус, харин тэдний практикт өргөн хэрэглэгдэж буй аргууд авч үзэх нь чухал юм. Судалгааны асуулгад оролцогчидын өгүүлсэнээр цөөхөн улс мерит тогтолцооны зарчмыг баримталдаг болох нь харагдсан. Энэтхэгийн хувьд меритийн зарчим голчилдог ч энэ нь төлөвлөсөн каст болон овгийнхон, нийгмийн бусад бүлгүүдтэй өрсөлдөх боломжгүй. Саяханаас дэвшилтэт болж буй Танзани улсаас өөр ямар ч улс энэ үзүүлэлтэд 3-аас дээш оноо аваагүй байна. Ихэнх орнуудын хувьд бага зэрэг эсхүл бүр мерит зарчим харгалзалгүй хүмүүсийг төрийн албанд дураар элсүүлдэг гэдэгтэй тайлбарлагчид санал нийлдэг. Бюрократуудыг сонгоход чадварыг нь бараг харгалздаггүй. Олон тайлбарлагчид ажилд авах шалгалтаар дутмаг, авсан ч дүр төдий байдаг гэжээ. Того улсад шалгалт авдаг байсан хэдий ч одоо бүр авахаа больсон байна.

Нэгэн тайлбарлагч, Иордан улсын гол асуудал бол албан хаагчдын тоо хэтэрсэн бөгөөд ажилтануудын чадварыг тэргүүнд тавьдаг болгохын тулд шинэчлэл хийх хэрэгтэй гэж үзсэн. Хамгийн өргөн хэрэглэгддэг харилцан хамаарал бол төрийн албаны ажилтнуудын хөндлөнгөөс улс төр хутгалдах явдал юм. Филиппины асуулгад оролцогчид төрийн албанд ороход хувийн харилцаа чухал байдаг гэсэн байна. Индонез, Того зэрэг улсуудад энэ нь бүр ч чухал ажээ. Ихэнх судлаачид Аргентин улсад төрийн албанд ажилтан авахдаа мерит зарчим огт хэрэглэдэггүй гэж дүгнэсэн. Тэгэхээр гэр бүлийн гишүүд болон найзууд нь ажилд ордог аж. Бюрократыг шинэчлэхийн тулд илүү өрсөлдөөнт байдлыг бий болгон чадвар бүхий мэргэжлийн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх хэрэгтэй. Дундаж оноогоор дээгүүр жагссан Чили улс бюрократын оноогоороо дундажаас доогуур байсан. Асуулгад оролцогчид мэргэжлийн боловсон хүчин бүрдүүлэхийн тулд төрийн албаны хөдөлгөөнгүй байдлыг болиулж, ажлын байрны улс төржилтийг багасгах хууль тогтоомж гаргах хэрэгтэй байна гэж гомдоллосон байна.

ОХУ-ын хувьд мөн адил ажилд авах нь гол асуудал болдог. Асуулгад хариулагчид бага зэрэг мерит зарчим үйлчилдэг, гэхдээ хувийн холбоог илүү их хардаг. Үр дүнд нь туршлага, дадлагагүй хүмүүс өндөр албан тушаалын орон тоог бөглөдөг. Таван бюрократын нэг нь л мерит зарчмын дагуу томилогдсон байдаг. Бүх судалгаагаар энэ нь улс орны хувьд хамгийн том дутагдал нь гэдгийг харуулдаг. Энэ нь дан ганц гүйцэтгэлд нь нөлөөлөөд зогсохгүй бүр цаашлаад засгийн газрын үйл ажиллагааны үр дүнг бууруулдаг. Ийм шударга бус байдал өргөн тархсанаар төрийн үйл ажиллагаа, нийгмийн хөгжилд эсрэгээр нөлөөлдөг байна.

Тайлагнах чанар

Төрийн албатууд төрийн үйлчилгээг үзүүлэх, хуулийн үйлчлэлийг хангах зэрэг ажлууд нь иргэдэд даацтай нөлөөлдөг учраас хянуур байх хэрэгтэй байдаг. Ийм учраас тайлагнах систем нь хээл хахууль болон төрийн албыг буруугаар ашиглах бүх хэлбэрүүдийг бууруулахад тусалдаг. Судлаачид судалгаанд оролцогчидоос төрийн албад үйл ажиллагаагаа ямархуу төвшинд тайлагнадаг болохыг бодож үзэхийг хүссэн. Тэгтэл тайлагнах чанарын оноо маш доогуур гарч дахин нэг асуудал бүхий тавцанг бий болгов. Асуудлын гол нь байдаг мөртлөө үйлчилдэггүй зохион байгуулалтын систем оршиж байв. Тайланд болон цэргийн дарангуйлал бүхий Пакистан улсуудын хувьд байдал арай өөр байсан.

Тайландын засгийн газар захиргааны холыг харсан, бюрократуудыг нийтийн өмнө тайлагнадаг болгоход чиглэсэн шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Ингээд захиргааны гомдлыг шийдвэрлэхэд чиглэсэн “Хажуулийн эсрэг хороо”, “Тусгай захиргааны шүүх, “Гомдлыг шийдвэрлэх байгууллага” (омбудсман) байгуулсан ажээ. Засгийн газрын бүх албан хаагчид, ялангуяа сонгогдсон албан тушаалтнууд өөрсдийн ашиг, хувийн хөрөнгө, өр зээлийг нийтэд зарлах ёстой гэснээр дээрх шинэчлэлийг явуулахад хөнгөвчилж өгсөн ажээ. Эдгээр алхамууд нь төрийн албыг зөв чигт явж байна гэсэн ойлголтыг нийтэд төрүүлдэг.

⁸⁵ M. Lipsky, *Street-Level Bureaucracy: Dilemmas of the Individual in Public Services*. New York: RussellSage Foundation 1980.

Пакистан улсын төрийн эрхийг цэргийн эрхтнүүд авсанаас хойш тайлагнах чанар илүү нэмэгдсэн байв. Энэ нь судалгааны асуулгад оролцогчидоос ирсэн мэдээлэл юм. Гэвч тэд энэ байдал хэр удаан үргэлжилэх талаар сайн мэдэхгүй байгаа аж. Цэргийн удирдлагаас захиргааг нийтэд тайлагнах асуудлыг эн түүрүүнд тавьж байгаа юм байна. Энэ ажиллагааны үр дүнд цөөн хэдэн албан тушаалтнууд албанаас чөлөөлөгдсөн бөгөөд зарим нь төрийн албыг буруугаар ашигласны төлөө шалгагдаж байна. Энэ нь өмнөх ардчилсан байдлаар сонгогдсон “зөөлөн” төрийн аппарат хариу болгон хийсэн алхам болжээ. Төрийн ажилтнуудыг тайлагнуулах хууль, зохион байгуулалтын механизм байдаг байсан ч тэр нь огт хүчилдэггүй байснаар нийтэд энэ алба хахуульд идэгдсэн гэх ойлголтыг төрүүлдэг байв. Төрийн албан хаагчдын энэ байдлыг далимдуулан сайд нарын төвшинд хахуулийн тогтолцоо бий болсон байв. Ингэснээр авлига улам зохион байгуулалттай болж, дээрээс доош чиглэх болсон байна. Төр засгийн удирдагчид нь ямархуу төлөвтэй байхаас төрийн албан хаагчдын байр байдал ямар байх нь хамаардаг гэдэг нь тодорхой байна. Хэрвээ сонгогдсон улс төрчид хахуульд идэгдээгүй бол бюрократуудад адилхан байх хэрэгтэй гэсэн жишээ болдог. Эсрэгээрээ тэд хахуульд идэгдсэн бол энэ нь төрийн алба даяар тийм хандлагыг тараадаг. Филиппин, Орос хоёр нь үүний тод жишээ юм. Танил талаа дэвшүүлэх, сонгуулийн дараа албан тушаал амлах нь мерит зарчимд түшиглэх, төрийн албан хаагчдын тайлагнадаг байх оролдлогыг улам дордуулдаг. Эцэст нь албан тушаалаа баян болох, өөрсдийн сонирхолоо хамгаалахын тулд ашигладаг болгодог байна.

Энэхүү судалгааны ажлаас судлаачид төрийн албаныхныг тайлагнадаг болгоно гэдэг их ярвигтай асуудал гэдэг дүгнэлтэнд хүрсэн. Гомдлыг шийдвэрлэх байгууллага (омбудсман), Ерөнхий аудитын хороо, эсхүл түр зуурын хороо зэрэг хээл хахуулийг багасгах зорилт бүхий механизмуудыг бий болгох нь хамгийн чухал тэргүүний алхам болно. Жинхэнэ асуудал бол дээрх механизмуудыг бүх талаар нь ажилладаг болгох явдал юм. Олон оронд ихэнх асуулгад оролцогчид эдгээр тусгай зориулалтын байгууллагууд нь үр дүнгүй ажиллаж байгаа гэдгийг цохон тэмдэглэсэн. Харин үүний оронд хэвлэл мэдээллээр дамжуулан шаардах, Индонез улс шиг ард түмэнд тайлагнадаг байхыг шаардах хэрэгтэй байж болох юм. Судалгаанд оруулсан орнуудын хувьд хэвлэл мэдээлэл нь дөрөв дэх засаглал болж чадахгүй байсан. Харин төр, захиргааны албан хаагчид тайлагнадаг болсон үед л олон оронд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бусад механизмуудтай ижил үр дүнд хүрэх боломжтой.

Ил тод байдал

Хэдийгээр ил тод байдал нь дэлхий дээрх улс орнуудын хувьд маргаантай асуудал болдог боловч нээлттэй байдал нь төрийн албыг урвуугаар ашиглах магадлалыг бууруулдаг гэх ойлголт өргөн тархсан. Үүний нэгэн адил ард түмэнд шийдвэр хэрхэн гарч буй талаар хангалттай мэдээлэл өгөхгүй бол бюрократуудын талаарх сөрөг бодолтой болдог байна. Судлаачид 16 оронд шийдвэр гаргах үйл явц хэр тод байгаа талаар судалгаа явуулжээ. Эцсийн дүн нь их санаа зовмоор гарсан байна. Бүх орны хувьд их бага оноотой байсан төдийгүй, бусад бүх судалгаанаас хамгийн доогуур оноотой нь ч байсан. Үнэхээр ч судалгаанд оролцогчид төрийн алба ил тод байдлаар дутмаг гэдэгт итгэдэг байна. Танзани, Тайланд, Иордан улсууд арай өндөр (3 орчим), Аргентин, Киргизтан, Индонез, Того улсууд маш бага оноо (2 орчим) авсан байна. Аргентин улс хамгийн доор жагсан нь судлаачдыг гайхшируулжээ. Гэхдээ асуулгад оролцогчид энэ асуудалд маш их шүүмжлэлтэй хандсан байв.⁸⁶ Ерөнхийдөө олон асуулгад оролцогчид илүү ил тод байдлыг бий болгох гэсэн нийтийн шаардлагыг ойлгож байна хэмээсэн аж. Гэхдээ гайхах зүйлгүй нь ил тод байдлын оноо тайлагнах чанарын оноотой ойролцоо байв.

Пакистан улсаас бусдын хувьд байдал нягт хэлхээ холбоотой байна. Цэргийн дарангуйллын дор тайлагнах чанар мэдэгдэхүйц нэмэгдэхэд, ил тод байдал нь буурсан байна. Тайлбарлагч нар үзэхдээ шийдвэр гаргалт улам бүр бүдгэрч, олон нийттэй хийх хэлэлцүүлэг улам багассан гэж үзжээ. Ил тод байдал нь улс төрийн дэглэмийн хэлбэртэй зөрчилддөг гэдгийг дурдах хэрэгтэй байх. Ардчилсан дэглэмтэй Аргентин, Перу улсууд, коммунист дэглэм бүхий Хятад улсууд үүний тод жишээ. Энэ нь ил тод байдал газар бүрт адил байдаг гэсэн үг биш. Харин зарим улсууд үүнийг нэвтрүүлэхийг оролдож байхад зарим огт оролдох ч үгүй байна. Болгар улсын зохицуулагч энэ асуудлыг хэн хүнээс илүү тодорхойлсон бөгөөд уг асуудал нь шийдвэрлэхэд маш их цаг авдаг гэсэн. Энэ нь дан ганц бюрократуудын төрх байдлын өөрчлөлттэй холбоогүй, харин нийт улс төрчид болон ард түмэнтэй холбогддог байна. Урт хугацааны ямар ч судалгаа авах нь тухайн дэглэмийн хууль, эрх зүйн байдлыг сайжруулахад нөлөөлдөг. Судалгаанаас дүгнэн үзэхэд бюрократын хууль, эрх зүйн байдал, мөн түүний дэг журмыг чангалахын тулд илүү ихийг хийх хэрэгтэй байна.

Хүртэх боломж

Энэ хэсэг бол төрийн халамж, үйлчилгээг хүртэх ижил боломж байхтай холбоотой. Энэ нь төрийн албаны хууль зүйн байдал, хөгжлийн үр дүнд чухал нөлөөтэй. WSG-ийн судалгаанд хамрагдсан орнуудын төрийн халамж, үйлчилгээг хүртэх боломж тэгш бус байх нь гайхах зүйл биш. Тайланд, Иордан, Чили улсаас бусад нь бага оноо авсан. Ялангуяа Пакистан, Киргизстан улсуудын хувьд. Өөр байгаагын шалтгаан нь дөрвөн өөр учиртай.

Эхнийх шалтгаан бол улсын хэмжээ юм. Үүнийг Хятад, Индонези дахь асуулгад оролцогчид гаргаж ирсэн. Хятадын баруун зүгийн өргөн уудам газар нутаг зүүн зүгийн далайн эргийнхэнтэй харьцуулахад дутагдалтай тал олонтой. Индонези улсад гол арал Жавагаас тусдаа орших арлын иргэд төрийн халамж, үйлчилгээ хүртэхэд давуутай болоход хэцүү байдаг гэж асуулгад оролцогчид хэлсэн. Того, Иордан зэрэг

⁸⁶ Үнэлгээний газар, олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд газар дээрх байдлыг яг таг хүргэдэггүй бөгөөд засгийн газрын санаа бодлыг тодруулан орон нутгийнханд хүргэдэг гэдгийг бидэнд батласан.

жижиг улсуудын үзүүлэлт дээрх орнуудаас харьцангуй дээгүүр байсан нь энэхүү газар зүйн таамаг баталж байна. Тухайлбал, Йорданы нийтийн захиргааны 1998 оны шинэ “Төрийн албаны тогтоол” нь төрийн үйлчилгээ болон хүний нөөцийн хөгжлийн орон нутгийн хяналтад чиглэсэн байв.

Хоёр дахь шалтгаан нь уг судалгаанаас урган гарсан бөгөөд хотын оршин суугчид хөдөөний оршин суугчдаас илүү тусламж, дэмжлэг авдаг ажээ. Хөдөө орон нутагт зарцуулж буй дэд бүтцийн төсвийг харахад ойлгомжтой юм. Филиппин улсаас асуулгад оролцогчид хот орчмын ялангуяа Манила дахь оршин суугчид хөдөөнийхнөөс илүү их үйлчилгээгээр хангагддаг гэсэн дүн гарсан. Ерөнхийдөө эдгээр хүмүүс нь тосгон, суурин дахь, ялангуяа алслагдсан арал дээрх хүмүүсээс хүрэх боломжийн хувьд хамаагүй хялбар. Чили, Энэтхэг, Орос дахь асуулгад оролцогчид мөн адил ийм дүнтэй байсан. Хөдөөгийн оршин суугчид нэмэлт зөвлөгөө, халамжийн нөхцөлтэй ч төрийн үйлчилгээнд хүрэхэд сул талтай байдаг.

Гурав дахь шалтгаан нь ялгавартай ашиглах боломж, нийгмийн давхраажилт юм. Зарим талаараа үүнд нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал хамаатай байдаг. Энэ нь Энэтхэг, Пакистаны асуулгад оролцогсдын дүн юм. Төрийн үйлчилгээг хүртэх нь эдгээр орнуудад доогуур байдаг. Хэрэв бюрократуудыг мерит зарчмаар сонгодог, төрийн албад дахь улс төрийн нөлөө бага байсан бол хүн амын ядуу хэсэгт бага зэргийн өөрчлөлттэй байх байсан байх. Мөн асуулгад оролцогчдын өгүүлснээр хахууль төлөх чадвартай бол төрийн үйлчилгээ хүртэх давуу талыг бий болгож чадна. Дүгнэн хэлэхэд, засгийн газар дахь бюрократын талбарыг дотроос нь өөрчилөхөд маш хэцүү. Харин засгийн газар ба төрийн бус байгууллагууд зэрэг иргэний нийгмийн байгууллагуудын хоорондын холбоо харилцаа болон мөн өөр бусад салбаруудаас нөлөөлөхөд арай илүү хялбар болох юм.

Дөрөвт, хэрэв бүгдэд нь тэгш үйлчилгээг үзүүлбэ гэж бодоход нэг газрын үйлчилгээний чанар нөгөөгөөс өөр. Мөн хүртэх чанар сайн байх боломжтой хотод уг үйлчилгээний хэрэгцээ арай багатай байдаг бол, хөдөө газраас илүү их зүйлс шаардагдана. Энэ төрлийн ялгаа нь улс төрийн талцах байдлаас салаалан гарч ирнэ. Эрх барьж буй намын сайдууд, гишүүдийн тойрогийн нутгуудад төрийн үйлчилгээ, хүртээмж ихэнхдээ сайн байдаг.

Төрийн үйлчилгээнд хамрагдах нь чухал зүйл. Гэхдээ тэгш бус байдал нь нэг бус нэлээд олон шалтгаанаас үүдэлтэй. Ихэвчлэн газар зүй, хүн ам зүй, нийгмийн давхрааны улмаас төрийн тэгш халамж маш түвэгтэй, үнэтэй болдог. Улс төрийн сонирхолуудыг нэгтгэн өөрчлөлт хийх нь амархан зүйл биш. Үүнтэй холбоотой бусад шалтгаанууд ч энэ дөрвөн танигдаж буй шалтгаануудаас илүү хүндрэл учруулдаг.

Практик болон судалгааны дүгнэлт

Бюрократ засаглал нь нийтийн эзэмшил, хүрээнд нөлөөлдөг бөгөөд үүнд судалгааны агуулга төвлөрч байдаг. Хөгжиж буй орнуудын төрийн алба, түүний бюрократ тогтолцооны талаарх дээрх судалгаа нь дөрвөн гол асуудлыг дэвшүүлсэн байна.

Үүнд:

Нэгд, бюрократ бол засаглал дахь асуудал бүхий талбарын нэг мөн. Бараг л мерит зарчимаар сонгодоггүй, бюрократууд ховорхон тайлагнадаг, төрийн алба нь бодит ил тод байдлаар дутмаг зэрэг олон дутагдалтай талууд нь тухайн улс орны хөгжлийн “чөдөр” болж, хүнд суртал, авлига, хээл хахуулийн эх сурвалж болдог байна.

Хоёрт, нэг талаар хууль дүрэм ба зохион байгуулалт, нөхөн төлбөр гүйцэтгэлийн холбоог бий болгоход хэцүү байдаг. Гэхдээ энэ холбоо нь тийм ч чухал биш. Ямар хууль ямар нөлөөтэй байгааг мэдэхэд хэцүү.

Гуравт, бюрократ талбарыг шинэчлэх асуудал бол их хүнд. Хэдэн жилийн шинэчлэлийн дүнд болон дундаж онооны байдлаас нь харахад шинэчлэхэд хамгийн хэцүү гэдгээ баталсан. Мэдээж шинэчлэл хийхэд их хугацаа шаардах бөгөөд үр дүнд хүрье гэвэл бүр илүү ч шаарддаг. Үүнийг ёс төдий зүйл гэж ойлгож болохгүй. Бюрократ нь засаглалын бусад салбараас тусдаа оршиж чаддаггүй. Судалгаагаар төрийн захиргааны хөгжлийн хэтийн төлөвлөгөө хязгаарлагдмал, ихэнх тохиолдолд ёс төдий, жинхэнэ асуудал дээрээ төвлөрч чаддаггүй гэдгийг харуулсан.

Дөрөвт, бюрократыг шинэчлэх гэдэг нь улс төрийн дэглэмийн өөрчлөлтийн асуудалтай хамааралтай. Судалгааны дүнгээр хөгжлийн төвшин тийм ч чухал биш. Ядуу орнуудын хувьд постбюрократ засаглалыг хөгжүүлэх боломжтой. Нийгэм, эдийн засгийн асуудал нь энэ талбарт бараг хүндрэл учруулдаггүй. Танзани, Тайланд хоёр нь өөр өөр улсууд ч гэсэн хоёуланд нь шинэчлэл явагдаж, үйл явц нь бүртгэгдсэн байна.

Бусад дөрвөн үзүүлэлтүүдийнболон бюрократын хамаарлыг шалгахад, тэдний хамаарал их хэмжээгээр өөрчлөгдөх тусам дүгнэлт бүдэг, хоёрдмол утгатай болж байгаа нь анзаарагджээ. Мерит тогтолцооны зарчмууд ач холбогдол багатай болж байна. Гэсэн хэдий ч асуулгад оролцогчдоос чанарын судалгаа авахад, төрийн итгэл даах байдалд тушаал дэвшүүлэх, ажилд авахад баримтлах мерит зарчим чухал гэж үзсэн. Энэхүү үзүүлэлт болон гүйцэтгэлийн хооронд тодорхой холбоос байхгүй. Өндөр албан тушаалтан бодлого боловсруулалтанд оролцох нь бас нэг нууцлаг үзүүлэлт. Өндөр албан тушаалтан бодлого боловсруулалтанд оролцох нь сайн талтайг харуулах бага зэргийн нотолгоо олджээ. Асуулгад оролцогчид бага зэргийн нөлөө нь зайлшгүй зүйл биш, харин өндөр албан тушаалтнууд заримдаа эерэг үр дүн үзүүлэхэд нөлөөлдөг гэж үзсэн. Энэ үзүүлэлт нь улс төрийн дэглэмийн шинж чанараас ихээхэн хамааралтай байна. Зарим дэглэмд сайн заавар зөвлөгөө нөлөөлдөг ч улс төрийн үнэнч, тууштай байдал зэрэг нь бусадтай харьцуулахад арай бага байсан ажээ. Ийнхүү засаглалын цэвэр чанарын асуудал нь хязгаартай гэдгээ харуулж байна. Энэ асуудлыг

илүү мэдэхийн тулд нэмэлт олон судалгаанууд хэрэгтэй юм. Учир нь олон улсын хөгжлийн нийгэмлэгийн төлөөлөгчдийн гаргасан хийсвэр загвар нь гажилттай.⁸⁷

Судалгаа дахь ил тод байдал, тайлагнах чанарын үзүүлэлтүүд нь гүйцэтгэлтэй хамааралтай байдаг гэсэн баталгаа гарч байна. Судлаачид өөрсдийн судалгааг дэлхийн банкны засаглын үр дүнтэй байдал судалгаагай⁸⁸ харьцуулахад дараалан 0.48 ба 0.49 гэсэн тоонуудын хамаарлыг олсон байна. Эдгээр хоёр судалгаа нь бюрократын үйл ажиллагааг сайжруулахад чухал үүрэгтэй. Хүртэх боломжийн талаар энэ хоёр судалгааг харьцуулан энгийн нэмэлт дүгнэлт хийжээ.

Үүнд:

1. Ил тод байдал, тайлагнах чанар хоёул доогуур байвал халамж, үйлчилгээний гүйцэтгэл бага байна.
2. Хэрэв ил тод байдал, тайлагнах чанар хоёул доогуур байгаад бусад нь өндөр үнэлгээтэй байвал халамж, үйлчилгээ нь дунд төвшинд байна.
3. Хэрэв ил тод байдал, тайлагнах чанар хоёул дунд төвшинд байвал халамж, үйлчилгээ дунд зэргийн төвшинд байна. Энэ нэмэлт үзүүлэлт нь ил тод байдал, тайлагнах чанар хоёр халамж, үйлчилгээнд нөлөөлөх чадамжтайг харуулж байна.

Энэ дүгнэлт нь төрийн захиргааны удирдлага, төрийн өмчийн үйлдвэрийг шинэчлэх гэж буй хүмүүст их сонирхолтой, чухал билээ. Энэ судалгаа нь авлига, хээл хахуультай тэргүүн эгнээнд тэмцэж, ил тод байдал, тайлагнах чанарыг сайжруулахаар ажиллаж буй байгуулагуудад итгэл, зориг өгч байгаа билээ.

НОМ ЗҮЙ

1. Kofi Annan, Partnerships for Global Community: Annual Report on the Work of the Organisation (UN, 1998).
2. 1998).
3. Goran Hyden and Julius Court, 2002, Governance and Development, World Governance Survey Discussion Paper 1, Tokyo: UNU.
4. Julius Court, Goran Hyden and Kenneth Mease, 2002, Assessing Governance: Methodological Challenges,
5. World Governance Survey Discussion Paper 2, Tokyo: UNU.
6. Weber, M., The Theory of Social and Economic Organizations. New York: Free Press 1947.
7. Bureaucracy and Growth: A Cross-National Analysis of the Effects of Weberian. State Structures on
8. Economic Growth. American Sociological Review, Vol. 64, No 5 (October 1999), pp 748-765; and, Peter Evans and J.E. Rauch, .Bureaucratic Structure and Bureaucratic Performance in Less Developed Countries.,
9. 8 Peter Evans, Embedded Autonomy: States and Industrial Transformation, Princeton, NJ: Princeton
10. The East Asian Miracle: Economic Growth and Public Policy. University Press 1995; and, World Bank. New York: Oxford University Press 1993.
11. University of California Press and London: Heinemann Educational Books 1983.
12. Bureaucracy and Economic Growth, in World Politics, vol. 51 (July 1999)
13. Michel Crozier, The Bureaucratic Phenomenon. Chicago: University of Chicago Press 1964.
14. Kaufmann, Aart Kraay, and Massimo Mastruzzi 2003. .Governance Matters III: Governance Indicators for
15. 1996-2002., Washington D.C.: World Bank (May).
16. M. Lipsky, Street-Level Bureaucracy: Dilemmas of the Individual in Public Services. New York: Russell Sage Foundation 1980.
17. Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ.,2013. Тод Магнат ХХК.

⁸⁷ Энэ мөрөн дэх ажлуудыг Өмнө ба Зүүн зүгийн хэсэг оюутнууд хийсэн. Энэ төслийг Ази дах засаглалын эргэн эрэлт гэж нэрлсэн ба Японы Хосай Их Сургуулийн профессор Ясүтами Шимомурагаар ахлуулсан байна.

⁸⁸ Даниель Кауфменээр удидуулсан Дэлхийн Банкны засаглалын үр ашгийн төвшин дэх судалгаа.

БНСУ-ЫН 2012 ОНЫ 18 ДАХЬ УДААГИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН УЛС ТӨР, ҮР ДҮН

Ж.ТӨРТӨГТОХ

Доктор, профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,

Улс төр судлалын тэнхим

Ч.ХАНДДУЛАМ

Улс төр судлалын тэнхимийн магистрант

Оршил

БНСУ-ын 18 дахь удаагийн Ерөнхийлөгчийн сонгууль 2012 оны 12-р сарын 19-нд болж өнгөрсөн. Энэ сонгуульд нэр дэвшигч Пак Гын Хе ялалт байгуулан БНСУ-ын Ерөнхийлөгч болсон билээ.

Тус сонгууль нь БНСУ-ын Үндсэн хуулинд 1987 онд нэмэлт өөрчлөлт оруулж, Ерөнхийлөгчийн шууд сонгуулийн системтэй болсноос хойш хоёр дахь удаад тохиолдож буй хоёр нэр дэвшигч халз өрсөлдсөн сонгууль болсон юм. Үүний өмнө 2002 онд болсон Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Гвон Ён Гил 4%-н саналаар ялж байсан бол 2012 онд нэр дэвшигч Пак Гын Хе нь нэр дэвшигч Мүн Жэ Ин-ээс ердөө 3% орчим саналын зөрүүтэйгээр ялалт байгуулсан маш ширүүн өрсөлдөөнт сонгууль болсон байна.

Дээр дурдсан 2002 болон 2012 оны сонгуулиас бусад дөрвөн удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд гурав дахь нэр дэвшигчид нь ойролцоогоор нийт саналын 15%-ийн санал авч байжээ.


2012 онд зөвхөн хоёр нэр дэвшигчийн хооронд халз өрсөлдөөн болсон учир нь БНСУ-ын Үндэсний ассамблейд суудал бүхий гуравдагч хүчний нам болох Нэгдсэн Дэвшилтэт Нам /Тунхаб Жинбу/-аас нэр дэвшигч И Жон Хы албан ёсоор нэрээ татаж, Үндэсний Ассамблейд авсан суудлаараа дөрөвдүгээрт ордог Чүнгчонг аймгийн нам болох Эрх Чөлөөний Төлөөх Нам /Чаюү Сонжин/ хэдийгээр парламентад тусдаа суудалтай боловч энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд эрх баригч Сэнүри Намтай нэгдсэн явдал юм.

БНСУ-ын 1987 оны Ерөнхийлөгчийн сонгуулиас хойш сонгогчдын сонгуулийн ирц буурсаар байгаа юм. Гэвч 2012 онд болсон Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц 2007 он болон 2002 оныхыг бодвол харьцангуй нэмэгдэж сонгогчдын улс төрийн идэвх, сонирхол тодорхой хэмжээгээр ихэссэнийг илэрхийлж байна. Үүнийг Зураг 1.-ээс харна уу.

Зураг 1. Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц



Сонгуулийн ялагч Пак Гын Хе-гийн улс төр



Зураг 2. И Мёнг Баг ба Пак Гын Хе



Тэрээр 2007 онд 17 дахь удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд нэрээ дэвшүүлэхээр нам дотроо Ерөнхийлөгч байсан И Мёнг Баг-тай (49.56 %) өрсөлдсөн боловч багахан саналын хувиар Пак Гын Хе (48.06%) ялагдаж байсан байна. Эрх барьж буй Ханнара Намаас И Мёнг Баг нэр дэвшин, БНСУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсон боловч дараагийн Ерөнхийлөгчийн сонгуулиар Пак Гын Хе амжилт үзүүлэх боломж, найдвартай болох нь 2007 онд харагдаж байсан ажээ. Пак Гын Хе-гийн эцэг бөгөөд БНСУ-ын Ерөнхийлөгч байсан Пак Жон Хы-гийн олон нийтийн дундах нэр хүнд харьцангуй өндөр, бүтээсэн ололт, амжилт чамгүй их, мөн нам дотроо нэлээд чухал байр суурь эзэлж, хамгийн том фракцыг

удирдаж байсан байдаг. Тиймээс Пак Гын Хе-гийн нам доторхи байр суурь нь Пак Жон Хы-гийн байр суурь мэт хүчтэй байсан байна.

2011 оны 12 сард Ханнара Намын гаргаж дэвшүүлсэн бодлого, үйл явдлаас үүдэн гарсан зарим сөрөг үр дагаварууд, тэдгээрийн талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байсан мэдээллүүдээс шалтгаалан Ханнара Нам нь “Онц нөхцөлд ажиллах хороо” байгуулан Пак Гын Хе-гээр удирдуулсан. Пак Гын Хе нь намынхаа нэр хүндийг сайжруулахын тулд намын нэрд өөрчлөлт зайлшгүй хэрэгтэй гэж үзэн, “Үндэсний их нам” буюу Ханнара намын нэрийг 2012 оны 2 дугаар сард “Шинэ ертөнц” буюу “Сэнүри” гэж өөрчилсөн.

Ингээд 2012 оны 4 дүгээр сарын 11-нд болсон БНСУ-ын Үндэсний Ассамблейн 19 дэх удаагийн сонгуулиар Сэнүри нам нь парламентын 300 суудлаас 152-ыг авч ялалт байгуулан, улс төрийн эрх мэдлийг авсан нь олон нийтийн дундах Пак Гын Хе-гийн нэр хүндийг өргөж, улмаар хүмүүсийн дэмжлэг эрс нэмэгдсэн юм.

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлсэн улс төрийн намуудын бодлого, улс төр

Эрх баригч Сэнүри Намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх сонгон шалгаруулалтын үр дүнд 2012 оны 8 дугаар сарын 20-нд Пак Гын Хе-г сонгосон байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 1.-ээс үзнэ үү.

Хүснэгт 1.

Нэр дэвшигч	Үр Дүн	Саналын хувь	Саналын тоо
Паг Гын Хе	Ялсан	83.97%	86589
Гим Мун Сү	2т	8.68%	8955
Гим Тэ Ху	3т	3.20%	3298
Им Тэ Хы	4т	2.69%	2676
Ан Санг Сү	5т	1.55%	1600
		100%	103118

Солонгосын хамгийн гол сөрөг хүчин болох Нэгдсэн Ардчилсан Намтай одоогийн ардчилсан улс төрийн хүчнүүд болон Ерөнхийлөгч асан Ну Му Хён нас барсны дараа гарч ирсэн хуучин хүчнүүд хамтран Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон юм. Одоогийн ардчилсан намын хүчнүүд Сун Хаг Гюу-г, хуучин хүчнүүд нь Мун Жэ Ин-г тус тус нэр дэвшүүлсэн. Ингээд сонгуулийн өмнөх шалгаруулалтанд Бусаны Сасан дүүргээс сонгогдсон БНСУ-ын Үндэсний Ассамблейн гишүүн, Засгийн газрын 4-р тамгын газрын дарга байсан Мун Жэ Ин Нэгдсэн Ардчилсан Намаас нэр дэвшихээр болсон байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 2.-оос үзнэ үү.

Зураг 3. Мун Жэ Инь

Хүснэгт 2.



Нэр дэвшигч	Үр Дүн	Саналын хувь	Саналын тоо
Мун Жэ Инь	Ялсан	56.5%	347,183
Сун Хаг Гюу	2т	22.2%	136,205
Гим Дү Гуан	3т	14.3%	87,842
Чон Сэ Гюн	4т	7.0%	43,027
		100%	614,257

Пак Жон Хи-гийн охин ба Ну Му Хён-ы найзын халз өрсөлдөөн

Зураг 4



Энэ сонгуулийн нэг онцлог нь өрсөлдөөн зөвхөн Пак Гын Хе болон Мун Жэ Ин нарын хооронд төдий биш, хуучин ерөнхийлөгчдийг орлон сонгуульд өрсөлдсөн явдал юм. Пак Жон Хы-гүйгээр Пак Гын Хе-г төсөөлөхийн аргагүйн адил, Ну Му Хён-гүйгээр Мун Жэ Ин-ийг төсөөлөх аргагүй юм.

Пак Жон Хы бол Өмнөд Солонгосын консерватив үзэлтнүүдийн дунд өнөөг хүртэл нэр хүнд өндөр, тэдний хүндлэлийг хүлээсэн хүн бөгөөд Эдийн засгийн өсөлт, Хүчирхэг улс, Үндэсний аюулгүй байдал гэсэн үндсэн асуудлуудыг консерватив үзлийн суурь болгон баримталж байсан юм. Харин Ну Му Хён бол Өмнөд Солонгосын либерал үзэлтнүүдийн хүндэтгэлийг хүлээсэн хүн бөгөөд либерал үзлийн суурь болох авторитар бус, эрх тэгш нийгмийг бүтээн байгуулалцсан гэж олон нийт үнэлдэг байна.

Иймээс сонгогчид тус тусынхаа баримталдаг байр суурь, үзэл баримтлалын үүднээс Пак Гын Хе ба Мүн Жэ Инь нарын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрт хандсан ажээ.

Энэ сонгуулийн бас нэг онцлог бол мөрийн хөтөлбөр болон бодлогын өрсөлдөөнөөс илүүтэйгээр нэр дэвшигчдийн нэр хүндийн өрсөлдөөнийг илүүтэй харгалзсан байна. Пак Гын Хе нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, Мүн Жэ Инь нь дотоодын эдийн засгийн асуудалд анхаарлаа хандуулна хэмээн тунхаглаж байсан боловч яваандаа Пак Гын Хе нь өөрийн эцгийн бүтээн байгуулсан Хан мөрний гайхамшиг⁸⁹ дахин сэргээнэ гэж, Мүн Жэ Инь нь Ну Му Хёны биелүүлж чадаагүй мөрөөдлийг биелүүлнэ хэмээн сонгуулийн бодлогоо өөрчилсөн байна.

Сонгуулийн дүн

Пак Гын Хе, Мүн Жэ Ин нарын авсан саналыг харьцуулан авч үзье. Эдгээр гол хоёр нэр дэвшигчийн хувьд Пак Гын Хе нь Мүн Жэ Ин-ээс 3.5%-иар илүү буюу 1080496 санлын тоогоор ялсан байна. Нэр дэвшигч тус бүрийн авсан саналын дэлгэрэнгүйг Хүснэгт 3-аас харна уу.

Зураг 5.





Хүснэгт 3

	Нэр дэвшигчид	Нам	Саналын тоо	%
1	ПагГынХе	Шинэ ертөнц нам	15,773,128	51.55
2	МүнЖэИн	Нэгдсэн ардчилсан нам	14,692,632	48.02
3	ИЖонгХы	Нэгдсэн дэвшилтэт нам	Нэрээ татсан	
4	ГангЖиВон	Нам бус	53,303	0.17
5	ГимСүнЖа	Нам бус	46,017	0.15
6	Гим СуЁн	Нам бус	16,687	0.05
7	ПагЖунСон	Нам бус	12,854	0.04
Хүчин төгөлдөр бус саналын тоо			126,838	-
Нийт саналын тоо			30,721,459	100
Нийт өгөх ёстой саналын тоо			40,507,842	75.84

Сонгогчдын нас, хүйсийн байдлыг нэр дэвшигч бүрээр авч үзвэл, Пак Гын Хе-д санал өгсөн хүмүүсийн 49,8% нь эрэгтэйчүүд, Мүн Жэ Ин-д санал өгсөн хүмүүийн 51,1% нь эмэгтэй хүмүүс байна. Зураг 6-аас үзнэ үү.

⁸⁹ Пак Жон Хи-гийн засгийн газар улс орноо орчин үежүүлэх зорилгоор эдийн засгийн хөгжлийн бодлого явуулснаар улс орны эдийн засаг сэргэж хөгжсөн ба үүнийг солонгосчууд «Хан мөрний гайхамшиг» хэмээн нэрлэдэг ажээ.

Зураг 6



Өмнөд Солонгосын аж үйлдвэржилтийн үеийг туулсан 50, 60 настнууд Паг Гын Хе, ардчиллыг голлож байсан 40 настнууд болон ардчиллын дараа төрсөн 20-30 настнууд Мун Жэ Ин-ийг харьцангуй илүү дэмжсэн байна.


Сонгуулийн дүнг Солонгосын бүс нутаг, аймаг бүрээр харьцуулан авч үзсэнийг Зураг 7, 8, 9-с тус тус харна уу.

Зураг 7.


Бүс нутаг		Паг Гын Хе	Мун Жэ Ин
Шинэ ертөнц нам		Нэгдсэн ардчилсан нам	
Нийслэл	Сөүл	3024572	3227639
	Инчон	852600	794213
	Гёнги	3528915	3442084
Чүнчон	Гангвон	562876	340870
	Дэжон	450576	448310
	Чүнгбүг	518442	398907
	Чүнгнам	658928	497630
	Сэжунг хот	33587	30787
Жолла	Гуангжү	69574	823737
	Жонбүг	150315	980322
	Жоннам	116290	1038347

Генгсан	Бусан	1324572	882511
	Улсан	413977	275451
	Генгнам	1259174	724896
	Дэгү	1267789	309034
	Генбүг	1375164	316659
Жэжү		166184	161235
Нийт		15773128	14692632

Зураг 8.



Зураг 9.



Пак Гын Хе-гийн Засгийн газрын бодлого, зорилт

Пак Гын Хе ерөнхийлөгч 140 төрийн бодлогын зорилт дэвшүүлснээс «Эдийн засгийн сэргэлт», «Үндэсний аз жаргал», «соёлын хөгжил цэцэглэлт», «Нэгдсэн энх тайвны үндсэн үндэс суурийг тавих» гэсэн 4 том бодлого ба 14 том дэмжих стратеги гэж ангилж ажлууд хийж эхэлсэн.

Мөрөөдлийн шинэ үе			
Үндэсний аз жаргал ↔ Улсын хөгжил			
Эдийн засгийн сэргэлт		Үндэсний Аз жаргал	
42 зорилт		64 зорилт	
Бүтээлч эдийн засаг	Бүтээлч эдийн засгийн экосистем, Жижиг бизнесийн компани, Шинэ бизнес, Шинэ зах зээл эхлэх, Бүтээлч чадварлаг боловсон хүчин, Шинжлэх ухаан техник, Мэдээлэл харилцаа холбоо	Хөдөлмөр эрхлэлт Нийгмийн халамжид зориулж Бүтээлч боловсрол	Амьдралын мөчлөгийн дагуу үе шат бүхий халамж, Бие даасан халамжийн бодлогын тогтолцоо, Бага төрөлтийг давж гарах эмэгтэйчүүдийн хөдөлгөөн Мөрөөдөл ба авьяасын боловсрол, Мэргэжлийн боловсон хүчин, амьдрах арга ухаанд суралцах, Ажлын байрны нөхцөл
Ардчилсан эдийн засаг	Зах зээлийн эдийн засгийн зарчим	Иргэдийн аюулгүй байдал	Гэмт хэрэг, гамшгаас урьдчилан сэргийлэх, урт удаан хугацаанд тав тухтай байх боломжтой хүрээлэн буй орчин
Ард иргэдийн эдийн засаг	Ард иргэдийн амьдралын аюулгүй байдал, Эдийн засгийн аюулгүй байдлыг тус тус хангахад чиглэсэн үйл ажиллагаа	Нийгмийн нэгдэл	Нэгдэл ба эв эе, Бүс нутгийн тэнцвэртэй хөгжил, Орон нутгийн эрх мэдлийг хуваах
Итгэл хүлээсэн засгийн газар			
			7 зорилт
Соёлын хөгжил цэцэглэл		Нэгдсэн Энхтайван үндсэн үндэс суурийг тавих	
10 зорилт			17 зорилт
Соёлын оролцоог ихэсгэх	Соёлын хөрөнгө санхүү, соёлын үндсэн дүрэм, Соёлын оролцооны боломж, соёлын ялгааг алга болгох, Олон үндэстнийг дэмжих ,амьдралын соёл, Орон зайн бүтэц	Аюулгүй байдлыг баталгаажуулах	Аюулгүй байдлыг баталгаажуулах, Тогтвортой энх тайван
Соёл урлаг дэмжих	Уран бүтээлчдийг дэмжих, Соёлын үнэт зүйл хадгалалтыг бэхжүүлэх, Соёл иргэншлийн оюуны соёлыг дэмжих	Солонгосын хойг дахь итгэлтэй үйл ажиллгаа	Аз жаргалтай нэгдэл тийш явах, шинэ Солонгосын хойг
Соёл, үйлдвэрлэлийг нэгтгэх	Аж үйлдвэрлэлийн хөгжил, өндөр нэмүү өртөг шингэсэн аялал жуулчлалыг дэмжих, Спортыг идэвхижүүлэх	Итгэлтэй гадаад харилцаа	Ард иргэдтэй хамтдаа хийх итгэлтэй гадаад харилцаа

2014 оны 2 дугаар сарын 5-нд Ерөнхийлөгчийн ажлын тайлангаас дээр дурдсан 140 бодлогын зорилтоос 29 нь онц сайн хийгдсэн, 27 нь хангалтгүй гэсэн үнэлгээтэй байсан байна.

Пак Гын Хе залуучуудын ажилгүйдлийн асуудал болон Өмнөд ба Умард Солонгосын харилцааны тогтворгүй байдал, дэлхийн эдийн засгийн хямрал, овоорон байгаа улсын дотоод болон гадаад асуудлуудыг ухаалгаар даван туулахаар сонгуульд нэр дэвшихдээ амлаж байсанчлан “Аз жаргалтай ард түмний үе”-ийг нээхээр ажиллаж байна.

НОМ ЗҮЙ

1. Солонгос улсын 18 дахь ерөнхийлөгчийн сонгууль https://librewiki.net/wiki/대한민국_제18대_대통령선거
2. *2012 оны ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнгийн анализ* <https://crossovernba.wordpress.com/2014/01/27/>
3. Хүн амын судалгаа <http://www.indexmundi.com/g/g.aspx?c=ks&v=21>
4. Пак Гын Хе-н засгийн газрын төрийн бодлгын 140 зорилт <http://www.korea.kr/policy/societyView.do?newsId=148761387>
5. Пак Гын Хе-н засгийн газрын 2 жилийн зорилт <http://weekly.donga.com/List/3/all/11/97123/1>

ХӨГЖИЖ БУЙ ОРНУУДЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ШИНЭТГЭЛ ДЭХ ПРАКТИК ЗАРЧМУУД

Ц.БАТБОЛД

Доктор, дэд профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,

Улс төр судлалын тэнхим

Х.ГАНТУЛГА

Улс төр судлалын тэнхимийн докторант

Түлхүүр үг: Улс төрийн институцийн төлөвшил, төрийн бодлогын мөн чанар, улс төрийн хүсэл зориг, Үр дүнгийн гэрээ, чанарын өрсөлдөөн, нийгмийн хариуцлагын механизм,

Товч агуулга: Төрийн захиргааны үйл ажиллагаа өмнө нь хууль болон бодлогын хэрэгжүүлэлтэд гол нь үр ашигтай байхыг шаардаж байсан бол, өнөөгийн захиргааны өөрчлөлтийн мөн чанар нийгэмд үр дүнтэй үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэж байна. Засгийн газрын стратегийн цөм нь шийдвэр гаргахдаа сонгогдсон улс төрчид болон төрийн үйлчилгээний туршлагатай мэргэжилтнүүдтэй өндөр түвшинд хамтран ажиллах, мөн засгийн газар төвлөрсөн бус төрийн бүтэц дээр суурилж агентлагуудын процедураас илүү үр дүнгээ хариуцах чадвартайгаар зохион байгуулагдах, үр ашигтай нийгмийн үйлчилгээг хангахын тулд орчин үеийн мэдээлэл харилцааны технологиор хангагдсан байхад чиглэгдэж байна.

Abstract: Public administration plays a central role on the Millennium Development Goals(MDGs) because they will only be achieved to the extent that the national states in the developing countries count with state organizations strong enough to promote them. In the case of the poorer countries, for which the attainment of these goals will depend on the support of developed countries through the UN system international institutions, such aid also will depend on the governance capacity of each country and particularly on the quality of the more general instrument of collective action they count with: the state organization and its public administration.

In each country, the strength or capability of the state organization depends, first, on its democratic political institutions, that make the rule of law effective, human rights assured, and the government or administration, legitimate.

XX зууны 80-аад оноос эхэлж, өдгөө ардчилсан улс орнуудыг бүхэлд нь хамраад буй төрийн буюу нийтийн захиргааны шинэтгэл нь намуудын улс төрийн бодлого, сонгуулийн мөрийн хөтөлбөрийн гол чиглэлийн нэг байсаар ирсэн бөгөөд одоо ч чухал асуудал хэвээр байна. Захиргааны шинэтгэлийг хэрэгжүүлж буй улс орон бүр тухайн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлог, улс төрийн засаглал, төрийн захиргааны үйл ажиллагаа дахь тулгамдсан асуудлууд тэдгээрийг шийдвэрлэх арга замыг ямар нэгэн хэмжээгээр тодорхойлон хэрэгжүүлж, янз бүрийн харилцан адилгүй эерэг үр дүн болон тодорхой сөрөг үр дагаваруудад хүрсэн байдаг.

Захиргааны шинэтгэлийг хэрэгжүүлж буй улс орнуудын нийтлэг тал нь энэ үйл ажиллагааны хүрээнд өмнө нь ихэнхдээ хууль болон бодлогын хэрэгжүүлэлтэд гол ач холбогдол өгч, захиргааг үр ашигтай байлгахад анхаардаг байсан бол, өнөөгийн захиргааны өөрчлөлтийн мөн чанар нь нийгэмд үр дүнтэй үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэж байна. Засгийн газрын стратегийн цөм нь шийдвэр гаргахдаа сонгогдсон улс төрчид болон төрийн үйлчилгээний туршлагатай мэргэжилтнүүдтэй өндөр түвшинд хамтран ажиллах, мөн засгийн газар төвлөрсөн бус төрийн бүтэц дээр суурилж агентлагуудын процедураас илүү үр дүнгээ хариуцах чадвартайгаар зохион байгуулагдах, үр ашигтай нийгмийн үйлчилгээг хангахын тулд орчин үеийн мэдээлэл харилцааны технологиор хангагдсан байхад чиглэгдэх болсон юм. Гэвч эдгээр шинэтгэлийн хандлага нь дараах хүчин зүйлсээс ихээхэн хамаарна.

Үүнд:

1. Ардчилсан улс төрийн институцуудыг оновчтой төлөвшүүлэх; Энэ нь хүний эрхэд хуулиар баталгаа өгсөн хуулийн үр ашигтай засаглал байх, засгийн газар ба төрийн захиргаа нь легитимтэй эсэхээс илүү шалтгаална.
2. Төрийн бодлогын мөн чанар; Энэ нь улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд бодит үр нөлөө үзүүлдэг байх, шийдвэр гаргах болон хэрэгжүүлэх түвшиндээ ардчиллын үнэт зүйлс, бодлогын зорилтуудад чиглэсэн эсэхээс шалтгаална.
3. Улс төрийн хүсэл зориг; Улс төрчдийн дийлэнх нь захиргааны өөрчлөлтийг хэрэгжүүлэх улс төрийн зорилготой эсэхээс шинэтгэлийн үйл явц ихээхэн шалтгаална.

Тухайлбал, төрийн захиргааны шинэтгэл нь улс төрийн хангалттай дэмжлэгтэй байж сая амжилтанд хүрнэ. Ядуу буурай орнуудын нөхцөлд эдгээр зорилгыг НҮБ болон олон улсын санхүүгийн байгууллагууд, бусад олон улсын байгууллагын системээр дамжуулан хийх хөгжингүй орнуудын дэмжлэг, тусламж, шахалтаас тодорхой хэмжээнд хамаарч байна. Ялангуяа дээрх хүчин (улс төрийн институт, бодлого, инновацийг хэрэгжүүлэх зорилго) зүйлсүүд бүрдээгүй үед захиргааны өөрчлөлт нь зохиомол, тухайн улс оронд идээшихгүй, хэлбэрдлийн шинжтэй үзэгдэл болон хувирдаг гэсэн шүүмжлэл түгээмэл ажиглагддаг. Олон улсын байгууллагын иймэрхүү тусламж, дэмжлэг нь тухайн улс орон бүрийн засаглалын чадвар, хамтын ажиллагааны арга хэрэгслийн чанар, улс төрийн болон төрийн захиргаанаас өөрөөс нь шалтгаална гэдгийг тооцох хэрэгтэй юм. Улс орон бүрийн төрийн байгууллагын чадвар, бэхжилт нь түүх, соёл, уламжлалын онцлогоос хамаарч өөр өөр байх нь зүйн хэрэг.

НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр болон Мянганы Хөгжлийн Зорилтуудтай нийцсэн төрийн захиргааны практик зарчмуудын уян хатан, өргөн тодорхойлолтыг тэд гишүүн орнууддаа өгөх нь захиргааны шинэчлэлтэд голлох хувь нэмрийг оруулж магадгүй юм гэж үздэг. Ардчилал бэхэжсэн орнуудын нийтийн захиргааны зарчмуудыг хөгжиж буй орнуудын захиргаанд хэрэглэснээр төрийн илүү үр ашигтай стратегийн цөмийг хэрэгжүүлэн төрийн чадамжийг өсгөж, нийгмийн үйлчилгээг илүү шинжлэх ухааны үр дүнтэй болгоход практик тус нэмэр болох нь зайлшгүй.

Тухайлбал, Мянганы Хөгжлийн Зорилтуудыг хангах хөтөлбөр нь “bottom up approach document” (Доороос дээшлэх хандлагын ба үндсэн зарчмуудыг хөгжүүлэх арга зүй, төрийн захиргааны үндсэн зарчмууд: Байгууллагын үнэлгээн дээр суурилсан шалгуурын жишээнүүд)-д тулгуурлаж байгаа бөгөөд тэд эдгээр зарчмууддаа маш энгийн, тодорхой, ашиглагдаж болохуйц хэмээн тайлбарлаж, хүлээн зөвшөөрөхөөсөө өмнө тухайн улсууд захиргааны институцийг чөлөөтэй сонгож байх зуур нягтлан үзэх, практик зөвлөгөөг санал болгож байна. Эдгээр зарчмууд “ил тод байдал, хариуцлагын тогтолцоо, оролцоо ба плюрализм, үр ашигтай, үр дүнтэй, шударга зарчим, үйлчилгээг ашиглах тухай багтаадаг”⁹⁰ байна. Төрийн захиргааны үйл ажиллагааны зарчмыг тодорхойлоход нэг талдаа эдгээр ерөнхий зарчмуудыг авч үзэх нөгөө талдаа үйл ажиллагааны зарчмын практик шаардлагыг хэлэлцэх шаардлага гарна. “Bottom up approach document” нь “шалгуур дээр суурилсан” хандлагаас “захиргааны стандартчилагдсан зарчмийг” ялгаж өгдөг. Стандартчилагдсан зарчмууд нь “нэг хэмжээ бүгдэд нь тохирдог” гэсэн хандлагын сонгодог асуудалтай тулгардаг. Шалгуур дээр суурилсан хандлагууд нь өөрсдөө энэхүү асуудлыг тодорхойлохоос зугатаж “түгээмэл таамаглал” болох: тусгай бус гүйцэтгэлийн арга хэмжээнүүдийг задлан шинжилсэн ч гэлээ байгууллагын шүүмж, түүний шалгуурын гол элементүүд нь үр дүнтэй байхад чиглэгдсэн, мөн чадавхи өндөртэй гүйцэтгэлийн тухай асуудал юм. Энэ хандлагыг хүлээн зөвшөөрлөө гэхэд доорх сэтгэлгээний шугамуудыг дээр нь нэмж авч хэлэлцэх ёстой болж байна. Энэ нь үйл ажиллагааны ба бүтцийн зарчмууд юм.

Бид үйл ажиллагааны зарчмыг тодорхой ул суурьтай, үйлдлийн прагматик курсэд хамааруулж ойлгох шаардлагатай. Энэ нь уян хатан тайлбарлалыг хүлээн зөвшөөрдөг боловч бас энгийн хэрэгжилтэнд шууд дэмжлэг үзүүлдэг онцлогтой. Бүтцийн зарчим нь төрийн байгууллагын бүтцийн өөрчлөлт, байгууллагын шинэчлэлтийн төлөвлөгөөгөөр хязгаарлагдахгүй бөгөөд хувийн агентлагууд, татварын эх сурвалжаар санхүүжин үйлчилгээ үзүүлэхийг дэмждэг байна. Эдгээр үйл ажиллагааны ба бүтцийн зарчмууд нь гурван хэсэгт хуваагдах бөгөөд тус тусад нь авч үзвэл төрийн бүтэц, төрийн үйлчилгээ, менежментийн хэрэгжүүлэлт зэрэг юм. Төрийн байгууллын нэгдсэн, эсвэл холбооны байх ёстой эсэх нь төрийн бүтцийн тухай асуудалтай холбоогүйгээр төрийн бүх үйлчилгээ шууд хууль ёсны төрийн албан хаагчдаар дамжин хийгддэг. Энэ хүрээнд үүрэг хариуцлагыг төрийн албан хаагчдаар сахиулах шаардлага бий болдог. Төрийн үйлчилгээний гуравдагч талыг нь аутсорсчлох (outsourcing-хөндлөнгийн этгээдүүдээр чанарын нэг түвшинд хямд хөлсөөр үйлчилгээ хийлгэх) нь шинэтгэлийн гол практик алхамын нэг болох ёстой аж. Орчин үеийн нийтийн захиргаа нь тодорхой үйл ажиллагааны чиглэлтэй бөгөөд тодорхой хэмжээнд төрийн үйлчилгээг шууд хангах боловч үйлчилгээнд нь зөвхөн төрийн тусгай үйл ажиллагааг л хамааруулдаг байна. Нийтийн захиргааны бодлого, шийдвэрүүд нь нутгийн захиргааны зарчмаар хэрэгждэг. Энэ нөхцөлд нийтийн захиргааны үйл ажиллагаанууд нь төрийн эрх мэдлийг ашиглах, эсвэл төрийн нөөцийг хянах зэрэгт хамаардаг байна.

Бусад үйл ажиллагаанууд болох төрийн санхүүгийн нэмэлт үйл ажиллагаа, хангамж нь тухайлбал, барилга, цэвэрлэгээний үйлчилгээ гэх мэт бүхлээрээ бизнесийн хэвшлээр аутсорсчлогдчихсон байх бөгөөд нийгмийн үйлчилгээ нь төвлөрсөн бус агентлаг эсвэл иргэний нийгмийн төрийн бус байгууллагаар аутсорсчлогдсон байх ёстой болдог байна. Харин туршлагатай төрийн албан хаагчид ба улс төрчдийн стратегийн цөм нь тэдэнд хатуу хариуцлага тооцдог төрийн хэлбэртэй байна. Үүнийг ажиглавал бүтцийн реформ нь төрийн үүрэг ролийн тухай юу ч хэлээгүй бөгөөд харин төрийн үйлчилгээ нь зөвхөн мэргэшсэн боловсон хүчнээр л хангагдана гэдгийг онцолжээ.

Төрийн захиргааны ийм үйл ажиллагааг таамаглахад бие даасан агентлаг эсвэл ТББ-ууд үргэлж төрийн яамдаас илүү үр дүнтэй, үр ашигтайгаар хариуцлагыг тооцож магадгүй юм. Харин төдийлөн эрх мэдэлгүй, гүйцэтгэгч төрийн албан хаагчид нь төрийн үйлчилгээнд бие даасан шинжтэйгээр голлох үүрэг гүйцэтгэж, гүйцэтгэлийн хариуцлага хүлээх ёстой болж байна. Ийм захиргааны бүтэц төрийн албанд шууд нөлөөлнө. Зохицуулагч агентлагууд нь угаасаа ТББ-ын төлөө ажилладаггүй. Өөрөөр хэлбэл, зохицуулагч агентлагууд давхар үүрэгтэй. Нэг нь үйлчилгээний аутсорсыг хангаж, нөгөө нь нийгмийн хариуцлагыг тооцох гэх мэт.

⁹⁰ United Nations' Economic and Social Council (2005) “Bottom-up Approaches and Methodologies to Develop Foundations and Principles of Public Administration: The Example of Criteria-Based Organizational Assessment”, p. 6.

“Bottom-up approach document” нь иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагыг дайчлан тэдний чадвар багтаамжийг ашиглан иргэдийн ашиг сонирхлыг дэмжих, төрийн албан хаагчдад хариуцлага тооцоход, мөн төрийн үйлчилгээг хангахад ашиглаж болох төрийн захиргааны тухай асуудал юм. Төрийн захиргааны энэ үүрэг одоо болтол эхний хэлэлцүүлэгт байсаар байна. Төрийн захиргааны үүрэг нь улс төрчидтэй цуг хуулийг мөрдүүлэх, шинэ бодлого, шинэ байгууллагын загварыг нарийвчлан боловсруулах, төрийн татварын нөөцийг зөв ашиглах, аутсорсчлогдсон байгууллагын үйлчилгээнд нийгмийн өмнөөс хариуцлага тооцоход чиглэгдэх явдал юм.

Төрийн албыг чадвартай, туршлагатай, өндөр нэр хүнд бүхий төрийн албан хаагчдаар бүрдүүлнэ. Тэд уян хаган карьерийг даган, техникийн шинжтэй асуудал дээр туршлагажсан, сайн цалинтай байх ёстой бөгөөд улс төрчид, сайд эсвэл ерөнхий нарийн бичгийн дарга нь өндөр түвшинд төрийн албыг шахаж ажиллуулна. Мөн төрийн албанаас гадуурх албан хаагчдийг хязгаартайгаар бий болгохыг зөвшөөрч болно. Бүх яам, агентлаг бүр төрийн аппарат дотор эсвэл төрийн аппаратаар санхүүжсэн бол зорилгоо тодорхойлсон стратегийн төлөвлөгөөтэй байж бодлогын гол сонголт нь зорилгодоо хүрэхэд зохицох ёстой болох аж. Агентлаг зорилгодоо хүрэхийн тулд хариуцлага хүлээх чадвартай байж, зорилгодоо хүрэхдээ нөөцөө үр дүнтэйгээр ашиглах ёстой. Ийм нөхцөлд агентлагууд төвлөрсөн бус байх ёстой болж байна. Төвлөрсөн бус агентлагуудад яаж хариуцлага тооцдог байх вэ гэдэг асуудал гарч ирнэ. Үндсэндээ агентлагт хариуцлага тооцох гурван үндсэн хэлбэр байна гэж үзжээ. Үүнд:

а. Үр дүнгийн гэрээгээр байгуулсан менежментээр;

б. Сайн чанарын төлөө өрсөлдөөнөөр удирдуулсан хэлбэр;

в. Нийгмийн хариуцлага тооцох механизм болох иргэний нийгмийн байгууллагууд, иргэний зөвлөл чухал үүрэгтэй.

Энэ гурван нөхцлийн доороос-дээш хандах хандлага дээрх хэрэглээний тал нь:

1. Үр дүнгийн гэрээгээр байгуулсан менежмент: Баримтуудаас авч үзвэл гүйцэтгэл дээр суурилсан засгийн газар нь норматив хэм хэмжээг баримталж, үр дүнгээр удирдах систем нь нөөц ба үр дүнгийн дундах шүүмжлэлийн гол шугам болж байна. Уг системийн загвар нь засгийн газрын менежерүүд, төрийн захиргааны академийн мэргэжилтнүүд энэ салбарын бусад судлаачидтай өргөн зөвлөлгөөн, хэлэлцүүлэг хийсний дараа сонгогдсон байх нь зохистой юм.
2. Сайн чанарын төлөө өрсөлдөөнөөр удирдуулсан хэлбэр: Улсын салбарын байгууллагууд, олон нийтийн болон хувийн салбарынхан үйлчилгээний нэгдсэн өртгийн тайлбар дээр улам их өрсөлдсөөр байна. Мөн үйлчилгээний чиг хандлага, нөөцийн үр дүнтэй хэрэглээн дээр чмаргалдсаар л байдаг. Төрийн захиргааны нэг хязгаарлагдмал хандлага бол ашгийн өсөлт, нөөцийн үр дүнтэй хэрэглээг чухал мэт боддог ч нийгмийн баялгийг хамгаалах, тухайлбал хүрээлэн буй орчныг хамгаалах нь бас чухал бөгөөд үүнийг тооцсон байх нь маргааныг бууруулах гол нөхцөл болно.
3. Нийгмийн хариуцлагын механизм: Төвлөрсөн бус засаглал ба салбар компанийг авч үзвэл энэ нь тэдний “нэгдэл дээр суурилсан байгууллагын хандлагыг”⁹¹ дэмждэг байна. Иргэд болон иргэдийн төлөөлөл шууд нэгдсэн зөвлөгөөнд оролцдог бөгөөд иргэний зөвшөөрөл ба бусад орон нутгийн ашиг сонирхлыг тодруулах, орон нутгийн хөтөлбөрийг үнэлэх зэрэг нь төрийн албан хаагчдад хариуцлага тооцоход баталгаа болдог.

Үйлдвэржсэн нийгмийн төрийн бүтэц, үйлчилгээ нь шууд төрөөс буюу дээрээс бюрократ загвараар чиглүүлэн хангагдаж, дунд, доод түвшиндээ олон төрийн албан хаагчдыг ашиглаж зорилгоо хэрэгжүүлдэг байсан билээ. Орчин үеийн төрийн захиргааны шинэтгэлийн процессийн зарчим нь бага багаар энэ үүргийг шилжүүлэх хэлбэрээр хэрэгжих бөгөөд төрийн албан хаагчдын эрхүүд хүндлэгдэж, ёс зүй өндөр байх ёстой болж байна. Учир нь бага багаар шилжилт хийсэн төрийн албан хаагчид төрийн бодлого, түүний нөөцийн санг өөрсдөө гардан хэрэгжүүлэгчид биш, харин түүнийг чиглүүлэн хуваарилах үүргийг хууль, дүрэм журмын дагуу шударга ёсны зарчмаар гүйцэтгэж, хэрэгжилтэнд нь мониторинг, хяналт тавьдаг нийгмийн эрх ашгийг хамгаалагчид болон хувирах ёстой аж. Энэ нөхцөлд байгууллагууд шинэ зарчмын дагуу бий болж, хуучин нэг нь бага багаар шилжилт хийнэ. Энэ нь ямар ч нөхцөл байдалд төрийн захиргаа түгээмэл үр дүнтэй, уриалгахан байх бөгөөд стандарт бус чанартай байж болно гэдгийг тооцох хэрэгтэй юм.

Ийм төрийн захиргаа нь шийдвэр гаргах түвшинд улс төрийн засаглалтай улам ойртож, улс төрийн бодлого, шийдвэрийн стратегийг үндэсний бодит нөхцөл байдал, нийгмийн шахалт, шаардлагын хүрээнд нарийвчлан авч үзэж, мэргэжлийн техник үндэслэлийг гаргах ёстой болно. Ингэснээр төрийн захиргааны үйлчилгээний гол нь хувьцаа эзэмшигчид ба иргэдийн хэрэгцээг авч үзэхэд чиглэгдэх төдийгүй тэднийг зах зээлийн эрсдлээс хамгаалах ёстой аж. Зах зээлийн эрсдлээс хамгаалах гэдгийг өөрөөр хэлбэл, зах зээл дэх шударга бус өрсөлдөөн, хууль бус үйлдлүүдээс төрийн албан хаагчид иргэдийн жам ёсны эрхийг хамгаална гэсэн үг юм. Энэ бол төрийн албан хаагчид улс төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхээс гадна чөлөөт зах зээлийн хэт шунахайрал, хуйвалдаан, шударга бус өрсөлдөөн, монополичилолоос нийгмийг хамгаалах төрийн албан хаагчдын нэмэгдсэн хариуцлага юм.

⁹¹ Bottom-up Approach Document, p. 9.

1. Нэмэгдсэн хариуцлага нь захиргааны сонгодог механизмын хяналт, сүүлийн үеийн үр дүнтэй менежмент, хөндлөнгийн аудитийн холбоогоор амжилтанд хүрнэ.
2. Хариуцлага нь бүх бодлогын ил тод байдлын зохицол бөгөөд ялангуяа интернэтийн өргөн хэрэглээг оролцуулснаар амжилтанд хүрнэ.
3. Үр нөлөө нь хуулийн байгууллагуудын болон нийгмийн үнэлэмжийн уур амьсгалын сайн зохицлыг өсгөснөөр, мөн төрийн албан хаагчид төрийн үйлчилгээгээрээ итгэмжлэгдсэн бол амжилтанд хүрнэ.
4. Өргөн тархсан мэдээллийн технологийг үр дүнтэйгээр өсгөснөөр амжилтанд хүрнэ.

Үүний үр дүн бол бие даасан төрийн албан хаагчид зорилгууддаа хүрэх арга замаа мэргэшлийн үүднээс зөв сонгож чадсан бол, мөн үр дүнд хүрсэн гэж бахархдаг, шагнагддаг бол, төрийн албан хаагчдын ёс зүйн итгэл төлөвшиж, нийгэмд итгэгдэж, тэдний легитим бэхжинэ.

Төрийн захиргааны эдгээр зарчмуудыг доорх байдлаар жагсаавал:

Төрийн бүтэцтэй холбоотой зарчмууд:

1. Төр хууль ёсны төрийн үйлчилгээг шууд хангахдаа зөвхөн төрийн тусгай үйл ажиллагааг л хангана. Энд төрийн эрх мэдлийг ашиглан төрийн нөөцийг хянах, нийгэмд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх зэргийг хамааруулна.
2. Бусад нэмэлт үйл ажиллагааны үндэс нь нийгмийн нөхцөл байдлаас урган гарах зохицуулалт болон шинжлэх ухааны шинэ технологийг дэлгэрүүлэхэд чиглэгдсэнээр хуучин бүхнийг хамарсан үйлчилгээнээс ялгагдах ёстой.

Төрийн үйлчилгээтэй холбоотой зарчмууд:

1. Төрийн захиргаа нь мэргэжлийн өндөр түвшний төрийн албан хаагчид дээр суурилна. Төрийн алба нь ажиллагсадаа чадварынх нь дагуу элсүүлж, дэмжин, сайн цалинтай, төрийн ашиг сонирхлын дагуу бэлтгэсэн байх.
2. Төрийн албан хаагчид төрийн байгууллагын үр дүнтэй байдлын төлөө ажиллаж, орчин үеийн төрийн захиргааны сонгодог бюрократын зарчмыг ашиглан хуулийн засаглалыг хэрэгжүүлэх, үр дүнтэйгээр зардлыг бууруулж, орчин үеийн төрийн менежментийн туршлагын дагуу төрийн үйлчилгээг удирдан үйлчилгээний чанарыг өсгөх.

Менежментийн практиктай холбоотой зарчмууд:

1. Дэлхийд технологийн болон нийгмийн өөрчлөлт их хурдацтай байгаа тул төрийн албан хаагчид шийдвэр гаргахад илүү бие даасан байх ёстой болж байна. Энэ нөхцөлд нийгмийн хөгжлийн хурдтай нийцсэн оновчтой шийдвэр түргэн гарах боломж нэмэгдэнэ. Мөн агентлагуудын нийгмийн болон шинжлэх ухааны үйлчилгээ нь аутсорсчлогдчихсон, иргэний болон төрийн байгууллагын өмнө илүү хариуцлагатай байх ёстой болно.
2. Нэмэгдсэн хариуцлага нь захиргааны сонгодог механизмын хяналт, сүүлийн үеийн үр дүнтэй менежмент, хөндлөнгийн аудитийн холбоогоор амжилтанд хүрнэ.
3. Хариуцлага нь бүх бодлогын ил тод байдлын зохицол бөгөөд ялангуяа интернэтийн өргөн хэрэглээг оролцуулснаар амжилтанд хүрнэ.
4. Үр нөлөө нь хуулийн байгууллагуудын болон нийгмийн үнэлэмжийн уур амьсгалын сайн зохицлыг өсгөснөөр, мөн төрийн албан хаагчид төрийн үйлчилгээгээрээ итгэмжлэгдсэн бол амжилтанд хүрнэ.
5. Үр дүн нь бие даасан төрийн албан хаагчид зорилгууддаа хүрэх арга замаа сонгож чадсан бол үр дүнд хүрсэн гэж бахархдаг, шагнагддаг бол итгэгдэнэ.
6. Өргөн тархсан мэдээллийн технологийг үр дүнтэйгээр өсгөснөөр амжилтанд хүрнэ.

НОМ ЗҮЙ

1. United Nations' Economic and Social Council (2005) "Bottom-up Approaches and Methodologies to Develop Foundations and Principles of Public Administration: The Example of Criteria-Based Organizational Assessment"
2. Krygier M. State and bureaucracy in Europe: The growth of a concept // Bureaucracy: The career of a concept. L., 1979.
3. Ж.Штигилиц. Тогтвортой өсөлтөнд хүрэхийн тулд Зүүний үзлийг дага. Орч Д.Бадамдаш. 2009. <http://www.openforum.mn>
4. Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК
5. Д.Рондинули, Ш.Чийма. Төрийн захиргаа ба ардчилсан засаглал. ОрчН.Даваадулам. УБ., 2008. НҮБХХ.
6. Ч.Сосормаа. Төрийн захиргаанаас нийтийн захиргаа руу. УБ., 2008. БИТ Пресс ХХК

ОРЧИН ҮЕИЙН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

С.ЗУЛЬФИКАР

*Доктор, дэд профессор, Удирдлагын академи
Улс төр судлал, нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч*

Түлхүүр үг: улс төрийн нам, олон түмний нам, өргөн хүрээний нам, улс төрийн агрегаци

A political party is a group of people that is organized for the purpose of winning government power by election or other means. Political parties found in the vast majority of countries and in most political system. A variety of classifications have been used for political parties. The most important are the following: elite and cadre political parties; mass political parties; catch all parties etc. By the same time party system is classified as one party system, two party system and multi-party system.

Although political parties are defined by a central function (the filling of political office and wielding of government power), their impact on the political system is substantially broader and more complex. In the process of developing collective goals, parties also help to articulate and aggregate the various interests found in society. The fact that national parties invariably articulate the demands of a multitude of groups forces them to aggregate these interests by drawing them together into a coherent whole, balancing competing interests against each other. Final goal for political parties is defined by competing for the government or state power. Parties are the chief means by which political power is exercised in Mongolia.⁹²

Нам (party) гэсэн ойлголтыг ХҮШ зуунаас хэрэглэж эхэлсэн байдаг. Үүний зэрэгцээ нам гэсэн ойлголттой ойролцоо утгаар фракц “faction” гэсэн үг хэрэглэгдэж байжээ. Гагцхүү нам “party” болон фракци “faction” гэсэн үг яг ижил утга илэрхийлдэггүй. Фракц нь улс төрийн сэтгэлгээний түүхэнд удаан хэрэглэгдэж ирсэн нэр томъёо бөгөөд латины “facere (to do, to act- хийх, үйлдэх)” гэсэн үгнээс гаралтай юм. Хожим энэ үг латин хэлнээ “factio” хэмээн бичигдэх болж улс төрийн бүлгийн эмх журамгүй байдал, зохион байгуулалтыг сулруулах үйлдэл, нийгмийг хагаралд хүргэх гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ. Энэ үгний ерөнхий утга нь латин хэлээр бие даасан байх, сэхүүн зан, харгис, хэрцгий гэсэн утгыг илэрхийлдэг байна.

“Party” хэмээх үг нь латин гаралтай (pars) гэсэн үг бөгөөд хуваагдах, салах гэсэн утгатай. Тухайн үед ижил утга бүхий сект “sect” (латины secare- таслах, цавчих, хайчлах, хуваах “to sever, to cut, to divide”) гэсэн үг мөн дээрх утгаар хэрэглэгдэж байжээ. XVI зуунаас улс төрийн эсрэг үзэл санаатай хүчин бий болж, хэлбэрших үед буюу нэг хүний гарт засаглал төвлөрч түүний эсрэг эрх мэдэл бүхий бүлгүүд нэгдэн гарч ирсэнээр тэдгээр бүлгүүдийг тусгайлан нэрлэхийн тулд “party” гэдэг үг улс төрийн хэрэглээнд нэвтэрсэн байна. Харин сект “sect” гэсэн үгээр улс төрийн хүрэн дэх биш шашны тодорхой зан үйл бүхий бүлгийг нэрлэх болжээ. Фракц гэсэн ойлголт нь улс төрийн үйл явцад одоо ч амь бөхтэй байгаа бөгөөд улс төрийн нам доторх тодорхой сонирхлын бүлгийг тодорхойлох нэршил⁹³ болсон байна.

Нам судлаач Ж.Сартори улс төрийн намыг “Улс төрийн үзэл санаа, үзэл баримтлал, сонирхлоороо нэгдсэн хүмүүсийн бүлэг”⁹⁴ гэж тодорхойлсон байна. Монгол улсын Улс төрийн намын тухай хуульд үүнтэй ижил агуулгаар намыг тодорхойлжээ. Тухайлбал, Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 1-т “Нам нь Монгол улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол улсын иргэдийн нэгдэл мөн” гэжээ. Р.Михельс “Улс төрийн байгууллага болох нам нь засгийн эрх мэдэл рүү тэмүүлдэг” гэсэн байна.⁹⁵ Францын улс төрийн философич Реймон Арон “Ардчилал ба тоталитаризм” хэмээх сонгодог бүтээлдээ “... намуудын зорилго бол засаглалыг хэрэгжүүлэх биш, харин засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох явдал юм” гэжээ.⁹⁶ Ямартай ч улс төрийн нам нь ардчилсан тогтолцооны онцгой субъект болох нь эндээс тодорхой байна.

⁹²Тодорхой үзэл санаа, хүсэл, ашиг сонирхол болон бүлэг хүмүүсийн нэгдэл. Улс төрийн үйл явцад хүмүүс тодорхой ашиг сонирхлын хүрээнд нэгдэх, нийлэх бусдаас ялгарах үзэгдэл.

⁹³ Онолын судалгаанд тулгуурлан зохиогчийн дэвшүүлсэн дүгнэлт болно.

⁹⁴ G.Sartori. Parties and Party System. London, 1976. p. 23

⁹⁵ R.Michels. Political parties; A sociological study of the oligarchical tendencies of modern democracy. Glencoe, Illinois., 1958. p. 382

⁹⁶ Даш-Ёндон Б(ред), Монголын нийгмийн өөрчлөлт. Шинжлэх Ухааны Академи, Философи Социологи Эрхийн Хүрээлэн, УБ., 2008, 278 дахь тал

Орчин үеийн хэв шинж бүхий улс төрийн нам анхлан Европт үүссэн гэж үздэг. Учир нь Европт нам үүсэх үйл явц хөрөнгөтний ардчилсан хувьсгал, нийгэм дэх сонирхлын ялгарал, заагшралын үйл явц цаашлаад ардчиллын үр дүн болох парламентад ёс, бүх нийтийн сонгуулийн эрхтэй холбоотой байв. Төрийн эрх мэдлийн легитимт шинжийг баталгаажуулдаг ардчилсан тогтолцоо төлөвшихийн хэрээр улс төрийн бодлогод олон түмнийг өргөнөөр татан оролцуулах суваг нь нам байж, засгийн эрх авсан нам бодлогоо нийгэмд хэрэгжүүлэх боломжтой болсон нь намуудын нийгэмд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, түүнийг улс төрийн бодлогын гол субъект болгоход хүргэжээ.⁹⁷

Гэхдээ улс төрийн намыг нийгэм тэр бүр эерэгээр хүлээн авч байгаагүй. АНУ-ын анхны ерөнхийлөгч Жорж Вашингтон “Нам бол нийгмийн эв нэгдлийг эвдэн, сөрөг үр дагавар дагуулж болзошгүй бүлэглэл” гэж тодорхойлж байв. Хэдий тийм боловч нам нь ардчилсан улс төрийн тогтолцооны цаашлаад засаглалын салшгүй хэсэг болж чадсан. Тэр битгий хэл улс төрийн үйл явцыг тодорхойлогч болж, нам болон намын тогтолцоо судлал нь харьцуулсан улс төр судлалын салбар судлал болголоо хөгжөөд байна.

Орчин үеийн улс төрийн тогтолцоонд улс төрийн намуудын үүргийг тодорхой хүрээнд хязгаарлаж болох хэдий ч зарим тохиолдолд нийгмийн харилцааны бүхий л хүрээнд улс төрийн намын оролцоотой хэрэгжсэн үйл ажиллагаа, түүний шууд үр дүн, үр дагавар гардаг. Иймд судлаачид улс төрийн намыг ашиг сонирхлын агергацийг хэрэгжүүлэх суваг гэдэгтэй санал нэгддэг. Улс төрийн тогтолцооны тухай онолын гол төлөөлөгч Давид Истон улс төрийн үйл явцад талуудын ашиг сонирхлыг нэгтгэн, системчлэх үүргийг улс төрийн нам хэрэгжүүлж байгааг шинжилж, тодорхойлсон. Үүний зэрэгцээ ардчиллыг өргөжүүлэх, төрийн үйл ажиллагаанд иргэд, сонгогчдын төлөөллийг хангах үүргийг улс төрийн зохион байгуулалтаар дамжуулан хэрэгжүүлдэг нь улс төрийн практик нэгэнт хүлээн зөвшөөрөгдөөд байна. Цаашлаад улс төрийн манлайлагчдыг бэлтгэх, хөгжүүлэх үүргийг нам хэрэгжүүлнэ. Өнөө цагт улс орны бодлогыг тодорхойлж, хүмүүсийг араасаа дагуулах авьяас чадвартай манлайлагчид (удирдагчид) улс төрийн нам дотор бэлтгэгдэж, сонгогдож, шилэгддэг улс төрийн соёл төлөвшиж байна.

Улс төрийн намуудыг зохион байгуулалтын бүлэг, үзэл санааны бүлэг, нийгмийн бүлэг гэж үзэж болно. Нөгөө талаар улс төрийн зорилго, түүнийг хэрэгжүүлэх тодорхой чиг үүрэг бүхий бүлэг ч гэж үзэх нь бий.⁹⁸ Иймд улс төрийн намуудыг түүхэн, зохион байгуулалт (намын байгуулалт), чиг үүргийн хувьд ангилах, бүлэглэх боломжтой юм. Судлаачид олон талт ангиллыг санал болгосон байх хэдий ч намуудыг нийтлэг шинж чанараар нь дараах гурван бүлэг болгон ангилсан байна.

Эхнийх нь элит нам (*elite political party*) юм. Намын бодлого, үйл ажиллагааг намын элитүүд хөтөлж, чиглүүлдэг, үзэл суртал нь тодорхой бус, нийгмийн дээд хэсэгт суурилдаг, гишүүнчлэл нь итгэл үнэмшил гэхээсээ элит дагасан шинжтэй байдаг.⁹⁹ Улс төрийн аливаа сонирхол нийгмийн элит хэсгийн дунд илүү илэрдэг бөгөөд энэ нь яваандаа улс төрийн нам болон зохион байгуулагдах үндэс болжээ. Европын улс төрийн намуудын эх үндсийг язгууртан, хөрөнгөтөн ангийн төлөөлөл тавьсан байх бөгөөд намууд нь элит намын хэв шинжийг түлхүү илэрхийлдэг байв.

Нийгмийн бүлгийн ялгарал, давхраажилт хүчтэй явагдахын хэрээр нийгмийн тодорхой хэсгийн ашиг сонирхлыг илэрхийлсэн, улс төрийн намууд бий болсон. Үүнийг олон түмний нам (*mass political party*) гэж нэрлэсэн байна. Нөгөө талаар бүх нийтийн сонгуулийн эрх нь олон түмний нам өргөжих хүчин зүйл болсон. XX зууны эхэн үеийн Европын намууд олон түмний намын хэв шинжийг илэрхийлдэг.

XX зууны хоёрдугаар хагаст олон намын тогтолцоо, түүнтэй уялдсан сонгуулийн тогтолцоо төлөвшиж, улмаар улс төрийн нөхцөл байдалд нийцүүлэн хүн амын бүхий л хэсгийн дэмжлэгийг авах шаардлага улс төрийн намуудад тавигдсан. Учир нь нийгмийн тодорхой нэг хэсэг бүлгийн ашиг сонирхолд тулгуурласан улс төрийн намууд засгийн эрхийг авах боломж зарим талаар хязгаарлагдах болжээ. Нөгөө талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, харилцааны шинэ дэвшилтэт технологи нь улс төрийн намын лидерүүдэд нийгмийн бүхий л хүрээнд хүрч ажиллах бололцоо олгож, нам-олон нийтийн харилцааг хялбаршуулсан. Отто Крихаммер үүнийг өргөн хүрээний¹⁰⁰ (бүхнийг шүүрэгч гэж ч орчуулж болох) нам (*catch all party*) гэж үзсэн. Энэ төрлийн нам нь нийгмийн тодорхой бүлгийг төлөөлөх бус үндэсний эрх ашиг, сонирхлыг бүхэлд нь удирдлага болгох учиртай.¹⁰¹

Эдгээрийн зэрэгцээ зохион байгуулалт, сонгуульд оролцож байгаа технологи, засгийн эрх барих үйл явцад оролцох хэлбэрийн шалгуур болгон намуудыг сонгогчдын таашаалд нийцэх зорилготой (*client*), *хөтөлбөрийг гол болгосон (programist)*, засгийн эрхийг хамтран барих замаар улс төрийн зорилгоо гүйцэлдүүлэх картел (*cartel*) нам гэж бүлэглэж болно. Гэхдээ эдгээрийн аль альны шинж чанарыг өөртөө шингээсэн улс төрийн намууд ч байна. Тухайлбал, олон түмний нам нь сонгуулийн хөтөлбөрөөр дамжуулан олон нийтийн дэмжлэг авах зорилт тавих нь бий.

Дээрх ангилалуудын зэрэгцээ улс төрийн намуудыг хэв шинжээр нь “*Эх газрын болон Америкийн*” загвар гэж ангилдаг. Эх газрын загварт улс төрийн нам дээрээс доош чиглэсэн хатуу тогтсон бүтэц, зохион байгуулалттай байж, гишүүнчлэлд тусгайлан ач холбогдол өгдөг. Эх газрын загварт баруун, зүүн Европ,

⁹⁷ Мөнхбат С, Монгол дахь улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын төлөвшилтийн асуудал. Доктор PhD-ын зэрэг горилсон диссертаци, УБ., 2009. 34 дэх тал

⁹⁸ Giovanni Sartori. Party Types, Organization and Functions. West European Politics Journal, September. 2010. p.5

⁹⁹ Довчин Ё (ред), Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2010, 328 дахь тал

¹⁰⁰ МУИС-ын Улс төр судлалын тэнхимийн багш нар өргөн хүрээний нам нэгж орчуулж, томъёолсон байна.

¹⁰¹ Довчин. Ё (ред). Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2010. 329 дэх тал.

төв Ази, Ойрхи Дорнодын улс төрийн намуудыг хамааруулж болно. Харин Америкийн загварт улс төрийн намуудад гишүүнчлэл чухал биш боловч лидерүүдээр дамжсан үндэсний болон орон нутгийн түвшний зохион байгуулалт бий болсон байдаг. Өөрөөр хэлбэл тодорхой лидерүүд тухайн орон нутагт намын үзэл санаа, үнэт зүйлийг олон нийтэд ойлгуулах, тэднийг араасаа дагуулах хэлбэрийн чөлөөт зохион байгуулалт төлөвшсөн байна.

Францын улс төр судлаач М.Дюверже намуудыг зохион байгуулалт, үйл ажиллагааны хэв шинжээс нь гадна сонгуулийн тогтолцооны үр дүнд улс төрийн хэдэн нам голлох, тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байгааг шалгуур болгон улс төрийн намын тогтолцоог тодорхойлсон.¹⁰² Үүнийг Дювержегийн хууль гэж нэрлэдэг. Мажоритар сонгуулийн тогтолцоо нь хоёр намын тогтолцоо төлөвших нөхцөл болдог бол хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцоо (халимогч байж болно) нь олон намын тогтолцоо төлөвших нөхцөл болдог гэж үзсэн байна. Энэ хууль олон талаар батлагддаг. Тухайлбал, Их Британи мажоритар сонгуулийн тогтолцоог хэрэглэдэг бөгөөд дэлхийн II дайнаас хойш үндсэндээ улс төрийн хоёр нам голлох үүрэгтэй байж, сонгуульд ээлжлэн ялалт байгуулж ирсэн. Харин Итали, Израйл зэрэг улсууд хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцоотой учраас сонгуулийн үр дүн байнга эвслийн засгийн газар байгуулах нөхцөл болдог байна. Үндсэндээ олон намын тогтолцоо бүрэлдсэн байна.

Одоо улс төрийн намууд хэрхэн төлөвшиж, хөгжиж байгааг авч үзье. Баруун Европын улс төрийн намууд уламжлалт хэв шинж алдагдаж байна гэж судлаачид үзэх болжээ. Учир нь намуудан ганц тодорхой бүлгийн ашиг сонирхол, зарим тохиолдолд зөвхөн язгууртан, элитүүдийн хүсэл сонирхлын үр дүнд бий болж, түүнтэй уялдсан улс төрийн манлайлал хэрэгжүүлдэг байсан зохион байгуулалт, чиг үүрэгт зарчмын өөрчлөлт бий болсон. Гэхдээ улс төрийн намд элитүүд зарим тохиолдолд лидерүүд гэж үздэг хэсгийн манлайлал ач холбогдолтой хэвээр байна. Гагцхүү тэд өөрсдийн сонирхлыг олон нийтийн сонирхолтой зайлшгүй уялдуулах шаардлагатай болжээ. Нөгөө талаар дан ганц нийгмийн тодорхой анги, нийтлэг бүлгийн ашиг сонирхлыг төлөөлөх бус нийгмийг бүхэлд нь хамарсан улс төрийн бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх хандлага давамгайлж байна. Ньюман үүнийг *“Ардчилалтай интеграцчилагдах”* үйл явц гэж тодорхойлжээ. Улс төрийн намууд баруун Европын улс төрийн үйл явцад нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрөгдөж, төлөвшсөн улс төрийн үйл явцтай интеграцчилагдаж чадсан нөхцөлд оршин тогтнох боломжтой болж байгаа юм. Иймд өргөн хүрээний намын хэв шинж улс төрийн намуудын үзэл баримтлал, зохион байгуулалт, үйл ажиллагаанд эрчтэй нэвтэрч байгаа юм.

Өргөн хүрээний нам хөгжих нөхцөл баруун Европ цаашлаад бусад улс оронд аяндаа төлөвшсөн үзэгдэл бишээ. Харин үүний эсрэгээр дараах хоёр хүчин зүйл онцгой үүрэгтэй байсан гэж ойлгож болно. Үүнд: 1) Улс төрийн намууд сонгуульд ялалт байгуулж, засгийн эрхийг авах, нэг бол засгийн эрх барихад идэвхтэй оролцох сонирхол нь улс төрийн намууд олон нийтэд нээлттэй нам болоход түлхэц өгсөн. 2) Сонгогчид мөн адил өөрсдийгөө ямар нэг улс төрийн үзэл санаа, үзэл баримтлалын салшгүй хэсэг гэж абсолют (туйлын) байдлаар ойлгохоос татгалзаж, иргэд, өөрийнх нь ашиг сонирхол, ямар ч нөхцөлд, ямар ч улс төрийн намаар дамжиж хэрэгжих бололцоотой гэж ойлгох болсон явдал юм. Нөгөө талаар өргөн хүрээний нам заавал олон гишүүн, дэмжигчтэй байна гэж хэт өрөөсгөл ойлгож болохгүй. Учир нь гишүүнчлэлд онцгойлон ач холбогдол өгдөг олон түмний намаас олон нийтийн дэмжлэг авахыг зорилго болгосон өргөн хүрээний нам алгаатай юм.

Тухайн улс төрийн намын үзэл санаа, үзэл баримтлал нь нийгмийн бүхий л хүрээг (ядахдаа дийлэнх хэсгийг) хамарсан шинжтэй бол өргөн хүрээний нам гэж ойлгож болох талтай. Гэхдээ мэдээж хөрөнгөтний эсвэл пролетарийн нам өргөн хүрээний нам болж чадахгүй нь улс төрийн үзэл баримтлалаас нь тодорхой ойлгогдоно.¹⁰³ Эдгээр нам нь олон түмний нам болохыг өмнө тэмдэглэсэн билээ. Хэрэв зэ гишүүд, дэмжигчдийн хүрээг шалгуур болгох аваас АНУ-ын Бүгд Найрамдах нам олон түмний намын хэв шинжийг илэрхийлэхгүй. Учир нь уг намд гишүүнчлэл чухал биш. Харин үүний эсрэгээр өргөн хүрээний шинжтэй кадрын нам гэж ойлгож болох талтай. Гэтэл Английн хөдөлмөрийн нам олон түмний намын шинжийг илэрхийлнэ. Учир нь үйлдвэрчний эвлэлийн гишүүд бараг автоматаар тус намын гишүүнчлэлтэй байдаг. Гэхдээ сүүлийн жилүүдэд дан ганц ажилчин ангийг бус нийгмийн бүхий л хүрээг хамарсан үйлдвэрчний байгууллагаар дамжуулан гишүүд, дэмжигчдийн хүрээгээ тэлэх бодлого барьж байна. Иймд Английн Хөдөлмөрийн нам өргөн хүрээний нам болох чиг хандлага баримталж байна.

Баруун Европын намуудад бий болж байгаа өөрчлөлт, төлөвшил нь рационал хандлага, шинжлэх ухаан, мэдлэг боловсрол, технологийг намын байгуулалтын түвшинд болон улс төрийн үйл ажиллагаанд түлхүү нэвтрүүлэх хандлагыг илтгэх болжээ. Учир нь улс төрийн нам олон нийтийн хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээг агрегацчилах чадавхтай, түүнийг хэрэгжүүлэх мэдлэг, боловсрол, туршлага, зохион байгуулалт, хүний нөөцтэй байх шаардлага тавигдаж байгаа юм. Иймд баруун Европын намууд намын байгуулалтыг чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлэхийг чухалчилж байна. Ингэснээр нам рационал улс төрийн бодлого тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх бодит бололцоо хангагдана гэж үзэх болжээ.

Скандинавын улс төр судлаачид К.Еласин, Л.Свэйсэнд нар улс төрийн намыг өвөрмөц байр сууринаас авч үзсэн байдаг. Тэд нам бол газар нутгийн нэгдэл, газар нутгийн тархалтаар үүссэн зохион байгуулалт гэж үздэг. Газар нутгийн нэгдэл нь тодорхой ашиг сонирхол, зорилго бүхий бүлэгт суурилан намын бүтэц, зохион байгуулалтын үндсийг тавьж, улмаар орон нутагт мөнхүү төвөөс хамааралтай бүтэц зохион байгуулалт тогтож, үндэсний түвшинд институцчилагдсан улс төрийн нам бий болдог байна.

¹⁰² Joseph A. Schlesinger, Mildred S. Schlesinger. Maurice Duverger and the Study of Politics. French Politics. 2006. No 4. p.59

¹⁰³ Maurice Duverger, “Factors in a Two-Party and Multiparty System,” in *Party Politics and Pressure Groups* (New York: Thomas Y. Crowell, 1972), p.23

Финлянд, Швед, Норвегийн улс төрийн намын хөгжил, төлөвшлийг баруун Европтой адилтгаж болохоор байдаг. 1970-аад оны сүүл хүртэл намуудад манлайлал, хатуу гишүүнчлэл онцгой ач холбогдолтой байсан. Скандинавын намуудын хатуу гишүүнчлэл, үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан шатлан захирах бүтэц нь тэднийг баруун Европын улс төрийн намтай шууд адилтгаж байв. Намын төв аппарат, орон нутаг дахь салбар, удирдах зөвлөл гэсэн зохион байгуулалт тогтсон байх бөгөөд орон нутагтай холбоотой шийдвэрийг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа нэгжүүд, үндэсний түвшний бодлого шийдвэрийг намын төв аппарат, удирдах дээд байгууллага болох хурал гаргадаг байна. Аж үйлдвэржилт, хотжилт эрчимжиж, нийгмийг хамарсан томоохон өөрчлөлт бий болохын хэрээр улс төрийн намуудын зохион байгуулалт, үүрэг өөрчлөгдсөн. Скандинавын улс төрийн намууд 90-ээд оны сүүлээс өргөн хүрээний намын зохион байгуулалт, үйл ажиллагааны хэв шинжийг эрэлхийлэх болжээ. Нийгэм, эдийн засгийн байдал сайжирч хүн амын амьдралын чанарын түвшин дээшилж, нийгмийн шинэ бүлгүүд бий болж, иргэдийн хүсэл сонирхол олон талтай болсон бөгөөд улс төрийн намууд мөн адил үүнтэй уялдсан уян хатан үнэт зүйл, хөтөлбөр санал болгож, зохион байгуулалт сонгож, үйл ажиллагаа явуулах шаардлага тавигдсан.

Скандинавын намууд нийгмийн бүлэг, иргэний нийгмийн сонирхлыг өөртөө нэгтгэхийг эрмэлзэх болжээ.¹⁰⁴ Сонирхлын бүлгүүд улс төрийн үйл явцад шахалт үзүүлэх хандлага улс төрийн практикт нэвтэрч, намууд үүнийг ухаалгаар ашиглаж байна. Улс төрийн намуудын дэргэд залуучууд, эмэгтэйчүүд, ахмадууд, мэргэжлийн гэх мэт сонирхлын бүлэгт тулгуурласан иргэний нийгмийн байгууллага зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байна. Намуудын үзэл санаа, үзэл баримтлалын ялгаа багасч харин үүний эсрэгээр иргэний нийгмийн сонирхлыг нэгтгэсэн, түүнд чиглэсэн хөтөлбөрийг шалгуур болгосон үнэт зүйл, зохион байгуулалт, үйл ажиллагааны өөрчлөлт явагдаж байна.

90-ээд оны эхэнд коммунист дэглэм нуран унасны дараа ЗХУ, зүүн Европын социалист орнууд олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрч улмаар шинэ болон хуучин улс төрийн хүчнүүдийн хооронд улс төрийн өрсөлдөөн бүхий орчин бий болсон. Хуучин коммунист нам(пост-коммунист)-ууд нэг бол үзэл баримтлал, нэрээ өөрчлөх, эсхүл намаа бүхэлд нь татан буулгах, дахин шинээр байгуулах сорилттой тулгарсан. Улс төр судлаач Жон Ишияма пост-коммунист 16 улс төрийн намын улс төрийн амьдрал дахь мөчлөг, оролцоог өвөрмөц байдлаар судалсан үр дүнг доор хураангуйлан сийрүүлэе.

Ардчилсан шилжилтийн жилүүдэд пост-коммунист намууд засгийн эрх мэдлээ алдах үзэгдэл шилжилтийн улсуудад давхцсан байна. Харин сонгуулийн нэг мөчлөг өнгөрсний дараа пост-коммунист буюу тэдний суурин дээр шинээр болон шинэчлэгдэн байгуулагдсан намууд улс төрийн үйл явцад идэвхтэй, амжилттай оролцож байв. Улс төр судлаачидүүнийг дараах хүчин зүйлтэй холбож тайлбарласан байна. Шилжилтийн явцад бий болсон нийгэм-эдийн засгийн хүндрэл нь иргэд хуучин дэглэмийн давуу талыг санагалзах (nostalgia) уур амьсгал бий болгосон. Нөгөө талаар эдгээр намууд нь үндэсний түвшинд зохион байгуулагдсан бүтэцтэй байсан. Хамгийн гол нь намын байгуулалтын чадавх, хүн хүч, хөрөнгө санхүүгийн хувьд давуу талтай байсан явдал юм. Үүний зэрэгцээ пост-коммунист намтай өрсөлдөхүйц зүүний чиг баримжаатай нам байхгүй байсан нь дэмжих хүчин зүйл болсон. Жон Ишияма пост-коммунист 16 улс төрийн намын зохион байгуулалт болон сонгуульд амжилттай оролцсон түвшний хамаарлыг персоны кореляцаар тооцож үзэхэд 0.76 буюу хүчтэй хамааралтай болох нь тогтоогдсон.¹⁰⁵

Эдгээр намууд нь социалист системтэй байх үед төрийн тогтолцооны цөм болж байсны дээр элитийн болон кадрын намын шинжтэй олон түмний намын хэв шинжийг түлхүү илэрхийлж байв. *Сүүлийн жилүүдэд пост-коммунист намууд улс төрийн үйл явцад идэвхтэй, үр дүнтэй оролцох зорилгоор нийгмийн оюунлаг хэсэг, дундаж давхрааны төлөөллийг үйл ажиллагаандаа шууд татан оролцуулж байна.* Учир нь нийгмийн дундаж давхраагулс төрийн рационал шийдвэр гаргах эх сурвалж, чадавх гэж үзсэн байна. Энэ нь улс төрийн хүчний хувьд тодорхой амжилт үзүүлэх хүчин зүйл болсон.

Улс төрийн шилжилтээс хойш пост-коммунист улсуудад ардчилсан, либерал, үндэсний үзэлтэй намууд шинээр байгуулагдаж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Хачирхалтай нь эдгээр намууд ч мөн адил олон түмний намын зохион байгуулалтыг сонгосон. Шинээр бий болсон намуудын тухайд гишүүнчлэл ач холбогдолоо бүрэн алдаагүй байна. Үүнийг урт хугацаанд хэвшин тогтсон хатуу гишүүнчлэлтэй болон кадрын намын соёлтой холбон ойлгож болох талтай. Нөгөө талаар шинээр байгуулагдсан улс төрийн намуудын тухайд загвар, туршлага болгох ойрын болоод тодорхой жишээ нь пост-коммунист намууд байсан юм.

Монгол улсад дээд шүүхэд бүртгэлтэй 22¹⁰⁶ улс төрийн нам байна. 2012 оны 10 сарын 23-ны өдөр 22 дахь улс төрийн нам (Монголын Консерватив Нам)-ыг Улсын Дээд Шүүх бүртгэжээ. Пост-коммунист орнуудад өрнөсөн улс төрийн үйл явцын нэгэн адил Монголд олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрснөөр барууны болон зүүний чиг баримжаатай улс төрийн хүчнүүд шинээр бий болсон. Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, улс төрийн олон ургальч үзлийн үндсийг тавьж, нийгмийн харилцаанд төлөвшүүлэхэд улс төрийн намуудын үүрэг зайлшгүй байсан гэдэгтэй улс төр судлаачид санал нэгддэг.

Манай улс төрийн намуудыг зохион байгуулалтын хэв шинжээр нь эх газрын улс төрийн намын загварт багтааж болно. Үүний зэрэгцээ гол хоёр улс төрийн нам хатуу бүтэц, үндэсний түвшинд зохион байгуулагдсан олон түмний намын хэв шинжийг илэрхийлдэг. Гэхдээ МАН, АН-ыг эс тооцвол олон түмний намын хэв шинжтэй, гишүүнчлэлд тухайлан ач холбогдол өгч, үндэсний түвшинд зохион байгуулагдаж, үйл

¹⁰⁴ Richard S.Katz, Peter Mair. How Parties Organize: Change and Adaptation in Party Organizations In Western Democracies. p. 167

¹⁰⁵ John Ishiyama. Party Organization and the Political Success of Communist Successor Parties. p.15

¹⁰⁶ Улсын Дээд Шүүхийн цахим хуудас (www.supremecourt.mn)-д тавигдсан албан ёсны мэдээллийг эш үндэс болгов.

ажиллагаа явуулж байгаа нам хараахан алга. Үүнийг улс төрийн намуудын хөрөнгө санхүү, хүний нөөцийн чадавхтай холбож ойлгох нь зүйтэй болов уу. Нөгөө талаар МАН, АН-ыг “кадрын”, “олон түмний”, “өргөн хүрээний” намын зарим хэв шинжийг агуулсан нам гэж үзэж болох юм. Учир нь энэ хоёр нам гишүүнчлэлд ач холбогдол өгөхийн зэрэгцээ нийгмийн бүхий л хүрээний дэмжлэгийг өөртөө тагах мөрийн хөтөлбөр, үндэсний болон орон нутгийн түвшний зохион байгуулалт, хүний нөөц зэрэгшинж чанарыг хадгалж байна. Харин бусад намууд нь эрх зүйн хувьд нам байх шалгуурыг хангасан сонирхлын картел, кардын, хөтөлбөрт суурилсан, клейнт төвтэй намуудын хэв шинжийг илтгэдэг. Манай ихэнх улстөр судлаачид “Ардчиллын замаар хөгжиж буй улстай харьцуулахад улс төрийн хоёр голлох намын хүчтэй нөлөөлөл бүхий намын систем тогтож байгаа нь Монголын онцлог болж байна”¹⁰⁷ гэж үздэг.

2008 он хүртэл УИХ-ын сонгууль мажоритар тогтолцоогоор явагдсан нь хоёр нам давамгайлсан улс төрийн намын тогтолцоо төлөвших нөхцөл болсон. Өөрөөр хэлбэл үндэсний түвшинд зохион байгуулагдан сонгуульд оролцох чадавхтай хоёр нам бий болсон юм. Сонгуулийн үр дүнд мөн адил үүнийг баталж байна. Харин 2012 оны сонгуулийг холимог хэлбэрээр явуулсан нь УИХ-д улс төрийн гурав дахь хүчин өргөн төлөөлөлтэй болох нөхцөл болсон. Гэхдээ 2012 оны хавар өрнөсөн улс төрийн үйл явц улс төрийн гурав дахь нам улс төрд хүчтэй орж ирэхэд нөлөөлөх хүчин зүйл болсон байх ч талтай. Үүнийг цаашид өрнөх улс төрийн үйл явцад нарийн шинжилгээ хийсний үндсэн дээр тодорхойлох боломжтой.

Монголын улс төрийн гол хоёр нам хатуу гишүүнчлэлтэй, төрийн бус (сонирхлын бүлгүүд)-ийг өөртөө нэгтгэх, дэргэдээ байгуулах зохион байгуулалт хэрэгжүүлж байгаа нь тэднийг Скандинавын олон түмний намын хөгжлийн хэв шинжтэй адилтгаж болохоор болгож байна. Үүний зэрэгцээ улс төрийн гол намуудад газар нутгийн тархалтын хэв шинж ажиглагдаж байна. Тухайлбал, улс төрийн намын тухай хуульд намуудын үйл ажиллагааны зарчмыг тодорхойлохдоо “Нам үйл ажиллагаагаа нутаг дэвсгэрийн зарчмаар явуулна”, 13.6-т “нам энэ хуульд нийцүүлэн өөрийн онцлогт тохирсон зохион байгуулалтын бүтцийг төв, орон нутгийн түвшинд байгуулан ажиллуулна” гэж газар нутгийн тархалтыг шалгуур болгох зохион байгуулалтыг хатуу зааж өгчээ.

Нөгөө талаар 2008 оноос хойш явагдсан сонгуулийн үйл явц, түүний үр дүнд байгуулагдсан засгийн газрын хэв шинж улс төрийн намуудын өвөрмөц харилцааг дэлгэн тавьсан. Улс төрийн намууд нийгмийн бүхий л хүрээнд хүрч, тэдний дэмжлэгийг өөртөө татахыг зорилго болгож байсан нь намууд өргөн хүрээний намын хэв шинжтэй болж байгааг харуулж байна. Үүгээр зогсохгүй өргөн хүрээний, хөтөлбөрт суурилсан, сонгогчдод үйлчлэх (client) намын хэв шинж зарим тохиолдолд ажиглагдаж байв.

2008 онд улс төрийн гол хоёр хүчин сонгуулийн үр дүнгээс үл хамааран эвслийн засгийн газар байгуулсан. Энэ байдал нь бодлогоор нэгдэх картел намын шинжийг илэрхийлж байв. Гагцхүү түүнээс хойш өрнөсөн улс төрийн үйл явц нь намууд бодлогын картел бус ашиг сонирхлын картел үүсгэж байсан болов уу гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Учир нь бодлогын картелд улс төрийн намууд засгийн газрыг аль болох тогтвортой байлгахыг эрмэлздэг бол ашиг сонирхлын картелд улс төрийн хүчнүүд өөрт ашигтай улс төрийн нөхцөл байдал үүсэхэд эвслээс шууд гардаг. 2012 оны сонгуулийн өмнө ардчилсан нам эвслийн засгийн газраас гарсан үйлдэл нь үүний нэр илрэл болов уу.

Монголд сонгуулийн өмнөх жил, нэг бол сонгуулийн үр дүнгээс шалтгаалан шинээр нам байгуулах практик түгээмэл ажиглагдаж байна. Сонгуулийн өмнө шинээр байгуулагдаж байгаа намууд гол төлөв тодорхой элитүүдийг дагасан, нэг бол тэдний байгуулсан намууд байдаг тул элит намын хэв шинж улс төрийн гурав дахь хүчний дунд ажиглагдаж байна. Тухайн элит (лидер) улс төрийн үйл явцад идэвхтэй оролцохоо больсон нөхцөлд нам нь улс төрийн хувьд ач холбогдолгүй болох хандлага ажиглагддаг. Үүнийг гол нь улс төрийн намууд бүрэн төлөвшиж чадахгүй байгаатай холбож үзэх нь зүйтэй.

“Улс төрийн намууд өнөө хэр сайтар төлөвшин цэгцэрч амжаагүй, үүнээс болж намуудыг үнэлэх олон түмний үнэлэмж буурч, намууд ч засаглалын харилцаанд хууль ёсны байр сууриа бүрэн олж авч чадахгүй байгаа нь намын системийн төлөвшлийн үйл явцад тодорхой байдлаар нөлөөлж байна”¹⁰⁸ гэж манай нам судлаачид үзжээ. Иймд манай улс төрийн намууд үзэл санаа, хүний нөөц, үйл ажиллагааны чадавхаа дээшлүүлж, олон нийтийн дэмжлэгийг бодлого, хөтөлбөр үйл ажиллагаагаараа дамжуулан татаж чаддаг байх нь улс төрийн нам төдийгүй улс төрийн үйл ажиллагааны төлөвшилтэд онцгой ач холбогдолтой байхаар байна.

Ямартай ч тус өгүүлэлд хэлэлцэгдэж байгаа орнуудын улс төрийн намуудын хөгжлийн хандлагын нэг яах аргагүй улс төрийн агрегаци хийх технологи юм. Үүнийг бодлого, үйл ажиллагааны зохион байгуулалтын орчил гэж ойлгож болно. Эх газрын хэв шинж бүхий намуудад бодлого, шийдвэр дээрээс гарч дунд болон анхан шатны нэгжүүдэд хүрч улмаар олон нийтэд түгдэг зохион байгуулалт тогтсон. Харин улс төрийн намууд өргөн хүрээний хэв шинжтэйболсноор бодлого доороос гарч дээшчих зохион байгуулалт нэвтэрч байна. Учир нь улс төрийн сонгуульд амжилттай оролцох үндэс нь яах аргагүй олон нийт хүсэн хүлээсэн бодлого, стратеги тодорхойлох явдал юм.

Гэхдээ энэ нь улс төрийн агрегаци хийх чадавхийг нэмэгдүүлэх бодит хэрэгцээг аяндаа төрүүлнэ. Зарим талаар улс төрийн намууд мэргэшсэн (professional party) байхын тулд судлаачид, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компаниудын дэмжлэгийг авах хандлага түгээмэл болжээ. Нийгэм, эдийн засгийн бодлого тодорхойлж,

¹⁰⁷ Даш-Ёндон Б (ред), Монголын нийгмийн өөрчлөлт. Шинжлэх Ухааны Академи, Философи Социологи Эрхийн Хүрээлэн, УБ., 2008, 269 дэх тал

¹⁰⁸ Даш-Ёндон Б (ред), Монголын нийгмийн өөрчлөлт. Шинжлэх Ухааны Академи, Философи Социологи Эрхийн Хүрээлэн, УБ., 2008, 269 дэх тал

боловсруулах, олон нийтийн санал бодол, хүсэл сонирхлыг агрегаци хийхийн тулд улс төрийн намууд мэргэшсэн бүтэц, хүний нөөцийн чадавхтай байх эсвэл бэлэн нөөцийг ашиглах шаардлага тавигдаж байгаа юм. Улс төрийн намууд дэргэдээ тинк танк ажиллуулах (заавал улс төрийн намын гишүүн байх шаардлагагүй) замаар мэргэшсэн улс төрийн хүчин байх сорилтыг даван туулж байна.

Улс төрийн үйл явцад намуудын ач холбогдол буурч байна гэж үздэг судлаачид их байдаг. Гэтэл бодит байдал дээр улс төрийн намын үүрэг, ач холбогдол өргөжиж байгааг олон судлаач тэмдэглэж байна. Улс төрийн намууд үйл ажиллагаагаа өргөжүүлэх шаардлага ч тавигдаж байна. Учир нь нийгмийн сонирхлыг агрегаци хийхийн тулд мэргэшсэн чадварлаг бүтэц, хүний нөөц шаардлагатай болж байгаа юм. Энэ бүтэц нь зарим тохиолдолд байнгын байдаг бол зарим тохиолдолд түр зуурын, тодорхой зорилтыг хангах шинжтэй байна. Иймд намын улс төрийн ажилтнуудын тоог нэмэгдүүлэх, тэдний мэдлэг чадвар, туршлагыг дээшлүүлэх бодит хэрэгцээ урган гарчээ. Ийнхүү баруун Европ, Америк, Скандинав, Пост-коммунист орнуудын улс төрийн томоохон намууд бүхэлдээ энэ өөрчлөлтийг хүлээн авч, туршин хэрэгжүүлж байна. Тухайлбал, нам олон нийттэй харилцах шинэ технологи нэвтрүүлж байгаа нь тэр чиглэлээр мэргэшсэн чадварлаг бүтэц, хүний нөөцтэй болох нөхцөл болсон. Үүнийг сүүлийн жилүүдийн сонгуулийн үйл явцаас тодорхой харж болно.

Намын чадавхийг дээшлүүлэх үйл ажиллагааг намын төв аппарат төдийгүй орон нутгийн намын байгууллагууд идэвхтэй өрнүүлж байна. Учир нь улс төрийн намууд орон нутагт дэмжлэг авч чадсанаар үндэсний болон орон нутгийн сонгуульд амжилттай оролцох бололцоо бүрдэж байсныг өнгөрсөн хугацааны туршлага, улс төрийн үйл явц харуулсан. Иймд орон нутгийн намын байгууллагыг бэхжүүлэх, хүний нөөцийн сургаж хөгжүүлэх зорилт намуудын хувьд онцгой ач холбогдолтой болсон.

Намууд нийгмийн сууриа өргөжүүлэхэд тухайлан ач холбогдол өгч байна. Үүнтэй уялдан сонирхлын бүлгүүдтэй холбогдсон нийгмийн сүлжээ үүсгэж, түүнийгээ өргөжүүлж чадсан намууд сонгуульд амжилттай оролцон, засгийн эрхийг авч улмаар мөрийн хөтөлбөрөө үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой болж байна. Өөрөөр хэлбэл сонгуульд амжилттай оролцох, бодлого хөтөлбөрөө тодорхойлох, хэрэгжүүлэхэд нийгмийн бүхий л хүрээндээ дэмжлэг авах шаардлага тавигдаж байна. Иймд улс төрийн намуудад нийгмийн бүлэг, иргэний нийгмийн дэмжлэг яах аргагүй чухал болжээ. Эцэст нь дүгнэхэд орчин үеийн улс төрийн намууд өргөн хүрээний намын хэв шинжтэй болох хандлага давамгайлж байгаа хэдий ч тухайн орны улс төрийн соёл, нөхцөл байдал, сонгуулийн тогтолцоотой уялдан кадрын, хөтөлбөрийн, олон түмний намын тодорхой хэв шинжийг хадгалсаар байна.

НОМ ЗҮЙ

1. Даш-Ёндон Б(ред). Монголын нийгмийн өөрчлөлт. Шинжлэх Ухааны Академи, Философи Социологи Эрхийн Хүрээлэн. УБ., 2008
2. Довчин. Ё (ред). Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2010
3. Мөнхбат С. Монгол дахь улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын төлөвшилтийн асуудал. Доктор PhD-ын зэрэг горилсон диссертаци. УБ., 2009.
4. Улс төрийн намын тухай хууль
5. Giovanni Sartori. Parties and Party System. London, 1976
6. Giovanni Sartori. Party Types, Organization and Functions. West European Politics Journal, September. 2010
7. G R. Michels. Political Parties: Sociological Study of the Oligarchical Tendencies of Modern Democracy. Glencoe. Illinois., 1958
8. John Ishiyama. Party Organization and the Political Success of Communist Successor Parties.
9. Joseph A. Schlesinger, Mildred S. Schlesinger. Maurice Duverger and the Study of Politics. French Politics. 2006. No 4.
10. Maurice Duverger, "Factors in a Two-Party and Multiparty System," in *Party Politics and Pressure Groups* (New York: Thomas Y. Crowell, 1972)
11. Milada A. Vachudovaa, and Liesbet Hooghe. Postcommunist Politics in a Magnetic Field: How Transition and EU Accession Structure Party Competition on European Integration
12. Richard S. Katz, Peter Mair. How Parties Organize: Change and Adaptation in Party Organizations In Western Democracies.
13. Ingrid Van Biezen. Building Party Organisations and the Relevance of Past Models: The Communist and Socialist Parties in Spain and Portugal. West European Politics
14. www.supremecourt.mn
15. www.gec.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ПАРЛАМЕНТАТ ЁСНЫ ТӨЛӨШИЛ, БЭХЖИЛТЭНД ТУЛГАРЧ БУЙ ТҮГЭЭМЭЛ АСУУДАЛ, ВЕСТМИНИСТЕРИЙН ЗАГВАРЫН НӨЛӨӨ

Э.БАТ-ЭРДЭНЭ

Улс төр судлалын тэнхимийн докторант

Түлхүүр үг: Монгол Улс, Парламентат ёс, парламентат ёсны хөгжил, төлөвшилд тулгамдаж буй асуудал, Вестминистерийн загвар, парламентат ёсны төлөвшил, улс төрийн нам, улс төрийн намуудын бодлого, төрийн албаны тогтолцоо, иргэдийн улс төрийн боловсрол, иргэний хяналт, хариуцлагын тогтолцоо, гүйцэтгэх засаглал,

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол Улс дахь парламентат ёсны төлөвшил, түүнд тулгарч буй олон асуудал байгаагийн гол шалтгааныг улс төрийн намын төлөвшил хангалтгүй байгаа асуудалтай холбоотой авч үзэн, батлахыг зорив. Монгол Улсын парламентат ёсны хөгжил, төлөвшилд тулгамдаж буй үндсэн асуудлыг улс төрийн намын төлөвшил, иргэдийн улс төрийн боловсрол, хяналт, төрийн албаны хэврэг тогтолцоо хэмээх гурван ойлголт дээр авч үзэж, энэхүү гурван асуудлыг шийдвэрлэх хамгийн зохистой хувилбар нь Вестминистерийн загварын онцлогт байна гэж үзэн гарах гарц бүхий хувилбарыг дэвшүүллээ.

Тус өгүүлэл нь гурван үндсэн хэсгээс бүрдэж байгаа болно.

1. Монгол Улсын парламентат ёсны төлөвшил, бэхжилтэнд тулгарч буй түгээмэл асуудлууд
2. Монгол Улсын парламентат ёсны төлөвшилд тулгамдаж буй дээрх түгээмэл асуудлуудыг шийдвэрлэхэд Вестминистерийн загварыг сонгох шаардлага
3. Монгол Улсын парламентат ёсны төлөвшилд тулгамдаж буй түгээмэл асуудлыг Вестминистерийн загварын онцлогоор шийдвэрлэх арга зам, зохистой хувилбарууд гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэж буй болно.

Abstract: There was purposed to show and determine the number of encountered issues on formation of parliament custom in Mongolia are caused from the insufficient formation of political parties in Mongolia.

The encountered issues caused to development and formation of parliament custom of Mongolia divides into 3 understandings: formation of political parties, political education and inspection of citizens, unstable structure of state service. We developed Westminster model for solving this issue that this version will be most optimal variant to solve this problem.

This article consists of 3 main parts:

1. The universal issues encountered to formation and strengthening of Parliament custom in Mongolia.
2. The requirements to choose Westminster model for solving encountered issues to formation and strengthening of Parliament custom in Mongolia.
3. Optimal version and way to solve by Westminster model the encountered issues to formation and strengthening of Parliament custom in Mongolia.

I. Монгол Улсын парламентат ёсны төлөвшил, бэхжилтэнд тулгамдаж буй асуудал

Тус бүлгийн үндсэн асуудал нь “Улс төрийн намуудын төлөвшил сул байгаагийн үндсэн шалтгаан юу вэ? энэхүү шалтгаан нь Парламентат ёсны төлөвшилд яагаад муугаар нөлөөлж байна вэ?, улс төр болоод, төрийн системд тогтолцооны гажуудал, түүнээс хамаарсан механизмын гажуудлыг хэрхэн бий болгож байгааг батлахыг зорьсон болно. Энэхүү асуудал нь тогтолцооны, цогц шинжтэй асуудал бөгөөд төр, иргэний хооронд дахь харилцан үйлчлэлийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээг цогцоор нь авч чадвал түүний дотор хамаарагдах нэгж хэсгүүд зөв гольдролоор ажиллана хэмээн үзсэн хэрэг юм.

1. Монгол Улс дахь намуудын нийгэмд хэрэгжүүлж буй бодлого төстэй

Монгол Улс дахь улс төрийн намуудын хэрэгжүүлж буй бодлого өөр өөрийн үнэт зүйлсийн чиг баримжаа, тэдгээртэй тулгуурласан улс төрийн бодлогыг хэрэгжүүлж чадахгүй байна. Улс төрийн намуудын нийгэмд хэрэгжүүлж байгаа бодлого төстэй байгаа явдал бол намууд нийгэмд хэрэгжүүлэх бодлогоо хайхардаггүй, харин ямар ч аргаар хамаагүй засгийн эрхийг авахыг зорьж буйн илрэл юм. Энэ байдлыг ерөнхийлөгч, УИХ, орон нутгийн сонгуулийн үеэр тод харж болох бөгөөд нийгмийн халамжын чиглэлийн бодлого дээр бүх намууд төвлөрч, иргэдэд бэлэн мөнгө, бэлэгсэлт тараах, амлах үйлдлийг улс төрийн намууд, Сонгуулийн ерөнхий хороо, иргэд мэддэг атлаа түүнийг хууль бус гэдэгт ач холбогдол өгч хариуцлага тооцох нь бараг л байдаггүй. Энэ нь Монгол Улс дахь улс төрийн институцын хөгжил сул, нөгөө талаасаа иргэдийн улс төрийн боловсрол, оролцоо муу байгааг илтгэж буй хэрэг юм.

2. Иргэдийн улс төрийн соёл, боловсрол, оролцоо

Иргэд улс төрийн намуудын бодлогыг нь харж сонгох, түүнд тулгуурлаж улс төрийн оролцоо нь бодитой болж, улс төрийн соёлд суралцах ёстой байтал Монгол Улсад эсрэгээрээ байна. МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн дэргэдэх сургалт, судалгааны “Альтернатив” төвөөс 2006 онд “Монгол Улс дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ” сэдэвт судалгаанд өгүүлснээр, уг судалгаанд оролцогчдоос “Ардчилал гэдэгт та юуг ойлгодог вэ?” гэсэн асуултанд оролцогчдын ихэнх нь эрх чөлөө, үзэл бодлын чөлөөт байдал, хувийн өмч гэсэн хариултаудыг хамгийн их сонгож, харин иргэдийн оролцоо, ард түмний засаглал, чөлөөт сонгууль, хариуцлага хүлээх, тайлагнах зарчим зэрэг ардчилалын чанарын талын асуултуудыг маш багаар сонгосон нь иргэдийн улс төрийн оролцоо, боловсрол, улс төрд хандах хандлага төлөвшиж, зөв чиг баримжаатай болоогүй байгааг харуулж буй чухал үзүүлэлт юм¹⁰⁹.

3. Төрийн албаны хэврэг тогтолцоо

Монгол Улс дахь улс төрийн намууд нь хөгжлийн нийтлэг хандлагаас хазайж буй илрэл нь “төрийн албанд” төрийн шалгуураар бус намын шалгуураар алба хаадаг төрийн захиргааны хэврэг системийг /Spoiled system/ бий болгох үндэс нь болж байна. Төрийн албаны хэврэг систем бий болсны муу үр дагавар нь төрийн захиргааны байгууллагуудын удирдлага солигдоход тухайн байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчид давхар солигдож байгаа явдал юм. Улс төрийн намуудын чадавхи бүх талаар сул /хариуцлагагүй бохир улс төрийг хийх, иргэдийг нийгэмшүүлэх чадвар сул, нийгэмд хэрэгжүүлэх бодлого адил г.м/, хариуцлагагүй байгаа байдлаас үүдсэн төрийн албаны хэврэг тогтолцоог ямар арга замаар бэхжүүлэх, төрийн албаны тогтвортой, бат бөх тогтолцоог /мерит загвар/ яаж бий болгох вэ? гэдэг асуудал нь Монгол Улсын парламентат ёсны төлөвшилд тулгамдаж буй гол асуудал юм.

Энэхүү өгүүлэлд Монгол Улсад дахь парламентат ёсны төлөвшил, бэхжилтэнд тулгамдаж буй гол асуудал бол улс төрийн намуудын нийгэмд хэрэгжүүлж байгаа бодлого адил байгаа явдал, иргэдийн улс төрийн соёл, боловсрол, оролцоо хангалтгүй байгаа явдал мөн төрийн албаны хэврэг тогтолцоо .., гэсэн гурван үндсэн асуудлыг авч үзлээ.

Эдгээр сөрөг үр дагавар бүхий уршгийг арилгах, засахад намыг төлөвшүүлэх, бэхжүүлэх, иргэдийг улс төрийн үнэт зүйл бүхий чиг баримжаа, үнэт зүйл дээр суурилсан улс төрийн нийгэмшлийг бий болгох, төрийн албыг тогтвортой байлгах зорилт тулгарч байна. Эдгээр зорилтыг шийдвэрлэхэд Вестминистерийн загварын онцлог чухал үүрэгтэй хэмээн үзэж байна.

II. Вестминистерийн загварыг сонгох шаардлага

Вестминистерийн загварыг цэврээр нь зохистой хэрэглэж чадвал Монгол Улсад дахь парламентат ёсны төлөвшил, бэхжилтэнд тулгарч буй дээрх асуудлыг шийдвэрлэх боломжтой гэдгийг дараах ойлголтуудаас харж болно.

1. Улс төрийн нам доторх лидерүүдийн тэмцэл өндөр байдаг нь улс төрийн намын төлөвшилд чухал ач холбогдолтой.

Вестминистерийн загвар бүхий онцлогоор парламентыг сонгох сонгуулийн үр дүнгээр олонх болсон намын дарга ихэвчлэн өрсөлдөгчгүйгээр гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн болдог. Энэ нь улс төрийн нам доторхи дотоод өрсөлдөөн, намын лидерүүдийн өөр хоорондоо намын даргын төлөө өрсөлдөж буй зөв өрсөлдөөний явцад намын аппарат өөрийн функцийн дагуу идэвхжих, төлөвших үндэс нь болдог. Өөрөөр хэлвэл улс төрийн намд дотоод өрсөлдөөн хүчтэй байна гэдэг нь намын лидерүүдийн өөр хоорондын хий, алдааг ажиглах, хянах замаар нэг талаас санхүүгийн хяналт, тус улс оронд мөрдөгдөж буй улс төрийн намын мөрдвөл зохих хууль, эрх зүй, тухайн намын дотоод дүрэм, журмын хяналт бий болох механизмыг бүрдүүлдэг байна. Дотоод тэмцэл, алдаа анасан өрсөлдөгчдийн хатуу хяналт нь тухайн улс төрийн нам хууль бус шийдвэр, үйл ажиллагаа гаргахгүй байх, санхүүгийн хувьд ил тод байх үндэс болж өгдөг байна. Энэ шаардлага, хяналт нь намыг төлөвшүүлэх үндсэн хөшүүргийн нэг болно.

2. Улс төрийн намд ирэх хариуцлага өндөр

Парламентад олонх болсон улс төрийн нам нь гүйцэтгэх эрх мэдлийг дангаар бүрдүүлнэ гэдэг нь намын хариуцлагыг маш өндөр болгодог. Намуудын үүрэг өндөр болсноор тухайн намууд өөр хоорондоо бодлого, үзэл баримтлал, үнэт зүйл, нийгэмд хэрэгжүүлэх шинэлэг бодлого гэх зэргээр ялгарч эхлэх сэдлийг бий болгодог байна. Түүнчлэн иргэд, олон түмний дэмжлэгийг ямар арга замаар авах онолын шинж бүхий нарийн концепцыг боловсруулж, өөрийн үндсэн мөн чанар, үүргийн дагуу улс төрд оролцох тогтолцоо, эрмэлзлэлийг бий болгох үндсийг тавьдаг. Энэ эрмэлзлэл нь иргэдийн улс төрийн боловсрол, улс төрийн үнэт зүйл, итгэл үнэмшил дээр үндэслэсэн улс төрийн чиг баримжаа, үнэт зүйлтэй болох хамгийн дөт зам мөн бөгөөд дэлхий дахины практикаас харахад ч тодоор ажиглагддаг билээ. Тухайлбал Швейцар улсад Христийн Ардчилсан намыг чин сүсэгтэй католикчууд л дэмждэг бол Социаль Демократ болон Радикал намуудыг сүм хийдэд хааяа эсвэл огт очдоггүй католик болон протестантууд л дэмждэг нь олон жилийн сонгуулийн үр дүнгээр давтагдсан байна. Үүнийг нэг талаас нь дүгнэвэл шашин, соёлоороо хуваагдсан явцгүй үзэгдэл, жишиг хэмээн үзэж болох ч иргэд өөр өөрийн чиг хандлага, үнэт зүйл дээр тулгуурлан саналаа өгнө гэдэг нь итгэл үнэмшил дээр суурилсан улс төрийн чиг баримжаа, оролцоо, нийгэмшил бий болох үндэс юм.²¹¹⁰

3. Эрх баригч намтай хариуцлага тооцох боловсронгуй тогтолцоо:

Хөгжиж буй нэг нийгмийн тогтолцооноос нөгөө нийгэмрүү шилжиж буй аливаа улс оронд улс төр, ардчилалын үнэт зүйлс тогтолцооны хувьд төлөвшин бэхжиж чадаагүй байдаг нь нийтлэг үзэгдэл юм. Сонгогчдын боловсрол, улс төрийн нийгэмшил сул, улс төрд хяналт тавих чадвар сул байгаа ийм үед хүчтэй

¹⁰⁹ МУИС Улс төр судлалын тэнхим “Политологи” сэтгүүл №-4 “Монгол дахь ардчилах үйл явц ба сонгууль” эрдэм шинжилгээний хмтарсан өгүүлэл, 9-р хуудсыг харна уу. Ш.Содном /Профессор/, Ц.Ганболд /Профессор/, Ё.Довчин /Профессор/

¹¹⁰ Арэнд Лийпхарт ., “Ардчилалын хэв загвар” 2008 он ., 3 дугаар бүлэг 58 дахь талыг харна уу.

сөрөг хүчний үүрэг онцгой ач холбогдолтой юм. Парламентын гол үүргийн нэг болсон улсын төсвийг батлах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих үйл явц бодитой болж буй эсэхэд парламентад буй сөрөг хүчний зүгээс хяналт тавих, шүүмжилж байх нь чухал юм. Сөрөг хүчний зүгээс хэлж буй шүүмжлэл нь ард түмэнд тухайн сонгож байгуулсан засагаа бодитой үнэлэх, боломж олгох, мэдэх эрхийг хангах боломжит гарц юм. Вестминистерийн загвар дахь энэхүү давуу талыг Нобелийн шагналт эрдэмтэн Артур Льюис гаргаж тавьсан ба “Аливаа парламентад олонхи, цөөнх засгийн эрхийг ээлжлэн барьсанаар цөөнхийн байдлыг хөнгөвчилж болно, өөрөөр хэлвэл өнөөдрийн цөөнх байнгын сөрөг хүчний хувь тавилан эдлэхгүй байх үүднээс хариуцлагатай улс төрийг хийх, олонх болсон намаа бодитойгоор шүүмжилж, хянах нь нэг талаас улс төр, төрийн систем авилгалаас холдох, нөгөө талаар бодитой шүүмжлэлийн үр дүнд иргэд мэдэх эрхээр хангагдах гарцыг бий болгож байна” хэмээн тайлбарлан бичсэн байна.

3. Гүйцэтгэх эрх мэдлийн тогтвортой байдал

Вестминистерийн загвар бүхий онцлогоор парламентад олонх болсон намын дарга гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн болно гэдэг нь гүйцэтгэх эрх мэдлийн институт харьцангуй тогтвортой ажиллах үндсийг бүрдүүлнэ. Энэ нь Монгол Улсад дараах хоёр байдлаар эерэгээр нөлөөлж байгаа болно.

а. Төрийн албаны тогтвортой /мерит/ систем:

Төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага тогтвортой байна гэдэг нь Монгол Улсын төрийн албаны мерит /бат бөх/ тогтолцоог бий болгох гол үндэс юм. Энэ нь дараах байдлаар тусгалаа олж буй болно. Гүйцэтгэх эрх мэдлийн институт тогтвортой ажиллана гэдэг нь Монгол Улсад төрийн захиргааны алба бэхжих, төрийн албан хаагчид ажилдаа гарших, мэргэшсэн албан хаагчид бий болох үндсэн дээр төрийн алба бэхжих үндэс болно. Энэ нь эхэнд дурдаж байсан төрийн албаны хэврэг тогтолцоог бат бөх болгох, төрийн албыг тогтворжуулах байж болох хамгийн зохистой хувилбар юм. Учир нь шилжилтийн нийгмийн өөрчлөлтийг туулж буй улс орнуудад төрийн алба бэхжих явдал нь нэг талаас цаг хугацааны хүчин зүйл бөгөөд төрийн албан хаагчдыг хөдөлгөөнгүй барьж, хэвшүүлэхийн тулд дээд удирдлага тогтвортой байх явдал хамгаас чухал юм.

б. Хариуцлага тооцох механизм тодорхой:

Ард түмний зүгээс өөрийн сонгож байгуулсан төртэй тооцох хариуцлагын тогтолцоо илүү нарийн, тодорхой болох гарц нээгдэнэ хэмээн үзэж байна. Нэг ёсондоо олонх болсон нэг нам, тэр дотроо намын дарга буюу гүйцэтгэх засаглалын тэргүүнтэй хариуцлага тооцох ил механизм бий болно. Зөвхөн намын дарга нь л ард түмнээс хасах үнэлгээ авч иргэдийн легитимэсийг бий болгоогүй тохиолдолд тухайн улс төрийн намын реитэнг бүхэлдээ унах явдал түгээмэл бий болдог. Парламентад суудал авсан тодорхой намууд хоорондоо эвсэн гүйцэтгэх засаглалаа бүрдүүлж буй үзэгдэл нь иргэд, сонгогчид, олон түмний зүгээс хэнтэй хариуцлага тооцох, гүйцэтгэх засаглалын зүгээс хариуцлагыг хэн хүлээх гэх зэрэг асуудлууд дээр тодорхойгүй байдлыг үүсгэж байна.

III. Вестминистерийн загвараар шийдвэрлэх арга зам, зохистой хувилбар

Монгол Улсын парламентат ёсны төлөвшилд тулгамдаж буй асуудлуудыг Вестминистерийн загвар бүхий тогтолцоог цэврээр нь хэрэглэх замаар шийдэх бодлогын хувилбаруудыг доор дурдсан болно.

1. Намуудын төлөвшлийг хангах, хариуцлагыг өндөрсгөх

Монгол Улсад улс төрийн институт, өөрөөр хэлвэл улс төрийн намын хөгжил, үйл ажиллагааны соёл сул, хангалтгүй байгаа асуудлыг Вестминистерийн загвар бүхий онцлогоор шийдвэрлэх дараах хоёр үндсэн гаргалгааг гаргасан болно.

а. Нам доторх өрсөлдөөн бүхий хяналт намыг төлөвшүүлэх нь

Вестминистерийн загвараар парламентыг сонгох сонгуулийн үр дүнгээр олонх болсон намын дарга гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн болдог үнэт зүйл бүхий зарчимтай. Энэ нь намын дотоод өрсөлдөөн, намын лидерүүдийн өөр хоорондоо намын даргын төлөө өрсөлдөж буй зөв өрсөлдөөний явцад намын аппарат өөрийн функцын дагуу идэвхжих, төлөвших үндэс болдог. Энэ тухай хоёрдугаар бүлэгт тодорхой байдлаар дурдсан бөгөөд гол нь лидерүүдийн намын даргын төлөө өрсөлдөж буй нам доторх өрсөлдөөн нь тухайн намыг санхүү, хууль эрх зүйн алдаагүй үйл ажиллагаа явуулахыг шаарддаг ба тухайн улс төрийн нам нийгэмд зөв бодлого хэрэгжүүлэх, цэврээр өрсөлдөх суурь үндэс нь болдог. Энэ нь Монгол Улсад нэн ашигтай байдлаар тусах бөгөөд Монгол Улс дахь улс төрийн намуудад санхүүжилт, санхүү, хууль, эрх зүйн хяналт зайлшгүй чухал байгаатай санал нийлнэ гэдэгт итгэлтэй байна.

б. Улс төрийн намууд хоорондын үзэл, хэрэгжүүлж буй бодлогын ялгааг тодруулах

Улс төрийн намд ирэх үүрэг, хариуцлага, хяналт маш өндөр, мөн тодорхой байдаг. Үүнийг дагасан улс төрийн намуудын өөр хоорондоо ялгарах, иргэд, сонгогчид, олон түмний дэмжлэгийг авахаас үүдсэн үнэт зүйл түүнд тулгуурласан бодлогын томоохон ялгаанууд нь нэг талаас намуудыг өөрийнх нь үнэт зүйлийн дагуу төлөвшүүлэх, нөгөө талаас иргэдэд улс төрийн үнэт зүйл, итгэл үнэмшилтэй болгох чухал асуудлын үндэс болж өгнө.

2. Иргэдийн улс төрийн соёл, хяналт, мэдэх эрхийг хангахын тулд сөрөг хүчнийг бэхжүүлэх

Хоёрдугаар асуудалбуюу улс төрийн намын гол үүргийн нэг болсон сонгогчид, иргэдийн, улс төрийн соёлд анхаарах, гол нөлөөг үзүүлэх, нийгэмшүүлэх үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаатай холбоотой иргэдийн улс төрийн соёл дутмаг, оролцоо сул, иргэд, сонгогчид улс төрийн боловсролын хувьд дутмаг, төрд тавих хяналт сул байна. Энэ асуудлыг дараах хувилбараар шийдвэрлэж болох гарцыг гаргасан бөгөөд эрдэмтэн Артур Льюисийн хандлага юм. Тэрээр өөрийн үзлийг тайлбарлахдаа “Аливаа парламентад олонхи, цөөнх засгийн эрхийг ээлжлэн барьсанаар цөөнхийн байдлыг хөнгөвчилж болно, өөрөөр хэлвэл өнөөдрийн цөөнх

байнгын сөрөг хүчний хувь тавилан эдлэхгүй байх үүднээс хариуцлагатай улс төрийг хийх, олонх болсон намаа бодитойгоор шүүмжилж, хянах нь нэг талаас улс төр, төрийн систем авилгалаас холдох, нөгөө талаар бодитой шүүмжлэлийн үр дүнд иргэд мэдэх эрхээр хангагдах гарцыг бий болгож байна¹¹¹ хэмээн үзсэн юм.

3. Төрийн албыг тогтворжуулах, төлөвшүүлэх, бэхжүүлэх

Гуравдугаар асуудал нь улс төрийн намын үндсэн функц, зөв чиг баримжаа, үйл ажиллагааны гольдрол алдагдсан учир төрийн албаны тогтолцоонд төрийн шалгуураар бус намын шалгуураар алба хаах систем бий болсон нь төрийн албаны тогтолцоог хэврэг болгож байна. Энэ асуудлыг дараах хоёр байдлаар шийдвэрлэх хувилбар Вестминистерийн загварт байгаа болно.

а. Гүйцэтгэх засаглалын тогтвортой байдал үйл ажиллагаанаас хамаарсан төрийн албаны тогтвортой тогтолцоо /мерит систем/

Гүйцэтгэх эрхмэдлийн байгууллага ихээхэн тогтвортой байдаг учир төрийн захиргааны тогтвортой алба, төрийн мэргэшсэн албан хаагчид бий болж төлөвшихөд чухал хүчин зүйл юм.

б. Иргэдийн зүгээс эрх баригч нам, намын даргатай хариуцлага тооцох механизм тодорхой

Ард түмнээс төртэй тооцох хариуцлага тодорхой, тухайн эрх баригч нам, намын даргатай хариуцлага тооцох тодорхой систем бий болж байна. Өөрөөр хэлвэл цэвэр весминистерийн загвар бүхий тогтолцоог хэрэглэсэнээрээ Боннын /зөвшилцлийн/ загвар дахь хэн хариуцлага хүлээх, иргэд хэнтэй хариуцлага тооцох зэрэг ойлгомжгүй асуудлаас гарч, хариуцлага хүлээх, иргэдийн зүгээс яаж хариуцлага тооцох тодорхой тогтолцоо вестминимтерийн загварт байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын парламентат ёсны төлөвшилд тулгамдаж буй нэн яаралтай шийдвэрлэвэл зохих асуудлыг улс төрийн намуудын төлөвшил сул, хэрэгжүүлж буй бодлого ижил байгаагаас үүдсэн гурван асуудлыг вестминистерийн загвар бүхий тогтолцоогоор шийдэх хувилбар, гаргалгааг хийлээ.

Парламентат ёс хэмээх ойлголт нь “Төр засаг ард түмнээс эхтэй байж, хууль тогтоогчийг ард түмнээс сонгох, тэдний зөвшөөрөл, хяналтын доор засаглалын үйл ажиллагаа хэрэгжих ёстой бөгөөд үр дүнд нь иргэдийн төлөө үйлчлэх улс төр, эдийн засаг, нийгмийн хамгааллын сонгодог тогтолцоо бий болох” нь парламентат ёсны үйлчлэх хүрээ юм. Тэвэл энэхүү ойлголтууд төлөвшин бэхжихэд тулгарч буй аюулыг:

- Монголд улс дахь намын хөгжил, үйл ажиллагааны хариуцлагын соёл сул байна.
- Энэ нь улс төрийн намын гол үүргийн нэг болсон иргэдийг улс төрийн соёлд сургах, нийгэмшүүлэх үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаатай холбоотой бөгөөд ийм учир иргэдийн улс төрийн соёл дутмаг, оролцоо сул, иргэд улс төрийн боловсролын хувьд дутмаг, төрд тавих хяналт сул байна.
- Намын үндсэн функц, үйл ажиллагааны гольдрол алдагдсан учир төрийн албаны тогтолцоонд төрийн шалгуураар бус намын шалгуураар алба хаах систем бий болсон нь төрийн албаны тогтолцоог хэврэг болгож байна хэмээн тус тус тодорхойлсон болно.
- Тулгарч буй энэхүү гурван асуудлыг шийдвэрлэхийн тулд вестминистерийн загвар бүхий тогтолцооны суурь ойлголт болсон үнэт зүйлсээр шийдэх хувилбар нь:
- Улс төрийн нам доторх лидерүүдийн тэмцэл хурц
- Улс төрийн намд хүлээлгэх хариуцлага өндөр, хяналтын механизм чанга
- Гүйцэтгэх эрх мэдлийн тогтвортой байдлаас шалтгаалсан төрийн албаны тогтвортой бүтэц
- Сөрөг хүчний хүчтэй шүүмжлэлээс иргэд төр засагт бодит үнэлэлт өгөх боломж
- Нэг талаас ямагт сөрөг хүчин байхгүйн улмаас хүчтэй хянах, нөгөө талаас эрх барьж буй намаас үйл ажиллагаагаа хийгүй, бодитой явуулах зэрэг Вестминистерийн загвар дахь онцлогоор Монгол Улс дахь парламентат ёсны төлөвшилд тулгамдаж буй дээрх гурван асуудлыг шийдэх боломж байгааг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

НОМ ЗҮЙ

1. Арэнд Лийпхарт, “Ардчилалын хэв загвар”, УБ., 2008 он
2. Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан, “Парламентат ёс”, УБ., 2005 он
3. МУИС-Улс төр судлалын тэнхим “Политологи” сэтгүүл /№-4/, УБ., 2009 он
4. Н.Лүндэндорж, “Төрийн онол”, УБ., 2008 он
5. О.Машбат, “Бонноос Үестминистерийн зүг”, УБ., 2008 он
6. Морис Дюверже, “Улс төрийн байгууламж үндсэн хуулийн эрх зүй”, УБ., 2007 он
7. Монгол Улсын Их Хурал, “Монгол Улсын парламент”, УБ., 2015 он

¹¹¹ Арэнд Лийпхарт “Ардчилалын хэв загвар” 52, 53-р талыг үзнэ үү.

АРДЧИЛЛЫН ОНОЛ, ПРАКТИК**ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛЫН НИЙГЭМД
ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ****Ц.БАТБОЛД***Доктор, дэд профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,**Улс төр судлалын тэнхим***Д.ОТГОНЧИМЭГ***Улс төр судлалын тэнхимийн докторант*

Түлхүүр үг: Хувь хүн, бие хүн, улс төрийн мэдлэг, албан ёсны ба албан ёсны бус боловсролын тогтолцоо, улс төрийн ухамсар, улс төрийн нийгэмшилт, улс төрийн соёл, улс төрийн оролцоо,

Товч агуулга: Уг өгүүлэлд орчин үеийн ардчилсан дэглэмтэй улс орнуудад засаг төрөө сонгож байгуулах, улс төрийн асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн улс төрийн мэдлэг, боловсрол, ухамсар, соёл, нийгэмшилт нь ямар үүрэг гүйцэтгэдэг болон түүний ач холбогдолыг тодорхойлох зорилго тавьсан болно.

Abstract: In this article shows that to establish to select the government in the modern democratic countries. In order to resolve the political issues, citizens 'political awareness, reviews, culture, socialization are fulfilled to determine their importance role in the society.

Хүн төрөлхтний нийгмийн харилцаанд улс төрийн мэдлэг, тэр дундаа улс төрийн шинжлэх ухааны мэдлэг чухал байр суурь эзэлдэг бөгөөд нийгмийн амьдралд улс төрийн мэдлэгийн гүйцэтгэж ирсэн болон одоо гүйцэтгэж буй үүрэг улам өсч байна. Соёл иргэншлийн бүхий л түүхийн туршид улс орон, ард түмний хувь заяа, тэрчлэн хувь хүний өдөр тутмын амьдралд ч улс төр чухал нөлөө үзүүлж ирсэн. Шинжлэх ухааны онол дахь улс төрийн мөн чанарын талаарх маргаан нь бодит улс төрийн үйл ажиллагааны мөн чанарын тухай маргаантай холбогддог. Эртний оюуны судалгаануудын нэг болох улс төр нь хууль, түүх, философийн гарал үүсэлтэй салшгүй холбоотой. Улс төрийн үндсэн зорилгыг анхны хүний нийгэм үүсэх үндсийг бий болгох явдал байсан гэж үздэг. Улс төр бол “засаглан захирамжлах нутаг дэвсгэр дээр янз бүрийн хэсэг бүлгүүд, янз бүрийн ашиг сонирхол, янз бүрийн уламжлал зэрэгцэн оршдог явдлыг хүлээн авсанаас үүдсэн үйл ажиллагаа юм.”¹¹²

Хүмүүс улс төрд оролцохгүйгээр сайхан амьдрах боломж, эрт үес эдүгээ хүртэл тэр бүр байсангүй. Тиймээс ч Аристотель хүний антропологи мөн чанарыг шинжлэн үзээд “хүн бол улс төрийн амьтан” хэмээн тодорхойлжээ. Хүмүүс нийгмээр амьдрах нь улс төрийн харилцаанд зайлшгүй орно гэсэн үг юм. Аристотелийн үзэж байснаар “улс төр гэдэг бол төрийн бүх ажил хэрэг...төгөлдөр сайхан амьдрал зохиоход чиглэгдсэн нийт иргэний харьцахуй юм. Энэ бол улс төрийн харьцахуй. Иймд улс төр бол хамтын үйл ажиллагаа мөн. Улс төрийн зорилго нь нийтийн сайн сайхан байдлыг хангах явдал юм. Улс төр гэдэг бол бүх нийтийн тэгш ёсыг хэрэгжүүлэх зорилго бүхий хамт нийтийн үйл ажиллагаа юм.”¹¹³ Тухайлбал, амьдралын бодитой асуудлууд ойрын хүмүүс, цаашилбал нийт хүн төрөлхтөнд хэрхэн нөлөөлөх вэ гэдэгт санаа зовсноос болж улс төрөөр хөөцөлддөг хүмүүс бий. Зарим нь улс төр бол хувь хүн, хэсэг бүлгүүдийг өөд өөдөөс нь турхирдаг, эсвэл эрх мэдлээ урвуулан ашиглах, луйвардах, төөрөгдүүлэх, урван тэрслэх, хүч хэрэглэхэд хүргэдэг гэж итгэснээс түүнийг жигшин үздэг. Мөн амьдралд нь хэрэгцээтэй зүйлтэй огт холбогдолгүй учраас улс төр тэдэнд ердөө ч хүртээлгүй, уйтгартай санагддаг гэж боддог хүмүүс ч байдаг. Эдгээр хандлага нэг бүр улс төрийн тухай үнэний үр агуулдаг. Үнэхээр бидний ихэнхийн улс төрийн хандлагад эдгээр бүх мэдрэмж ямар нэг хэмжээгээр оролцож, харин тэдгээрийн хувь харьцаа цаг үе, үйл явдлаас хамааран өөрчлөгдөж байдаг ажээ.

Нийгэм бол бүгдийг багтаасан социал систем. Нийгэмд хамаарах бүхэн нэг талаасаа улс төрийн байх агаад бүгд цаад утгаараа улс төрийн бодлогоос гадуур байх боломжгүй.¹¹⁴ Гарольд Лассуэлл “Улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явц, механизмыг ойлгож таньж мэдэх боломж мөн улс төрийн рационал шийдвэр гаргахад шаардагдах тодорхой онолын хандлага, эмпирик баримт сэлтийг бүрдүүлж өгдөг утгаараа бүх шинжлэх ухаан улс төрийн шинжлэх ухаантай холбогдож байдаг”¹¹⁵ гэжээ. Улс төр нь хувь хүний амьдралын өөдлөн дэвжих, уруудан доройтох боломж нөхцлийг тодорхойлдогос хүмүүс түүнд оролцож байдаг. Г.Лассуэлл

¹¹² Bernard Crick, 1964, In Defense of Politics ,Baltimore, Maryland: Penguin Books, p.18.

¹¹³ Аристотель. Улс төр.УБ., 2006.11,17, 28 -р тал.

¹¹⁴ Г.Цэнд-Аюуш. Улс төрийн ухамсар: түүхэн судалгаа. УБ., 2012. х. 23.

¹¹⁵ Лассуэлл.Г. Психопатология и политика. Чикаго.1930. с.123.

улс төрийг “хэн юуг хэзээ яаж хүртэж байна вэ?” гэдгийг тогтоох үйл явц хэмээн товч тодорхойлсон бол, Дэвид Истон улс төрийг ердөө “нийгмийн баялаг, үнэт зүйлсийг албадан байршуулах үйл явц” гэж үзжээ. Гэхдээ улс төр бол зөрчилдөөн ба хамтран ажиллахтай нягт холбоотой. Өөрөөр хэлбэл, ялгаатай үзэл бодлын өрсөлдөөн, янз бүрийн ашиг сонирхлын эсэргүүцэл, тэмцэл зэргээр хүмүүсийн хэрхэн амьдрах зарчмыг хүлээн зөвшөөрөх эсвэл үл зөвшөөрдөг үйл явц юм. Энэ утгаараа улс төр хүмүүст олон нүүр гаргаж, сайн сайхныг ч, бас муу муухайг ч авчрах хүч болж чадна.

Улс төрийн гол цөм нь юуны түрүүнд өөрийнхөө хийгээд бусдын талаар чухал шийдвэр гаргадаг хувь хүн, хэсэг бүлэг болон тэдэнд эрх мэдэл олгон ажиллуулж буй засаглалын институцийн мөн чанараас хамааралтай. Хүмүүс түүнийг мэддэг ч эдгээр дүрэм журмуудын нөлөөлөл болон түүнийг дагаж мөрдөх зэргээс үүдэн тэд бусадтайгаа хамтрах ёстой гэдгээ мэддэг. Энэ утгаараа улс төрийн шийдвэр нийтийн буюу нийгмийн гэсэнтэй дүйж очин, үргэлж ямар нэг нийтлэгийн хүрээнд гарч байдаг онцлогтой. Тодруулж хэлбэл, засаглалын шийдвэрүүд гагцхүү нийтийн эрх ашигтай холбогдож байж л улс төрийнх байдаг. Улс төр ямагт олон хүний эрх ашгийг хөндөж, үр дагавар нь олон хүнд мэдрэгдэж байдаг.

Гэхдээ сонголт бүр, шийдвэр бүхэн улс төрийнх байдаггүй. Гэр бүл дотор, найз нөхдийн хүрээнд, сайн дурын байгууллагад болж байгаа бүхэн ихэвчлэн хувийн хүрээнд хамаарагдана. Энэ хүрээний үйлдлүүд сайн дурын, дэглэж журамлагдаагүй шинжтэй, тухайн бүлгээс гадагш хэнд ч холбогдолгүй байна. Энэ утгаар нь авч үзвэл бүх шийдвэр нийтийнх байдаггүй. Либерал нийгэмд хүмүүсийн хувийн амьдралын хүрээ нийтийн хүрээг шахсан байдаг. Өөрөөр хэлбэл, хувь хүн түүний хамаарагдах сонирхлын бүлгүүд нийгмийн амьдралын хувь заяа, түүний улс төрийн шийдвэрийг өөртөө тааламжтайгаар хувьсган өөрчлөхөөр өрсөлдөн тэмцэлдэж байдаг.

Орчин үеийн улс орнуудад ихэнхдээ ардчилсан дэглэм тогтож, тэдгээрийн нийгэм, улс төрийн асуудлыг шийдвэрлэх улс төрийн мэдлэг, чадвар бүхий хүмүүсийг сонгох болон улс төрийн үйл явц, шийдвэрт оролцож дуу хоолойгоо илэрхийлэх нь иргэдийн улс төрийн мэдлэгтэй улам бүр салшгүй холбоотой болсоор байна. Ардчилсан засаглалын сонгодог илэрхийлэл нь Абрахам Линкольний хэлсэнээр “ард түмний төлөөх, ард түмний өөрсдийнх нь, ард түмний засаглал” юм. Энэ утгаараа ард түмэн төр, засгаа байгуулах сонгуульд идэвхтэй оролцож сонголтгоо хийдэг. Гэтэл сонгогчдын улс төрийн мэдлэг, боловсрол дорой байх нь сонгуулийг нэг ёсны эрх баригчдын улс төрийн ээлжит “тоглоом” болгон хувиргахад хүргэдэг гэсэн судлаачдын шүүмжлэл тасардаггүй. Эндээс иргэд, сонгогчдын улс төрийн мэдлэг, боловсрол ардчилсан төр, засаглалтай нийгэмд чухал ач холбогдолтой болох нь тодорхой харагдана.

Иймд ардчилсан дэглэм дэх сонгогч бүр улс төрийн мэдлэг боловсрол, соёлтой, хувийн болон нийгмийн хариуцлагаа ухамсарлаж төлөвшсөн хувь хүн ба бие хүн байх шаардлага зүй ёсоор тулгардаг. С.И.Ожеговын “Орос хэлний тайлбар толь”-д хувь хүн буюу бодгаль гэдэг нь тусдаа хүн, амьд организм гэсэн үг бөгөөд хувь хүн бол бусад хүмүүсийн дунд тусдаа байгаа бие хүн; бие хүн гэдэг нь ямар нэгэн шинж чанар агуулсан хүн, утга учиртай этгээд; хүн гэдэг бол нийгмийн нэгэн гишүүн гэж тайлбарласан байна. “Философийн нэвтэрхий толь”-д бие хүн гэдгийг *нэгдүгээрт, хувь хүний нийгмийн харилцаа ба ухамсарт үйл ажиллагааны субъект болохын хувьд, хоёрдугаарт, хувь хүнийг ямар нэгэн нийгэм ба хэсэг бүлгийн гишүүн болохыг тодорхойлох, нийгэмд чухал ач холбогдол бүхий шинж чанаруудын тогтсон систем гэж ойлгоно гэсэн байна.*

Гэвч өнөөгийн ардчилсан засаглалтай улс орнуудад улс төрийн онол, сургаал номлол, үзэл сурталд төдийгүй нийгмийн амьдралын хүрээнд ч хүний тухай асуудлыг өөр өөрөөр авч үзэж үнэлэлт дүгнэлт өгөх хандлага хадгалагдсаар байна. Тухайлбал, либерал үзэл сурталд хүнийг ёс суртахууны хувьд бие даасан хувь хүн хэмээдэг бол, зүүний үзэл суртлын чиг хандлагад хүн бол тухайн нийгмийн харилцааны бүтээгдэхүүн буюу нийгмийн үүрэг, хариуцлагаа ухамсарласанаар бие хүн болж төлөвшдөг гэж үздэг. Либералууд улс орны хөгжил дэвшил, түүний соёл иргэншлийн түүх нь альтруизм буюу өөрийгөө золиослох үзэл дээр бус, харин эгоизм буюу өөрийгөө бодох үзэл дээр тулгуурласаар ирсэн гэж тайлбарладаг. Айн Рэнд «Хүний жинхэнэ мөн чанар нь индивидуалист (хувь хүн өөрийнхөө төлөө амьдардаг гэдэг үзэл) байх явдал юм. Үүнээс ичээд байх юм юу ч байхгүй. ...Бид эгоист болон индивидуалистуудыг өөрийн өчүүхэн хэргцээгээ хангаж чадахгүй, зориг зүрхгүй, авьяас чадваргүй сул дорой хэн нэгэнтэй хольж хутган эндүүрсэн ойлголттой байж болохгүй. ...Хүн бусдынхаа төлөө хийж чадах зөв бөгөөд сайн зүйл бол бусдын хэрэгт оролцохгүй байх явдал юм»¹¹⁶ гэжээ.

Харин зүүний хандлагад нийгэм бол хүмүүсийн органик нэгдэл бөгөөд хувь хүн нь нийгмийн харилцаанд орохдоо гэр бүл, сургууль соёл, ажил хөдөлмөр гэх зэрэг олон хүчин зүйлээр дамжиж ёс суртахууны хүмүүжил, мэдлэг боловсрол, дадлага туршлага эзэмшиж, нийгмийн үүргээ биелүүлж чадах бие хүн болон төлөвшдөг гэж үздэг. К. Маркс “...Хүний мөн чанар бол нийгмийн харилцааны цогцолбор мөн”¹¹⁷ гэжээ. “Хүн бол нийгмийн амьтан бөгөөд тэр нь бие хүний хувьд зөвхөн нийгмийн дотор л хөгжиж чадна. Хүн нийгмийн тодорхой орчинд амьдардаг. Тэр нь гэр бүлийн гишүүн, ямар нэг анги буюу нийгмийн давхраа, аль нэг үндэстний төлөөлөгч байдаг. Түүний бүхий л амьдрал хүмүүстэй харилцах үргэлжийн харилцаа, хамт олон, нийгмийн дотор өрнөдөг. Хүмүүсийн амьдралын нөхцөл тэдний ашиг сонирхол, ертенцийг үзэх үзэл, ёс суртахууныг тодорхойлдог.”¹¹⁸

Гэсэн хэдий ч ардчилсан засаглал нь нийгэм дэх плюрализм (олон ургальч үзэл)-ийг хүлээн зөвшөөрдөг учраас хувь хүний ёс суртахууны бие даасан байдал болон бие хүний хүмүүжил, ёс суртахууны төлөвшилтийн асуудлуудын аль алин нь тухайн нийгмийн улс төрийн ухамсартай холбогдоно. Улс төрийн ухамсар нь “...

¹¹⁶ Den Uyl, Douglas & Rasmussen, Douglas. The Philosophic Thought of Ayn Rand. Chicago: 1986. University of Illinois Press

¹¹⁷ К. Маркс, Ф. Энгельс. Түүвэр зохиол, 1 дүгээр боть, УБ., 1969, 1 дахь тал

¹¹⁸ Ред. С.Норовсамбуу, С.Пүрэв, Д.Содномгомбо. Шинжлэх ухааны коммунизм. УБ., 1988. х 398

аливаа хүн улс төрийн орчинд амьдарч, улмаар тэрхүү орчинд тодорхой үүрэг гүйцэтгэж, эрх баригчидтай харилцаж, эрх үүргээ хэрэгжүүлж хариуцлага хүлээх чадварыг тодорхойлдог оюуны чадамжийн бүрдэл цогц юм.”¹¹⁹ Нийгмийн амьдралын хөгжил дэвшил, хямрал тэмцэл, зогсонги байдал зэрэг нь хүмүүсийн улс төрийн ухамсарт янз бүрийн өөрчлөлтийг авч ирдэг. Тухайлбал, “нийгэмд хямралт байдал үүссэн үед үүнээс гарах гэж эрх баригчид оролдохдоо тооцоогүй амлалтууд дэвшүүлж, үүний биелэлт нь удаашрахлаар хүмүүсийн хүлээлт, дургүйцлийг өдөөж олон түмний улс төрийн ухамсрыг доод төвшин рүү татан оруулдаг”¹²⁰ байна. Тухайлбал, Зүүн Ази болон Латин Америкийн цөөнгүй улс орнууд хямралт нөхцлийн дунд ардчиллаас ухарч, авторитар дарангуйллын дэглэмийг тогтоож байсан бөгөөд хожим нь тэдгээр улсуудын ихэнх нь ардчиллыг сэргээн тогтоосон юм. Энэ нь нэг талаар иргэдийн улс төрийн мэдлэг боловсрол дорой, ардчилал, хүний эрх, эрх чөлөө, иргэний эрх, үүргийн талаарх ойлголт сул байгаатай холбоотой юм.

Улс төрийн мэдлэг бол хүний танин мэдэхүйн үйл ажиллагааны үр дүнг оршин тогтнох нийгмийн системтэй холбож буй хэлбэр юм. Ард түмний улс төрийн мэдлэг нь нийгмийн харилцаанд үүссэн янз бүрийн асуудлыг шийдвэрлэх, түүнийг үр ашигтай, зохион байгуулахад тусалдаг. Улс төрийн мэдлэг нь өргөн утгаараа улс төрийн үзэгдэл, үйл явцын талаарх ойлголт, үзэл санаа хэлбэрээр бодит байдлын дүр төрх юм. Харин явцуу утгаар улс төрийн мэдлэг нь тодорхой ажлын талаарх шалгуур, мэдээлэл болж өгдөг төдийгүй шийдвэрлэх чадварт итгэлтэй хандах ойлголтын үүрэг гүйцэтгэн өөрсдийн зорилгодоо хүрэхийн тулд ашиглах хэрэгсэл болдог. Францын нийгмийн зүтгэлтэн Анри Барбюс (1873-1935) “улс төрийн шинжлэх ухааны судалгаанд улс төрийн боловсролыг орхигдуулж болохгүй” хэмээн онцолсон төдийгүй “энэ нь төрийн үзэл санаа, үйл ажиллагааны талаарх хүн төрөлхтний хэл юм” гэжээ.

Иргэдийн нийгэм, улс төрийн мэдлэгийг ерөнхийд нь ердийн мэдлэг, шинжлэх ухааны мэдлэг гэж хувааж болно. Улс төрийн талаарх ердийн мэдлэг бол уламжлал, билэг тэмдэг, итгэл үнэмшил, сүсэг бишрэл, хувийн туршлага гэх зэрэг хүчин зүйлстэй холбоотой өдөр тутмын практик үйл ажиллагааны нийтлэг мэдрэмжээс бүрдэнэ. Энэ нь хүн төрөлхтний түүхийн үе шат бүрт оршиж байсан янз бүрийн шинж чанартай улс төрийн харилцааны бодит байдлын талаарх үндсэн мэдээлэл бүрдэх үйл явц юм. Улс төрийн талаарх иргэдийн ердийн мэдлэг нь албан бус батлагдаагүй, бичигдээгүй хэм хэмжээ зэргээс хамаарсан энгийн мэдлэг бөгөөд хүний өдөр тутмын зан үйл, алсын харааны чиг баримжааны үндэс суурь болж байдаг ч ихэвчлэн алдаа, зөрчилтэй байдаг. Ийм шинж чанартай улс төрийн талаарх ердийн мэдлэг нь ихэвчлэн практик улс төрийн үйл явцын үр дүнд олон нийтийн улс төрийн мэдлэг болж хувирдаг байна.

Хүмүүсийн энгийн өдөр тутмын амьдралаас тодорхойлогдсон ердийн мэдлэгийг хоёр төрөлд хувааж болно. Энэ нь ердийн практик мэдлэг ба хэт хялбаршуулсан тайлбарт уламжлалт мэдлэг юм. Ердийн практик мэдлэг нь уламжлал болон өдөр тутмын практик амьдрал, улс төрийн бодит үйл явцаас сургамж авсан мэдлэг байх бөгөөд реалист, прагматик, рационал хандлагад илүү тулгуурласан үйл байдал дахь нөхцөлт рефлексийн шинж чанартай мэдлэг юм.

Хэт хялбаршуулсан уламжлалт мэдлэг нь ямар нэг баримт нотолгоогүй мэдээлэлд тулгуурлан логик гаргалгаа хэлбэрээр тайлбарлагдсан үнэн бус байж болох мэдлэг юм. Ийм мэдлэг нь ам дамжсан яриа, цуурхал, мухар сүсэг, хүсэл мөрөөдөл, уламжлалд тулгуурласан ойлголт зэрэг өнгөц мэдлэгийг улс төрийн үйл явц, үзэгдэлтэй холбон логик дүгнэлт өгсөнөөс үүдэн тайлбарлагдан гарч ирдэг. Өөрөөр хэлбэл, ирж буй мэдээллийг ойлгож хүлээж авах байдлыг логик ба дүрийн (сэтгэл хөдлөлийн), мэдрэмжийн (бие эрхтэнд ирж буй нөлөөлөл), зөн билгийн (хоосон дүрслэлд төвлөрөх) гэсэн төрлүүдээр бий болгодог ердийн мэдлэг юм. Ийм мэдлэгийг улс төрчид олон нийтэд санаатай, санаагүй хэлбэрээр төлөвшүүлэн өөрсдийн зорилгоо дэмжүүлэх хэлбэрээр ашиглах нь түгээмэл байдаг.

Улс төрийн шинжлэх ухааны мэдлэг бол тусгайлан боловсруулсан ойлголт, хэллэгүүдээр томъёологдсон бодит байдал, үзэгдэл, үйл явцын объектив, субъектив хууль, зүй тогтлууд, тэдгээрийн нотолгоо, баталгаа бүхий үндэслэл дүгнэлтүүд бөгөөд хүн төрөлхтний улс төрийн харилцааны оюуны болон практик үйл ажиллагааны бодит үр дүн юм. Хүмүүсийн нийгмийн амьдрал дахь улс төрийн харилцааны объектив, субъектив харилцан шүтэлцээ бүхий “үнэн” зөв мэдлэгийн тогтолцоог бүтээснээр улс төрийн шинжлэх ухааны мэдлэг бий болдог. Орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны судалгааны янз бүрийн арга хэрэгсэлүүд нь улс төрийн үзэгдэл, үйл явц тэдгээрийн хувьсал хөгжлийн тухай тодорхой бодит баримт мэдээлэлд тулгуурлан задлан шинжилсэн дүгнэлтээр нийгмийн амьдралыг оновчтой зохицуулах мэдлэгийг бий болгох зорилгод захирагдана. Улс төрийн мэдлэгийн хүрээнд улс төрийн үйл явцад идэвхтэй оролцогчид төрийн удирдлагын механизмыг ашиглан зөвшөөрөл ба хязгаарлалт тогтоон зохицуулах, улс төрийн хүсэл зорилгыг үндэслэн бий болгож, улс төрийн байгуулал, институт, хэм хэмжээ ба үзэгдлүүдэд үнэлгээ өгч хүмүүсийн улс төрийн үйл байдлын зохистой хэв загварыг тодорхойлж байдаг. Энэ утгаараа улс төрийн шинжлэх ухааны мэдлэг зөвхөн үнэний тухай мэдээлэх үүрэгтэй.

Улс төрийн мэдлэгийн зарим бүрэлдэхүүн хэсэг нь түүнийг хүмүүс хүлээн зөвшөөрөх явдлаас хамаардаг гэсэн хандлага байдаг. Энэ нь уг мэдлэгийг туйлын харьцангуй шинжтэй гэсэн хэрэг биш юм. Учир нь хүмүүсийн ухамсрын түвшин улс төрийн аль нэг онол, үзэл санааг хүлээн авах эсэх нь эцсийн дүндээ нийгэм, эдийн засаг, соёл боловсрол, нийгмийн амьдралын хөгжлөөс хамаарах төдийгүй бодит улс төрийн үйл явцаас ихээхэн шалтгаалдаг. Өөрөөр хэлбэл, тухайн нийгмийн улс төрийн үйл явцыг хүмүүс хэрхэн хүлээн авах нь түүний тайлбар болон бодит үр дүнтэй илүү холбоотой.

¹¹⁹ С.Болд. Улс төрийн ухамсар. Шинэ толь. УБ., 1998, №1 21-р тал

¹²⁰ Г.Цэнд-Аюуш. Улс төрийн ухамсар: түүхэн судалгаа. УБ., 2012. х. 46.

Улс төрийн үйл явцыг ард түмэнд хэрхэн тайлбарлаж таниулахаас хамаарч улс төрийн мэдлэгийн асуудал чухлаар тавигддаг. Энэ үйл явцыг эрх баригч төр засаглал, улс төрийн сөрөг хүчнүүд, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид зэрэг олон субъектууд өөр өөр байр суурьнаас тайлбарлана. Чухам энэ нөхцөлд иргэдийн улс төрийн суурь мэдлэг үүнийг ялгаж тунгаан зөв байр суурийг олж дэмжих шаардлага тулгардаг. Ардчилсан нийгэмд иргэд засаг, төрөө өөрсдөө сонгон байгуулж, хяналтаа тавих ёстой бөгөөд энэ нөхцөлд тэдэнд улс төрийн шинжлэх ухааны суурь мэдлэг зайлшгүй шаардлагатай болж ирдэг. Энэ утгаар улс төрийн шинжлэх ухааны мэдлэгийн үндсийг дэлхийн ихэнх улс орнууд их дээд сургуулийн суурь хөтөлбөрт оруулж өгөн улс төрийн боловсролыг оюутан залуучуудад эзэмшүүлдэг. Орчин үеийн өндөр хөгжилтэй ардчилсан засаглалтай улс орнуудын иргэдийн ихэнх хувийг дундаж давхрага эзлэх болсон. Энэ нь тэдгээр дунд ангийнхан бараг бүгд албан ёсны дээд боловсрол эзэмшсэн байдаг гэсэн үг бөгөөд энэ хүрээнд улс төрийн шинжлэх ухааны суурь ойлголт, мэдлэгийг их дээд сургуулиар олж авсан байдаг.

Орчин үеийн нийгмүүдийн соёл иргэншлийн хөгжлийн түвшин дээшлэхийн хэрээр дэлхийн ард түмнүүд ардчилсан засаг төрийн тогтолцоонд улам бүр татагдан орсоор байна. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн ухамсар, амьдралын түвшний дээшлэлт нь улс төрийн соёлтой холбоотойгоор улс төрийн харилцаа, хэм хэмжээний бодит байдлыг илүү нээлттэй болгож иргэдийн өөрсдийнх нь хяналт тогтоохыг хүсэмжлэх хандлага нэмэгдсээр байна. Авторитар, тоталитар дэглэмийн үед ард түмэнд дэвшилтэт хэмээн хүчээр тулган хүлээлгэсэн нэг үзэл баримтлал, үнэт зүйлс, дэг журам тэдний хувьд улс төрийн үнэн биш байдаг нь батлагдсан зүйл. Харин ардчиллын нөхцөлд олон ургалч үзэл баримтлал, үнэт зүйлсүүд нийгмийн зайлшгүй хэрэгцээ шаардлага болон урган гардаг. Учир нь тэдгээр үзэл баримтлал, үнэт зүйлсийн алийг нь хэзээ, хэрхэн ашиглах нь иргэд сонгогчдын улс төрийн норматив мэдлэгийн хүрээг зайлшгүй шаарддаг зүйл юм. Бодит нөхцөл байдлын хүрээнд хүмүүсийн чөлөөт сонголт, хийсвэр талархал дэмжлэгүүд улс төрийн норматив мэдлэггүйгээр улс төрийн үйл явцыг хааш нь ч эргүүлж мэднэ.

Улс төрийн шинжлэх ухааны мэдлэгийн нэгээхэн хэсэг нь норматив шинж чанартай байдаг бол түүний үндсэн хэсэг нь улс төрийн бодит үйл явц, үзэгдлийг үнэн зөв тусгаж, хүмүүсийн ухамсраас үл хамаарч байдаг. Өөрөөр хэлбэл, судлаачид эмпирик баримт сэлтэд тулгуурлан үнэнийг магадлан шалгаж тогтоосоноор тухайн үзэгдэл, үйл явцын бодит үнэнийг илрүүлэх зорилго тавьж ажилладаг. Энэ нь улс төрийн үйл явцад бодит үнэн зөв үнэлэлт, дүгнэлт өгөөд зогсохгүй тэдгээрийн ирээдүйн талаарх таамаглал, прогнозыг бий болгодог. Үүний тулд судлаачид улс төрийн шинжлэх ухааны судалгааны аргуудыг хэрэглэж нэг адил үр дүнд хүрэх бололцоотой байдаг. Шинжлэх ухааны улс төрийн мэдлэг нь тодорхой үзэгдлүүдийг тайлбарлах, урьдчилан хэлэхэд чиглэгдэнэ. Улс төрийн объектив үнэн нь сонгуулийн үр дүн, олон нийтийн санал асуулга, бодит үзэгдэл үйл явц, улс төрийн мэдээ баримтууд, мөн хандлага байдлаар илэрдэг улс төрийн зүй тогтлууд юм. Энэ нь улс төрийн талаарх хүмүүсийн ердийн мэдлэгийн түвшнээс өөр юм. Улс төрийн шинжлэх ухааны мэдлэгийг хүмүүст ойлгуулж, мэдрүүлэх нь тийм ч хялбар бус ажил. Харин их дээд сургуулиар дамжин улс төрийн суурь боловсрол эзэмшсэн хүмүүст ойлгуулах нь харьцангуй хялбар байж магадгүй.

Улс төрийн шинжлэх ухаан нь хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг иш үндэс болгон улс төрийн байгууллыг үнэлэн цэгнэж, хамгийн сайн, хамгийн үр ашигтай улс төрийн институт, удирдлагын арга барилыг эрж хайдаг. Иймээс ч янз бүрийн улс төрийн онолыг үнэн үү эсвэл хуурамч уу гэхээс илүү сайн ба муу, нийгэмд ашигтай эсвэл хортой, энэрэнгүй ба энэрэнгүй бус, дэвшилтэт ба харгис гэж үнэлдэг. Тэдгээрийн үнэн магадлалт чанар нь хүмүүсийн хоорондын гэрээний хүлээн зөвшөөрөх, үнэлэх явцаас хамаарах бөгөөд энэ нь тэдний улс төрийн мэдлэг, туршлагатай холбоотой. Тиймээс иргэдийн улс төрийн мэдлэг нь мэдээлэл, хууль, дүрэм журам, улс төрийн үзэгдэл, үйл явцын объектив шинж чанар, улс төрийн субъектүүдийн хийсвэр болон бодит сэтгэлгээний хэв маяг, шинжлэх ухааны онолын болон эмпирик мэдээлэл, практик суурь мэдлэг зэргээс бүрддэг. “Онолын мэдлэг нь хоорондоо уялдаа холбоо бүхий системлэг мэдлэг... бол ...ажиглалт, сорилт, баримт болон тоон мэдээллүүдээс олж авсан мэдлэгийг эмпирик”¹²¹ мэдлэг гэнэ.

Мэдээлэл болон мэдлэгийн гол ялгаа нь тэдгээрийн бүтэц, үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явцад өөрчлөлт гарахад хүргэж болох шинэ баримт, суурь ойлголт сэтгэлгээ, шинэ үзэл баримтлалтай холбоотой. Өөрөөр хэлбэл, улс төрийн мэдлэг бол улс төрийн үзэгдэл үйл явцын талаарх төлөвшсөн ойлголт байдаг бол, улс төрийн мэдээлэл нь мэдлэгийг өөрчлөх, баталгаажуулах аль эсвэл хэрхэхийг шийдэж чадахгүй байдалд оруулсан төвөгтэй сонголтыг байнга авч ирдэг.

Ардчилсан улс орнуудад улс төрийн шинжлэх ухааны мэдлэг, боловсрол хүн амыг улс төрийн талаар нийгэмшүүлэх, тэдний иргэнлэг шинж, ардчилсан улс төрийн соёлыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Ардчилсан засаглал нь улс төрийн шинжлэх ухааны мэдлэг, боловсролоор дамжуулан иргэдийн улс төрийн оролцоо, идэвхийг нэмэгдүүлсэнээр тэдний улс төрийн мэдлэгийг нэмэгдүүлээд зогсохгүй засаглалын шийдвэр, хэрэгжилтийг оновчтой болгох өдөөн-зохицуулалтын үүрэг гүйцэтгэн, улс төрийн үйл байдалд шууд нөлөө үзүүлж байдаг. Үүний тулд ардчилал нь олонхийг төлөөлсөн засаглалд тулгуурладаг. Тиймээс ардчилсан засаглал нь иргэд, сонгогчдоос улс төрийн тодорхой мэдлэг боловсролын шалгуурыг байнга шаардаж байдаг онцлогтой.

Үүнд:

- Улс төрийн боловсрол: - Иргэд сонгуулиас сонгуулийн хооронд улс төрийн мэдлэг, туршлага хуримтлуулах нь орчин үеийн хурдтай өөрчлөгдөж буй нийгмийн шаардлагыг тэр бүр хангаж чадахгүйд хүрч байна. Иргэд, сонгогчид улс төрийн ерөнхий суурь мэдлэг, боловсролгүйгээр сонголт хийх нь сугалаа сугалахтай адил бөгөөд тэдний тодорхой мэдлэггүй сонголт аз сорисон туршилт

¹²¹ Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. х. 29

мэт байж болохгүй. Учир нь сонгогчид ихэнхдээ улс төрийн элдэв манипуляц, PR-т хялбар автаж, алдаатай сонголт хийснээр амьдрал хувь заяа нь дордох явдал түгээмэл тохиолддог. Тиймээс иргэдэд улс төрийн суурь боловсрол олгох нь ардчилсан нийгмийн зайлшгүй шаардлага мөн;

- Улс төрийн хариуцлага: - Иргэд, сонгогчид нэгэнт сонгосон л бол, сонголтынхоо хариуцлагыг дараагийн сонгууль хүртэл хүлээх ёстой бөгөөд эс тэгвэл тоглоомын дүрэм зөрчигдөж, хувийн хариуцлагагүй, тэвчээргүй, замбараагүй, нийгэмшилтгүй, хууль дүрэмгүй анархизм ноёрхох болж, Томас Гоббсын хэлснээр “бүхний эсрэг, бүхний дайны байдал” үүсч болох юм. Нөгөө талаар тэсвэрлэхийн аргагүй засаглалыг хугацаанаас нь өмнө солих “шалгуур” механизмтай байх нь зүйд нийцнэ;
- Улс төрийн соёл: - улс төрийн үйл явцад оролцох иргэдийн оролцоо хүчирхийлэл, хүмүүнлэг бус явдлаас ангид улс төрийн оролцооны соёлыг төлөвшүүлсэн хэлэлцүүлэг, форум, төлөөлөл зэрэг шаардлага, дэмжлэг, зөвшилцөлийн олон механизмтай байх нь орчин үеийн глобальчлагдсан иргэншлийн шаардлага болж байна;
- Хүлээцтэй байх чанар: - Ардчиллын нөхцөлд олон урьгалыч үзэл, улс төрийн бодлогын альтернатив, эерэг, сөрөг мэдээллүүд байх нь зайлшгүй бөгөөд иргэд, сонгогчид мэдээлэлд хүлээцтэй хандаж сонголтоо зөв хийх нь чухал бөгөөд энэ нь ардчилсан нийгэм дэх иргэдийн өөрсдийнх нь харилцааны мөн чанарыг илэрхийлнэ;
- Өрсөлдөх чадвар: - Ардчилсан засаглал нь амьдрах чадвар бүхий дунд давхрагынханы эрх зүйт төр бөгөөд хэрэв нийгмийн гишүүдийн олонхийн амьжиргаа доод төвшинд байгаа нөхцөлд төрийн зохицуулалт, социал төрийн бодлогоор хүн амын олонхийг дундаж төвшинд хүргэж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ;

Иргэдийн улс төрийн боловсрол нь олон нийтийн мэдээллийн хэрэгслэлийн мэдээллүүд ба улс төрийн бодит байдлыг харьцуулан улс төрийн шийдвэр, үйл явцад бодит оновчтой дүгнэлт хийх, зөв зохистой шийдвэрийг дэмжих, эсвэл буруу шийдвэрийг эсэргүүцэх зэрэг улс төрийн оролцоо бүхий нээлттэй нийгмийг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой. Иргэдийн улс төрийн боловсрол өндөр байгаа нөхцөлд тэд бодит байдлыг зөв тусгаж, бүтээлчээр зохион байгуулагдах үйл явцад дэмжлэг үзүүлэн засаглалын легитимийг бэхжүүлдэг. Тухайлбал, улс төрийн суурь боловсрол эзэмшсэн иргэд тухайн нөхцөлд улс төрчдийн гаргаж буй шийдвэрт үнэлэлт дүгнэлт өгч, шүүмжлэн засварлах чадвартай байдаг. Энэ нөхцөлд иргэдийн улс төрийн идэвх, оролцоо эрх баригчдын шийдвэрт нөлөө үзүүлж нийгэм, улс төрийн хүрээний томоохон алдаанаас сэргийлэх боломжийг олгож байдаг. Харин эсрэгээрээ буюу иргэдийн улс төрийн боловсролын түвшин доогуур байгаа нөхцөлд тэд улс төрчдийн гаргаж буй шийдвэрийн мөн чанарыг танихгүй бөгөөд ихэнх тохиолдолд улс төрчдийн хувь хүний мөн чанар, ёс суртахууныг илүү шүүмжилдэг байна. Энэ нөхцөлд улс төрчид иргэд, сонгогчдын өмнө төгс төгөлдөр хүн мэт жүжиг тавих бөгөөд далдуур ёс суртахуунгүй, явцуу ашиг сонирхолд үйлчилсэн шийдвэрийг гаргаж байдаг. Улс төрчдийн ийм үйлдлийг улс төрийн боловсролгүй иргэд тэр дор нь мэдэж чадахгүй бөгөөд асуудал хүндэрсэн, амьдрал дордсон нөхцөлд сая ойлгож эхэлдэг. Өөрөөр хэлбэл, улс төр, эдийн засгийн хямрал нүүрлэсэн нөхцөлд л хүссэн хүсээгүй ойлгох болно. Харамсалтай нь тэд хямарсан улс төр, эдийн засгийн тогтолцоог аврахын тулд хэн нэгэн дарангуйлагчийг хүсэмжилж эхэлдэг. Энэ бол дэлхийн олон орнуудын түүхэнд тохиолдож байсан үзэгдэл юм. Үүгээр иргэдийн улс төрийн боловсролын танин мэдэхүйн хандлагад үнэлэн цэгнэх үүрэг нь илэрч байдаг.


Өнөөдөр олон улсын хамтын нийгэмлэг улс төрийн тулгуур үндэс болсон нийт хүн төрөлхтний хүмүүнлэг үнэт зүйлс, хүнийг дээдлэх хэмжүүрийг хүлээн зөвшөөрч байгаа нь дэлхий дахины улс төрийн үйл явцад улс төрийн шинжлэх ухааны танин мэдэхүй, түүний үзүүлэх хүмүүнлэгийн идэвхтэй нөлөөг өргөжүүлж байна. Улс төрийн шинжлэх ухааны мэдлэг, зөвлөмжийг удирдлагын практик үйл ажиллагаанд хэрэглэх нь улс төрийн засаглалыг бүхэлд нь хүнлэг энэрэнгүй болгох зам мөн. Улс төрийн үйл явцын шинжлэх ухааны үндэслэл нь улс төрийн соёлын хөгжлийн төвшний нэн чухал үзүүлэлт юм. Улс төрийн шинжлэх ухаан улс төрийн амьдралыг тухайлбал, улс төрийн институт, улс төрийн харилцаа, улс төрийн удирдлагын шийдвэр, үйл байдал зэргийг үр ашигтай, оновчтой болгох үүрэг гүйцэтгэдэг. Уг шинжлэх ухаан улс төрийн өөрчлөлтийн онолын үндэс болдог бөгөөд улс төрийн аль нэг институтыг бий болгох, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохын зайлшгүйг үндэслэн төрийн удирдлагын оновчтой загвар, нийгэм улс төрийн зөрчил, мөргөлдөөнийг харьцангуй зохистой шийдвэрлэх технологийг боловсруулах үүрэг хүлээдэг.

Коммунист үзэл суртал дангаар ноёрхсон авторитар, тоталитар дэглэмтэй улс орнуудад улс төрийн боловсролыг нэг үзэл суртлын хүрээнд хязгаарлаж, албан ёсны боловсролын системээс гадна нам, үзэл суртлын бодлогоор нийгмийн бүх хүрээнд хатуу хяналттайгаар хүчээр төлөвшүүлэх оролдлогыг хийж ирсэн байдаг. Тухайлбал, энэ чиглэлээр монгол оронд нам, төр засгийн байгууллагуудаас ухуулга сурталчилгаа, ном зохиол болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн байгууллагууд, боловсролын бүх шатны тогтолцоо зэрэг ашиглаж болох бүхий л чиглэлээр улс төрийн боловсрол олгож, коммунист бие хүнийг төлөвшүүлэх зорилт тавьж байсан. Эдгээр нь зөвхөн туйлширсан нэг үзэл суртлыг дэмжин нийгмийг хүн төрөлхтөний жам ёсны хөгжлөөс гажуудуулсан төдийгүй хувь хүний эрх, эрх чөлөө, хувийн өмч, нийгмийн давхражилт зэрэг байх ёстой олон үнэт зүйлсийг үгүйсгэснээр нийгмийн динамик шинжийг алдагдуулж системийг бүхэлд нь нурахад хүргэсэн.

Нийгмийн үнэт зүйлс, дадал чадвар болон мэдлэг бусдад дамжуулах албан ёсны үйл явцыг боловсрол гэж тодорхойлсон байдаг.¹²²Иргэдийн улс төрийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх үйл явц нь өнөөгийн ардчилсан улс орнуудад албан ёсны ба албан ёсны бус боловсролын тогтолцоо болон практик үйл ажиллагаагаар хэрэгжиж иржээ. Иргэдэд улс төрийн мэдлэгийг эзэмшүүлэх албан ёсны тогтолцоо нь боловсролын системээр дамжин хэрэгждэг бол, албан бус нь янз бүрийн төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ном зохиол болон иргэний нийгмийн идэвхжлээр хэрэгждэг байна. Албан ёсны боловсролын систем нь ерөнхий боловсролын сургуулиас эхлэн их дээд сургууль хүртэлх хугацаанд улс төрийн шинжлэх ухааны суурь мэдлэгийг иргэдэд олгодог. Тухайлбал, ерөнхий боловсролын сургууль нь суралцагч хүүхдүүддээ түүх, нийгэм судлалын хичээлүүдээр нийгмийн улс төрийн харилцаа, төр улсын талаарх албан ёсны хэм хэмжээг мэдлэгийг философи, эдийн засаг, хууль эрх зүйн анхан шатны мэдлэгтэй холбон танин мэдүүлэх үүргийг гүйцэтгэдэг. Их дээд сургуулиуд нийт оюутануудад ерөнхий суурь хичээлийн агуулгад улс төрийн шинжлэх ухааны үндсэн ойлголтуудыг заадаг бол, мэргэжлийн болон ахисан түвшний сургалтад тодорхой бүлэг оюутнуудад нарийвчлан мэргэшүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх чадварт сургадаг боловсролын тогтолцоо юм. Улс төрийн шинжлэх ухааны мэдлэг нь оюутнуудад эртний болон өмнөх ба одоо цаг үеийн гүн ухаантнуудын янз бүрийн байр суурьнаас хандсан сэтгэлгээний үзэл номлол, онолын болон эмпирик баримтуудад тулгуурласан ойлголт, үзэл баримтлал, хандлага зэрэг танин мэдэхүйн категориудыг эзэмшүүлсэнээр нийгэм, улс төрийн үйл явцад бие даасан үнэлэлт, дүгнэлт өгч чадах боловсролтой иргэдийг төлөвшүүлэх үндсэн үүрэгтэй. Энэ нь орчин үеийн ардчилсан нийгэмд амьдарч байгаа иргэдийн хувьд улс төрийн шинжлэх ухааны онолын мэдлэгийг олж авах, эзэмших өргөн боломжийг агуулж байдгаараа их ач холбогдолтой.

Улс төрийн шинжлэх ухааны практик мэдлэг нь иргэд өөрсдөө нийгмийн амьдралаас олж авдаг шууд улс төрийн туршлага буюу түгээмэл шинжтэй ердийн ойлголтууд юм. Энэ нь өнөө үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин иргэдэд хүрдэг улс төрчдийн хэлсэн үг, яриа, илтгэл, дурсамж, улс төрийн тоймчдын тайлбарлал, сөрөг хүчний байр суурь, улс төрийн үйл явцын талаарх янз бүрийн байр суурьнаас харуулсан мэдээллүүд, батлан гаргасан хууль эрх зүйн тогтолцооны үр дүн, эсвэл үр дагавар, иргэдийн улс төрийн оролцоо, нийгмийн улс төр, эдийн засаг, соёл болон социал амьдралын түвшин зэрэг олон обьектив, субъектив хүчин зүйлийн хамаарал дахь иргэдийн ерөнхий ойлголтоос үүссэн мэдлэг юм. Иргэдийн улс төрийн талаарх ийм ердийн мэдлэг нь ихэнхдээ мэдээллийг сэтгэл хөдлөл, уламжлал, хялбаршуулсан логик болон тухайн нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээгээр хүлээн авсан өнгөц мэдлэг юм.

Бүдүүвч 1. Иргэдийн улс төрийн ерөнхий мэдлэг бүрэлдэх үйл явц



Улс төрийн талаарх иргэдийн ердийн мэдлэг нь рационал бус бөгөөд оршин буй нийгмийнхээ улс төрийн үзэгдэл, үйл явцын утга учрыг ихэнхдээ танин мэдэж ойлгох чадваргүй байдаг. Тухайн нийгэм нь улс төр, эдийн засгийн хямралд орсон үед хүмүүс илүү ихээр улс төржиж, улс төр, эдийн засгийн үйл явцыг танин мэдэхийг эрмэлздэг хэдий ч тэдгээрийн утга учрыг ердийн мэдлэгийн хүрээнд олох боломж хязгаарлагдмал байдаг. Тиймээс иргэд улс төрийн туршлагад суурилсан ердийн мэдлэгийн хүрээнд хямралаас гарах гарцыг зааж өгөх хэн нэгэн улс төрч, эсвэл улс төрийн хүчнийг эрэн хайж, тэдний заасан чиглэл рүү уухайлан түрж, цус урсгасан хувьсгал хийхэд бэлэн байдаг онцлогтой. Гэхдээ улс төрийн амьдралын алдаа, оноон дээр бий болсон ердийн мэдлэг нь ард түмний оюун санаа, ухамсарын гүнд хадгалагдсанаар аливаа алдааг давтахаас сэргийлэх магадлалыг нэмэгдүүлдэг ач холбогдолтой зүйл юм. Албан ёсны ба албан ёсны бус боловсролын

¹²² Н.Смельзер. Социологи. УБ., 2001. х 407. ФСЭХ.

тогтолцоо, уламжлал болон практик үйл ажиллагаанаас олж авсан иргэдийн мэдлэгийг тэдний улс төрийн ерөнхий мэдлэг гэж ойлгож болно.

Улс төрийн талаарх шинжлэх ухааны болон практик мэдлэг нь иргэдийн улс төрийн боловсрол, соёлын хэмжээг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй. ХХ зуунд улс орнууд иргэдийнхээ боловсролыг хөгжүүлэхийн тулд, үнэ төлбөргүйгээр нийтээр нь бичиг үсэгтэн болгох хөдөлгөөн, бүх нийтийг бүрэн бус болон бүрэн дунд боловсролтой болгох төрийн бодлого хэрэгжүүлэх зэрэг олон арга хэмжээ авч ирсэн түүхтэй. Үүний үр дүнд бүх нийтийн боловсролын тогтолцоо улс орон бүрт бий болж, харьцангуй боловсролтой иргэд ХХI зууны нүүр царайг тодорхойлох болсон.

Нийгмийн ухамсрын суурь үндэс нь хүний ухамсар, оюун санаа юм. Улс төрийн ухамсар бүрэлдэж төлөвших нь хүний мэдлэг, соёл боловсрол, нийгэмшилтээс гадна хувь хүний улс төр нийгмийн идэвх, оролцоо, уг оролцоогоо амьдралынхаа бодит хэрэгцээ шаардлага болгох чадвар зэрэг олон зүйлээс хамаарна.¹²³ Хүмүүсийн ухамсарын хүрээ улс төрийн мэдлэг боловсрол нэмэгдэхийн хэрээр өргөжин тэлж байдаг. Нийгмийн улс төрийн харилцаа холбооны дутмаг хөгжил нь иргэдийн эрх, эрх чөлөөгөө илэрхийлж, хэрэгжүүлэх сонирхлыг бууруулж, тэдний улс төрийн ухамсрыг төрийн удирдлагын механизмаас хөндийрүүлэхэд хүргэдэг. Үнэн хэрэгтээ аливаа хувь хүний улс төрийн ухамсар нь нийгэмд учирч буй бэрхшээл, хямралт үйл явц, бодит байдлыг мэдэрч бухимдал, дургүйцлээ илэрхийлэх юмуу, эсхүл аливаа сонирхлын бүлэг, улс төрийн нам, хүчний зорилго, үзэл баримтлалыг дэмжиж ухамсарласны үндсэн дээр бүрэлддэг. Энэ утгаараа улс төрийн мэдлэг, боловсрол нь улс төрийн ухамсарыг төлөвшүүлэхэд их ач холбогдолтой. Тухайлбал, эрх чөлөө, тэгш байдал, хүний эрх, ардчилал, шударга ёсонд итгэх итгэл үнэмшил, тэдгээрийн талаарх мэдлэг дээр аль нэгэн улс төрийн үзэл номлолыг талархан дэмжих, эсхүл эсэргүүцэх замаар улс төрийн ухамсар бүрэлддэг.

Тиймээс улс төрийн ухамсар танин мэдэхүй, мэдээллийн, үнэлэмжийн, зохицуулах, дайчлах болон нэгтгэх чиг үүргүүдтэй бөгөөд тэдгээр нь бие хүний хувьд ч, нийгмийн төвшинд ч харилцан адилгүй хэрэгжиж байдаг. Улс төрийн бодит байдлыг үзэл баримтлал, онол, номлол, сэтгэл санааны мэдрэмжгүйгээр төсөөлж ухаарах боломжгүй. Үүнээс гадна хүмүүс улс төрд оролцох нөхцөл байдалд үе үе орохдоо сонгууль, улс төрийн лоозон, мөрийн хөтөлбөрийн олон янз байдал, ухуулга сурталчилгааны учрыг нь олж мэдэхийг эрмэлздэг билээ. Тийм сонголтын нөхцлийг бүрдүүлэхэд улс төрийн ухамсрын нөлөөлөл ямар байдгийг мэдэх явдал нь гол юм.¹²⁴

Аливаа сургалтын бүхий л үйл ажиллагаа хүмүүсийг нийгэмшүүлэхэд чиглэгддэг. Гэсэн хэдий ч сургалтын агуулга суралцагчдын ашиг сонирхолд тэр бүр нийцдэггүй явдал байдаг. Гэхдээ энэ цаг үед ардчиллын гурав дахь давалгаа дэлхийн улс орнуудад ардчилсан засаглал тогтоох үйл явцыг өргөжүүлсээр байна. Энэ нөхцөлд иргэдийн улс төрийн боловсрол, улс төрийн нийгэмшилт улам чухлаар тавигдах болсон. Аливаа ард түмний улс төрийн мэдлэг, боловсрол нь улс төрийн ухамсар, улс төрийн нийгэмшилт, улс төрийн соёлоор илэрхийлэгддэг.

Улс төрийн харилцаа нь нийгмийн бүх гишүүд, хүн нэг бүрийн ашиг сонирхлыг ямар нэг хэмжээгээр хөндөж байдаг онцлогтой. Хүмүүсийн үйл ажиллагаа ямагт нийгмийн шинжтэй...хүмүүсийн харилцан үйлдлийн хүчинд социаль үйл ажиллагаа хэрэгжиж байдаг¹²⁵. Өөрөөр хэлбэл, хүмүүс улс төрийн харилцаанд орж, түүний үйлчлэлийн механизмууд тухайлбал, өөрсдийн амьдарч буй улс орны болон орон нутгийн засаг захиргааны удирдлага, “хэний гарт атгагдаж байгаа, хэн шийдвэр гаргаж байгаа, түүнийг биелүүлэх үүрэг хариуцлагыг хэн хүлээж байгаагийн талаар хамгийн ерөнхий ч гэсэн төсөөлөлтэй байх ёстой”¹²⁶ болдог байна. Хүн тухайн нийгэмд ноёрхож буй улс төрийн соёлыг өөртөө цомтгон эзэмшсэнээр засаглалын харилцааны олон талтүйл явцад татагдан орж, өөрийгөө улс төрийн соёлын нэг субъект болгон төлөвшүүлсэнээр амьдралаа авч явдаг. Үүнийг манай монголчууд эртнээс нааш “Усыг уувал ёсыг нь дагадаг” гэсэн үг хэллэгээр илэрхийлж ирсэн бөгөөд энэ нь хүмүүсийн улс төрийн нийгэмшилтийн тухай ойлголт юм.

Улс төрийн нийгэмшилт бол улс төрийн зан үйл, улс төрийн үзэл баримтлалд нөлөөлж байдаг хүний амьдралын бүх шат дахь албан ёсны ба албан ёсны бус, улс төрийн болон улс төрийн бус, зорилготой ба зорилгогүй улс төрийн сургалтын систем юм.¹²⁷ Өөрөөр хэлбэл, хүний амьдралын үйл явцад гэр бүл, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, иргэний нийгмийн байгууллагууд, хөдөлмөрийн хамт олон, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, улс төрийн намууд, төр, засгийн байгууллагууд ямар нэг хэлбэр, хэмжээгээр оролцож байдаг. Энэ утгаар нь улс төрийн нийгэмшилтийг улс төрийн үнэт зүйлс, итгэл үнэмшил, дадал туршлага зэргийг ухамсартай, чиглэсэн зорилготойгоор нэвтрүүлэх буюу хүмүүст эзэмшүүлэх явдал гэж ойлгож болно. МЭӨ 430 онд Перикл “цөөхөн хүмүүс улс төрийг бүтээж чадах боловч бүх нийтээрээ түүний тухай өгүүлж чаддаг” гэжээ.

Улс төрийн нийгэмшилт бол объектив агуулгатай, маш нарийн төвөгтэй, зөрчилтэй үйл явц юм. Өөрөөр хэлбэл, улс төрийн нийгэмшилтийг зөвхөн улс төрийн шинжлэх ухааны мэдлэг боловсролын сургалт, улс төрийн талаарх иргэдийн ердийн практик мэдлэг хоёроор хязгаарлаж болохгүй. Учир нь иргэдийн улс төрийн нийгэмшилтэд улс төрийн дэглэм түүний мөн чанар, тухайн нийгмийн уламжлалт үнэт зүйлс, шашин шүтлэг, газар зүйн детерминизм, нийгмийн өөрчлөлт, шинэчлэл зэрэг олон обектив, субъектив хүчин

¹²³ Г.Цэнд-Аюуш. Улс төрийн ухамсар. УБ., 2012. х. 26

¹²⁴ Г.Цэнд-Аюуш. Улс төрийн ухамсар. УБ., 2012. х. 27


¹²⁵ Маркс.К. Энгельс.Ф. Соч.,т. 27. с. 402

¹²⁶ Ц.Ганболд. Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2001. Х

¹²⁷ Баталов Э. Политическая культура современного американского общества. М. 1999.

зүйлс нөлөөлдөг. Тухайлбал, авторитар дэглэмтэй улс оронд хүмүүсийн улс төрийн төлөвшил, нийгэмшилт нь тухайн улс төрийн систем, түүний шинж чанарыг хадгалахад чиглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, иргэний улс төрийн үзэл баримтлалыг хязгаарласан “албадлага”-ын шинжтэй улс төрийн төлөвшлийг бүрдүүлж өгдөг. Авторитар дэглэм нь улс төрийн плюрализмын хөгжлийг хязгаарлан нийгмийн анги давхрагуудад зориулсан улс төрийн төлөвшил, соёлын нэг хэв загварыг бий болгож, иргэдийн олонхийг дэглэм, түүний эрх баригчдад тааламжтай хандахыг тулган хүлээлгэдэг. Ийм нөхцөлд нийгмийн үндсэн хэсэг улс төрийн асуудлыг шийдвэрлэхээс зайлуулагдсан, улс төрийн идэвхийн түвшин доогуур байна. Эндээс тухайн нийгэмд улс төрийн хуучны уламжлалт болон албат (харьяат¹²⁸)-ын соёл давамгайлах нь тодорхой болдог. Улс төрийн уламжлалт соёлын гол үнэт зүйл нь тэдний овог, аймаг, үндэстэн хэлбэрээр харьяалагдаж байдаг угсаатны ашиг сонирхол юм. Энд хувь хүн өөрийгөө бие хүн гэж ухамсарладаггүй, угсаатны нийтлэгээс ялган салгаж чаддаггүй байна. Г.Алмонд, С.Верба нар “тодорхой нийгмийн соёлын систем бол улс төрийн эцсийн шалтгаан мөн” гэсэн түгээмэл зарчмыг тайлбарласан.¹²⁹

Бүдүүвч 2. Иргэдийн улс төрийн ерөнхий мэдлэгийн нийгэмд гүйцэтгэх үүрэг



Ардчилсан дэглэм нь хувь хүний эрх, эрх чөлөө, иргэдийн янз бүрийн үзэл бодлыг хүндэтгэсэн улс төрийн плюрализмыг хүлээн зөвшөөрдөг учраас иргэд улс төрд идэвхтэй оролцож, оролцооны соёл давамгайлах хандлагатай төлөвшдөг. Шийдвэр гаргахад хүмүүс оролцох, сонгуулийн эрх эдлэх, төрийн бүтцийг хянах бололцоо бэлхэн байх нь оролцооны улс төрийн соёлын онцлог шинж юм. Ардчилсан засаглал дахь иргэдийн улс төрийн туршлагыг бүрдүүлдэг үндсэн механизмууд нь сонгууль, иргэдийн оролцоо, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө юм. Сонгууль бол ардчилсан дэглэмтэй улс орнуудын бүх шатны (парламентын, ерөнхийлөгчийн, орон нутгийн) төр засаглалаа байгуулах иргэдийн улс төрийн оролцооны албан ёсны хэлбэр юм.

Иргэдийн улс төрийн оролцоо нь дан ганц сонгуулиар хязгаарлагдахгүй бөгөөд иргэд улс төрийн шийдвэрт нөлөөлөх олон арга хэрэгслүүдийг ашиглах боломжоор хангагдсан байх ёстой. Иргэд үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх нь ардчилсан засаглалын суурь зарчим юм. Иргэн ба нийгэм бүхэлдээ улс төрийн үйл явцад оролцох арга замаар улс төрийн соёлын цаашдын хөгжлийг хангахуйц улс төрийн шинэ шинэ туршлага эзэмшиж байдаг. Жан Жак Руссогийн “Нийгмийн Гэрээ” бүтээл нь бүхэлдээ улс төрийн шийдвэр гаргах түвшинд болон өөрийн онолын хүрээнд ч хувь хүний, иргэн бүрийн оролцоог чухалчилсан байдаг. Энэ нь ердөө институцийн байгуулал дээр хавсаргасан нэмэлт биш бөгөөд, институциудын үйл ажиллагаа болон түүнд оролцож байгаа бие хүмүүсийн сэтгэл зүйн чанар, хандлагын хооронд харилцан хамаарал байдаг гэдгийг баталсан төдийгүй, улс төрд оролцогч этгээдүүдэд сэтгэл зүйн нөлөөтэй юм.¹³⁰ Ж.Ж.Руссогийн онолд оролцооны үүргийг өөр хооронд нь ялгаатай тайлбарлаж, улс төрийн систем дэх оролцооны асуудалд тодорхой эдийн засгийн нөхцөл байх тухай санал дэвшүүлсэн. Руссо нийгмийг жижиг фермийн эздээс бүтэх ёстой төдийгүй, эдийн засгийн хувьд эрх тэгш, бусдаас үл хамаарсан байхыг зөвлөсөн. Түүний систем нь туйлын тэгш байдлыг шаарддаггүй бөгөөд ялгаатай байдал байх авч, тэр нь улс төрийн тэгш бус байдалд хүргэхгүй байх ёстойг сануулж байдаг. Ухаандаа, ямар ч хүн хэн нэгнийг худалдаж авахаар баян биш, ямар ч хүн өөрийгөө худалдахаар ядуу тартагтаа тулсан биш байх ёстой бөгөөд иргэний хамгийн ариун эрх нь ямар нэгэн зүйлийг эзэмшдэг байх явдал гэсэн ойлголттой байх ёстой. Улс төрийн тэгш байдал, улс төрийн хараат бус байдал нь үүнээс хамаарах тул тэр нь иргэдийн аюулгүй, бие даасан байдлын баталгаа болно¹³¹ гэж үзсэн.

Энэ нөхцөлд л хувь хүмүүсийн зохих хандлага, сэтгэлзүйн шинж чанарууд төлөвшлөө олно. Тэрхүү төлөвшилт нь чухамдаа оролцооны үйл явцаар дамжин хэрэгжинэ. Тийм учраас ардчиллын онолд оролцооны гүйцэтгэх үүрэг нь иргэдийн сэтгэлзүйн бэлтгэл болон ардчиллын чадамж, процедурыг эзэмшихүйц практик мэдлэг олгохын аль алийг багтаасан өргөн утга бүхий боловсруулан гэгээрүүлэх чадвартай юм. Тиймээс ч оролцоот системийн тогтвортой оршихын тухайд онцгой асуудал байдаггүй. Энэхүү систем нь оролцооны үйл явцын боловсруулан гэгээрүүлэх үр нөлөөгөөр дамжин өөрөө өөрийгөө тэтгэж байдаг онцлогтой. Оролцоот үйл явц нь оролцоонд шаардагдах шинж чанаруудыг өөрөө хөгжүүлэн тэтгэж байдаг. Өөрөөр хэлбэл, хүмүүс хэдий чинээ оролцоотой байна төдий чинээ оролцоонд хамрагдах чадамжаа сайжруулж байдаг. Иргэдийн оролцоонь хамтын шийдвэрийг хүлээн авахад дэм болдог бөгөөд үйл ажиллагааг нэгтгэн нийлүүлэх ач холбогдолтой байдаг.


¹²⁸ Харьяатын улс төрийн соёл нь улс төрийн үйл явцад оролцогсод дуулгавартай байх, захирагдах, биелүүлэх явдлаар тодохойлогддог бөгөөд уг чанартаа албадлагын объект болж хувирдаг байна.

¹²⁹ Алмонд Г., Верба С. Гражданская культура и стабильная демократия // Политические исследования. 1992. № 4

¹³⁰ К.Пейтман. “Ж.Ж.Руссо, Ж.С.Милл. Ж.Б.Х.Коул: Ардчиллын оролцооны онол”/Улс төрийн шинжлэх ухааны дээж бичиг/ Орч Ц.Батболд. УБ., 2012. X 180-185.

¹³¹ J.J.Rousseau. The Social Contract. M.Cranston (trans), 1968. P-nguin Books. 1968, 11-р тал, мөн (1913), 254-р тал.

Бүдүүвч 3. Улс төрийн оролцоо нь иргэдийн улс төрийн соёл, нийгэмшилтийг төлөвшүүлэх нь.



Ардчилсан нийгэм оршин тогтнож буй нөхцөлд иргэдийн оролцооны механизм оршин байх нь оролцоогоор дамжсан нийгэмшилт бүх хүрээнд хэрэгжих бололцоотой тийм нийгэм орших боломжийг бүрдүүлдэг. Хувь хүмүүс өөрсдийнхөө амьдрал, орчинг аль болох захирах бололцоотой байя гэвэл эдгээр хүрээн дэх эрх мэдлийн бүтцүүд нь шийдвэр гаргах үйл явцад хүмүүс оролцох бололцоотой байхаар зохион байгуулагдсан байх учиртай. Ардчилал нь үндэсний хэмжээнд нийт ард түмэн дээд зэргийн оролцоотой байхын тулд нийгмийн бусад хүрээ ардчилагдаж, улмаар нийгэмшилт буюу “нийгмийн дадлагажилт” явагдах учиртай.¹³² Иргэдийн улс төрийн оролцоо гэдэг нь шийдвэр гаргах үйл явцад (тэгш) оролцохыг хэлдэг бөгөөд “улс төрийн тэгш байдал” гэдгээр шийдвэрийн үр дүнг тодорхойлоход ижил эрх мэдэлтэй байхыг ойлгодог. Оролцооны онолд ардчилсан системийг зөв хэмээн үзэхдээ оролцооны үйл явцын хүнд тусах үр дүнгөл тулгуур болдог. Оролцооны загварыг дээд зэргийн оролт (оролцоо) шаардсан бөгөөд гаралт нь зөвхөн бодлого (шийдвэрүүд) төдий бус хүн бүрийн нийгэм, улс төрийн чадварын хөгжлийг өөртөө агуулсан, улмаар гаралтаас оролт уруу “эргэх холбоо” өгч байдаг тийм загвар гэж ойлгож болох юм.¹³³ Хүмүүсийн шинэ үе болгон нийгмийн улс төрийн соёлыг хамгаалан хадгалах, түүнийг илүү шинэ туршлагаар баяжуулан хөгжүүлэх үүрэг хариуцлагатай. Энэхүү хариуцлагыг хүн бүр мэдэрдэг, ойлгож мэддэг байх ёстой. Учир нь бие хүний улс төрийн мэдлэг, боловсрол, соёл, нийгэмшилтийн өндөр түвшин бол хөгжил дэвшлийн үндсэн нөхцөл юм.

НОМ ЗҮЙ

1. Ц.Ганболд. Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2001. ЭКИМТО ХҮ
2. Г.Цэнд-Аюуш. Улс төрийн ухамсар: түүхэн судалгаа. УБ., 2012. “ТОДМАГНАТ” ХХК
3. Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. “ТОДМАГНАТ” ХХК
4. С.Болд. Улс төрийн ухамсар. Шинэ толь. УБ., 1998, №1
5. К. Маркс, Ф. Энгельс. Түүвэр зохиол, 1 дүгээр боть, УБ., 1969.
6. Н.Смельзер. Социологи. УБ., 2001. ФСЭХ.
7. Ж.Волф. Улс төрийн философи. Орч Б.Батчулуун. УБ., 2012. НЕРКО ХХК
8. Ред. С.Норовсамбуу, С.Пүрэв, Д.Содномгомбо. Шинжлэх ухааны коммунизм. УБ., 1988.
9. Ц.Батболд, Б.Батбаатар. Иргэдийн улс төрийн оролцоо: Монгол дахь иргэний хөдөлгөөний улс төрийн чиг хандлага. Политологи сэтгүүл. № (11) 402. УБ., 2014.
10. К.Пейтман. “Ж.Ж.Руссо, Ж.С.Милл, Ж.Б.Х.Коул: Ардчиллын оролцооны онол”/Улс төрийн шинжлэх ухааны дээж бичиг/ Орч Ц.Батболд. УБ., 2012. Соёмбо Принтинг ХХК
11. Багалов Э. Политическая культура современного американского общества. М. 1999.
12. Алмонд Г., Верба С. Гражданская культура и стабильная демократия // Политические исследования. 1992. № 4
13. Den Uyl, Douglas & Rasmussen, Douglas. The Philosophic Thought of Ayn Rand. Chicago: 1986. University of Illinois Press
14. К.Пейтман. Participation and Democratic Theory. L., 1970.

¹³² К.Пейтман. Participation and Democratic Theory. L., 1970. P 22-24.

¹³³ Ц.Батболд, Б.Батбаатар. Иргэдийн улс төрийн оролцоо: Монгол дахь иргэний хөдөлгөөний улс төрийн чиг хандлага. Политологи сэтгүүл. № (11) 402. УБ., 2014. х 125.

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ УЛС ТӨРИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ НӨХЦӨЛ БАЙДАЛ

С.БАЗАРПҮРЭВ

Доктор, профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,

Улс төр судлалын тэнхим

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Улс төр судлалын тэнхимийн докторант

Key words: foreign investment, politics policy, implementation of law

Abstract: Mongolia is rich in natural resources, including metals and minerals, gas and oil with less economic resources and lack of workforce. Thus Mongolia need to attention on making policy of foriegn investment.Despite government efforts to attract foreign investments through investment policies and incentives, but several challenges still need be addressed.Furthermore, government should be focus on stable political policy.Foreign investment on the political policy of this study when looking at the frame of Institute for Government and Law will be discussed in terms of the law and regulation.

Гадаадын хөрөнгө оруулалтын (ГХО) талаар төрөөс баримтлах улс төрийн бодлоготодорхой түвшинд хэрэгжиж үр дүнгээ өгсөн. Гадаадын хөрөнгө оруулалтын талаар олон талт арга хэмжээ авч ажиллаж байгаа ч цаашид улс төрийн цогц бодлогоболовсруулах тал дээр төрөөс түлхүү ажиллах нь чухалбайна. Мөн шинээр гадаадын хөрөнгө оруулалтыг татахын зэрэгцээмонголд ажиллаж байгаа хөрөнгө оруулагчдыг анхаарах нь гадны хөрөнгө оруулагчдыг татах чухал алхам болно.

Монгол улс эдийн засаг, улс төр, нийгэм, оюун санааны өөрчлөлтийг хийсэн. Монгол улс эдгээр шилжилтийг хийж байгаа нь зүйтэй хэрэг болсон. Олон намын тогтолцоо, чөлөөт сонгууль, шинэ Үндсэн хууль, хүний эрх, эрх чөлөө зэрэг ардчилсан нийгэмд байх ёстой зүйлүүдийг хийж чадсан. Эдийн засгийн хувьд либералчлах бодлого явагдаж иргэд хувийн малтай болж өмч хувьчлалын бодлогыг хэрэгжүүлсэн. Нийгэм, оюун санааны хувьд санал бодлоо бусадтай чөлөөтэй хуваалцах, шашин шүтэх, эс шүтэх зэрэг шинэчлэл хийсэн чажилгүйдэл, инфляци, улс төрийн тогтворгүй байдал зэрэг олон шийдвэрлэх ёстой асуудал тулгамдаж байна.

Дээрх асуудлыг шийдвэрлэхэд, улс орноо хөгжүүлэх, дэд бүтэц, үйлчилгээгээ сайжруулахад зайлшгүй хөрөнгө хэрэгтэй. Энэ хөрөнгийг дотоодын эх үүсвэрээс шийдэж хүрэлцэхгүй болгадаадын эх үүсвэрийг ашиглан (гадаадаас татан авч) асуудлыг шийддэг. Үүнийг гадаадаас орж буй хөрөнгө оруулалт гэж үзнэ. Монгол улс байгалийн баялаг тэр дундаа уул уурхай, эрдэс баялаг, газрын хий, газрын тосоор арвин их нөөцтэй ч эдийн засгийн нөөц, ажиллах хүчний нөөц бололцоогоор маш дутмаг. Энэ дутуу нөөц бололцоогоо нөхөхийн тулд гадаадын хөрөнгө оруулалтад анхаарлаа хандуулан цаашид түүнийг баримтлах улс төрийн бодлогыг нарийвчлан судлах нь зайлшгүй.

Монгол дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт 2011 онд хамгийн дээд цэгтээ буюу 4.7 тэрбум ам.долларт хүрснээс хойш буурах хандлагатай байна. 2011 оноос 2015 оны эхний улиралд ерөнхийдөө 85 хувиар буурсан ба 644 сая ам.долларт хүрсэн. Энэ нь эдийн засгийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлөлсөн¹³⁴. Жишээлбэл, ДНБ 2011 онд 17,3% байсан бол 2012 онд12,3%, 2014 онд 7,8%, 2015 онд 4,4%¹³⁵ хүртэл буурсан нь ГХО багассантай мөн холбоотой. ГХО-ын 80%¹³⁶ нь жилээс жилд уул уурхайн салбарт төвлөрдөг бөгөөд нүүрс, зэсийн үнэ дэлхий даяар унасан нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг бууруулахад хүргэсэн гадаад орчны хүчин зүйл болж байна. Нөгөөтэйгүүр, төрд сонгогдсон эрх баригчид, засгийн газрын зохисгүй, залгамжгүй бодлого (жишээ нь, уул уурхайн салбарт л, уул уурхайн зөвшөөрлүүдийг хураах, уул уурхайтай холбоотой гэнэтийн ашиг орлогын татварыг ихээхэн хэмжээгээр ногдуулах, уул уурхайн компанийн бизнесийн шийдвэрт хориг тавих эрх эдлэх, гэх мэт) зэрэг нь хөрөнгө оруулалт ихээхэн хэмжээгээр буурахдотоод хүчин зүйл болж байна.

¹³⁴ Монголбанк, Инфляцийн төлөв байдлын тайлан, 2015 оны 6-р сар

¹³⁵ Монгол улсын эдийн засгийн сарын тойм, 2015 оны 6-р сар

¹³⁶ 2015 оны Хөрөнгө оруулалтын орчны тухай мэдэгдэл, Эдийн засаг, Худалдааны хэлтэс

Хөрөнгө оруулалт гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг¹³⁷ хэлнэ гэж Хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэгдүгээр бүлгийн гуравдугаар зүйлийн 3.1.1-д заасан байдаг. Өөрөөр хэлбэл, Монгол улсад өөрийн бизнесээ өргөжүүлэн тэлэх, түүнээсээ ашиг олох зорилготой гадаадын орноос шууд орж ирж байгаа хөрөнгө оруулалтыг, мөн биет болон биет бус хөрөнгө гадаад орноос дотоодод орж ирээд зогсохгүй баялгийг бий болгох зорилготой, үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих явцыг хамруулан гадаадын хөрөнгө оруулалт гэж ойлгож болно. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэгдүгээр бүлгийн гуравдугаар зүйлийн 3.1.3-д “гадаадын хөрөнгө оруулагч” гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж байгаа гадаадын хуулийн этгээд, хувь хүн /Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, түүнчлэн гадаад улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн/-ийг¹³⁸ хэлнэ гэж тодорхой заасан байдаг.

Энэ утгаараа гадаадын хөрөнгө оруулалт нь дан ганц бэлэн мөнгөний урсгал биш юм. Гадаадын хөрөнгө оруулалт эргэн төлөх өр үүсгэхгүйгээр гадаад валютыг эдийн засагтаа татан оруулж, эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, шинэ технологи үйлчилгээг нэвтрүүлэх, хүний нөөцийг чадваржуулах, удирдлагын шинэ хэв маягийг авч ирэх зэрэг олон давуу талыг бий болгодог. Гадаадын хөрөнгө оруулалтыг өөрийн оронд оруулах гэж улс орнууд ихээхэн хүчин чармайлт гарган онцгой анхааран ажилладаг. Ялангуяа буурай хөгжилтэй болон хөгжиж буй орнууд. Учир нь гадаадын хөрөнгө оруулалт нь эргэн төлөх өр үүсгэдэггүй урсгал хөрөнгө учраас ашигтай талтай.

Гадаадын хөрөнгө оруулалтын эрүүл орчныг бүрдүүлэгч хэд хэдэн хүчин зүйл байдаг. Тухайлбал, эдийн засгийн либералчлалын хүчин зүйлүүд (өмчлөл, дотоодын хувь хэмжээтэй холбоотой хязгаарлалтуудыг халах гэх мэт), эрүүл бизнесийн орчны хүчин зүйлүүд (улс төр, эдийн засгийн тогтвортой байдал, үйлдвэр худалдааны гаатай бодлогууд, чадварлаг, боловсролтой ажиллах хүчин гэх мэт) болон хөрөнгө оруулалтыг дэмжих хүчин зүйлүүд (төрийн дарамтыг бууруулах, хөрөнгө оруулалтын урамшуулал гэх мэт) хэмээн бүлэглэж болно. Гадаадын хөрөнгө оруулалтыг амжилттай хэрэгжүүлсэн улсууд дээрхи нөхцлүүдийг бүрдүүлжтүүнийг тогтвортой хадгалж чадсан байдаг. Жишээ нь, Сингапур улс газар нутаг, хүн амын хувьд жижиг, мөн байгалийн баялаггүй ч гадаадын хөрөнгө оруулалтыг татсан асар туршлагатай. Стратегийн нарийн төлөвлөгөө боловсруулж, бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хөрөнгө босгохын тулд засгийн газрын агентлагуудаа чадваржуулж, чадварлаг боловсон хүчнийг татах замаар гадаадын хөрөнгө оруулалтад тулгуурласан эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгосон¹³⁹.

Монгол улс гадаадын хөрөнгө оруулалтад зах зээлээ нээсэн цагаас 2013 оны 10-р сарын 31 өдрийн байдлаар дэлхийн 112 орны 12,764¹⁴⁰ гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүртгэгдэж, 14 гаруй тэрбум ам.долларын шууд хөрөнгө¹⁴¹ оруулжээ. 2014 оны байдлаар нийт хөрөнгө оруулалтыг салбараар авч үзвэл уул уурхай олборлолт, газрын тос 73,3%, худалдаа нийтийн хоол 17%, банк, санхүү 1,4%, тээвэр 1,3%, барилгын материал, инженер 0,9%, хөнгөн үйлдвэр 0,8%, боловсрол, шинжлэх ухаан, соёл 0,13% байна. Харин хөрөнгө оруулж буй улсуудаар үзвэл БНХАУ 38%, Гонг Конг 13%, АНУ 13%, Сингапур 3%, Австрали 3%¹⁴² улс тус тус байна.

Хөрөнгө оруулж буй салбар, улсыг харьцуулан авч үзвэл уурхай олборлолт, газрын тосны салбарт 73,3%, БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалтын хэмжээ 38% байгаа нь монгол улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйл гэж үзэж байна. Тухайлбал, 2014 оны байдлаар Хятад улс нийт гадаадын хөрөнгө оруулалтын 38%-ийг эзэлж байгаа нь үндэсний аюулгүй бодлогод онцгой анхааран ажиллах хэрэгтэйг харуулав. Үндэсний аюулгүй байдлын бодлого нь гадаадын хөрөнгө оруулалтын бодлоготой шууд холбогддог. Монгол улсад хөрөнгө оруулж буй аль нэг улс нийт хөрөнгө оруулалтын 1/3-ээс ихгүй хөрөнгө оруулалт хийх ёстой байдаг. Хятад улсаас орж буй хөрөнгө оруулалт мөн уул уурхай олборлолт, газрын тосны салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалтыг хязгаарлах бус бусад улсаас татах хөрөнгө оруулалтын хэмжээ, бусад салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын эдийн засгийн аюулгүй байдлын үзэл баримтлалд: Эдийн засгийн аюулгүй байдал гэж дотоод нөөц бололцоогоо ашиглан нөхөн үйлдвэрлэл явуулах, ард түмнийхээ хэрэгцээг хангах, тусгаар тогтносон байдлаа бэхжүүлэх эдийн засгийн чадавхитай байх, шаардлагатай нөхцөлд улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах эдийн засгийн бүтэц бүрдсэн байдлыг хэлнэ гэж тусгасан байдаг. 2016 оны 1-р сарын байдлаар ДНБ 4,4% болж буурсан, Улсын өр 2010-2014.VII хооронд 3.3 дахин өссөн, үүнээс ЗГ-ын гадаад өр 1.8 дахин, дотоод өр 6.4 дахин, ТӨҮГ-ын өр 1.9 дахин тус тус нэмэгдсэн, эдгээр өрийн өсөлтийн үр дагавраар өнөөгийн үнэ цэнэд шилжүүлээгүй улсын өрийн хэмжээ ДНБ-ний 56.8%-д хүрч, 11.6 их наяд төгрөгийн өртэй, нэг хүнд ногдохоор авч үзвэл жилийн 3.9 сая төгрөг, өдрөөр нэг хүнд ойролцоогоор 11>000 төгрөгийн¹⁴³ өр ногдож байгаа зэрэг нь үндэсний аюулгүй байдалд анхаарах цаг нь болсныг харуулж байна. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлүүдээс а) бусад улс орны түүхий эдийн хавсарга болох- Тухайлбал 2014 оны байдлаар БНХАУ-руу Монгол улсын нийт экспортын 88% нь буюу анхан шатны боловсруулалт бүхий

¹³⁷ Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 он

¹³⁸ Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 он

¹³⁹ Зургаан зорилготой төлөвлөгөө: Ажлын байр өсөлтийг бий болгох боломжийг хувийн хэвшилд олгох нь, УБ хот, 2012 он

¹⁴⁰ U.S. Embassy in Ulaanbaatar Mongolia, 2014 Mongolia Investment Climate Statement, 7/28/2014

¹⁴¹ U.S. Embassy in Ulaanbaatar Mongolia, 2014 Mongolia Investment Climate Statement, 7/28/2014

¹⁴² Mongolia Investment Climate Statement /2014.07.28/

¹⁴³ <http://www.ikon.mn/n/cas>

уул уурхайн түүхий эдийг худалдсан байна, б) стратегийн ач холбогдол бүхий экспортын барааны үнэ унах, зах зээл үгүй болох- Монгол улсын ДНБ-ны 16 хувийг дангаараа эзэлдэг Уул уурхайн бүтээгдэхүүний ханш сүүлийн жилүүдэд огцом хэмжээгээр унасан жишээлбэл нийт экспортын бүтцийн 35%-г бүрдүүлж байсан түүхий коксжих нүүрсний экспортын зах зээл сүүлийн 4 жилд 5 дахин унасан,в) эдийн засгийн стратегийн ач холбогдол бүхий салбарт нэг улсаас шууд хараат болох –Монгол улсын хувьд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, өмнө дурдсан уул уурхайн зах зээлээс ихээхэн хамааралтай байдаг. Хөдөө аж ахуйн салбарт нийт ажиллах хүчний 1/3 нь ажиллаж ДНБ-ны 15%-г бүрдүүлдэг томоохон салбар боловч бүтээмж болон технологийн шинэчлэл тааруу тул мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг түүхийгээр нь БНХАУ-с шууд хамааралтай байгаа юм. Уул уурхайн зах зээлийн хувьд дэлхийн зах зээл дэхь үнээс ихээхэн хамааралтай бөгөөд дэлхийн зах зээлд эрэлтийг бий болгож буй улс БНХАУ-с шууд хамаарч байна. Импортын хувьд үйлдвэрлэлийн дамжлагын гол орц болох шатахуун тослох материал, бензиний жилийн нийт хэрэцээний 95%-г дан ганц ОХУ-симпортлож байна. Харин эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлүүдээс абусад улс буюу олон улсын байгууллагад өртэй болж дарамт шахалт, хараат байдалд орох буюу 2012 оноос эхэлсэн гадаад зах зээлд гаргасан олон улсын бондууд, мөн Засгийн газрын дотоод бондуудаас ихээхэн хамааралтай болж улсын өрийн түвшин 2014 оны 12-р сарын байдлаар ДНБ-ны 53%-д хүрсэн байна, б) үндэсний мэргэжилтэй боловсон хүчин, ажиллах хүчин олноороо гадаадад цагаачлах-сүүлийн жилүүдэд бий болж буй уул уурхайн салбарын уналт, валютын ханшны тогтворгүй байдлаас болж хөдөлмөрийн насны ажиллах чадвартай иргэд Солонгос болон бусад улс руу ажиллах нь нэмэгдсэн в) ажилгүйчүүд, түүний дотор хөдөлмөрийн насны хөдөлмөрлөх чадваргүй хүн амын тоо хэт ихсэх зэрэг нь үндэсний аюулгүй байдал аюулд орсныг харуулж байна. Дээрх үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох хүчин зүйлийг шийдвэрлэх ГХО-ын талаарх улс төрийн бодлогыг системтэй боловруулах хэрэгтэй байна.

Монгол улс гадаадын хөрөнгө оруулалтын талаар өөрийн улсад тохирсон тодорхой бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримтлах улс төрийн бодлогод тухайн улсын гадаадын хөрөнгө оруулалттай холбоо бүхий хууль, дүрэм-журам, эрх зүйн баримт бичиг зэргийг багтаан авч үзлээ. Эдгээр нь зөвхөн дотоодбодлогоор хэрэгжихээс гадна гадаад хүчин зүйлүүдээс ихээхэн хамаардаг. Энд олон улсын эрх зүйн баримт бичгүүд, олон улсын хууль, олон улсын гэрээ зэрэг хамруулан авч үзсэн. Энэхүү дотоод, гадаад хөрөнгө оруулалтын талаарх бодлогууд нь цогц байдлаар тэнцвэртэй хэрэгжин амжилттай болдог туршлага дэлхийн олон улсад байна. Монгол улс гадаадын хөрөнгө оруулалтын талаар дараах хууль, эрх зүйн баримт бичигт тулгуурлан ажилладаг. Эдгээрт:

№	Хуулийн нэр	Товч тайлбар
1	Хөрөнгө оруулалтын тухай хууль	2013 оны 10-р сард УИХ Монгол улсын Хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталсан. Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг хүчингүйд тооцсон. Хөрөнгө оруулалтын тухай хууль нь Монголын нутаг дэвсгэр дээрх хөрөнгө оруулагчдын хууль эрхзүйн эрх, үүргийг тодорхойлон татварын орчныг тогтворжуулж, хөрөнгө оруулалтыг зохицуулах агентлагийн эрх мэдэл, хариуцлагыг бий болгож цаашид хөрөнгө оруулалтыг дэмжих урамшууллаар хангах зорилготой. Хуулиар хориглож, хязгаарлаагүй аль ч салбарт хөрөнгө оруулалт хийж болно.
2	Ашигт малтмалын тухай хууль	2014 оны 7-р сарын 1-нд УИХ 2006 оны Ашигт малтмалын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулсан. Жишээ нь, 3-р бүлгийн 23-р зүйл Ашигт малтмалын өмнөх үйл ажиллагаа, 4-р бүлгийн 29-р зүйл Хөрөнгө оруулалтын гэрээ, 30-р зүйл Хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах, 6-р бүлгийн 47-р зүйл Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, 10-р бүлгийн 65-р зүйл Хөрөнгө оруулалтын гэрээтэй холбогдсон маргааныг шийдвэрлэх тухай зүйлүүд бүхлээрээ хасагдсан
3	Өрсөлдөөний тухай хууль	Өрсөлдөөний тухай хуулиар гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт бүхий аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа явуулах өрсөлдөөний тухай бичиг юм. Энд монополь компани болон бусад компаний өрсөлдөөний талаар тусгасан байдаг
4	Татварын бодлого	Өрсөлдөөний тухай хуулиар гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт бүхий аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа явуулах өрсөлдөөний тухай бичиг юм. Энд монополь компани болон бусад компаний өрсөлдөөний талаар тусгасан байдагхугацаанд татварын таатай хөнгөлөлт эдлэх эрхтэй болно. Эдгээр татваруудад байгууллагын орлогын албан татвар, гаалийн татвар, нэмүү өртгийн орлогын татвар болон ашигт малтмалын нөөц баялаг ашигласны төлбөр багтана

5	Үндэсний аюулгүй байдлын хууль	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн зарчим, үндэсний аюулгүй байдлыг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, иргэний оролцоог тодорхойлж, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг уялдуулахтай холбогдсон харилцааг зохицуулах үүрэгтэй.
6	Гадаад валютын бодлого	Засгийн газар хөрөнгө оруулалтын мөнгөн шилжүүлгийг хянах тал дээр илүү либерал тогтолцоотой байхыг эрмэлздэг. Гадаад, дотоодын бизнес эрхлэгчид хөрөнгө оруулалтын санхүүжилт, ашиг орлого, зээл барагдуулалт болон түрээсийн төлбөрийг ямар ч мөнгөн тэмдэгт валют руу, хүссэнээрээ хаашаа ч хамаагүй хөрвүүлэн шилжүүлдэг. Мөн дэлхийн томоохон улс орнуудын мөнгөн тэмдэгт болох гадаад валютыг олж авахад ямар ч бэрхшээл гардаггүй байна.
7	Хөрөнгө оруулалтын хоёр талт гэрээ	Хөрөнгө оруулалтын хоёр талт гэрээ гэдэг нь “хэлэлцэн тохирсон улсуудын иргэдийн оруулсан хөрөнгө оруулалтыг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилгоор хоёр улсын хооронд байгуулсан гэрээ. Нэг улсын иргэн нөгөө улсад хөрөнгө оруулах нөхцөл, болзол болон хөрөнгө оруулагч иргэдийн эдлэх эрх, тэдэнд олгох хамгаалалтыг уг гэрээгээр тодорхойлсон байдаг ¹ . Монгол улс 150 улстай хөрөнгө оруулалтын хоёр талт гэрээг байгуулсан байна ² .
8	Хөрөнгө оруулалтын урамшуулал	Засгийн газар татвараас чөлөөлөх болон татварын урамшууллын бодлогыг хэрэгжүүлдэг. Шатахуун, хүнсний гол бүтээгдэхүүний импорт, эсвэл хөдөө аж ахуйн салбар зэрэг өсөлтөд төвлөрсөн тодорхой салбарууд дахь импортыг татвараас чөлөөлдөг. Татвараас чөлөөлөх энэхүү арга хэмжээ нь импортын татвар болон нэмэгдсэн өртгийн албан татварт хамааралтай.
9	Татварын 2 талт гэрээ	Монгол Улс өнөөг хүртэл нийт 28 ³ улстай давхар татварын гэрээ буюу татварын тухай 2 талт гэрээ байгуулсан. Үүний 72 хувь 1991-1997 оны хооронд хийгдсэн байна.

Эдгээр хууль, баримт бичгийг улсын их хурал баталж засгийн газар, түүний харьяа байгууллагууд хэрэгжүүлдэг. Монгол улсын засгийн газрын тухайд 2014 оны 11-р сард Ардчилсан намын удирдсан эвслийн засгийн газрыг УИХ унагаж сарын дараа буюу 12-р сард Шинэчлэлийн засгийн газрыг байгуулсан. Ерөнхий сайд гадаадын хөрөнгө оруулалтыг дахин сэргээн хямарсан эдийн засгийг сайжруулахад төвлөрсөн хүчин чармайлт гарган Оюу Толгой (зэс/алт) болон Таван Толгой (нүүрс) гэсэн гадаадын хөрөнгө оруулалт төвлөрсөн 2 мега төслийг гацаанаас гаргах асуудал дээр улс төрийн бүх намын нэгдмэл байр суурьтай засгийн газрыг удирдан ажиллахаа¹⁴⁴ хэлсэн. Энэ нь хөрөнгө оруулалтын бодлогод нөлөөлөх алхам болсон гэж зарим судлаачид үзэж байна.

Хөрөнгө оруулалт сүүлийн хоёр жилийн дотор 2.4 тэрбум ам.доллараар буурсан. Энэ огцом буурсан шалтгаан нь нэг талаараа Оюу Толгойн ил уурхайн бүтээн байгуулалт дууссантай холбоотой гэж үзэж болно. Мөн БНХАУ–н эдийн засгийн өсөлтийн сааралтын улмаас худалдан авах эрэлт буурч Монгол улсын коксжих нүүрсний экспортод хүчтэй нөлөө үзүүлсэн зэрэг гадаад эдийн засгийн шалтгаануудтай. Гэвч нөгөө талаас хамгийн чухал нөлөөтэй нь улс төрийн тогтворгүй байдал, хууль эрхзүйн тогтвортой бус орчинболж байна. Жишээ нь, Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалт хийх тухай хуулийг /2012 оны 5-р сар/ батлаад буцаан хүчингүйд тооцсон. Энэ мэт засгийн газар хугацаанаасаа өмнө солигдох, засгийн газрын бодлого өөрчлөгдөх, хууль батлаад эргээд хүчингүйд тооцох зэрэг үйлдлүүд нь хөрөнгө оруулах үйл явцад сөргөөр нөлөөлж байна. Улс төрийн бодлогын тогтвортой, залгамж байдал чухал асуудал юм. Хөрөнгө оруулалтын хэрэгжих хугацаа, түүнээс гарах ашиг нь урт хугацаанд хэрэгжих үйл ажиллагаа учраас хөрөнгө оруулагчдад урт хугацааны тогтвортой бодлого, бодлогын хэрэгжилт маш чухал. Гадаадын хөрөнгө оруулалт нь хоёр талын харилцан ашигт хамтын ажиллагаа учраас өөрсдийн эрх ашгийг хангаад зогсохгүй нөгөө талын эрх ашгийг дээд зэргээр хангах дээр ажиллах нь гадаадын хөрөнгө оруулалтын талаар төрөөс баримтлах бодлогын чухал хэсэг гэж үзэж байна. Энд засгийн газраас гадна Хөрөнгө оруулалтын газар, Гадаад харилцааны яам ажилладаг байна. Хөрөнгө оруулалтын газрын тухайд Хөрөнгө оруулалтын тухай хууль нь Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газрыг татан буулгаж, Ерөнхий сайдын ажлын албанд тайлагнах зорилготой хөрөнгө оруулалтыг дэмжих нэгж буюу Хөрөнгө оруулалтын газрыг бий болгосон. Хөрөнгө Оруулалтын Газар нь татвар тогтворжуулах гэрчилгээ олгох үүрэгтэйгэх мэт гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалттай холбоотой үйл ажиллагаанд оролцон ажилладаг байна. Харин Гадаад харилцааны яамны тухайд Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал 2012 онд Гадаад харилцааны яамнаас Эдийн засгийн яамны ажлын чиг үүрэгт шилжсэн ба тус яам гадаад хөрөнгө оруулалтыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Монгол улсын энхийгэрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг ханган, улс орнуудтай найрсаг харилцаа хөгжүүлснээрээ гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих улс төрийн таатай орчин, уур амьсгалыг бүрдүүлж худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаарх олон улсын баримт бичигт нэгдэх, хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээр байгуулахад түлхүү оролцдог байна¹⁴⁵.

Гадаадын хөрөнгө оруулалт нь нэг орноос нөгөө орон руу гуйвах энгийн нэг мөнгөний урсгал биш,

¹⁴⁴ 2015 оны Хөрөнгө оруулалтын орчны тухай мэдэгдэл, Эдийн засаг, Худалдааны хэлтэс

¹⁴⁵ “Гадаадын хөрөнгө оруулагчдад тулгарч буй асуудлууд ба шийдвэрлэх гарц” сэдэвт уулзалт зөвлөгөөнд Гадаад харилцааны яамны хийх танилцуулга УБ хот, 2013 оны 3-р сарын 1

түүнтэй хамт үргэлж шинэ технологи, шалгарсан менежментийн арга барил, маркетингийн ноу-хау, нарийн мэргэшсэн мэргэжилтэнг дагуулж ирдэгийн дээр эдгээр нь тухайн хөрөнгө оруулалт хийгдэж байгаа улсын эдийн засагт чухал ач холбогдолтой. Тиймээс гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжин түүнийг нэмэгдүүлэхэд ялангуяа ГХО-ын талаарх төрөөс баримтлах бодлогод анхаарах хэрэгтэй. Хөрөнгө оруулалтыг дагаад эдийн засгийн өсөлт, ажлын байр, үйлдвэрлэл, худалдаа, худалдан авах чадвар зэрэг олон үзүүлэлт өсч нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдалд эерэг үр дагавартай.

Монгол улсад гадаадын хөрөнгө оруулалтыг татах суурь нөхцлүүд болох улс төрийн ардчилсан дэглэм, эдийн засгийн либерал бодлого, татварын бага хэмжээ, хууль эрх зүйн тодорхой орчин зэрэг нь байгаа хэдий ч цаашид гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, түүний үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэснээрөөс баримтлах улс төрийн бодлого чухал байна. Гадаадын хөрөнгө оруулалтын талаар төрөөс баримтлах улс төрийн бодлого тодорхой түвшинд хэрэгжиж байгаа ч хангалтгүй ажиллаж байна гэж гадны төдийгүй дотоодын хөрөнгө оруулагчид, зарим судлаачид хэлж байна. Үүний суурь бодлого нь нэгэнт гадаадаас ороод ирчихсэн хөрөнгө оруулагчдыг дэмжин хоёр талын харилцан ашигт ажиллагаа гэдэг байр суурьт анхааран хамтран ажиллах нь хамгийн эхний гадаадын хөрөнгө оруулалтын талаар төрөөс баримтлах бодлогын нэг зайлшгүй мөн. Жишээ нь: Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар: Хөрөнгө оруулалтыг татах ажлыг эхлэхээс өмнө одоо байгаа, нэгэнт хөрөнгөө оруулчихсан хөрөнгө оруулагчдын санал бодлыг сонсох, тэдэнд хөрөнгөө нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх нь чухал. Ер нь бол шинэ хөрөнгө оруулагчдын ихэнх нь Монголд аль эрт хөрөнгөө оруулсан шүү дээ. Тэд Монголын зах зээлийг мэддэг хүмүүсээр дамжин орж ирдэг гэсэн судалгаа хүртэл гарсан¹⁴⁶.

Мөн гадаадын хөрөнгө оруулалтыг амжилттай хэрэгжүүлэх орчныг бүрдүүлэхэд анхаарлаа хандуулахгүйгээр гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломж хомс. Тухайлбал, Монгол улсад бизнес эрхлэхэд тулгаргах "топ 10" бэрхшээлийг Invest policy review Mongolia тайланд харуулсан. Үүнд, мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй 17,9%, засгийн газрын үр ашиггүй хүнд суртал 14,9%, дэд бүтцийн хангамж хангалтгүй 11,3%, авлига 9,2%, инфляци 8%, гадаадын валютын зохицуулалт 6,8%, улс төрийн тогтворгүй байдал 6,4%, санхүүжилт авах 5,8%, ажиллах хүчний этик муу 5,7%, засгийн газрын тогтворгүй байдал 3,5%¹⁴⁷ байна гэж хариулжээ. Эдгээр асуудлуудыг шийдэхгүйгээр гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчтай ойлголцох асуудал хүндрэлтэй болж байна. Энэ бичил судалгааны үр дүнд гадаадын хөрөнгө оруулалтыг татах суурь хүчин зүйлүүдээ ашиглан гадаадын хөрөнгө оруулалтын талаар төрөөс баримтлах улс төрийн бодлогыг дараах хүрээнд авч үзлээ. Үүнд:

Эдийн засгийн хүрээнд - Гадаадын хөрөнгө оруулалтын талаар төрөөс баримтлах улс төрийн бодлого бүх салбарыг хамран хэрэгжих хэрэгтэй. Гадаадын хөрөнгө оруулалт ихэвчлэн уул уурхайн салбарт ордог бол /нийт ГХО-ын 73.3%¹⁴⁸(2014 он), 80% (2015 он)/ бусад салбарт ялангуяа боловсрол, хөдөө аж ахуйн /ХАА/ салбарт оруулах хөрөнгө оруулалтыг улс төрийн бодлогоор "уях" хэрэгтэй байна. Хүн ам цөөн, ажиллах хүчний нөөц бололцоо дутмаг манай улс иргэдийнхээ боловсролд хөрөнгө оруулах нь улс орны хөгжил, үндэсний аюулгүй байдал гэх мэт асуудлуудад чухал үүрэгтэй. Мөн хөдөө аж ахуйн салбар нь Монгол улсын ДНБ-ний 14,5%-г бүрдүүлдэг, нийт ажиллах хүчний 30% буюу 329,1 мянган ажилчидтай, үүнээс 93% нь мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг байна. 2010-2013 онуудад ХАА-н салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт 10,4 тэрбум доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 0,04%¹⁴⁹ байна. Харин боловсролын салбарт (соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл) хийгдсэн хөрөнгө оруулалт нийт хөрөнгө оруулалтын 0.13%¹⁵⁰-ийг эзэлж байна. Энэ үзүүлэлт маш хангалтгүй, гадаадын хөрөнгө оруулалтыг эдгээр салбар луу чиглүүлэх улс төрийн бодлогыг баримтлан ажиллах зайлшгүй шаардлагатайг харуулж байна. Мөн баялаг бүтээх салбарт буюу аж үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалтыг татах бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эдгээр салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжсэн бодлого хэрэгжснээр улсын эдийн засгийн өсөлт, салбарын ирээдүйд онцгой ач холбогдолтой.

Хууль, эрх зүйн хүрээнд - Хууль, дүрэм журмын тогтвортой хэрэгжилтийн баталгааг гарган ажилласнаар гадаадын хөрөнгө оруулалтад эерэг хандлагыг бий болгоно. Мөн хөрөнгө оруулагчид болон Монгол улсын харилцан хүртэх ашгийг дээд хэмжээнд байлгах тал дээр харилцан анхааран ажиллах нь хууль, эрх зүйн хүрээнд хийх чухал ажил юм. Хуулийн хэрэгжилт, түүнийг хянах хяналтыг сайжруулснаар гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээх өндөр боломжтой.

Улс төрийн хүрээнд - Улс төрийн зүгээс Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулагчдад анхаарал хандуулан дэмжиж ажиллах нь дараагийн хийх гадаадын хөрөнгө оруулалтын суурь нөхцөл бүрдэж байгаа хэрэг. Дээрх эдийн засаг, хууль, эрх зүйн хүрээнд хийгдэх бүх ажлууд улс төрийн шийдвэр, улс төрийн баталгаагаар дамжин амжилттай хэрэгжнэ. Үүний тулд улс төрийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн улс төрийн олон ажлыг хийх хэрэгтэй. Улс төрийн тогтвортой байдлыг ханган ажиллах нь хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын орчныг таамаглах нөхцлийг бүрдүүлэх юм. Ингэснээр түүнийг нэмэгдүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэх боломж нэмэгдэнэ.

¹⁴⁶ <http://investmongolia.gov.mn/?p=998>, Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатартай хийсэн ярилцлага

¹⁴⁷ United Nations Conference on Trade and Development, UNCTAD, Investment policy review, 2013

¹⁴⁸ Mongolia Investment Climate Statement /2014.07.28/

¹⁴⁹ Төрөөс ХАА-н талаар баримтлах бодлого, 2014 он

¹⁵⁰ <http://www.hunnu.mn/content/48290.htm>

Гадаадаас хөрөнгө оруулалт татах нь чухал боловч нэгэнт үйл ажиллагаагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулагчдад эдийн засаг, эрх зүй, улс төрийн хүрээнд анхаарал хандуулах, хууль эрхзүйн орчныг тогтворжуулах нь хамгийн чухал ажил болоод байна. Гадаадын хөрөнгө оруулалтын талаар төрөөс баримтлах улс төрийн бодлого нь байнгын үргэлжлэх “залгамж холбоотой” байж гадаадын хөрөнгө оруулагчдад таатай орчинг бүрдүүлэх юм. Энэхүү улс төрийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа, байнгын залгамж холбоо бүхий бодлого нь улс төрийн баталгаа болдог. Гадаадын хөрөнгө оруулалт нь гэдэг нь хоёр талын харилцан ашигт үйл ажиллагаа учраас зөвхөн өөрийн ашгийг нэн тэргүүнд тавилгүй хамтрагчийнхаа хүсэл, ашгийг тооцоолох нь гадаадын хөрөнгө оруулалтын орж ирэх урсгалыг нэмэгдүүлэх улс төрийн бодлого юм. Мөн хууль, эрхзүйн орчноо тогтворжуулан ажиллах нь дан ганц гадны хөрөнгө оруулалтаас татах гэхээс илүүтэй бүх төрлийн олон улсын харилцаанд эерэг үр дагавартай. Хөрөнгө оруулагчдыг урт хугацаанд ашиг олох нөхцлийг бүрдүүлсэн, оруулсан хөрөнгө, техник технологийнхоо үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжоор хангах нь хөрөнгө оруулалтыг татах суурь юм. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалт нь хэрэгжих хугацаа, ашиг хүртэх бололцоо нь урт хугацаанд хэрэгжих үйл ажиллагаа байдаг учраас хөрөнгө оруулагчдад урт хугацааны тогтвортой бодлого, эдийн засгийн таатай орчин шаардлагатай. Гадаадын хөрөнгө оруулалт нь зөвхөн бэлэн мөнгөний урсгал биш, түүнтэй хамт үргэлж шинэ техник технологи, оновчтой менежментийн /удирдлагын/ арга барил, маркетингийн ноу-хау, нарийн мэргэшсэн мэргэжилтэнг дагуулж ирдэгийн дээр эдгээр нь тухайн хөрөнгө оруулалт хийгдэж байгаа улсын эдийн засагт чухал ач холбогдолтой.

НОМ ЗҮЙ

1. Ашигт малтмалын тухай хууль, шинэчилсэн найруулга, 2014 оны 7-р сарын 1
2. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль /хүчингүйд тооцсон/
3. “Гадаадын хөрөнгө оруулагчдад тулгарч буй асуудлууд ба шийдвэрлэх гарц” сэдэвт уулзалт зөвлөгөөнд Гадаад харилцааны яамны хийх танилцуулга УБ хот,
4. Зургаан зорилтот төлөвлөгөө: Ажлын байр өсөлтийг бий болгох боломжийг хувийн хэвшилд олгох нь, УБ хот, 2012 он
5. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, 2011 оны 12-р сарын 15
6. Монгол Улсын Их Хурлын тухай хууль, 2006 он
7. Монголбанк, Инфляцийн төлөв байдлын тайлан, 2015 оны 6-р сар
8. Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 он
9. Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалт хийх тухай хуулийг 2012 оны 5-р сар, /хүчингүйд тооцсон/
10. Сайрус Бенсон, Викториа Орловски, Олон улсын хөрөнгө оруулалтын гэрээний арбитр, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, 2015 он
11. Төрөөс ХАА-н талаар баримтлах бодлого, 2014 он
12. U.S. Embassy in Ulaanbaatar Mongolia, 2014 Mongolia Investment Climate Statement, 7/28/2014
13. 2013 оны 3-р сарын 1, Гадаад харилцааны яам
14. 2015 оны Хөрөнгө оруулалтын орчны тухай мэдэгдэл, Эдийн засаг, Худалдааны хэлтэс
15. Mongolia Investment Climate Statement /2014.07.28/
16. United Nations Conference on Trade and Development, UNCTAD, Investment policy review, 2013
17. www.investmongolia.mn
18. <http://www.mta.mn/document/list?&type=6&page=2>

СОНГУУЛЬ БА КОНДОРСЕГИЙН ПАРАДОКС, ЭРРОУГИЙН ТЕОРЕМ

Ц.ГАНБОЛД

*Профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхим*

Түлхүүр үг: Сонгууль, бүгд найрамдах байгуулал, сонгуулийн маргаан, итгэлцэл, сонгуулийн механизм, Кондорсегийн парадокс, Эрроугийн теорем, үндэсний эв нэгдэл.

Abstract: Done well, electoral system design can add to the momentum of political change, encourage popular participation, and enable the emergence of legitimate representatives who are capable of handling a wide range of needs and expectations, immediately and in the future. Done badly, it can derail progress towards democracy or even political stability.

To be successful, electoral system design processes must build understanding and trust—not just among politicians and election administrators, but among civil society organizations, among commentators, and above all among the citizens of a country undergoing democratic reform. Electoral systems must be designed not only to work under current situations but also to accommodate future changes in attitudes and behavior as electoral incentives change. They can contribute to the development of stable democracy or they can be a major stumbling block to it.

Дэлхийн улс төрийн түүхийн өргөн цар хүрээнд авч үзвэл сонгууль бол бүгд найрамдах байгуулалын амин сүнс нь юм. Ардчиллын тухайд чөлөөт, шударга сонгууль бол ардчиллын зорилго бус, хүн төрөлхтний одоогоор олж мэдсэн хамгийн боломжийн хэрэгсэл ажээ.

Буруу зохион байгуулж буруу хэрэглэвэл сонгууль нь үймээн самуун, иргэний дайн, хүчирхийллийг өдөөгч ч болчихдог эмзэг, элдэвтэй хэрэгсэл мөн. Тиймээс сонгуулийн тухай асуудал нь ихээхэн будилаантуулагдсан, ээдрээтэй асуудал билээ. Яагаад гэвэл сонгууль бол улс төрийн засаглал, улс төрийн эрх мэдэл, улс төрийн ашиг сонирхолтой холбогддог учраас ээдрээ будилааны ид шид нь түүнд оршино.

Сонгууль бас мөнгө олох хэрэгсэл болчихдог аюултай үйл явц. “Багийн засаг даргын авгайн дүүгээс” эхлээд л сонгууль будилаантуулж мөнгө олдог хачирхалтай улс төрийн соёл Монголд тогтноших хандлагатай байгааг хэрхэвч зөвшөөрөх ёсгүй.

Төлөөллийн байгууллагаа сонгох бүх нийтийн, шууд сонгууль бол зөв шударга зохион байгуулж чадвал засаглалын хамгийн хүчирхэг, үндсэн эх сурвалж талаасаа хамгийн үнэ цэнэтэй. Хэрэв тийнхүү хууль ёсны дагуу, шударга зохион байгуулж чадахгүй бол олигархиудын дэглэсэн жүжиг төдий зүйл, хатуухан хэлвэл ард түмний нэр барьж тэднийг доромжилж буй хэрэг юм.

Ардчилалд шилжиж байгаа орнууд төдийгүй ардчиллын үлгэр загвар болдог орнуудад хүртэл сонгуулийн тогтолцоо, түүний бүтэц зохион байгуулалтыг байнга боловсронгуй болгож байх шаардлагатай ажээ.

Ардчилал, Сонгуульд туслах Олон Улсын Хүрээлэнгээс /IDEA/ эрхлэн гаргасан “Electoral System Design: The New International IDEA Handbook. 2005.” номд дэлхийн 213 тусгаар тогтносон улс, газар нутгийн сонгуулийн тогтолцооны онцлогыг дурдахдаа Монголын 2000 оны УИХ-ын сонгуулийг хамгийн муу жишээнд оруулсан байдаг.

Бид жинхэнэ чөлөөт ардчилсан сонгуульд суралцах ёстой. Улс төрийн хүчнүүд ч, улс төрчид, улс төрийн намуудын идэвхитэн дэмжигчид, төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид, төрийн бус байгууллагууд, сонгогчид ч суралцах, сонгуулийн утга учир, мөн чанарыг сайтар ойлгох ёстой.

Бид сонгуулийн тогтолцоо, сонгуулийн технологи, сонгуулийн менежмент, сонгуулийн хууль тогтоомж, үйл явцын талаар гадны байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтарч болон бие дааж академик болон хэрэглээний шинжтэй сургалт, семинар зохион байгуулж, ном сурах бичиг гарын авлага гаргаж ирсэн. Тэдгээрт сонгуулийн явцад будлиан луйвар гардаг, түүнээс сэргийлэх хэрэгтэй гээд улс төрийн намуудын идэвхитэн, сонгуулийн менежрүүдэд нь хичээл ном заагаад явуулахаар нөгөө нөхдүүд маань болохгүй гэсэн болгоныг улам нарийн боловсронгуй болгоод хэрэглэчихдэг нь хачирхалтай. Хачирхах юм байхгүй, тэгсэн этгээд шан харамж авч, албан тушаал ахидаг юм. Хууль нь гууль болсон нийгэмд л ийм байдал жишиг болдог учиртай.

Чөлөөт, шударга сонгууль явуулахад улс төрийн намуудын төлөвшил, сонгуулийн төв байгууллагын үйл ажиллагаа, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоо, хэвлэл мэдээллийн байгууллагууд гэх мэт олон хүчин зүйл нөлөөлдөг. Тэдгээрийн дотор сонгуулийн менежмент, сонгуулийн технологи чухал байр суурь эзэлнэ.

Сонгууль маш их маргаан дагуулдаг улс төрийн үйл явцын нэг мөн. Тэдгээр маргаан, зөрчил сонгуулийн бүхий л мөчлөгт илэрцг байдаг. Юуны өмнө:

- Хууль эрх зүйн орчин чөлөөт, ардчилсан сонгуулийн олон улсын жишиг стандартад хэрхэн нийцэж байгаа;
- Үйл явцыг журамласан байдал, сонгуулийн бэлтгэл ажил (сонгуулийн хороодын гишүүдийг сургаж бэлтгэх гэх мэт);
- Сонгуулийн тойргуудыг тогтоож байгуулах, мандат хуваарилах;
- Сонгогчдын нэрсийн жагсаалт;
- Сонгуульд оролцох нам эвсэл, нэр дэвшигчийг бүртгэх үйл явц;
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө хангагдах байдал;
- Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа;
- Сонгуулийн кампанит ажилд төрийн эх үүсвэрийг ашиглаж байгаа эсэх;
- Санал хураах өдрийн үйл явц;
- Санал тоолох, нэгтгэх үйл явц;
- Сонгуулийн маргаан шийдвэрлэх үйл явц.

Хөндлөнгийн хяналтын асуудал гэх мэт олон асуудлыг дурдаж болно. Маргаан бол аливаа ил тод ардчилсан өрсөлдөөний зүй ёсны нэг тал юм. Гэхдээ сонгуульд итгэх итгэлийг алдагдуулахгүй, хүч хэрэглэсэн зөрчилдөөн үүсгэхгүй байх үүднээс маргааныг үр нөлөөтэй шийдвэрлэж байх нь сонгуулийн үйл ажиллагаанд онц чухал байдаг. Сонгуулийн аль ч шатанд гарч болох асуудлыг зохицуулахад шаардлагатай маргаан шийдвэрлэх механизмыг эртнээс бий болгож, сонгуулийн хууль тогтоомжид маргаан шийдвэрлэх албан ёсны журмыг тодорхойлох хэрэгтэй. Маргаан шийдвэрлэх механизм бодитой, шударга байх нь сонгуулийн үйл ажиллагаа болон ардчиллын байгууллагуудад итгэх олон нийтийн итгэлийг бий болгоход чухал ач холбогдолтой.

Оролцогчид нь тоглоомынхоо дүрмийг зөвшөөрөөгүй нөхцөлд улс төрийн шилжилтийг дан ганц сонгуулиар зохицуулах нь хангалтгүй юм. Ийм нөхцөлд хуурай өвсөнд гал асаахын нэг адил сонгууль өөрөө эрх мэдлийг тайван замаар шилжүүлэхийн оронд хүчирхийлэл, зөрчилдөөнийг өдөөгч болдог аюултай.

Ер нь мөн чанарын хувьд сонгууль бол маргаан дагуулахгүй байх аргагүй нарийн төвөгтэй улс төрийн үйл явц болох талаар бүгд найрамдах байгууллын анхны үеэс л судлаачид анхааруулж байсан.



Кондорсегийн парадокс

<http://tverdyznak.livejournal.com/1348973.html><https://en.wikipedia.org>

Сонгуулийн дүн хүн бүрийн сэтгэлд нийцдэггүй. Тэр нь ч аргагүй. Гэхдээ сонгуулийн дүнд олонх сэтгэл хангалуун байх ёстой. Тэгж чаддаг уу? Сонгууль бүрийн дараа гомдогсод, гонсойгсод, сонгууль будлиантай боллоо гэж сэжиглэгсэд дандаа гарч ирдэг. Яагаад тэр вэ? Энэ асуудал бүр 18 дугаар зууны үед ч судлаачдын сонирхлыг татаж байсан байх юм.

Кондорсегийн зарчмаар бол олон нийтийн жинхэнэ хүсэл зоригийг тодорхойлохын тулд сонгогч бүр бүх нэр дэвшигчдийг эрэмбэлэх ёстой байдаг юм байна.

Кондорсегийн зарчмыг дараах жишээн дээр тайлбарлая.

Жишээ: Энд хэрэглэх $A > B > C$ гэдэг нь сонгогч А нэр дэвшигчийг В нэр дэвшигчээс, В нэр дэвшигчийг С нэр дэвшигчээс илүү үзэж байна гэсэн тэмдэглэгээ юм.

60 хүн дараах байдлаар санал өгчээ. Үүнд:

23 хүн: $A > C > B$

19 хүн: $B > C > A$

16 хүн: $C > B > A$

2 хүн: $C > A > B$

Дээрхээс харвал А нэр дэвшигч харьцангуй олонхийн санал авсан байна. Хэрэв харьцангуй олонхийн саналаар сонгуулийн дүн шийдэгдэх бол А нэр дэвшигч сонгогдох нь харагдаж байна.

Абсолют олонхийн саналаар сонгогдох ёстой бол дахин сонгууль явагдах болно. Энэ тохиолдолд өрсөлдөөн илүү олон санал авсан А ба В нэр дэвшигчдийн хооронд өрнөх ба

$A > B$ гэж үзсэн сонгогчдын тоо $23+2=25$

$B > A$ гэж үзсэн сонгогчдын тоо $19+16=35$

байгаа тул В нэр дэвшигч ялалт байгуулна.

Гэтэл 23 хүн $A > C$ гэж $19+16+2=37$ сонгогч $C > A$ гэж үзсэн байх юм. Түүнчлэн $23+16+2=41$ сонгогч $C > B$ гэж үзсэн байна. Тэгэхээр нийт сонгогчдын олонх нь $C > B$, $B > A$, $C > A$ гэж үзэж байгаа юм байна. Нэгтгэн дүгнэвэл $C > B > A$ болох ба Кондорсегийн зарчмаар бол С нэр дэвшигч ялалт байгуулахаар харагдаж байна.

Сонгогчдын санал өөрчлөгдөөгүй байтал сонгуулийн системээс /аргаас/ шалтгаалан өөр өөр үр дүн гарах боломжтой байна.

Хэрэв Кондорсегийн зарчмаар гурван нэр дэвшигчийг харьцуулахад $B > C$, $C > A$, $A > B$ гэсэн дүн гарвал яах вэ? Эдгээр дүгнэлтүүдээс нэгдсэн дүгнэлт хийх боломжгүй юм. Чухам ийм тохиолдлыг Кондорсегийн парадокс гэдэг байна.

Кондорсегийн парадоксыг өөр нэг жишээн дээр авч үзье. Гурван хүүхдээс алим, лийр, гадил жимснүүдээс алийг нь идэх вэ гэсэн асуулт асууж л дээ. Эхний хүүхэд алим, лийр, хоёр дахь хүүхэд алим, гадил, гурав дахь хүүхэд лийр, гадил гэсэн санал хэлжээ. Алим, лийр, гадил гурвуул хоёр хоёр саналтай тул бүгд ялж байна. Гэвч энэ тохиолдолд хэний ч санал нийтийн сонголтонд нөлөөлж чадсангүй.

Кондорсегийн парадокс нь Эрроугийн боломжгүйн теорем гэж нэрлэгдэх дараахь теоремын эхлэл болсон байна



Kenneth Arrow,

Stanford University.jpg <https://en.wikipedia.org/>

Эрроугийн боломжгүйн теорем

$N > 1$ тооны сонгогч, $n > 2$ тооны нэр дэвшигчийн /альтернатив/ төлөө санал өгнө. Сонгогч бүр нэр дэвшигчдийг өөрийнхөөрөө эрэмбэлсэн байгаа. Сонгуулийн систем нь сонгогч бүрийн эрэмбэлсэн жагсаалтуудын олонлогийг /профиль/ нэг ерөнхий эрэмбэлэгдсэн жагсаалт болгох функц юм. Сонгуулийн систем нь дараах чанаруудыг хангах ёстой. Үүнд:

1. Универсал чанар. Сонгогчдын саналын дурын профилийн хувьд сонгуулийн үр дүн /эрэмбэлэгдсэн жагсаалт/ гарах ёстой.
2. Гүйцэд чанар. Сонгуулийн дүнд бүх боломжит $n!$ хувилбарууд гарч ирэх боломжтой байх ёстой.
3. Монотон чанар. Хэрэв бүх N сонгогчийн жагсаалтад x альтернатив тодорхой байрнаас доошгүй байвал ерөнхий жагсаалтад x тэр байрнаас доошлох ёсгүй.
4. Диктаторгүй байх чанар. Сонгуулийн дүн хэн нэг сонгогчийн хүсэл зоргоор, бусад сонгогчдын саналыг тооцохгүйгээр гарах ёсгүй.
5. Хөндлөнгийн альтернативаас үл хамаарах чанар. Бүх N жагсаалтад x , y альтернативууд байрандаа үлдээд бусад альтернативууд өөрчлөгдөхөд эцсийн жагсаалтад эдгээр альтернативуудын байрлал өөрчлөгдөхгүй байх ёстой.

Эрроугийн теорем. $N > 1$ тооны сонгогч, $n > 2$ тооны нэр дэвшигчтэй тохиолдолд дээрх бүх чанаруудыг хангах сонгуулийн систем оршин байхгүй.

1. Универсал
2. Диктаторгүй
3. Хөндлөнгийн альтернативаас үл хамаарах чанарууд болон дараах чанарыг авч үзье. Үүнд:
 - Парето эффектив байх чанар буюу нэгдмэл саналын зарчим. Хэрэв бүх сонгогчийн жагсаалтад X альтернатив Y альтернативаас дээгүүр байгаа бол эцсийн жагсаалтад ч мөн тийм байх ёстой.

Эрроугийн теорем бол мөн л $N > 1$ тооны сонгогч, $n > 2$ тооны нэр дэвшигчтэй тохиолдолд дээр дурдсан бүх дөрвөн чанарыг хангасан сонгуулийн систем оршин байхгүй гэсэн томъёололтой юм.

Теренс Таогийн хувилбар

Y нь сонгогчдын олонлог, S нь нэр дэвшигчдийн олонлог байг. Сонгогч бүр нэр дэвшигчдийг эрэмбэлсэн байг. Өөрөөр хэлбэл, хэрэв $S = \{X, Y, Z\}$ бол Y сонгогч $Y > Z > X$ гэж эрэмбэлсэн байж болох юм. Бид

- сонгогч бүр нэр дэвшигчдийг бүрэн эрэмбэлсэн /рационал/,
- сонгогч бүр нэр дэвшигчдийг ямраар ч эрэмбэлж болох /чөлөөт/,
- нэг сонгогчийн эрэмбэ бусад сонгогчдын эрэмбээс үл хамаарах /бие даасан/

байна гэж үзье.

Сонгуулийн систем гэдэг нь сонгогч нэг бүрийн саналыг үндэслэн олон нийтийн сонголтыг тодорхойлох функц юм. Бид сонгууль нь дараах зарчмуудтай байхыг хүсдэг. Үүнд:

1. Рационал байх зарчим. Сонгуулийн үр дүн бүрэн эрэмбэлэгдсэн байх
2. Тодорхой байх зарчим. Сонгуулийн үр дүн зөвхөн сонгогчдын сонголтоос хамаардаг байх
3. Консесусын зарчим. Хэрэв бүх сонгогч A хувилбарыг B хувилбараас дээр гэж үзэж байгаа бол сонгуулийн дүнд ч тийм л байх ёстой
4. Шударга байх зарчим. Бүх нэр дэвшигчдэд адил хандах. Өөрөөр хэлбэл нэр дэвшигчид солигдоход сонгуулийн систем өөрчлөгдөхгүй байх ёстой.
5. Гурав дахь хувилбараас үл хамаарах зарчим. Сонгуулийн дүн дэхь X ба Y нэр дэвшигчдийн эрэмбэ нь гурав дахь Z нэр дэвшигчдэд санал өгсөн сонгогчдын саналаас хамаарахгүй байх ёстой.
6. Диктаторгүй байх зарчим.

Дээрх зургаан аксиомыг зэрэг хангах сонгуулийн систем байх боломжгүй.

Чухамхүү ийм ээдрээ төвөгтэй учраас маш ойлгомжтой эрх зүйн зохицуулалт, олон талын зөвшилцөл, улс төрийн соёл, мэргэжлийн болон үндэсний ёс суртахуун, хариуцлага, сахилга бат чухал.

Сонгуулийн өмнө болон ид өрнөлийн үе, дүн мэдээ гарч байгаа мөч болон түүний дараах цаг хугацаанд сэтгэл хөдлөл, овиллогүй ааш ариншин, худал хуурмаг мэдээлэл, өдөөн хатгалга, ... асар их аймшигтай, эмгэнэлтэй үр дагавартайг цохон тэмдэглэх хэрэгтэй.

Сонгуульд оролцогч талууд нэн ялангуяа улс төрийн намууд, улс төрчид, нэр дэвшигчид болон сонгуулийн төв байгууллага, түүний удирдлага, сонгуулийн хэсэг, тойргийн хороонд ажиллагсад, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд үндэсний эв нэгдлийг эрхэмлэсэн улс төрийн хариуцлагаа цаг ямагт сайтар ухамсарлах ёстой.

Сонгуулийн мөчлөгийн турш зөрчлийг багасгах өргөн хүрээний бодлого нь тухайн орны институцийн бүтэц, улс төрийн тогтолцоо, сонгуулийн хуулинд тусгалаа олсон байх ёстой. Улс төрийн хүчирхийлэл гардаг орнуудад дээрх гурван хүчин зүйлийн нэгдэл чухал ач холбогдолтой. Өмнө дурдсанчлан, эдгээр хүчин зүйлийн дээр улс төрийн нам, хүчнүүдийн сонгуулийн мөчлөг дэх оролцоо, сонгуулийн үр дүнг зөвшөөрөх чадвар, хүсэл сонирхлоос ихээхэн хамаарна. Энэ нь сонгуулийн байгууллагын хараат бус, ил тод, үр нөлөөтэй ажиллагааны талаарх бодит байдал болон төсөөлөлтэй зарим талаар холбоотой боловч сонгуулийг тайван замаар явуулахад ардчиллын зарчмуудыг хүндэтгэн үзэх улс төрийн соёл шийдвэрлэх үүрэгтэй.

НОМ ЗҮЙ

1. https://en.wikipedia.org/wiki/Arrow%27s_impossibility_theorem
2. https://en.wikipedia.org/wiki/Marquis_de_Condorcet
3. “Electoral System Design: The New International IDEA Handbook. 2005.,
4. Сонгуулийн ялалтын стратеги УБ., 2012.,

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ АРГА ЗҮЙ

Д.ОЮУНЧИМЭГ

*МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, докторант*

Түлхүүр үг: Сонгуулийн кампанит ажил. Сонгуулийн кампанит ажлын мэргэжилтнүүд. Сонгуулийн сурталчилгаа, түүний арга зүй

Abstract: Election advertisement differs from election campaigning. In other words, an election advertisement is an information and communication process for voters from election candidates and political parties which do not include the issue of fund raising, in-party list, distribution of working groups, vote counting, dispute solving solutions and etc.

Election advertisement is a very precise process performs within certain purpose, timing, strategy and tactics.

It is essential not only for political parties and candidates but also for electorates to make a choice whether to be rational or irrational on election.

Сонгуулийн хуулинд оруулсан шинэчлэлээр сонгуулийн кампанит ажлын хугацааг ажлын 14 хоног болгосон, бүх шатны сонгууль нэг хуулиар, нэг өдөр зохион байгуулагдах болсон зэрэг нь энэ жил явагдах бүх шатны сонгуулийн сурталчилгааны арга, хэлбэр, технологидбагагүй өөрчлөлт орох нөхцөл шаардлагыг үүсгэж байна.

Сонгуулийн кампанит ажил нь улс төрийн намууд, нэр дэвшигчдэд ялалт байгуулахад нь, иргэдсонгогчдод сонголтлоо хийхэд нь ач холбогдолтой төдийгүй, түүнийг зохион байгуулж явуулдаг мэргэжилтнүүдийн мэдлэг чадвар, ур ухааныг сорьсон, хүч хөдөлмөр шаардсан, сонгогчдын хийгээд сонгогдогчдын сонирхолыг татдаг үйлажиллагаа юм.

Өнгөрсөн зууны 30-аад оны эхэн үед Г.Лассуэль мэдээлэл харилцааны үйл явцын загвар боловсруулсан. Тэрхүү загвар нь “Хэн ярьж байна? – Юу мэдээлэв? – Хэнд мэдээлэв? – Ямар сувгаар мэдээлэв? – Ямар үр нөлөөтэй байв?” гэсэн таван асуулт, түүний таван хариултаас бүрддэг.

Лассуэль дээрхи загвартаа 20-иод жилийн дараа өөрчлөлт оруулан “Хэн? - Ямар санаа агуулж? - Ямар нөхцөлд? - Ямар нөөцөөр? - Ямар стратегихэрэглэж? - Ямар нөлөөлөл аудиторт үзүүлж? - Ямар үр дүнд хүрэв? гэсэн загвар болгон шинэчилсэн. Г.Лассуэлийн энэхүү загварыг ямар ч сонгуулийн кампанийн суурь загвар гэж үзэж болно.

Сонгуулийн кампанит ажил гэдэгт юуг ойлгож байна вэ? Энэ талаар олон янзын тодорхойлолт байдаг. Нэлээд нийтлэг тодорхойлолтын нэг бол: “... өргөн утгаар бол хуулиар дүрэмчилсэн, сонгуулийн комиссын зохион байгуулдаг, иргэнд хүсэл эрмэлзлэлээ чөлөөтэй илэрхийлэх боломж олгох дэс дараалсан арга хэмжээг сонгуулийн кампанит ажил гэж нэрлэнэ. Нарийвчилсан бол утгаар сонгуулийн кампанит ажил гэдэг сонгуулийг хүссэн үр дүндээ хүргэхэд чиглэсэн нэр дэвшигч ба түүний багийн (намын) үйл ажиллагаа юм. Ерөнхий утга агуулгаараа бол бүх нэр дэвшигч, улс төрийн намын кампанит ажлаас гадна засаг захиргаа, сонгуулийн комисс болон ерөөсөө сонгуулийн үйл явцад оролцсон бүх хүн болон байгууллагын үйл ажиллагааг өөртөө багтаадаг. Нэр дэвшигчийн (намын) сонгуулийн кампанит ажил сонгогчийн саналыг тоолж, сонгуулийн үр дүн гарснаар дуусдаг. Харин Сонгуулийн кампанит ажил эхэлсэн агшныг тогтоох нэлээн хэцүү” хэмээсэн тодорхойлолт юм. (1) (Е.Малкин, Е.Сучков 2011)

Судлаач Д.Баасансүрэн “сонгуулийн кампанит ажил” гэсэн ойлголтыг “сонгуулийн кампани” хэмээн нэрлэх санал дэвшүүлээд сонгуулийн кампанит ажлыг “сонгуулийг албан ёсоор зарласнаас хойших хугацаанд сонгуульд ялалт байгуулахын тулд нам, эвсэл, нэр дэвшигч, түүний сонгуулийн штаб, баг, шадар туслагчид, ухуулагчид болон намын гишүүд, дэмжигчдийн сонгуультай холбоотой хэрэгжүүлж буй сурталчилгаа, зохион байгуулалтын олон талт, өргөн хүрээтэй үйл ажиллагааны нийлбэр цогц” хэмээн тодорхойлсон байна. (2) (Д.Баасансүрэн 2012)

Сонгуулийн кампанит ажлын хугацааг хуульчлан тогтоох нь харьцангуй шинжтэй. Шууд утгаарулс төрийн намууд, нэр дэвшигчид хуулинд заасан тодорхой хугацааны дотор зөвшөөрөгдсөн арга, хэлбэрүүдээр сурталчилгаагаа явуулах эрх, үүрэгтэй.

Өргөн утгаар улс төрийн намууд, нэр дэвшигчдийн сонгуулиас сонгууль хүртэлхи хугацаанд хийж буй бүхий л үйл ажиллагаа нь сонгуулийн кампанит ажлын үндэс болдог. Өөрөөр хэлбэл улс төрийн нам болон намын лидерүүдийн хувьд энэхүү “перманент” буюу тасралтгүй үргэлжлэн явуулж буй улс төрийн үйл ажиллагаа нь ерөөс тэдний оршин тогтнох үндсэн арга юм.

Явцуу утгаар бол сонгуулийг албан ёсоор зарлаж, улс төрийн намууд сонгуульд өрсөлдөхөөр нэр дэвшигчдээ бүртгүүлж, сонгуулийн кампанит ажлын штабаа байгуулж, төсөл, календарчилсан төлөвлөгөө боловсруулж, сурталчилгааны арга хэлбэрээ сонгон хэрэгжүүлэх тодорхой хугацааны үйл явцыг хамааруулж сонгуулийн сурталчилгаахэмээн нэрлэж байна. Харин сонгогчийг ухуулах ухуулга сурталчилгаа үндсэндээ сонгуулийн өмнөх кампанит ажлуудын үед хийгдэж байдаг бөгөөд сонгуулийн кампанит ажлын үе бол тэр бүхнийг гагцхүү “хайрцаглаж” өгөх л үе юм. Иймээс сонгуулийн кампанит ажил, сонгуулийн өмнөх кампанит ажил нь арга, хэлбэр, агуулгын хувьд эрс ялгаатай төдийгүй түүнийг хүлээн авч буй сонгогчдын сэтгэл зүй ч ихээхэн ялгаатай, улмаар үр нөлөө нь ч өөр өөр байдгийг манай зарим улс төрийн намууд бүрэн тооцож чаддаггүй.

Богино хугацааны кампанит ажил нэлээд урт хугацаагаар үргэлжилсэн кампанит ажлаас илүү их санхүүгийн зардал шаарддаг байна. “Шинжээчдийн үнэлгээгээр бол орон нутагт хийх дөрвөн сарын кампанит ажил ижил үр нөлөөтэй боловч зөвхөн нэг сарын хугацаанд явуулах кампанит ажлаас ойролцоогоор 2 дахин бага санхүүгийн зардал шаарддаг ажээ.”(3) (А.Б.Зверинцев 2003)

Сонгуулийн кампанит ажил төвшин, хамрах цар хүрээ, төрлөөрөө өөрөөрхэлбэрүүдтэй. Сонгуулийн кампанит ажлын хэлбэр бүр стратеги, тактик, технологийн хувьд ялгаатай байх боловч харин тэдгээрийн арга зүйн үндэс нэг юм.

2016 онд УИХ-ын болон орон нутгийн сонгууль нэгэн зэрэг явагдахучир энэ үед сонгуулийн кампанит ажлыг хоёр өөр төвшинд нэгэн зэрэг явуулах “зэрэгцсэн кампанит ажил” явагдахаар харагдаж байна.

СудлаачА.Б.Зверинцевийн тодорхойлсноор сонгуулийн кампанит ажил бол зохион байгуулагдсан мэдээлэл харилцаа юм. Тэгвэл энэхүү кампанит ажлын технологи гэж чухам юу вэ? Зарим сонгуулийн дүнг “бохир” технологийн үр дүн байсан гэж үзэх хандлага сонгогчид төдийгүй нэр дэвшигчдийн дунд ч байдаг. Энэхүү “технологи” сонгуулийн үед гайхамшигийг бүтээдэг үү? “Технологи” сайн байх явдал нь амжилтанд хүрэх түлхүүр мөн үү?

Дээрхи асуултанд судлаачид болон судалгаануудын дүн нэгдсэн хариулт өгч чаддаггүй, үүнээс үүдэн зарим нэр дэвшигчдийг бухимдуулж, төөрөлдүүлдэг. Жишээ нь мэргэжлийн ном зохиолдээрээс “Хэрэв сонгуулийн үе дэх гайхамшигийн тухай ярих хэрэгтэй юм бол харин ч технологи талаасаа сул сонгуулийн кампанит ажил заримдаа ёс мэт амжилттай болдог явдалд энэ гайхамшиг оршино. Гэхдээ сонгуулийн технологи, технологич хэрэггүй гэж баталвал ... санаанд оромгүй нэлээн таагүй зүйлстэй учрах болно. ... Сонгуулийн сайтар мэргэшсэн “технологич” хэнийг ч хаана ч сонгуулах боломжтой гэсэн үзэл бодол амьдрал дээр яагаад ч батлагдахгүй байна” гэх зэрэг санаануудыг олж үзэж болно. (4)(Е.Малкин, Е.Сучков, 2011)Энэ бүхэн уг салбарын нэр томъёонууд, тэдгээрийн агуулгын зөрүү, тэр ч бүү хэл мэргэжилтнүүдийн ажил үүргийн талаархи ойлголтын зөрөөтэй холбоотой зөрчлийг илтгэж байна.

“Технологи” хоосон орон зайд оршин тогтнодоггүй. Гагцхүү ярьж,хийж бүтээжбуй үйл ажиллагаа бүрийг технологийн дагуу хийх л гэж байна. Тэгэхлээр сонгуулийн кампанит ажлын “технологич” бол “PR-ийн мэргэжилтэн” хараахан биш юм. Гагцхүү “PR-ийн мэргэжилтэн”-ний зүгээс шаардлагатай гэж үзэж, сонгуулийн штаб хүлээн зөвшөөрсөн үед л “бохир технологи”-ийн элементийг хэрэглэх нөхцөл үүсдэг.

Зарим судлаачид сонгуулийн “бохир технологи”-ийг хууль зөрчсөн үйл ажиллагаа гэж үздэг тал бий. Гэвч сонгуулийн “бохир технологи” нь хуулийн хүрээнд, хууль зөрчилгүй хийгддэгээрээ онцлогтой.

Дээрхи асуудалтай холбоотойгоор зайлшгүй авч үзэх ёстой сэдэв бол сонгуулийн кампанит ажлыг хэн хэрхэн хэрэгжүүлэх нь зохистой вэ гэдэг асуудал юм.

“Таныг хэн хамгийн сайн мэдэх вэ? гэсэн асуултанд бид “эцэг, эх, найз нөхөд, эхнэр, нөхөр, эсвэл би өөрийгөө сайн мэднэ” хэмээн хариулдаг. Тэгвэл хүмүүс яагаад өөрийгөө сайн танихгүй эмч, хуулийн зөвлөх, үсчин дээр очдог вэ? Учир нь тэд “мэргэжлийн” учраас. Иймээс сонгуулийн кампанит ажлыг гагцхүү “мэргэжлийн” баг байж л зардал чирэгдэл багатай, оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлнэ.Жишээ нь хөдөө орон нутагт нэр дэвшигчийн багийн дийлэнхийг орон нутгийн ухуулагч нараас бүрэлдүүлж болох хэдий ч төв удирдлага нь “мэргэжилтнүүд”-гүйгээр амжилттай ажиллах боломжгүй гэсэн үг юм.

Сонгуулийн кампанит ажлыг оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлбэ гэвэл: “Имижмейкер”, “PR менежер”, “Улс төрийн зөвлөх”, “Эх зохиогч”, “Хэвлэлийн нарийн бичиг”, “Сөрөг байдлыг эмчлэгч”, “Хэлэлцээр хийгч”, “Сэтгэл зүйч-оператор”, “Хямралыг шийдвэрлэгч”, “Цуурхлын мэргэжилтэн”, “Рекламын мэргэжилтэн” зэрэг нарийн мэргэшсэн мэргэжилтнүүдийн туслалцаа хэрэгтэй болно.”(5)(Е.Н.Пашенцев 2000)

Сонгуулийн кампанит ажлыгтардан хэрэгжүүлдэг дээрхи мэргэжилтнүүдийг бүгдийг нь авч ажиллуулах боломж хомс, нөгөө талаас зарим чиглэлийн мэргэжилтэн боловсон хүчин дутмаг байдаг, гол нь тэдгээрийн ажил үүргийн хуваарийн талаар зарим нэр дэвшигчид ташаа ойлголттой байдаг зэргээс үүдэн тэдгээр мэргэжилтнүүдэд янз бүрийн эрх, үүргийг хольж хутган хавсаргаж гүйцэтгүүлэх явдал багагүй ажиглагддаг. Тухайлбал “имижмейкер”-ийг сонгуулийн кампанит ажлыг зохион байгуулагчаар ажиллуулах, эсвэл сурталчилгаа болон олон нийттэй харилцах асуудлыг хариуцсан “PR менежер”-ийн үүрэг гүйцэтгүүлэх,

“улс төрийн зөвлөх”, “сонгуулийн менежер”, “улс төрийн технологич” нарын ажил үүргийг хольж хутгах зэрэг алдаа оноо гарсаар байна.

Аль нэг мэргэжилтэн нөхцөл байдлаас хамааран сонгуулийн кампанит ажлын өөр мэргэжилтний үүргийг хавсран гүйцэтгэж болно. Гэвч тэдгээр нь өөр хоорондоо зөрчилдсөн, уялдаа холбоо муутай болох аваас хэмнэлтээс илүү хохирол дагуулдаг.

Сонгуулийн кампанит ажлын стратеги, тактик гэж юу вэ? Сонгуулийн кампанит ажлын стратеги, тактикаа боловсруулахаас өмнө кампанит ажлынхаа “нөөц”-ийг нарийвчлан тодорхойлж, зөв байрлал дээр нь тавих явдал нэн чухал.

Үүнд “үндсэн” болон “нэмэлт” нөөцөө авч үзнэ. Үндсэн нөөцөд мөнгө санхүүгийн хэрэгслээс гадна нийгэм-улс төрийн бүтцэд тулгуурласан нэр дэвшигчийн өөрийнх нь чадвар болон цаг хугацаа, мөн оюуны буюу мэргэжилтнүүдийн нөөцийг хамааруулан авч үзэхийн зэрэгцээ энэхүү үндсэн нөөц ажилласнаар үүсэх нэмэлт нөөцөд: хүний нөөц буюу гишүүд дэмжигчдийн нөөц, улс төрийн нөөц, мэдээллийн нөөц, материаллаг нөөц зэрэг нь нэр дэвшигчтэй холбоотой. Эндээс харахад нэр дэвшигч өөрөө сонгуулийн кампанит ажлын хамгийн гол, суурь нөөц болж байна.

Сонгуулийн кампанит ажлын дээрхи нөөцүүдийн зэрэгцээгээр манай улсын хууль, журам, төрийн захиргааны бүтэц зохион байгуулалтаас үүдэн тодоос тод үүрэг гүйцэтгэж буй өөр нэг нөөц бол “засаг захиргааны нөөц” юм. Ийм нөөцийг судлаачид “сонгуулийн бохир технологид хамааруулж үздэг бөгөөд хамгийн бохир болоод шударга бус нь юм” хэмээн тэмдэглэдэг. (6) (Е.Малкин, Е.Сучков, 2011)

Мэдээж сонгуульд өрсөлдөж буй намууд, нэр дэвшигчдийн нөөц харилцан адилгүй. Иймд дутмаг нөөцөө бусад нөөцөөрөө нөхөж ажиллана гэсэн үг юм.

Ард түмэн хэнийг сонгодог вэ? Сонгогч чухам юуны төлөө саналаа өгдөг вэ? Сонгогчийг санал өгөх сэдэл, шалтгаанаас нь хамааран “хувийн чиг баримжаатай сонгогч”, “улс төрийн чиг баримжаатай сонгогч” гэсэн хоёр бүлэгт хуваан авч үзвэл асуудлын хариултыг олоход дөхөм болно. Ийм нөхцөлд сонгогчийн эхний бүлгийн хандлагыг “төгс нэр дэвшигчийн хандлага”-аар, харин хоёр дахь бүлгийг “нийгэм-эдийн засгийн хандлага”-аар тус тусад нь тодорхойлж болмоор харагдаж байна. Гэвч үнэн хэрэг дээр бүх зүйл арай өөр байдаг. Сонгогчийн санал өгдөг жинхэнэ шалтгааныг тэдэнд тавьдаг асуултаас олох хэцүү. Асуулгад оролцогсдын үнэн сэтгэлээсээ хариулсан хариултанд үндэслэн таамаглалыг гаргаж ирж болох ч бодит байдал дээр тэдний сонголт хийхэд нь тун өөр механизм үйлчилсэн байдгийг судлаачид хүлээн зөвшөөрдөг.

Ийнхүү сонгогчдын санал өгөх сэдэл шалтгааныг бүрэн төгс тодорхойлох боломжгүй ч сонгуульд өрсөлдөгчдийн зүгээс кампанит ажлын “үндсэн” нөөц хүчин зүйлдээ анхаарал хандуулан ажиллах нь нэн тэргүүний зорилт юм. Энэхүү үндсэн нөөцөд “цаг хугацаа”, “мөнгө санхүү”, “нам болон нэр дэвшигчийн имиж”, “хүн хүчний нөөц” хамаарагдагийг өмнө тэмдэглэсэн. Тэдгээрээс цаг хугацааны нөөцийг өсгөн нэмэгдүүлэх боломжгүй, мөнгө санхүү болон боловсон хүчний нөөцийг зөв менежментээр зохицуулах боломжтой байдаг бол харин нэр дэвшигч болон улс төрийн намын имиж бүрдүүлэлт цаг хугацаа, хүч хөдөлмөр, бодит үр дүнг шаарддаг чухал нөөц юм.

Нэр дэвшигчийн имиж гэж юу вэ? “Нэр дэвшигчийн имиж гэдэгт тухайн хүний талаар бусад хүмүүс, олон нийтийн олж сонссон, таньж мэдсэн бүхий л зүйлийг багтаан ойлгодог. Тухайлбал нэр дэвшигчийн гадаад дүр төрх, зан төрх, бусдад ойлгогдсон сэтгэгдэл, нэр хүнд, бусдаас өгсөн үнэлгээ багтдаг. Сонгогчид нэр дэвшигчийг байгаагаар нь бүрэн таньж мэдсэн учраас бус харин өөрийн ойлголт, төсөөлөл, үнэлгээг үндэслэн дэмждэг. Үнэн хэрэг дээрээ нэр дэвшигчдийг имижээр нь таньж, үнэлж дүгнэн, сонгодог байна.

Нэр дэвшигчид имиж яагаад хэрэгтэй байдаг вэ? Хэрэв ямар нэгэн хүн эсвэл объект танд таалагдаж байвал танд эерэг сэтгэгдэл, эерэг имиж төрж байна гэсэн үг. Харин танд таалагдахгүй байвал сөрөг сэтгэгдэл, сөрөг имиж төрж байна гэсэн үг. Аливаа хүн өөрт таалагдсан хүнтэй хамтран ажиллах, түүнийг дэмжин, сонгохыг хүсч байдаг. Ийм учраас улс төрийн зүтгэлтнүүд, улс төрийн лидерүүд, улс төрийн намууд олон нийттэй харилцаа холбоо тогтоож тэдний санаа бодолд эерэгээр нөлөөлөхийг эрмэлздэг, өөрсдийн имижийг бүрдүүлэхэд онцгой анхаардаг.

Имиж нь объектив хүчин зүйлээр нөхцөлдсөн субъектив шинжийг илэрхийлдэг. Улс төрийн лидерт имиж бүрэлдэх үйл явц нь нэг талаас “жам ёсны дагуу урсгалаараа бүрэлдэх” үйл явц, нөгөө талаас мэргэжлийн үүднээс зориудаар удирдан явуулж буй “бүрдүүлэх” үйл ажиллагаа хоёрын хамтын үр дүн байдаг. Эхнийх нь урсгалаар явдаг учир алдаа оноо ихтэй бол хоёр дахь нь алдаа багатай, оновчтой, илүү үр дүнтэй байдаг.

Нэр дэвшигчийг бусад хүмүүстэй адил гэж харуулах нь зөв үү? Эсвэл бусад хүмүүстэй адилгүй гэж харуулах нь зөв үү? Аль нь ч биш юм. Өөрөөр хэлбэл “хүн”-ий хувьд бусад хүмүүстэй адил, харин “мэдлэг чадвар”-ын хувьд бусад хүмүүстэй адилгүй болохыг харуулах нь илүү үр дүнтэй.

Имижмейкер нэр дэвшигчийн имижийг “өсгөх”, “хадгалах” гэсэн үндсэн хоёр хандлагаас сонгон ажиллах төдийгүй олон чиглэл, баялаг агуулга, хэлбэрээр, арга, тактикаар хэрэгжүүлдэг. Улс төрийн лидерийн имиж бүрдүүлэх суурь хүчин зүйл нь нэр хүнд, мэргэжлийн ур чадвар. Иймээс имижмейкер нэр дэвшигчийнхээ мэргэжлийн ур чадварыг “нэр хүндтэй байдал”, “өөртөө итгэлтэй байдал”, “байнгын чанар”, “хяналт тавих чадвар” гэсэн чадваруудыг нь тодосгож өгөх нь зүйтэй байдаг. Имиж хоосон орон зайд үүсэхгүй. Өөрөөр хэлбэл хийж бүтээсэн зүйлгүй, буруу зүйлд орооцолдсон нэр дэвшигч байх аваас ямар ч имижмейкер байгаад тус болохгүй төдийгүй өөрийн улс төрийн намын имиж, нэр хүндийг унагахад хүрнэ.

Имиж улс төрийн лидерт хэрэгтэй байж, түүнийг амжилт хийгээд ялагдалд хүргэж байдаг зүйл төдийгүй төрийн эрх барихын төлөө өрсөлдөж буй улс төрийн намуудад түүнээс ч дутуугүй хэрэгцээтэй. Олон нийт, сонгогчдын талархал, дэмжлэг бол улс төрийн намын оршин тогтнох, амжилтанд хүрэх үндэс.

Улс төрийн намын имиж гэдэгт тухайн намын үзэл суртал, үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр, дүрэм журам, олон нийттэй тогтоосон холбоо харилцаа, явуулж ирсэн хийгээд явуулж буй үйл ажиллагаа, үйл ажиллагааны арга хэлбэр, дотоод ардчилал, санхүүжилт, лидерүүдийн нэр хүнд, боловсон хүчний бодлого зэрэг бүхий л хүчин зүйлсийг хөгжил хөдөлгөөн дунд нь авч үзэх шаардлага тулгарна. Эдгээр хүчин зүйлс бүхэн тухайн намын имижийг бүрдүүлэхэд өөр өөрийн нөлөөгөө ямагт үзүүлж байдаг.

Монголын улс төрийн намуудын өнөөгийн нэр хүнд, имиж ямар байна вэ? Үүнийг хэн нэгэн судлаач өөрийн таамаглалаар тодорхойлж болохгүй. Гагцхүү сонгогч иргэдийн үнэлэлт дүгнэлт, хандлагаар тодорхойлогдоно.

Монголд нам тус бүрийн имиж ямар байна вэ гэдгээс гадна ерөнхий ойлголт болох “улс төрийн нам” гэж юу вэ? Түүний өнөөгийн нийгэмд түүний гүйцэтгэж буй үүрэг ролийн талаархи олон нийтийн үнэлэлт дүгнэлт буюу “улс төрийн нам” гэсэн ойлголтын имиж чухал үүрэг гүйцэтгэж байдаг. Олон нийтийн дунд “улс төрийн нам бол авилгын загалмайлан эцэг”, “улс төрийн нам бол албан тушаал хөөцөлдсөн хүмүүсийн нэгдэл”, “улс төрийн нам бол хоосон амлагчид”, “улс төрийн нам бол нийгмийг хагалан бутаргагчид” гэх зэргээр сөрөг имиж оршин үйлчилж байвал аль ч улс төрийн намд сөргөөр нөлөөлнө.

Харин “улс төрийн нам бол нийгмийн идэвхитэй хэсгийн нэгдэл”, “улс төрийн нам бол оюуны тинк танк төв”, “улс төрийн нам бол шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бодлого боловсруулдаг байгууллага”, “улс төрийн намууд байж гэмээнэ нийгмийн улс төрийн тогтолцоо бүрэлдэнэ” зэргээр эерэг имиж оршин үйлчилж байвал бүхий л улс төрийн намуудын үйл ажиллагаанд таатай суурийг тавьж өгнө.

Гэвч энэ суурин дээр ордон сүндэрлүүлэх, эсвэл муухан майхан барьж тэр нь нуран унах эсэх нь тухайн намаас бүрэн хамаарна. Монголын улс төрийн намууд өөр өөрийн имижтэй оршиж, тэрхүү имиж нь тодорхой хугацаанд харьцангуй өөрчлөгдөж байдаг. Улс төрийн намууд өөрийн имижээ олонталт имижийн хэв маягийн дагуу авч үзсэний үндсэн дээр задлан шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, засвар хийж, “хайрцаглаж” хэлбэржүүлж байдаг.

Улс төрийн намын тань имиж таны амжилтын үндэс. Сонгуульд нэр дэвшигч бүр нас, хүйс, үзэл баримтлал, нам, эвсэл зэрэг “корпоратив буюу бүлгийн имиж”-ээсээ ангид байх боломжгүй.

Сонгуулийн сурталчилгаа бол сонгуулийн кампанит ажилтай ижил ойлголт бус юм. Өөрөөр хэлбэл хөрөнгө босгох, нам дотроо нэрсийн жагсаалт гаргах, тойрогт нэр дэвших, сонгуулийн тойрог, хэсгийн хороонд хэн ажиллах, санал тооллогыг хэрхэн явуулах, маргааныг хэрхэн хянан шийдвэрлэх зэрэг үйл ажиллагаануудыг оролцуулалгүй гагцхүү нэр дэвшигч болон улс төрийн намын зүгээс сонгогчдод чиглэсэн мэдээлэл харилцааны үйл ажиллагааг сонгуулийн сурталчилгаа гэнэ. Энэ бол тодорхой цаг хугацаанд явагддаг, зорилго, нөөцөө тодорхойлсны үндсэн дээр стратеги, тактикаа боловсруулж хэрэгжүүлдэг, нарийн технологи шаардсан үйл ажиллагаа.

Сонгуулийн сурталчилгаа нь улс төрийн нам, нэр дэвшигчдэд чухал төдийгүй сонгогчдод бодит мэдээлэл олж авах, шүүн тунгаах, сонголтоо бодитой хийх, тэдний сонголтонд рациональ эсвэл иррациональ хүчин зүйлийн нөлөөлөл давамгайлах эсэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлж байдаг.

Дэвшүүлсэн зорилго, цаг үеийн шаардлага, нөхцөл байдал, өрсөлдөгчид, нөөц, боломж зэргээс үүдэн сонгуулийн сурталчилгааны арга, аргачлал нэгэн жороор хийгдэх боломжгүй. Сонгуулийн кампанит ажлын арга зүй, аргачлалыг авч үзэхдээ “параметр”, “гармония”, “доза” гэх зэрэг бараг орчуулалгүй хэрэглэгддэг зарим ойлголтуудын нарийн утгыг мартаж болохгүй.

Сонгуулийн кампанит ажлын стратеги, тактик гэж юу вэгэдэгт тогтсон ганц хариулт байх боломжгүй. Сонгуулийн кампанит ажлын стратегийг буруу сонговол “өөрийгөө буудахтай адил зүйл болно” гэсэн хэллэг байдаг. Сонгуулийн кампанит ажлын стратегид үндсэндээ улс төрийн нам, нэр дэвшигчид сонгогчийг санал өгүүлэхийн тулд тэдэнд чухам юуг хүргэх хэрэгтэйг тусгах бөгөөд үүнтэй зэрэгцэн тактикаа боловсруулна. Сонгуулийн кампанит ажлын стратеги харьцангуй “түгээмэл” шинжтэй байдаг. Сонгуулийн кампанит ажлын ямар ч стратеги сонгогч сонголтоо хийхэд түлхэж өгдөг сэдэл, шалтгааныг олж мэдэхэд чиглэх бөгөөд тэрхүү олж мэдсэн төсөөлөл дээрээ үндэслэн үйл ажиллагааны чиглэл, загвараа сонгон ажиллана. Сонгогчийн санал өгөх сэдэл шалтгааныг олж тогтоох нь эргэлзээтэй, ялангуяа “хөвөгч” буюу хөдөлгөөнт сонгогчийн сонгуульд хандах хандлагыг урьдчилан хэлэх явдал бараг ашиггүй ажил болдог байна. Гэвч сонгуулийн кампанит ажлын стратегийг боловсруулахдаа суурь электоратын стереотип, болон “хөвөгч” буюу хөдөлгөөнт сонгогчдын сонголтын чиг баримжааг анхааран судлах нь кампанит ажлын тактик боловсруулахад зайлшгүй шаардагддаг хүчин зүйлсийн нэг юм.

Сонгуулийн кампанит ажлыг “электоратын хандлага”, “гэнэнхандлага”, “хөтөлбөрийн хандлага”, “аппаратын буюу элитийн хандлага”, “гэнэн корпоратив хандлага”, “нийгэм-эдийн засгийн хандлага”, “төгс нэр дэвшигчийн хандлага”, “асуудал хөндөх хандлага”, “иж бүрэн хандлага”, “ялгах буюу хаягийн хандлага”, “сурталчилгааны хандлага”, “стереотип хандлага” зэрэг олон загваруудад түшиглэн зохион явуулж байна.

Сонгуулийн кампанит ажлын стратегийг зөвхөн нэг хандлага дээр үндэслэн боловсруулж болохгүй. Сонгуулийн кампанит ажлын баг стратеги байхгүй байх аваас нөөцөө үр ашиггүй зарцуулахад хүргэдэг бол

харин стратегийг буруу сонговол нөөцөөсонгогчийн саналыг олж авахад бус бүр тэдний саналыг алдахад зарцуулагддаг байна.

Стратеги боловсруулахад ямар мэдээлэл зайлшгүй цуглуулах шаардлагатай вэ? гэсэн асуудлыг шийдэхийн тулд нэр дэвшигчийн имижийн үндсэн шинжийг тодорхойлох хэрэгтэй болно. Үүний тулд түүний мэргэжлийн болон ёс суртахуун, зан чанарын талаархи мэдээлэл, улс төрчийнхөө хувьд тааламжтай болон тааламжгүй сэтгэгдэл төрүүлэх шинж чанарууд, улс төрийн нам, бүлэг, гэр бүл, эд хөрөнгө, эрүүл мэнд, дадал зуршил, найз нөхдийн талаархи зэрэг мэдээллүүд дээр нь үндэслэж нэр дэвшигчтэй хамтран шийдвэрлэх нь манай нөхцөлд илүү дөхөмтэй байдаг.

Мэдээллийн цуглуулга ньгухайн нэр дэвшигчийн параметр болдог ач тустай зүйл. Түүнээс гадна өрсөлдөгчдийн талаархи боломжит мэдээллийг цуглуулвал үйл ажиллагааны чиг хандлагаа тодорхойлоход тустай. Мэдээлэл цуглуулах үйл явц сонгуулийн кампанит ажлын зорилготой яг таг тохирч байх ёстой бөгөөд гагцхүү үнэн зөв бүрэн мэдээлэл дээр оновчтой стратеги, тактик боловсрогдоно.

Сонгуулийн кампанит ажлын тактик нь тухайн зорилт, үйл ажиллагаа бүрт цаг үеийн нөхцөл байдал, боломж, нөөц зэргээс үүдэн уян хатан, оновчтой байхыг шаардаж байдаг. Сонгуулийн кампанит ажлын стратеги, тактик харилцан уялдаатай, оновчтой байх төдийгүй сонгон хэрэглэж буй тактик ямар ч нөхцөлд үндсэн стратегиас гажихгүй байж амжилтанд хүрнэ.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Е.Малкин, Е.Сучков, Сонгуулийн технологийн үндэс-1, УБ., 16-р тал
2. Д.Баасансүрэн, “Монгол дахь сонгуулийн кампанийн технологи” УТШУ-ны докторын зэрэг горилсон бүтээл, 33-р тал
3. А.Б.Зверинцев “Мэдээлэлхарилцааныменежмент PR”, Орч УБ., 2003, 111-р тал
4. Е.Малкин, Е.Сучков, Сонгуулийн технологийн үндэс-1, УБ., 16-р тал
5. Е.Н.Пашенцев Паблик рилейшнз от бизнеса до политики, Москва, 2000
6. Е.Малкин, Е.Сучков, Сонгуулийн технологийн үндэс-1, УБ., 38-р тал

НОМ ЗҮЙ

1. Алмонд Г ба бусад Харьцуулсан улс төр: онолын хүрээ УБ.,
2. Дагвадорж. Д Маркетингийн судалгаа, УБ., 2007
3. Зверинцев.А.Б Мэдээлэл харилцааны менежмент, УБ., 2003
4. Малкин.Е, Е.Сучков.ЕСонгуулийнтехнологийн үндэс-1, УБ., 2011
5. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2009
6. Оюунчимэг.Б Лидерийн сэтгэл зүй УБ., 2001
7. Чимид Б. Сонгуульд суралцахуй. УБ., 2012
8. В.И.Васильев Путеводитель по избирательной кампании, Москва, 1999
9. С.Ф.Лисовский, В.А.Евстафьев Избирательные технологии, Москва, 2000
10. А.А.Максимов “Чистые” и “грязные” технологии выборов, Москва, 1999
11. А.Ю.Панасюк Вам нужен имиджмейкер? Москва, 2000
12. Е.Н.Пашенцев Паблик рилейшнз от бизнеса до политики, Москва, 2000

БАЙГАЛИЙН БАЯЛАГ БА УЛС ТӨР

Ч.ӨЛЗИЙСАЙХАН

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш дэд профессор

Ц.ӨЛЗИЙЖАРГАЛ

Улс төр судлалын магистр

Хураангуй: 1990 оны ардчилсан хувьсгалаар зах зээлийн эдийн засаг, ардчилсан улс төрийн тогтолцоо бүх зүйлийг зохицуулж бүх нийтээрээ аж жаргалтай, сэтгэл хангалуун амьдарна гэсэн итгэл найдвар тээж шинэ нийгмийн харилцаанд улс нийтээрээ шилжин орсон. Харин түүнээс хойшхи 26 жилийн түүх бол зах зээлийн эдийн засаг, ардчилсан засаглал, газар доохи асар их байгалийн баялаг бол ухаалаг төрийн бодлогогүйгээр ард нийтийн сайхан амьдралыг бий болгож чадахгүй юм байна гэдгийг нэгэнт ойлгуулж өглөө. Иймээс эдгээр харилцааг хэрхэн зохицуулах нь оновчтой вэ гэдэг талаар судлаачид нэгэнт анхаарлаа хандуулж эхэлжээ. Энэ эрэл хайгуулд хувь нэмрээ оруулахаар энэхүү өгүүллийг бичлээ.

Түлхүүр үг: Байгалийн баялаг, баялагийн хараал, улс төрийн намын амлалт, эх орны хишиг, иргэдийн хүлээлт

Abstract: Due to democratic revolution in 1990, the whole country transferred into new social relations with a great hope that market economy and democratic political relations could regulate everything and the nation can play a happy wealthy life. However, the history of 26 years since then made us conscious that only market economy, democratic governance and underground wealth can create healthy and wealthy life without smart state policy.

Байгалийн баялгийн арвин их нөөцтэй улсуудын өнөөгийн байдал

Дэлхийн улс орнуудын хөгжлийн түүх өөр өөрийн өвөрмөц онцлогтой. Хөгжил дэвшил, дэлхийн улс орнуудын хувьд үнэлж цэгнэгдэх байдал нь ч хөгжлийн түвшин, хүний эрхийн байдал, улс орны хүч чадлаас хамааран өөр өөр байна. Харин судлаачид төдийгүй, жирийн иргэдийн дунд ч бүс нутгуудын талаар төстэй ойлголтууд бий болох хандлагатай байна. Тухайлбал, Япон, Өмнөд Солонгос, Тайвань, Сингапур, Хонгонг гэх мэт азийн улс орнууд байгалийн баялаг багатай ч хүний нөөц, технологийн дэвшил дээрээ тулгуурлан эрчимтэй хөгжиж байгаа бүс нутаг бол Арабын хойгийн болон Нордикийн бүс нутгийн улсууд нефтийн их баялагаа зөв захиран зарцуулсан тул нийгмийн халамжийн бодлогыг амжилттай явуулж дэлхийд хөгжил болон баян чинээлэг амьдралын түүхээрээ гайхагдаж байгаа улс орнууд, Европын улс орнууд аж үйлдвэржилтийн үеэс эхлэн дэлхийн улс орнуудад тэргүүлэх байр суурь эзэлсээр байгаа орнууд, Африк тивийн улс орнууд бол байгалийн асар их баялагтай ч нийгмийн хөгжил дорой, иргэний дайн самуун ихтэй, өвчин зовлон, ядуурлаасаа гарч чадахгүй зовж байгаа ард түмэн гэх мэт нийтлэг төрхүүдийг тоймлон зурж болно. Газрын тос, алмаз, эрдэс түүхий эд зэрэг анхдагч бүтээгдэхүүний томоохон экспортогч орнуудын эдийн засгийн өсөлт нь ихэнх тохиолдолд бусад орнуудынхаас хоцорч явдаг байна. Энэ үзэгдлийг “баялгийн хараал, баялгийн гай” гэж нэрлэжээ.

Энэ хараал нь ямар үр дагаварт хүргэх вэ?

Байгалийн баялаг ихтэй боловч энэхүү баялагаа хэрхэн зарцуулах талаар хяналтын механизм муутай улс орнуудад үдэсний аюулгүй байдлаа хангах чадамж султай, нийгэм нь цөөн тооны баячууд болон нийгмийн дийлэнх ядуучууд гэсэн ялгаварал гарахад хүргэжээ. Энэ нь ард иргэд, төр засаг, хөрөнгө оруулагчдын хооронд үл итгэх байдал, ашиг сонирхлын зөрчлийг бий болгож байна. Байгалийн баялагаас үүдэлтэй зөрчил мөргөлдөөн дэлхий дээр нилээд их гарч байна. Тухайлбал, сүүлийн үед дэлхийн улс орнуудад гарсан 17 зөрчлийн 7 нь Африкийн улс орнуудад гарчээ.

Байгалийн баялагтай холбоотой зөрчил мөргөлдөөнүүд нь эргэн сэргээгдэхүй байгалийн баялгын зарцуулалт, бараа бүтээгдхүүний үнийн өсөлт, хэрэглэгч орон болон нийлүүлэгч орны хөгжлийн зөрүү илт ажиглагдах болсон нь эдийн засгийн бодлогын үр өгөөжийн талаар эргэлзээтэй байдал, сэтгэл дундуур байдлыг бий болгож байгаа, зарим улс орнуудад худалдааны эмзэг байдал бий болгож, улс орныг хамарсан эдийн засгийн хямралын нэг чухал хүчин зүйл болж байгаа зэрэг уламжлалт бус зөрчлүүдийг бий болгож өрсөлдөөн, мөргөлдөөнд хүргэх нь цөөнгүй байна.

2035 он гэхэд Азийн эрчим хүчний хэрэглээ 2, нефтийн хэрэглээ 2, байгалийн хийн хэрэглээ 3 дахин, нүүрсний хэрэглээ 81 хувиар өсөх тооцоо гарчээ¹. Хүн амын нягтаршил ихтэй Ази тивийн хамгийн их тулгамдсан асуудал бол түүхий эд, эрчим хүчний асуудал болж байна. Байгалийн баялгийн нөөцийн өнөөгийн төлөв байдлыг ажиглавал, Ази тив тэр дундаа Зүүн Хойд азийн бүс нутгийн байгалийн хий, газрын тосны

¹ “Байгалийн баялагийг ашиглахад үндэсний аюулгүй байдлыг тооцох нь” Цаг төр.мн. УБ., 2013. 11. 13

гол нөөц, нийлүүлэгч нь энэ төрлийн түүхий эдээр хамгийн баялаг улсууд болох Оросын Холбооны Улс, Монгол Улс болох нь эргэлзээгүй байна.

Монгол Улсын хувьд эрдэс баялгийн салбар эрочимтэй хөгжиж байгаа боловч энэ талаар төрөөс баримталж байгаа бодлогод сэтгэл дундуур байгаа байдал нэн их байгаа бөгөөд энэхүү бодлогыг Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд нийцүүлэх, үндэсний ашиг сонирхлыг гадаадын хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолтой “хоёр тал хоёулаа хожих” гэсэн зарчимд нийцүүлэх замаар харилцан итгэлцсэн хамтын тогтвортой ажиллагааг бий болгох нь юу юунаас илүү чухал байна.

Байгалийн баялгийг дагадаг хараал зүхлийн гол аюул бол ашигт малтмалын түрээс ардчилалд гажуудал үүсгэдэг явдал юм². Өнөөгийн монголын улс төрийн эдийн засгийн харилцан хамааралын байдал, ард түмний дуу хоолой, ашиг сонирхол энэ чиглэлийн төрийн бодлогод тусгагдаж байгаа байдал зэргийг тунгаан үзвэл үнэхээр ардчилал гажуудалд орсон, үүнийг засах хойшлуулашгүй шаардлага байгааг харуулж байна.

Байгалийн баялаг ба улс төр

Сүүлийн үеийн мэдээллийн хэрэгсэлүүд, судалгаа шинжилгээний ажлуудад шинжилгээ хийж үзвэл хэдэн жилийн өмнө байгаагүй олигархижсан төр, улс төрийн намуудын бэлэн мөнгөний амлалт, баялгийн хараал, гадныхантай хуйвалдсан эрх баригчид гэх мэт ойлголтууд ихээхэн гарах болжээ.

“Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” хэмээн үндсэн хуулиндаа заасан. Энэ хуулийн заалт бол байгалийн баялаг бол ард түмний эрх ашигт зориулагдах ёстой болохыг хоёргүй утгаар заасан байгаа билээ. Өөрөөр хэлбэл, байгалийн баялаг бол олсон хүний өмч биш харин хэн ч олж илрүүлсэн байсан гэсэн өмчлөгч нь нэгэнт урьдаас тодорхой заагдсан байгаа билээ. Олон зуун жилийн турш ард түмэн хойч үедээ өвлүүлж хадгалж ирсэн байгалийн баялгийг нийт ард түмэнд биш харин цөөхөн хэдэн эрх мэдэлд байгаа хүмүүсийн тусын тулд зориулж байгаа нь улс оронд баян ядуугийн ялгаа, орлогын зөрүүтэй байдлыг урьд хожид байгаагүй хэмжээгээр ихэсгэж, үүний улмаас зүй ёсоор эзэмших ёстой баялгаасаа хүнийсгэгдсэн нийгмийн дийлэнхи олонхийн эсэргүүцлийг нэмэгдүүлж, ингэснээр нийгмийн зөрчил тэмцэл, бослого самууны учир шалтгаан болж улс орны хэдэн арван жилийн хийж бүтээсэн бүтээн байгуулалт, хөгжлийн үр дүнг устган үгүй хийхэд хүргэж байгаа болохыг улс орнуудын түүх бэлхэнээ гэрчилж байна.

Монгол Улс газрын доорхи баялгаараа дэлхийд тэргүүлэх орнуудын нэг болжээ. Гэтэл энэ их баялгийг цөөн хэдэн компаниуд уралдан экспортлосоор зөвхөн өөрсдөө асар их баялаг бий болгож байгаа боловч энэ их баялгийг ашигласны үр шим ард олны амьдарлыг дээшлүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулж чадахгүй байна.

Өөрөөр хэлбэл, дэлхийн зах зээл дээр өсөн нэмэгдэж байгаа байгалийн баялгийн эрэлтийг даган байгалийн баялгийн үнэ өсч, энэ нь Монгол улсын эдийн засагт таатай байдлыг бий болгож байгаа мэт боловч нийгэмд сөрөг байдлыг бий болгосоор байна. Тухайбал: төрийн эрх мэдлийг гартаа авсан улс төрийн намууд мөрийн хөтөлбөртөө худал амлалт оруулж “Эх орны хишиг”, “эрдэнийн хувь” гэх мэт нийт ард түмний дунд эрдэс баялагийн орлогын хүлээлтийг үүсгэж байна.

Амлалт, нийгмийн хүлээлт хоёрын хоорондхи зөрүү улам ихсэхийн хэрээр зөрчил нэмэгдэж иргэд, нийгмийн бухимдал нэмэгдэж байна.

Монгол улс ардчиллын 25 жилийн хугацаанд хавтгайрсан халамжийн орон болж хүүхдийн 10000, 20000 төгрөг, залуу гэр бүл 500000 төгрөг, оюутны 70000 төгрөг, “Эх орны хишиг” нэг сая төгрөг зэрэг сонгуулийн амлалтуудыг улс төрийн намууд тооцоо судалгаагүй амлаж, хэрэгжүүлснээр эдийн засагт ихээхэн дарамт үүссэн. Улс төрийн намууд төр, засгийн эрхийг гартаа авахын тулд халамжид дуртай ард түмнээ сонгуулиар ашиглаж байгалийн баялгийн орлого болох бэлэн мөнгө амласнаас Монгол улс халамжийн орон болоод байна. Үүнийг дараах улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр дэх амлалтуудад зарцуулсан мөнгөн дүнгээс харж болох юм. (Хүснэгт 1-ээс харна уу)

№	Сонгуулийн амлалтын нэр	Нам	Он	Хэрэгжүүлсэн он	Төсөв	Зарцуулсан мөнгө	Гарсан үр дүн
1	Х ү ү д и й н мөнгө	Ардчил-сан нам	2004 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрийн гол уриа	2005 оноос хэрэгжсэн.	1 сая 450,000 хүүхдэд төсөвлөсөн боловч 954 мянган хүүхэд авсан.	120 тэрбум төгрөг*4 жил=480 тэрбум төгрөг	
2	Залуу гэр бүлийн 500,000 төгрөг	МАХН	2004 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрийн гол уриа	2006 оноос хэрэгжсэн.	15,000 гэр бүл гэрлэлтээ батлуулж байсан бол 30,000 гэр бүл гэрлэлтээ баталгаажуулсан.	15 тэрбум төгрөг*3 жил= 45 тэрбум төгрөг	Жилд 1500 гаруй гэр бүл гэр бүлээ цуцлуулдаг байсан бол энэ тоо 4000 -д хүрсэн байна.

² Пол Коллиер. “Адагт үлдсэн тэрбум” УБ., 2009, хуудас 55-р талд

3	Эх орны хишиг	МАХН, АН	2009 оны 6 сарын 24-нд хамтран ажиллах гэрээний 5-д “Стратегийн болон томоохон орд газруудаас олсон орлогоос 1,5 саяас доошгүй төгрөгийн хэмжээгээр Монгол улсын иргэн бүрт хүртээнэ” гэж заасан.	2010 оны 2 сараас эхлэн олгосон.	2,9 сая иргэнд 500,000 төгрөг буюу 1,4 их наяд төгрөг олгохоор болсон.	2011 онд 133,000 оюутны сургалтын төлбөрт 66,9 тэрбум төгрөг, 2012 онд 144,000 оюутны сургалтын төлбөрт 71 тэрбум төгрөг, 2013 онд Эх орны хишигийг бэлэн мөнгө хэлбэрээр 2,9 сая иргэнд 1,4 их наяд төгрөгийг олгосон байна.
---	---------------	----------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------	------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Эх сурвалж: “Хулгайчгүй Монгол хөдөлгөөн” <http://www.myf.mn>

Монгол Улсад уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Ардчилсан нам, Иргэний Зориг Ногоон нам, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвсэл хамтран Монгол улсын засгийн газрын 2012-2016 онд Хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан гаргажээ. Үүнд:

- ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход тухайн орон нутгийн иргэдийн оролцоог хангах;
- ашиглалтын тусгай зөвшөөрлийг Засгийн газрын шийдвэрт үндэслэн олгодог болгох;
- аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд олгох ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоонд тодорхой хязгаарлалт тавих;
- ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг орон нутгийн саналд тулгуурлан зөвхөн төрөөс тогтоосон нутаг дэвсгэрт олгодог болгох;
- улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн стратегийн ордууд дээр байгуулагдах компанийн 51-ээс доошгүй хувийг Монголын тал эзэмших;
- стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтыг шинэчлэн, томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулахыг эрчимжүүлэх. Стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшлийг нэгтгэн, корпорацийн зохион байгуулалтад оруулж, Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу иргэдэд давуу эрхийн хувьцаа олгоно... гэж заажээ.

Уул уурхайн салбараас эдийн засгийн хамаарах хамаарлыг бууруулах, урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах, өрсөлдөх чадвар бүхий олон тулгуурт эдийн засгийг бий болгох нь эдийн засгийн бодлогын тэргүүлэх зорилт болно хэмээн тодорхойлсон. Гэвч улс төрийн албан тушаалтнууд ашигт малтмалын наймаа, төсвийн хөрөнгөөр хийгдэх хайгуулын тендэрүүдийг өөрсдөд ашигтай байдлаар зохицуулж нөөц баялаг ихтэй улс орны хувьд түүхий эдийн хавсарга, гадаад дотоодын улс төр бизнесийн ашиг сонирхлын сөргөлдөөний талбар болох эрсдэлтэй байдалыг бий болгосоор байна. Байгалийн баялагийг эзэмшиж буй улсын төрийн бодлого, төрийн ноён нуруу баялагаа баялаг болгох уу? хараал болгох уу? гэсэн сонголтод ихээхэн нөлөөлдөг байна. /Монгол улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын зургыг Зураг №1-ээс харна уу./

Зураг №1. Монгол улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд



Эх сурвалж: <https://www.google.mn>

Монголд нийт 4 лиценз эзэмшдэг Канадын “Энтри Голд” компани Монголын Оюутолгойн ордын баруун болон зүүн хэсэгт нээсэн алтны ордынхоо график дүрслэлийг дэлхий дахинаа зарлаж хөрөнгө оруулалт татаж эхэлжээ. “Энтри гоулд” компани уг ордын нөөцийг Японы арлыг алтаар гурван удаа бүрхэхүйц хэмээн тодотгоод байна³. Монгол Улсад олон жил уул уурхайн салбарт үйл ажиллагаагаа явуулж байгаа ба эдгээр компаниудын түүхийг судлахад олборлолт хийж байсан улсдаа баялагийн хараал ба ерөөлийн аль алийг нь авч ирсэн байна.

Монгол улсын хувьд хичнээн их байгалийн баялагтаа атлаа иргэд нь ядуу буурай амьдарч байгаагийн гол шалтгаан бол ашигт малтмалын лицензийн наймааг улс төрийн намуудын цөөн хэдэн олигархичууд хийж сонгуулийн жил бүр иргэдэд хуурамч амлалт өгч луйвардагт байгаа юм. Үүний нэг илрэл бол НҮБ-аас жил бүр дэлхийн улс орнуудыг аз жаргалаар нь эрэмблэсэн жагсаалт гаргадаг. Тус жагсаалтын “2016 оны аз жаргалын индекс”-т манай улс дэлхийн 157 орноос 101 дүгээр байрт орсон байна. Энэ нь бид хичнээн их байгалийн баялагтай, цөөн хүн амтай боловч улс төр, төр засагтаа итгэх ард түмний итгэл суларсан, байгалийн баялагийг ард түмэн хүртэхгүй байна.

Зураг №2

92	 Pakistan	5.132	
93	 Lebanon	5.129	
94	 Portugal	5.123	
95	 Macedonia	5.121	
96	 Vietnam	5.061	
97	Somalland region	5.057	
98	 Tunisia	5.045	
99	 Greece	5.033	
100	 Tajikistan	4.996	
101	 Mongolia	4.907	
102	 Laos	4.876	
103	 Nigeria	4.875	
104	 Honduras	4.871	
105	 Iran	4.813	
106	 Zambia	4.795	
107	 Nepal	4.793	
108	Palestinian Territories	4.754	
109	 Albania	4.655	
110	 Bangladesh	4.643	
111	 Sierra Leone	4.635	

Эх сурвалж: <http://undesten.mn>

Монголын улс төрийн эдийн засгийн харилцан хамааралын байдал, ард түмний дуу хоолой, ашиг сонирхол энэ чиглэлийн төрийн бодлогод тусгагдаж байгаа байдал зэргийг тунгаан үзвэл үнэхээр ардчилал гажуудалд орсон, үүнийг засах хойшлуулашгүй шаардлага байгааг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Байгалийн баялаг, байгаль орчны асуудал нь нийт иргэдийн хувьд нэн тэргүүнд тавигдаж байгаа бөгөөд энэ нь нүүдэлчин уламжлал, өвөг дээдсээс уламжлан ирсэн эх байгалиа тэр чигээр нь хадгалан хойч үедээ үлдээх гэсэн үндсэн гол үнэт зүйл, язгуур соёлтой салшгүй холбоотой. Нөгөө талаар ардчилалд шилжсэнээс хойш хараа хяналтгүй олгосон уул уурхайн ашиглалтын лиценз зөвшөөрөл, хариуцлагагүй төр, уул уурхайгаас үүдсэн их хэмжээний газар нутгийн хөрсний бохирдол, бэлчээргүйдэл, гол горхи, булаг шанд, усны хомсдол зэрэг бий болж экологи болон нийгмийн тэнцвэрт байдал их хэмжээгээр алдагдсанг илтгэж байна.

Монгол орон байгалийн нөөц ихтэй жижиг улсын хувьд бүс нутгийн геостратегийн ашиг сонирхлын солбилцол болж, түүхий эдийн хавсарга, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын сөргөлдөөний талбар болох эрсдэл үүсээд байна. Байгалийн баялагаас үүдэлтэй зөрчил, сөргөлдөөний гол эх сурвалж нь үндсэндээ баялгийн шударга бус хувиарлалт байдаг бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтыг хэт дэмжин ард иргэдийнхээ амьдралыг доройтуулах нь зөрчил үүсэх нөхцөл болдог байна. Монгол Улс бүс нутгийн геостратегийн ашиг сонирхлын солбилцол болж, түүхий эдийн хавсарга, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын сөргөлдөөний талбар болох эрсдэлтэй.

³ Оюутолгойгоос хэд дахин том орд Монголоос нээснээ зарлалаа. <http://www.inet.mn/>

НОМ ЗҮЙ

1. “Адагт үлдсэн тэрбум” П.Коллиер, УБ., 2009 он
2. МУИС, Бизнесийн их сургууль “Уул уурхай түшиглэсэн эдийн засаг дах макро эдийн засгийн удирдлага ба бизнесийн хөгжил” ОУЭШХИЭ. УБ., 2014 он
3. “Монголын хүн амын сэтгүүл”. УБ., 2013 №22 \390\
4. Байгалийн баялагийг ашиглахад үндэсний аюулгүй байдлыг тооцох нь., <http://tsagtur.mn/>
5. Д.Содном “Монгол улсын ашигт малтмалын ордыг үр ашигтай ашиглах асуудалд”сэдэвт судалгаа тайлан <http://blog.amarjargal.org>
6. Хөгжил ба байгалийн баялаг. Нээлттэй нийгэм форум, <http://www.forum.mn>
7. Ц.Даваадорж, Р.Анарбаяр “Эрдэс баялагаас үүдэлтэй зөрчлийн тухайд” МУТСНХ, Монголын улс төр асуудал, эрэл шийдэл. №2 УБ., 2011
8. Д.Мягмарсүрэн “Улс төрд баялгийн үзүүлэх нөлөөлөл ба Монгол улс” <http://www.ulstor.com>
9. “Хулгайчгүй Монгол хөдөлгөөн” МЗХ-ны сонин / <http://www.myf.mn/>
10. “Таван толгой” дахь бидний өмч, өмч биш өр болсон нь <http://sonin.mn/news/politics-economy/11334>
11. <https://www.google.mn>
12. Оуютолгойгоос хэд дахин том орд Монголоос нээнээ зарлалаа. <http://www.inet.mn/>
13. “Монгол Улс аз жаргалгүй орон болсоор байна” <http://undesten.mn/index.php>

БҮГД НАЙРАМДАХЧУУДГҮЙ БҮГД НАЙРАМДАХ УЛС

Г.ЦЭНД-АЮУШ

*Доктор, дэд профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхим*

Д.СҮХБОЛД

Улс төр судлалын тэнхимийн докторант

Түлхүүр үг: парламентат ёс, шударга сонгууль, эрх мэдэл, абсентиезм.

Хураангуй: Бүгд найрамдах засгийн мөн чанар алдагдаж эрх мэдэл залгамжилсан “хэмжээгүй эрхт хаант засгийн” хэлбэртэй болсон тухай. Сонгууль бол элитийн циркуляци явагдах гол механизм болох, дэлхийн зарим улсуудад парламентийн гишүүд хэрхэн солигдож шинэчлэгддэг талаар өгүүлэв.

Краткий обзор: В данной статье говорится о том, что как народное государство потеряло свою сущность и превратилось по форме “неограниченную наследственную” власть, как главный механизм для выборов является циркуляция элитов и как происходит обновление членов парламента в некоторых современных государствах.

Сонгууль бол төлөөллийн ардчиллын амин сүнс. Сонгуулийн талаарх үзэл баримтлал эртний Грек, Ромын үеэс эхлэлтэй. Бүр тодруулбал Эртний грекийн их сэтгэгч Платон “Төр” зохиолдоо хууль тогтоогчдыг заавал сонгуулиар сонгох ёстой, сонгууль 3 үе шаттай явагдах бөгөөд эхний шатанд иргэдээс төрийн алба хаах чадвартайд тооцогдсон 360 хүнийг сонгох, дараа нь уг 360-аас 100-г дахин сонгоод эцсийн шатанд төр барих 37 хүнийг сонгох тогтолцоог дэвшүүлжээ. Харин улс төрийн сэтгэлгээний түүхийн анхдагч сэтгэгчдийн нэг Аристотельнэг хүний ганцаар захиран дарангуйлах дэглэм болох эзэн хааны засаглалыг шүүмжлээд ард иргэдийн олонх нь төрийн засгийг барих ёстой гэжээ.

Ард иргэдийн олонх нь /сонгуулиар сонгогдсон- Д.С/ засгийн эрхийг барьдаг төрийн засаглалын хэлбэрийг орчин үед Бүгд найрамдах засаг гэдэг. Энэхүү бүгд найрамдах засгийн гол шинж засгийн эрх барих хүчин болон лидер нь бүх нийтийн сонгуулиар сонгогдог ба эргээд иргэд сонгогчдынхоо өмнө ажлаа тайлагнадаг.

Түүхийг сөхөн үзвэл эртний Ромд МЭӨ 509 онд тэр үеийн язгууртнууд болох патрицууд эзэн хааныг хаан ширээнээс нь түлхэн унагаж, төрийн эрхийг сенатад шилжүүлснээр бүгд найрамдах засгийг тогтоожээ. 17-18-р зууны үед өрнөсөн Англи, Франц, Голландын хөрөнгөтний хувьсгалуудын эцсийн зорилго тэр үеийн хэмжээгүй эрхт хаант засгийг түлхэн унагаж, сонгуулиар сонгогддог бүгд найрамдах засаглалыг тогтоохын төлөө байсан бол 1921 онд монголчууд харийн дарлалаас эх орноо чөлөөлж, улмаар 1924 оны анхны үндсэн хуулиар хаант засаглалаас бүгд найрамдах засаглалд шилжсэн юм.

Орчин үеийн улс төрийн ном зохиолд төрийг засаглалын хэлбэрээр нь хаант ба бүгд найрамдах гэж ангилж үздэг. Өдгөө дэлхий дахинд хаант засагтай 36 орчим улс байгаагаас 30 орчим нь хэмжээт, 6 нь хэмжээгүй эрхт хаант засгийн хэлбэрээр, оршиж буй бол 150 орчим улс бүгд найрамдах засгийн хэлбэрээр оршин тогтнож байна.

Хэмжээт эрхт хаант засаг болон бүгд найрамдах засгийн үед л засгийн эрхийн төлөөх бүх нийтийн сонгууль явагддаг. Л.Эктон “Их эрх мэдэл хүнийг эвддэг бол хязгааргүй эрх мэдэл хүнийг илүү их эвддэг” гэж хэлсэнчлэн 4 болон түүнээс дээш жилээр төрийн өндөр дээд албан тушаалд байсан хүн хамрынхаа үзүүрээс цаашхийг харахаа больдог нь гэм биш зан. Нэрт сэтгэл судлаачид болох З.Фрейд, Э.Фромм, Англи, Францын алдарт сэтгэгчид болох Т.Гоббс, Ж.Руссо, якобинчуудын гарамгай удирдагч болох Ж.П.Марат нар хүний бусдаасаа ялгарах хүсэл, эрх мэдэл, засаглал уруу үргэлжид тэмүүлдэг байгалийн төрөлх зан араншинг зоригтойгоор хэлж шүүмжилж байв. Энэ ч учраас дэлхийн ихэнх улс орнуудад төр засгаа сонгох сонгуулийг 4-5 жил тутамд тогтмол явуулдаг. Ардчиллын нэрт онолч Р.Даль “Тогтмол явагддаг чөлөөт шударга сонгууль гэж байхгүй бол ардчилал үгүй”¹⁵¹ хэмээн дүгнэжээ. Харин ард түмний сонголтын, үндсэн дээр эмхлэгдэн байгуулагдсан төр нь улс төрийн тавцан дээр гарч ирчихээд эргээд олон түмний итгэл найдварыг хөсөрдүүлсэн зан авир гаргаж, дураараа авирлаж эхэлбэл ард түмэн түүнийг эсэргүүцэн тэмцэх эрхтэй гэсэн санааг иргэний нийгмийг үндэслэгч Английн сэтгэгч Т.Гоббс, эрх зүйт төр болон либерализмыг үндэслэгч Ж.Локк, нийгмийн гэрээний онолын шинэ шатанд гаргагч Францын соён гэгээрүүлэгч Ж.Руссо нар өөрсдийн үзэл баримтлалдаа дэвшүүлсэн байдаг. Эзэгнэн захирагч бурхны таалалд үл нийцэх бодлого явуулбал түүнийг залхаан цээрлүүлэх, бүр хаан эзнийг егүүтгэх нь хүртэл шударга үйлдэл болно гэсэн санааг 12-р зууны Английн сэтгэгч, хуульч И.Солсберский өөрийн зохиол бүтээлдээ тэмдэглэжээ. Тэгвэл орчин үед төрд эсэргүүцэл үзүүлэх эрхээ эдлэхдээ ард түмэн аль болох улс төрийн соёлтой хандаж түүнийгээ байнга явагддаг чөлөөт шударга сонгуулиар илэрхийлэх боломжтой болжээ.

¹⁵¹ Р.Даль “Ардчиллын тухай” УБ 1998 он 76-р тал

Иймээс сонгууль бол хүн төрөлхтөний хувьд төрийг шударгаар тогтоон барих, хянах, болохгүй бол солих боломжтой зохицуулагч механизм мөн. Цаашлаад сонгууль нь бүрэн эрхийн хугацаандаа хангалтгүй үйл ажиллагаа явуулсан төр болон улс төрийн зүтгэлтнийг олон нийтийн зүгээс эгүүлэн татах, огцруулах улмаар түүнийг шинээр эмхлэн байгуулах, дахин сонгох асуудлыг төвөггүй шийдэх, нөгөө талаас төрийн зүгээс өөрийнхөө явуулж буй бодлого үйл ажиллагааг олон нийтээр дүгнүүлэх түүнээс үнэлэлт авах процесс юм. Харин монголчуудын хувьд 1924 оны анхны үндсэн хуулиараа хаант засгаас бүгд найрамдах засагт шилжиж, 1992 онд ардчилсан шинэ үндсэн хуулиараа бүгд найрамдах засгаа улам баталгаажуулж парламентын засаглалыг сонгон авсан. Ингээд 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012 онуудад засгийн эрхийг барих хүчинг сонгох сонгуулийг нийт 6 удаа хийжээ.

Гэтэл аль 1992 оны сонгуулиар парламентийн гишүүн болж байсан хүмүүс 2012 онд буюу бүхэл бүтэн 20 жилийн дараа дахиад л парламентын болон засгийн газрын гишүүнээр сонгогдож болон томилогдож байх юм. 1992 оноос хойш бүр тасралтгүйгээр төрийн өндөр дээд албан тушаал болон парламентын гишүүнээр ажилласан нэр бүхий хүмүүс ч байна. Тэдгээр хүмүүс өөрсдийгөө мэргэшсэн парламент ч гэж сайрхан нэрлэдэг.

Гэтэл улс төрийн шинжлэх ухаан болоод түүний салбар ухаан болох парламент судлалд¹⁵² “мэргэшсэн парламент ч” гэх нэр томъёо огтоос үгүйг тэдгээр эрхмүүд мэддэггүй нь харамсалтай. Олны танил улс төрчид сонгуульд нэр дэвшээд унана гэдэг бол ард түмэн тэдгээр хүмүүсийг дэмжихгүй, дахин төрийн өндөр дээд албан тушаал хашихыг нь хүлээн зөвшөөрөхгүй, шууд хэлбэл тэр хүний улс төрийн карьерт цэг тавьж байна гэсэн үг. Гэтэл сонгуульд унасан хүнийг намын шийдвэрээр засгийн газрын гишүүн болоод төрийн өндөр дээд албан тушаалд томилдог гэж тогтолцоо тогтсоор удлаа. Сонгогдсон ч сонгогдоогүй ч хорь гучин жилээр төрийн өндөр дээд албан тушаалуудыг үе улиран хашихдаа нэг салбараас огт өөр нөгөө нэг салбар уруу шилжиж ажилладаг, яг л хүүхэддэйн кинонд гардаг шиг бүхнийг чадагч супермен улс төрчидтэй Монголд угсаа залгамжилсан бүгд найрамдах төр нэгэнт батжин тогтжээ. Угсаа залгамжилсан бүгд найрамдах төр гэсэн нэр томъёо улс төрийн шинжлэх ухаанд огт байдаггүй ч өнөөгийн монголын улс төрийн нөхцөлд логик алдаатай энэхүү шинэ нэр томъёог хэрэглэхээс өөр гарц алга.

Эртний Энэтхэгийн нийгэм улс төрийн харилцааг олон зуун жил зохицуулж ирсэн кастын системд хүний ажил үүргийн хуваарилалтыг бурхнаас цаанаас нь заяасан гэж ойлгоод боол бол насаараа боол, цэрэг, худалдаачин бол насаараа цэрэг, худалдаачин удирдагч брахман бол насаараа брахман байсаар насыг бардаг байж. Брахманы хүүхэд хичнээн ухаан мулгуу, тэнэг байсан ч брахманы үр удам учраас брахман л байна, боолын хүүхэд хичнээн авьяас билэг төгс байсан ч боолын үр удам учраас боол хэвээрээ л байна. Яг түүн шиг монголын цус нь ойртсон зуун хэдэн улс төрчдийг бурхан цаанаас нь насаараа төрийн өндөр дээд албан тушаал хашиг гээд заяачихсан юм болов уу?

Тэд ч эртний энэтхэгийн брахманууд шиг насаараа УИХ-ын гишүүн, ЗГ-ын гишүүн байгаад зогсохгүй үр хүүхдүүдээ хүргэл ирээдүйн брахман болгохоор зорьж хар залуугаас нь яам тамгын газрууд уруу чихэж байна. Харин хөөрхий ард түмэн бид хичнээн мэдлэг боловсролтой, ухаан төгс байгаад ч насаараа боол байж, насаараа тэднээр удирдуулах заяатай бололтой. Гэтэл дэлхийн хүн төрөлхтөнд төр удирдах хичээлийг олон удаа заасан ухаант өвөг дээдэс маань “хааны алба халаатай, эзний алба ээлжтэй, эргэх нар ээлжлэх төр”, гэх мэтчилэнгээр төрийн албыг нэг хүн насаараа хашиж болохгүй, заавал солигдож шинэчлэгдэж байх ёстойг ёгтлон өгүүлсэн байдаг. Эртний монголчуудын философи сэтгэлгээнд байдаг загас толгойноосоо өмхийрч, тос дотроосоо өтнө, голын эх нь булингартай бол адаг нь булингартай гэх хэлцүүдийн утгыг өнөөгийн Монголын шинээр солигдож шинэчлэгддэггүй, алдаа гаргасан ч улс төрийн хариуцлага хүлээдэггүй, ард түмэн дэмжихгүй сонгохгүй байсан ч намын томилгоогоор төрийн өндөр дээд хариуцлагатай албан тушаалд гардаг, үүнээсээ хэзээ ч ичдэггүй, улс төрийн соёл ёс зүйгүй, ардчиллын амин сүнс болсон сонгуулийг хэлбэрийн төдий болгосон улс төрчдөд хамаатуулж болохоор санагдана. Үнэхээр монголын төр толгойноосоо өмхийрч, дотроосоо өтсөн мэт. Уг нь сонгууль бол засгийг хянах, солих боломжийг ард түмэнд өгсөн ардчиллын үнэт зүйл бөгөөд шууд хэлэхэд төр засагт анхааруулга өгч болохгүй бол шинэчилж өөрчилдөг ард түмний бойкот /хориг тавих/ юм.

Элитийн онолыг үндэслэгч Италийн нэрт эрдэмтэн В.Парето “элитийн циркуляци” гэсэн онол гаргажээ. Энэ онолоор нийгмийг удирдагч анги, удирдуулагч анги гэж хоёр хуваагаад, удирдагч анги болох элитүүд заавал шинэчлэгдэж, цус сэлбэгдэж байх ёстой, хэрвээ шинэчлэгдэхгүй бол нийгэм урагшлан хөгжихгүй гэжээ.

1789 оны Францын агуу их хөрөнгөтний хувьсгалын якобинчуудын гарамгай удирдагч Ж.П.Марат тэр үеийн шинэчлэгдсэн франц орныг удирдах шинэ үндсэн хуулийн төсөлдөө “Засгийн газрын гишүүнээр ажилласан хүнийг дараагийн 10 жилийн хугацаанд засгийн газрын болоод парламентийн гишүүн байх эрхийг нь бүрмөсөн хориглох “заалтыг оруулсан байдаг. Орчин үед ч гэсэн парламентийн гишүүдийг болон төрийн өндөр дээд албан тушаалтнуудыг нэг л удаа сонгодог тогтолцоог зарим улс орнууд амжилттай хэрэгжүүлж байна. Тухайлбал, Бүгд найрамдах Солонгос улс нь ерөнхийлөгчийн засаглалтай улс бөгөөд ерөнхийлөгчийг бүх нийтийн шууд сонгуулиар нэг л удаа 5 жилийн хугацаагаар сонгодог, ерөнхийлөгч дахин сонгогдох эрхгүй. Хууль тогтоох дээд байгууллага болох Үндэсний ассамблейн гишүүн ч гэсэн 4 жилийн хугацаагаар нэг л удаа сонгогдох эрхтэй. Гэхдээ Үндэсний ассамблейн гишүүд засгийн газрын гишүүн давхар байж болдог.

¹⁵² Улс төр судлалын ном зохиолуудаас дээрх нэр томъёог хайгаад олоогүй

¹⁵³ Америкийн нэгдсэн улсын хууль тогтоох дээд байгууллага болох Конгресс нь сенатын болон төлөөлөгчдийн гэсэн 2 танхимтай бөгөөд Сенатын танхимын бүрэн эрхийн хугацаа 6 жил байдаг ч нийт гишүүдийн бүрэлдэхүүний гуравны нэг нь 2 жил тутамд шинээр сонгогдож шинэчлэгдэж байдаг. Харин төлөөлөгчдийн танхим нь муж улс бүрийн хүн амаас хоёр жил тутам сонгосон гишүүдээс бүрдэнэ.

Японы хууль тогтоох дээд байгууллага болох Дайет буюу парламент нь Төлөөлөгчдийн танхим, Зөвлөхүүдийн танхим гэсэн гэсэн 2 танхимаас бүрдэх бөгөөд зөвлөхүүдийн танхимын бүрэн эрхийн хугацаа 6 жил байдаг ч нийт гишүүдийн 50 хувь нь 3 жил тутамд шинээр сонгогдож байдаг.

Тэгвэл 1991 онд ЗХУ-аас салж тусгаар тогтнолоо зарласан¹⁵⁴ Казахстан улс нь Сенат, Мажалис /үндэсний хурал/ гэсэн байнгын ажиллагаатай 2 танхимтай парламенттай бөгөөд сенатын танхимын бүрэн эрхийн хугацаа 6 жил байдаг ч нийт гишүүдийнх нь 50 хувь нь 3 жил тутамд шинэчлэгдэж өөрчлөгдөж байдаг тогтолцоотой. ¹⁵⁵Франц улс Сенат, Үндэсний ассамблей гэсэн 2 танхим бүхий парламенттай, Сенат нь 9 жилийн хугацаагаар сонгогдсон 321 гишүүдээс бүрдэж байсан бөгөөд 2004 оноос бүрэн эрхийн хугацаа нь 6 жил, гишүүдийн тоог хүн амын өсөлттэй уялдуулан 2010 оноос 346 болгон нэмэгдүүлсэн. Гурван жил тутамд Сенатын нийт гишүүдийн гуравны нэг нь шинэчлэгддэг байсан бол одоо нийт гишүүдийн 50 хувь нь 3 жил тутамд солигдож шинэчлэгддэг болжээ. Харин бүгд найрамдах ¹⁵⁶Чех улсын хууль тогтоох байгууллага нь Сенат, Депутатуудын танхим гэсэн 2 танхимаас бүрдэх ба Сенатын бүрэн эрхийн хугацаа мөн 6 жил ч хоёр жил тутамд нийт 81 гишүүний гуравны нэгийг сонгох сонгууль болдог.

Энд жишээ болгон авсан улсуудын хууль тогтоох байгууллагууд Солонгосоос бусад нь дандаа 2 танхимтай байгаа боловч яг хууль тогтоох танхимынх нь гишүүд /тухайлбал Сенат/ ихэвчлэн солигдож шинэчлэгдэж байгааг анхаарах хэрэгтэй.

Монголын улс төрийн системд лидерийн цус сэлбэлт хийгдэхгүй гаднах нийгмийн зүгээс ирж буй шаардлагад систем идэвхитэй хариу өгч дасан зохицож чадахгүй, удаа дараалан засгийн газар огцорч, энэ хирээрээ нийгэм эдийн засаг тогтворгүй болж засаглалын хямрал гаарч буй энэ тохиолдолд иргэдийн улс төрөөс залхах, улс төрийн намууд болоод төр засгийг үзэн ядах, хэн нь ч гарсан адилхан гэж үзэх хандлага ихсэж энэ нь сонгуульд үл оролцох хэлбэрээр илэрч байна.

Тухайлбал өнгөрсөн 2012 оны УИХ-ын сонгууль болоод орон нутгийн сонгуульд оролцох иргэдийн ирц өмнөх сонгуулиудыг бодвол эрс буурч УИХ-ын сонгуулийн ирц 78% орон нутгийн сонгуулийн ирц бүр 50 хувьдаа ч хүрэхгүй дахин сонгууль явуулсан. Өмнөх сонгуулиудад 80, 90%-ын ирцтэй оролцдог байсан иргэдийн идэвхи ингэж огцом буурсан нь монголын улс төрийн системд том аюулын харангыг дэлдэж байна. Энэ бол ард иргэдийн тайван замаар дургүйцлээ илэрхийлж, төрд бойкот тавьж байгаагийн шинж. Монголын сонгогчдын сонгуулийн идэвхи буурсан энэ үйл явцыг ардчилал өндөр хөгжсөн барууны улс орнуудад ажиглагддаг сонгуулийн эрхтэй мөртлөө сонгуульд сайн дураараа санал өгөхгүй байх үзэгдэл буюу ¹⁵⁷абсентизмтэй адилтгаж тайлбарлах нь үнэхээр учир дутагдалтай. Сонгуулийн эрхтэй сонгогчид сонгуульд оролцохгүй байх нь ардчилал өндөр хөгжсөн орнуудын хувьд тогтвортой үзэгдэл төдийгүй аяндаа бий болсон сонгуулийн "тоглоомын" бичигдээгүй дэг журам болсон байдаг. Сонгогчид сонгуульд оролцохгүй байх нь улс төрийн янз бүрийн үр дагавартай байж болох боловч энэ нь тодорхой хэмжээнээс хэтрээгүй тохиолдолд улс төрийн системийн хэвийн үйл ажиллагаанд төдийлөн нөлөөлдөггүй байна. Барууны орнуудад эдийн засаг тогтвортой, иргэний нийгэм төлөвшсөн, бүр тодруулбал тэнд ард иргэдийнх нь эдийн засгийн эрх чөлөө хангагдсан байдаг учраас засгийн газрын үйл ажиллагаа болоод сонгуулийг төдийлөн ойшоодоггүй сонгогчдын хэсэг үүссэн байдаг. Эсрэгээрээ Монголд эдийн засаг тогтворгүй, иргэний нийгэм төлөвшөөгүй, иргэдийн эдийн засгийн эрх чөлөө хөнгагдаагүй, төр засаг нь өдрөөс өдөрт томрон данхайж, татвар, даатгал нэрээр ард иргэдээ хуульчлан тонож буй энэ үед иргэдийн төр засагтаа итгэх итгэл өдрөөс өдөрт унаж тэр хирээрээ улс төрийн систем нь засаглалын легитим шинжээ улам бүр алдаж, сонгууль нь ямар ч үнэ цэнэгүй зүйл болох дээрээ тулж байна.

Ард түмэн сонгуулийн үйл ажиллагааг бойкотлох зорилгын үүднээс санал хураалтанд оролцохгүй байх нөхцөл боломжийг ч үндсэн хуулинд тусгаж болох үндэстэй. Гэтэл бүр эсрэгээрээ монголын сонгогчдын ирц сонгууль бүрт унаж байгаа учраас үндсэн хуулинд сонгуульд саналаа заавал өгөхийг иргэн бүрийн журамт үүрэг гэж зааж өгөх талаар сүүлийн үед ярих болж, үүнийг хөхүүлэн дэмжигчид ч бас цөөнгүй олширчээ.

Ардчилсан нийгэмд улс төрийн хүчнүүд сонгогчдын идэвхийг дээшлүүлэх талаар ихээхэн анхаардаг бөгөөд Австри, Австрали, Бельги, Голланд, Итали зэрэг орнуудад сонгогчдыг сонгуульд оролцохыг нь үүрэг болгосон тухай хууль үйлчидэг. Гэхдээ дээр хэлсэнчлэн сонгуульд санал өгдөггүй хэсэг нь улс төрийн системийнх нь үйл ажиллагаанд ноцтой нөлөө үзүүлдэггүй. Харин монголын төрийн удаа дараагийн засаглалын хямралаас болж сонгогчдын ирц унаж, тэр нь монголын улс төрийн системд аюулын дохиог өгч байгааг зогсоохын тулд сонгуульд заавал санал өгөхийг хүчээр хуульчилж болохгүй. Хэрэв ингэвэл монголын төр айдас, албадлага дээр тулгуурласан улс төрийн дэглэм уруу шилжсэн гэсэн үг. Түүхэнд ийм дэглэмүүд урт удаан хугацаанд оршин тогтноогүйг дэлхий нийтээр мэднэ.

Мөн ингэж хуульчлах юм бол ард түмний тайван замаар төрд эсэргүүцлээ илэрхийлэх цорын ганц боломж хаагдана. Яагаад гэвэл ардчилсан сонгуулийн амин сүнс болсон таван үндсэн зарчмын нэгийг устгаж буй учраас тэр. /чөлөөтэй байх зарчим/ Сонгуулийн таван үндсэн зарчим гэдгийг товчоор өгүүлбэл:

¹⁵³ Д. Цолмон Ч.Лхагважав "АНУ-ын үндсэн хууль" УБ., 2000 он

¹⁵⁴ Ж.Төртогтох "Парламент судлалын гарын авлага" 59-р тал

¹⁵⁵ Ж.Төртогтох "Парламент судлалын гарын авлага" 135-р тал

¹⁵⁶ Ж.Төртогтох "Парламент судлалын гарын авлага" 145-р тал

¹⁵⁷ Абсентеизм /Сонгуулийн эрхтэй сонгогчид сонгуульд сайн дураараа орохгүй байх үзэгдэл/ Б.Энхболд " Улс төрийн шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь" УБ 2005 он 12-р тал

1. Сонгууль бүх нийтийн байх зарчим /Тухайн улсын насанд хүрсэн нийт иргэд сонгуульд оролцох эрхтэй гэсэн санаанд үндэслэгдэнэ/
2. Тэгш эрхийн зарчим /нэг хүн 1 санал/
3. Шууд байх зарчим /сонгуулийн эцсийн үр дүн нийт иргэдийн санал хураалтаар шууд шийдэгдэнэ/
4. Чөлөөтэй байх зарчим /Сонгуулийн эрхээ эдлэх эсэх нь иргэний өөрийнх нь хувийн хэрэг бөгөөд сонгуульд оролцохыг албаддаггүй, оролцсонгүй гэж шийтгэл хүлээлгэдэггүй/
5. Санал нууцаар гаргах зарчим /Сонгогч ямар нэг дарамт шахалтгүйгээр чухам аль нам эвсэл, нэр дэвшигчийн төлөө өгч буй нь нууц байх/

Монгол улсын үндсэн хуулийн 21-р зүйлийн 2.т “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.” гэж заасан байдаг. Эндээс “сонгуульд иргэд чөлөөтэй оролцоно” гээд иргэдийн тайван замаар дургүйцлээ илэрхийлэх боломжийг ард түмний мэдэлд үлдээсэн мэт байдаг ч мөн үндсэн хуулийн 22-р зүйлийн 1.т “Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсгийг нь хамарсан гэнэтийн аюул тохиолдсон, дайны ба нийтийн эмх замбараагүй байдал үүссэн зэрэг онцгой нөхцөлийн улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй бол мөнхүү нөхцөл арилж, шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлнэ” гэсэн заалтаар иргэдийн сонгуулийг бойкотлож болох эрхийг нь үгүйсгэсэн байдаг. Учир нь ард иргэдийн сонгуульдаа оролцохгүй төрд бойкот тавих энэ үйл явцыг нийтийн эмх замбараагүй байдал үүссэн онцгой нөхцөл гэж үзээд өмнөх улсын их хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх хууль зүйн үндэслэл урган гарч байна.

Төрийн үйл ажиллагааг эсэргүүцсэн ард иргэдийн санаа зоригийн үүднээс төрийн сонгууль санаатайгаар бойкотлогдсон нөхцөлд ч төр хожиж байхаар үндсэн хуульчлагдсан байгаа нь иргэдийн сонгуульд чөлөөтэй оролцох боломжийг нь үндсэндээ хаачихсан байна. Сонгогч өөрийн шаардлагатай гэж үзсэн сэдлээрээ төрийн сонгуульд оролцохгүй байх нь тэрсэлдэж байгаагийн даруухан илрэл бөгөөд ийм үйлдэл хэт олон удаа давтагдвал яах вэ гэсэн асуулт яг одоо бидний өмнө тулж ирчихээд байна. Сүүлийн үед үндсэн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах төсөлтэй холбоотой санал шүүмжлэл, маргаан их гарч байгаа ч энэхүү өгүүлэлд хөндсөн асуудалтай холбоотой асуудлыг ерөөсөө ярихгүй байгаа нь ардчиллаас ухарсан ухралт мөн.

ДҮГНЭЛТ

1. Монголд хуульт тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудад 1992 оноос хойш 20 жилийн хугацаанд тавь гаруй хүн л дахин дахин сонгогдож, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж, төрийн түшээд нь сонгуулиар солигдож байх учиртай бүгд найрамдах засгийн мөн чанарыг жинхэнэ утгаар нь гажуудуулж Монгол улсыг бүгд найрамдахчуудгүй бүгд найрамдах улс болгожээ.
2. Үндсэн хууль болоод сонгуулийн хуулинд өөрчлөлт оруулахдаа ямар ч сайн хүн байсан парламентын гишүүнээр 1 удаа л дахин сонгогдох, УИХ-ын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь дууссанаас хойш засгийн газрын гишүүнээр томилохгүй байх, засгийн газрын гишүүнээр ажилласан хүнийг дараагийн 5-8 жилийн хугацаанд дахин засгийн газар болоод парламентын гишүүн болох эрхийг нь нэг мөсөн хориглох заалтыг заавал оруулах
3. Улсын их хурлын болон орон нутгийн сонгуулийн ирц 50 хувьдаа хүрэхгүй тохиолдол 2 удаа дараалан давтагдвал Улсын их хуралд итгэл үзүүлэх эс үзүүлэх тухай ард нийтийн санал асуулгыг яаралтай явуулах, санал асуулгын үр дүнгээр Улсын их хурлыг тараах эрхзүйн зохицуулалтыг үндсэн хуулинд тусгаж өгөх
4. Монголын улс төрийн системд лидерийн нөхөн сэлбэлт хийгдэхгүй гаднах нийгмийн зүгээс ирж буй шаардлагад систем идэвхитэй хариу өгч дасан зохицож чадахгүй, энэ хэвээрээ үргэлжилвэл сонгуулийн ирц ирэх сонгуулиудад бүр ч доошоо унаж, төрийн засаглал легитим шинжээ бүрэн алдах аюултайгаар барахгүй улс төрийн мөргөлдөөн ч гарахгүй гэх баталгаагүй. Дээрх өөрчлөлтүүдийг үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөнд оруулж өгч чадвал эрх мэдэл залгамжилсан бүгд найрамдах засаг халагдаж, жинхэнэ бүгд найрамдах засаг тогтоно гэсэн дүгнэлт хийв.

НОМ ЗҮЙ

1. Платон “Государство”
2. АНУ-ын үндсэн хууль
3. Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага УБ., 2010
4. Т.Гобсс лефиафан
5. Р.Даль “Ардчиллын тухай” УБ., 1998
6. Ж.Руссо “Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд УБ., 2002
7. Д.Баярхүү “Монгол улс коммунизмаас капитализм руу УБ., 2004
8. Улс төрийн шинжлэх ухаан МУИС. УБ., 2001

НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁС ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Ё.ДОВЧИН

*Доктор, профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхим*

Г. ХОСЦЭЦЭГ

Улс төр судлалын тэнхимийн докторант

Нутгийн өөрөө удирдах ёс, нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай ойлголт нь маш эртний ойлголт бөгөөд хүн төрөлхтний түүхтэй салшгүй холбоотой юм. Энэ ойлголт нь суурин болон нүүдлийн соёл иргэншил оршин тогтсонтой холбоотойгоор үүссэн. Нутгийн өөрөө удирдах ёсны асуудал судлаачдын бүтээлд харьцангуй эрт орсон судлагдахуун гэж үзэж болно. Нутгийн өөрөө удирдах байгууллага хэмээх нэр томъёогоор хожим үүссэнч төрийг удирдахад олон түмнийг оролцуулах гэсэн утгаар Англи, Францын сэтгэгчид (Т.Гоббс, Д.Локк, Л.Монтескье, Ж.Руссо зэрэг) болон XIX зууны ардчилсан онолын төлөөлөгчид (А.Токвиль, Л.Штейн, Р.Гнейст) хүний эрх, эрх зүйт төрийн онолын асуудлыг боловсруулахдаа энэ асуудлыг авч үзжээ. XIX зууны эхний хагасаас А.Токвиль, Р.Гнейст, Л.Штейн зэрэг судлаачдын бүтээлд орон нутгийн өөрөө удирдах ёсны тухай сургаалийн онолын үндсийг боловсруулжээ. Францын төрийн зүтгэлтэн, түүхч А. Токвиль уг асуудлыг цогц байдлаар судлан онолын үндэслэл бүхий үзэл баримтлал дэвшүүлсэн хүн юм. Тэрээр “Америк дахь ардчилал” бүтээлдээ “Община буюу хүй элгэн институт бол шинжлэх ухааны анхан шатны сургууль чухамдаа ямар үүрэгтэй байдгийн адил нутгийн удирдлага хараат бус байх боломжийг тогтооход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг юм. Эдгээр нь ард түмэн эрх чөлөөнд хүрэх замыг нь нээж өгч, тэднийг эрх чөлөөгөө ашиглахад нь сургаж, улмаар түүнийг үр ашигтай мэдрэн, эдлэх боломжийг бүрдүүлдэг. Хүй элгэний институтгүйгээр үндэстэн эрх чөлөөт Засгийн газраа байгуулж болох боловч түүнд жинхэнэ эрх чөлөөний шинж төрх байхгүй болно”¹⁵⁸ гэж бичжээ.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн нутаг дэвсгэр болон тэнд оршин суудаг хүн ам тэдний эрх ашгийг хамгаалах, төртэй харьцах, тэдний хоорондын харилцааны эрх зүйнхүчин зүйлийг холбож өгдөг институци юм. Аливаа улс орны засаглалын байгууллага нь улс орныг нэг цэгээс удирдах боломжгүй тул хүн амаа нутаг дэвсгэрийнх нь шинжээр тодорхой нэгжүүдэд хувааж, тэнд өөрийн төлөөллөө бий болгох замаар засаглах шаардлага гардаг, нөгөө талаар тодорхой нутаг дэвсгэрт оршин амьдарч буй хүмүүс өөрсдийн төлөөллийг сонгон төрийн үйл хэрэгт оролцох боломжийг олгодог. Нутгийн удирдлага гэдэг нь төвийн удирдлагаас ангид бүхнийг хэлэх бөгөөд энэ нь нутаг дэвсгэрийн нэгжийн зорилго, удирдлагын захиргааны чиг үүргийг тодорхойлоход олон түмэн оролцох арга барилтай, гадны ямар нэг нөлөө хяналтаас чөлөөтэй байж хэрэгжүүлдэг нутаг дэвсгэрийн нэгжүүдийн засаглах тодорхой бүрэн эрхийн тухай асуудал юм.

Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь тухайн нутаг дэвсгэрийн байгууллага, нэгж, хамт олны дотоод амьдралын асуудал, ажил хэргийг тухайн нутгийн иргэд хамт олон шууд буюу төлөөллийн байгууллагаараа уламжлан оролцож, бие даан шийдвэрлэх хариуцах ёсыг хэлдэг.¹⁵⁹

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн хамт олны нийгмийн асуудал болон тэдний эрх ашгийг хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэж чаддаг, өөрөө хариуцлагаа үүрэх чадвартай, өөрийн гэсэн өмчтэй, иргэдийн төлөөллийн болон нөгөө талаас төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага юм. Нэг үгээр нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа нь нутгийн өөрөө удирдах ёсны хэрэгжилтийг харуулах хэмжүүр гэж болно. Үндсэн хуулийн 62-р зүйлийн 1-т “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна” хэмээн тусгаж өгсөн байдаг. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн оролцоотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

Нутгийн өөрөө удирдах ёс бүрэлдэн тогтох талаар олон улсын баримт бичгүүдэд дараах үндсэн асуудлууд тусгалаа олсон байдаг байна. Тухайлбал:

- Нутгийн өөрөө удирдах ёсны зарчмуудыг хууль, тогтоомжоор ялангуяа Үндсэн хуулиар баталгаажуулсан байх
- Орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд ардчилсан төлөөллийн үндсэн дээр сонгогддог байх
- Нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь төрийн удирдлагын тогтолцоонд үл хамаардаг байх
- Төрөөс засаг захиргааны нэгжийн хилийн цэсийг өөрчлөхдөө орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагатай урьдчилан зөвшилцдөг байх

¹⁵⁸ А.Токвиль. Демократия в Америке. М., 1992. с-65

¹⁵⁹ О. Тунгалаг. “Хурал өөрөө удирдах ёс”. УБ., 2000

- Нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд ижил төстэй байгууллагуудтай эвлэлдэн нэгдэж, холбоо байгуулах эрхтэй байх
- Орон нутгийн байгууллагын өөрт нь хамаарах асуудлыг тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчдын сайн сайхны төлөө зохицуулан хэрэгжүүлэх эрх, чадварыг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад хадгалах
- Энэхүү эрхийг чөлөөтэй, нууц, тэгш, бүх нийтийн сонгуулиар сонгогдсон гишүүдээс бүрдсэн, өөрсдийн өмнө хариуцлага хүлээх гүйцэтгэх байгууллагатай зөвлөлд буюу хуралд эдлүүлэх
- Нутгийн өөрөө удирдах байгууллага өөрийн өмч, хөрөнгө санхүүтэй байж, түүнийгээ захиран зарцуулах эрхтэй байх
- Орон нутгийн байгууллагууд өөрийн дотоод бүтэц боловсон хүчний асуудлаа тухайн орон нутгийн онцлогт тохируулан өөр бүтээлтэй удирдах зорилгоор өөрсдөө шийдвэрлэх
- Орон нутгийн байгууллагуудын түвшинд төвийн зүгээс оролцохоор хууль тогтоомж боловсруулахдаа заавал зөвшилцдөг байх
- Орон нутгийн байгууллагын үйл ажиллагаанд зөвхөн үндсэн хууль болон бусад хуулиар тодорхойлсон хүрээнд хяналт тавина
- Сонгогдсон орон нутгийн төлөөлөгч нь үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулах эрх зүйн болон эдийн засгийн боломжоор хангагдсан байх
- Орон нутгийн сонгогдсон төлөөлөгч эрхэлж болох албан тушаалын жагсаалтыг хуулиар баталгаажуулах
- Нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд эрх ашгаа шүүхээр хамгаалуулах эрхтэй байх.

Манай улсын эрдэмтэд нутгийн өөрөө удирдах ёс, нутгийн удирдлагын байгууллагын талаар судалгаа хийж ном бүтээл туурвисан байна.

Я.Долгоржав “Нутгийн өөрөө удирдах ёс” ном бичиж, нутгийн өөрөө удирдах ёсыг бүрдүүлэгч элементүүдийг дараах байдлаар авч үзжээ. Үүнд:

- Түүхэн ёсоор бүрэлдэж хуулиар тогтоогдсон тодорхой нутаг дэвсгэр, түүн дээр амьдардаг иргэд
- Шийдвэр гаргадаг, бодлого тодорхойлдог өөрийн удирдлагын байгууллага
- Түүнийг бүрдүүлэгч сонгогдсон төлөөлөгч буюу гишүүд
- Ажлын алба
- Хуулиар түүнд олгогдсон бүрэн эрх болон түүнийгээ хэрэгжүүлэх бие даасан арга зам
- Нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулахад хүрэлцэх хэмжээний өөрийн хөрөнгө төсөвтэй байх гэсэн бүрэлдэх хэсгүүдийг тодорхойлсон байна. Тэрээр эдгээр шинжүүдийг бүрдүүлж чадсан нэгэн нутаг дэвсгэрийн хамт олныг хүй элгэн буюу коммун гэнэ хэмээжээ.

Хуульч Б.Чимид “Нутгийн өөрөө удирдах ёс гэж тухайн нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хамт олны дотоод амьдралын асуудал, ажил хэргийг тэндэхийн иргэд шууд болон төлөөлсөн байгууллагаараа уламжлан бие даан шийдвэрлэж эрхлэн хөтлөх, хариуцах ёсыг хэлнэ” хэмээн үзсэн байна.

Харин судлаач С.Төмөр “Нутаг дэвсгэрийнхээ аливаа нэгжид оршин суугчид, иргэд өөрсдийн амьдрал, аж ахуйд хамаарах бүхий л асуудлыг ардчилсан, шууд, нууц, тэгш, тогтмол, бүгдийг хамарсан сонгуулиар сонгон байгуулсан төлөөллийн байгууллагаараа дамжуулан өөрсдийн итгэл үнэмшил, нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн мөнгөнийхөө хирээр, хууль тогтоох дээд байгууллагаас батлан гаргасан хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн зохицуулах эрх мэдлийг нутгийн өөрөө удирдах ёс” хэмээн тодорхойлжээ.¹⁶⁰

Энэ бүхнээс авч үзэхэд нутгийн өөрөө удирдах ёсны улс төрийн ач холбогдол нь юу бэ? гэсэн асуудал гарч ирнэ. Хүн төрлөхтөн үүссэн үеэсээ эхлэн өөрсдийнхөө асуудлыг хүй элгэнээрээ нэгдэж шийдэж эхэлсэнээс улбаалан өнөөдрийг хүртэл хөгжиж ирсэн нутгийн өөрөө удирдах ёсны эрх зүйн орчныг бүрдүүлж чадсан явдал нь тэдний ололт юм. Нутгийн өөрөө удирдах ёсны ач холбогдол нь доорх байдлаар илэрхийлэгддэг байна. Үүнд: ардчиллыг хөгжүүлэх, төр хэрэгжүүлэх зарим чиг үүргээсээ чөлөөлөгдөх, төр захиргаа иргэд хоорондын харилцаа холбоо бэхжих, орон нутгийн онцлогийг харгалзах боломж бүрддэг, иргэдийн хяналт хувийн санаачлага нэмэгддэг гэх мэт ач холбогдолууд байна. Монгол дахь нутгийн өөрөө удирдах ёсны хөгжлийн өнөөгийн түвшин цаашдын хандлагыг зөв тодорхойлохын тулд нутгийн өөрөө удирдах ёс хөгжсөн орнуудын энэ хүрээнд үйлчилж байгаа хууль, эрх зүйн баримт бичгүүдийг өөрийн орны байдалтай жишин үзэх шаардлага зайлшгүй гарч байгаа юм. “Нутгийн өөрөө удирдах ёсны Европын Харти”-д өөрөө удирдах байгууллагуудад дараах үүрэг шаардлага тавьж байгаа бөгөөд уг Хартийн хүрээнд багтан орох хүсэлтэй Европын холбооны орнуудын хувьд эдгээр шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд: Тухайн орон нутгийн асуудлыг бие даан шийдвэрлэдэг байх, өөрсдийн иргэдээс сонгогдсон төлөөлөгчтэй байх, бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг бие даан явуулах боломжтой байх, үйл ажиллагаагаа явуулахад өөрийн гэсэн санхүүгийн эх үүсвэртэй байх, бүрэн эрхийг нь хуулиар баталгаажуулж өгсөн байх гэх мэт.

¹⁶⁰ “Нутгийн өөрөө удирдах ёсны тухай Үндсэн хуулийн үзэл баримтлал: онол практикийн зарим асуудал” 5 дахь тал

Гэвч манай улсын хувьд дээрх шаардлагуудыг хангаж өгөхийг оролдож байгаа боловч нутгийн өөрөө удирдах ёс хэрэгжих тал дээрээ учир дуяагдалтай байгаа нь олон судалгааны явцад харагдаж байгаа. Төвлөрлийг сааруулах асуудал чухлаар тавигдаж байна. Төвлөрлийг сааруулснаар орон нутгийн өвөрмөц нөхцөл, оршин суугчдын сонирхол, эрх ашгийг илүү мэддэг орон нутгийн удирдлага илүү зөв шийдвэр гаргаж чадна,

- Түүнчлэн орон нутгийн удирдлагын гаргасан шийдвэрийг илүү сайн хэрэгжүүлнэ.
- Ардчиллын хөгжилд бодитой хувь нэмэр болно. Хүмүүс санаа бодлоо илэрхийлэхэд хамгийн ойр байгаа эрх мэдэлт байгууллага ба уг байгууллага хүмүүсийн санал, шаардлагыг хүлээн авч шийдвэрлэх чадвар их байх тусам ардчилсан оролцооны зарчим үр дүнтэй хэрэгжих болно.
- Хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд түлхэц үзүүлнэ.
- Бүс нутаг, манай орны нөхцөлд бол аймгууд хоорондын, сумд хоорондын хөгжлийн ялгааг багасгахад нөлөө үзүүлнэ.

НОМ ЗҮЙ

1. Д.Баярсайхан. “Хүний эрх ба нутгийн өөрөө удирдах ёс” .УБ ., 1999
2. Д.Дондог.“ Орон нутгийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалт”. УБ., 2007
3. Д.Дондог, О.Тунгалаг “Нутгийн удирдлага- эрх зүйн шинэчлэл”. УБ., 2007
4. Я.Долгоржав.“Нутгийн өөрөө удирдах ёс”.УБ ., 2000
5. Б.Чимид. “ Үндсэн хуулийн үзэл баримтлал: нутгийн удирдлага”.УБ.,2000
6. Монголын нутгийн удирдлагын холбоо “ Нутгийн удирдлага сэтгүүл”
7. Монгол Улсын Үндсэн Хуулийн Эрх Зүй: Нутгийн өөрөө удирдах ёс, онол, туршлага, хэгийн төлөв.УБ.,2004
8. Монголын нутгийн удирдлагын холбоо “Нутгийн өөрийн удирдлагын өнөөгийн байдал: Ололт, дутагдал, хандлага”.УБ.,2003
9. М.Сандаг-Очир. “Нутгийн удирдлага”. УБ.,2003
10. Улс төрийн боловсролын академи. “Монгол Улсын Үндсэн Хуулийн үзэл баримтлалын асуудал”. УБ.,2000

УЛС ТӨРИЙН СОЁЛЫН АНГИЛАЛ ЗҮЙН АСУУДАЛД

Б.ОТГОНБАЯР

ХААИС, ЭЗБС, ХЭЗТ

Философийн тэнхимийн докторант

Хураангуй: Улс төрийн соёлын ангилал зүй нь тодорхой нэг улс төрийн соёлын мөн чанар, учир утгад нэвтрэх боломж олгож бусад ангилалтай харьцуулсны үндсэн дээр түүний онцлогийг илрүүлэн тогтоож судлах, тухайн улс төрийн системийн хөгжлийн түвшин, шинж чанарыг түүнд оршин буй улс төрийн соёлын хэв маягуудаар тодорхойлох боломжийг олгодог онол арга зүйн ач холбогдолтой. Улс төрийн соёлын төлөвшилтөд улс төрийн субъектүүд, тэдгээрийн хөгжил, нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, түүхэн хөгжлийн онцлог, уламжлал, зан заншил, шашин зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг тул олон янзаар илэрдэг.

Түлхүүр үг: Улс төрийн соёл, Улс төрийн соёлын ангилал, Овгийн хэв маяг, Албатын хэв маяг, Оролцооны хэв маяг, Холимог хэв маяг.

Abstract: In order to reveal typology of political culture, political development we have to study inside structure of political culture, their function and every country's specific character. In this research paper comparative important typology with others. In result that compared and analyzed attractive political division, author divided into the four basic typology such as formation of social materialism, process and civils participation, regulation, specific of civilization.

Судалгааны материал, арга зүй

Типологи буюу хэв шинжийн ангилал зүй нь тухайн тогтолцоог бүрдүүлэгч объектүүдийг төгс загварын үндсэн дээр төрөлжүүлж хуваан ангилж, тайлбарлах шинжлэх ухааны танин мэдэхүйн арга юм. Юмс үзэгдлийн мөн чанарыг түүнийг бүрдүүлж буй элементүүдэд задалснаар бүрэн танин мэдэх боломжгүй, харин тэдгээрийн хоорондын шүтэлцээ, харилцан холбоог илэрхийлж, нэгтгэн харилцан үйлчлэл бүхий нэг систем болгож үзэх нь танин мэдэх ач холбогдолтой. Энд судалж байгаа зүйлийн ялгаатай болон төстэй талуудыг илэрхийлж, тэдгээр талуудыг ижилсүүлэх найдвартай аргыг хайсны дүнд тухайн судлагдаж буй системийн зүй тогтлыг нээн илэрхийлж, объектын нээгдээгүй шинж байдлыг урьдчилан хэлэх боломжийг бүрдүүлнэ.

Г.Алмонд “Харьцуулсан улс төрийн системүүд” (1956) өгүүлэлдээ улс төрийн соёлын ангиллыг анх томъёолжээ. Энэхүү ангиллыг цаашид боловсруулж Г.Алмонд, С.Верба нар “Иргэний соёл”(1963) бүтээлдээ улс төрийн соёлыг хувь хүмүүсийн баримталдаг улс төрийн чиг баримжаа талаас нь судалж үндсэн гурван хэв маяг болох уламжлалт овгийн, албатын, оролцооны соёл гэж ангилжээ. 1970-1990-ээд оны үед Р.Такер, У.Розенбаум, Р.Инглекхарт, Л.Элазар нарын судлаачид улс төрийн соёлын ангиллыг үйл байдал, оролцоо талаас нь ангилж шинэ шатанд гаргав.

Тодорхой нэг улсын улс төрийн соёл, оролцоог судалсан АНУ-ын Д.Элизар, Германы М.Грайфхайген, Испаний А.Лопес Пина, Э.Л.Арангурен, Ирландын Дж.Рэйвен, С.Т.Уилен, ЗХУ-ын Н.Т.Кейзоров, Ф.М.Бурлацкий, ОХУ-ын Ю.Р.Шапко, К.С.Гаджиев, А.И.Дженусов, Э.А.Баталов нарын бүтээлүүдэд тухайн улс орны онцлогийг илэрхийлсэн ангиллуудыг тайлбарлажээ.

1990-ээд оноос Монголын эрдэмтэн судлаач Ц.Ганбат, Э.Тамир, Ё.Довчин, Д.Содномгомбо, А.Цанжид нар манай орны улс төрийн соёлын ангиллын асуудлыг орчин үеийн онол, арга зүйгээр судалсан нь Д.Содномгомбо, Ч.Найдансүрэн” (2000), Ё. Довчин (2000) нарын нэг сэдэвт зохиол бүтээлд тусгагджээ

Улс төрийн соёл нарийн төвөгтэй, олон шалтгаант холбоо бүхий үзэгдэл учраас түүнийг хүмүүсийн улс төрийн ухамсар, сэтгэл зүйтэй холбож үндсэндээ системийн оюун санааны хүрээгээр хязгаарлан үздэг хэсэг эрдэмтэд байхад, нөгөө хэсэг нь иргэдийн улс төрийн үйл байдал, үйл ажиллагаанд баримтлах хэм хэмжээ, сэтгэлгээ, үйл байдлын хүсэн хүлээгдэж байгаа загвар гэж тайлбарладаг. Зарим эрдэмтэд иргэдийн улс төрийн үйл байдлаар улс төрийн соёлыг хязгаарлаж болохгүй, түүхэн хөгжлийн явцад бүрэлдэн тогтдог ерөнхий соёлын нэг илрэл гэж үздэг хандлага бий. Улс төрийн соёлд улс төрийн системийн талаарх мэдлэг ойлголт гэсэн когнитив түвшнээс гадна улс төрийн системийн талаарх үнэлэмжийн чанартай гүнзгий ойлголт, төсөөлөл болон сэтгэл хөдлөлийн шинжтэй сэтгэхүйн илрэл нэгэн зэрэг багтаж байдаг нь түүний дотоод зөрчлийг нөхцөлдүүлдэг.

Нийгмийн бүлгүүд нь эрх мэдэл, төр, улс төрийн нам, улс төрийн оролцоо, үйл байдалд янз бүрийн байр суурь баримталж өөр өөрийн онцлог бүхий улс төрийн дэд соёлуудыг бүрдүүлдэг. Дэд соёлыг илэрхийлэн тээгч нь нийгмийн анги, бүлэг, үндэстэн, ястан, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, залуучууд, настайчууд, тодорхой

нутаг дэвсгэрт оршин суугчид, шашны бүлгийнхэн гэх мэт нийгмийн социал бүлгүүд байдаг. Улс төрийн дэд соёлд хамгийн их ач холбогдолтой хэв маягууд бол бус нутгийн, социал-эдийн засгийн, угсаатан-хэлний, шашны, насны дэд соёлууд юм. Нийгэмд тэдгээр дэд соёлууд хэрхэн өөр хоорондоо зохицож, сөргөлдөж, аль нь давамгайлж албан ёсны соёл болж бусдыг өөртөө захируулдаг болох зэргийг судлууштай асуудал юм. Улс төрийн элит, хошуучлагчдын соёл нийгмийн амьдралд голлох үүрэгтэй. Эдгээр нь улс төрийн соёлыг зөөгч бүтцийн хувьд ангилж байгаа асуудал юм. Зарим судлаачид дэд соёлыг нийгмийн дэвшилд нөлөөлж байгаа байдлаар нь дэвшилтэт, хоцрогдсон дэд соёл гэж хоёр ангилжээ. Мөн ноёрхох ба эрх баригчдын, сөрөг хүчний улс төрийн соёл гэсэн ангилал ч бий. Эдгээрээс хөгжлийн гол зүтгүүр болох улс төрийн соёлыг аль болох дэмжиж дэлгэрүүлэх ёстой.

Улс төрийн соёлын сонгодог ангиллын үндсийг Г.Алмонд, С.Верба (1963) нар боловсруулсан. Иргэдийн улс төрийн чиг баримжааг үндэслэн “цэвэр үзэл санааны” гурван хэв маягийг томъёолжээ. Улс төрийн соёлын нэгдүгээр “цэвэр” хэв маяг бол уламжлалт буюу овгийн (patochial) хэв маяг. Иргэдийн улс төрийн чиг баримжаа нь тэдний шашны, эдийн засгийн, нийгмийн чиг баримжаанаас ангижраагүй, отог, овог, аймгийн, шашны үнэлэмж дээр тулгуурладаг, овгийн ахлагч, бөө зэрэг тодорхой хүнд үйлчилдэг. Иргэдэд улс төрийн систем, түүний бүрдэл үйл ажиллагааны талаарх мэдлэг бараг байхгүй, улс төрийн үйл явцад оролцдоггүй хэв маяг юм. Хоёрдугаар “цэвэр” хэв маяг бол хамжлага албатын (subject) хэв маяг юм. Энд иргэд улс төрд идэвхгүй ханддаг, улс төрийн систем, байгууллагуудын тухай мэдлэгтэй, улс төрд нөлөөлж болно гэж ойлгодог, улс төрд өөрийгөө хамаатуулдаг ч улс төрийн амьдралд өөрөө биш, харин улс төрийн байгууллагууд голлох үүрэгтэй гэж үзэж идэвхтэй бус, шийдвэр хүлээгч, биелүүлэгч байр суурь баримталдаг. Шийдвэр гаргахад нөлөөлдөггүй мөртлөө шийдвэр гарсны дараа шүүмжлэх байр суурьтай. Иргэд нь төрд захирагдахдаа түүнээс явз бүрийн нийгмийн тэтгэмж, баталгаа зэрэг хишиг буян горилж, шахалт шаардлагыг төвөгшөөж байдаг. Гуравдахь “цэвэр” хэв маяг бол идэвхтэй буюу оролцооны улс төрийн соёлын хэв маяг юм. Ийм улс төрийн соёлын хэв маягтай иргэн улс төрийн идэвхтэй, мэдлэгтэй, улс төрийн үйл явцыг сонирхож, түүнд нөлөөлөхийн тулд оролцож байдаг. Иргэд сонирхлоо улс төрийн сонгууль, сонирхлын бүлэг, улс төрийн намаар дамжуулан ухаалгаар илэрхийлж, хамгаалж, улс төрийн бодлого боловсруулахад нөлөөлж байдаг. Үүний зэрэгцээгээр улс төрийн системд зүйг баримталсан байдлаар хандаж, гарч буй шийдвэрт хүндэтгэлтэй хандаж, хууль сахин биелүүлж байдаг [1]. Энэ ангилал нь бодит амьдралд дангаараа оршдоггүй, шинжилгээ судалгааны үүднээс туйлшруулан тогтоосон ангилал юм. Социологийн судалгааны харьцуулсан арга зүйн шинжтэй эдгээр гурван хэв маягуудыг холимог агуулсан иргэний соёл гэсэн тодорхойлолтыг гаргажээ. Иргэний соёл гэдэг нь засаг захиргаанд иргэд нь дэмжлэг, шүүмжлэлтэй байр сууринаас хандсан иргэдийн оролцоог хослуулсан соёл юм. Дээрх ангиллыг тэд өөрсдөө ч өөрчилж, бусад судлаачид нилээд шүүмжилдэг байв. Г.Алмонд, С.Верба нар эдгээр гурван хэв маягийг амьдралд “цэвэр” хэлбэрээр бус, хосолж холимог хэлбэрээр оршдог гэжээ.

Тэд дээрх гурван “цэвэр” хэв маягийг хослуульж уламжлалт овгийн-хамжлага албатын, хамжлага албатын-оролцооны, уламжлалт овгийн-оролцооны гэсэн холимог хэв маягийг гаргажээ. Нэгдүгээр хэв маяг нь хүн амын олонх нь овгийн, тосгоны, феодалын засаглалд, мөн түүнчлэн нарийн бүтэцтэй улс төрийн системд, засгийн газарт хандах хандлага нь идэвхгүй, захирагдах байдлаар ханддаг улс төрийн соёлын хэв маяг юм. Хоёрдугаар хэв маягийн онцлог нь хүн амын олонх хэсэг нь нийгэмд ноёрхож байгаа улс төрийн дэглэм, түүний үнэлэмжийг дэмжих чиг баримжаатай идэвхтэй улс төрийн үйл ажиллагаа явуулдаг, нөгөө үлдсэн хэсэг нь засгийн газрын авторитар бүтцэд чиглэсэн, харьцангуй идэвхгүй чиг баримжаатай. Гуравдугаар хэв маяг нь ардчилсан чиг баримжаагаар хөгжиж буй орнуудын улс төрийн соёлын хэв маяг юм [2]. Эдгээр ангиллууд нь улс төрийн соёлын үндсэн бүрдэл болох улс төрийн чиг баримжаагаар нь ангилсан ангилал юм.

Г.Алмонд улс төрийн системийн холимог соёлтой дөрвөн хэв маягт анхаарлаа хандуулжээ. Үүнд: 1, аж үйлдвэржилтийн үеийн ардчилсан улс төрийн системд 60% нь оролцооны идэвхтэй, 30% нь хамжлагын, 10% нь овгийн уламжлалт улс төрийн соёлтой, 2, аж үйлдвэржилтийн үеийн авторитар улс төрийн системд дээрх улс төрийн соёлийн харьцаа 5%, 85%, 10%, 3, шилжилтийн үеийн авторитар улс төрийн системд 30%, 40%, 30%, 4, аж үйлдвэржилтийн өмнө үеийн ардчилсан улс төрийн системд 20%, 20%, 60% тус тус харьцаатай хосолсон байна гэжээ. Гэхдээ энэ харьцаа нь тухайн улс орны онцлогоос хамаарч хэлбэлзэж байх болно. Аж үйлдвэржсэн ардчилсан улс төрийн системд холимог хэв маягийн иргэний улс төрийн соёл оршино гэжээ [3].

Соёл иргэншлийн онцлогийг үндэс болгон улс төрийн соёлыг дорнын соёлын үнэлэмжтэй, өрнийн соёлын үнэлэмжтэй улс төрийн соёлын загвар гэж ангилдаг. Дорнын улс төрийн соёлын загварт хамжлага-оролцооны улс төрийн соёл зонхилох ба авторитар засаглалын тогтсон уламжлал хадгалагдаж хувь хүн ба улс төрийн холбоо хангалттай бус байдаг. Дорнын соёлын үнэлэмж, уламжлал бүрэлдэхэд Кунзийн сургаал, лал болон буддын шашин нөлөөлж, уламжлал шийдвэрлэх үүрэгтэй. Дорны соёлд эрх мэдлийг аливаа хүний хүч чадавх, давуу байдлаас үл хамаардаг тэнгэрээс заяасан зүйл, улс төр нь хүн бүхний бус тодорхой хүрээний хүмүүсийн оролцох хэрэг гэж үздэг. Иргэний нийгмээс илүү төр давамгайлдаг. Элит ба олон түмний хооронд өмч хөрөнгө, эрх мэдлийн ялгаа их, төр болон элитийн сонирхол, мөн орон нутгийн, язгуур угсаатны сонирхолд тэргүүлэх ач холбогдол өгдөг.

Өрнийн соёлын онцлог нь христийн сургаал, эртний грекийн түүхэн хөгжил зэрэг хүчин зүйлээр тодорхойлогддог. Улс төрийн идэвхийн буюу оролцооны загвар зонхилдог, улс төрийн ардчиллын тогтсон уламжлалтай, төр ба нийгмийн хооронд зөвшилцөлтэй, нийгэмд дунд анги зонхилдог, амьдралын

материаллаг түвшин өндөр. Улс төрийн соёлд шинэчлэл, уламжлалын шүтэлцээ чухал ач холбогдолтой. Эрх мэдэлд шалгарлын замаар буюу аль нэг нь бусдаасаа давуутай байж хүрдэг, улс төрийг бүх хүний тэгш оролцоон дээр тулгуурласан аливаа маргаантай асуудлыг шийдвэрлэх хүрээ гэж ойлгодог. Тухайн улсад ямар улс төрийн соёл бүрэлдэн хөгжих нь нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын олон хүчин зүйлсээс гадна тухайн орны улс төрийн түүхэн хөгжлийн явц, уламжлал, зан заншил, шашин шүтлэг зэрэг нь нөлөөлдөг.

Улс төрийн соёлыг нийгмийн нэгдмэл чанар хэрхэн хангагдсан байдлаас үүдэн нэг төрөлт буюу зөвшилцлийн, олон туйлт соёл гэж хуваан авч үздэг. Нийгмийн гол үнэлэмж, зорилтуудын талаар нэгдмэл ойлголт бүрэлдэж нийгмийн бүлгүүд, улс төрийн хүчнүүд энэ талаар нэгдсэн ойлголтод хүрсэн бол зөвшилцлийн соёлд тооцогдоно. Зөвшлийн улс төрийн соёл бүрэлдсэн тохиолдолд иргэдийн олонх нь үндсэндээ ойролцоо үзэл бодолтой болж нийгмийн хөгжил дэвшилд хүрэх таатай нөхцөл бүрэлдэнэ. Олон туйл бүхий улс төрийн соёлт нийгэмд иргэдийн дунд хэт баруун, хэт зүүний үзлийг баримтлагчид олонхийг бүрдүүлж нийгэм туйлширч, хагаралд хүрэх аюултай байдаг.

Улс төрийн соёлыг нийгмийн түүхэн хөгжлийн үе шатыг харгалзан үзэж Н.М.Кейзеров боол эзэмшигчдийн, феодалын, капиталист, социалист хэв маягт [4], В.В.Муругова, В.Т.Шапко нар улс төрийн соёлыг ноёлох ангийн, дарлагдагч ангийн [5], Ф.М.Бурлацкий, А.А.Галкин нар улс төрийн соёлыг архаих (хуучны үеийн), элитар, төлөөлөгчийн, иргэний өндөр соёл [6] гэж ангилжээ. Иргэний нийгэм болон улс төрийн системийн хоорондын харилцааны хэв маягийг илэрхийлсэн нийгмийн хөгжлийн төвшнөөс хамааруулж тэд ангилжээ. Эдгээр ангилал нь нэг талын, ангич байр сууринаас хандсан ангилал юм.

Д.Элазар америкийн нийгмийн үнэлэмжийг судалсны үндсэн дээр улс төрийн соёлыг ёс суртахуунт, хувийн, уламжлалт улс төрийн соёл гэж гурав ангилжээ. У.Блюм улс төрийн либераль, хамт олны соёлыг товойлгон гаргах шаардлагатай гэж үзжээ. Э.Я. Баталов улс төрийн соёлын ангиллын үндэслэлд нийгмийн амьдралыг зохицуулах механизм болох зах зээл ба төрийг тавьж зах зээлийн, этатист (төрийн) улс төрийн соёл хоёр гэж ангилжээ. Зах зээлийн улс төрийн соёл нь ашиг олох сонирхолтой чөлөөт үйлдвэрлэгчдийн хоорондын таваарын чөлөөт солилцоо, худалдах, худалдан авах харилцааны үүднээс улс төрийн асуудал, үйл явцыг авч үздэг. Этатист улс төрийн соёл нь улс төрийн үйл явцыг төрөөс хянадаг, улс төрийн асуудлыг шийдвэрлэхдээ төрийн зохицуулалттай холбож үздэг, төрийн үүрэг, эрх мэдлийг чухалчилдаг [7].

У.Розенбаум улс төрийн соёлыг фрагмент (хэсэгчлэгдсэн), интеграл (нэгдмэл) гэж ангилжээ. Гэхдээ янз бүрийн загвар дундаж хэв маяг байна. Фрагмент хэв маяг нь нийгмийн улс төрийн тогтолцооны үндсэн зарчмуудын зөвшилцөлгүй, нийгмийн бүлгүүд нь нэг нь нөгөөдөө хэт итгэдэггүй, зөрчилдөөнийг зохицуулах зөвшөөрөгдсөн үйлчлэн зохицуулах арга ажиллагаа байхгүй, тогтвортой биш, байнга солигдож байдаг засгийн газартай, улс төрийн тоглоомын дүрэмгүй улс төрийн соёл юм. Интеграл хэв маяг гэдэг нь зөвшлийн улс төрийн соёл бөгөөд улс төрийн тогтолцооны үндсэн гол асуудлаар зөвшилцөх бүрэн боломжтой, мөргөлдөөнийг зохицуулах иргэний дэг журамтай, улс төрийн хүчирхийлэл маш бага, олон ургальч үзэл бүхий нийгмийн улс төрийн соёл юм [8].

Үндэсний онцлогийг илэрхийлсэн улс төрийн соёлын онцлогт хэв маягуудыг судлаачид тодорхойлсон байдаг. Судлаач Ё.Довчин монголын уламжлалт нүүдлын соёл иргэншил, монголчуудын ертөнцийг үзэх үзэл, менталитет, амьдралын хэв маяг, ёс суртахуун, зан уламжлалтай холбоотойгоор тал нутгийн улс төрийн соёл гэсэн тодорхойлолтыг гаргаж иржээ [9]. Судлаач А. Цанжид бүтээлдээ улс төрийн соёлыг хувь шинжит (индивидуалист), уламжлалт гэж ангилжээ. Хувь шинжит улс төрийн соёлын эх үндэс нь хүн хувийн амьдралаа өөрөө хариуцаж, хөдөлмөр, хичээл зүтгэл, овсгооноос шалтгаалж амьдралаа сайн сайхан байлгана. Хүн шийдвэр гаргахдаа өөрийн ухаанд тулгуурлана. Хувь хүний амьдралд төр оролцохгүй, харин хувь хүний эрх чөлөөг төр хамгаалж хангана. Уламжлалт улс төрийн соёл бол хүн өөрийгөө нийгмийн нэг хэсэг гэж мэдэрч нийгмийн уламжлал, заншлын хүрээнд амьдрах ёстой гэж үздэг, “хүн ахтай, дээл захтай”, “дэм дэмэндээ, дэс эрчиндээ” гэдэг зарчмаар аж төрөх ба төр иргэний хооронд “эцэг, хүүгийн” харилцаа байх ёстой гэж үздэг. Хүн өөрийнхөө сайн сайхны төлөө өөрөө чармайхаас гадна ах дүү, төрөл төрөгсөд, нутаг усныхан, төр засгийн дэмжлэг тусламжид тодорхой найдвар тавьдаг. Өнөөгийн Монголд уламжлалт маягийн соёлоос хувь шинжит соёлд зах зээлд нэвтрэхийн хэрээр шилжиж байгаа нь эдийн засгийн хөгжилд түлхэц болох боловч, хүн ёс суртахууны хувьд буурч буй хэрэг гэж үзэх үзэл бас бий. Монголчуудын улс төрийн соёл нь өрнөдийнхтэй харьцуулахад уламжлалт шинжтэй боловч Азийн бусад ард түмэнтэй харьцуулахад илүү индивидуалист шинжтэй.

Улс төрийн соёлыг гадны нөлөө, өөрчлөлтийг тусгах байдлаар нь нээлттэй, хаалттай гэж ангилна. Ардчиллын зарчим, үндэсний уламжлалаас тунгаан авсан шилдэг өвд тулгуурласан улс төрийн соёл нь манай орны улс төрийн амьдралын эрүүл саруул байдлыг хангана. XX зууны эхэн үе хүртэл улс төрийн соёл нь гадны нөлөө, дэлхий дахинд гарч байсан өөрчлөлтийг бага тусгасан хаалттай шинжтэй байсан нь алслагдмал байдал, соёлын дотоод дархлаа зэрэгтэй холбоотой. Гэвч XX зуунд Оросоор дамжин европ соёл, коммунист номлол төрийн бодлогоор нэвтэрч хуучин соёлын дотоод дархлааг эвдэж монголын улс төрийн соёл өөрчлөгдөж эхэлсэн байна. Өөрчлөлтийн энэ явц одоо хэр нь үргэлжилж байгаа бөгөөд 1990-ээд оноос ардчилсан өөрчлөлтийн нөлөөгөөр шинэ чиглэлээр улам ч эрчимжиж ардчилсан, оролцоот улс төрийн соёл төлөвшиж байна [10].

Улс төрийн соёлыг бүс нутгаар, тивээр, үндэстний байдлаар, шашны нөлөөг тусгаснаар нь, улс төрийн субъектээр, засаглалыг хэрэгжүүлэх арга, хэлбэрээр, улс төрийн тогтолцоонд эзлэх байр сууриар, улс төрийн үйл явцад оролцох байдлаар, улс төрийн үйл явцын хүрээгээр, нийгэмд тархсан байдлаар, соёл иргэншлээр,

үнэлэмжээр нь гэх мэт олон шалгуураар ангилжээ. Улс төрийн соёлын гол гол ангиллуудыг харьцуулан задлан шинжилсний дүнд бид улс төрийн соёлын ангиллуудыг дөрвөн үндсэн бүлэгт хувааж болох юм гэж үзлээ.

Нэгдүгээр бүлэгт, улс төрийн систем ба соёлын хоорондын харилцааг тодорхойлохдоо нийгмийн түүхэн хөгжлийн үе шат, формацын онол дээр үндэслэж цаг хугацааны шатлалыг анхаарсан, ангич, намч байр суурьтай ангилал зүй багтана. Үүнд: Е.Вятер, Н.М. Кейзеров, Ф.М. Бурлацкий ба А. Галкин, В.В. Муругова, В.Т.Шапко, М.М. Лисенков нарын ангилал багтана. Улс төрийн дэглэмтэй холбоотойгоор улс төрийн соёлыг ангилсан К.С.Гаджиев, нийгмийн хөгжлийн түвшингээс хамааралтайгаар нийгмийн ямарваа нэгэн субъектийн хөгжлийн түвшинтэй хамааралтай ангилсан А.И.Дженусовын ангилал багтана

Хоёрдугаар бүлэг ангилалд үндэсний, шашны, бүс нутгийн онцлогуудыг илэрхийлсэн болон ерөнхий соёл талаас нь анхаарч ангилсан Б.С.Ерасов, П.К.Гречко, Ю.В.Ирхин нарын ангиллууд багтана.

Гуравдугаар бүлэг ангилалд улс төрийн системийн өөрчлөлтөнд иргэдийн хандах улс төрийн үйл байдал, оролцоо чиг баримжааны онцлогоор ангилсан ангиллууд болох Г.Алмонд, С.Верба, У. Розенбаум нарын бүтээл багтана. Мөн энэ бүлэгт улс төрийн субъектийн итгэл үнэмшил болон үйл байдал хоёрын зөрөлдөөнийг илтгэсэн бодит ба хүслэнт улс төрийн соёлын Р.Такерын ангилал багтана.

Дөрөвдэх бүлэг бол улс төрийн системийн зохицуулах механизм дээр тулгууралсан улс төрийн соёлын хэв маяг багтана. Үүнд: Л.Элазар, Э.Баталов нарын ангилал багтана.

НОМ ЗҮЙ

1. Almond G., Verba S. The Civic Culture: Political attitudes and Democracy in Five National. Princeton, 1963. (дам ишлэв)
2. Алмонд Г., Верба С. Гражданская культура и стабильная демократия // Полис, 1992. № 4.
3. Политология. Ред., Василица М.А. М., 1999. с. 369-375.
4. Кейзеров Н.М. Политическая и правовая культура. М., 1973. с. 56.
5. Муругова В.В. Политическая культура развитого социалистического общества. Автореф. канд. дисс. с. 13.
6. Бурлацкий Ф.М., Галкин А.А. Современный Левиафан: Очерки политической социологии капитализма. М., 1985. с. 212.
7. Баталов Э.А. Политическая культура современного американского общества. М., 1990. с. 52-53.
8. Rosenbaum W. Political culture. N.- Y., 1975. p. 37. (дам ишлэв)
9. Цанжид С. Улс төрийн шинэ соёл, төлөвшилт, тулгамдсан асуудал. Шинэ толь. 2000. №30. х.86-98. Цанжид С. Улс төрийн шинэ ухаан. УБ. 1999. х. 119-125. Довчин Ё. Степная политическая культура. СПб. 2000. с. 39-46. Содномгомбо Д. Найдансүрэн Ч. Улс төрийн соёл, түүний Монгол дахь төлөвшлийн асуудал. УБ. 2000. х. 16-22.

ХАРЬЦУУЛСАН УЛС ТӨР, ЭМПИРИК СУДАЛГАА**УЛС ТӨРИЙН ТОГТОЛЦООНЫ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД: СОНГОГЧДЫН САНАА БОДОЛ****С.МӨНХБАТ***Доктор, профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,**Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч***Д.ГАЛСАНДОНДОГ***Улс төр судлалын тэнхимийн докторант*

Abstract: The political system is the major subject of a political science. Political system, the set of formal legal institutions that constitute a “government” or a “state.” This is the definition adopted by many studies of the legal or constitutional arrangements of advanced political orders. More broadly defined, however, the term comprehends actual as well as prescribed forms of political behaviour, not only the legal organization of the state but also the reality of how the state functions. Still more broadly defined, the political system is seen as a set of “processes of interaction” or as a subsystem of the social system interacting with other nonpolitical subsystems, such as the economic system. This points to the importance of informal sociopolitical processes and emphasizes the study of political development.

This article has the following priority issues.

- Some core issues about political system
- Core issues of Mongolian political system
- Public opinion and political system
- A political consensus is the best mechanism to resolve the problems.

НЭГ. УЛС ТӨРИЙН ТОГТОЛЦООНЫ ТУХАЙ ЗАРИМ ТАЙЛБАР, ДҮГНЭЛТ

Улс төрийн тогтолцооны асуудал нь улс төрийн шинжлэх ухааны нэг судлагдахуун болохын хувьд эрдэмтэн, судлаачдын анхаарлыг татсаар ирсэн. Судлаачид улс төрийн тогтолцооны талаар ерөнхийлөн нэгдсэн нэг тодорхойлолтыг хараахан өгөөгүй байна. Харин өөр өөрсдийн байр суурь, судалгааны чиглэл, онол, арга зүйгээс хамааран харилцан ялгаатай байдлаар тодорхойлох оролдлого нэлээдгүй байдаг. Судлаачдын дундах энэхүү байр суурийг авч үзэхэд хоёр үндсэн хандлага зонхилж байна. Үүнд,

1. Улс төрийн тогтолцоо, улс төрийн системийг адилгаж үзэх хандлага. (Г.Алмонд, Дж.Пауэлль, Р.Далтон, К.Стром, Д.Истон, М.Сланн, Ц.Ганболд, С.Базарпүрэв, Д.Болд-Эрдэнэ, Ю.Атар г.м)
2. Улс төрийн тогтолцоо, улс төрийн систем хоёр ялгаатай гэж үзэх хандлага. (А.Гидденс, Ч.Өлзийсайхан, Г.Цэнд-Аюуш, Г. Банзрагч)

Улс төрийн тогтолцоо нь улс төрийн системтэй бүтэц хийгээд үүргийн хувьд ижил юм. Тийм учраас улс төрийн тогтолцоо, системийг нэг утгаар ойлгох нь зүйтэй гэж үздэг судлаачид дараах үндэслэлийг дэвшүүлдэг. Тухайлбал, Г.Алмонд, Дж.Пауэлль нар “Улс төрийн систем бол нийтийн засаглалын шинжтэй шийдвэр гаргахад үйл ажиллагаа нь чиглэгддэг нийгмийн системүүдийн нэг онцлог хэв маяг юм”¹⁶¹ гэсэн бол улс төрийн системийн онолын нэрт төлөөлөгч Д.Истон “улс төрийн тогтолцоо бол төр иргэний харилцаа холбоо, улс эрх мэдлийг зохион байгуулж буй улс төрийн байгууллага, түүний үйл ажиллагаанд тулгуурласан хэм хэмжээ, үзэл санааны харилцан үйлчлэлийн нийлбэр цогц”¹⁶² гэж тус тус тодорхойлсон байна. Гэхдээ Г.Алмонд улс төрийн системийг улс төрийн бүтэц талаас нь илүү гаргахыг эрмэлзсэн нь онол арга зүйн их ач холбогдолтой болсон юм. Тэрээр Д.Истоны нэгэн адил системийн оролт, гаралтаар дамжуулан өөрөө өөрийгөө зохицуулж хөгжүүлж байдаг институциональ хийгээд функциональ шинжүүд дээр зохицуулалтын, коммуникатив, улс төр үзэл суртлын гэсэн дэд системүүдийн харилцан үйлчлэлийн шинж байдал нь улс төрийн системийг тодорхойлно гэсэн дүгнэлтийг хийжээ. Манай судлаач доктор Д.Болд-Эрдэнэ “Зарим судлаачид улс төрийн тогтолцоо, системийг агуулгын багтаамжийн хувьд ялгаатай, хоёр өөр ойлголт гэж үздэг. Гэтэл тогтолцоо хэмээх нь систем гэдгийн монголчилсон хувилбар юм. Учир иймд

¹⁶¹ Г.Алмонд, Дж.Пауэлль, К.Стром. Харьцуулсан улс төр: Онолын хүрээ. Орчуулсан. Ё.Довчин. 22 дахь тал. УБ., 2006

¹⁶² Ч.Өлзийсайхан. Улс төрийн систем, улс төрийн тогтолцоо, төрийн тогтолцоо гэсэн ойлголтуудын тухайд. Политологи сэтгүүл. №297 (50). УБ., 2009. 63 дахь тал.

“систем”, “тогтолцоо” гэдэг ойлголтыг аль алиныг нь нэг утгаар ойлговол зохино”¹⁶³ гэсэн дүгнэлтийг бас хийсэн байна.

Харин улс төрийн тогтолцоо, улс төрийн систем хоёр өөр хоорондоо ялгаатай гэж нөгөө хэсэг судлаачид үзэж байна. Тухайлбал Лондонгийн эдийн засгийн сургуулийн профессор, нэрт социологич А.Гидденс Улс төрийн тогтолцоо бол зөвхөн засгийг тойрон хүрээлсэн улс төрийн үйл ажиллагааны төрөл гэж үзэж тайлбарласан. Тэрээр “Засгийн газар гэсэн нэр томъёог улс төрийн аппаратад буй албаны хүмүүсээс тогтоол, улс төрийн шийдвэр тогтмол гаргах явдлыг тэмдэглэж хэрэглэнэ. Засгийн газрын тухай ярихдаа бид удирдлагын үйл явцыг өөрийг нь болон шууд засгийн газрыг, өөрөөр хэлбэл захиргааны үйлдлийнхээ төлөө хариуцлага үүрдэг түшмэдийн аппаратыг ойлгоно. Харин улс төрийн хүрээ буюу систем нь төрийн яг одоо байгаа институцийн хүрээнээс ихээхэн хэтэрч болно”¹⁶⁴ хэмээн бичсэн байна. Үүнээс үзэхэд улс төрийн тогтолцоо гэдгийг төрийн байгууллагын хүрээнд, харин улс төрийн систем гэдгийг улс төрийн амьдралын өргөн хүрээнд авч үзэж судлах саналыг дэвшүүлжээ. Доктор, дэд профессор Ч.Өлзийсайхан “Улс төрийн тогтолцоотой харьцуулахад улс төрийн систем нь илүү өргөн ойлголт юм гээд улс төрийн систем, улс төрийн тогтолцоо нь нэг улсын хэмжээнд өөр өөрийн онцлог бүтэцтэйгээр, төр иргэний хоорондын харилцаа нь өөр өөрийн онцлог зохицуулалтын хэм хэмжээтэйгээр төлөвшин тогтсоныг харуулна. Тодруулж хэлбэл ардчилсан улс төрийн системтэй олон орон өөр өөрийн улс төрийн онцлог бүхий тогтолцоотой байна. Энэ нь төрийн тогтолцоо улс орнуудад өөр өөрөөр хэлбэршин тогтдогт үндэслэнэ”¹⁶⁵ гэсэн дүгнэлт хийсэн байна.

Энэ мэтчилэн улс төрийн тогтолцоог нэг мөр ойлгох, тайлбарлах асуудалд судлаачид нэгдсэн байр сууринд хараахан хүрээгүй байгаа юм. Хүрэхэд их төвөгтэй асуудал юм. Учир юунд хэмээвээс улс төрийн тогтолцоо, улс төрийн системийн харилцан хамаарал нь чиг үүргийн хувьд зарим тохиолдолд давхцаж байдаг оршино. Улс төрийн системийн төлөвшилтөд улс төрийн тогтолцооны эрэмбэ, зохион байгуулалтын хэлбэр зэрэг нь шууд нөлөө үзүүлнэ. Улс төрийн системийн төлөвшилт нь эргээд улс төрийн тогтолцоог боловсронгуй болон хөгжихөд суурь нөхцөл болдог. Иймд энэхүү хоёр ойлголтыг тусд нь бие биенээс нь ялган салгаж ойлгоход нэг талдаа төвөгтэй, салгаж ойлголоо гэхэд тэдгээрийн тус бүрийн мөн чанар, онцлогийг бүрэн дүүрэн гаргах боломжгүй юм. Ийм л харилцан хамаарал бүхий ойлголтууд.

Тийм учраас судлаачдын дээрх тайлбарлал, үндэслэлийн зэрэгцээ улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий тольд хэрхэн тайлбарласныг авч үзэх нь онол, арга зүйн чухал ач холбогдолтой. Орос хэлнээ хэвлэгдсэн улс төрийн нэвтэрхий толь бичиг (Политическая энциклопедия.М.,1999)-т “Улс төрийн тогтолцоо нь тухайн улсын түүхийн явцад бүрэлдэн бий болсон засаглалын хэлбэрийн үйлчлэлийн үр дүнд улс төрийн системийн бүтэц, зохион байгуулалтын шинжийг илэрхийлж бий болдог, засаглагч, эрх баригчдын улс төрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх хэрэгсэл болсон систем бүхий тогтолцоо юм”¹⁶⁶ гэжээ. Үүнээс үзэхэд улс төрийн тогтолцоо бол тухайн улс орны улс төрийн зохион байгуулалтын үндсэн хэлбэр, түүнийг хэрэгжүүлэх явцад тогтоож бүрэлддэг формац юм.

Улс төрийн тогтолцоо бол тухайн улсын хөгжлийн явцад бүрэлдэн тогтсон улс төрийн зохион байгуулалтын хэлбэр, дүрс юм гэж дээр нэгэнт тодорхойлсон билээ. Өөрөөр хэлбэл улс төрийн харилцаанд оролцож буй субъектүүдийн (төр, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагууд, бие хүн, хууль эрх зүй, улс төрийн уламжлал) хооронд хэвшин тогтсон харилцаа, зохион байгуулалтын хэлбэршсэн бүтэц юм. Тиймээс учраас улс төрийн тогтолцоо нь төрийн тогтолцооноос илүү өргөн хүрээг хамардаг ойлголт. Харин төрийн тогтолцоо бол төрийн эрх мэдлийг хуваарилан тэнцэржүүлж буй хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн салаа мөчрүүдийн хоорондын харилцан хяналт, тэнцэл бүхий харилцаагаар илэрхийлэгддэг ойлголт юм.

Хэдий тийм ч улс төрийн тогтолцоо, төрийн тогтолцоо нь өөр хоорондоо огт хамааралгүй зүйл биш. Харин ч хоорондоо маш нарийн сэжимээр холбогдож чиг үүргийн давхцлыг үүсгэсэн олон талт харилцааны шинж байдалд оршдог бөгөөд ингэхдээ төрийн тогтолцооны шинж, харилцаа улс төрийн тогтолцоонд тэргүүлэх байр суурь эзэлж байдаг билээ. Тиймээс төрийн тогтолцооны аливаа шинэтгэл улс төрийн тогтолцооны мөн чанар, агуулгыг өөрчлөхөд онцгой үүрэгтэй. Ингээд улс төрийн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэгддэг институциональ хийгээд функциональ хандлагаар Монголын улс төрийн тогтолцооны мөн чанар, тулгамдаж буй асуудлуудыг тодруулахыг оролдоё.

ХОЁР. МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН ТОГТОЛЦООНЫ ТУЛГАМДСАН АСУУДАЛ

1990 онд бид нийгмийн бүх хүрээг хамарсан өөрчлөлт, шинэчлэлийг нэгэн зэрэг хийсэн. Энэхүү өөрчлөлтийн тэргүүлэх чиглэл нь улс төрийн тогтолцооны шинэчлэл байсан гэдэгтэй хэн ч маргахгүй биз ээ. 1990 онд Монголд олон намын систем бүрэлдэн бий болж, ард түмэн ардчилсан чөлөөт сонгуулиар төрөө байгуулах эрхийг олж авсанаар энэ үйл явц эхэлсэн. 1992 онд батлагдсан Үндсэн хууль үүнийг улам баталгаажуулсан юм. Монгол улсын гавьяат хуульч Б.Чимид “Шинэ үндсэн хууль нь Монгол улсын оршин хөгжихүйн шинэ эриний тулгуур үндсийг бататгасан, мөн чанарын хувьд өмнөхөөс эрс өөр, ардчилсан хэв маягийн баримт бичиг мөн....төр нийгмийн байгууллын өнөө, ирээдүйн үндэс тулгуурыг бэхжүүлсэн утгаар

¹⁶³ Д.Болд-Эрдэнэ. Улс төрийн системийн онолын үзэл баримтлал. Философи, эрх зүйн судлал сэтгүүл. XXV боть. 137 дахь тал.

¹⁶⁴ А.Гидденс. Социологи. Орчуулгын редактор Д.Ганхуяг. УБ., 2006. 246 дахь тал

¹⁶⁵ Ч.Өлзийсайхан. Улс төрийн систем, улс төрийн тогтолцоо, төрийн тогтолцоо гэсэн ойлголтуудын тухайд. МУИС. Политологи сэтгүүл. №297 (50). УБ., 2009. 65 дахь тал

¹⁶⁶ Политическая энциклопедия. Ред. Г.Ю.Семигин. Москва., 1999. Стр. 217

нь үндсэн хуулийн үр өгөөжийг өгүүлэвч баршгүй билээ”¹⁶⁷ хэмээн шинэ үндсэн хуулийн ач холбогдолыг үнэлсэн байдаг. Тиймээс ч бид үндсэн хуулиараа улс төрийн тогтолцооны ардчилсан хэв загварыг бий болгож дэлхий дахины ардчилсан хөгжлийн жишиг хандлага руу тэмүүлж байгаа билээ. Ийнхүү үндсэн хуулиар тогтсон улс төр, төрийн тогтолцооны шинэ хэлбэрийг хөгжүүлэх амаргүй сорилтуудыг даван туулах явц өнөө хэр үргэлжилж байна. Онож алдахын аль алиныг хослуулж ирлээ.

Үндсэн хуулийг хэрэгжүүлэх явцад өнөөгийн улс төр хийгээд төрийн тогтолцооны механизмд зарим согог илэрч, энэ нь цаашид төрийн үйл ажиллагааг гажуудуулах хэмжээнд хүргэж буй тухай, түүнийг засаж залруулах зайлшгүй шаардлага байгаа талаар эрдэмтэн судлаачид судлан дүгнэж, улс төрчид, улс төрийн намууд ярьж бичих болсноор нэлээдгүй хугацаа өнгөрч байна. Энэ хандлага нийгэм, улс төрийн сэтгэлгээ, ухамсарт улам бүр хүлээн зөвшөөрөгдөх шинжтэй боллоо. Үнэхээр манай улс төрийн тогтолцоо гажуудчихаад асуудал үүсээд байна уу? эсвэл түүнийг зориудаад “гажуудсан” болгож хандаад байна уу? Тийм зорилго аль нэг улс төрийн хүчин, нийгмийн тодорхой бүлэгт байна уу? Эсвэл үгүй юу? гэдэгт хариулт өгөх ёстой. Мэдээж үүнийг нэг илтгэлээр бүрэн дүүрэн гаргаж, шийдэх арга замуудыг тодорхойлох боломж хомс юм. Тийм учраас судлаачийн хувьд энэ асуудалд анхаарлаа хандуулж Та бүхэнтэй санал бодлоо солилцохоор энэхүү илтгэлийг бэлдлээ.

Институциональ талаасаа авч үзвэл бид улс төрийн тогтолцооны ардчилсан хэв шинж (хэлбэр)-ийг бүрдүүлэх үйл явц үндсэн хуулийн эрх зүйн системийн хүрээнд чамгүй сайн явагдсан гэж үзэх үндэс бий. Өөрөөр хэлбэл улс төрийн ардчилсан тогтолцооны “бодит байдал” харагдах талаасаа нийгэм-улс төрийн амьдралын тодорхой хэв маяг болсон гэсэн үг. Үүнийг тодорхойлвол,

- Төрийн ардчилсан байгуулал (иргэд төрөө байгуулах эрхтэй болсон, төрийн эрх мэдэл хуваарилах онол хэрэгжих хөрс бүрдсэн)
- Олон намын систем
- Сонгуульт ардчилал
- Иргэдийн эвлэлдэн нэгдэх, оролцоогоо хангах бүх эрх
- Өмчийн олон хэлбэр бүхий чөлөөт эдийн засгийн тогтолцоо
- Олон ургаль үзэл, санал бодол, хэвлэлийн эрх, эрх чөлөө
- Хүний эрхийг хангах, хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн гэх мэт. Тогтолцоо талаасаа энэ бүгд бидний амьдралд бодитой бий болжээ. Харин бодитой байгаа тогтолцоогоо цаашид бэхжүүлэх, боловсронгуй болгоход бид юу хийж байна вэ? Юу хийж чадах вэ? гэдэг л хамгийн их анхаарал татсан асуудал юм. Чухамхүү үүн дээр л цаашид анхаарах учиртай. Ардчилал хүний сайнд найдахаасаа илүү тогтолцооны давуу талд тулгуурлан хөгждөг. Тийм учраас юуны урьд тогтолцоогоо, тэр дундаа улс төрийн тогтолцоогоо зөв бүрдүүлж бэхжүүлэх нь нийгмийн тулгамдсан асуудлыг шийдэж хөгжилд хөтлөх хөтөч болно. Ардчиллын бэхжилт, чанарыг судалж буй олон улсын хүрээлэн, төвүүдийн хийж буй судалгаанаас харахад ардчиллын бэхжилтэд эерэг болон сөргөөр нөлөө үзүүлж буй чухал хүчин зүйлсийн нэгэнд улс төрийн тогтолцоог оруулсан байна. Улс төрийн тогтолцооны төлөвшил сул, бэхжээгүй улс оронд ардчилал хөгжих боломжгүй, харин зөв бүрэлдэж, хэвшсэн орнуудад ардчилал бэхжин чанаржих зүй тогтолтойг судлаачид нотолсон¹⁶⁸ байна.

Ази дахь ардчиллын шилжилт, бэхжилт, чанарыг судлан дүгнэсэн Азийн барометр судалгааны эмхэтгэлд судлаач Роуз, Линц нар аливаа орны (тухайлан судалгаанд хамрагдсан 7 орон буй. Тэдгээрийн нэг нь Монгол) улс төрийн тогтолцоог компьютерийн техник хангамж, программ хангамжтай зүйрлэсэн. Компьютер техник хангамж, программ хангамжийн бүрдэл бий болсон нөхцөлд ажилладаг. Тэрээр улс төрийн тогтолцоог компьютерийн техник хангамжтай, улс төрийн сайн бодлого, хөтөлбөр, хууль дүрмийг программ хангамжтай зүйрлүүлж жишсэн. Монголын хувьд компьютерээр бол техник хангамж буюу улс төрийн тогтолцоо нь тодорхой түвшинд бүрдэж бий болжээ. Харин тэрхүү тогтолцоог ажиллуулж, хөгжүүлдэг бодлого буюу компьютерээр бол программ хангамж нь маш сул байна гэсэн үнэлгээг¹⁶⁹ өгсөн байна. Өөрөөр хэлбэл манай улс төрийн тогтолцооны институциональ шинж нь бүрэлдэж чадсан хэдий ч түүнийг функциональ чиг үүрэгтэй нь оновчтой уялдуулах ажлууд сайн хийгдээгүй гэсэн дүгнэлтийг хийсэн байна. Бидний хувьд ч ийм дүгнэлттэй санал нэг байгаа юм.

Өнөөдөр Монголын улс төрийн тогтолцооны функциональ шинж алдагдсаны сөрөг үр дагавар олон шинж хандлагаар илрэх болсон бөгөөд үүнд дараах объектив болон субъектив хүчин зүйлүүд нөлөөлсөн гэж үзэж байна.

¹⁶⁷ Б.Чимид. “Ардчилсан Үндсэн хууль бол Монголын ард түмний бүтээл мөн” сэдэвт илтгэл. Үндсэн хуулийн 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. УБ., 2012.01.10

¹⁶⁸ Азийн барометр судалгааны эмхэтгэл. Редактор Д.Ганбат. УБ., 2008, Монголын ардчиллын төлөвшил. Редактор Г.Чулуунбаатар. ШУА.ФСЭХ. УБ., 2010, Д.Лүндэежанцан. Эрх мэдэл ба ардчилал. УБ., 2015, А.Лийпхарт. Ардчиллын хэв загвар. Гучин зургаан орны төр засгийн хэлбэр ба илрэл. УБ., 2007, О.Машбат. Үндсэн хууль: улс төр-эрх зүй, хянал-тэнцэл. УБ., 2015, Ж.С.Фишкин. Хүмүүс үзэл бодлоо илэрхийлэхүй: Зөвлөлдөх ардчилал ба олон нийтийн зөвлөгөөн. Орчуулсан Г.Зандашатар. УБ., 2015, Marc Landy, Sidney M. Milkis. American Government: Balancing democracy and Rights. Cambridge press., 2010

¹⁶⁹ Азийн барометр судалгааны эмхэтгэл. Редактор Д.Ганбат. УБ., 2008. 249 дэх тал

Объектив талаасаа,

- ардчилсан улс төрийн тогтолцооны уламжлал бага байсан (монголын уламжлал, онцлогоос урган гарсан шинэ мэдлэг, онол бүтээж ардчиллын нийтлэг үнэт зүйлтэй уялдуулах замаар бүрэлдүүлэх, одоо ч шаардлага их бий.)
- нийгмийн бүх хүрээг хамарсан шилжилтийг нэгэн зэрэг хийсэн нь олон хүндрэл бэрхшээлүүдийг бодит амьдралд бий болгосон
- чөлөөт зах зээл нь материаллаг байдлыг хэт шүтэх үзэл, хандлага руу хөтөлсөн
- гадаад орчны (хоёр хөрш) нөлөө зэрэг байгаа бол

Субъектив талаасаа,

- бүх зүйлийг шинээр эхлэх, шинэ мэдлэг олж авах, суралцах шаардлага тулгарсан
- нийгмийн сэтгэлгээг хэт задалж нийтээрээ хөгжлийг баримжаалах концепцгүй болсон
- улс төрийн намуудын бодлого, үзэл суртлын саармагжилт явагдсан
- хувийн ашиг сонирхол улс төрийг хөтлөх хандлагатай болсон
- хуулиас хэтийдсэн улс төржилт асуудлыг шийдэх арга механизм болж хувирсан зэргийг дурьдаж болно.

Аливаа тогтолцоо, систем тодорхой зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэж бий болдог. 1990 онд өнөөгийн улс төрийн тогтолцооны үндсийг тавихдаа улс төрийн тогтолцооны төвлөрсөн илэрхийлэл болсон төрийн тогтолцооны эрх мэдэл хуваарилалтын зарчмыг алдагдуулсан нь өнөөдөр бүх асуудлын гол зангилаа болж байна. Эрх мэдэл хуваарилах сонгодог зарчмаар хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн төрийн гурван салаа мөчрийн эрх мэдэл нь энэ тэнцүү, харилцан бие биеэсээ урган гарсан цогц байхын зэрэгцээ хоорондоо хянал-тэнцэлтэйгээр тус тусынхаа чиг үүргийг хэрэгжүүлдэг¹⁷⁰. Төрийн эрх мэдлийг хуваарилах онолыг үндэслэгчид үзэхдээ төрийн эрх мэдлүүд зөвхөн үйл ажиллагаа ч биш тэдгээр нь бүр анхнаасаа үүсэж бий болох, бүрэлдэн тогтох үеэсээ л бие даасан байдалтай байх ёстой гэсэн зарчмыг тунхагласан байдаг. Өөрөөр хэлбэл төрд буй “нэг цул” эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх чиг үүрэгт хуваарилж тус бүрийнх нь хараат бус бие даасан, харилцан нэг нэгийгээ нөхцөлдүүлж, хянал тэнцэлтэй байх суурь зарчмуудыг л үндсэн хуулиар баталгаажуулсан байх учиртай билээ. Гэтэл манайд энэ зарчмыг гажуудуулсан нь даамжирсаар төрийн механизмыг гацаах хэмжээнд хүргээд байгаа билээ. Төрийн механизмын гацаа, түүнээс үүдсэн тогтолцооны гажуудал нь улс төрийн тогтолцоондоо шууд нөлөө үзүүлж системийг бүхэлд нь хямрахад хүргэж байгаа юм. Үүний нэг илрэл нь хууль тогтоох чиг үүрэг өөрт байгаа давуу эрх мэдлээ ашиглан гүйцэтгэх эрх мэдлийг эрхшээлдээ оруулах байдал сүүлийн жилүүдэд ажиглагдах болсон. Энэ талаар судлаач О.Машбат “Эрх мэдлийг хуваарилсан байх гол үндэс бол эрх мэдлийн хооронд хянал-тэнцлийн баттай хөшүүрэг байх явдал юм. Ийм хөшүүрэг байхгүй бол парламент улс төрийн давуу байдлаа ашиглан засгийн газрыг эрхшээлдээ оруулах боломжтой”¹⁷¹ гэж дүгнэсэн байна.

Ийнхүү төрийн эрх мэдэл хуваарилах зарчим Монголд алдагдсан шалтгаан нь Үндсэн хуульд бус харин улс төрчид, шийдвэр гаргагчдын буруутай үйл ажиллагаа, бодлогод бий хэмээн үзэх судлаачид байна. “Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл хоёр бараг нийлсэн. Шалтгаан нь улс төрчид санаачилгаараа үндсэн хуулийг өөрчилж, нам, төр хоёр хутгалдсан”¹⁷² гэж профессор Б.Чимид үзсэн бол доктор Н.Лүндэндорж “өдгөө монгол улсад төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд хуваарилан хэрэгжүүлэх бус, харин төрийн эрх барих дээд байгууллага төрийн дээд эрхээ дангаараа эдэлж байна. Тэр байгууллага үндсэн уугуул чиг үүргээ (төлөөлөх, хууль тогтоох) бараг хэрэгжүүлэхгүй нөгөө дээд эрхээ л хэрэгжүүлж байна”¹⁷³ гэж тус тус дүгнэжээ.

Төрийн тогтолцооны функциональ чиг үүрэгт гарч буй энэхүү гажуудал нь парламентад суудалтай улс төрийн намын “тоглоомын дүрэм”-ийг өөрчилж, үндсэн хууль болон бусад хуулиас давсан улс төржилтийг гааруулж улс төрийн тогтолцоогоо эвдэх, хямруулах зам руу хөтөлж байна. Гавьяат хуульч Б.Чимид энэ тухай “Монголчууд ардчиллыг сонгосон нь буруу биш, харин түүний уг чанар болсон ардчилсан улс төрийн тогтолцоог зөв төлөвшүүлж, механизмыг зөв ашиглаж чадахгүй, жишээлбэл намууд шиг гуйвуулж, далимдуулагчид ардчилсан ёсыг хувьдаа шунхайран ашиглаад байгааг ойлгох хэрэгтэй. Бид сахилгатай зохион байгуулалт, зохион байгуулалттай ардчиллыг л дэмжинэ”¹⁷⁴ гэсэн нь бид бурууг тогтолцоонд өгөхөөс өмнө өөрсдийн үйл ажиллагаанаас олж засаж залруулах ёстойг анхааруулсан хэрэг юм.

Нэгэнт бодит байдал иймийн учир УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар болон парламентад суудалтай болон суудалгүй намуудын хүрээнд зөвшилцлийн механизмыг бий болгох замаар үүссэн гажуудлыг засаж залруулах гарцыг хамтаараа эрэлхийлэх явдал юу юунаас чухал байна.

¹⁷⁰ Ш.Монтескье. Хуулийн амин сүнс. Орчуулсан Т.Төмөрхүлэг. УБ., 2008. I дэвтэр II, III бүлэг

¹⁷¹ О.Машбат. Үндсэн хууль: улс төр-эрх зүй, хянал-тэнцэл. УБ., 2015. 36 дахь тал

¹⁷² Б.Чимид. Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. УБ., 2006. 75 дахь тал


¹⁷³ Н.Лүндэндорж. Олигархийн дарангуйллаас ардчилалд хүрэх зам. Эрх зүй сэтгүүл. № 2-3. МУИС.УБ., 2007. 25 дахь тал

¹⁷⁴ Б.Чимид. Ардчилсан үндсэн хууль бол Монголын ард түмний бүтээл мөн. Үндсэн хуулийн 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. УБ., 2012.01.10.

ГУРАВ. УЛС ТӨРИЙН ТОГТОЛЦООГ ҮНЭЛЭХ СОНГОГЧДЫН САНАА БОДОЛ


Дээр дурьдсанчлан улс төрийн тогтолцоонд шийдвэрлэх асуудал олон байгаа гэдгийг судлаачид, шийдвэр гаргагчид хүлээн зөвшөөрч ярьж, бичиж байгаа билээ. Үүний зэрэгцээ иргэд сонгогчдын улс төрийн тогтолцоогоо хэрхэн үнэлж буй нь анхаарал татах асуудал мөн. Тиймээс бид олон нийтийн санал бодлын судалгаанд үндэслэж тэдний үнэлэмж, хандлагыг тодруулах боломжтой. Сонгуулиас сонгуулийн хооронд улс төрийн институциуд (төр, нам, иргэний нийгмийн байгууллагууд)-д итгэх иргэдийн итгэл улам суларсаар байгаа дүр зураг олон удаагийн давтамжит судалгаанаас харагдаж байгаа нь сонгогчид оршин буй улс төрийн тогтолцоогоо төдийлөн итгэл муутай хандаж ирсний нотолгоо юм. Үүнийг зарим судалгааны дүнгээр харуулья.

Манай өнөөгийн улс төрийн тогтолцоо Таны сэтгэлд хэр нийцдэг вэ?¹⁷⁵



Судалгааны дээрх дүнгээс харахад улс төрийн тогтолцооны өнөөгийн төлөвшлийг сэтгэлд нийцдэг гэж судалгаанд оролцогсодын 18.8% нь үзсэн бол, 32.2% нь бага зэрэг нийцдэг, 22.6% нь бараг нийцдэггүй, 23.3% нь нийцдэггүй гэж хариулж санал бодлоо илэрхийлсэн байна. өөрөөр хэлбэл судалгаанд оролцогсодын 45.9% нь нийцдэггүй гэдэгтэй бүрэн итгэлтэй байна. Үүн дээр бага зэрэг нийцдэг гэж хариулсан респондентыг оролцуулан тооцвол 70 гаран хувь нь өнөөгийн улс төрийн тогтолцоонд сэтгэл дундуур явдагаа илэрхийлсэн байна. Иргэд улс төрийн тогтолцоогоо яагаад ингэж доогуур үнэлж байна вэ? Учир юунд байна? гэх зэргээр цааш задалж ойлгохын тулд улс төрийн тогтолцоог бүрдүүлж буй институциудын бодлого, үйл ажиллагаанд өгч буй үнэлгээг иргэдийн тэдгээр байгууллагуудад хэр итгэж буй байдлаар тодруулж болох юм.

Улс төрийн тогтолцоог бүрдүүлж буй институциудад итгэх итгэл¹⁷⁶



Судалгааны дүнгээс үзэхэд Ерөнхийлөгч, УИХ, улс төрийн намуудад итгэх итгэл сул байна. тухайлбал, Ерөнхийлөгчид итгэх итгэл 40%, харин бараг итгэдэггүй, итгэдэггүй үзүүлэлт 54.8% байгаа бол УИХ-д итгэх итгэл 32.2%, харин бараг итгэдэггүй, итгэдэггүй үзүүлэлт 61.7%, улс төрийн намуудад итгэх итгэл 25% байгаа бол итгэдэггүй үзүүлэлт 67.1% байна. Үүнээс үзвэл иргэд, сонгогчид нийгэм дэх улс төржилтөөс тэрхүү улс төржилтийг “хөөсрүүлж” буй улс төрийн намууд, парламент, улс төрчдийн бодлого үйл ажиллагаанд илүү их шүүмжлэлтэй хандсан байна.

¹⁷⁵ Сант Марал. Улс төрийн барометр. 2015.04 сар

¹⁷⁶ Сант Марал. Улс төрийн барометр. 2015.04 сар

Ийм байдал нь иргэд сонгогчдын улс төрийн иснтитуци, байгууллагуудад итгэх итгэлийг улам сулруулах сөрөг хүчин зүйлсийн нөлөөг нэмэгдүүлж, харин тэдгээрийн оронд бие хүн, тодорхой нэг лидерийн манлайлалыг хүсэмжлэх үйл байдлыг төлөвшүүлэх хандлагыг бий болгож байна. Улс төрийн тогтолцоо сул, төлөвшил муу байгаа улс оронд тодорхой бие хүн, лидерийг хүсэмжилдэг, тэр нь бодит биелэлээ олох үед дарангуйлал руу, авторитари дэглэм рүү гулсан орох тохиолдол цөөнгүй байгаа юм. Монголын сонгогчдын нийгэм, улс төрийн сэтгэл зүйн өнөөгийн хандлага, үйл байдлын төлөв ийм нөхцөл рүү ороход бэлтгэгдэж байгаа юм биш үү гэсэн болгоомжлол байна. Бие даасан хараат бус судалгааны байгууллагууд, их дээд сургуулиудын судалгааны төв, хүрээлэнгүүдээс хийсэн судалгааны дүнгүүдээс харахад ийм байдал ажиглагдаж байгаа юм. Үүнийг МУИС-ийн Улс төр судлалын тэнхимээс жил бүр хийдэг судалгааны дүнгээс харж болно.

Иргэд улс төрийн тогтолцоогоо ингээж үнэлж байна¹⁷⁷



Судалгааны энэхүү дүнгээс харахад сонгогчид Монгол улсад парламентын засаглалаас Ерөнхийлөгчийн засаглалыг илүүд үзсэн байна. 2013 онд парламентын засаглалыг дэмжих хандлага 33%-тай, Ерөнхийлөгчийн засаглалыг дэмжих дэмжлэг 38.3% буюу 5%-ийн зөрүүтэй байсан бол 2014 онд буюу жилийн дараа энэ хандлагын зөрүү даруй 10.4% болж өссөн байна. Парламентын засаглалыг дэмжих дэмжлэг 29.3% болж 5.3%-иар өссөн байгаа бол Ерөнхийлөгчийн засаглалыг дэмжсэн нь 39.7% болж даруй 10.4%-иар өссөн байна. Судалгааны энэхүү үр дүн юуг өгүүлж байна вэ? гэвэл цаашид бид улс өнөөгийн төрийн тогтолцоогоо төлөвшүүлж, бэхжүүлэх зайлшгүй шаардлагатайг нотолж буй хэрэг юм. Цаашид улс төрийн тогтолцоогоо бэхжүүлж, төлөвшүүлэхийн тулд бид юунаас эхлэх ёстой вэ гэдэг асуудал тулгарах нь мэдээж хэрэг. Тэгвэл бид үүнийг эхлүүлэх эхний алхам бол улс төрийн нам, хүчнүүд болон нийгмийн бүх хүрээнд үндэсний зөвшилцөл, ойлголцолыг бий болгож ажиллах явдал мөн.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА МЕХАНИЗМ БОЛ УЛС ТӨРИЙН ЗӨВШИЛЦӨЛ МӨН.

Нийгэм бол олон ашиг сонирхолын нэгдлээс бүрдэж байдаг. Сонирхлын давхцал байхгүй нөхцөлд төр болон зохион байгуулалттай сонирхлын бүлэг нийтлэг шийдвэрүүдийг гаргаж хэрэгжүүлэх нь улс төрийн зөвшилцөл хийх шаардлагыг зайлшгүй бий болгодог. Зөвшилцөл байхгүй нөхцөлд нэг бол шийдвэр гаргахгүй, эсвэл ямар нэг хэмжээний хүчирхийллийн арга хэрэгслийг хэрэглэх нь зайлшгүй болно. Тиймээс нийгэм улс төрийн амьдралын тогтвортой байдлыг хангахад зөвшилцөл чухал ач холбогдолтой. Монголд улс төрийн тогтолцоог төлөвшүүлэх үүний тулд төрийн тогтолцооны тулгуур асуудлууд (төрийн эрх мэдэл хуваарилах суурь зарчмыг тогтоох)-аа оновчтой шийдвэрлэх, улс төрийн зөвшилцөлийн механизмыг бий болгож, бэхжүүлэх шаардлага улс төрийн амьдралаас урган гарч байгааг дээр өгүүлсэн. Улс төрийн зөвшилцлийг доорх чиглэлүүдээр өрнүүлэх нь чухал ач холбогдолтой. Үүнд,

- Үндсэн хуульд өөрчлөлт оруулах замаар төрийн тогтолцоогоо эрх мэдэл хуваарилах онол, зарчмыг дагуу боловсронгуй болгох
- Улс төрийн намын институтжилтийг хангахад үйлчлэх эрх зүйн орчныг бий болгох
- Сонгуулийн системийн оновчтой хувилбар сонгож, төлөвшүүлэх
- Төрийн албаны тогтвортой байдал, улс төрөөс ангид байх үндсийг тогтоох
- Оюу толгой, Таван толгой зэрэг томоохон төслүүдийг урагшлуулах
- Эдийн засгийн хүндрэл, бэрхшээлийг даван туулах зэрэгт эн тэргүүнд анхаарвал зохино.

¹⁷⁷ МУИС. Улс төр судлалын тэнхим. Монголчуудын улс төрийн үзэл бодол, сэтгэлгээнд гарч буй өөрчлөлт сэдэвт судалгаа. 2013, 2014

Яагаад улс төрийн зөвшилцөл чухал вэ? Өнөөдөр нийгмийн бүлгүүд, улс төрийн намууд, тэр атугай төрийн эрх барьж буй болон парламентад суудалтай намуудын хүрээнд, төрийн өндөрлөгүүдийн хооронд үндэсний шинж, агуулгатай аливаа асуудлыг зөвшлийн аргаар, зөвшилцөлийн зарчмаар шийддэг ур ухаан дутагдаж байна. Үндсэн хуулийн өөрчлөлт, намын эрх зүйн шинэтгэл, сонгуулийн реформ, төрийн албаны шинэтгэлийн хийгдэхгүй байгаа нь ингэж дүгнэхээс өөр аргагүйд хүрч байна. Таван толгойн төсөл ч урагш хөдөлсөнгүй. Сонгуулийн хууль, намын хууль, үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал зэрэгт намууд өөр өөр байр суурьтай байгаа нь үүний илэрхий жишээ юм. Энэ бүх асуудлыг шийдэхэд улс төрийн намуудын эрүүл саруул ойлголцол, зөвшилцөл хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэнэ. Нийгэм, улс төрийн тулгамдсан тулгуур асуудлуудаа зөвшилцөлийн зарчмаар шийдэж чадаагүйгээс үүдсэн сөрөг үр дагаврыг нийгэм нийтээрээ л амсах болно. Улсаараа л хохирно. Харин хожил, хонжоо хүлээсэн нийгмийн цөөнх байхыг үгүйсгэхгүй. Иймд төрд, улс төрийн намуудад ойлголцол, зөвшилцөлийн эрүүл саруул соёл төлөвших нь юу юунаас чухал байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992
2. Д.Лүндээжанцан. Монгол улс дахь эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2014
3. Д.Лүндээжанцан. Эрх мэдэл ба ардчилал. УБ., 201:
4. Б.Чимид. Ардчилсан Үндсэн хууль бол Монголын ард түмний бүтээл мөн. Үндсэн хуулийн 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. УБ., 2012
5. Б.Чимид. Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. УБ., 2006.
6. О.Машбат. Үндсэн хууль: улстөр-эрх зүй, хянал-тэнцэл. УБ., 2015
7. М.Сланн. Улс төрийн удиртгал. Орчуулсан Ё.Довчин. УБ., 2005
8. Азийн барометр. Ардчиллын харьцуулсан судалгаа. УТБА. УБ., 2008
9. Монголын ардчиллын төлөвшил. ШУА. ФСЭХ. УБ., 2011
10. А.Гидденс. Социологи. УБ., 2006
11. Ш.Монтескье. Хуулийн амин сүнс. УБ., 2008
12. Ж.С.Фишкин. Хүмүүс үзэл бодлоо илэрхийлэхүй. Орчуулсан Г.Занданшатар. УБ., 2015
13. Политологи сэтгүүл. №297 (50). МУИС. УБ., 2009
14. Философи, эрх зүйн судлал сэтгүүл. XXV боть. ШУА.ФСЭХ. УБ., 2010
15. Политическая энциклопедия. Ред. Г.Ю.Семигин. Москва., 1999
16. Marc Landy, Sidney M. Milkis. American Government: Balancing Democracy and Rights. Cambridge press., 2010

ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ТӨРИЙН БОДЛОГОД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

С.БАЗАРПҮРЭВ

Профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,

Улс төр судлалын тэнхим

Д.ГООМАРАЛ

Улс төр судлалын тэнхимийн магистрант

Түлхүүр үг: Ядуурал, ядуурлыг бууруулах төрийн бодлого, ядуурлын шалтгаан

Abstract: Defining the poverty in a short way that the most simplest feature to every person is the tactile of the low income and the spare consumption. It must not be defined that the reason of the poverty is from social and economical factors. We must research individual factors. It is necessary to the researching of science and it is important to the decision making in state politics and implementing that politics.

1990 оны үед өрнөсөн нийгэм, эдийн засгийн өөрчлөлт нь хүмүүсийн оюун санаа, сэтгэл зүй, ухамсар, амьдрах арга барил, нийгэмд эзлэх байр суурь зэрэг нийгмийн амьдралын бүхий л хүрээнд өөрчлөлтийг эхлүүлсэн юм. Үүнээс өмнөх нийгэм эдийн засгийн тогтолцооны үед цалин хөлс, ажлын байрыг таван жилийн төлөвлөгөөгөөр тодорхойлогдсон эрэлт нийлүүлэлтийн дагуу тогтоож байсан ба энэ үед ажил эрхлэлтийн төвшин нийгэмд жигд байсан болохоор иргэдийн амьдралын төвшин ойролцоо байсан юм. Ядуурал нь харьцангуй далд байдалд байсан бөгөөд 1990 оноос эхлэн уг асуудал нийгмийн хэмжээнд хурцаар хөндөгдөх болж ил гарсан.

XVIII–XIX зууны эхэнд нийгмийн шинжлэх ухааны хүрээнд ядуурлыг судлах социаль дарвинизм, эгалитаристизм гэсэн үндсэн хоёр хандлага байсан байна.

Социаль дарвинизмын үзэл баримтлалд ядуурал нь оршин тогтнохын төлөө тэмцэл, байгалийн шалгарал зэргээс үүдэн нийгмийн тэгш бус байдлаас бий болдог хэмээн үздэг. Ядуучуудын материаллаг байдлын хүндрэл, хүрэлцээтэй бус байдал нь тэднийг нийгмийн давхраажилтын доод давхаргад буюу ядууралд хүргэдэг гэж үздэг.¹⁷⁸

Т.Мальтус “Essay on the principle of Population” бүтээлдээ байгалийн хуулиар нийгэм гэдгийг үгүйсгэхийг оролдсон ба үүнийг прогрессийн хуулиар тайлбарласан ажээ.¹⁷⁹ Хүн ам геометр прогрессоор өсөж байхад тэдний амьдралын хэрэгцээ, оршин тогтнох нөхцөл нь арифметик прогрессоор өсдөг. Энэ ялгавартай өсөлт нь илүүдэл хүн амыг бий болгоно. Ийнхүү хүн хоол хүнс, өмсөх хувцас дутагдалтай байдлаас үүдэн ядуурал бий болдог аж. Хүн амын түргэн өсөлтөөс ядуурал хамаарч байдаг ба төр засгаас ядуу хүмүүст туслах нь ядуу үе давхрагыг үржих хүрээг тэлдэг гэжээ.

Г.Спенсер “Социальная статика”¹⁸⁰ бүтээлдээ ядуурал нь нийгмийн хэвийн үзэгдэл хэмээн тэмдэглээд ядуурал ба нийгмийн тэгш бус байдал нь нийгмийн үйлдвэрлэлийн хөгжилтэй хамт өсдөг гэж дүгнэжээ. Хүмүүс янз бүр байдаг, зарим нь нийгмийн амьдралын олон зүйлд амархан дасдаг байхад, нэг хэсэг нь чаддаггүй. Тиймээс ядуурал үүсдэг. Ядуучуудад туслах нь тэдний үйл ажиллагаа, эрх чөлөөг хязгаарласантай адил. Ядуурал гэдэг нь нийгмийн баялгийг тэгш бус хуваасанд оршдог. Татварыг нэмэгдүүлэх замаар ядуучуудад туслах хэрэгтэй. Бусдын төлөө ядуурах нь тийм ч тааламжтай байдал биш юм. Тэрнээс салах арга зам байхгүй, нийгмийн хангамжаар хэдий чинээ олон хүн амьдарна төдий чинээ биеэ даасан ажлын байрны тоо багасгаж, түүнээс хамааран олонхид хэрэгцээтэй таваарыг үйлдвэрлэж байгаа хүмүүсийн тоо цөөрнө гэж үзжээ.

Эгалитарист урсгалын төлөөлөгчдийн тоонд К.Маркс, Э.Реклю, Ч.Бут, С. Раунтри зэрэг эрдэмтэд ордог¹⁸¹.

К.Маркс капитализмын үед олон нийтийн тодорхой хэсэг нь хөлсний хөдөлмөр эрхлэгчид нөгөө хэсэг нь ажилгүйчүүд байдаг тул ядуурах нь зхйлшгүй гэж үзсэн. Ажилгүйчүүд ядуурах нь тодорхой тул хөлсний хөдөлмөр эрхлэгчид буюу ажилчид ажлаа алдахгүй, ажилгүйчүүдийн эгнээнд орохгүйн тулд капиталистуудад хямдаар хөлслөгдөн нөгөө талаас ашгийн норм байнга буурах учир тэд ядуурах болдог гэж үзжээ.

¹⁷⁸ Сычева. В.С “Определение и измерение бедности история вопроса” 1996 года

¹⁷⁹ Философийн толь. УБ хот. 1984он. Хуудас 241

¹⁸⁰ Сычева. В.С “Определение и измерение бедности история вопроса” 1996 года

¹⁸¹ Сычева. В.С “Определение и измерение бедности история вопроса” 1996 года

Э.Реклю “Богатство и нищета”¹⁸² бүтээлдээ ядуурлыг авч үзсэн ба ядуурлын эцсийн үе шат бол гуйланчлал гэжээ. Хэрэв хэн нэгэн хүн зөвхөн өдөр тутмын болон үндсэн хэрэгцээгээ хангаж байвал тухайн хүн ядууд тооцогдоно. Ийм хүмүүс маш бага хэмжээний хөрөнгөтэй байдаг. Эд хөрөнгийн дийлэнх нь хоол унд, хувцас хунарт зарцуулдаг гэж үзжээ.

Английн социологич Ч.Бут, С.Раунтри нар XIX зууны сүүлчээр Англид явуулсан судалгаандаа тулгуурлан ядуурлын үндэс бол хэрэгцээ хэмээн дүгнэжээ. Тухайлбал, хоол унд, орон байр, хувцас зэрэг наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүйгээс үүдэн ядуурал үүсдэг.

Хэн нэгэн долоо хоног тутмынхаа хэрэгцээтэй орлоготой бол тухайн хүнийг буюу гэр бүлийг ядуу гэнэ. Хэрэв хүрэлцэхгүй орлоготой бол нэн ядуу гэнэ. Тухайн орны жирийн амьдралын хэрэгцээнд харьцуулахад тухайн хүний гэр бүлийн хэрэгцээг хангахгүй бол ядуурал гэнэ гэж тодорхойлжээ. Ядуурлын шалтгаан мөн чанарыг үе үеийн эрдэмтэд ийнхүү янз бүрээр тайлбарлаж ирсэн байна.

Амьдрал болон боломжийн хомсдол буюу хүний ядуурал бол олон хэмжээст бөгөөд олон төрөлтэй үзэгдэл юм. Хүний ядуурлын тухай ойлголтыг анх 1997 оны Хүний хөгжлийн илтгэлд танилцуулсан юм¹⁸³.

Ядуурал, ядуу хүн гэдгийг тодорхойлох нь зөвхөн шинжлэх ухааны судалгаа шинжилгээнд зайлшгүй төдийгүй төрийн бодлогын хэмжээнд шийдвэр гаргах бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Сүүлийн жилүүдэд Монгол улсад ядуурал, ядуучууд тодорхойлохдоо дэлхий нийтийн жишгийг харгалзан үзэж ирлээ. Ингэхдээ ядуурлыг хүний хөгжлийн үндсэн үзүүлэлтүүдтэй нягт холбож үздэг олон улсын хандлагыг зонхилон баримтлаж ирсэн байна. Тухайлбал, ядуурал гэдгийг хүний хөгжлийн наад захын хэрэгцээ боломж хязгаарлагдмал гэсэн үг гэж Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тодорхойлжээ.¹⁸⁴ Ядуурал гэдэг нь нийгэм, эдийн засгийн хямрал бэрхшээлтэй уялдан хүн амын амьдралын төвшин буурах явцад улам хурцдан гардаг үзэгдэл юм. 1994 онд Монгол улсын засгийн газар, НҮБ-ын хүний хөгжлийн газартай хамтран ядуурлын учир шалтгаан түүний нөхцөл байдлын үнэлгээг хийж “Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг баглан гаргасан. Уг хөтөлбөрт төрөөс тогтоосон амьжиргааны баталгаажих доод төвшингөөс доогуур орлоготой буюу тэрхүү орлогынхоо хэмжээгээр хязгаарлагдмал хэрэглээтэй хүмүүсийг ядуу гэж тодорхойлжээ. Өрхийн нэг хүнд ноогдох орлого нь амьдралын баталгаажих доод төвшингийн 40 хувьд хүрэхгүй хүнсний хэрэгцээгээ хангаж чадахгүй бол нэн ядуу өрххэмээн өөр нэг ангилал байгааг тодотгосон байна.

Эдгээр тодорхойлолтоос дүгнэж харахад ядуурал гэдгийг бага орлого, хомс хэрэглээ гэж ойлгож болно. Хүний хэрэглээ гэдэг тэдний өдөр тутмын хэрэгцээ буюу хоол хүнс орон сууц, эрүүл мэнд боловсролын наад захын хэрэгцээний хангамжийн байдал юм.

Ядуурлын шугам нь ядуурлыг хэмжих гол хэмжүүр юм. Ядуурлын шугамыг гол төлөв орлого хэрэглээнд үндэслэн тогтоодог. Дэлхийн ихэнх орнууд орлого болон хэрэглээг судлан хүн амын ядуурлын шугамыг тогтоодог байна. Орлогын төвшин нь ядуурлыг хэмжих чухал хэмжүүр мөн чанар хүний амьдралыг доройтуулж байдаг олон хүчин зүйлийн нэг л юм.

Олон жилийн туршид ядуурлын тухай үзэл баримтлалыг олон орны шинжээчид янз бүрийн аргаар судлан боловсруулт хийж, хүн амын дундах ядуурлыг тодорхойлох хандлага түгээмэл байв.

Ядуурлыг иргэдийн орлогоор тодорхойлох арга чиглэл байдаг. Хоол хүнс, хувцас, орон байрны байвал зохих доод хэмжээ буюу наад захын хэрэгцээ тус бүрд норм тогтооно. Хэрэв тухайн айл өрх энэ нормийг хангаж чадахгүй байвал ядуу гэж үздэг. Ядуурал гэдэг нь хувь хүн өөрийн үндсэн хэрэгцээний аль нэг хэсгийг бүрэн ба хагас байдлаар хангаж чадахгүй байгаа байдлыг хэлнэ. Дээрх хэсэг бараа үйлчилгээг нэгтгэн үнэлэх замаар амьжиргааны доод төвшин буюу орлогын доод төвшинг тодорхойлдог. Орлогын доод хэмжээ нь хоол хүнсний хэрэгцээтэй нягт холбоотой байдаг ба үүнийг бусад хэрэгцээнээс илүү чухалд үздэг.

Ядуурлыг хүний үндсэн хэрэгцээгээр тодорхойлох арга бий. Ядуурал нь хүний хоол хүнсний хэрэгцээг хязгаарлан доройтуулдаг. Тухайн арга нь нийгмийн зүгээс хүн амыг ядууралд өртөхөөс урьдчилан сэргийлэх хүний наад захын хэрэгцээнээс гадна эрүүлмэнд, боловсрол, нийгмийн бусад үйлчилгээгээр хэрхэн хангаж буйг илтгэн харуулж, үйлчилгээний хязгаарласан байдлаар ядуурлыг тодорхойлдог. Энэ аргад тухайн хүний ажил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоо зэрэг хэрэгцээг чухалчлан авч үздэг байна.

Ядуурлыг хүний чадвараар тодорхойлох арга байдаг. Энэ аргад орлого чухал бус харин тухайн хувь хүн чадвартай байх нь гол зорилго юм. Хувь хүн аливаа үүргийг гүйцэтгэх чадвар чадавхитай байгаагаар ядуурлыг хэмжин тодорхойлдог.

Нэг хүнийг нөгөө хүнтэй харьцуулах замаар ядуурлыг хэмжих арга байдаг. Нийгмийн шинжлэх ухаанд уг аргыг хохирох хандлага гэж нэрлэдэг. Нийгмийн хувьд хохирсон хүмүүс нь ядуу байдаг. Ийм хүмүүс өөрийн нийгмийн зэрэг дэв, өөрт хамаарах бүлгийн орлого, чадвар болон бусад шинж чанараараа ихээхэн хол хоцорч, нийгмийн амьдралд бүрэн оролцож чадаагүй байна. Дэлхий нийтэд орлого болон хэрэглээг үндэслэн ядуурлыг тодорхойлох нь элбэг байдаг ба уг аргыг төдийлөн хэрэглэдэггүй байна.

Ядуурал нь олон янз байдаг бөгөөд хүний ядуурал, орлогын ядуурал, хэт ядуурал, харьцангуй ядуурал, туйлийн ядуурал гэж байдаг.¹⁸⁵

- Хүний ядуурал гэдэг нь бичиг үсэгтэй байх, боломжийн хоол хүнстэй байх зэрэг хүний чадавхийн хоцрогдолтой холбоотой байна.

¹⁸² Сычева. В.С “Определение и измерение бедности история вопроса” 1996 года

¹⁸³ Селиг Жахан, Н.Батнасан, “Хүний хөгжил”, УБ хот, 2006

¹⁸⁴ Монгол Улсын Засгийн газар, “Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр”, УБ хот. 1994 он

¹⁸⁵ Дэлхийн банк “Ядуурал ба түүний арга зүй” 1992 он

- Орлогын ядуурал гэдэг нь наад захын орлого, зарлагын хоцрогдлыг хэлэх бөгөөд энэ нь нилээд өргөн хүрээтэй ойлголт юм.
- Хэт ядуурал нь хүнсний наад захын хэрэгцээгээ хангах чадваргүй байдалд орсныг хэлдэг.
- Харьцангуй ядуурал гэдэг нь ядуурлыг тодорхой цаг хугацааны хувьд болон тухайн нэг улс орны хэмжээнд онцлог байдлыг харгалзан өөрчлөн тогтоосныг хэлнэ. Харьцангуй ядуурал нь орлого баялгийн хувиарлалт, ядуучуудын нийгмийн бусад давхаргатай харьцуулан судалдаг байна.
- Туйлийн ядуурал гэдэг нь бусадтай үл харьцуулсан амьжиргааны наад захын төвшинд хүрч чадахгүй байдлыг тодорхойлно.

Нийгэм эдийн засгийн шилжилтийн үед улс орны үйлдвэрлэлийн хэмжээ, ард түмний амьдралын төвшин буурч, хүүхэд эмэгтэйчүүдийн өвчлөл, эх үрийн эндэгдэл нэмэгдэж, нийгмийн хямрал гүнзгийрч, засгийн газраас ард түмний амьдралыг баталгаажуулах эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн системийг сайжруулах олон талт арга хэмжээг авах ялангуяа ядуу өрхийн хүүхдүүд, өндөр настан, тэтгэвэр тэтгэмж авдаг иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд зэрэг нийгмийн эмзэг хэсгийнхэнд үзүүлэх дэмжлэг, ядуурлыг бууруулах хөтөлбөрийг боловсруулах шаардлага гарч ирдэг байна.

Хүн амын ядуурлыг судлахын тулд эхлээд амьжиргааны төвшинг тодруулах шаардлагатай юм. Олон улсад хүн амын амьжиргааны төвшинг тухайн улс орны хөгжлийн төвшингөөс хамаарч нэг хүнд ноогдох дундаж орлогын хэмжээгээр эсвэл хэрэглээний сагсыг үндэслэн тодорхойлдог байна. Хэрэглээний сагсыг бүрдүүлж байгаа бараа үйлчилгээний нэр төрөл хэмжээ нь улс орны онцлог, хүн амын насны бүлэг зэргээс хамаарч ялгаатай байдаг.¹⁸⁶

Амьжиргааны төвшин гэдэг нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, ахуйн болон хэрэглээний соёлын төвшингөөс хамаарч хүн амын оюуны болон материаллаг, нийгэм ахуйн хэрэглээний цогц ойлголт юм.¹⁸⁷ Амьжиргааны төвшинг нийгмийн хөгжил, үйлчилгээ хангамж, бичиг үсэг тайлагдсан байдал, анхан шатны сургуульд хамрагдалт, эрүүл мэндийн үйлчилгээ, орон сууц болон ундны усны болон эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламж зэрэг үзүүлэлтүүдтэй уялдуулан тодорхойлдог.

Манай улсад амьжиргааны доод төвшинг тогтоохдоо хөгжиж буй орнуудад ашигладаг аргыг хэрэглэдэг. Хэрэглээнд тулгуурлан амьжиргааны төвшинг тогтоодог. Монгол улсын засгийн газар 1991 оноос эхлэн хүн амын амьжиргааны төвшинг хот хөдөөд ялгаатай тогтоож, бараа үйлчилгээний үнэ тарифын өөрчлөлт, инфляцийн төвшинтэй уялдуулан шинэчлэн тогтоож байна.

Амьжиргааны баталгаажих доод төвшинг Үндэсний Статистикийн газраас 1991 оноос эхлэн хэрэглээний сагс, хэрэглээний үнийн өөрчлөлтөөр тодорхойлж ирсэн байна. 1991-1997 онуудад амьжиргааны төвшинг хөдөө хот гэж тогтоодог байсан бол 1997-2001 онуудад өрнөд, дорнод, өмнөд, дундад, төв гэж тогтоодог болсон. 2001 оноос өнөөдрийг хүртэл баруун бүс, хангайн бүс, төвийн бүс, зүүн бүс, Улаанбаатар гэж амьжиргааны төвшинг тогтоож байна.

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн үеэс өнөөг хүртэл нийгмийн хамгааллын тогтолцоог бүрдүүлэх, боловсронгуй болгох талаар шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлж, нийгмийн даатгалын сангаас болон төсвөөс багагүй хөрөнгө зарцуулж байна.

Ядуурлыг бууруулах бодлогын хэрэгжилт, түүний үр дагаварын өөрчлөлтийг дараах үе шатаар авч үзнэ. Тухайлбал ядууралтай тэмцэж эхэлсэн үе (1990-1993), хандивлагчийн идэвхитэй дэмжлэгийн үе (1994-2004), нийгмийн халамжийг нэмэгдүүлэн ажил эрхлэлтийг дэмжин ядуурлыг бууруулах бодлого хэрэгжиж ирсэн үе (2005-2008) гэж үечлэн үзэж болохоор байна.¹⁸⁸

1993 он хүртэлх бодлогын баримт бичигт ядуурал гэх ойлголтыг бага орлоготой иргэд гэсэн томъёогоор илэрхийлж байсан. 1993 оноос эхлэн бодлогын баримт бичигт ядуу, нэн ядуу гэсэн нэр томъёо тусгагдах болсон.

1990-1993 онуудад ядуурлыг бууруулахтай холбоотой Засгийн газраас 16 удаагийн шийдвэрийг гаргасан байна. Үүний 14 нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийг байнгын орлоготой болгоход чиглэгдсэн арга хэмжээ байсан байна. Гэвч 1992, 1993 онуудад дундаж бодит цалингийн хэмжээ 1991 оныхоос 50 хувиар буурсан нь ажил эрхлэлтийг дэмжих бодлогын арга хэмжээг няцаах үйлчлэл үзүүлсэн гэж үздэг.¹⁸⁹ 1990-1993 онуудад ядуурлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн бодлогын онцлог нь үндсэн хэрэгцээг хангах байсан.

1994 онд Монгол улсын засгийн газар, НҮБ-ын хүний хөгжлийн газартай хамтран ядуурлын учир шалтгаан түүний нөхцөл байдлын үнэлгээ хийсэн бөгөөд түүний үр дүнд тулгуурлан “Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг зургаан жилийн хугацаатай хэрэгжүүлж ядуурлыг төвшинг 26,5 хувиас 13,2 хувь болгон бууруулах зорилт тавьсан.¹⁹⁰

1994-2004 онуудад Үндэсний статистикийн газар хандивлагч орнуудтай хамтран хүн амын амьжиргааны судалгааг 1995, 1998 онуудад хийсэн ба Дэлхийн банктай хамтран 2000 онд ядуурлыг оролцооны аргаар үнэлэх нь судалгааг хийсэн. 1995 онд хийгдсэн ядуурлыг судалгаагаар нийгмийн эмзэг хэсэгт өндөр настан, хүүхэд, олон хүүхэдтэй гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүйчүүд гэж тодорхойлсон байна.

¹⁸⁶ Селит Жахан, Н.Батнасан, “Хүний хөгжил”, УБ хот, 2006

¹⁸⁷ Селит Жахан, Н.Батнасан, “Хүний хөгжил”, УБ хот, 2006

¹⁸⁸ Я.Бямбасүрэн, Ядуурлыг бууруулах төрийн бодлогын зарим асуудал, УБ хот, 2012, хуудас 115

¹⁸⁹ НҮБХХ, Монголын хүний хөгжлийн илтгэл 2007: Хөдөлмөр эрхлэлт, ядуурал, 2007, Мөнхийн үсэг ХХХ

¹⁹⁰ Я.Бямбасүрэн, Ядуурлыг бууруулах төрийн бодлогын зарим асуудал, УБ хот, 2012, хуудас 122


Нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн бодлогын чиглэлээр Засгийн газар нийгмийн эрэлт хэрэгцээг хангах зорилгоор нийгмийн даатгалын хуулийг 1994 онд батлан гаргаж 1997, 1999 онуудад өөрчлөлт оруулсан. Нийгмийн эмзэг хэсгийн амжиргааг дэмжиж зорилгоор 1995 онд нийгмийн халамжийн багц хуулийг батлан тэдэнд олгох халамжийн тэтгэвэр тэтгэмжийг байнга олгох нөхцлийг бүрдүүлж өгсөн.

1994-2004 онуудад хэрэгжүүлсэн ядуурлыг бууруулах төрийн бодлогыг хоёр чиглэлд хувааж үзэж болох юм. Үүнд:

1. Нийгмийн эмзэг хэсгийн амжиргааг дэмжих, нийгмийн халамж болон урьдчилан сэргийлэх нийгмийн даатгалын үйл ажиллагаа
2. Ядуу иргэдэд чиглэсэн төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа – төсөл хөтөлбөрөөс хамгийн өргөн хэрэгжсэн нь “Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр” байсан бөгөөд хөтөлбөрийг ерөнхий сайдаар ахлуулсан ядуурлыг бууруулах үндэсний хороо удирдан бүх аймаг, сум, дүүрэгт хэрэгжсэн. Төслийн хөрөнгө нь олон улсын хандивлагчдын хөрөнгөөс бүрдсэн. Төслийн хөрөнгийн томоохон хандивлагчид нь Дэлхийн банк (56,69%) Шведийн олон улсын хөгжлийн агентлаг (12,33%) НҮБХХ (9,02%) зэрэг олон улсын байгууллагууд юм.¹⁹¹


1994-2004 онуудад ядуурлыг бууруулах чиглэлээр нийт 66 төрлийн багц арга хэмжээг Засгийн газраас бие даан болон хандивлагч орнуудын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж, улс орныг бүхэлд нь хамарсан гурван удаагийн судалгааг хийж ядуурлын мөн чанар, нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлон тэдгээрт тулгуурлан бодлогын арга хэрэгслийг өөрчлөн ажилласан боловч төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.

Хүснэгт 1. Хүн амын ядуурлын төвшин



2008 оны сонгуульд намууд мөрийн хөтөлбөртөө ардчилсан нам иргэн бүрт 1 сая төгрөг, хүүхэд бүрт сар бүр 10000 төгрөг харин МАХН иргэн бүрт 1,5 сая төгрөг, шинэ төрсөн хүүхдийн мөнгөн тусламж 100 мянган төгрөг, шинэ гэр бүлд 500 мянган төгрөг зэргийг амласан. 2008, 2009 онуудад нийгмийн халамжийн сангийн зарлагад /Хүснэгт 2/ маш их нөлөө үзүүлсэн бөгөөд хүний хөгжил сангийн хишиг хувийг нийт өрх болон хүн амын 97 хувь нь хамрагдсан байна. Гэтэл тухайн онуудад ядуурал буураагүйг 2006-2010 оны оны үзүүлэлтээс харж болно /Хүснэгт 1/.


Хүснэгт 2. Нийгмийн халамжийн сангийн зарлага 2006-2012 он



¹⁹¹ МУЗГ, ЯБҮХ-ийн төгсгөлийн хураангуй тайлан 1994-2000, Адмон, 2001 он

1995 оноос хойшхи хугацаанд ядуурлын шугамаас доогуур амжиргаатай хүн амын эзлэх хувь 35 – 38 хувийн хооронд байсан бөгөөд ядуурал дорвитой буураагүй юм. Харин 2003 оноос эхлэн хөдөөгийн хүн амын дунд ядуурал газар авч, хөдөө амьдарч байгаа хоёр хүн тутмын нэг нь ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай байгааг хүснэгт 3 – аас харж болно.

Хүснэгт 3. Ядуурлын хамралтын хүрээ



2014 оны байдлаар хамгийн чинээлэг өрхөд ноогдох хэрэглээ ядуу өрхийнхөөс 8,3 дахин их байна.¹⁹² Энэ нь баян, ядуугийн хэрэглээний ялгаатай байдал ямар хол түвшинд хүрснийг илтгэж буй хэрэг юм.

Ядууралд ажилгүйдэл, мэргэжил, боловсрол, эрүүл мэнд, цалин хөлсний хэмжээ зэрэг голлох хүчин зүйлүүд нөлөөлж байна.

Хүснэгт 4. Ядуурлын хамралтын хүрээ. Боловсролын төвшингөөр /2014 оны байдлаар/

Д/д	Боловсролын төвшин	Хувь
1	Боловсролгүй	54,9
2	Бага	44,6
3	Бүрэн бус дунд	40,1
4	Бүрэн дунд	26,2
5	Техникийн буюу мэргэжлийн	22,1
6	Тусгай мэргэжлийн дунд	17,9
7	Дээд	9,8
8	Магистр	1,4

Хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт, нийлүүлэлтийн харьцаа алдагдсан энэ үед нэг нь ажлын байр хайгаад, нөгөө нь ажиллах хүч эрээд байгаа ч хөдөлмөр эрхлэлтийн тоо нэмэгдэхгүй байгаад дээд боловсролын сургалтын чанар, мэргэжлийн нийлүүлэлт нь ажил олгогч, олон нийтийн эрэлтэнд тохирохгүй байгаа мөн нийгэмд бэлэнчлэх сэтгэлгээ залхуу хойрго байдалтай холбон тайлбарлаж болох юм.

Ядуурлыг бууруулахын тулд түүн рүү чиглэсэн бодлого явуулснаар нийгмийн халамжийн үйлчилгээний ачааллыг бууруулж, ядуурлаас улбаатай нийгмийн бусад асуудлыг шийдэж чадна.

Ядуурлыг тодорхойлох гол шалгуур нь орлого юм. Ажлын байр байхгүй гэсэн шалтгаанаар ажилгүй гэртээ суудаг иргэд цөөнгүй байдаг. Үндэсний Статистикийн хорооны тоон мэдээлэл, Нийслэлийн хөдөлмөрийн газрын тоон мэдээнээс харахад аж ахуй нэгжээс ирсэн тоо бүртгэлтэй ажилгүй иргэдийн тооноос хоёр дахин их байна.

Хүснэгт 5.

Үндэсний Статистикийн Хороо	Нийслэлийн хөдөлмөрийн газар
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо	Аж ахуй нэгж байгууллагаас ирсэн ажлын байрны захиалгын тоо
31000 ⁴ мянга гаруй	62000 ⁵ мянга гаруй

Ажлын байрны тоо ажилгүй иргэдийн тооноос хоёр дахин их байхад яагаад ажилд орж чадахгүй байна вэ гэсэн асуулт гарч ирж байна. Нийт зарлагдсан ажлын байрны нийтлэг шалгуурт ажилласан жилийн туршлага, боловсролын төвшин, хэлний мэдлэг, техникийн мэдлэг, нас зэрэг үзүүлэлт байна.

¹⁹² Статистикийн Үндэсний Хороо, Тоон мэдээлэл, 2014 он

Дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нь ядуурлыг багасгахад нөлөө үзүүлнэ. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед цалин хөлс, ажлын байрыг таван жилийн төлөвлөгөөгөөр тодорхойлогдсон эрэлт нийлүүлэлтийн дагуу тогтоож байсан ба энэ үед ажил эрхлэлтийн төвшин нийгэмд жигд байсан болохоор амьдралын төвшин ойролцоо байсан.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих явцад нийгмийн реформ хэрэгжүүлэх зорилт тавьсан. Түүний үр дүнд эерэг үр дүн гарсан боловч ядуурал, ажилгүйдэл, нийгмийн тэгш бус байдал, авилгалыг өөхшүүлэх явдал дагалдан гарсан.

Төрөөс баримтлах нийгмийн бодлогын гол зорилго нь иргэн бүрийг чинээлэг хангалуун амьдарч ажиллах бүх талын бололцоог нийгэм дэх янз бүрийн ашиг сонирхлыг нэгтгэх замаар бий болгох явдал юм. Хүн амын дунд тулгамдаж буй нийгэм өөрөө зохицуулж чадахааргүй, төрийн оролцоо зайлшгүй шаардлагатай салбар болохын хувьд төрийн бодлогын гол цөм гэж хэлж болно.

Гэвч нийгмийн хамгааллын арга хэмжээ нь нийгмийн хөгжлийг дэмжих, хүн амын ядуурлыг бууруулахад дорвитой хувь нэмэр оруулж чадахгүй байна. 2014 оны байдлаар ядуурлын төвшин 27,4% байгаа бөгөөд Монгол улсын мянганы хөгжлийн зорилтот төвшинг 2015 он гэхэд 18% хүртэл бууруулах зорилт тусгагдсан нь хэрэгжилтийн үр дүн удаашралтай байгааг харуулж байна.

Одоогийн нийгмийн халамжийн тогтолцоо нь хоёр дутагдалтай тал ажиглагдаж байна.

- Нийгмийн халамжийн тогтолцооны хамрах хүрээ нь хангалтгүй, олон ядуу өрх халамжийн тэтгэмжийн гадна үлдэж байна.
- Нийгмийн халамжийн одоогийн тогтолцоо нь ядуурлыг нэмэгдүүлэх хандлагатай байна. Тэтгэмж тэтгэвэр авахын тулд ядуу, эмзэг бүлгийн гишүүн байх сонирхолтой хүний тоо өсөх хандлагатай байна.

Төрөөс ядуурлыг бууруулах талаар төсөл хөтөлбөр гарч байгаа боловч ядуурлаас гарах арга замыг ядуу хүмүүсээс гарах санал санаачлаган дээр үндэслэн хийвэл илүү үр дүнд хүрнэ. Тухайн нийгмийн давхаргад амьдарч байгаа иргэд тулгамдаж буй асуудлыг илүүтэйгээр хөндөж чадна. Иргэдийн санал санаачлаган дээр үндэслэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлбэл ядуурлын өнөөгийн төвшингөөс доошилж чадна. Харин энэхүү ажлыг төр зохион байгуулах хэрэгтэй.

Сүүлийн жилүүдэд ядуурлыг амжилттай бууруулсан орны тоонд Тайвань, Өмнөд Солонгос, Хонгконг, Сингапур зэрэг улсууд орж байна. 1965 онд БНСУ – ын ядуурлын хэмжээ 41,4% байсан бол 2004 онд 1-2% болгож бууруулж чадсан. БНСУ – д ядууст олгох тэтгэмжийг зөвхөн ажиллах чадваргүй иргэдэд олгож эхэлсэн. “Эхлээд өсөлт, дараа нь халамж” гэсэн уриатайгаар ядуурлыг бууруулах хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн нь өнөөдрийн төвшинд хүргэсэн байна.

Монголд нийгмийн халамж хавтгайрсан. Хөдөлмөр эрхлэх боломжтой иргэд тэтгэмжийн мөнгө авахын тулд ядуу, эмзэг бүлгийн гишүүн гэсэн нэрийг зүүж байна. Иймээс нийгмийн тэтгэмж авдаг иргэдийг үнэн зөв тогтоох, хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг ажил хийхийг уриалах зэрэг ажлыг эхлүүлбэл ядуурлын төвшинг бууруулж чадна.

НОМ ЗҮЙ

1. Н.Наранчимэг, П.Увш, Н.А.Волгин “Нийгмийн бодлого” УБ 2009 он
2. Г.Түмэннаст “Жам ёсны тусламжаас нийгмийн хамгаалалт ертөнц өөд” УБ 2009 он
3. Г.Түмэннаст “Нийгмийн хамгааллын харьцуулсан судалгааны арга зүй” Политологи VI УБ 2010 он
4. Г.Түмэннаст “Нийгмийн хамгаалалт төрийн судалгааны онол арга зүйн зарим асуудал” Политологи V УБ 2009 он
5. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол практик /Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл/ УБ 2009 он
6. Ч.Дагвадорж “Нийгмийн хамгаалал: онол, арга зүй, туршлага харьцуулалт удирдлага” УБ 2003 он
7. П.Бямбацэрэн, Ч.Дагвадорж “Нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлууд” УБ 2000 он
8. Г.Оюунчимэг, Ч.Дагвадорж “Нийгмийн халамжийн удирдлага” УБ 2003 он
9. Д.Дашпүрэв “Монголын нийгмийн өөрчлөлт шинэчлэлтийн үе шатууд” УБ 2005 он
10. Үндэсний Статистикийн Төв газар “Монгол улс дахь ядуурлын дүр төрх – өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны 2007 – 2008 оны үр дүн” УБ 2009 он
11. Үндэсний Статистикийн Төв газар “Өрхийн орлого, зарлага, амжиргааны түвшний түүвэр судалгааны үндсэн тайлан 2002 – 2003 он” УБ 2010 он
12. Үндэсний Статистикийн Хороо “Макро эдийн засгийн болон аж байдлын үзүүлэлтээр хийсэн хүчин зүйлийн судалгаа” УБ 2010 он
13. Я.Бямбасүрэн, П.Доржсүрэн “Төрийн бодлого” УБ 2006 он
14. Янг Е, Квин Л “Үр нөлөө бүхий бодлогын баримт бичиг боловсруулах нь” УБ 2002 он
15. “Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам” 2013 оны жилийн эцсийн тайлан
16. “Бодлогын судалгаа шинжилгээ” судалгааны эмхэтгэл XI боть
17. “Бодлогын судалгаа шинжилгээ” судалгааны эмхэтгэл VIII боть
18. Сычева. В.С “Определение и измерение бедности история вопроса” 1996 года
19. Я.Бямбасүрэн, Ядуурлыг бууруулах төрийн бодлогын зарим асуудал, УБ хот, 2012

ЭРДЭС БАЯЛГИЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭЖ БАЙГАА СУДАЛГААНЫ БОЛОН ПРАКТИК АЖЛУУДЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Ч.ӨЛЗИЙСАЙХАН

Доктор, дэд профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,

Улс төр судлалын тэнхим

С.МӨНХГЭРЭЛ

Улс төр судлалын тэнхимийн магистрант

Түлхүүр үг: Эрдэс баялаг, ашигт малтмал, уул уурхай, төрийн бодлого, хамтын ажиллагаа

Товч Агуулга: Монгол улс дахь эрдэс баялгийг зохистой ашиглах талаар төрөөс баримтлах бодлого, түүнийг сайжруулах чиглэлд төр болон иргэний нийгэм, олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, судалгааны талаар өгүүлнэ. Энэхүү судалгааны ажилд Монгол Улсын эрдэс баялгийн нөөцийг зохистой ашиглах талаар төрөөс баримтлах бодлого, түүнийг сайжруулах чиглэлд төр болон иргэний нийгэм, олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, судалгааг тоймлон өгүүлнэ. Юуны өмнө одоо мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, бодлого, судалгааны ажлуудыг нэгтгэж гаргасан. Эрдэс баялгийн талаарх төрийн бодлогын тухай гадаад дотоодын шинжээч болон бусад талуудын дүгнэлтийг нэгтгэн гаргахыг хичээсэн ба тэдний байр суурийн зөрөөтэй байдал нь асуудалд хандахад ихээхэн өөр өөр дүгнэлт, чиглэл зөвөлгөө өгч байдгийг харуулахыг хичээлээ. Эрдэс баялгийн талаарх төрийн бодлогыг сайжруулах арга зам, гарцыг эрж хайх оролдлого хийсэн болно.

Abstract: This research paper describes an overview of government policies of Mongolian mineral resources proper use and for its improvement civil society participation, policies, activities, and study that implementing from international organizations will be described. First of all, research papers of current laws, rules, regulations and policies are integrated here.

The study tries to consolidate the findings of domestic and foreign experts or alternative stakeholders on state policies for mineral resources, and on basis of their divergent views gives very different conclusion, or recommendation. It attempts to find ways and outputs to improve state policies on mineral resources.

Агуулга:

1. Одоо мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, бодлого, судалгааны ажлуудын тойм
2. Эрдэс баялгийн талаарх төрийн бодлогын тухай шинжээч болон бусад талуудын дүгнэлт
3. Бодлогыг сайжруулах арга зам, гарц, шинжээчдийн зөвлөмж

Монгол Улсад уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж эхэлсэн 1990 оноос хойш эрдэс баялгийг зүй зохистой, үр ашигтай ашиглах төрийн бодлогыг сайжруулах чиглэлд төрийн болон төрийн бус байгууллагуудын хийсэн судалгааны дараах бүтээлүүд байна.

1. Олборлох салбар дахь гэрээний ил тод байдал-гэрээг ил болгох үндэслэл, үр ашиг, арга зам, А.Батпүрэв, 2013, Нээлттэй Нийгэм Форум.
2. Уул уурхайн салбарын бодлогын зарим асуудлууд, 2009, Нээлттэй Нийгэм Форум.
3. Гадаад орнуудын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн судалгаа, Б.Батхишиг, 2015
4. ОУИТБС–ын Шинэ стандартыг Монголд хэрэгжүүлэх нь: Харьцуулсан үнэлгээ, зөвлөмж, 2014, Нээлттэй Нийгэм Форум.
5. Таван Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаарх санал зөвлөмж, Нээлттэй Нийгэм Форум, 2015
6. Уул уурхай, байгаль орчин, хүний эрх, Нээлттэй Нийгэм Форум, 2015
7. Оюутолгой ХХК-ийн засаглалын үнэлгээ, Д.Байлхүү, 2014
8. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын засаглалын үнэлгээ, Д. Байлхүү, Л. Болормаа, 2014

9. Орлогын Ажиглагч Индекс: Ил тод байдал: Засгийн газрууд ба газрын тос, байгалийн хий, уул уурхайн үйлдвэрлэл, Орлогын Ажиглагч Институт, Транспэрэнси Интернэшнл, 2011”
10. Уул уурхайн орлогын менежментийн макро бодлого ба институциональ тогтолцоо, Ц.Батсүх, А.Батпүрэв, Д.Ганбат, 2010
11. Тавантолгойн Нүүрсний ордыг ашиглах Засгийн газрын саналын талаарх шүүмж, Н.Дорждарь, 2010
12. Уул уурхайн салбарын бодлогын зарим асуудлууд, Жозеф Бэлл, Роберт Конрад, Карин Лиссакерс, ННФ, 2009
13. Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачилга: Олон Улсын зөвлөх бүлгийн тайлан, Нээлттэй Нийгэм Форум, Орч: Г.Батбаяр, 2006
14. Монголд эрдсийн сан байгуулах шаардлага, арга зам, Г.Цогтсайхан, 2006
15. ОУИТБС-д анхаарлаа хандуулъя, Орлогын Ажиглагч Институт, Төлснөө нийтэл компани, 2006
16. Уурхайн хаалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь, С.Цэдэндорж, Ж.Бямба-Юу, М.Дагва нар, 2010
17. Уул уурхайн орлогын менежментийн макро бодлого ба институциональ тогтолцоо, Ц.Батсүх, А.Батпүрэв, Д.Ганбат нар, 2010
18. АНУ-ын Аляскийн байнгын сангийн тухай танилцуулга, 2008
19. Оюу толгойн гэрээ байгуулахад анхаарах зүйлс сэдэвт нээлттэй ярилцлага, 2007
20. Төрийн ил тод байдал : Нийгмийн баялгийн хуваарилалт Форум, 2006
21. Уул уурхайн татварын асуудал, тогтвортой байдлын гэрээ, Айвенхоу Майнзын орд ашиглалтын төлөвлөгөө, 2006
22. Гар аргаар олборлолтын улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх нь, ADB, 2013
23. Хамтран ажиллацгаая гарын авлага- Уул уурхайн компани, бичил уурхай эрхлэгчидтэй хамтран ажиллах тухай, ADB, 2012
24. Жилийн тайлан, ННФ, 2013
25. Гүн өрөмдөж үзэхүй-Олборлох үйлдвэрлэлийн орлого, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга /ОУИТБС/-ын тухай иргэний нийгмийн гарын авлага, орч-Г.Батбаяр, 2009
26. Адагт үлдсэн тэрбум, Пол Коллиер, 2009
27. Сүйрэл: Мөхөж устах, мандан бадрахаа нийгэм хэрхэн сонгодог тухай, Жэред Даймонд, 2008
28. Монгол Улсын ашигт малтмалын ордыг үр ашигтай ашиглах асуудалд, Д.Содном, 2007
29. Шударга ёс тогтооцгооё: Алтны үнэ өртгийг тооцох нь, Орч. Г.Батбаяр, 2007
30. Монголын байгаль орчны тухай хууль тогтоомжуудын үнэлгээ, 2008
31. Монгол орны ашигт малтмалыг үр ашигтай ашиглах асуудалд, 2007,
32. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл явц дахь иргэдийн оролцоо, 2008,
33. Монгол улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2011 оны тайлан эмхтгэл, 2012,
34. Газрын тос, болон эрдэс баялгийн татварын харилцаа: зарчим, сорилт, нөхцөл байдал, 2009

Эрдэс баялгийн салбар дахь судалгаа шинжилгээ чамлахааргүй их хийгдсэнийг дээрх судалгааны бүтээлүүдээс харж болно. Гэвч судалгаа, шинжилгээний ажлууд, шинжээчдийн зөвлөмж, санал боломжийн хэмжээнд байсаар байхад яагаад эрдэс баялгийн салбар нийгмийн зүгээс хамгийн их шүүмжлэл дагуулсан, бодлого муутай, нийгэмд өгч байгаа үр ашиг хангалтгүй, улс орныг өрийн хямралд оруулсан салбар болов гэдэг нь анхаарал татсан асуудал болж байна. Иймд эдгээр бүтээл, судалгааны ажлуудыг төрийн бодлого шийдвэрт хэрхэн тусгаж вэ, судалгаа хэр үр өгөөжтэй байсан бэ, судалгааны ажлууд улс орны хөгжлийн гарцыг зөв зааж чадах уу гэх мэт олон асуудлыг анхаарч үзэхийг шаардаж байна.

Одоо мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, бодлогын баримт бичгүүд

Эрдэс баялаг ашиглах, олборлох, бодлого зохицуулах чиглэлээр дараахь хууль эрх зүйн баримт бичгүүд батлагдан гарсан байна.

1. Монгол улсын үндсэн хууль, 1992
2. Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал, 2010
3. Ашигт малтмалын тухай хууль, 2015
4. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, 2014
5. Ирээдүйн өв сангийн тухай хууль, 2014
6. Газрын тосны тухай хууль, 2014
7. “Стратегийн ордуудыг ашиглах тухай,
8. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”2014

9. Аюулгүйн Бүс Тогтоох Журам Батлах Тухай, 2009, Сайдын Тушаал
10. Дүрэм Батлах Тухай, 2000, /Ил Уурхайн Аюулгүй Ажиллагааны Нийтлэг Дүрэм/
11. Журам Батлах Тухай, 2013, /Газрын Тосны Бүтээгдэхүүний Тусгай Зөвшөөрлийн Журам/ Сайдын Тушаал
12. Журам Батлах Тухай, 2015, “Газрын Тос, Уламжлалт Бус Газрын Тосны Чиглэлээр Мэргэжлийн Зэрэг Олгох” /Сайдын Тушаал/
13. Журам Батлах Тухай, 2015, /Газрын Тос, Уламжлалт Бус Газрын Тосны Тайланд Тавигдах Шаардлага/ Сайдын Тушаал
14. Журам Батлах Тухай, 2005, /Төсвийн Хөрөнгөөр Илрүүлсэн Эрдсийн Хуримтлал Бүхий Хайгуулын Талбайн Лицензийг Дуудлага Худалдаагаар Олгох Тухай Журам, /Сайдын Тушаал/
15. Журам Батлах Тухай, 2015, /Тусгай Зөвшөөрөл Олгох Сонгон Шалгаруулалтын/ Сайдын Тушаал/
16. Журам Батлах Тухай, 2015, /Шинжээчийн Эрх Олгох Асуудлыг Мэргэжлийн Төрийн Бус Байгууллагаар Гүйцэтгүүлэх/ Сайдын Тушаал
17. Журам Шинэчлэн Батлах Тухай, 2006, /Улсын Төсвийн Хөрөнгөөр Гүйцэтгэх Геологийн Судалгааны Ажлыг Санхүүжүүлэх/ Сайдын Тушаал
18. Журмууд Батлах Тухай, 2006, / Улсын Төсвийн Хөрөнгөөр Гүйцэтгэх Геологийн Судалгааны Ажлыг Төлөвлөх, Санхүүжүүлэх, Хэрэгжилтэд Хяналт Тавих, /Сайдын Тушаал/
19. “ Эдийн Засгийн Ил Тод Байдлыг Дэмжих Тухай” хууль, 2015
20. “Байгаль Орчныг Хамгаалах Тухай”, хууль, 1995
21. Гол, Мөрний Урсац Бүрэлдэх Эх, Усны Сан Бүхий Газрын Хамгаалалтын Бүс, Ойн Сан Бүхий Газарт Ашигт Малтмал Хайх, Ашиглахыг Хориглох Тухай, 2009
22. “Байгалийн Нөөц Ашигласны Төлбөрийн Тухай” хууль, 2012
23. “Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Үнэлгээний Тухай” хууль, 2012

зэрэг ашигт малтмалтай холбогдсон хууль, журмууд болон байгаль орчинтой холбогдох хуулиуд хэрэгжиж, хуулийн хэрэгжилтийн талаарх мониторинг, шинжилгээний ажлууд мөн хийгдэж байна.

Уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг 2012 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл: Бүрэн биелсэн 39, хэрэгжих шатандаа 41, үүнээс 90 хувьтай 12 заалт, 70 хувьтай 10 заалт, 50 хувьтай 11 заалт, 30 хувьтай 70 заалт, 10 хувьтай 1 заалт, хугацаа болоогүй 1 заалт, биелэлт ерөнхий дүнгээрээ 86 хувьтай байна.¹⁹³

Эрдэс баялгийн талаарх төрийн бодлогын тухай шинжээч болон судалгааны байгууллагуудын дүгнэлтийн тойм

Эрдэс баялгийн салбарын дэлхийн нийтийн болон монгол улсын өнөөгийн байдлын талаар манай улсын болон гадаадын шинжээчид дараах дүгнэлтүүдийг хийсэн байна.

Байгалийн Нөөц, Баялгийг Удирдахад Чадавхыг Бэхжүүлэх ОУВС-ийн “Итгэлцлийн Сан”: “Эрдэс баялаг ихтэй хөгжиж буй орнуудын ихэнх нь байгалийн нөөц, баялгийнхаа нөөц бололцоо, чадавхыг бүрэн ашиглаж мэддэггүйгээс хөгжиж чаддаггүй. Энэ нь голдуу газрын тос, хий, ашигт малтмалын баялагтай орнуудад тохиолддог. “Баялгийн хараал” гэж нэрлэдэг тухайн орнуудын удирдлагууд байгалийн нөөц, баялгаас урган гардаг институц, бодлогын асуудлуудыг шийдвэрлэхэд гаргадаг алдаа юм. Тухайн улсын удирдлага сул, холбогдох хууль, тогтоомжууд алдаатай, бодлого хангалттай бус байдаг. Удирдлагууд голдуу томоохон, олон улсын Олборлох Үйлдвэрийн компаниудтай хангалттай бус зохион байгуулалтын үндсэн дээр хамтран ажилладаг. Мөн ихэвчлэн засаглалын орчин бүрэн төгөлдөр бус, байгалийн нөөц, баялагтай холбоотой асуудлуудыг нууцаар шийдвэрлэх хандлагатай байдаг”¹⁹⁴ гэжээ. Үнэхээр өнөөг хүртэл ашигт малтмалыг олборлох, борлуулах тал дээр Монгол Улс оносоноосоо алдсан нь их байж мэдэх юм. Ихэнх баялгаа ашиглаж хөгжиж чадсан улс орнуудын баримталдаг бодлогоос ихээхэн өөр, харин хөгжлөөр ихэд хоцрогдсон байгалийн баялаг ихтэй улс орнуудтай төстэй гэж хэлж болохуйц төрийн удирдлагатай, хариуцлага тооцох механизм сул, хууль тогтоомжууд нь улс оронд ашиг өгөхөөргүй зохицуулалттай, бодлогогүй, байсан ч олон улсын жишгээр гэж авч байгаа бодлогууд нь ядуу дорой улс орнуудын бодлоготой адил төстэй, баялгаа хэрхэн ашиглах гэж байгаа талаарх төрийн бодлого гэрээ хэлэлцээрүүдээ нууц байдалд байлгаж байгаад гэнэт тохирч гарын үсэг зурж ингэснээр гэрээ хэлэлцээрийг засах гэхээр улс орон ихээхэн хэмжээний өрөнд орохуйцаар тохиролцсон байдаг зэрэг алдаа дутагдлууд их байна.

“Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилга” нь дэлхийн 48 улсад мөрддөг олон улсын санаачилгаар үйл ажиллагаагаа явуулдаг байгууллага юм. Энэ байгууллагад Монгол Улс нэгдэн орсоор өдгөө найман жил болж байгаа юм. Гэсэн хэдий ч Монголд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниуд олборлох үйлдвэрлэлийн стандартаа мөрдөх явдал харилцан адилгүй байна. “Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилга” байгууллагын тэргүүн Клейр Шорт: “Уул уурхай тогтвортой салбар биш. Гэхдээ тогтвортой хөгжилд хүрэхэд уул уурхайг ашиглаж болно. 2013 онд Сидней хотод ОУИТБС-ын 6 дугаар бага хурлын үеэр тусгай зөвшөөрлийг ил тод болгох асуудал хүчтэй яригдсан. Монголд ч мөн адил энэ санаачилга явж байгаа. НҮБ-ийн конвенцийн дагуу нутгийн иргэд уугуул иргэдийнхээ зөвшөөрлийг бүрэн авсан байх ёстой

¹⁹³ <http://www.mm.gov.mn/infos/view/36>

¹⁹⁴ <http://www.iltod.gov.mn/?p=1858>

байдаг. Гэтэл Монгол Улсын хувьд иргэд нь уугуул гэдгийг хэрхэн тодорхойлохыг мэдэхгүй байна”¹⁹⁵ гэж тэмдэглэжээ.

Гадаад улс орнуудын байгууллага, судлаачид төдийгүй Монгол улсын эрдэмтэн судлаачид ч улс орныхоо байгалийн баялаг ашиглах бодлогод сэтгэл хангалуун бус байна. Дэлхийн олон улс орны түүхээс харвал байгалийн баялгаас хараат байх тусам эдийн засгийн өсөлт нь сул, олон тохиолдолд бүр агшиж байдаг. Байгалийн баялгаас хараат байна гэдэг нь анхдагч бус, Засгийн Газрынх нь арчаагүй бодлого анхдагч юм. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн бодлого буруу үед олборлох салбараас нь өөр ямар ч салбар оршин тогтнох боломжгүй гэж үздэг... Институцүүдийн чадавхи дорой нөхцөлд байгалийн баялаг өрийн хямралд хүргэх нь олонтаа. Мексик, Нигери, Венесуэлийн 80 аад оны жишээнээс бид үүнийг харж болно. Нөөцийн олон улсын зах зээл дээрх үнэ бага зэрэг буурахад л нөөцөөс хараат Засгийн газрууд зардлаа танах хэрэгтэй болдог. Гэвч популист бус алхам хийгдэх боломжгүй нөхцөлд энэ нь ихэнх тохиолдолд гаднаас зээл авах замаар санхүүжигддэг. МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор Б.Эрдэнэбат: “Уул санаа нь нэгэнт л байгалийн баялаг байгаа юм чинь түүнийгээ барьцаалж олон улсын санхүүгийн байгууллагууд, зах зээл дээрээс зээл аваад түүнийгээ дэд бүтэц, хөрөнгө оруулалтад зарцуулах. Зээлдүүлэгчдийн зүгээс муу юм болоход баялгаа зараад зээлээ төлчихнө гэсэн үндэслэлээр байгалийн баялаггүй улсуудтай харьцуулахад илүү зээл олгох сонирхолтой байдаг. Харамсалтай нь, нэг талаас хэдий хэмжээний зээл, ямар хүүтэйгээр авч, хэр үр ашигтай захиран зарцуулагдаж буйг нь хянаад, удирдаад явах чадалтай институцүүд байдаггүй”¹⁹⁶ гэж тэмдэглэжээ.

Уул уурхай, эрдэс баялгийн салбарын үйл ажиллагааг иргэд болон ТББ-ууд ихээхэн шүүмжилсээр байна. Тэд ерөөсөө энэ салбарыг хөгжүүлэхийг эсэргүүцээд байгаа биш харин үр өгөөжгүй гэрээ хэлэлцээр хийх, хяналт шалгалт хийх боломжгүйгээр олборлолт явуулахыг эсэргүүцдэг. Гэтэл тэдний үйл ажиллагааг нийгэмд зориуд өөр утга агуулгатайгаар таниулах зохион байгуулалттай үйл ажиллагаа байдаг мэт сэтгэгдэл төрөхөөр байдаг. “Хариуцлагатай Уул Уурхайн санаачилга” ТББ-ын тэргүүн доктор Л.Долгормаа: “Монгол Улсад төдийгүй дэлхий нийтийн анхаарлыг татсан томоохон нөөцтэй ордууд илэрч байгаа. Бид байгалийн баялгийг ашиглахыг зүйтэй гэж үзэж байгаа юм. Гэхдээ гол нь зохистой хуулийн дагуу ашиглах ёстой. Үүний тулд хууль байх шаардлагатай. Хуулийн үндсэн зохицуулах асуудал бол тайлан, татварын асуудлыг ил тод болгох юм. Сүүлийн жилүүдэд манайд том жижиг, үндэсний болон гадны хөрөнгө оруулалттай олон үйлдвэр олборлолт явуулж байна. Гэтэл эдгээрийн үйл ажиллагаа ялангуяа төлбөр, хураамжийн төлөлтийн тодорхой бус байдал байсаар байна. Энэ асуудлаас болоод өнөөдөр зарим томоохон төслийн үйл ажиллагаа удааширч цаг алдах, ойлголцохгүй байх үүний үр дүнд эдийн засгийн үр ашиг алдагдах гэх мэт олон сөрөг нөлөөлөл гарч л байна...Сүүлийн үед эрдэс баялгийн салбарын ил тод биш байдал нь авлигатай байна гэсэн хардлагыг төрүүлж байна. Ийм сөрөг хандлагаас үүдээд компаниуд болон нутгийн иргэдийн хоорондын зөрчил ихсэж байгаа”.¹⁹⁷ Уул уурхай, эрдэс баялгийн салбар төрийн бодлого сул дорой, ард нийтийн эрх ашигт нийцээгүй шийдвэр гаргах явдал үргэлжийн, ердийн зүйл болсоор байгаагийн улмаас төр засагт итгэх тэдний итгэл өдрөс өдөрт улам муудсаар байна. Ард нийтийн итгэл ийм доогуур байгаа нь үндэсний аюулгүй байдалд ч заналхийлж болохуйц үр хөврөлийг агуулж байж болохыг анхаарах ёстой билээ.

Улс орны хэмжээнд нэгдсэн нэг зөв бодлого мөрдөгдөхгүй байгаагаас нийгмийн хөгжлийг урагш ахиулах энэ салбар төлөвлөлт, зохион байгуулалт, хуваарилалтын хувьд хамгийн зохисгүй хувилбартай байгаа бөгөөд нэгэнт байдал ийм учраас улс төрчид нь энэ байдалд тоглолт хийж өөрсдөө байр сууриа бэхжүүлэх, гэхдээ эцсийн дүнд байдал сайжирсан зүйл огтхон ч үгүй үргэлжилдэг нь хэвшмэл зүйл болжээ. Энэ салбар хэт задгай, эзэнгүй, зөвшөөрөл лиценз нь хяналтгүй болсон учраас зарим үед бүгдийг нь хааж хорьдог болсон бөгөөд энэ нь ч эргээд байдлыг сайжруулсан зүйлгүй, хэсэг хугацааны дараа дахиад л бахь байдгаараа үргэлжлэх болжээ. Эдийн засагч Д.Жаргалсайхан: “Улс төрийн ийм тогтворгүй байдал, төрийн бодлого сул байгаагаас баялагын салбар дахь тогтвортой байдлыг мөн алдагдуулдаг..Байгалийн баялаг олборлосны хураамжийг (royalty) орон даяар жигдрүүлэхгүй бол бүх аймаг зөвхөн газраа ухааж, уул уурхайг л хөгжүүлэх хандлагатай болжээ. Хөвсгөл аймгийнхан Өмнөговийн тэр хураамжийн тодорхой хэсгийг авдаг бол заавал Далай ээжийн эрэг дээрх Бүрэнхаан уулаа нурааж, фосфор авна гэхгүй байхсан. Улс орныхоо хаана нь, хэзээ, юугаа хөгжүүлэхээ удирдаад явж чадахгүй болж байна”¹⁹⁸ гэж тэмдэглэжээ.

Уул уурхайтай ойр байгаа төдийгүй нийт иргэд энэ салбар, нэгжүүдийн талаарх мэдээллийг авахыг үргэлж хүсдэг. Тэхдээ ерөнхий мэдээлэл биш нарийвчилсан, татвар хураамж, эзэд, аюулгүй байдал гэх мэт зүйлсийг мэдэхийг хүсч байдаг. Гэтэл манайд энэ мэдээллүүд бүгд хаалттай. Тэр ч байтугай томоохон гэрээ хэлэлцээрүүд ч жирийн иргэд байтугай УИХ-ын гишүүдэд ч мэдэгдэхгүйгээр хийгдэж байх жишээтэй. Ил тод уул уурхайн тухай ярьдаг ч энэ нь яриа төдий л байгаа, олон жил ийм байсан цаашид ч ярьсаар байх нь эргэлзээгүй, харин ажил хэрэг болох нь тодорхойгүй юм. Учир нь үүнийг ил тод, хариуцлагатай болгох төрийн тогтолцоо хангалтгүй, тиймээс энэ харилцааг сайтар зохицуулсан хууль эрхзүйн орчин бүрдэх нь ихээхэн бүрхэг юм. Зөвхөн компаниас засгийн газарт өгч байгаа мөнгийг ил болголоо гээд салбар тэр чигтээ ил болж чадахгүй юм. Орлогын ажиглагч хүрээлэнгийн Монгол Улс дахь зохицуулагч Н.Дорждарь: “төлсөн татвар нь үнэхээр төлөх ёстой хэмжээндээ байна уу, татвар төлсөн хэдий ч байгаль орчинд томоохон хохирол учруулаад байвал тэр тухай мэдээлэл байна уу гээд олон асуудал бий. Мөн компанийн жинхэнэ эздийн тухай асуудал байна. Орон нутагт малчид амьжиргаагаа залгуулж байтал хажууд нь уурхай

¹⁹⁵ <http://www.eitimongolia.mn/mn/interviews-and-publications>

¹⁹⁶ <http://www.tsahimurtuu.mn/index.php/stories/2012-05-10-04-50-09/1756-archive-story-1575>

¹⁹⁷ <http://vip76.mn/content/35174>

¹⁹⁸ <http://jargaldefacto.com/%D0%BC%D1%8E%D0%BD%D0%B8%D1%81/#sthash.olmIMBxN.dpufYul>

баригдаад амьдралд нь нөлөөлөөд эхлэхээр яах вэ. Асуудал гарвал, өөрт тохиолдож буй зовлон бэрхшээлийг компанийн хэнтэй нь ярих вэ, худаг, ус бэлчээрийн асуудлаа компанийн эзэнтэй ярьж ойлголцож шийдмээр байна шүү дээ. Ялангуяа байгалийн баялаг, нийтийн өмчийг ашиглаж байгаа хүмүүсийн мэдээлэл ил тод байх нь зайлшгүй хэрэг. Энэ нь Улсын их хурлын гишүүд олны итгэлийг хүлээж, олны нэрийн өмнөөс, татварын мөнгийг зарцуулах шийдвэр гаргадагтай яг ижилхэн. Тиймээс ч улс байгаа. Үүний нэгэн адилаар газрын хэвлийд байгаа баялгийг ашиглагчид яагаад нууц байх ёстой гэж¹⁹⁹ өгүүлжээ.

Газрын хэвлийн баялгийг ашиглах тал дээр иргэд, судлаачид, ТББ-ынхан аль нь ч сэтгэл хангалуун биш байгаа болох нь харагдаж байна. Харин зөвхөн шийдвэр гаргасан эрхмүүд л сэтгэл хангалуун байгааг хэрхэн ойлгох вэ. Асуудал үр ашигтай шийдэгдсэн үү, үгүй юу гэдэг нь бодит үр дүнгээр л харагдах ёстой. Гэтэл ард иргэдийн амьдрал дээрдсэн нь үгүй, улс орон ч хөгжиж дэвжсэн нь үгүй, нийгэм баян, ядуу гэсэн хоёр хэсэг рүү улам туйлшран хуваагдаж байгаа нь ямар ч гэсэн улс орны хувь заяаг шийдэх ёстой энэ гол салбарт ихээхэн асуудал нуугдаж байгааг л харуулна.

Бодлогыг сайжруулах арга зам, гарц, шинжээчдийн зөвлөмжийн талаарх дүгнэлт

Эрдэс баялагийг ашиглах талаархи төрийн бодлогыг сайжруулахын тулд дараахь үндсэн чиглэлд анхаарах ёстой. Үүнд:

1. Хяналт мониторингийн чиглэлд үр ашигтай ажиллаж чадахуйц бүтэц зохион байгуулалттай мэргэжлийн байгууллагууд бий болгож ажиллуулах
2. Өнөөг хүртэл бие даасан хөндлөнгийн байгууллагууд, шинжээчдээс гаргасан зөвлөмж, саналыг төрийн бодлого шийдвэрт тусгах ажил их хоцрогдсон, үр нөлөөтэй судлаачдын хэлэлцүүлгийн явцад хамгийн оновчтой хувилбарыг сонгох явдал ихээхэн дутагдалтай байгааг засч, сайжруулах
3. Эрдэс баялгийн салбар дахь хууль, эрх зүйн зохицуулалт муу байгаагаас энэ салбар нь улс орны эдийн засгийг хөгжүүлэхэд дорвитой өөрчлөлт өгч чадахгүй, ойрын ирээдүйд ч өгөх ашиг тус нь нийт олборлож байгаа эрдэс баялагтай харьцуулахад муу байгааг засч эрх зүйн орчноо нэн яаралтай сайжруулах
4. Гадны орнуудын алдсан болон оносон туршлагыг аль алиныг нь харьцуулан судалж, баялагтай холбогдсон интитуцийн чадавхийг сайжруулах

Мэргэжлийн байгууллагуудын хяналт болон мониторингийн ажлуудад шинжилгээ хийж харвал ихээхэн сонин дүр зураг ажиглагдах болно. Юуны өмнө гадаад орнуудаас санхүүжилт авдаг байгууллага, нийгэмлэгүүд энэхүү судалгаа мониторинг хийж харин Монгол улсын талаас санхүүжүүлж ажилласан ийм чиглэлийн ажил тун бага байна. Нөгөө талаас судалгааны ажлууд нь санхүүг ил болгох, орон нутаг болон улсын төсөвт өгөх мөнгийг зохицуулах, хянах, нэгэнт байгуулсан гэрээ хэлэлцээрийг баталгаатай, тогтвортой байлгах, засаглалыг тогтвортой байлгах талын үзүүлэлтүүд дээр л ихээхэн судалгаа хийсэн байх боловч энэхүү гэрээ хэлэлцээрийн бодлогын зөв буруу эсэх дээр шинжилгээ хийсэн зүйлүүд ажиглагдахгүй байгааг анзаарч болно.

Тухайлбал, АНУ-ын тэрбумтан Жорж Соросын санхүүжилттэй Нээлттэй нийгэм форум энэ чиглэлд хамгийн өргөн цар хүрээтэй ажлууд хийж байна. Олборлох салбарын орлогыг хянах интитуцийн тогтолцоог бүрдүүлэх эрхзүйн орчныг сайжруулах, бодит амьдралд уг тогтолцооны хэрэгжилтийг хангахад тус салбарын орлогод хяналт тавих шалгуур, үзүүлэлтүүдийг тодорхойлох нь нэн чухал ач холбогдолтой гэж үг хүрээлэнгээс хийсэн шинжилгээнд дурдсан байна. Харин АНУ-д төвтэй Орлогын ажиглагч хүрээлэнгийн боловсруулсан аргачлалын дагуу Монгол Улсын орлогын менежментийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг гаргаж, цаашид тогтмол мониторинг хийхэд ашиглахад бэлэн болгоод байгааг дурдсан байна. Уг нь энэ ажлыг Монгол Улсын засгийн газар өөрөө илүү анхаарч өөрсдийн боловсруулсан аргачлалын дагуу Монгол Улсын орлогын менежментийг гаргах нь илүү зохистой юм. АНУ-ын Орлогыг ажиглагч хүрээлэнгийн аргачиллаар улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, өр зээлийн хэмжээнд тавигдах хязгаарыг хянах, түүнчлэн уул уурхайн орлоготой ямар нэгэн байдлаар уялдаагүй бүрддэг буюу зарцуулагддаг Тогтворжилтын сан, Хөгжлийн сан, Хөгжлийн банк зэрэг бүтцийн хувьд суурь үзүүлэлтүүдийг цуглуулсан байна. Энэ асуудал бол өөр нэг улсын байгууллага бүх тоон үзүүлэлтийг хянаж, зааварчилж байх ёстой бус харин Монгол Улс өөрөө үүнд анализ хийж хэрхэн яаж зарцуулах, хэрхэн яаж бодлого явуулахаа шийдэх нь илүү зохистой юм. Нээлттэй нийгэм хүрээлэнгээс санал болгож байгаа зөвлөмж нь эдгээр суурь үзүүлэлтийг шинэчлэх, тухайлбал орон нутгийн төсөвт хуваарилагдах уул уурхайн орлогын зохицуулалттай холбоотой өөрчлөлт оруулах зэрэг ажлыг 2013 онд үргэлжлүүлэн хийхээр төлөвлөсөн байх ажээ. Үнэхээр манай улсын засгийн газраас уул уурхайн салбараас орж ирэх орлогыг орон нутагт түлхүүг хуваарилах чиглэлд энэ зөвлөмжийн дагуу хийгдсэн байж болохоор хэд хэдэн эрх зүйн зохицуулалт хийгдсэн. Харин энэ зохицуулалт нь Монгол Улсын нийгмийн нийт бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэхэд ямар ч ач холбогдол өгөхгүй харин олборлолт хийж байгаа орон нутгийн ард иргэд нь нийт улс оронд ашиггүй гэрээ хэлэлцээрүүдийг хамгаалагч болгон ашиглахад л чухал үүрэг гүйцэтгэгчид болох чиглэлээр хийгдсэн ажил байж болох юм. Учир нь орон нутагт илүү хуваарилалт хийгдсэнээр улс орны өөр хэсэгт оруулах ёстой хөрөнгө оруулалт багасч байгаа нь нэгдмэл улсын хувьд төдийлөн зөв зохицуулалт болж чадахгүй юм.

Олборлох салбарын бодлогыг идэвхтэй хянах иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх, Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачилгын үйл ажиллагаанд шууд ба шууд бусаар оролцдог иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх чиглэл нь Нээлттэй Нийгэм хүрээлэнгийн үйл ажиллагааны чухал

¹⁹⁹ <http://vip76.mn/content/25233>

хэсэг юм. Эдгээр байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад нь бүх талын дэмжлэг үзүүлж ирсэн²⁰⁰ болохыг уг хүрээлэнгийн зөвлөмжид тодорхой дурдсан байна.

Оюутолгойн зэс-алтны томоохон төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээг Монгол улс байгуулсан билээ. Түүнчлэн алт, жонш, нүүрсний Бороо Гоулд, Цайрт Минерал, Чиньхуа Мак зэрэг компаниудтай тогтвортой байдлын гэрээ байгуулсан. Цаашид ч томоохон орд газар, стратегийн ордуудыг, тухайлбал Тавантолгойн нүүрсний ордыг ашиглахад гадаадын хөрөнгө оруулагчтай тодорхой гэрээг байгуулна гэсэн хүлээлт байгаа. Гэрээнүүд олон жил үргэлжлэх уул уурхайн томоохон төслийн болж баталгаажих тул тэдгээрийг хэрэгжүүлэх орчин нөхцөл их хэмжээгээр өөрчлөгдөх магадлалтай. Олборлох салбар дах иргэний нийгмийн хяналтын байгууллага, Нээлттэй Нийгэм Форум, Орлогын Ажиглагч Хүрээлэнгүүдээс дараахь агуулга бүхий зөвлөмжүүдийг гаргасан байна. Үүнд, юуны өмнө Монгол Улсын Засгийн газар өөрийн хүлээсэн үүргээ биелүүлэх, гэрээнд заасан эрхээ хэрэгжүүлэх чадавхи зэрэг нь эцсийн дүндээ тухайн гэрээнүүд Монголд ашигтай байх эсэхийг тодорхойлно гэж үзсэн байна. Зүй нь эдгээр гэрээ хэлэлцээрүүд ашигтай байх эсэх нь Монгол Улсын Засгийн газар өөрийн хүлээсэн үүргээ биелүүлэх эсэхээс гэхээсээ урьдаар гэрээ нь хоёр талын эрх ашгийг хэрхэн зөв зохицуулсан бэ гэдгээс илүү их хамаарах юм. Хоёр талын эрх ашиг зөв зохицуулагдсан байдлаас гэрээ тогтвортой байх, хоёр тал гэрээнд заасан эрхээ хэрэгжүүлэх чадамж тодорхойлогдох юм. Гэрээг хэрэгжүүлэхэд олон асуудал үүсэн гарах нь зайлшгүй, харин гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах нь тийм амар ажил биш байдаг. Ийм нөхцөлд гэрээг амжилттай хэрэгжүүлэхэд учирч болох эрсдлүүдийг Засгийн газар, хөрөнгө оруулагчид болон бусад талууд сайн ойлгох хэрэгтэй бөгөөд нэгэнт батлагдсан уул уурхайн гэрээг амжилттай хэрэгжүүлэхэд тустай тодорхой арга механизмыг бүрдүүлэхэд талууд хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна.

Энэ асуудлаар Нээлттэй Нийгэм хүрээлэнгээс хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлгийн зорилго нь уул уурхай салбарт зурагдсан гэрээний хэрэгжилт, түүний зохистой хяналтыг хангахад Монголын талаас шийдвэрлэх бодлогын чухал асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулахаас гадна иргэний нийгмийн байгууллагууд, тэр дундаа Нээлттэй Нийгэм Форум болон Орлогын Ажиглагч Хүрээлэн энэ асуудлаар шаардлагатай тогтолцоо, чадавхийг бий болгохын тулд ямар хувь нэмэр оруулж болох талаар санал бодлоо солилцоход оршино²⁰¹ гэж үзсэн байдаг. Гэхдээ уул уурхайн чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн гэрээ хэлэлцээрүүдийг иргэд, олон нийтийн байгууллагууд хүлээн зөвшөөрөхгүй байх нь олонтоо байгаа боловч энэ чиглэлд хувь нэмрээ оруулахаар амлаж байгаа эдгээр хүрээлэнгүүд санал солилцохоос өөр зүйлийг огт хийгээгүй нь бодит үнэн юм.

Монгол Улс өөрөө Уул уурхайн хөрөнгө оруулалт, эрдэс баялгийн бодлогын зөвлөлийг байгуулсан байна. Санхүүгийн зах зээлийн бодлогыг тодорхойлох, зохицуулах, хянахтай холбогдсон үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий энэхүү Уул уурхайн хөрөнгө оруулалт, эрдэс баялгийн бодлогын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулжээ:

Бодлогын зөвлөлийн дарга: Санхүүгийн зохицуулах хорооны орны тооны бус гишүүн Д.Ганбаяр

Бодлогын зөвлөлийн гишүүд: Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Н.Алагаа

ГОУХАН-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн Орон нутгийн хөгжил, Засаглалын зөвлөх, хуульч Ч.Оюун-Эрдэнэ

Уул уурхайн яамны Стратеги бодлогын төлөвлөлтийн газрын Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Энхбаатар

“Forbes-Монгол” Эдийн засаг бизнесийг дэмжигч сэтгүүл, Live Energy Group-ийн хөрөнгө оруулалтын зөвлөх Д.Галтбаатар

Монголын Уул уурхайн салбар дахь Хөрөнгө оруулагчдын ассоциацийн ерөнхийлөгч, “Танил Энержи” ХХК-ийн ерөнхий захирал Т.Лхагва

Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн зөвлөх, Эдийн засгийн ухааны доктор, судлаач Б.Аюуш

Монгол Улсын нүүрсний салбарын судалгаа, Япон, Солонгос улсад нүүрс, уул уурхайн бүтээгдэхүүн экспортлох талаарх судалгааг хийсэн, Мэдээллийн технологиор мэргэшсэн Б.Гантулга

УИХ-ын гишүүн Ж.Батзандангийн Эдийн засгийн зөвлөх Д.Эрдэнэбат

Отгонтэнгэр ИС-ийн Хууль зүйн сургуулийн Бизнесийн эрхзүйн тэнхмийн эрхлэгч, Хуульчдын холбооны Сургалтын дэд хорооны Удирдах зөвлөлийн гишүүн Р.Очирбал

“Эй Эстэйт ХХК”-ийн захирал, Эдийн засагч, эдийн засгийн зөвлөх Г.Оюунгэрэл

Уул уурхайн яамны Эрдэс баялгийн салбарын ахмадын нэгдсэн холбооны тэргүүн, судлаач Ч.Хурц²⁰²

Монгол Улсын Уул уурхайн хөрөнгө оруулалт, эрдэс баялгийн бодлогын зөвлөлийн бүтцийг харвал бас л нэлээд асуудалтай болох нь харагдана. Энэ зөвлөлийн гишүүд нь геологич, эдийн засагч, хуульчдаас бүрдэж байна. Харин улс орны алс хэтийн ирээдүй, алдаа онооны дэнсийг яг энэ мэргэжлийн хүмүүс биш харин нийгэм судлал, төрийн бодлогын анализ, улс орнуудын хөгжлийн түүхийг судалдаг судлаач шинжээчид илүү

²⁰⁰ http://www.openforum.mn/index.php?sel=project&menu_id=260&obj_id=4869#sthash.kGSVhjmh.dpuf

²⁰¹ http://www.opensocietyforum.mn/index.php?sel=project&menu_id=279&obj_id=3687#sthash.i4smlRK.dpuf

²⁰² <http://www.frc.mn/news/1121>

зөв хэлэх ёстой. Гэтэл өнгөрсөн 25 жилийн дотор яг энэ чиглэлийг зөвлөгөө, судалгаа шинжилгээ төрийн бодлогод дэндүү их дутагдсан билээ. Үүний үр дүн нь дэлхийд үнэ цэнэтэй ордуудаа хэзээ ашиг нь ирэх нь тодорхойгүй байдлаар гэрээ хэлэлцээр хийж өгчихсөн нь нийгмийн зүгээс маш их шүүмжлэлийг дагуулсаар, төр засагт итгэх ард түмний итгэлийг бууруулсаар байна. Эдийн засагчид уг нь үүнийг урьдчилан харах ёстой боловч өнөөгийн монголын эдийн засагчид нь зөвхөн өнөөдрийг маргааштай харьцуулж ашигтай байдлаар асуудлыг тайлбарлаж байгаа билээ. Уг нь жинхэнэ эдийн засагч хүн бол өнөөдөр алдагдалтай байсан ч ирээдүйд олж чадах ашгийг тооцоолж бодлого боловсруулахад оролцох ёстой билээ. Том гүрний баримталдаг эдийн засгийн бодлого нэг өөр, жижиг зах зээлтэй, технологи, хөрөнгө мөнгөний чадавч муу байгаа орны эдийн засгийн бодлого бас өөр байх ёстой гэдгийг ойлгож төлөвлөх нь өнөөгийн эдийн засагчдад дутагдаж байгаа хамгийн чадавч ч байж магадгүй юм.

Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрдэм шинжилгээ, судалгааны төвүүд:

Геологи, Гидрогеологийн Салбарын Судалгааны Төвүүд
 Геологийн Шинжлэх Ухааны Төв
 Эрдэс Баялаг, Геомэдээллийн Сургалтын Төв
 Геологи, Эрдэс Баялгийн Музей
 Нагояа Их Сургуулийн Хээрийн Судалгааны Төв
 Стратиграфи-Палеонтологийн Судалгааны Төв
 Геофизикийн Сургалт Аргазүйн Төв
 Геологийн Салбарын Инженерүүдийн Мэргэжлийн Зэрэг Олгох Сургалтын Төв
 Уул Уурхайн Салбарын Судалгааны Төвүүд
 Тэсэлгээ Технологийн Төв
 Уул Уурхайн Төсөл, Судалгааны Төв
 Тусгай Зөвшөөрөл Олгох Төв
 Уул Уурхайн Инженерүүдэд Мэргэшлийн Зэрэг Олгох Сургалтын Төв
 Экологи, Тогтвортой Хөгжлийн Төв
 Уурхайн Төлөвлөлт Үнэлгээ Сургалтын Төв
 Геодезийн Салбарын Судалгааны Төвүүд
 Монгол-Солонгосын Уул Уурхай, Эдэлбэр Газрын Мэдээллийн Систем, Тандан Судалгааны Хамтарсан Төв

Геологи, уул уурхай, газрын тос олборлолтын чиглэлээр төрийн болон төрийн бус олон судалгааны төвүүд үйл ажиллагаа явуулж байгаа болох нь дээрхи жагсаалтаас тодорхой харагдаж байна. Харин энэ олон төвүүдийн жагсаалтад уул уурхайн олборлолтын чиглэлээр төрөөс баримтлах чиглэл, бодлогын талаар судалгаа хийдэг нэг ч байгууллага байхгүй байгаа юм. Нэгэнт төрийн бодлогод зөв чиг хандлагыг тодорхойлж заах ямар ч судалгааны төв байхгүй юм болохоор энэ чиглэлээр өнөөг хүртэл явж ирсэн төрийн бодлого үнэхээр алдаатай байхаас өөр яах ч билээ.

Бие даасан хөндлөнгийн байгууллагууд, шинжээчдийн гаргасан зөвлөмж, саналыг авч төрийн бодлого шийдвэрт тусгуулах нөлөөллийн зарим нэг ажлууд хийгдэж байна.

Жишээ нь, ОУИТБС-ын тэргүүн хатагтай Клейр Шорт: “Монгол Улс байгаль орчноо хамгаалдаг, ээлтэй технологиор ажилладаг, хууль дээдэлдэг компаниудыг л түлхүү ажиллуулах хэрэгтэй. Байгалийн баялгийг ухаж авсан даруйдаа байгаль орчноо сэргээх, үр ашигтай зарцуулах л чухал байдаг ” гэж зөвлөсөн байх ажээ. “Ядуу буурай улсын хувьд баялгийн сандаа хадгалах боломж нь байхгүй болохоор өнөө, маргаашдаа зарцуулах хэрэгтэй болдог. Гэхдээ зарцуулалтаа хийхдээ ухаалаг байх хэрэгтэй. Ирээдүйгээ бодсон, үр ашигтай хөрөнгө оруулалт л хийх хэрэгтэй. Уул уурхай өөрөө тогтвортой салбар биш. Гэхдээ тогтвортой хөгжилд уул уурхайн салбарыг ашиглаж болох юм.”²⁰³

Эдийн засагч Д.Жаргалсайхан: “Байгалийн баялгаа ашигласнаар хөгжилд хүрсэн орнуудын гол амжилтын нууц нь улс төрийн тогтвортой байдал, төрийн бодлогын залгамж чанар тогтвортой үргэлжилдэгт оршдог. Эрдэс баялгийн салбарт тогтвортой үйл явцыг бий болгоно гэдэг нь ЗГ, хөрөнгө оруулагчид, иргэний эрх ашгийг тэнцвэртэйгээр бодлогодоо тусгаж чадвал тогтвортой байдаг юм байна гэдгийг олон орны туршлагаас харж болохоор байна...”²⁰⁴ гэжээ. Клейр Шорт, Жаргалсайхан нарын зөвлөмжид уул уурхайн салбарыг ашиглахад оновчтой хариуцлагатай байх талаар анхааруулж байгаа боловч Жаргалсайхан нь хөрөнгө оруулагч тал болон, иргэдийн эрх ашгийг тэнцвэртэй хангаж өгөх нь уг гэрээ хэлэлцээрийн ч, улс төрийн ч тогтвортой байдлыг хангах гэсэн хамгийн гол амин чухал зүйлийг олж харж хэлж байгаагаараа илүү чухал байгаа юм. Гэхдээ ийм санаа нийгэм, судлаачдын зүгээс шийдвэр гаргагчдад хангалттай хүрч

²⁰³ <http://www.eitimongolia.mn/mn/interviews-and-publications>

²⁰⁴ <http://jargaldefacto.com/%D0%BC%D1%8E%D0%BD%D0%B8%D1%81/#sthash.olmIMBxN.dpufYul>

байгаа боловч энэ нь хууль эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдах тал дээр огт ахиц дэвшил гарахгүй байгаа билээ.

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын хуулийн ахлах зөвлөх Т.Алтангэрэл:“Олон улсын хөрөнгө оруулалтын гэрээ...г бүх талаас нь задлан шинжилгээ хийж нарийн мэргэжлийн мэдээлэл баримтыг мэдэхгүйгээр гэрээ байгуулах нь болчимгүй зүйл. Төр үүргээ яаж биелүүлж байна, хөрөнгө оруулагч гэрээний үүргээ биелүүлж байна уу? аль аль нь гэрээний үүргээ зөрчсөн бол яах ёстой вэ? гэдгээс эхлээд зайлшгүй анхаарах ёстой зүйлс олон байдаг. Тиймээс гэрээг гардан хийж буй албан хаагчид мэдээлэл, мэдлэгтэй байх нь хамгийн чухал. Хуульд нийцсэн гэрээ байгууллаа гэхэд дараа нь хэрхэн хяналт тавих, мониторинг яаж хийх вэ гэдэг нь чухал”²⁰⁵ гэсэн нь манай төрийн бодлого боловсруулагчдад анхаарах ёстой чухал зөвлөгөө юм. Харин гэрээ хэлэлцээр байгуулж байгаа албан хаагчид нь хөрөнгө оруулагч талын хөрөнгө, мөнгөөр, тэдний үзүүлж харуулах гэсэн зүйлийг харж, тэдний санал болгож байгаа гэрээ хэлэлцээр, олон улсын туршлагыг харж үүнийгээ байж болох ганц хувилбар юм шиг санаж туйлшран хүлээж авч байгаагаас гэрээ хэлэлцээрүүд үр дүн муутай, маргаан санал зөрөлдөөнөөс салахгүй байна.

²⁰⁵ <http://mobile.news.mn/mcontent/205740.shtml?s=politics>

XX ЗУУНЫ МОНГОЛ ДАХЬ УЛС ТӨРИЙН ДЭГЛЭМИЙН АСУУДЛААРХ МОНГОЛЫН ЭРДЭМТДИЙН СУДАЛГАА

Ж.ЖАРГАЛ

*Доктор, МУБИС, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль
Нийгмийн ухааны тэнхим*

Товч утга: Энэхүү өгүүлэл нь XX зууны Монгол Улсад тогтож байсан улс төрийн ардчилсан бус дэглэмийн асуудлаар манай орны нийгмийн ухааны эрдэмтдээс хийсэн судалгаа, дэвшүүлэн тавьсан үзэл санаа, дүгнэлтийн тоймыг улс төрийн сэтгэлгээний үүднээс авч үзсэн цуврал өгүүллийн эхнийх нь юм. Зохиогч өгүүлэлд манай орны эрдэмтэд 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхэн үед туурвисан бүтээлүүддээ монгол оронд тогтож байсан ардчилсан бус дэглэмийн асуудлыг судалсан байдлыг өгүүлсэн болно.

Түлхүүр үг: XX зууны Монгол Улс, улс төрийн ардчилсан бус дэглэм, авторитаризм, тоталитаризм, хэлмэгдүүлэлт

Abstract: This article is the first of the serials, considering from political point of view, about the researches made by scholars of our country, view and opinions been presented, and overall conclusion regarding on issue of political non-democratic regime that was present in Mongolia in the XX centuries. The author wrote about how the scientists of our country in the end of 1980's and beginning of 1990's studied the non democratic regime that was present in Mongolia in its literary works.

Монголын улс төр судлаач эрдэмтдээс профессор Ц.Ганболд, Ё.Довчин, Ю.Атар, А.Цанжид, И.Лхам, Д.Болд-Эрдэнэ, Д.Ганбат нар өөрсдийн зарим бүтээлдээ XX зууны Монгол Улсад тогтож байсан улс төрийн дэглэмийн талаар санал бодлоо илэрхийлжээ.

Профессор Ю.Атар XX зууны монголын улс төрийн системийг шинжилсэн нэгэн сэдэвт бүтээлдээ тоталитар болон авторитар дэглэмийн мөн чанар, шинж илрэл, дэлхийн орнуудад тогтож ноёрхсон хэв маяг, хэлбэрийг авч үзээд тухайн үеийн ЗХУ, коминтерний нөлөө оролцоогоор 1930 – аад оны сүүлч үе болоход манай оронд тоталитар дэглэм бүрэн тогтсон бөгөөд түүний хэлмэгдүүлэлтийн хүч Японоос өдөөсөн Халх голын дайн, дэлхийн хоёрдугаар дайны үед тодорхой хэмжээгээр саарсан, улмаар 1950 – иад оны дунд үеэс улс оронд авторитар дэглэм бүрэлдэж 1990 он хүртэл оршин тогтсон гэсэн үзэл санааг дэлгэрэнгүй өгүүлсэн байна²⁰⁶.

Профессор А.Цанжид нэгэн өгүүлэлдээ сонирхолтой чухал санал хэлжээ. Тэрбээр: “Нэлээд судлаачид Монгол Улсад 90-ээд он хүртэл оршин тогтнож байсан төрийг тоталитар дэглэмтэй байсан гэж үзсэнтэй санал нэгдэж байгаа юм. ... Тоталитар дэглэм байсан уу, үгүй үү гэдгийг шийдвэрлэхэд шалгуурын асуудал чухал юм. Бидний саналаар хоёр төрлийн, эсхүл хоёр бүлэг шалгуур байж болох юм. Нэгд нь төрийн хяналтын хүрээг авч үзэх нь оновчтой мэт санагдана. Төр нийгмээс өөрийгөө салган түүний дээр тавьж, нийгмийн амьдралын улс төр, нийгэм, эдийн засаг, оюун санааны хүрээнд хатуу хяналт тогтоосон байх нь түүний тоталитар шинжийг илэрхийлэх шалгуур мөн. Харин нийгмийн амьдралын бусад хүрээг харьцангуй чөлөөтэй байлгаж зөвхөн улс төрийн хүрээнд цөөхөн эрх мэдэлтний хяналтыг тогтоох нь төрийн авторитар шинжийн шалгуур юм. ... Хоёрт, төрийн шинж чанарыг (манайд үүнийг улс төрийн дэглэм ч гэж бас нэрлэдэг) тодорхойлох шалгуурт засаглалын механизмыг оруулж болох талтай. Засаглалын механизм гэдэг бол тодорхой хүчин, бүлэг хүмүүст засгийн эрхийг барих, өөрөөр хэлбэл засаглах бололцоог олгодог өвөрмөц үйл ажиллагаа, түүнийг явуулах эрх, хэм хэмжээний цогц юм. Түүнд юуны өмнө гурван зүйлийг оруулж болно. Үүнд: а) засгийн эх булаг, б) шийдвэр гаргах эрх, арга, в) удирдах элитийг сонгон шалгаруулах арга зэрэг болно. ... Дээрх шалгууруудыг манай улсын өмнөх Үндсэн хуулиуд, ялангуяа 1960 оны Үндсэн хуулиар тодорхойлогдсон төрийн шинж чанарт хэрэглэх юм бол төр тоталитар байсан гэдгийг хүлээн зөвшөөрөх учиртай нь илт юм. ... Харин эл дүгнэлттэй санал нийлдэггүй хүмүүс социалист орнуудад оршин тогтнож байсан улс төрийн дэглэмийг Хитлерийн болон түүнтэй төсөөтэй бусад дэглэмүүдтэй харьцуулсны үндсэн дээр хуучин социалист орнуудад, түүний дотор Монгол Улсад тоталитар дэглэм байгаагүй гэж үзэх нь бий. Дээрх шалгууруудын үүднээс эдгээр дэглэмүүдэд хандвал нэг хэв маягийн болох нь харагдана. Харин тухайн цаг үеийн болон гадаад, дотоод нөхцөл байдал, удирдлага болгосон улс төрийн үзэл онолын ялгаа зэргээс үүдэн тоталитаризмын хоёр өөр хэлбэр (баруун болон зүүн радикал) байсан гэж үзэж болох юм. Тоталитар дэглэмүүдэд байдаг нийтлэг шинж бол эхлээд хүчирхийллийн янз бүрийн аргуудыг хэрэглэн нийгэмд байр суурь эзлэн улмаар өөрийгөө бэхжүүлдэг явдал юм. Дараа нь аажимдаа илт эсэргүүцэгчид устаж үгүй болох, хүмүүс дэглэмийн тавьж байгаа шаардлагад үйл ажиллагаагаа зохицуулан “өөртөө цензур” тавьж

²⁰⁶ Атар Ю. Монголын улс төрийн системийн төлөвшлийн онцлогийг судлах нь (Системийн онолын загвараар) Хөх хот, 2005, 116-117, 123-137 дахь тал

сурах, иргэдийн улс төрийн соёл тоталитар хэв маягтай болж, үнэлэмж өөрчлөгдөх зэрэг шалтгаанаар тоталитаризмын илрэх хэлбэр аядуу болдог. Чухам ийнхүү аядуу болсон тоталитаризм Монгол оронд оршин тогтнож байсан билээ. Дашрамд дурьдахад, хуучин ЗХУ болон социалист бусад оронд их бага ямар нэг хэмжээгээр болж өнгөрсөн улс төрийн хэлмэгдүүлэлт нь эдгээр оронд тоталитар дэглэм үүсэж бэхжсэн арга байсан гэж үзэж болох юм” гэж бичжээ (бид товчлов. – Ж.Ж)²⁰⁷.

Энэ бол манай оронд тоталитаризм тогтож байсан асуудлыг судлахад онол, арга зүйн ач холбогдолтой чухал санаа юм. Манай зарим эрдэмтэн “аядуу тоталитаризм” гэж байдаггүй, ардчилсан бус, тэр тусмаа дарангуй дэглэм нь нэг бол хахир хатуу тоталитар, эсвэл арай аядуу авторитар байдаг гэсэн санал хэлдэг. Гэтэл асуудлыг тийнхүү “нэг бол тийм, эсвэл ийм” гэж хоёр тийшээ савлуулан туйлшруулж болохгүй, тэгж сэтгэх нь бодит байдалд нийцэхгүй, ЗХУ болон социалист байсан орнууд дахь тоталитар дэглэм 1950-иад оны дунд үеэс эхэлж багагүй хувирч тоталитаризмаас авторитар дэглэм рүү хувьсан шилжих, эсвэл эл хоёр дэглэмийн шинж илрэлүүд хоорондоо зэрэгцэн орших болсон гэсэн саналыг гадаадын хэд хэдэн эрдэмтэн илэрхийлсэний дотор францын эрдэмтэн Эдгар Морен ЗХУ дахь тоталитар тогтолцоо Сталины дараа аядуу, түүгээр ч үл барам харьцангуйгаар “хүнлэгжих” болсон гэжээ²⁰⁸. Энэ нь дэлхийн тодорхой орнуудад тогтсон тоталитар дэглэмийг түүхэн хувьсал, өөрчлөлтөөр нь авч үзэж судлах хэрэгтэйг харуулж байгаа юм.

Доктор И.Лхам Монголын нийгмийн ардчилал, шинэчлэлийн асуудлыг К. Попперийн <<нээлтэй нийгэм>>-ийн тухай үзэл баримтлалын үүднээс судалсан нэгэн сэдэвт зохиолдоо: “Монгол орон ХХ зууны 20-30-аад оноос 90-ээд он хүртэл <<хөрөнгөтний биш хөгжил>>, <<социалист хөгжил>> гэх мэт нэрийн дор <<Зөвлөлт маягийн хөгжлийн загвар>>-аар замнаж ирсэн. Энэхүү хөгжлийн загварын гол шинж нь социалист тоталитаризм болж байлаа. Монгол орны хөгжлийн тоталитаризмын шатны үндсэн агуулга нь тус оронд модернизацийн зорилтуудыг коммунист маягийн аргаар хэрэгжүүлсэн түүхэн үйл явцаар тодорхойлогдож байна. ... Монгол Улс 1990 оноос эхлэн тоталитар хаалттай нийгмээс ардчилсан нээлтэй нийгэмд шилжиж, гадаад эдийн засаг, гадаад бодлого, мэдээллийн харилцаа гэх мэт нийгмийн амьдралын бүх хүрээнд үндсэн өөрчлөлт хийж байна” гэж бичжээ²⁰⁹. Эндээс доктор И.Лхам монголын нийгмийг коммунист арга замаар модернизаци хийж шинэчлэх явцад тус оронд 1930-аад оноос 1990 он хүртэлх үед социалист хэв маягийн хаалттай тоталитаризм тогтож байсан гэсэн үзэл санааг гаргаж тавьсан нь тодорхой харагдаж байна.

Профессор Д.Болд-Эрдэнэ манай оронд тоталитаризм тогтож байсан асуудлыг авч үзсэн өгүүллийг 2007 онд нийтлүүлжээ. Тэрбээр өгүүлэлдээ ЗХУ, Коминтерны оролцоотойгоор, бас төр барьсан МАХН-ын бодлого, үйл ажиллагааны алдаа гажуудал, бусад зарим хүчин зүйлийн улмаас ХХ зууны Монгол оронд тоталитар дэглэм бүрэлдэн тогтож байсан гэсэн үзэл санаа бүхий дүгнэлтийг түүхэн үйл явдал, тодорхой баримт материалын үндсэн дээр гарган тавьжээ. Эрдэмтэн Монгол оронд тоталитаризм бүрэлдэн тогтсон үйл явцыг хэд хэдэн үе шатад хувааж “... 1920 – иод оны дунд үеэс 1930-аад оны эхэнд тоталитаризмын суурь үндсүүд хэдийнээ бүрэлдэж, улмаар тэр бүхэн нь цаашдаа хэлбэршин зүгшрэх болсон”, “...1930-аад оны дунд үеэс 1940-өөд оны дунд үе хүртэлх хугацаанд бүхэлдээ тоталитаризм бүрэн агуулга, шинжээрээ оршин үйлчлэх болсон”, “...1940-өөд оны дунд үеэс 1980-аад оны сүүлч үе хүртэлх хугацаанд монгол оронд оршин тогтож байсан тоталитар дэглэм өмнөхөөсөө хэд хэдэн онцлог шинжээр ялгарах болсон юм”. “... Сүүлийн үед социализмын гажуудал хэмээн нэрлэж байсан үзэгдлүүд болох захиран тушаах арга, нэг хүнийг тахин шүтэх ёс, бүдүүлэг тэгшитгэл, хуваарилалт, үзэл суртлын хатуу хяналт, хязгаарлалт зэрэг нь монголд олон арван жил ноёрхсон тоталитаризмын хоорондоо холбоо бүхий цогц бүхэл шинжийн тодорхой илрэл, түүний бодит үр дагавар болох нь нэгэнт тодорхой болсон юм” гэж дүгнэн бичсэн байна²¹⁰.

Профессор Д.Болд-Эрдэний эл санаа бодол чухал бөгөөд манай түүхч эрдэмтдийн нэлээд нь дээр дурдагдсан үзэгдлүүдийг тоталитар дэглэмээс хөндий авч үзэж тус тусдаа бий болсон алдаа гажуудал хэмээн үзэж байсан дутагдлын учирь олж харахад ач холбогдолтой байгаа юм.

1990 оноос хойш нийтлэгдсэн социологийн тоймтой ном бүтээлийг үзэхэд манай социологич эрдэмтэд монгол орон дахь тоталитар болон авторитар дэглэмийн асуудлыг төдийлөн анхаарч авч үзээгүй байна.

Гэхдээ социологич эрдэмтдээс профессор Х.Гүндсамбуу, Ч.Гамир нар авч үзэн буй асуудлаар үзэл санлаа хэлжээ. Х.Гүндсамбуу монголын нийгмийн давхраажлыг судалсан нэгэн сэдэвт томоохон бүтээлдээ: “...ХХ зууны монголын нийгмийг социологийн үүднээс тун нарийн судлууштай байгаа юм. Үнэндээ бол хорьдугаар зууны монголын нийгмийг түүхийн үүднээс, тэгэхдээ мушгин гуйвуулсан байдлаар нэлээд судалсан, харин социологийн үүднээс бараг судлаагүйг онцгойлон дурьдалтай” гэж цохон тэмдэглээд ХХ зууны Монгол Улсад оршин тогтож байсан улс төрийн дэглэмийн талаар: “... хорьдугаар зууны монголд социализм байсан эсэх нь маргаантай ч захиргаадалтын хүнд сурталт – тоталитар тогтолцоо байсан нь ямар ч маргаангүй. ... Миний төсөөллөөр монголд тоталитар тогтолцоо бүрэлдэх хоёр шимт хөрс байсны нэгдэх нь дорнын деспотизм, нөгөө дэх нь хүй элгэний хийгээд нэг нутаг усныхны социализм юм. ... ХХ зууны монголд эхлээд нэг хүний буюу Х.Чойбалсангийн, дараа нь бичил бүлгийн буюу Ю.Цэдэнбал тэргүүтэй МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүдийн дарангуйлал тогтож, тэр нь 1990 оны ардчилсан хувьсгалын эхэнд унасан билээ” гэж бичжээ²¹¹.

²⁰⁷ Цанжид А. Монгол Улсын Үндсэн хуулийн онолын үзэл баримтлалын тухай зарим асуудал. – Шинэ толь. – 1999, №4 (28), 18-30 дахь тал

²⁰⁸ Морен Э. О природе СССР: Тоталитарный комплекс и новая империя. Перевод с французского. М., 1995, с.38

²⁰⁹ Лхам И. К. Попперийн <<нээлтэй нийгэм>>-ийн үзэл санаа ба нийгмийн ардчилсан үйл явц (Философийн шинжилгээ). УБ., 2001, 71-72 дахь тал

²¹⁰ Болд –Эрдэнэ Д. Монгол дахь тоталитаризм: үүсэл бүрдэлт, үе шат, онцлог. – Шинэ толь. – 2007, №2 (59), 17-28 дахь тал

²¹¹ Гүндсамбуу Х. Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага (ХХ зуун). УБ., 2002, 37 дахь тал

Социологич Ч.Тамир Монголд тоталитар дэглэм тогтож байсан асуудлаар судалгааны хоёр өгүүлэл нийтлүүлсэн нь нэн сонирхолтой байна. Зохиогч 2009 онд МУИС-ийн “Политологи” сэтгүүлийн №4 –д нийтлүүлсэн “Улс төрийн Товчооны гишүүдийн хэв маяг, социал төрх” (1940-1990 он) гэсэн өгүүлэлдээ 1940-1990 оны хооронд МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, орлогч гишүүнээр сонгогдон ажиллаж, нам, төрийн өндөр албан тушаал хашиж байсан нийт 47 хүний улс төр, үзэл бодол, социал шинж төрх, боловсрол, нутаг ус, гишүүн байсан хугацаа, дэвшсэн ба буусан байдлыг тэр үеийн улс төрийн дэглэмтэй нягт холбож, социологийн үүднээс шинжилж үзээд тэдгээр гишүүдийн “... албан тушаал хаших хугацаа нь уртсах тусам эрх мэдэл илүүтэй төвлөрүүлэх хандлага их байна. Ингэж албан тушаалыг ээлжилж, хавсруулж, төвлөрүүлж удаан хугацаагаар хаших явдал түгээмэл байсан нь эрх мэдлийг хуваарьгүй эзэмшигч ноёрхогч элит нь бүрэн хаалттай систем байсныг харуулна. ... Энэ баримт нь Ю.Цэдэнбал огцорсон ч 1990 он хүртэл монголын улс төрийн дарангуйлагч дэглэм огтхон ч өөрчлөлт ороогүй хэвийн ажиллаж байсныг харуулах бөгөөд тоталитар дэглэм нь авторитар дэглэмээс ялгаатай нь удирдагч нь солигдоход огтхон ч өөрчлөлт ордоггүй гэдгийг нотлож байна. ... Тиймээс Монгол Улсад 1940-1990 оны хооронд тоталитар дэглэм үүсч бүрэлдэж оршин тогтож байсныг батлан харуулж байна” (бид товчлов. Ж.Ж.) гэж бичжээ²¹². Зохиогч эл өгүүлэлдээ манай оронд тоталитар дэглэм бүрэлдэн тогтох, улмаар бэхжиж ноёрхоход МАХН, түүний дээд удирдлага бүхий Төв Хорооны Улс төрийн Товчоо үндсэндээ хаалттай, намын олон түмний хяналтнаас гарсан, дархлагдсан байдалтай байсан явдал ихээхэн үүрэг нөлөөтэй байсан гэсэн үзэл санааг баримт нотолгоотой гаргаж тавьсан нь манай түүхч эрдэмтдийн энэ талаарх үзэл бодолтой нийцэж байгаа юм.

Ч.Тамир, эл өгүүллийн үргэлжлэл гэж үзэж болохоор “Монголд тоталитар дэглэм тогтоход институцийн (дүрмийн) гүйцэтгэсэн үүрэг” гэсэн өөр нэг өгүүлэлдээ тус оронд тоталитаризм тогтож байсан асуудлаар манай нэлээд эрдэмтний хийсэн судалгаа, нийтлүүлсэн бүтээлийн агуулга, үзэл санаа, дүгнэлтийг шинжлэн үзээд тэдгээрийг нэгдүгээрт, тус оронд авторитар дэглэм тогтож байсан, хоёрт, тоталитар дэглэмтэй байсан, гуравт, зарим эрдэмтэн эл хоёр дэглэмийн тухай ойлголтыг төдийлөн ялгаж хэрэглээгүй, тиймээс тэдгээр нь хоорондоо сүлжилдэн оршиж байсан гэсэн үзэл санаа бүхий гурван чиглэлтэй үнэлэлт дүгнэлт гарч байгааг авч үзсэн нь энэ талаарх судалгааны анхны оролдлого болсон байна.

Зохиогч өгүүлэлдээ “... социализмын үеийн Монгол нь 1940-1990 он хүртэл тоталитар дэглэмтэй байсан, энэ дэглэм нь ялгаатай хэв маягуудтай байсан” гэсэн урьдчилсан таамаглал дэвшүүлэн тавиад түүний дагуу Чойбалсан ба Цэдэнбалын дэглэмийг эл үед хуралдсан МАХН-ын их хурал, Төв Хорооны Улс төрийн Товчооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааг улс төрийн дэглэмтэй нягт уялдуулж, улс төрийн социологийн үүднээс шинжлэн үзээд 1940-1990 онд Монголд улс төрийн тоталитар дэглэм тогтож байсан, гэхдээ тэр нь 1940-1954, 1954-1990 онд хоорондоо мөн чанар, уг шинжээрээ нэгэн нэгдмэл боловч багагүй ялгаа онцлогтой хоёр янзын хувилбар бүхий төлөв байдалтай байсан гэсэн сонирхолтой, шинэлэг үзэл санааг агуулсан дүгнэлтийг гарган тавьжээ²¹³. Социологийн эл үзэл бодол нь манай нэлээд эрдэмтэн тус оронд 1940-өөд оноос 1950-иад оны эхэнд тоталитар дэглэм, 1950-иад оноос 1980-иад онд авторитар дэглэм тогтож байсан гэж үздгийг эргэн харж нягтлан судлахад ач холбогдолтой юм.

Монгол Улс XX зууны 70 орчим жилд уламжлалт нийгмийг хувьсгалт ёсоор өөрчлөн байгуулах чиглэлээр замнасан түүхэн үед тус оронд оршин тогтож ирсэн улс төрийн дэглэм, түүний хувьсгал хувирлыг чухамдаа манай түүхч эрдэмтэд бусдаас илүү судлан шинжилж олон бүтээл туурвижээ. Тэдгээр эрдэмтдийн дотроос академич Ж.Болдбаатар, шинжлэх ухааны доктор, профессор Ч.Дашдаваа нар асуудалд тогтмол анхаарал хандуулж тоймтой, нэгтгэн дүгнэсэн үзэл санааг гарган тавьж, түүнийгээ шинээр хийсэн судалгааныхаа үр дүнгээр нягтлан тодотгож, чамбайруулсаар иржээ. Энэ нь эдгээр эрдэмтний 2003-2011 онд нийтлүүлсэн тус тусын болон хамтарч бичсэн бүтээл, түүнчлэн “Монгол Улсын түүх” таван боть хамтын суурь бүтээлийн тавдугаар боть, “Монгол Ардын намын түүх” есөн боть хамтын бүтээлийн II, III, V, VI ботийн холбогдох бүлэг зүйлүүдэд тусгалаа олжээ.

“Монгол Улсын түүх”-ийн V ботид XX зууны 30-50-иад оны үеийн монголын улс төрийн дэглэмийн талаар профессор М.Санждорж, З.Лонжид нарын бичсэн зүйлүүд мөн орсон байна.

Академич Ж.Болдбаатар 1950-1980-иад оны үеийн улс төрийн дэглэмийг судалж 1990-ээд оны төгсгөл үед дэвшүүлэн тавьж байсан үзэл бодлоо үндсэндээ хэвээр баримтласны хамт зарим зүйлийг нэмж нягтлан тодотгосон байна. Академич “Монгол Улсын түүх” зохиолын V ботид тус оронд 1930-1950-иад оны эхэнд тогтон ноёрхож байсан тоталитар дэглэм нь 1950-иад оны эхний хагас болон дунд үед бий болсон дотоод гадаад нөхцөл байдал, хүчин зүйлийн нөлөөгөөр хүч суларч улмаар авторитар дэглэмээр солигдсон, эл үйл явцын агуулга нь: 1950-иад оны үед “Улс орны удирлагын дотор гарсан зөрчил тэмцлийг өнгөцхөн харвал ажлын дутагдал доголдлыг арилгах, удирдлагыг орчин цагийн боловсролтой шинэ хүчнээр сэлбэх зорилготой байсан мэт боловч хэрэг явдлын гүн рүү өнгийвөл нэг хүнийг тахин шүтэхийн хор холбогдлыг арилгах, тухайн нийгмийн тогтолцооныхоо хүрээнд ардчиллыг гүнзгийрүүлэх гэсэн дэвшилтэт, олон ургальч үзэл бодлыг нухчин дарах улс төрийн тун өөр агуулгатай байсан юм. Ийнхүү улс оронд авторитар дэглэм тогтох улс төр, үзэл суртлын урьдач нөхцөл аажим аажмаар бэлтгэгдсээр байв. Түүнчлэн 50-иад оны эцэст ардын хувийн аж ахуйтныг хоршоолсноор БНМАУ-д авторитар дэглэм тогтох эдийн засгийн гол

²¹² Тамир Ч. Улс төрийн Товчооны гишүүдийн хэв маяг, социал төрх (1940-1990 он). – “Политологи” сэтгүүл. – 2009, №4 (50), 168-176 дахь тал

²¹³ Тамир Ч. Монголд тоталитар дэглэм тогтоход институцийн (дүрмийн) гүйцэтгэсэн үүрэг. – “Политологи” сэтгүүл. – 2010, №6 (58), 150-159 дэх тал.

нөхцөл бүрэлдсэн юм. 1960 оны VII сарын 6-нд БНМАУ-ын Ардын Их Хурлын 4 дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаар БНМАУ-ын III Үндсэн хуулийг баталсан нь улс оронд авторитар дэглэм тогтох эрх зүйн үндсийг бүрдүүлжээ. ... Үндсэн хуульд <<БНМАУ-ын төр, нийгмийг удирдан чиглүүлэгч хүч бол ... Монгол Ардын Хувьсгалт Нам мөн>> гэж заасан нь нам төвтэй улс төрийн тогтолцооны эрх зүйн үндсийг бүрэлдүүлсэн байна. Энэ нь төржсөн нам, намжсан төр бий болж, нам, төрийн ажлын зааг ялгаа яваандаа алдагдах үндсийг тавьж өгчээ”²¹⁴. “...Төгсгөлд нь дүгнэхэд 1965 –аас 1980-аад онд БНМАУ нийгмийн байгууллын хувьд социализм байгуулж дуусгах зорилт тавьж, түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө хүчин зүтгэж байсан, улс төрийн дэглэмийн тухайд авторитаризм хуваарьгүй ноёрхсон орон болон хувирчээ. 1960-аад оны дунд үеэс монголын нийгэмд хүчээ авсан авторитар дэглэм 1980-аад он гэхэд нийгэм – улс төрийн өөрийн гэсэн тодорхой үндэс, агуулга, хэлбэртэй болсон байна” гэж бичжээ²¹⁵. Эндээс үзвэл академич 1950-иад оны дундаас 1960-аад оны дунд хүртэлх арав гаруй жил ба тэр явцад болж өнгөрсөн улс төр, үзэл суртал, нийгэм, эдийн засаг, эрх зүйн томоохон үйл явдал нь тус оронд 1930-1940-өөд онд тогтож байсан тоталитар дэглэм авторитар дэглэмээр халагдаж солигдох, нэг үгээр хэлбэл авторитар дэглэм бүрэлдэн тогтож ноёрхох урьдач нөхцөл, хүчин зүйлийг бэлтгэсэн нэг ёсондоо эл хоёр дэглэмийн завсрын шинж агуулгатай үе байсан гэсэн сонирхолтой, шинэлэг санааг гарган тавьжээ. Энэ нь манай орон дахь улс төрийн дэглэмийн хувьсал, өөрчлөлтийг тодорхой хандаж тусгайлан судлахад ач холбогдолтой байгаа юм.

Академич Ж.Болдбаатар 2011 онд нийтлэгдэж гарсан “Монгол Ардын Намын түүх” есөн боть бүтээлийн ихэнхэд нь зохиогчоор оролцжээ. Тэдгээрийн нэг нь 1946-1953 оны үеийн намын түүхийн асуудлыг авч үзсэн V боть байгаа бөгөөд академич түүний IV бүлгийг бичиж түүндээ 1940-өөд оноос 1950-иад оны эхэн үеийн улс төрийн дэглэмийг судалж үзэл бодол, үнэлэлт дүгнэлтээ гаргаж тавьсан байна. Зохиогч энэ талаар “Монгол дахь тоталитар дэглэм гүнзгийрсэн нь” гэж гарчигласан гуравдугаар зүйлд: “Дайны жилүүдэд цаг үеийн шаардлагаар удирдлагын төвлөрлийг хүчтэй болгосон нь тоталитар тогтолцоог улам гүнзгийрүүлсэн ажээ. ЗХУ-д И.В.Сталины дарангуйлал тогтож, ЗХУ-д төдийгүй коммунист ажилчны хөдөлгөөнд И.В.Сталиныг тахин шүтэх болсон нь Монголд Х.Чойбалсанг тахин шүтэх үзэл гүнзгийрэхэд үлэмж нөлөө үзүүлж байв”²¹⁶. “Нэг хүнийг тахин шүтэх үзэл газар авах тусам тоталитар дэглэм улам бүр гүнзгийрч нийгмийн бүхий л эд эс бүхнийг хяналтандаа авах болов. Үзэл суртлын хяналт чангарч бүхнийг нэг үзэл суртлын шүүлтүүрээр шүүх хандлага хүчтэй болов”²¹⁷. “<<Маршал Чойбалсангийн>> хэмээн түүхнээ нэрлэгддэг 1940 оны Үндсэн хууль батлагдсны дараа БНМАУ-д нэг хүнийг тахин шүтэх, улмаар нийгмийг хөгжүүлэх чиг баримтлалаа ЗХУ-ын бодлогыг хуулбарлах тал руу хэт хандуулж, намын үзэл суртал, сургалт хүмүүжлийн бүх ажил марксист-ленинист онол, арга зүйд бүрэн тулгуурлан намын гишүүд гэлтгүй малчин ардаас балчир сурагчдыг хүртэл энэ талаар зохих зохих түвшиндээ мэдлэгтэй болгохыг шаардах болов. Энэ бүхэн Монгол орон нэг хүний ганцаар дарангуйлал тоталитар дэглэм гүнзгийрэн оршиж байсныг харуулна” гэж дүгнэн бичжээ²¹⁸.

Академич Ж.Болдбаатар түүнчлэн доктор Д.Дашдуламтай хамтран дээр дурдсан есөн боть бүтээлийн VI ботийг (1954-1965 он) мөн бичиж түүний гуравдугаар бүлэгт эл үеийн улс төрийн дэглэмийг авч үзсэн байна. Зохиогчид түүндээ 1950-иад оны хоёрдугаар хагасаас МАХН-ын дээд удирдлагад нэг талаас Ю.Цэдэнбал ба түүнийг дэмжигчид, нөгөө талаас Д.Дамба, улмаар Д.Төмөр-Очир, Л.Цэнд, Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарын хооронд явагдсан зөрөлдөөн тэмцэлд Ю.Цэдэнбал 1964 онд ялснаар “... Монголын нийгмийн удирдлагын хямрал шувтарч, 1960-аад оны дунд үе гэхэд номенклатурчдын шинэ анги бүрэлдэж, Монгол оронд улс төрийн тоталитар дэглэм тогтжээ”²¹⁹. “Эл үед Монголд ноёрхох болсон улс төрийн тоталитар дэглэмийн танин мэдэхүйн үндэс нь ард түмэнд үл итгэн, нийгмийг бүхэлд нь хамарсан хяналтын тогтолцоог бий болгосонд оршино. Ийм учраас уг дэглэмийн нийгмийн бааз нь ард түмэн ч биш, намын олон түмэн ч биш, харин Намын Төв Хорооны мэдлийн ажилтнуудын эрх дархтай дээд хэсэг болж байв. Онол, үзэл суртлын үндэс нь марксизм, ... ангийн тэмцэл, пролетарийн диктатур, социалист байгуулалтын нийтлэг зүй тогтол, ... үзэл суртлын тэмцэл зэрэг ухагдахууныг туйлчилж догматикаар тайлбарлан хэрэглэж ирсэн явдал юм. Зохион байгуулалтын хэлбэр нь хамтын удирдлагыг ёс төдий хэрэглэж, хэрэг дээрээ нэг хүний тушаал шийдвэрийг бурханчилан шүтэж, үг дуугүй биелүүлэхэд чиглэж байв. Ажлын арга барилын сонгодог шинж нь захиран тушаах хүнд сурталт ёс байсан юм. ... Тоталитар дэглэмийг бэхжүүлэхэд нөлөөлсөн олон хүчин зүйл байсныг тэмдэглэх нь зүйн хэрэг юм. Тухайлбал, сталинизмын олон улсын нөлөө, социализмын туршлагыг дан ганц ЗСБНХУ-ын туршлагаар хэмжиж ... байсан догматик бүдүүвчлэл, олон улсын коммунист хөдөлгөөн, социалист системийн шалгарсан манлай хүчний тухай нийтэд тархсан сэдэв нь Монгол дахь эл дэглэмийг тэтгэн дэмжих олон улсын шимтэй хөрс болж байжээ” (бид товчлов. – Ж.Ж.) гэж дүгнэн бичсэн байна²²⁰.

²¹⁴ Монгол Улсын түүх. Тавдугаар боть. (XX зуун). УБ., 2003, 296-297 дах тал

²¹⁵ Мөн зохиол. 358 дахь тал

²¹⁶ Монгол Ардын Намын түүх (1946-1953). V боть. Зохиогч: П.Дэлгэржаргал, Р.Төрдалай, Ж.Болдбаатар. УБ., 2011, 212 дахь тал

²¹⁷ Мөн зохиол. 216 дахь тал

²¹⁸ Мөн зохиол. 218-219 дэх тал

²¹⁹ Монгол Ардын Намын түүх (1954-1965). VI боть. Зохиогч: Ж.Болдбаатар, Д.Дашдулам. УБ., 2011, 214 дэх тал

²²⁰ Мөн зохиол. 223-224 дэх тал

Академичийн доктор Д.Дашдуламтай хамтран бичсэн эдгээр зүйлийн үзэл санаа, дүгнэлт нь түүний 2003 онд “Монгол Улсын түүх” –ийн V ботид бичсэн зүйлийн агуулга, логиктой багагүй зөрчилдөж байна. Тухайлбал, тэрхүү V ботид зохиогч манай оронд 1930-аад онд тогтсон тоталитар дэглэм 1950-иад оны эхний хагаст хүч сулран хувьсаж улмаар 1960-аад оны дунд үед авторитар дэглэмээр бүрэн халагдсан гэж үзсэнийг бид дээр иш татаж тодорхой өгүүлсэн бөгөөд харин 8 жилийн дараа 2011 онд бичсэн дээрх зүйлдээ 1960-аад оны дунд үед манай оронд тоталитар дэглэм ноёрхож байсан гэсэн нь хоорондоо зөрж байна. Энэхүү сүүлчийн үзэл санаа нь угтаа бүлгийг хамтран бичсэн доктор Д.Дашдуламын санал бодол байгаа болов уу гэж бодогдовч дурдсан үед тогтож байсан тоталитар дэглэмийн нийгэм, улс төр, үзэл суртлын үндэс, шинж чанарын талаар бичигдсэн хэсгийн үг өгүүлбэр, бичлэг нь академичийн 2003 онд “Монголын түүх”-ийн V ботид бичсэн зүйлтэй яг адил байгаа юм. Тэгэхлээр тэрбээр энэ асуудлаарх санаа бодлоо сүүлийн үед тодогтож, манай оронд 1960-аад оны дунд үед ч тоталитар дэглэм тогтон ноёрхож байсан хэмээн үзсэн байж болох талтай.

Энд үүнтэй холбоотой нэг зүйлийг дурдахад “Монгол Ардын Намын түүх” есөн боть зохиол нь хэдийгээр намын түүхийн асуудлын үүднээс голлон бичигдсэн байгаа ч гэсэн тэдгээрт бүхэлдээ XX зууны Монголын улс төрийн түүх, түүний дотор улс төрийн дэглэмийн асуудал чухал байр суурь эзэлж тусгалаа олжээ. Харин 1966-1983 оны үеийг хамарсан VII ботид (зохиогч нь З.Баасанжав) эл үеийн улс төрийн амьдрал, ер нь улс төрийн ямар тогтолцоо, дэглэм оршиж байсныг авч үзээгүй, үүний дээр эл олон боть зохиолын VIII боть бичигдээгүй ажээ. Тиймээс манай түүхч эрдэмтэд, түүний дотор намын түүхээр мэргэшсэн эрдэмтэд 1960-аад оны дунд үеэс 1990 он хүртэлх үеийн улс төрийн дэглэмийн талаар сүүлийн үед ямар санал бодолтой байгаа нь одоогоор төдийлөн тодорхой биш байна гэж үзэж болохоор юм.

“Монгол Улсын түүх”-ийн V ботид манай орны 1930-аад оны үеийн улс төрийн дэглэмийн асуудлыг түүхч эрдэмтэн З.Лонжид “Ардчилсан ёс зарчим алдагдаж, тоталитар дэглэм тогтсон нь” гэж гарчиглан дэлгэрэнгүй авч үзжээ. Зохиогч тэр талаар: “...1934 оны сүүлийн хагасаас намын удирдах тэргүүлэх үүргийг дахин сэргээж, төр, засгийн бүх үйл ажиллагааг намын хяналтад оруулж эхэлсэн байна. ... Ялангуяа 1933 оноос эхлэн тус улсын дорнод хязгаарт түгшүүртэй байдал бий болсон явдлыг МАХН шиглаж, төр засгийн бүх эрхийг өөртөө төвлөрүүлэн Улсын Бага хурал, Засгийн газрын үйл ажиллагааг шууд зааварлах болов. ... Намаас төр захиргааны бүх хэрэгт урьдын адил хүчтэй нөлөөлөх болж байгааг П.Гэндэн зэрэг хүмүүс эсэргүүцэж байсан боловч тэднийг ... зэмлэж, П.Гэндэн бол <<намын удирдах үүргийг зөвшөөрөхгүй байсан ба ... улс төрийн хортой явдлуудыг удаа дараагаар гаргаж байсан>> хэмээн буруутгаж ... ЗХУ-д нутаг заан суулгах шийдвэрийг 1936 оны хавар МАХН-ын Төв Хорооны бүгд хурал гаргасан юм (Бид товчлов. – Ж.Ж.). Энэ шийдвэр МАХН улс орны бүх удирдлагыг өөртөө бүрэн эрхтэйгээр төвлөрүүлэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд намын байгууллагын оролцоо, зөвшөөрөлгүйгээр их, бага ямар ч асуудлыг төр засгаас шийдвэрлэх эрхгүй болсон байна. Өөрөөр хэлбэл, намын дарангуйлал газар авах нөхцөл бүрджээ. ... Тийнхүү 1934 оноос эхлэн намын удирдлагыг сэргээж эхэлсэн нь 1936 оны хавраас Намын Төв Хорооны тэргүүлэгч, Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч, өрлөг жанжин (маршал), Дотоод Явдлын Яамны сайд Х.Чойбалсанд онцгой эрх олгосноор дуусгавар болж, ардчилал хязгаарлагдаж, төр ёс алдагдаж, хууль хяналт завхарч, ганц хүний дарангуйлал зонхилох байдал гараагаа авч, нэлээд хурдацтай гүнзгийрч байлаа” гэж бичжээ²²¹. Эрдэмтэн цааш энэхүү тоталитар дэглэм Коминтерн, ЗХУ-ын удирдлагын нөлөө шахалтаар улс төрийн хилсдүүлэлт үйлдсэн, тэр нь 1937 онд ид оргилдоо хүрч, 1940-өөд он, түүнээс хойш ч олон жилийн турш янз бүрийн хэлбэрээр үргэлжилснийг авч үзжээ²²².

Профессор З.Лонжидын судалгаа, гаргаж тавьсан дээрх үзэл санаа нь манай оронд 1930-аад онд тоталитаризм тогтсон асуудлыг цааш нарийвчилж судлахад наандаж хоёр зүйлийн ач холбогдолтой гэж бодогдож байна. Нэгд, 1930-аад онд Итали, Герман, ЗХУ болон хожим нь бусад хэд хэдэн оронд тоталитар дэглэм янз бүрийн хэв маяг, хэлбэрээр бүрэлдэн тогтож ноёрхоход эдгээр оронд өргөн олон түмний нийгмийн бааз сууриа болгосон улс төрийн ганц нам дангаар тогтож, улмаар төр, нийгмийг бүхэлд нь дэглэн засаглаж, нэг үзэл суртлыг туйлшруулан баримталснаар тоталитар нам болж хувирсан явдал гол үүрэг нөлөөтэй байсныг гадаадын олон эрдэмтэн судалж нийтлэг үзэл бодол, дүгнэлтэд хүрсэн байдаг. 1930-аад онд манай оронд тоталитар дэглэм бүрэлдэн тогтох үйл явц мөн ийм арга механизмаар явагдсныг профессор З.Лонжид түүхэн үйл явдал, баримт мэдээний үндсэн дээр илэрхийлэн харуулжээ. Хоёрт, философич Ш.Түдэв зэрэг зарим эрдэмтэн манай оронд МАХН нь төрийн үйл хэрэгт тэр бүр хугалдан оролцохгүй явж ирсэн гэж үзсэн байдаг²²³. Гэтэл түүхэн үйл явдал үнэндээ тийм байгаагүй, олон янзын хүчин зүйл, түүхэн нөхцөл байдлын нөлөөгөөр улс төрийн ганц нам байсаар ирсэн МАХН тус оронд авторитар болон тоталитар дэглэм бүрэлдэн тогтоход ихээхэн нөлөө оролцоотой байсныг З.Лонжид баримт нотолгоотой гаргаж тавьсан байна.

Монголын төрийн түүхийг олон жил дагнан судласан нэрт эрдэмтэн, профессор М.Санждорж 2000 оноос хойшихи зарим бүтээлдээ, тухайлбал, 2003 онд нийтлэгдсэн “Монгол Улсын түүх”-ийн V ботид бичсэн зүйлдээ 1940-1950-иад оны үед манай оронд тогтож байсан улс төрийн дэглэмийн асуудлаарх үзэл санаагаа нэлээд хэмжээгээр нягтлан тодогтожээ. Жишээлбэл, тэрбээр 1995 онд нийтлэгдсэн “Хорьдугаар зууны монгол” хамтын бүтээлд 1940-1950-иад оны эхэн үеийн улс төрийн дэглэмийг чухамдаа тоталитаризм гэж нарийн тодорхой зааж шууд нэрлээгүй, тэр нь тоталитар дэглэм байсан гэсэн утгатай санаагаа “Цэдэнбалын дэглэм, Чойбалсангийн дэглэм хоёрыг нэгэн төвшинд тавьж, ижил тоталитар гэж нэрлэж боломгүй байна”

²²¹ Монгол Улсын түүх. Тавдугаар боть (XX зуун). УБ., 2003, 202-203 дах тал

²²² Мөн зохиол. 203-212 дахь тал

²²³ XX зууны Монголын түүхийн зарим асуудал. УБ., 1999, 101 дэх тал

гэж тойруу байдлаар илэрхийлж байсан бол²²⁴ 2003 онд “Монгол Улсын түүх”-ийн V ботид энэ үеийн тоталитар дэглэмийн талаар тодорхой, дэлгэрэнгүй өгүүлжээ. Түүний бичсэн зүйлээс заримыг нь товчлон иш татъя.

“1940-1953 он бол Монгол Улсын хувьд дайны үеийн онцгой зорилтуудыг хэрэгжүүлэх, дайны дараа дайнаас болж учирсан хохирол, сүйтгэлийг арилгах, энх цагийн бүтээн байгуулах зорилтуудыг богино хугацаанд нөхөн гүйцэлдүүлэх шаардлага тулгарсан өвөрмөц гэмээр өөрчлөлтүүд гарчээ. Тэдгээр өөрчлөлтүүдийн тодорхойлогдох гол шинж, үндсэн чиглэл нь нэг хүнийг тахин шүтэхэд сууриласан тоталитар дэглэм улам бүр батжин бэхжсэн явдал байв. 1940 оноос хойш 1947 он хүртэлх ... нөхцөлд нам, төрийн эрх баригч цөөн хүмүүсийн эрх мэдэл асар өсөж, удирдлагын төвлөрөл нэн хүчтэй болжээ. Нийгмийн амьдралд намын эзлэх байр суурь бэхжин нөлөө нь нэмэгдэв. ... Чухам эндээс л намын удирдлагыг тойрсон шадар хүмүүсийн бүхэл бүтэн бүлэг бүрэлдэх үндэс гараа эхэлжээ. ... Намын үзэл суртлын ажил нь олон түмний үндэсний ухамсар, бахархлыг үгүйсгэж, чөлөөт сэтгэлгээг боогдуулж, үнэнийг илэрхийлэх эрмэлзлийг нухчин дарж байв. Ингэж ганц үзэл номлолыг хүчээр тулгасан нь нийгмийг тодорхой утгаар оюуны хоосрол руу түлхсэн байна” гэх зэргээр тухайн үеийн тоталитар дэглэмийн гол шинж, эл дэглэм тогтож ноёрхоход МАХН-ын үйл ажиллагаа голлох үүрэгтэй байсан зэрэг улс төрийн үйл явдлыг авч үзэж гарган тавьжээ²²⁵.

Профессор Ч.Дашдаваа 1990-ээд оны эхэн үеэс хойш XX зууны Монголын улс төрийн түүхийг голлон судалсан бүтээлүүддээ 1930-1980-аад оны үеийн улс төрийн дэглэм, түүний хувьсал, шинж чанарыг авч үзэж тодорхой үзэл санал, дүгнэлтүүдийг илэрхийлэн гаргажээ. Ч.Дашдаваа 2003 онд нийтлүүлсэн “Улаан түүх” номондоо авч үзсэн гол асуудал болох 1928 оны сүүлчээр Коминтерн ба БХК (б) намаас социализм байгуулах зорилтыг Монголд тулган хүлээлгэж улмаар хүчээр хэрэгжүүлэх болсон үйл явцыг цааш гүнзгийрүүлж, дэлгэрэнгүй судалсны үр дүнд тулгуурлаж 2008 онд “Монгол дахь төрийн эргэлт” гэсэн том хэмжээний нэгэн сэдэвт бүтээл нийтлүүлжээ. Зохиогч түүндээ Монгол оронд 1920-иод онд үндэсний ардчилсан шинж төрхийг олж бүрэлдэж байсан төрийн засаглал Коминтерн, БХК (б) Намын дээрх бодлогоор тасалдаж 1920-1930-аад оны зааг үед тус оронд тоталитар дэглэм бүрэлдэн тогтсон, тэр нь 1930-аад оны сүүлчээр нэг хүний дарангуйллын авторитар дэглэм болж хувиран ноёрхсон гэсэн үзэл санааг товчлож тавьсан байна.

Зохиогчийн энэ талаарх дүгнэлтийн чанартай санал бодлыг бүтээлийн төгсгөл хэсгээс иш татаж өгүүлбэл: “Зөвлөлт хэв маягийн социалист өөрчлөлт Монголын нөхцөлд тохирохгүй хэмээн үзэж, нийгмийн амьдралын бүх салбарт өрнөсөн ардчилсан өөрчлөлтийг үргэлжлүүлэхийг эрмэлзэж байсан үндэсний ардчилсан үзэлтэй Монголын удирдагчидад <<баруунтан>> хэмээх нэр хаяг зүүж, тэднийг албан тушаалаас нь нэлэнхүйд нь зайлуулах замаар Монгол оронд социализм байгуулах зорилтыг эрх баригч улс төрийн намын гол бодлого болгон хувиргах үйл ажиллагааг Коминтерн, БХК (б) Намаас шууд удирдан зохион байгуулсан байна. Монголд төрийн эргэлт зохион байгуулах Коминтерн, БХК (б) Н-ын энэхүү зорилт 1928 оны эцэст болсон МАХН-ын VII их хурал, Улсын IV Их Хурлаар бүрэн хэрэгжжээ. Монгол дахь төрийн эргэлтийн мөн чанар нь ардчилсан шинж төрхийг олж байсан улс төрийн засаглалаас тоталитар дэглэмд, иргэдийн дийлэнх олонхийн эрх ашиг, сонирхлыг хамгаалахаас хүн амын зөвхөн зарц, ядуу хэсгийн ноёрхлыг тогтоон дээдлэхэд, төлөвшиж байсан зах зээлийн эдийн засгийн харилцаанаас төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоонд, олон ургалч үзлээс дан ганц хувьсгалт үзэл суртлын ноёрхолд шилжсэн явдлаар тодорхойлогдож байв”²²⁶. “... Үүний уршгаар Монгол орон нийгэм-эдийн засгийн гүнзгий хямралд орсон бөгөөд тэр нь богино хугацаанд улс төрийн хямрал болон хувирч, <<төр засгийг>> эсэргүүцсэн ард олны бослого, хөдөлгөөн орон даяар гарсан билээ. Ийм нөхцөлд 1932 оны дунд үеэр эрх баригч намын болон Улсын Бага хурлын онц хуралдаануудын шийдвэрээр Монгол оронд социализм байгуулах практик үйл ажиллагаанаас эрс шууд татгалзаж, <<шинэ эргэлтийн бодлогыг>> хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн билээ. ... Гэвч 1930-аад оны эцэст ЗХУ-аас Монголд экспортолсон улс төрийн хэлмэгдүүлэлтийн уршгаар ардчиллыг сэргээн хөгжүүлэх үйл явц бас л тасран зогссон билээ. Улс төрийн хэлмэгдүүлэлтийн үр дүнд Монголд нэг хүний дарангуйллын авторитари дэглэм тогтож, ЗХУ-ын нөлөөний хүрээнд БНМАУ баттай орсон байна. Монгол орон дахин социалист байгуулалтын туршилтын талбар болж хувирсан билээ” гэж зохиогч дүгнэн бичжээ²²⁷.

Дээр иш татаж дурдсан Ч.Дашдаваагийн үзэл санаанд бусад эрдэмтдийнхээс ялгаатай хоёр зүйлийн санал байгаагийн нэг дэх нь тэрбээр манай оронд тоталитар дэглэм 1928 оноос бүрэлдэн тогтож эхэлсэн гэж үзсэн явдал юм. Энэ нь цаашдаа нягтлан судлуулж, дэмжүүштэй санал юм гэж бодогдож байгаагийн зэрэгцээ эл асуудлыг судласан манай олон эрдэмтэн тоталитар дэглэм тус оронд 1930-аад оны эхэн үеэс (1933 оноос) бүрэлдэн тогтох болсон гэж үзсэнийг бид дээр өгүүлсэн билээ. Профессорын бусдынхаас ялгаа зөрөөтэй хоёр дахь өөр санал бол тэрбээр 1930-аад оны төгсгөл үеийн дэглэмийг тоталитар биш, харин нэг хүний дарангуйллын авторитар дэглэм гэж үзсэн санал юм. Гэтэл дээр нэр зааж бүтээлийг нь авч үзсэн эрдэмтдийн олонх нь эл үеийн дэглэмийг тоталитаризм гэж үзжээ. Энд анхаарч тэмдэглэвэл зохих өөр нэг зүйл бол Ч.Дашдаваа 1930-аад оны улс төрийн хэлмэгдүүлэлт бол ЗХУ-аас Монголд экспортогдсон үзэгдэл бүхий үйл явдал гэж тодорхой нэрлэж заасан нь доктор Д.Өлзийбаатар болон бусад зарим эрдэмтний үзэл санаатай нийтлэг байна.

²²⁴ Хорьдугаар зууны Монгол. (Түүхийн тойм) УБ., 1995, 96 дах тал

²²⁵ Монгол Улсын түүх. Тавдугаар боть (XX зуун). УБ., 2003, 265-267 дах тал

²²⁶ Дашдаваа Ч. Монгол дахь төрийн эргэлт. УБ., 2008, 354-355 дах тал

²²⁷ Мөн зохиол. 361-362 дахь тал

Профессор Ч.Дашдаваа 1920-1930-аад оны зааг үеийн монгол дахь тоталитаризмын тухай дээрх үзэл санаагаа мөн 2008 онд нийтлэгдсэн “Монгол Улсын хөгжлийн бодлого, үзэл баримтлал: хувьсал, өөрчлөлт” (XX зуун) гэсэн хамтын томоохон бүтээлд бичсэн бүлэгтээ хэд хэдэн зүйлээр тодотгож нэлээн дэлгэрүүлж тавьсан байна. Энд тэр бүгдийг авч үзэх аргагүй тул эрдэмтний үзэл санааны агуулга, логикийг товчилон өгүүлж, дүгнэлтийн чанартай заримыг нь иш татъя.

Зохиогч бичсэн бүлэгтээ Коминтерн, БХК (б) Намаас Монголд тулгасан социализм байгуулах үйл явц нь тус орны улс төрийн тогтолцоонд сөргөөр нөлөөлсөн, тухайлбал, Улсын V их хурлаас (1928. XII-1929.I) “тус улсад жинхэнэ ардын дарангуйлан захирах хатуу засаг тогтоох” шийдвэр гаргасан, улс төрийн тогтолцоонд МАХН-ын эзлэх байр суурь хүчтэй болж намын байгууллагууд төр засгийн үйл ажиллагаанд хутгалдан оролцож захиран тушаагч байгууллага болж хувирсан, нам олон түмнийг зохион байгуулах, ухамсарлуулан итгүүлэх бус харин захиран тушаах, албадан хавчих, кампаничлах арга барил голлох болсон зэргээр бүхэлдээ <<төржсөн нам>>-ын шинж төрхтэй болж улмаар гүйцэтгэх ёсгүй үүргийг хэрэгжүүлэхийг оролдох болсноор Үндсэн хуулийн заалтыг зөрчих, ард олны эрх чөлөөнд халдах, хүмүүсийг үндэслэлгүй баривчилж шоронд хорих явдал багагүй гарсныг авч үзжээ ²²⁸.

Зохиогч үүний үндсэн дээр: “Дээр дурдсан зүйлүүд нь Монгол оронд улс төрийн диктатурын нэг хэлбэр тоталитар дэглэм тогтсныг илэрхийлэн харуулж байв. Хэрэв авторитар дэглэмийн нөхцөлд нийгэм нь төрөөс тодорхой хэмжээнд автономи шинжтэй оршин тогтож, эдийн засаг, оюуны амьдрал болон хувь хүмүүсийн хоорондын харилцааны салбарт тэр бүр хутгалдан оролцдоггүй бол тоталитар дэглэмийн үед нийгмийн амьдралын бүх хүрээнд ноёрхлоо тогтоодог ажгуу. Үүнийг тухайн үеийн Монголын нийгмийн амьдралын нөхцөл байдал ч нотолсон билээ. Дарангуйлагчийн үүргийг нам, төрийн удирдлагад олонх болсон <<зүүнтнүүдийн>> эрх баригч элит бүлэг Коминтерний шууд дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байв. ... Улс төрийн тогтолцоонд намын ноёрхол голлосон, Үндсэн хууль болон аливаа хууль ёсыг баримтлахыг үгүйсгэсэн, засаглал хуваарилалтын зарчмыг хөсөрдүүлсэн, олон ургальч үзлийг нийгэм-улс төрийн үзлээс шахан зайлуулсан, анги, бүлгүүд, давхраадын ашиг сонирхлыг гаргуунд нь гаргасан, төрийн байгууллагуудын үүргийг бууруулан, оронд нь нам, олон нийтийн янз бүрийн байгууллагуудын интеграцийг бий болгож тоталитар дэглэмийн өвөрмөц хэрэгсэл болгон хувиргасан, залхаан цээрлүүлэх аппаратын үүргийг үлэмж дээшлүүлж, хүчирхийлэлд тулгуурлан засаглалын легитим шинжийг хадгалахыг оролдож байсан, хувь хүний эрх, эрх чөлөөг хааж боогдуулсан зэрэг нь Монголд тогтсон тоталитар дэглэмийн үндсэн шинж төлөв болж байв” гэж дүгнэн бичсэн байна ²²⁹. Дээрх бүтээлүүдээс үзвэл профессор Ч.Дашдаваа авторитар ба тоталитар дэглэмийн мөн чанарын ялгаа, онцлогийг илэрхийлэн гаргаж, манай оронд 1920-иод оны сүүлч үед тоталитар дэглэм тогтсон хийгээд түүний нийтлэг ба онцлог шинжийг авч үзсэн нь түүний судалгаа, дэвшүүлэн тавьсан үзэл санаа, дүгнэлтийн үнэ цэнэ юм.

Академич Ж.Болдбаатар, профессор Ч.Дашдаваа нар XX зууны Монголын улс төрийн түүх, түүний дотор улс төрийн дэглэмийн асуудлыг байнга анхаарч тус бүр судалж ирсний зэрэгцээ мөн хамтарч “Шинэчлэлийн төлөө хөдөлгөөн, түүний хувь заяа” (1952-1966) гэсэн нэгэн сэдэвт хамтын бүтээлийг 2005 онд нийтлүүлжээ. Тэд эл бүтээлийн зорилгыг: “...бидний судалгааны зорилго нь 1952-1966 оны үе бол нэг талаас, социализмын хүрээнд ардчилал, шударга ёсыг тогтоохыг эрмэлзэгчид, нөгөө талаас захиран тушаах тогтолцоог үргэлжлүүлэн багатах талыг баримтлагчдын хоорондын үзэл санааны зөрөлдөөн, тэмцлийн үе байсныг харуулахад оршино. Үүнд: ... Монголд тоталитар дэглэм, номенклатурчдын анги бүрэлдсэн явц, учир шалтгаан, үр дагаварыг шинжлэн үзэх зорилт тавьсан болой” гэж заажээ ²³⁰.

Тэд энэ дагуу архивын сан хөмрөгийн олон эх материал, бусад баримт мэдээг шинжилсний үндсэн дээр нэг хүнийг тахин шүтэхийн хор уршгийг арилгах, монголын нийгмийг сталинизмын ноёрхлоос чөлөөлөх үзэл санааг баримтлагчид болон Ю.Цэдэнбал, түүнийг хүрээлэгчдийн хоорондын тэмцэл 1950-иад оны эхнээс 1960-иад оны дунд үед арав гаруй жил үргэлжилж, хуучныг баримтлагчдын ялалтаар төгссний улс төрийн үр дагавар болж тоталитар дэглэм тогтсон гэж дүгнэн үзээд ²³¹ түүний үзэл суртал, улс төр, нийгэм, зохион байгуулалт, эдийн засгийн үндэс хийгээд гол шинж, агуулгын талаар: “1960-иад оны дунд үе гэхэд монголын нийгмийн амьдралд социализмын сталинч загвар биежсэнээр нийгмийг бүхэлд нь төвлөрсөн удирдлагын хөшүүн хойрго тогтолцоонд захируулж, нэг хүнийг тахин шүтэх шинэ маягийн хэлбэр - Ю.Цэдэнбалыг үг дуугүй аялдан дагалдах явдал нам, төр засгийн дээд удирдлагын үйл ажиллагааны эгэл хэм хэмжээ болжээ. ... Ю.Цэдэнбал улс орны хөгжлийн үндэсний бөгөөд өвөрмөц шинжтэй илүү ардчилсан хувилбар эрэлхийлсэн шинэ сэтгэлгээ бүхий хүмүүсийг үзэл бодлын нь хувьд нухчин дарж, намын удирдлагаас шахан зайлуулснаар ганцаар захирах дэглэмийг 1960-иад оны дунд үе гэхэд бүрэн тогтоож чаджээ. Энэхүү дэглэмийн гол шинж нь төржсөн намын хязгааргүй ноёрхол, үзэл суртлын догмагизм буюу ЗХУ, ЗХУКН-ыг сохроор даган дууриах явдал, албан тушаалын өмчлөл болж байв” гэж дүгнэн бичжээ ²³².

Эрдэмтдийн эл хамтын бүтээл нь манай оронд тогтож байсан тоталитар дэглэмийн асуудлыг түүний аль нэг түүхэн тодорхой үеэр нь нарийвчлан судлахын үлгэр жишээг харуулсан эрдэм шинжилгээний чухал бүтээл болжээ гэж үзэж байна.

²²⁸ Монгол Улсын хөгжлийн бодлого, үзэл баримтлал: хувьсал, өөрчлөлт (XX зуун). Зохиогчид: Ж.Болдбаатар, Ч.Дашдаваа, Г.Дашням, Ж.Болд, Ч.Баянжаргал, С.Туяа, Б.Баттөмөр. Хянан нягталсан: Г.Чулуунбаатар, Ч.Баянжаргал, Н.Хишигт. УБ., 2008, 115-116 дах тал

²²⁹ Мөн зохиол. 116 дахь тал

²³⁰ Болдбаатар Ж., Дашдаваа Ч. Шинэчлэлийн төлөө хөдөлгөөн, түүний хувь заяа (1952-1966). УБ., 2005, 5-6

²³¹ Мөн зохиол. 249 дэх тал

²³² Мөн зохиол. 236 дахь тал

Манай орны нэлээд эрдэмтэн 1950-иад оны эхэн үеэс 1990 он хүртэлх хугацаанд тус оронд тогтож байсан улс төрийн дэглэмийг авторитаризм гэж үздэг бол Ж.Болдбаатар, Ч.Дашдаваа, Д.Дашдулам болон бусад нэлээн эрдэмтэн 2005 оноос хойшихи бүтээлүүдэд тоталитар дэглэм гэж үзсэн нь дээр авч үзсэн ном зохиолуудаас тодорхой харагдаж байна. Ийм үзэл санааг Ч.Дашдаваа Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн асуудлаар Төрийн ордонд 2005 онд зохиогдсон эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэлээ тус хурлын материалын эмхтгэлд нийтлүүлэхдээ улам бүр тодруулж: "... 1960-аад оны дунд үе болоход Монгол оронд тоталитар шинж бүхий улс төрийн дэглэм бүрэлдэн тогтжээ. ... Гэвч энэхүү тоталитар дэглэм 20 орчим жил л оршин тогтнох тавилантай байсан ажээ. 1980-аад оны дунд үеэс Монгол оронд өөрчлөн байгуулалтын үйл явц эхэлж, улмаар 80-90-ээд оны зааг үеэс ардчилсан хөдөлгөөн монголын нийгмийг бүхэлд нь хамарч, 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулиар Монгол орон ардчилсан орон болж хувирсан билээ" гэж бичжээ²³³.

Монгол Улсад 1990 онд эхэлж хэрэгжсэн ардчилсан язгуур шинэчлэлээр нийгэм, улс төрийн социалист байгуулал халагдаж, улмаар монголын нийгмийн түүх, бодит байдлыг ойлгон тайлбарлаж ирсэн марксист үзэл суртал, онолын догматик сэтгэлгээ хүч нөлөөгөө алдаж хэрэглэгдэхгүй болсноор тус орны түүх, түүний дотор XX зууны улс төрийн түүх, оршиж ирсэн улс төрийн систем, дэглэмийг шинэ сэтгэлгээгээр, үнэн бодитойгоор судлан шинжлэх нөхцөл бололцоо бий болжээ. Манай нийгмийн ухааны эрдэмтэд үүний дагуу эдгээр асуудлыг чухалчлан судалж эдүгээ хүртэлх хугацаанд олон бүтээл нийтлүүлэн гаргажээ. Тэдгээр нь одоо эргээд нийгмийн сэтгэлгээний түүх бичлэгийн бие даасан судалгааны объект болж байна. XX зууны Монгол дахь улс төрийн дэглэмийн асуудлыг манай философич эрдэмтэд, улс төр судлаач, социологчид зохих хэмжээнд судалжээ. Тэгэхдээ эл чиглэлийн судалгаанд түүхч эрдэмтэд илүү их идэвх зүтгэлтэй оролцож, олон чухал бүтээл гаргажээ. Тэдний судалгаа түүхэн бодитой үйл явдал, архивын арвин их баримт материалд шинжилгээ хийх үндсэн дээр хийгдснээр, гол зорилго, агуулгаараа XX зуунд манай оронд тогтож ирсэн улс төрийн дэглэм, түүний үндсэн шинж, хувьсал өөрчлөлтийн үйл явцыг бүхэлд нь зураглан гаргаснаараа шинжлэх ухааны үнэ цэнэтэй, судалгаа – танин мэдэхүйн ач холбогдолтой байна.

НОМ ЗҮЙ

1. Атар Ю. Монголын улс төрийн системийн төлөвшлийн онцлогийг судлах нь (Системийн онолын загвараар) Хөх хот, 2005
2. Цанжид А. Монгол Улсын Үндсэн хуулийн онолын үзэл баримтлалын тухай зарим асуудал. – Шинэ толь. – 1999, №4 (28)
3. Морен Э. О природе СССР: Тоталитарный комплекс и новая империя. Перевод с французского. М., 1995
4. Лхам И. К.Попперийн <<нээлттэй нийгэм>>-ийн үзэл санаа ба нийгмийн ардчилсан үйл явц (Философийн шинжилгээ). УБ., 2001
5. Болд –Эрдэнэ Д. Монгол дахь тоталитаризм: үүсэл бүрдэлт, үе шат, онцлог. – Шинэ толь. – 2007, №2 (59)
6. Гүндсамбуу Х. Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага (XX зуун). УБ., 2002
7. Болдбаатар Ж., Дашдаваа Ч. Шинэчлэлийн төлөө хөдөлгөөн, түүний хувь заяа (1952-1966). УБ., 2005
8. Тамир Ч. Улс төрийн Товчооны гишүүдийн хэв маяг, социал төрх (1940-1990 он). – “Политологи” сэтгүүл. – 2009, №4 (50)
9. Тамир Ч. Монголд тоталитар дэглэм тогтоход институцийн (дүрмийн) гүйцэтгэсэн үүрэг. – “Политологи” сэтгүүл. – 2010, №6 (58)
10. Дашдаваа Ч. Монгол дахь төрийн эргэлт. УБ., 2008
11. Монгол Улсын түүх. Тавдугаар боть. (XX зуун). УБ., 2003
12. Дашдаваа Ч. Монгол дахь ардчиллын түүхэн уламжлалын асуудалд. – Монгол Улсын ардчилсан хөгжил ба Үндсэн хууль (Эрдэм шинжилгээний бага хурал. Илтгэлүүд. 2005 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр). УБ., 2005
13. Монгол Ардын Намын түүх (1946-1953). V боть. Зохиогч: П.Дэлгэржаргал, Р.Төрдалай, Ж.Болдбаатар. УБ.,
14. Монгол Ардын Намын түүх (1954-1965). VI боть. Зохиогч: Ж.Болдбаатар, Д.Дашдулам. УБ., 2011
15. Монгол Улсын түүх. Тавдугаар боть (XX зуун). УБ., 2003

²³³ Дашдаваа Ч. Монгол дахь ардчиллын түүхэн уламжлалын асуудалд. – Монгол Улсын ардчилсан хөгжил ба Үндсэн хууль (Эрдэм шинжилгээний бага хурал. Илтгэлүүд. 2005 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр). УБ., 2005, 48-56 дах тал

ЦАГААН ТҮҮХИЙН ТАЛААРХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ СУДЛАХ ОНОЛ, АРГА ЗҮЙ

Ц.ГАНБОЛД

*Профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхим*

Л.ИДЭР

Улс төр судлалын тэнхимийн докторант

Түлхүүр үг: Төр, хоёр ёсны сургаал, Төрт ёс, Цагаан түүх

Хураангуй: Манай Монгол улс бол төр засаглалын өнө эртний уламжлалтай орон билээ. Төр бол хүний нийтлэгийн амьдралыг зохицуулах, зохион байгуулах арга хэлбэр бөгөөд нийгмийн амьдралын амин чухал хэрэгцээ шаардлагаар буй болсон, соёл иргэншлийн үнэт зүйл мөн ажээ.

Монголчууд эртнээс нааш төрийн өөрийн бүрдлийг бий болгож улам боловсронгуй болгож төлөвшүүлж ирсэн түүхэн уламжлалтай ард түмэн билээ. Түүхээс үзвэл МЭӨ III зууны үед мандсан Хүннү улс нь өөрийн нутаг дэвсгэртэй, хил хязгаартай, өөрийн хүн амтай, хаантай, аравтын ёсыг үндэс болгосон, нутаг орноо захирах тогтолцоотой, дайчин гавшгай морьт цэрэгтэй, хууль цаазтай, бие даасан гадаад харилцаатай, улс хэмээх нь байтугай эдүгээ гүрэн хэмээн яригддаг төрийн том бүрдэл байсан байна. Монголын түүхэн сурвалжуудад төр барих үлгэр жишээ гэмээр олон зарчим, үйл явдлыг тусгасан байдаг нь бид түүнийгээ онол арга зүйн хувьд судлах, уламжлуулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Abstract: Mongolia is an historic country in governmental experience. The government is a system by which a community is coordinated or controlled. It is a civilizational value which is created by vital necessities of a community.

Mongols are historic nation which have built their own state and cultivated it since ancient time. Ancient sources reports that Xiongnu which became a dominant power was supposed to a nomadic political confederation which had its own monarch, people, territory, administration based on the decimal system, aggressive horse cavalry, legislation and foreign relations. Present day Mongols have to study and use our historic governmental experience as a doctrine because Mongolian sources report that many principles and experience in governing properly.

Улс төрийн сургаалийн түүх бол хүн төрөлхтөний нийгмийн сэтгэлгээний хөгжлийн салшгүй чухал хэсэг мөн. Улс төрийн сургаалийн түүх нь тухайн үеийн ард түмэн, түүний дотроос төрж гарсан сэтгэгчдийн зүгээс улс төрийн бодлого, төр засаглал, нийгмийн анги, бүлгүүдийн эрх ашиг, эрх, эрх чөлөө, шударга ёс, ардчилал, дарангуйлал, хууль цааз, улс орнуудын хоорондын харилцаа, дайн ба энх зэрэг улс төрийн үзэгдлүүдийг ухааран ойлгох, танин мэдэх, талаар гаргасан оролдлого, чармайлтын үр дүн болж бүрэлдэж боловсрогдсон мэдлэг үзэл санаа, сургаал номлолыг өөрөө агуулна. Хожмын үеийнхэн өөртөө тулгарсан улс төрийн онол, танин мэдэхүйн болон практикийн шинэ асуудал зорилтыг шийдвэрлэх оролдлого хийхдээ өнгөрсөн үеийн улс төрийн сургаалийн түүх рүү эргэн харж түүнээс ухаарал олж, сургамж авдаг. Энэ талаар манай оронд баялаг бөгөөд чухал туршлага хуримтлагджээ.

Бид энэ баялаг туршлагаас суралцах шаардлагатай байна. Монголын улс төрийн сурталгээний асуудлыг Ч.Жүгдэр, Феодализм тогтох үеийн монголын гүн ухаан, нийгэм улс төрийн сэтгэлгээ /Эртнээс XIV зуун/ УБ., 1987 он, Ч.Жүгдэр, XV-XVIII зууны нийгэм- улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн түүхэн тойм УБ., 1984 он, Ч.Жүгдэр, XIX-XX зууны зааг дахь монголын нийгэм- улс төр, философи сэтгэлгээний хөгжил УБ., 1972 он, Монголын философийн түүх, I дэвтэр, УБ., 1997 он, Монголын философийн түүх, /XIII-XVIII/ II дэвтэр, УБ., 2000 он, Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил /мэ III- мэ XX зуун/ I, II боть УБ., 1995 он зэрэг бүтээлүүдийг дурдаж болно. Тэдгээр нь монголын улс төрийн сэтгэлгээний талаар түүхэн үзэгдлийг судалж танин мэдэх, онолын үүднээс нэгтгэн дүгнэхэд жинтэй хувь нэмэр болсон байна. Нийгмийн сэтгэлгээний тодорхой үед нийгмийн аль нэг үзэгдэл, асуудлыг судалж бичсэн зохиол бүтээл цаг үе улиран өнгөрсний дараа өөрөө эргээд судлагдахуун болж тухайн сэтгэлгээний түүхийн асуудал болж тавигддаг байна. Энэ нь ялангуяа нийгмийн ухаан, тэр дотор философи, социологи, улс төрийн шинжлэх ухаанд нийтлэг тохиолддог ажээ.

Энэчлэн монголын улс төрийн сургаалийн талаархи хийгдсэн судалгаа, түүний үр дүн болж, нийтлэгдсэн томоохон суурь бүтээлүүдийн онолын үзэл санаа, арга зүйн баримтлал, дүгнэлтийг улс төрийн сэтгэлгээний түүхийн үүднээс эргэн харж судлах хэрэгцээ шаардлага чухлаар тавигдаж байна. Өнөө үед монголын төрийн талаар бий болсон үзэл санаа, сэтгэлгээг үеэ өнгөрөөсөн хуучин ач холбогдолгүй гэж үзэх биш, харин ч түүнийг ухааран ойлгож архив, түүхийн олон чухал баримт материалд тулгуурлан онол арга зүйн шинэ түвшинд гаргаж цааш нарийвчлан судлах, түүний үндсэн дээр төрийн талаарх онолын үзэл баримтлалыг баяжуулах хэрэгтэй байгааг сүүлийн улс төрийн амьдрал харуулж байна. Энэ талаар судалгаа хийх, түүний дотор монголын төрийн уламжлалын асуудлаар өнөө хүртэл олон арван жилийн туршид бий болсон үзэл баримтлалуудыг нэгэн цогц асуудал, судлагдахуун болгож улс төрийн сэтгэлгээний түүхийн үүднээс шинжлэх явдал чухал ач холбогдолтой болно. Хүмүүсийн үйлдвэрлэн бүтээх үйл ажиллагаа материаллаг харилцаанаас гадна түүний тусгал болсон нийгмийн оюун санааны тал гэж байдаг бөгөөд үүнд: төр улс, үзэл суртал, зан заншил зэрэг үзэл санаа онолын цогц багтана.

Эдгээр нь нийгмийн ухамсрын хэлбэрүүд бөгөөд нийгмийн ахуйн янз бүрийн талыг тусгадаг байна. Монголын төрт ёс түүхэн уламжлал нь төр оршин тогтож ирсэн үеийг хамаарах хугацааны хувьд ихээхэн урт олон зууныг багтааж байгаа учраас дагнаж төрт ёс болоод улс төрийн сургаал талаас нь судалсан зүйл хомс тул харин түүнийг товч боловч авч үзэж тайлбар тодотгол хийж бага боловч санаа гаргахыг эрхэм зорилго болголоо. Монголын төрт ёсны уламжлалыг философи, түүх талаас нь авч үзсэн боловч улс төрийн сургаалийн түүх талаас нь онцлон судласангүй. Иймд тэр үеийн төрт ёсны түүхэн уламжлалын зарим зүйлийг тодруулахыг хичээв.

Монгол гүрний үед монголоор бичсэн түүх, төрт ёсны шинжтэй <<цагаан түүх>> гэгч зохиол нь XVI зууны үед нэмэн засварлагдсан байх боловч XVI зууны үеийн Монгол улс төрийн байгууллагын тухай баялаг хэрэглэгдэхүүнийг цагаан түүхийг зохиогч <<хоёр ёсон>> буюу хан төр, шашин хоёрын тухай эртний Энэтхэгийн буддын онол сургаалийн түүх бичлэгт тулгуурлан зохиожээ. Монгол төр ёсны, улс гүрний оршин тогтносон эх сурвалж бүхий дурсгалт бичиг зүйлүүд нилээдгүй байгааг түүхчид тогтоон тайлбар хийсэн байна. Үүнд: 1959 оны эхээр Өвөрхангай аймгийн орон нутгийг судлах музейн даамал мөн аймгийн Хүн хүрээгийн голын хойд хөвөөнд байдаг <<Шаазан толгой>> гэдэг хуучин цагийн хотын ор үлдэц дээрээс нэгэн хүрэл тамга олжээ. Ийнхүү энэ тамга бол төрийн зохион байгуулалт нэлээдгүй цэгцэрсэн нийгмийн харилцааг зохицуулж байсны баталгаа болно.

Монголын төрт ёс түүхэн уламжлалыг улс төрийн сургаалийн түүх талаас нь судлах явдал нэн анхаарал татаж байна. Энэ асуулыг авч үзсэнээр, Монголчуудын төр ёс уламжлалыг өөрийн орны өвөрмөц нөхцөл байдалд тулгуурлан хөгжүүлэх хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм. Монголын улс төрийн үйл явцыг задлан шинжилгээ хийж нэгтгэн дүгнэх ажлуудыг хийлээ. Монголын төрийн түүх, философи, эдийн засаг, соёлын асуудал тодорхой хэмжээгээр судлагдсан боловч харин улс төрийн сургаалийн чиглэлээр харьцангуй бага судлагдсан байна. Монголын төрийн түүхэн уламжлалын асуудлыг хөгжлийн явцад нь авч үзэж, түүний бүтэц, шинж, агуулга, онцлогийг судлан улмаар улс төр сургаалийн үүднээс авч үзсэн анхны оролдлого юм. Монголын төр хийгээд улс төрийн бодлого нь монголын улс төрийн түүхийг судлахад чухал хэрэглэгдэхүүн болж чадна. Тэгээд ч Монголчууд бол Төв Азийн олон улс дотроос харьцангуй эрт үеэс төрт ёсыг бий болгож төрөө энх амгалан уламжлуулж ирсэн байдаг.

Монгол улсын үндсэн хуулинд: <<Төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөх>> талаар чухалчлан заасан билээ. Монголын төр засаглалын өндөрлөгүүд (Ерөнхийлөгч, Улсын их хурал, Засгийн газар, Шүүх) төрт ёсны уламжлалыг шинэ нөхцөлд хэрэгжүүлэхэд анхаарч байна. Энэ бүхэн нь Монголын төрийн түүхэн уламжлал, шинэчлэлийн асуудал, төрт ёс, улс төрийн сургаалийн түүхийг гүнзгий ойлгож, судлах эрмэлзлэлийг өсгөв.

Монгол газар, нутагт 800 мянгаад жилийн тэртээ хүмүүс амьдран сууж, хоёр мянган жилийн өмнө төр ёс тогтсон билээ. VI-IX зууны үеэс тус оронд улс байгуулан засаглаж явсан Түрэг угсааны халааг Монголчууд авсан бөгөөд энэ нь язгуурын Монголчууд тэргүүтэй Монгол туургатны засаглалын шинэ үе эхлэхийн угтал болжээ. XI-XII зууны үед Хамаг Монгол нэртэй улс үүсэн бэхжиж түүнд түшиглэн нийт эсгий туургатныг нэгтгэн захирсан нь Монголын нийгмийн хөгжлийн шаардлагаас урган гарсан түүхэн үзэгдэл бөгөөд энэ нь чухамдаа Хамаг Монголчууд бол 1206 онд Монголын нэгдсэн тулгар төр улсын үндсэн гал голомт, тулах хүчин байжээ гэсэн санааг нотолж байгаа юм.

Эдүгээ Монгол улс өөрийн гэсэн онцлог төр ёсны бодлого явуулахыг шаардаж байна. Энэ үед Монгол төрийн түүхэн уламжлал шинэчлэлийн асуудал, төрт ёсыг гүнзгий ойлгох, танин мэдэх явдал юу юунаас ч чухалчлагдах болов. Монголын төрт ёсны түүхэн уламжлалаас үзэхэд Монгол нутаг дээр тогтож байсан Монгол угсаатны улсууд төрийн хэлбэр байгууламжийн хувьд нэгдмэл төвлөрсөн улсууд байдаг бөгөөд Хүннүгээс эхлэн улсаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваариар баруун, зүүн гар, төв хэсэг гэж гурав хуваан захирч байжээ. Энэ нь түүний дараа гарч ирсэн Сяньби (мэ I-III зуун), Нирун (330-555) зэрэг улсуудад уламжлагдаж улмаар 1206 онд Монголын нэгдсэн төр улс байгуулагдахад залгамжлагджээ.

Ер нь Монголын төрт ёсны түүхэн уламжлалыг хадгалсан түүх архивын баримт бичигт орсон зүйл, бусад мэдээллээс эхлээд эрдэмтэн, мэргэд түүхч нарын тэмдэглэл, <<Арван буянт номын цагаан түүх>> зэрэг олон арван материал нь Монголын төрт ёсны түүхэн уламжлал, улс төрийн түүхийг судлахад чухал ач холбогдолтой. Монголын улс төрийн түүхийг судлахад Монголын эртний эх сурвалжаас гадна монголын түүх уран зохиолын дурсгал бичиг, эрдэмтдийн олон арван бүтээл байгаа нь зүй ёсоор анхаарал татсан юм.

В.Инжинаши, Лувсанданзан, Саганцэцэн, заваа Дамдин, Д.Равжаа, Рашипунцаг, Дандаа хэмээх Дэмчигдорж, Б.Цэрэндорж, А.Амар, Б.Ринчен, Ш.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, Х.Пэрлээ, Н.Сэр-Оджав, Н.Ишжамц, Д.Гонгор, А.Майдар, Д.Наваан, А.Дамдинсүрэн, Г.Сүхбаатар, Ч.Далай, философи, улс төр судлаач эрдэмтэн Болд-Эрдэнэ, Д.Лүндээжанцан, А.Цанжид, Ц.Ганболд, А.Юндэндорж, С.Базарпүрэв, Г.Цэнд-Аюуш, Ж.Төртогтох, Ц.Батболд нарын зэрэг эрдэмтэд төр ёсны уламжлал, шинэчлэлийн талаар чухал мэдээ, тайлбар, дүгнэлт санал дэвшүүлжээ.

Гадаадын олон эрдэмтэд Монголын төрт ёсны түүхэн уламжлал, улс төрийн түүхийн эх сурвалжийг анхааран судалсан байна. Тухайлбал түүхч Марко Поло, Жувеини, Пано Карпини нар өөрсдийн зохиол бүтээлдээ: Монголын төрт ёсны түүхэн уламжлалын тухай түүхчлэн бичсэн бол Макриз, Рашид-Адин нар монголын төр ёсны дурсгалыг авч үзжээ. Эдгээр түүхч эрдэмтдийн зохиол бүтээлд үндэслэн монголын төрт ёсны талаар эрдэмтэн Б.Я.Владимирцов, Л.Л.Викторова, А.Б.Рязановский, Л.Н.Гумилев, Л.И.Думан, К.Ф.Голстунский, Сайшаал, И.С.Урбанаева, Х.Футаки, Г.Сүхбаатар, Ц.Доржсүрэн, Х.Пэрлээ, Ш.Нацагдорж, Н.Ишжамц нар түүх, төр ёсны талаар авч үзэж судласан байна. Тэдгээрт хууль дээдлэх ёс, төрийн эрх мэдэл хуваарилах, улс төр, төрт ёсны уламжлал, шинэчлэлийн талаар тодорхой асуудал дэвшүүлсэн байна.

Гэвч Монголын төрт ёсны түүхэн уламжлалын авч үзсэн хэдий ч улс төрийн сургаалийн чиглэлээр судалж бичсэн бүтээл бараг үгүй байна. Тиймээс эдгээр эх сурвалжууд дээр тулгуурлан улс төрийн сургаалийн түүхийн гол зүйлийг түүвэрлэн задлаж нэгтгэн дүгнэхийг зорьсон юм. Монголын төрийг үйл явцыг улс төрийн сургаалийн түүх талаас нь авч үзэх нь гэсэн нь миний зорилго билээ. Эл судалгаа нь Монголын төрт ёсны түүхэн уламжлал, шинэчлэлийн үр нөлөө бүхий сонирхолтой арга хэлбэрээр, хөгжлийн онцлогийг гаргаж нэгтгэн дүгнээд энэ чиглэлийн судалгааг цаашид өргөжүүлэх онол, практикийн чухал асуудлыг хөндөж байгаа юм. Монголын төрт ёсны түүхэн уламжлалаас үзэхэд, тэдгээр нь эртний Монгол нутагт оршиж байсан улс гүрний хөгжил, мандал, мөхөл, дахин сэргэлт, өөрчлөлтийг тусгахын зэрэгцээ нийгмийн харилцааг зохицуулж ирсэн хэв хууль, зан заншил, ёс суртахууны хэм хэмжээнээс эх үүсэлтэй бөгөөд энэ учир тэдгээрийг бататган бэхжүүлж хаан юмуу, эсхүл төрийн хууль засаглалыг гаргаж ирсэн байна. Монгол туургатныг нэгтгэж чадсан эртний засаглал оновчтой тодорхой бөгөөд хүчтэй, өнө удаан хугацаанд үйлчилж ирсэн шинжтэй байна.

Монголын нийгмийн харилцааг зохицуулж байсан ард иргэдийн дунд тэдний зан заншлын харилцааг зохицуулдаг ёс, горим, хэв хууль үйлчилж байсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Чингис хаан:

<<Алд бие мину алжааваас алжаатугай

Ахуй төр мину бүү алдартугай

Бүтэн бие мину зововоос зовтугай

Бүрэн улс мину бүү эвдэртүгэй >> хэмээн сургасан байдаг. Энэ нь төр ёсыг эрхэмлэн өрх гэр, улс орноо гэсэн үзэл санаа хүмүүжлийг хүмүүст төлөвшүүлэхэд чиглэсэн чухал сургаал юм гэдгийг нотолж байна. Монголчуудын төрийн үзэл уламжлал Хүннүгийн үеэс эхлэн дагаж мөрдөж хожим хойшдоо улам боловсронгуй болсоор ирсэн төрөө хүндэтгэх үзэл юм.

Монголчуудын бий болгосон эртний хууль цааз бол Монголчуудын зан заншлын хамгийн нийтлэг хэвшил зуршлыг хөрш суурь болгож, дээр нь овог, аймаг тус бүрийн хэм хэмжээг нэмэн нэгтгэж эцэст нь улсын хэрэгтэй хэм хэмжээг тогтоон засаглалыг хэрэгжүүлж байжээ. Монголчуудын зан заншил, ёс суртахууны охь шилдэг зүйлийг уламжлан авч төрийн зүгээс ёс зүйн болон, эрх зүйн хэм хэмжээг нэгтгэн хуульчилж нийгмийн амьдралд хэрэгжүүлж чадснаараа төрийн засаглал бат тогтвортой байжээ. Үүнээс улбаадан хууль хүндэтгэх, төр ёсыг дээдлэх, үзэл төлөвшиж засаглалыг хэрэгжүүлдэг болжээ. Монголчуудын тэр үеийн төрийн засаглал нь амьдрал ахуйн хэрэгцээ шаардлагад илүү тохирч, ард түмний хүсэл зоригт нийцэж байсан учир өөрсдийнхөө ухамсар бишрэлээр төрийг шүтэн дээдэлсээр иржээ. Үнэхээр Монголчуудын төр ёсны үзэлд шашны суртахууны хорио цээрийг ашиглаж, хууль ёсны баталгаатай болгодог байсан уламжлал байна. Монголчууд ийнхүү уугуул, нутаг усаа эзэгнэж төрийн уламжлал, ёс заншлаа хадгалж, нүүдлийн мал аж ахуйгаа эрхэлсээр иржээ. Монголчуудын төрт ёсны уламжлалын онцлог нь нүүдлийн мал аж ахуйн асуудлыг тусгасан үндсэн шинжтэйгээс гадна төр улсаа удирдах, иргэд ардаа захирах, агуулгатай байсан нь түүний нэг онцлог юм.

Монгол төрийн бодлого нь хойш хойшдоо уламжлагдан шинэчлэгдэж хөгжихийн зэрэгцээ өөрчлөгдөн гээгдэх зэрэг хөгжлийн урт удаан хугацааны явцад улам бүр дэвшилттэй болсоор иржээ. Тухайлбал нэг хэсэгтээ мөнх хөх тэнгэрийг шүтэж бөө мөргөлийг эрхэмлэсэн үзлийг хуульчилж байсан бол Монголын эзэнт гүрний бутралын дараа нэгтгэх агуулгын дор дундад үе (XV-XVI зууны) шарын шашныг дэлгэрүүлж түүний үзлийг хуульчлан бататгаж ирсэн тодорхой баримт байна. Үүнийг 1575 онд гарсан Түмэдийн Алтан хааны үйл ажиллагаа гэрчилнэ. Ийнхүү XIII-XVII зууны Монгол төрийн түүх, хууль ёс өөрчлөгдөн хөгжиж иржээ. Монголын төрт ёсны уламжлалын гол эх сурвалжууд гэвэл Чингис хааны <<Их засаг>>, <<Түмэдийн Алтан хааны цааз>>, Халх Ойрадын <<Дөчин дөрвөн хоёрын их цааз>> Халх журам, 1570 оны Мандахуй цэцэн хатны <<Ойрадын тухай цааз>>, 1570 оны Түмэдийн Алтан хаан Анаадын (1507-1582)<<Шашин төрийн цааз>>, 1558-1593 онд төр барьсан Түмэн засагт хааны <<Засаг цааз>> түүнчлэн <<Арван буянт номын цааз түүх>> нь Монголын төр ёсны уламжлал тодорхой хэмжээгээр тусгагджээ. Эдгээрийн тухай <<Эрдэнийн товч>>, <<Алтан товч>>, <<Шар товч>> зэрэг сурвалж бичигт дурджээ. Ер нь Хүннү, Кидан гүрний үед нийгмийн харилцааг зан заншил, ёс суртахууны хэм хэмжээгээр зохицуулж байсан нь хаадын зарлиг, хад чулуу, хаданд сийлсэн бичиг сэлтээр батлагдана.

Орчин үед хүмүүсийн ухамсар өөрчлөгдөж, төрт ёс түүх соёлоо дээдлэх үзэл бодол өөрчлөгдөж байна. Төрийнхөө хуулийг эрхэмлэн хүндэтгэх, дээдлэн улмаар өөрийн итгэл, үнэмшил болгон ухамсартайгаар хандах дадал зуршилтай болгох асуудал юм. Монгол улсын үндсэн хуульд эрх зүйт төрийн тогтолцоог бүрдүүлэх, иргэдийг хүмүүнлэг энэрэнгүй эрхэм дээд үзэл, Монголын ард түмний олон үеийн шилдэг уламжлал, эх оронч үзлээр хүмүүжүүлэх, төрт ёсоо дээдлэх, үзэл баримтлалыг тунхаглан хэрэгжүүлэхээр заасан юм. Нийгэмд улс төр, үзэл суртал, иргэний гэх мэт олон харилцаа үйлчилдэг. Аливаа нийгэмд өмнөх үеийн уламжлал зан заншил, ёс суртахууны хэм хэмжээ уламжлагдан хөгжсөн байдаг. Тухайлбал, Монгол улсын үндсэн хуульд Монголчуудын эрхэлж ирсэн аж ахуй, уламжлалт зан заншил, шашин шүтлэгтэй холбоотой олон асуудал тусчээ. Монгол улсад <<Төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэн>> гэсэн нь төр нь шашны хэрэг тус тус байж, бие биеэ хүндэлсээр байсны уламжлал юм.

Монголчуудын төр эртний уламжлал хийгээд хүчирхэг улс, ёс журамтай ард түмний шинжийг тод илтгэн харуулдаг юм. Монгол улсад байлдан дагуулахын зэрэгцээ эв эеийг олж, ёс төрийг сахиж ертөнц дэлхийд мандан бадарч байсан. Улс төрийн сургаалийн түүх шинжлэх ухааны үзэл онолын арга зүйг өөрчлөхийг цаг хугацаа, нийгмийн хөгжил шаардах боллоо. Эдүгээ аливаа асуудлыг зөвхөн ганц талаас нь өрөөсгөлөөр авч үзэхээ больж тийнхүү асуудалд шүүмжлэлтэй хандаж, өмнөх үеийн түүх, онол сургаалийг ургуулан судалж байна. Ер нь өнгөрсний тухай ойлголт мэдлэггүйгээр одоог ойлгох, ирээдүйг урьдчилан харах боломжгүй билээ. Төрт ёсны сургаал, төр нийгмийн хөгжлийн асуудлыг авч үзэх нь онол, арга зүйн шинэ асуудал болно.

Эртний Монгол нутаг дээр Хүннү (МЭӨ 209-330) улс байгуулагдан хаан анх удаа бий болон төр, шашин, ёс, заншил уламжлан хөгжиж иржээ. (VI-IX зууны) үед Монгол газар төр улсаа байгуулан зонхилж явсан Түрэг угсааны дараа Төв Азийн түүхнээ язгуурын Монголчууд үүсэх түүхийн шинэ үе эхэлжээ. Гурван голын язгуурын Монгол аймгийн VIII-XIII зууныг хүртэл таван зуугаад жилийн түүхийн үйл явдлаар судлавал VIII-XI зуун буюу эхний гурван зуугаад жилд овог төрлийн байгуулал задарч, шинэ овог аймаг үүссэн нь XI-XII зуун буюу сүүлийн хоёр зуугаад жилд тэдгээр олон овог аймгийг нэгэн жолоонд оруулж нэгтгэн захирах чиглэл хослон өрнөж уул хэрэг явдал XIII зууны эхэнд гүйцэлджээ. XI-XII зууны Монголын нийгмийн бүх хэрэг явдал Хамаг Монгол улсын дотоод зөрчил, Хамаг Монгол ба бусад Монгол аймаг, Ханлигийн хоорондын харилцаагаар шийдвэрлэгдэж байв. Ийм учраас Хамаг Монгол улсыг бэхжүүлэн түүний хүчин бололцоонд түшиглүүлэн нийт эсгий туургатны нэгтгэсэн тулгар төр улс тогтоох нь Монголын нийгмийн хөгжлийн шаардлагаас урган гарсан түүхэн үзэгдэл байсан юм.²³⁴

Хамаг Монголчууд бол 1206 онд Монголын нэгдсэн тулгар төр улсын үндсэн гол мөхлөг, тулах хүчин болжээ. Монголчууд ийнхүү уугуул нутаг угсаа эзэгнэж төрийн уламжлал, ёс заншлаа хадгалж, засаглалаа бэхжүүлж иржээ. Монголчуудын төрт ёсны онцлог нь амьдрал аж ахуйнхаа үндсэн шинжийг тусгаснаас гадна бусад улсын нэгэн адил төр улсаа удирдах, ард иргэдээ захирахад чиглэсэн улс төрийн бодлогыг хэрэгжүүлж иржээ. Ер нь Монголчууд 2000 гаруй жилийн төр, улсын тусгаар тогтнолын түүхтэй. МЭӨ 209 оноос төрийн зохион байгуулалтай Хүннү улс (МЭӨ 209 оноос II зуун) Монгол нутгаар төвлөн байгуулагдаж МЭӨ 198 онд Хятадын хан улстай эрх тэгш гэрээ байгуулж нутаг дэвсгэрийнхээ хилийн заагийг албан ёсоор тогтоож байжээ. Байлдах, найрамдах, их хаан өргөмжлөх, хууль тогтоох зэрэг асуудал хэлэлцдэг том ноёдын их хуралдай байсан нь эзэн хаанд туслах эрх бүхий байжээ. Бас хааны дэргэд чухал хэрэг зөвлөдөг <<сэцдийн зөвлөл>> байсан юм. <<Монголын нууц товчоо>>-нд зарлиг, засаг хэмээх үгнүүд байгаа нь анхаарал татаж байна. Хүннү улс бол Монголчуудын анхны төр мөн. Өөрсдийгөө <<тэнгэрийн хүү>> хэмээн үзэх Хүннү нарын улс төрийн үзэл нь Монголчуудын төрийн нэн эртний уламжлал бөгөөд тэрээр аажимдаа Монголчуудын төрийн шүтлэг <<Төрийн сүлд өршөө>> хэмээн үзэж байсан байна. Эдгээрээс Монголын хамгийн нэртэй нь бөгөөд төр ёсны чухал дурсгал агуулсан түүх бол <<цагаан түүх>> юм. 1206 онд Чингис Их Монгол улсын төрийн тэргүүн улсын их хаан болжээ. Ийнхүү улсын нэрийг албан ёсоор <<Монгол улс>> гэж зарлигаар зарлаад төрийн хаш тамга хэрэглэхээр тогтоож есөн манжлагат их цагаан туг, хар сүлдийг нэгдсэн төрийн туг сүлд, дараа нь 1220 онд Хархорум хотыг улсын нийслэл болгожээ.

Чухам ингэснээр эртний нутагт улс гүрэн оршиж ирсний уламжлалыг дагаж төр улс бий болжээ. Тэгээд эдүгээгийн бидний авч үздэгээр тусгаар тогтносон улсад байвал зохих (улсын албан ёсны нэр, туг сүлд, тамга нийслэл) төрийн онцлогийг зарлигаар тогтоосон нь түүний баталгаа юм. <<Улсын зохион байгуулалт>> төр ёсны хөгжилд хийсэн нэгэн чухал нээлт бол есөн өрлөг сайд, түүнээс дооши олон ахлаху, (черби), хорчи (хишигтэн) нарыг бий болгож <<Го ван>> нэртэй улсын тэргүүн сайд ван өнөөгийн ойлголтоор ерөнхий сайдын албан тушаал бий болгосон нь төрийн зохион байгуулалтын өвөрмөц шинжтэй тухайн үеийн дээд зэргийн аппарат байв. Есөн өрлөг сайд, зарим черби нар улсын ажлын нэг нэг чиглэлийг хариуцах болсон. Өрлөг жанжин Мухлайг Улсын Го ван болгожээ. Улсын тэргүүн сайдын эрх мэдэл нь хожим Булга Чинсон, Чинга Чинсан нарын үед улам өндөрсөжээ.

Энэ үед төрийн бодлого нэлээд төгөлдөржиж боловсорсон гэж үзэх үндэстэй. Манай нэрт түүхч Ш.Сандаг, Н.Ишжамц нарын бүтээл болон сурвалж бичгүүдэд өгүүлснээр улсаа гурван том хэсэгт хуваарилаад Боорчи, Мухулай, Наяа гурван ноёноор захируулж Шихихутгийг <<Улсын заргач>>, Хубилайг бүх цэргийн хэргийг мэдэх болгож, ордны гадаад, дотоод зохион байгуулалт, улсын хуралдай, хурим найр, ав хоморго, дайн байлдааны цагийн ёс журмыг нарийн заасан дүрэм журмууд тогтоож, аливаа асуудалд баримтлах чанд сахилга бат тогтоожээ.

²³⁴ Д.Гонгор. Халх товчоон УБ., 1970, 4 дэх тал

ХIII зууны эхэнд Монголын нэгдсэн төр улс байгуулагдсанаас хойш Монгол улсын нутаг ус, хүн ам нь Чингис хаанд шууд захирагдаж яваад нас барсны нь дараа нэгэнт тогтсон уламжлалт заншил ёсоор түүний отгон хөвгүн Тулуйн (1192-1233) мэдэлд шилжжээ.²³⁵ Энэ тухай манай тулгар бичигт <<Эзэн сэрүүндээ Тулуйг гал голомт сахин атугай хэмээсэн бүлгээ>>, <<Отгон нь Тулуйн голомтыг сахин авай>>²³⁶ гэх зэргээр өгүүлжээ. Гэвч Тулуйн мэдэлд нийт Монгол орныг бүхэлд нь олгоогүй, харин Чингисийн <<Алтан ураг>>-ийн төрөл, төрөгсөд буюу түүний эх Өэлүн хатны ах дүүст хүртээл болгож Гол(ын) улсад Монголын нэгдсэн төр улсыг байгуулахад тэргүүн үүрэг гүйцэтгэсэн Монголчуудад эрх олгосон нь уламжлалт ёс заншлыг хадгалсан юм. Тэгээд ч Хамаг Монгол улсын хэзээний уламжлалт өлгий газар, тухайлбал Бурхан халдун уул бол <<Гурван мөрний эхэнд бусдыг бүү нутаглуултугай>> хэмээн онгон дархалсан <<Их нутаг>> Монголын хаадын (хатад ч буй) шарилын ард бүхий ихсийн газар <<Их хориг>> байсан бөгөөд Монголын нэгдсэн тулгар улсын нийслэл Хархорум хот, их хаадын уламжлалт гал голомт <<Дөрвөн их орд төвлөрч, төрийн сүлд бэлэг тэмдгийн зүйл>> есөн хөлт цагаан туг, хар сүлд, <<хаш эрдэнэ буюу хаан төрийн Хасбуу тамга>> хадгалагдах <<Их засаг>> мэтийн цааз, зарлиг тогтоогдож, шадар хишигтэн цэрэг хааны сан хөмрөг, ордон дотоод ёс явдлын бүхий л эрх баригдаж Монголчуудын уламжлалт баяр ёслол <<Дөрвөн цагийн их хурим>> болж бүх улсын далай хааныг өргөмжлөх, байлдах, найрамдах мэт гүрний дотоод гадаадын хэрэг явдлыг зөвлөн тогтоодог ноёдын <<Их хуралдай>> чуулдаг байжээ. Монголчуудын улс байгуулан нь Хүннүгийн анхны төр улс гэж тогтоосон, МЭӨ 198 онд Хүннү улс Хятадын Хан улстай харилцан эрх тэгш гэрээ байгуулж байсан тодорхой баримт бий. Түмэн засагт хаан, хутагтай цэцэн хун тайж нар нийлэн өөрийн улс төр, хуулийн бодлого Баримталж ирсний тод жишээ нь 1575 онд <<Арван буянт номын цагаан түүх>> хэмээх шашин төрийн хууль болно²³⁷. Тэр нь хууль ёсоор хүн бүхэн бурхан, ном, лам гурвыг <<Гурван эрдэнэ>> гэж дээдлэн шүтэх, бөө мөргөлийн бүрмөсөн орхих, бөөгийн онгон шүтээнийг эвдлэж, устгах хүн мал ба аливаа амьтдыг алан цус асгаруулахаа болих, эсэргүүцсэн этгээдийг хатуу цээрлүүлэн шийтгэх тухай заажээ²³⁸.

Энэ үнэхээр 1577 онд Монголд шашин дэлгэрүүлж Алтан хаан хутагтай цэцэн хун тайж Төвдийн шашны тэргүүн Ш далай лам Содномжамцыг өргөөндөө залж багш болж орсны учир хатуу цаазын зэрэгцээ нэн түрүүн шашны номоор зүүн, баруун түмнийг эв найрамдлын журмаар нэгтгэх гэсний илрэл юм. Тухайлбал, эдүгээгийн хоёр ёсноос өгүүлбээс: <<Номын цааз хивийн зангиа мэт алдаршгүй бат бэх учир хааны цааз алтан буулга мэт сүр хүчин ихтэй. Улс иргэн бүхэн түгэн тархсан тэрхүү хоёр ёсноос хааны цаашдын цаазнаас их өчүүхэн цаазыг юу юунд тохируулан буулгавал ийм ажгуу. Та нар бол Монголын 40 хошуу, 5 отгийн тэргүүлэгчид их багагүй, бүгдээрээ оюундаа сайтар хянан магадлагтун. Хэрэв та нар эс магадлан үл тоомсорловоос Эрлэг номун хааны зарлиг ёсоор хоёр ёсны хатуу ялыг хүлээх нь магадтай тул бүгдээрээ сэтгэлдээ сайтар тодорхой магадлагтун>> хэмээсэн нь сонин.

НОМ ЗҮЙ

1. Арван буянт номын цагаан түүх. Монголын түүхэн сурвалж бичгийн 2-р боть, УБ.,2006 он
2. Бира Ш Түүвэр зохиол, “Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь” УБ.,1960 он
3. Ишжамц.Н “Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь” УБ.,2002 он
4. Монголын философийн түүх УБ., 2000 он
5. Чоймаа Ш “Хос ёсны сургаалаар төрөө засаж ирсэн уламжлал” итгэл
6. Эрдэм шинжилгээний бичиг №2 УБ.,2004 он
7. Жамбал.А Улс төрийн сургаалийн түүх УБ.,2001 он
8. Чагдаа Х “Монголчуудын философи сэтгэлгээний үүсгэл, түүхэн уламжлал УБ.,2006 он
9. Төр, сүм хийдийн харилцаа: Орчин үе УБ.,1998 он

²³⁵ Монголын нууц товчоо УБ., 1989 он, 269-270-р тал

²³⁶ Галдан Эрдэнийн эрхи УБ., 1960 он 47-47-р тал

²³⁷ Монгол үндэстний товч түүх, Өвөр Монгол, Хөх хот., 1988, 176-277, 334-335-р тал

²³⁸ Арван буянт номын цагаан түүх, Хөх хот., 1981, 65-70-р тал

ТӨРИЙН УЛС ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОМИЛГООНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Д.БУМДАРЬ

*Доктор, дэд профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхим*

Э. БАЗАРРАГЧАА

Улс төр судлалын тэнхимийн магистрант

Түлхүүр үг: төрийн алба, улс төрийн албан тушаал, улс төрийн томилгоо, Монголын улс төрийн албан тушаалын томилгоо, Японы улс төрийн албан тушаалын томилгоо, Английн улс төрийн албан тушаалын томилгоо, Германы улс төрийн албан тушаалын томилгоо, Францын улс төрийн албан тушаалын томилгоо, Америкийн улс төрийн албан тушаалын томилгоо

Улс төрийн албан тушаалын томилгоо бол төрийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх чадвартай, мэргэшсэн, өндөр ёс суртахуунтай улс төрчдийг төрийн улс төрийн албан тушаалд сонгож томилох тогтолцоо юм. Төрийн улс төрийн албан тушаал (political appointee) нь хууль, тогтоомжоор олгогдсон эрх мэдлийн хүрээнд төр, засгийн газрыг төлөөлж шийдвэр гаргадаг гол албан тушаал юм.

Төрийн улс төрийн албан тушаалыг ойлгох ойлголт нь ардчилсан засаглалтай улс орнуудад ерөнхийдөө нэг агуулгатай боловч улс орон бүрийн соёл, улс төрийн тогтолцоо, төрийн байгууламжын уламжлал, шинэчлэлийг тусгасан харьцангуй онцлогтой байдаг.

Энэ өгүүлэлд улс орнууд төрийн улс төрийн албан тушаалд ямар албан тушаалыг хамруулдаг, улс төрийн албан тушаалд ямар шаардлага тавьдаг, улс төрийн томилгоо хийхэд баримталдаг гол гол шалгуурын талаар тойм шинжилгээ хийхийг зорьсон болно.

Abstract; Political system of the appointment is to employ appointees who can implement political policies, being professional and take an ethics pledge. Political appointees are under the authority granted by the state and engraved in the main decision making on behalf of the government. The state positions in a democratic countries are general, although it reflects according to the cultural differences, political systems, public facilities, tradition and innovation as well as features of the country. This article studies the countries' civil service and political positions and its requirements of political appointments and key criteria.

Английн улс төрийн албаны томилгоо

Англи улсын төрийн албаны тогтолцоог 18 дугаар зуунаас үүсэлтэй гэж үздэг. 1854 онд “Northcote–Trevelyan Report”²³⁹ батлаж, засгийн эрх солигдох болгонд өөрчилөгдөж байсан төрийн албаны тогтолцоонд шинэчлэл хийсэн. 1870 онд дахин нэмэлт өөрчилөлт оруулж төрийн албанд шалгалт өгөх зарчмаар нээлттэй сонгон шалгаруулалт хийдэг болжээ. Энэ утгаар нь “Northcote–Trevelyan Report”-ыг өнөөгийн Английн төрийн албаны тогтолцооны суурийг тавьсан хэмээн үздэг. Вэстминистерийн тогтолцоотой холбоотойгоор Английн улс төрийн системд хоёр томоохон нам ээлжлэн засгийн эрх барьж ирсэн түүхтэй.

Эрх баригч намын сонгогдсон гишүүд улс төрийн албан тушаалд зонхилж томилогддог. Төрийн албан хаагчид нь мэргэшсэн байдгийн зэрэгцээ улс төрийн хувьд төвийг сахид уламжлалтай бөгөөд засгийн газрын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй ханддаг. Төрийн жинхэнэ албаны томилгоонд улс төрийн зорилгоор ханддаггүй, улс төрчид оролцдоггүй онцлогтой.

Харин улс төрийн албан тушаалын томилгоо жинхэнэ утгаараа 1964 оноос эхлэлтэй. Хөдөлмөрийн нам арван гурван жилийн турш засгийн эрхийг тасралтгүй барьж ирсэн Консерватив намыг ялж, намын дарга Вильсон (James Harold Wilson) ерөнхий сайдаар сонгогдсон. Тэрээр эдийн засгийн зөвлөхөө засгийн газарт дагуулж ирсэн. Энэ нь төрийн албан хаагчдаас бус, харин гаднаас улс төрийн албан тушаалд томилгоо хийгдсэн анханы тохиолдол байжээ. Англид улс төрийн албан тушаал нь 100 орчим албан тушаал хамаардаг бөгөөд үүний 70 нь улс төрийн тусгай зөвлөхүүд²⁴⁰ байдаг. Ийм учир Английн улс төрийн албан тушаалын томилгоог дээд зэрэглэлийн зөвлөх-ийн шинжтэй хэмээн үзэж болно.

²³⁹ <http://onlinelibrary.wiley.com/doi/10.1111/j.1467-9299.1954.tb01719.x/abstract>, Public administration. Vol 32, Issue 1, pp-16.

²⁴⁰ http://ssl.jinji.go.jp/hakusho/h15/jine200402_2_013.html#n54.1、年次報告書、平成25年度、イギリス、参照。

Английн улс төрийн албан тушаал, улс төрийн томилгоо:

- Төрийн сайд, дэд сайд, парламентын дарга, төрийн нарийн бичгийн дарга зэрэг албан тушаалд эрх баригч нам томилдог
- Төрийн албаны тогтолцоо нь улс төрчид, төрийн жинхэнэ албан хаагч гэсэн тогтолцоотой бөгөөд улс төрийн тусгай зөвлөхүүдийг гаднаас (салбаруудаас) шилж авч томилдог
- Тусгай зөвлөхүүд нь сайдуудад улс төрийн зөвлөгөө өгдөг²⁴¹

Английн улс төрийн томилгооны энэхүү тогтолцоо нь төрийн мэргэшсэн албаны тогтолцоонд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлдэггүй сайн талтай гэж тайлбарладаг.

Германы улс төрийн албаны томилгоо

Герман нь холбооны улсын төрийн байгуулалтай, харьцангуй онцлогтой. Холбооны засгийн газар төрийн алба нь мужуудын захиргаатай харилцан уялдаатай ажилладаг. Төрийн мэргэшсэн албаны тогтолцоондоо мерит систем (мэргэжлийн мэдлэг чадвар, туршлага, байгуулсан гавьяа зүтгэлийг харгалзан төрийн албанд элсүүлэх, тушаал дэвшүүлдэг тогтолцоо)-ийг хуульчилж өгсөн бөгөөд баталгааг сайн хангасан байдаг.

Харин засгийн газрын яамдуудын төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, элчин сайд зэрэг улс төрийн албан тушаалд мэргэшсэн албаных шиг баталгааг тэр бүр өгдөггүй байна. Улс төрийн эдгээр албан тушаалтныг шалтгааныг тодорхой тайлбарлахгүйгээр албан тушаалаас нь халах боломжтой байдаг. Гэхдээ албан тушаалаас халагдсаны нөхөн олговор нь өндөр байдгийн зэрэгцээ улс төрийн өөр албан тушаалд дахин томилогддог зохицуулалттай. Эдгээр албан тушаалыг “улс төрийн зорилго бүхий засгийн газрын алба”²⁴² буюу улс төрийн томилгооны албан тушаал хэмээн нэрлэдэг. Энэ зохицуулалт нь 1850 оноос хэрэгжсэн бөгөөд анхандаа засгийн газрын эсрэг байр суурьтай төрийн албан тушаалтанг солих эрх зүйн боломжийг нээх зорилгоор эхлэсэн түүхтэй.

Өнөөгийн байдлаар Герман улсын улс төрийн томилгоонд 400 албан тушаал багтдаг²⁴³. Үүний тал хувь нь мужуудын албан тушаал байдаг. Гэхдээ эдгээр албан тушаалд сонгуулийн дүнгээр нэг дор бүгдийг сольж томилдоггүй. Улс төрийн албан тушаалд ажиллаж байгаад 65 нас хүрсэн бол тэтгэвэрт гардаг. Тэтгэврийн насанд хүрэлгүйгээр ажлаа хүлээлгэн өгсөн албан тушаалтан дараагийн ажилд томилогддог. Ийм албан тушаалд ихэвчлэн мужын удирдлагын томоохон албан тушаал, их дээд сургуулийн удирдах алба, төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн зэрэг хамаардаг. Германы улс төрийн томилгоо нь үндсэндээ төрийн мэргэшсэн албанаас мерит системийн дагуу хийгддэг бөгөөд албан хаагчийн мэргэжлийн мэдлэг чадварын түвшин, эрхэлсэн ажлын бодит үр дүн нь шийдвэр гаргах үндэс болдог.

Японы улс төрийн албаны томилгоо

Япон улсын төрийн албаны тогтолцоо нь язгууртанд үйлчлэх (**royal service**) албанаас нийтэд үйлчлэх (**public service**) төрийн албанд шилжин хөгжсөөр өнөөгийн дүр төрхийг олсон түүхтэй. Мэйжигийн шинэчлэлийн үеэс Эзэн хаанд үйлчилдэг албанаас бүх нийтэд үйлчлэх албанд шилжиж эхэлсэн байдаг. Тухайлбал, 1867 оны 12 сарын 9-нд улсынхаа мэдлэг чадвартай иргэдийн бүртгэл гаргаж, тэдний дундаас төрийн тохирох албан тушаалд тавьж ажиллуулах тухай зарлиг анх удаа гаргасан байна. Хожим нь 1886 оны 2 дугаар сард “Яамдын тогтолцоо”²⁴⁴-ны тухай зарлиг гаргаж, төрийн албанд ажиллах хүмүүсийг шалгалтын журмаар шалгаруулан авч, дагалдангаар ажиллуулж ажилд нь сургах заалтыг оруулсан байдаг. Энэ нь Япон улсын төрийн албаны тогтолцооны суурь нь болжээ.

Мэйжигийн шинэчлэлийн эхэн үед төрийн албанд ажиллах хүмүүсийг шалгаруулж авахдаа “бялуу хуваах” (spoils system) зарчмыг баримталдаг байсан бөгөөд цааш цаашдын олон удаагийн шинэчлэлийн үр дүнд өөрчлөгдөн хөгжсөөр өнөөгийн түвшиндээ хүрсэн байна. Японы төрийн албаны шинэчлэл нь Английн мерит систем (merit system) болон Америкийн 1881 оны Ж.Пендлетоны төрийн албаны тухай хууль (Pendleton Civil Service Act)-тай цаг хугацааны хувьд зэрэгцэн, тэдгээрээс хамааралгүйгээр хийгдэж байсан онцлогтой гэж судлаачид үздэг. Энэ утгаараа Япон нь азийн улс орнуудаас хамгийн түрүүнд төрийн албанд мерит системийг санаачилан хэрэгжүүлж чадсан улс юм.

Япон улсын орчин үеийн төрийн албанд ажилд ороход тавигддаг үндсэн шаардлага бол төрийн албаны шалгалтад тэнцсэн байх явдал юм. Төрийн албан хаагч, орон нутгийн албан хаагч хэн ч байсан энэ шалгалтыг заавал өгсөн байх ёстой. Төрийн албанд шалгаруулж авах шалгалт нь гурван түвшинтэй.

Гуравдугаар түвшний шалгалтанд тэнцсэн тохиолдолд төрийн албаны гүйцэтгэх, туслах үүрэгтэй албан тушаалд ажиллах боломжтой. Хоёрдугаар түвшний шалгалтад тэнцсэн бол төрийн албаны удирдах албан тушаалаас бусад албан тушаалыг хаших эрхтэй байдаг. Нэгдүгээр түвшний шалгалтанд тэнцсэн бол төрийн албанд орж ажиллах бөгөөд цаашид тогтвортой ажиллан хуримтлуулсан мэдлэг, чадвар, туршлага, гаргасан үр бүтээлээрээ шалгарч, улмаар төрийн удирдах албан тушаалд шат дараатай ахиж дэвших, томилогдох боломжтой байдаг.²⁴⁵

²⁴¹ 同書参照。

²⁴² http://ssl.jinji.go.jp/hakusho/h15/jine200402_2_013.html#n54.1、年次報告書、平成25年度、ドイツ、参照。

²⁴³ 年次報告書「諸外国の国家公務員制度の概要」（平成25年）、参照。

²⁴⁴ 川手 接『戦後日本の公務員制度史』（単行本、2005年）、参照。

²⁴⁵ 出雲明子『公務員制度改革と政治主導：戦後日本の政治任用制』（単行本、2014年）、参照。

Японы төрийн албаны шалгалт нь чанд зохион байгуулалттай, шудрага өрсөлдөөнтэй байдаг бөгөөд уг шалгалтад тэнцэх нь нэг ёсондоо насан туршийн ажлын баталгаа болж чаддаг. Учир нь засгийн эрхэнд ямар ч нам гарсан ч, төрийн албан хаагчийг улс төрийн зорилгоор халж солих боломжгүй байдаг. Мөн төрийн албаны “Боловсон хүчний зөвлөл”-ийн шийдвэрийг хэн ч өөрчлөх эрхгүй байдаг хууль журамтай. Засгийн газар ойр ойрхон солигдсон ч төрийн албаны үйл ажиллагаа тасралтгүй явагддаг нь үүнтэй холбоотой юм.

Харин улс төрийн албан тушаалын томилгоо нь өрнөдийн орнуудыхаас ялгаатай юм. Ерөнхий сайд, яамдын сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга зэрэг улс төрийн албан тушаалыг эрх баригч намаас сонгогдсон парламентын гишүүн давхар хашиж болдог. Мөн засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, ерөнхий сайдын тусгай зөвлөх, сайдын тусгай зөвлөхөөр парламентын гишүүн ажиллаж болдог журамтай. Улс төрийн томилгоо хийгддэг албан тушаал 440 гаруй байдаг.²⁴⁶

Яамдын удирдах албан тушаалд төрийн албаны нэгдүгээр түвшний шалгалтанд тэнцэн ажиллаж мэдлэг, чадвар туршлага хуримтлуулж мэргэшсэн албан хаагчийг зэрэг дэв ахиулан улс төрийн шийдвэрээр томилдог. Эдгээр албан тушаалд сайд, сайдын тусгай зөвлөх, төрийн нарийн бичгийн дарга зэрэг албан тушаал хамаардаг.

АНУ-ын улс төрийн албаны томилгоо

АНУ-ын төрийн албаны тогтолцоо нь “бялуу хуваах” спойл тогтолцооноос мерит системд шилжихэд Ж.Пендлетоны хууль²⁴⁷ хэмээн алдаршсан төрийн албаны хууль чухал үүрэг гүйцэтгэсэн. Орчинд үеийн төрийн албаны тогтолцоо нь мерит системд тулгуурладаг төрийн мэргэшсэн алба, улс төрийн томилгоогоор бүрддэг улс төрийн албан тушаалаас бүрддэг. Америкийн улс төрийн тогтолцоонд Ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалыг тэргүүлдэг бөгөөд засаглалыг хэрэгжүүлэхийн тулд улс төрийн томилгоо хийх эрх эдэлдэг. Яамдын төрийн нарийн бичгийн дарга, удирдах албан тушаал, төрийн нарийн бичгийн даргын багт багтдаг албан тушаал зэрэг нийтдээ **3000 албан тушаалд улс төрийн томилгоо** хийгддэг. Энэ нь Ерөнхийлөгчөөр сонгогдон эрх үүргээ хэрэгжүүлж эхэлсэн үеэс эхлэн бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэлх хугацаанд хийгддэг томилгоо юм. Улс төрийн албан тушаалын томилгоог гаднаас хийдэг бөгөөд энэ нь дараах үндэслэлтэй. Үүнд:

- Америкт парламентын гишүүн засгийн газрын гишүүнээр сонгогдож болохгүй хуулийн заалттай. Ерөнхийлөгч өөртэй нь хамтран ажиллах мэргэжлийн чадвартай, итгэл даах ажилтнуудаас улс төрийн томилгоо хийдэг бөгөөд энэ нь төр улс байгуулагдсан үеэс уламжлалтай юм.
- Цагаачлалын түүх нь америкт чадварлаг хүний нөөц бүрэлдэхэд хүчтэй эерэг нөлөө үзүүлсэн бөгөөд энэ нь улс төрийн албан тушаалд гаднаас томилгоо хийхэд тааламжтай нөхцөл бүрдүүлсэн байдаг.
- Европын улс орнууд хаант засаглалтай байснаасаа улбаалан язгууртны төрийн албаны баялаг туршлагатай, харин Америкийн хувьд ийм уламжлал байгаагүй.²⁴⁸

Гэвч энэхүү улс төрийн албан тушаалын томилгооны тогтолцоо нь шүүмжлэл дагуулдаг. Тухайлбал, төрийн мэргэшсэн албан хаагчид улс төрийн удирдах албан тушаалд дэвших боломж хязгаарлагддаг гэж үздэг. Үүний зэрэгцээ ерөнхийлөгчийн багт нэгэнт орох л юм бол улс төрийн албан тушаалд шууд томилогдох боломжтой хэмээх ёс зүйгүй ойлголт газар авахад хүргэдэг уршигтай гэж шүүмжилдэг. Үүний улмаас улс төрийн томилгоонд зарим зохицуулалт хийсэн бөгөөд улс төрийн удирдах албан тушаалд гаднаас шилэн авч хийх томилгоо нь нийт удирдах албан тушаалын 10 хувиас хэтрэхгүй байхаар хязгаарласан байна. Энэ нт төрийн мэргэшсэн албан хаагчдаас тушаал дэвших боломжийг илүү нэмэгдүүлж өгсөн байна.

Францын улс төрийн албаны томилгоо

Францын улс төрийн тогтолцоо нь ерөнхийлөгчийн хагас засаглалтай. Парламентын гишүүн нь засгийн газрын гишүүн байхыг Үндсэн хуулиараа хориглосон байдаг. Хэрвээ засгийн газрын гишүүн болох аваас парламентын гишүүнээс татгалзах хууль эрхзүйн зохицуулалттай.²⁴⁹ Франц-д улс төрийн томилгооны 1300 албан тушаал байх бөгөө үүний 600 нь төрийн өндөр албан тушаал, харин 700 нь сайдын танхимын багийн гишүүд (cabinet staff) юм.²⁵⁰ Төрийн өндөр албан тушаалд томилогдож байгаа албан хаагчид нь Захиргааны Үндэсний Их сургууль (Ecole Nationale d'Administration- ENA) төгссөн байх шаардлагатай. Харин сайдын танхимын багийн гишүүдийн 70-80 хувь нь энэ сургуулийг төгссөн байдаг байна. Францын улс төрийн албан тушаал хашиж буй албан хаагчийг сонгуулийн дүнгээр шинэ засгийн газар, шинэ сайд томилогдох тохиолдолд сольж өөрчилдөг боловч үүнийг аажмаар үе шаттай хийдэг эрхзүйн зохицуулалт байдаг. Энэ нь Францын улс төрийн томилгооны бусад улс орнуудынхаас ялгарах нэг онцлог юм.

Францын улс төрийн албан тушаалын томилгоо нь 19 дүгээр зууны хоёрдугаар хагасаас эхэлсэн түүхтэй бөгөөд албан хаагчийн мэдлэг чадвар, туршлагыг эн тэргүүнд үзэж ажилд томилдог, эрхэлсэн ажил үүргээ хэрхэн биелүүлсэн байдал, үр дүнг харгалзан албан тушаалаас өөрчилдөг уламжлал нь өнөөг хүртэл тууштай хадгалагдаж үлдсэн ажээ.

²⁴⁶ 人事院事務総局管理局法制課、『各国公務員制度研究〈第4部〉』（古書、1957年）。

²⁴⁷ <http://www.britannica.com/topic/Pendleton-Civil-Service-Act> Pendleton Civil Service Act, United States 1883.

²⁴⁸ Kellough, Edward and Lloyd G. Nigro eds., Civil Service Reform in the States: Personnel Policy and Politics at the ubnational Level, State University of New York Press, 2006.

²⁴⁹ 年次報告書「諸外国の国家公務員制度の概要」（平成25年）、参照。

²⁵⁰ 下井康史『フランスにおける公務員の任用・勤務形態の多様化（上）』自治研究81巻3号、2005年、参照。

Төрийн өндөр албан тушаалд ажиллах, тухайлбал агентлагын даргын албан тушаалд улс төрийн томилгоогоор томилогдох албан хаагч 40 нас хүрсэн байх шалгуур байдаг. Харин сайдын танхимд ажиллах ажилтан 30-40 нас хүрсэн байх эрхзүйн заалт байдаг бөгөөд энэ нь цаад утгаараа тухайн албан хаагчийн мэдлэг, чадвар, туршлагын түвшинд тавьж буй шаардлага юм. Сайдын танхимын багт улс төрийн томилгоогоор ажиллах албан хаагчийг төрийн мэргэшсэн албаны боловсон хүчний “өсөх ирээдүйтэй нөөц”-өөс сонгож авдаг. Улс төрийн томилгоогоор ажиллаж байгаа албан хаагч нь томилгооны хугацаа дуусах, албан тушаалаас өөрчилөгдөх тохиолдолд төрийн мэргэшсэн албандаа эргэж ажиллах эрхтэй байхаар зохицуулалт хийгдсэн байдаг.

Монгол улсын улс төрийн албаны томилгоо

Монгол улсын төрийн албаны тухай хуульд “Төрийн улс төрийн албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог болон сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах, мөн тэдгээрийн бүрэн эрхийнх нь хугацаанд өөрт нь үйлчлэх орон тооны дараахь албан тушаал хамаарна” гэж заасан байдаг. Үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу төрийн албаны улс төрийн албан тушаалд дараах албан тушаал хамаардаг. Үүнд:


- Монгол Улсын Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайд
- Их Хурлын дэд дарга, Их хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга, Ерөнхий сайдын зөвлөх, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга
- бүх шатны Засаг дарга болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч
- улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтны албан тушаал
- Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаал
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, хот, тосгоны захирагчийн албан тушаалыг төрийн улс төрийн албан тушаалтай адилтган үзэж болно²⁵¹ хэмээн хуульд заасан байдаг.

Хууль эрхзүйн энэхүү заалтын дагуу манай улсад 2600 улс төрийн албан тушаал байдаг байна.

Төрийн улс төрийн албан тушаалыг хууль эрхзүйн баримт бичигт ийнхүү тодорхой заасан байдаг. Гэвч хэрэг дээрээ улс төрийн томилгоо нь хуулиар тогтоогдсон дээрх хэмжээнээс хэтэрч хуулийг зөрчиж байна/Зураг.1/. Улс төрийн томилгоо нь хүрээгээ тэлж улс төрийн албан тушаалаас хальж, төрийн жинхэнэ мэргэшсэн албан хаагчдыг хамрах болсон нь ноцтой үзэгдэл юм. Засгийн эрхэнд гарсан нам явцуу сонирхолдоо хөтлөгдөн, төрийн мэргэшсэн албыг ийнхүү улс төрийн томилгоо, халаа сэлгээний бай болгож байгаа нь нэн харамсалтай үзэгдэл юм. Төрийн мэргэшсэн албанд ийнхүү улс төрийн байр суурьнаас хандах нь жинхэнэ мэргэшсэн өндөр мэдлэг чадвартай албан хаагчдыг төрийн албанаас шахаж гаргах далд зорилго агуулдаг бөгөөд улмаар төрийн албаны чадавхийг сулруулж төрийн үйл хэргийг мөхөсдүүлэх, улс орныг эзэнгүйдүүлж эмх замбараагүй байдал үүсэх нэн том хор уршигтай.

Манай улсын төрийн албан хаагчдын тоог 2015 оны байдлаар Зураг.1-д үзүүлэв.

Зураг.1. Төрийн нийт албан хаагчдын тоо /албан тушаалын ангилалаар/



Эх сурвалж: <http://tov.gov.mn/data/main/main1427250120.pdf>

²⁵¹ Монгол улсын төрийн албаны тухай хууль 2008 он, <http://www.legalinfo.mn/law/details/487>, 2015/12/20.

Хүснэгт.1. Улс орнуудын улс төрийн томилгооны албан тушаалын тоо, харьцуулал

Улсын нэр	Хүн ам	Улс төрийн томилгооны албан тушаалын тоо
Монгол улс	3 сая	2600
Япон улс	127сая	440
Англи улс	64 сая	100
Герман улс	80 сая	400
Франц улс	60 сая	1300
АНУ	260 сая	3000

Улс орнуудын улс төрийн албан тушаалын тоог харьцуулж үзвэл манай улсын хувьд улс төрийн албан тушаалын тоо хэт нүсэр, бараг 300 сая хүн амтай улс орныхтой дүйцэхүйц байна. Ийм шинжлэх ухааны ямар нэгэн үндэслэлгүй, улс орны бодит байдалд нийцээгүй авцалдаагүй зүйл нь төсөөлөх боломжгүй сөрөг үр дагаварт хүргэдэг.

Энд өгүүлсэн зүйлийг товч дүгнэж үзье.

Улс орнууд төрийн албаны тогтолцоондоо улс төрийн албан тушаал, улс төрийн томилгоог багтааж эрхзүйн хувьд баталгаажуулдаг нь ихээхэн утга учиртай байдаг. Тухайлбал:

- Улс төрийн томилгоог хийснээр засаглалыг хэрэгжүүлэх үйл явцад хяналт тавих, ил тод байдлыг хангах, хариуцлага тооцох боломжийг өргөжүүлдэг.
- Төрийн удирдах албан тушаалд мэдлэг чадвар, туршлагыг харгалзан улс төрийн ухаалаг томилгоо хийж чадсан тохиолдолд баримталж ирсэн бодлогыг боловсронгуй болгох, үр дүнтэй хэрэгжүүлэх илүү сайн нөхцөл бүрддэг
- Улс төрийн ухаалаг томилгоо нь ард түмний язгуур эрх ашгийг төрийн байгууллага, түүний аппаратын явцуу эрх ашгаас дээгүүрт тавьж тууштай хамгаалж, хэрэгжүүлэх боломж бүрдүүлдэг.
- Улс төрийн ухаалаг томилгооны үр дүнд сонгогчдын дэмжлэг авсан бодлого, засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх явдлыг салбар яамд, агентлаг, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны зорилт болгож тавих илүү таатай боломж бүрддэг.

Улс төрийн томилгоог сайтар бодож цэгнэж, бодит нөхцөл байдалдаа ухаалгаар тохируулж хийж чадаагүй нөхцөлд ноцтой сөрөг үр дагаварт хүргэдэг уршигтай. Жишээлбэл:

- Сайдын албан тушаалын зэрэгцээ дэд сайд, засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга, төрийн нарийн бичгийн дарга гэхчилэн шат дараалсан албан тушаалыг улс төрийн томилгоо хийснээр хариуцлагын тогтолцоо суларч, тодорхой албан тушаалтантай хариуцлага тооцох боломж хязгаарлагддаг.
- Засгийн газар ойр ойрхон хугацаанд солигдох тохиолдолд улс төрийн томилгооны үр дүн гарахгүй бөгөөд төрийн албаны үйл ажиллагаа суларч, тодорхойгүй нөхцөл байдал үүснэ.
- Улс төрийн томилгоо хэт зонхилсон тохиолдолд мэргэшсэн албан хаагчийн ажилд хандах хандлага сулардаг төдийгүй өндөр мэдлэг чадвартай ажилтнууд төрийн албанаас шахагдан гарах, улмаар төрийн чадавхи сулрах үр дагаварт хүргэдэг.
- Улс төрийн томилгоо ойр ойрхон хугацаанд хийгдэх, зохистой хэмжээнээсээ хальж хүрээгээ тэлэх нь төрийн үйл ажиллагааны горимыг алдагдуулж, эрч хүчийг сааруулж, төрийн бодлогын залгамж чанарыг алдагдуулах уршиг дагуулдаг.

Ийм учраас улс төрийн томилгоог төрийн албаны хуулиар тогтоогдсон хүрээнд хэрэгжүүлэх, төрийн мэргэшсэн албаны албан тушаалд улс төрийн томилгоог халдварлуулахгүй байх тогтолцоонд нэн яаралтай шилжих шаардлагатай байна. Үүний зэрэгцээ төрийн албаны хуульд заагдсан улс төрийн албан тушаалын тоог цөөрүүлэх, мэргэшсэн төрийн албан хаагчдын улс төрийн төвийг сахисан байр суурийг баталгаажуулах, төрийн улс төрийн албан тушаалд томилоход баримтлах мэргэжлийн болон ёс зүйн шалгуурыг өндөржүүлэх асуудал нь шийдлээ хүлээж байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол улсын төрийн албаны тухай хууль /Шинээр батлагдсан хуулийн эмхэтгэл/, УИХ-ын Тамгийн газар, УБ., 2008 он.
2. Ц. Самбаллхүндэв “Монгол улсын төрийн албаны тойм”, Ном хур ХХК, УБ., 2008 он.
3. Kellough, Edward and Lloyd G. Nigro eds., Civil Service Reform in the States: Personnel Policy and Politics at the ubnational Level, State University of New York Press, 2006.
4. 下井康史『フランスにおける公務員の任用・勤務形態の多様化（上）』自治研究 81 卷 3 号、2005 年。
5. 出雲明子『公務員制度改革と政治主導：戦後日本の政治任用制』（単行本、2014年）。
6. 川手 接『戦後日本の公務員制度史』（単行本、2005年）
7. 年次報告書「諸外国の国家公務員制度の概要」（平成25年）。

Цахим хаяг

1. <http://www.legalinfo.mn/law/details/487>
2. <http://www.britannica.com/topic/Pendleton-Civil-Service-Act> Pendleton Civil Service Act, United States 1883.
3. http://ssl.jinji.go.jp/hakusho/h15/jine200402_2_013.html#n54.1、年次報告書、平成25年度、ドイツ.
4. <http://onlinelibrary.wiley.com/doi/10.1111/j.1467-9299.1954.tb01719.x/abstract>, Public administration. Vol 32, Issue 1.
5. http://ssl.jinji.go.jp/hakusho/h15/jine200402_2_013.html#n54.1、年次報告書、平成25年度、イギリス.
6. <http://tov.gov.mn/data/main/main1427250120.pdf>

МОНГОЛ ДАХЬ АРДЧИЛАЛ: ИРГЭНИЙ УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЛ

С.МӨНХБАТ

*Доктор, профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч*

Д.БУМДАРЬ

*Доктор, дэд профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхим*

Г.МЭНДХҮҮ

*Доктор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Сэтгүүл зүй, олон нийттэй харилцах тэнхим*

Түлхүүр үг: иргэний улс төрийн оролцоо, оролцооны ардчилал, сонгогчдын улс төрийн үйл байдал, улс төрийн нам, сонгууль, сонгуулийн коммуникаци, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (ОНМХ), телевиз, иргэний сэтгүүл зүй, цахим сэтгүүл зүй

Abstract; Discussing public issues openly and in participation of all, ancient Greeks and Romans engaged in the idea of direct democracy. One of the exemplary places of this type of democracy was the ancient Athens. In comparison, modern democratic nation states have adopted the representative form of democracy. Though it may be the best system in place thus far, representative democracy has its own weaknesses. For this reason, some scholars argue that direct democracy is a substitutive asset, which can reduce the weaknesses of representative democracy²⁵².

In direct democracy, issues are discussed openly by the participation of all in one place at the same time, allowing for the dissemination of information and the resulting conclusion and decisions to be fair and transparent. Similarly, modern day mass media makes this mode of discussion and decision making in politics more available and accessible to public. The main goal of direct democracy is to make the entire state (or government) policy and decision-making processes fair, transparent and inclusive of public opinion.

Ардчилал, ардчилсан нийгмийн үзэл санаа өнө эртний түүхийн улбаатай ч улс төр, нийгмийн хөгжлийн бодит байдал болж амьдралд бодитой хэрэгжиж эхэлсэн үе нь ХХ зуунтай холбоотой талаар олон судлаачид дүгнэн бичсэн нь буй. Харин Монголчууд бидний хувьд ардчилал дахь хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг бодит агуулгаар хэрэгжүүлэх боломж, бололцоо одоогоос 26 жилийн өмнө л нээгдсэн билээ.

1990 оны эхээр Монгол улсад өрнөсөн ардчилсан хувьсгал манай орны нийгэм, улс төр, эдийн засгийн амьдрал, ард түмний оюун санаа, сэтгэлгээнд эргэлтийн шинжтэй өөрчлөлтийг авч ирсэн билээ. Монгол улс ардчилалд шилжээд олон жилийн нүүрийг үзэхдээ улс төрийн ардчиллын зарчмууд, үнэт зүйлсийг өөрийн орны хөрсөнд нутагшуулан соёолуулах талаар бас чиг чамгүй ажил амжуулсныг тэмдэглэх хэрэгтэй²⁵³. Үнэхээр иргэний нийгмийн тогтолцоо, иргэдийн улс төрийн оролцоог хангах, эрх зүйт төрийн төлөвшүүлэх эхлэлийг тавих чигт шийдвэртэй алхамуудыг хийж чадсан юм. Монголчууд бид Ерөнхийлөгч, УИХ, Орон нутгийн иргэдийн хурлыг төлөөлөгчдөө сонгодог болов. Олон намын систем, сонгуульт ардчилал, парламентат ёс бодит биелэлээ олж олон ургальч үзэл дэлгэрэв. Иргэдээс улс төрийн дэглэм, систем, улс төрд хандах хандлага, чиг баримжаа өөрчлөгдөж Монголчуудын улс төрийн үйл байдал, оролцоонд гүнзгий өөрчлөлт орлоо. Иргэдийн улс төр, эдийн засгийн эрх, эрх чөлөөг бодитой олгох эрх зүй, нийгмийн орчин бүрэлдэв. Ийнхүү ардчилал Монголд бодитой болсон нь том ололт юм. Гэвч олсон энэхүү ололтоо баталгаажуулан бэхжүүлж, төлөвшүүлэх асуудал бидний өмнө том сорилтуудыг бий болгож байна. Иймд бид тэрхүү тулгарч буй олон сорилтуудыг энэхүү өгүүлэлдээ тодруулж гаргахыг эрмэлзсэнгүй. Тийм бололцоо ч хомс бөгөөд тусдаа өргөн хүрээг хамарсан судалгаа шаардах асуудал юм. Харин бид энэхүү өгүүллээрээ ардчиллын суурь болсон иргэдийн улс төрийн оролцоо, түүний хэрэгжилтийн байдал Монголд ямар байгааг тодруулах зорилго тавьсан болно.

²⁵² Macpherson C.B. The Real World of Democracy. Oxford: Oxford University Press 1966, Benjamin R. Barber. Strong Democracy: Participatory Politics for a New Age. Berkeley. California University Press 1984

²⁵³ Ш.Содном, Ц.Ганболд, Ё.Довчин. Монгол дахь ардчилах үйл явц ба сонгууль. МУИС. Политологи сэтгүүл. №297 (50), УБ., 2009. 6 дахь тал.

Оролцооны ардчилал нь эртний Грек, Ромын үеэс улс төрийн амьдралд бодит биелэлээ олж хөгжсөн байдаг. Тухайлбал эртний Афинд шууд ардчилал хөгжиж байжээ. Хотын иргэд шууд оролцооны үндсэн дээр нийтийн өмнө тугамдаж буй асуудлаа шийддэг байсан бөгөөд аажмаар төлөөллийн ардчиллаар солигдсон юм. Эдүгээ дэлхий дахинд төлөөллийн ардчилал амжилттай хөгжиж байна. Харин сүүлийн жилүүдэд оролцооны ардчиллын талаар судлаачид нэлээдгүй ярьж, бичих боллоо. Аливаа зүйл төгс төгөлдөр байдаггүйн адилаар төлөөллийн ардчилал ч өөрийн гэсэн дутагдалтай талтай. Төлөөллийн ардчиллын дутагдалтай талыг нөхөх, саармагжуулах хэлбэр бол оролцооны ардчилал хэмээн судлаачид дүгнэдэг²⁵⁴.

Оролцооны ардчиллын онцлог нь иргэд аливаа асуудлыг шийдэхдээ нийтийн талбай, хурлын танхимд цугларч харилцан зөвшилцөн шийдвэр гаргадагт оршино. Ингэхдээ иргэд мэдээллээр сайн хангагдсан байх бөгөөд орчин үед цахим технологийг өргөн ашиглах болсон нь оролцооны ардчиллыг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна. Оролцооны ардчиллын гол зорилго нь төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах бүхий л үйл явц ил тод байж иргэд үүнд нийтээрээ хяналт тавин оролцоход оршино. Ингэснээр төрд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх замаар улс төр, нийгэм, эдийн засгийн тогтвортбайдлыг хангаж, аливаа бодлого, шийдвэрт олон түмний дэмжлэгийг бий болгоход чухал нөлөөтэй. Судлаач К.Макферсон оролцооны ардчиллыг шударга, ил тод, хүмүүнлэг нийгмийг цогцлуулахад онцгой ач холбогдолтой гэж үзсэн байдаг. Тэрээр нийгэмд шударга ёс тогтож, улс төрийн тогтолцоо төлөвших тусам оролцооны ардчиллыг шаарддаг гэж дүгнэжээ²⁵⁵.

Монголчуудын улс төрийн оролцооны үндсийг 1992 оны шинэ Үндсэн хууль баталгаажуулж өгсөн юм. Үндсэн хуулийн 1-р бүлгийн 3.1-д “Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эдэлнэ”²⁵⁶ гэж хуульчилсан нь улс төрийн эрх, эрх чөлөөгөө эдлэх өргөн боломжийг ард иргэдэд олгосон юм. Өөрөөр хэлбэл А.Линкольны хэлсэнчлэн “Ардчилал бол ард түмнээс байгуулагдсан, ард түмний төлөө, ард түмний өөрсдийнх нь засаг” гэсэн мэргэн үг Монголд бодит биелэлээ олох нөхцөл Үндсэн хуулийн хүрээнд бүрдсэн билээ.

Үндсэн хуулийн хүрээнд иргэдийн улс төрийн оролцоог хангах, улс төрийн эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжийг олгосон суурь зарчим, зохицуулалтууд өнөө хэр үйлчилж байгаагийн дотор дараах хоёр заалт хамгийн ач холбогдол бүхий суурь зохицуулалт болж байна. Үүнд, Үндсэн хуулийн 2-р бүлгийн 16.9-д Монгол улсын иргэд “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийн удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно”²⁵⁷, мөн хуулийн 16.10-т “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй...Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэмлэгдүүлэхийг хориглоно”²⁵⁸ гэж тус тус хуульчилсан Монголчуудын улс төрийн оролцооны эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн билээ.

Монгол улсад 1992 онд батлагдсан эдүгээ хүчин төгөлдөр мөрдөж буй Үндсэн хуулиас гадна Улс төрийн намын тухай хууль²⁵⁹ (1990), Сонгуулийн хууль²⁶⁰ (2015), Төрийн бус байгууллагын хууль²⁶¹ (1995), Ард нийтийн санал асуулгын хууль²⁶² (1995)-иудаар иргэдийн улс төрийн оролцооны эрх зүйн орчинг зохицуулж байна. Дээрх хууль, эрх зүйн баримт бичгүүдэд иргэдийн улс төрийн оролцооны конвенциаль буюу нийцтэй оролцооны үйл байдлыг дэмжиж харин неконвенциаль буюу нийцгүй оролцооны хэлбэрүүдийг хориглосон. Өнөөдөр Монголчуудын улс төрийн оролцооны хамгийн түгээмэл хэлбэрүүд дараах үйл ажиллагаагаар илэрч байна. Үүнд,

- Сонгуульд оролцож сонгож, сонгогдох
- Улс төрийн нам, эвсэл холбоо байгуулах, эвлэлдэн нэгдэх, гарах
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр өөрийн үзэл бодол, саналаа чөлөөтэй илэрхийлэх
- Төрийн үйл хэрэгт биечлэн болон төлөөлсөн байгууллагаараа шууд ба дам оролцох
- Хуулийн хүрээнд жагсаал цуглаан зохион байгуулах, оролцох зэргээр улс төрийн оролцоогоор дамуулж улс төрийн эрхээ эдэлж байгаа билээ.

Гэвч бодит амьдралд дээрх үйл ажиллагаануудаар дамжуулан улс төрийн эрхээ эдлэх, оролцоогоо хангах байдал иргэд, сонгогчдын дунд нийгэм, эдийн засгийн олон талт хүчин зүйлсээс шалтгаалан харилцан адилгүй нөхцөл байдлыг бий болгож иргэдийн улс төрийн үндсэн эрхүүд зөрчигдөхөд хүрч байна. Үүнийг тодруулах үүднээс иргэд сонгогчдын дунд социологийн судалгаа хийж тэдний улс төрийн оролцооны түвшин, дүр

²⁵⁴ Macpherson C.B. The Real World of Democracy. Oxford: Oxford University Press 1966, Benjamin R. Barber. Strong Democracy: Participatory Politics for a New age. Berkeley. California University Press 1984

²⁵⁵ Macpherson C.B. The Real World of Democracy. Oxford: Oxford University Press 1966

²⁵⁶ Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992

²⁵⁷ Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992

²⁵⁸ Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992

²⁵⁹ Улс төрийн намын тухай хууль. 1990

²⁶⁰ Сонгуулийн хууль. 2015

²⁶¹ Төрийн бус байгууллагын тухай хууль. 1990

²⁶² Ард нийтийн санал асуулгын тухай хууль. 1995

төрх, үндсэн хэлбэрүүдийг тодруулах замаар оролцооны чиг хандлагын өөрчлөлтийг гаргахыг эрмэлзсэн болно. Энэхүү судалгааг Монгол улсын нийт хүн амын 46%, сонгуулийн насанд хүрсэн сонгогчдын 47% төвлөрөн амьдардаг Улаанбаатар хотод явуулсан болно. Судалгааны түүврийг нас, хүйс, ажил мэргэжлийн ялгаатай байдлын төлөөлөх чадварыг жигд хангах замаар санамсаргүй түүвэрлэлтийн аргаар хийж явуулсан учраас судалгаанд оролцогчдын төлөөлөх чадвар өндөр байв. Судалгааны эх олонлог Улаанбаатар хотын Сонгино хайрхан, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүргүүдийн иргэд, сонгогчид юм.

Судалгаагаар бидний тодруулахыг зорьсон эхний асуудал бол иргэдийн улс төрийн оролцооны хэлбэр, чиг хандлагыг тодруулах явдал байв. Тэрээр “Нийгэм, улс төрийн амьдралд Та өөрийгөө ямар түвшинд оролцдог гэж дүгнэж байна вэ?”²⁶³ гэсэн асуултад судалгаанд оролцогчид дараах хариултыг өгсөн байна.

Хүснэгт.1

д.д	Хариулт	Хувь
1	Тогтмол оролцдог	8.7%
2	Заримдаа оролцдог	63.5%
3	Огт оролцдоггүй	20.1%
4	Хариулж мэдэхгүй	7.8%

Судалгааны дүнгээс үзэхэд Монголчуудын улс төрийн оролцоотөдийлөн сайнгүй байгаа дүн гарч байна. Иргэд өөрсдийнхөө улс төрийн оролцоог хүнийссэн байдлаар тайлбарлаж буй нь хамгийн их анхаарал татаж байна. Учир нь судалгааны дүнгээс харвал улс төрийн амьдралд хааяа нэг оролцдог гэж үзсэн иргэд нийт судалгаанд хамрагдагсадын 63.5% байгаа нь өндөр үзүүлэлт юм. Ингэж өөрийнхөө улс төрийн оролцоог үнэлж буй иргэдийн ихэнх нь дөрвөн жилд нэг болдог сонгууль, сонгуулийн оролцоогоор өөрийнхөө улс төрийн оролцоог дүгнэж байна. Сонгууль улс төрийн оролцооны түгээмэл хэлбэр мөн боловч зөвхөн сонгуулиар улс төрийн оролцоог ойлгож, хандах нь учир дутагдалтай билээ. Судалгаанд оролцогчдын 29% нь нийгэм, улс төрийн амьдралд огт оролцдоггүй эсвэл хариулж мэдэхгүй байгаа нь иргэдийн улс төрд хандах хандлага ямар доогуур түвшинд байгаа харуулж байна. Ингэж өөрсдийнхөө улс төрийн оролцоог сөргөөр үнэлж, дүгнэж буй хэсгийн санал бодолд нийгэм, ахуйн орчин, аж амьдралын байдал суурь нөлөө үзүүлж байгаа юм. Улс төрөөс иргэдийн амьдрал ахуйн хамаарал харьцангуй бага Өрнөдийн орнуудын сонгогчдын үйл байдалтай харьцуулахад ингэж улс төрөөс хүнийсэх болсон шалтгаан Монголчуудын хувьд өөр байгаа нь судалгааны явцад тодорсон юм. Чинээлэг дундаж давхарга нийгмийн олонхи болсон Өрнөдийн нийгэмд ямар нам, улс төрийн хүчин, улс төрч засгийн эрхэнд гарахаас хамаарч иргэдийнх нь амьдрал ахуйд хүчтэй савлалтыг бий болгодоггүй, улс төрийн бодлогын тогтвортой залгамж чанар хадгалагдаж байдаг нь иргэдийнх нь улс төрөөс хүнийсэх (хамааралгүй болох) үндсэн шалтгаан юм. Харин Монголд чинээлэг тогтвортой дундаж давхарга бүрэлдээгүй учраас иргэдийн аж амьдрал улс төрөөс хэтэрхий их хамааралтай байсаар л байна. Ийм байдал нь иргэдийн улс төрөөс хүнийсэх, улс төрийн нам, улс төрчдөд үл итгэх итгэлийг бий болгох шимтэй хөрс болсоор байгаа юм.

Судалгааны явцад бидний тодруулахыг эрмэлзсэн өөр нэг асуудал нь бол иргэдийн улс төрийн оролцоонд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсээс илүүтэй нийгэм, улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцоход хүргэдэг нөлөөлөгч хүчин зүйлсийг олж тогтоох явдал байв. Үүнийг тодруулахын тулд бид Таныг өөрийн амьдарч буй хороо, дүүрэг болон улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагын зүгээс зохион байгуулдаг аливаа үйл ажиллагаанд оролцоход хүргэдэг нийгэм, эдийн засаг, улс төрийн нөлөөлөгч хүчин зүйлсийг юу вэ? гэсэн асуулт тавьж хариулт авсан юм. Судалгаанд оролцогчдын хариулсан байдлыг доорх хүснэгтээр харуулья²⁶⁴.

Хүснэгт.2

д.д	Нөлөөлөгч хүчин зүйлс	Хувь
1	Нийгмийн тулгамдаж буй асуудлууд (ажилгүйдэл, ядуурал)	40.4%
2	Хүний эрхийн зөрчил	6.8%
3	Улс төрийн оролцооны нээлттэй бус орчин	4.1%
4	Хувийн ашиг сонирхол	14.7%
5	Нийгмийн бухимдал, стресс	5.5%
6	Нийгмийн шударга бус байдал	16.4%
7	Төр, намд үл итгэх итгэл	3.8%
8	Бусад	8.2%

Судалгааны дээрх дүнгээс харахад иргэдийн нийгэм, улс төрийн үйл ажиллагаанд оролцоход нөлөөлөгч суурь хүчин зүйл нийгмийн учир шалтгаантай байгаа нь нотлогдож байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын 60.4% нь өөрсдийн улс төрийн оролцооны үндсэн шалтгааныг нийгмийн хүчин зүйлстэй(ажилгүйдэл, ядуурал, нийгмийн стресс, нийгмийн шударга бус байдал гэх мэт) шууд холбон үзсэн байна.

²⁶³ Монголчуудын улс төрийн оролцоо, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа. МУИС. УБ. 2015

²⁶⁴ Монголчуудын улс төрийн оролцоо, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа. МУИС. УБ. 2015

Харин улс төрийн оролцооны ямар хэлбэрийг илүүтэй сонгож оролцдог вэ? гэсэн асуултад хариулсан дүн дараах байдлаар гарсан байна. Үүнд.

Хүснэгт. 3

д.д	Оролцооны хэлбэрүүд	Хувь
1	Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ханддаг	30.9%
2	Төрийн байгууллагад ханддаг (утсаар, захидлаар, өргөдөл, гомдол, хэвлэлийн хурал гэх мэт)	43.8%
3	Жагсаал, цуглаанд оролцох хэлбэрээр	12.9%
4	Дээрх бүх хэлбэрээр	12.4%

Судалгааны дээрх бүгдээс харахад Монголчуудын улс төрийн оролцоондоо хэвлэл мэдээллийн хэрэгсэл, захидал, харилцаа, хэвлэлийн хурал зэргийн өргөн ашигладаг болсон байна. 1990 оны эхээр ихэнхдээ жагсаал цуглаанд оролцох хэлбэрээр өөрсдийн улс төрийн оролцоогоо хангадаг байсан бол хэвлэл мэдээллийн орчин үеийн хөгжлийн ололт амжилтууд нийгмийн бүх салбарт тэр дундаа улс төрийн салбарт маш хүчтэй нөлөө үзүүлдэг хэрэгсэл болсон байна. Яг энэ асуудалтай уялдуулан бид дараагийн асуултаа улс төр ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн харилцан хамаарал, улс төрд медиа хэрэгслийн нөлөөлөх нөлөөллийг тодруулах зорилго тавьж дараах асуултыг асуусан юм. Та амьдарч буй хороо, дүүрэг, хот, улсын хэмжээний асуудлаарх мэдээллийг ямар сувгаар ихэвчлэн авдаг вэ?²⁶⁵ гэсэн асуултад дараах хариултуудыг өгсөн байна. Үүнд,

1. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр - 81%
2. Танил найзуудаас аман хэлбэрээр - 8.5%
3. Төрийн байгууллагын мэдээллээс - 5.1%
4. Төрийн бус байгууллагын мэдээллээс - 4.9%
5. Хариулаагүй - 1.7% тус тус үзсэн байна.

Эндээс үзэхэд иргэдийн мэдээллийг хүлээн авдаг хамгийн чухал хэрэгсэл бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл болж байна. Ийм байхаас ч өөр аргагүй юм. Нийгмийн тогтолцооны аясыг дагаад манай орны олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн (ОНМХ) үйл ажиллагаанд зохих өөрчлөлт орсон нь иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал нөлөөг үзүүлж байгаа билээ.

1990-ээд оноос хойш ОНМХ нь нэг намын суртал ухуулгыг дамжуулагч биш, харин олон ургалч үзлийн гол индэр нь болж хувирсан байна. Жишээ нь, аливаа асуудлаар эсрэг тэсрэг байр суурь баримтлаж байгаа улстөрч, эдийн засагч гээд янз бүрийн ажил мэргэжлийн хүмүүсийг урьж, тэдний үзэл бодлыг уралдуулж, дүгнэлт хийх бололцоо олгодог хэлэлцүүлэг, мэтгэлцээн, ярилцлагын нэвтрүүлгийг телевизүүд хамгийн олон үзэгчтэй байдаг “оргил цаг”-аар нэвтрүүлж байна. Тухайлбал, МҮОНТВ-ийн “Эвлүүлэггүй яриа”, “Ярилцъя”, “De Facto”, “Нээлтэй хэлэлцүүлэг”, 25-р суваг телевизийн “Дуусдаггүй яриа”, С1 болон 2-р суваг телевизээр дамжуулдаг “Цензургүй яриа”, Монгол HD телевизийн “Нүүдэл шийдэл” зэрэг олон нэвтрүүлгийг энд дурьдаж болно.

Олон нийтийн статустай радио, телевиз байгаа эсэх нь ардчилсан орнуудын хувьд нэг чухал үзүүлэлт болдог. Байгуулагдсан цагаасаа хойш төрийн мэдэлд байсан Монголын Үндэсний Радио, Монголын Үндэсний Телевизийг 2005 онд “олон нийтийн” статустай болгосон юм. Монгол Улсын парламент 2005 оны нэгдүгээр сарын 27-нд Олон нийтийн радио телевизийн тухай хууль батлан, улмаар энэ хуулийг 2005 оны долоодугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхлэсэн. Ингэснээр үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ дамжуулдаг Монголын ууган радио, телевизийн үйл ажиллагаа, нийтлэл нэвтрүүлгийн бодлогод төрийн зүгээс ямар нэгэн нөлөө үзүүлэх эрсдэлийг багасгаж чадсан. Үндэсний хэмжээний радио, телевиз нь олон нийтийн статустай болсноор иргэд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэхэд таатай нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж болно.

Орчин үед олон нийт ОНМХ-д өөрийн санал санаачлагаар хандаж үзэл бодлоо илэрхийлэхээс гадна интернэтийн орчинд нийгмийн сүлжээгээр эсвэл блог нээж нийтлэл бичиж өөрийн байр сууриа илэрхийлэх нь түгээмэл байна. Жирийн иргэн шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад тодорхой хэмжээгээр нөлөөлөхийг хичээж байгаа энэ үзэгдлийг иргэний сэтгүүл зүй нэрлэдэг. Сэтгүүл зүй судлаач Л.Норовсүрэн “Иргэний сэтгүүл зүй нь интерактив сэтгүүл зүйн нэг хэлбэр бөгөөд амьдралын өөр өөр түвшний хүмүүсийг сонин сэтгүүлд өгүүлэл материал бичүүлэх, амьдралаас олж илрүүлсэн зүйлээ мэдээлэхэд өргөнөөр татан оролцуулдаг сэтгүүл зүйн үйл ажиллагаа юм” хэмээн тодорхойлжээ.²⁶⁶ Иргэний сэтгүүл зүйн сэдэв маш өргөн хүрээг хамардаг. Тэдгээрийн дотроос хүний эрх, эрх чөлөө хамгаалах, байгаль, экологийн асуудал, дэлхийн дулаарал, байгалийн гамшигт үзэгдлээс иргэдэд учирч болох аюулаас урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг багасгах, нийгэмд шударга ёс тогтоож, ардчиллын зарчмыг хэрэгжүүлэх, авлигатай тэмцэх, жирийн иргэд, эмзэг бүлгийнхэнд тулгарч байгаа амьдралын бэрхшээлийг хөнгөлөх зэрэг асуудлаар төр засагт шахалт, шаардлага тавьсан асуудал хөндсөн нийтлэл сүүлийн жилүүдэд иргэдийн идэвх санаачлагыг өрнүүлэх, оролцоог нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлэх боллоо. Иргэдийн тодорхой хэсэг өөрсдийн аж

²⁶⁵ Монголчуудын улс төрийн оролцоо, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа. МУИС. УБ. 2015

²⁶⁶ Л. Норовсүрэн. Иргэний нийгэм ба иргэний сэтгүүл зүй. УБ., 2011. МУИС-ийн ЭШБ. №12 (370) х.23

төрж байгаа хорооны нутаг дэвсгэрийг цэвэр тохилог байлгах асуудлыг хөндөж ОНМХ-д хандах, энэ тухай санал санаачлага цахим орчинд нийтлэх, улмаар холбогдох албан тушаалтны сонорт хүргэж байгаа үйл ажиллагаагээр энэ бүхэн илэрч байна.

Ардчилсан нийгэмд хүн бүр нийгмийн хөгжил дэвшлийн төлөө байр сууриа илэрхийлж, өөрийн итгэл үнэмшилээ хамгаалах, бусадтай санаа бодлоо хуваалцах эрхтэй. Энэ эрхээ эдлэх хамгийн түгээмэл хэлбэр бол ОНМХ-д шууд хандах, интернэтийн орчинд “иргэний сэтгүүл зүй”-г ашиглах явдал юм. Улстөрчид ч иргэний сэтгүүл зүйг ашиглаж өөрсдийн байр сууриа олон түмэнд хүргэх нь хамгийн тохиромжтой гэж үзэж байна. Харин хэвлэл мэдээллийн хэрэгслээр авч буй мэдээ, мэдээллийн үнэн бодитой байхын сацуу тэнцвэртэй байх явдал хамгийн чухал байдаг. Судалгааны явцад энэ талаар асууж тодруулахад дараах хариултуудыг өгсөн байна. Таны авч байгаа мэдээлэл үнэн бодит, тэнцвэртэй байж чаддаг уу?²⁶⁷

- | | |
|---------------------------------------------|---------------------------------|
| 1. Үнэн бодитой гэж боддог | - 22.6% |
| 2. Нягтлан шалгах шаардлагатай гэж боддог | - 65.6 |
| 3. Үнэн бодит байдалд ач холбогдол өгдөггүй | -11.8% тус тус хариулсан байна. |

Үүнээс үзэхэд хэдийгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл иргэдийн мэдээлэл авах хамгийн гол суваг болж чадаж буй боловч мэдээллийн үнэн бодит байдалд эргэлзэж буй байдал давамгайлж (65.6%) байна. Иргэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр авч буй мэдээллийнхээ үнэн бодит байдалд ийнхүү эргэлзэж буй нь нэг талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн цацаж буй мэдээллийн тодорхой хэсэг нь зориудын шинжтэй, цаанаа тодорхой бодлого агуулсан байдагтай, нөгөө талаар иргэдийн мэдээллийг цензурдэх, шүүн тунгааж үнэн, худлыг ялгах чадвар сул байгаагаар шууд холбоотой гэж дүгнэж болохоор байгаа юм.

Судалгаагаар тодруулахыг зорьсон дараагийн асуудал бол иргэд улс төрийн оролцооны олон хэлбэрийг ашиглан өөрсдийн оролцоогоо нэмэгдүүлснээр төр засгийн хийгээд орон нутгийн түвшний шийдвэр гаргалтад нөлөөлж чадаж буй талаарх сэтгэл ханамжийг тандах явдал байв. Улс төрийн оролцооны олон талт хэлбэрийг ашиглаж оролцоогоо нэмэгдүүлснээр Та аливаа шийдвэр гаргалтад нөлөөлж чаддаг уу?²⁶⁸ гэсэн асуултад дараах хариултуудыг өгсөн байна. Үүнд,

- | | |
|--------------------------------------------------------|----------------|
| 1. Тийм. Оролцоогоо хангаж чадаж байна | - 13.8% |
| 2. Үгүй.Оролцоогоо хангаж чадахгүй байна | - 22.2% |
| 3. Хангалттай биш ч бодол саналаа илэрхийлж байх ёстой | - 63.0% |
| 4. Хариулаагүй | - 1.0% тус тус |

үзсэн байна.

Эндээс дүгнэхэд оролцоогоо хангаж чадахгүй байна, хангалттай биш гэж үзсэн респондентын жин 85.2% байгаа нь маш ноцтой асуудал юм. Хэдийгээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийгэм, улс төрд үзүүлэх нөлөө нэмэгдэж буй боловч иргэдийн дуу хоолойг төр засагт хүргэж бодлогод нөлөөлөх түвшинд хүрээгүй гэж иргэд үзсэн байна. Энэ нь нэг талдаа иргэдийн өдөр дутмын амьдрал, нийгмийн өмнө тулгамдсан олон асуудлыг төр шийдвэрлэх боломж хомс байгаагаас үүдсэн иргэдийн бухимдал, нөгөө талдаа тэрхүү нийгмийн бухимдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан намжаах гэсэн шийдвэр гаргагчдын бодлого, үйл ажиллагаатай холбоотой гэж үзэж болно.

ДҮГНЭЛТ

Монголын иргэд, сонгогчдын улс төрийн оролцооны хэлбэр, төлөв байдал, түүнд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үзүүлэх нөлөө 1990 оноос эрчимтэй нэмэгдэж ирсэн. Эдүгээ иргэдийн мэдээлэл авах, түгээх хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдэж тэр хэрээр хэвлэл мэдээллийн хэрэгслээс нийгэм рүү чиглэсэн мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийн бодлогод зохих ахиц, дэвшлүүд гарч хөгжсөөр байгаа билээ.

Мөн нийгмийн хөгжил, өөрчлөлтийг даган сонгогчдын улс төрийн ухамсар, үйл байдалд томоохон өөрчлөлтүүд гарчээ. Ийнхүү өөрчлөлт гарах үндсэн шалтгаан нь нийгмийн хөгжлийн суурь асуудлуудтай холбоотой ч ардчилал, тэр дундаа оролцооны ардчилал бидэнд ийм боломжийг олгож буй юм. Бидний хийсэн судалгаанаас дүгнэхэд Монголд улс төрийн оролцоо, оролцоот ардчиллын олон хэлбэрүүд нэгэнт бодит байдал болсон байна. Харин тэдгээрийг цаашид бэхжүүлж, хөгжүүлэх асуудал чухал байгаа нь харагдаж байна. Тиймээс иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, оролцоот ардчиллыг хөгжүүлэхэд дараах алхамуудыг хийх чухал ач холбогдолтой гэж дүгнэж буй болно. Үүнд,

- Нийгмийн өмнө тулгамдаж буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэх гарцыг зөв тодорхойлсон бодлого гаргаж хэрэгжүүлэх
- Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдийн нийгмийн тэгш бус байдлыг халах
- Үндсэн хуулийн өөрчлөлтөөр орон нутаг, сум, хорооны тулгамдсан асуудлыг иргэд өөрсдөө хэлэлцэж шийдвэрлэдэг тогтолцоог бий болгох

²⁶⁷ Монголчуудын улс төрийн оролцоо, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа. МУИС. УБ. 2015

²⁶⁸ Монголчуудын улс төрийн оролцоо, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа. МУИС. УБ. 2015

- Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдал (улс төрчид, намууд, бизнесмэнүүдээс)-ыг хангах, эрх зүйн орчинг сайжруулах
- Мэдээллийн үнэн бодит байдалд хөндлөнгийн хараат бус байгууллага мониторинг хийж, хянадаг болох
- Иргэдийг үзэл бодол, намын харьяаллаар ялгаварлан гадуурхахыг таслан зогсоох
- Хүний эрхийн зөрчил (үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх, жагсаал цуглаан хийх, аливаа байгууллагад элсэн орох, эвлэлдэн нэгдэх гэх мэт хүний үндсэн эрхүүд)- ийг бууруулах, таслан зогсооход төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэн бэхжүүлэхээрэгт төр бодлогоор анхаарч ажиллах шаардлагтай байна.

Иргэд, сонгогчдын зүгээс ч үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх, оролцоогоо нэмэгдүүлэхэд чиглэсэн аливаа үйл ажиллагаанд хуулийн хүрээнд оролцож нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд анхаарах цаг болсон байна. судалгааны дүнгээс харахад Монголчуудын дийлэнх нь шаардлага гарвал нийгэм, улс төрийн аливаа үйл ажиллагаанд татагдан ордог байна. Энэхүү улс төрийн оролцооны албадлагын хэв маягаас идэвхтэй оролцооны хэв маяг руу шилжих явдал чухал байна. Хэрэв шилжиж чадвал оролцоот ардчиллыг Монголд хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

НОМ ЗҮЙ

1. Д.Лүндээжанцан. Эрх мэдэл ба ардчилал. УБ., 2015
2. А.Лийпхарт. Ардчиллын хэв загвар. Гучин зургаан орны төр засгийн хэлбэр ба илрэл. УБ., 2009
3. Монголын ардчиллын төлөвшил. Хамтын бүтээл. ШУА. ФСЭХ. УБ., 2011
4. Монголын нийгмийн өөрчлөлт. Хамтын бүтээл. ШУА.ФСЭХ.УБ., 2008
5. Ардчилал: асуудал, эрэл, шийдэл. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2012
6. Зулькафиль М. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ.,
7. Зулькафиль М. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ. 2005
8. Норовсүрэн Л. Иргэний сэтгүүл зүй. УБ., 2011
9. Мэндхүү Г., Өнөрсайхан Т. Мэргэжлийн телевиз. УБ.,2015
10. Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992
11. Сонгуулийн хууль. УБ., 2015
12. Улс төрийн намын тухай хууль. 1990
13. Төрийн бус байгууллагын тухай хууль. 1995
14. Roskin C, Medeiros J. Political Science an Introduction. Pearson., 2012
15. Macpherson C.B. The Real World of Democracy. Oxford: Oxford University Press 1966
16. Benjamin R. Barber. Strong Democracy: Participatory Politics for a New age. Berkeley. California University Press 1984

“ТӨРИЙН АЛБАН ХААГЧ”-ИЙН ИМИЖ БҮРДҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ ЯВЦАД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН НӨЛӨӨ

У.БАТЦЭРЭН

*ШУА-ийн Философийн хүрээлэн, Улс төр судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан,
Улс төр судлалын тэнхимийн докторант*

Товч агуулга: 1990-ээд оны сүүлээр телевиз, радио, сэтгүүл зэрэг хэвлэл мэдээлийн хэрэгслийг ашиглан улс төрчид болон төрийн албан хаагчид өөрийн имижээ бүрдүүлж байсан бол өнөө үед интернэт орчинг илүүтэй ашиглаж байна. Учир нь цахим орчинг хэвлэл мэдээллийн нэгэн хэрэгсэл хэмээн үзэх хандлага бий болсон цагт төрийн албан хаагчийн имижийг бүрдүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг маш чухал юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй нийтлэл, нэвтрүүлэг, зурагт хуудас зэргийн чанар, ерөнхий чиг хандлага нь олон нийтэд хэрхэн хүрч байгаа болон нийгмийн шаардлагад хэрхэн нийцэж байгаагаар төрийн албан хаагчийн имиж нь тодорхойлогдох боломжтой юм. Өнөө үеийн төрийн албан хаагчийн имиж нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн анхаарлын төвд байдаг нийгмийн үзэгдэл юм.

Түлхүүр үг: Төрийн албан хаагч, удирдлага, олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сонин, сэтгүүл, сэтгүүлч, имиж, улс төрийн имиж, имиж бүрдүүлэлт, ёс зүй.

Abstract: In the latest of the 90s politicians and public servants who formed their own image through the press and media such including with TV, radio and journals or magazines, in the nowadays, they have been using internet based communication environment in forming their imageology and status behaviour. However, the state-of-the-nature of cyberia is performed by the most preferable trends in the forming imageology of public servants, which is the major tools of the press and media for their performance. The imageology of public servants should be defined by the two types of determinations such as tolerances and outreach to the public and and social demands in the general tendency and its quality of posters, broadcasting and publication and further performance of imageology of public servants. Contemporary image of public servants is the major attention to the press and media which is performing the main part of the social appearances.

Төрийн албан хаагчийн имиж бүрдүүлэлтийн асуудлыг авч үзэх тохиолдолд “имиж” хэмээх ойлголтын учир холбогдлыг тайлбарлахад зүй ёсоор хүргэдэг. “Имиж” гэдэг нь (*латинаар image, оросоор имидж*) шинж төрх, нэр хүнд, төсөөлөл, зураг, орон зай зэрэг олон салаа утга агуулга бүхий ойлголт юм. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн гаргасан “*Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь*”-д “имиж – хүн, хүний үйл ажиллагааны тухай тодорхой ойлгоц өгөхүйц төсөөллийг илтгэн харуулах цогц дүр, нүүр царай, дүр төрх”²⁶⁹ хэмээн тайлбарласан байна. Доктор Ё.Довчин “*Улс төрийн үг хэллэг нэр томъёоны толь*”-д “image – төрх төлөв, дүр, төсөөлөл – имидж, образ, представление”²⁷⁰ хэмээн тайлбарласан байна. Харин английн судлаач Э.Сэмпсон “Таны хувийн имиж бол таны зураг юм. Та имижгүй байж чадахгүй. Та хүссэн ч бай хүсээгүй ч бай таны хүссэнээс үл шалтгаалан бусдад үзүүлэхээр өөрөө сонгож авсан тэр л зүйлийг хүмүүс харж байдаг. Тэр зүйл бол Таны имиж” хэмээн өгүүлсэн байдаг. Эндээс үзвэл төрийн албан хаагчийн дүр төрхийн чухал үзүүлэлт нь имиж болох нь тодорхой байна. Харин тэдний имиж ямар байгаагаас нь хамааран тухайн албан хаагчийн явуулж буй үйл ажиллагаа, ажлын амжилт зэрэг нь тодорхойлогдож болох юм.

Өнөөдөр төрийн албан хаагчийн имижийг бүрдүүлж буй зонхилогч хүчин зүйл, технологи нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл болж байна. XXI дүгээр зуунд хэвлэл мэдээллийн технологи эрчимтэй хөгжиж улмаар аливаа улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжил түүнээс ихээхэн хамааралтай болж буй нь илэрхий мэдрэгдэх боллоо. Үүнтэй холбогдон Монгол улсад хэвлэл мэдээллийн үзэгдэл нь улс төрийн амьдралыг бүхэлд нь болон төрийн үйл ажиллагаа, төрийн албан хаагчдад ихээхэн хүртээмжтэй болж байна.

Өнөө үед хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан имижээ бүрдүүлэх, өсгөх үйл явцыг тусгайлан судалж энэ хүрээнд судалгааны тодорхой аргачилал боловсруулах талаар эрдэмтэн судлаачид болон улс төрчид анхаарах болов.

Төрийн албан хаагчийн имиж бол хэдийгээр мөн чанараараа субъектив чанартай гэсэн ч үнэлгээний суурь хүчин зүйлд тооцогддог. Тэр нь төрийн удирдлагын бүх явцад хамгийн их нөлөө үзүүлдэг Төрийн албан хаагчийн имиж гэдэг нь уг чанартаа: төр – захиргааны байгууллагын ажилтан болсон төрийн албан хаагчийн талаарх олон түмний ухамсарт туссан дүр зураг, төсөөлөл юм.

²⁶⁹ “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”. II боть. МУ-ын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн. Ред: Болд Л. нар, УБ., 2008, 773 дахь тал.

²⁷⁰ Довчин Ё. “Улс төрийн үг хэллэг нэр томъёоны толь”. УБ., 2005, 108 дахь тал.

Имиж нь сайн, муу үйл, сайхан, муухай, гоё, гаж, ашигтай, ашиггүйн тухай ёс суртахууны үнэлэмж болон мэдрэмжийг өөртөө агуулдаг. Имиж нь ерөнхий агуулгаараа хүмүүст эерэг дүр төрхийг төрүүлдэг урлаг хэрнээ тодорхой практик үйлдэл дээр нийтээр зөвшөөрөгдсөн хэм хэмжээтэй зөрчилдөх тал байдаг. Ажилтны имиж нь гадаад байдал, ерөнхий дүр төрхөөрөө илрэх ч зарим талаараа түүний оюун ухаан, дотоод сэтгэлээс нь нилээдгүй хамаардаг. Тухайлбал, гадаад байдал гэдэгт хувцаслалт, биеийн хэл, төрх болон бусдын нүдэнд харагдах байдал, ажлын байрны эмх цэгц, эелдэг харьцаа, нүдний харц, дууны өнгө гэх мэт олон зүйлийг дурдаж болох юм. Харин оюун санаа гэдэг нь хэл ярианы эмх цэгц, гаргасан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт, олон түмэнд шууд хүрч буй үйл ажиллагаа зэргээс ихээхэн шалтгаалдаг байна.

Төрийн албан хаагчийн гадаад илрэл бүхэн тэр бүр дотоод мөн чанараа бүрэн тусгаж чаддаггүй. XIV далай ламын өгүүлсэнээс жишээлэн үзвэл: “Хэн нэгэн алдартны аятайхан зүс царайны цаана зохистой зан чанар байгаа эсэхийг бид мэдэж байх шаардлагатай. Бие хүний гадаад хийгээд дотоод байдалд зөрүү байх ёсгүй. Эцсийн эцэст энэ бол нэг л хүн шүү дээ. Харин зөрүүтэй ойлголт түүнд итгэж болохгүй гэдгийн илэрхийлэл болно”²⁷¹ хэмээн нэгэнтээ дүгнэн хэлсэн байдаг.

Төрийн албан хаагчийн имижийг жирийн хүнийхтэй жишиж үзвэл тэрээр зохих эрх мэдэл, хэм хэмжээ, албан тушаал, зэрэг дэв бүхий байдгаараа ялгаатай. Харин түүний имижийг дагаад тэр хэмжээгээр өндөр үүрэг хариуцлага оногддог. Нэг үгээр хэлбэл, төрийн албан хаагчийн имиж нь төрийн албаны нэр хүндийг бүхэлд нь илэрхийлж байна гэсэн үг. Энэ нь төрийн албан хаагч нь зөвхөн өөрийнхөө төлөө төдийгүй бусдын сайн сайхны төлөө ажиллаж амьдардагтай холбоотой. Энэ нь бусдад эерэг, сөрөг ямар нэг байдлаар нөлөө үзүүлэх талтай. Учир нь төрийн албан хаагч хүн ямар ч тохиолдолд хууль дүрэм, хэм хэмжээгээ барьж шудрага ажиллах үүрэгтэй. Энэ нь зарим хүмүүст таалагдах, эс таалагдах нь байдаг. Ер нь бүрэлдэн бий болсон, хайрцаглагдсан имижийг өөрчлөхөд бэрхшээлтэй, эмзэг байдаг төдийгүй түүнээс шууд хамааралтайгаар хүмүүс хоорондын харилцаанд ч сөрөг байдал үүсч болдог. Ингэхээр төрийн албан хаагч бусад хүмүүсийн нэгэн адил ёс суртахуун, шудрага ёсны хэм хэмжээний зарчмыг сахих ёстой. Иймд төрийн албан хаагчийн имиж бүрдүүлэлт, имижийн бүтэц дараах гурван бүрдэл бүхий өвөрмөц талтай байж болох юм. Үүнд:

1. Бие хүн, тухайн төрийн албан хаагчийн өөрийн имиж
2. Өөрөөр нь тодохойлогдох байгууллагын имиж
3. Өөрөөр нь илэрхийлэх нийгэм, соёлын имиж

Имижийн дээрх бүтэц нь цаг хугацааны хувьд төрийн албан хаагчийн бодлого, зорилго, чиглэлтэй нь уялдаж. Иймд төрийн албан хаагчийн имижийг бүрдүүлэх хамгийн үр дүнтэй, ашигтай хэлбэр бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэр дундаа цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл юм.

Өнөө үед имиж бүрдүүлэхэд зонхилох үүргийг цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу цахим ертөнц, радио, телевиз гүйцэтгэж байна. Эдгээр нь өргөн цар хүрээтэй, шуурхай мэдээлэх боломжтой, харьцангуй хямд төсөр, олон түмэнд хүртээмжтэй, тэдний сонирхлыг цаг тухайд нь тагдаг зэрэг олон талаараа давуу тал онцлогтой. Цахим орчинг хэвлэл мэдээллийн нэгэн төрөл мөн эсэх, эсвэл тэр нь бие даасан нөлөөллийн хэрэгсэл үү? гэх зэргээр өнөө үед маргах нь байдаг. Гэхдээ ямар ч шалгуураар авч үзлээ гэсэн энэ нь хэвлэлийн хэрэгслийн нэгэн төрөл болж таарах байх. Гэхдээ өөрийн онцлог бүхий хэрэгсэл гэдэг нь ойлгомжтой.

Харин хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох сонин, сэтгүүл, зурагт хуудас зэрэг нь цахим мэдээллийн хэрэгслээс ялгагдах өөрийн онцлогтой. Өнөөгийн Монгол улсын хэмжээнд цахим ертөнцийн хүрч чадахгүй алс хязгаар газарт зөвхөн шуудангаар хэвлэл хүрч байгаа цагт хэвлэл мэдээллийн хэрэгслээр имижийг бий болгон бүрдүүлэх нь онцгой ач холбогдолтой. Учир нь манай улсын нийт нутаг дэвсгэрийн 80% орчим хувь нь бэлчээрийн тал нутаг буюу 1,564,116 хавтгай дөрвөлжин км юм. Түүнчлэн бид гарт баригдаж өөрийн нүдээр харсан зүйлдээ илүү итгэлтэй байдагтай ч холбоотой юм. Төрийн албан хаагчийн имиж нь өдгөө хамгийн их асуудал дагуулсан хэвлэл мэдээллийн чухал сэдэв болоод байна.

Манай улс 1990 оноос хойш хэвлэл мэдээллийн хувьд харьцангуй чөлөөт улс болсон. Үүнийг дагаад хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн орлого, борлуулалтаа нэн тэргүүнд тавин нийгэмд болсон янз бүрийн үймээн шуугиантай материал, нийгмийн сэтгэл хөдлөлийг дэвэргэсэн зүйлсийг ихээр нийтэлж байна. Энэ нь мөн чанартаа төрийн албан хаагчийн имижийн талаарх сөрөг ойлголт, төсөөллийг олон нийтэд илүүтэй харуулж буй хэрэг юм. Сөрөг мэдээлэл, цуу үг болон сонссон зүйлээ магадлалгүйгээр бичих нь олон түмэнд үнэн мэдээлэл хүргэх үүргээ зөрчих төдийгүй, төрийн байгууллагын тодорхой шийдвэрийг үл тоомсорлох улмаар төрийн албан хаагчийн нэр хүндийг гутаах, олон нийтийг үнэн бодит мэдээллээс тусгаарлах зэрэг сөрөг талтай. Иймд сонин, сэтгүүлийн редакцийн зүгээс өөрийн сэтгүүлчдийнхээ улс төрийн үзэл баримтлал, ёс зүй, зан суртахууны талаар цаг ямагт анхаарч байх ёстой болдог. Үүнтэй холбоотойгоор төрийн албан хаагчийн эерэг имижийг хэрхэн бүрдүүлэх гэсэн асуудал гарч ирдэг. Төрийн албан хаагчийн имижийг дараах арга замын дагуу эерэгээр бүрдүүлж болох юм. Үүнд:

- Олон нийтийн хүсэн хүлээсэн мэдээ, мэдээллийн цаг тухайд нь аль нэг талыг өрөөсгөлөөр барилгүй хүргэж байх;
- Төрийн болон, хэвлэл мэдээллийн байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулан, тэдгээрийн хооронд харилцан чөлөөтэй мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлэх;

²⁷¹ Мөнхбаяр Б. “Имижийн хэрэглээний талаар ойлголт”. нийтлэл, эх сурвалж: http://ulstur-tech.blogspot.com/2010/10/blog-post_9739.html. УБ., 2016.01.11.

- Төрийн албан хаагчдаас хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан хэлсэн үг, үгийн давтамж зэрэгт засвар, нэмэлт тайлбар зэргийг хийлгүй олон нийтэд хүргэж байх зэрэг олон ажлыг хийж болох юм.

Өнөөдөр хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь бодит байдлыг байгаагаар нь харуулах төдийгүй, олон нийтийн санаа бодол, түүнчлэн төрийн аппаратын болон төрийн албан хаагчийн харилцааг төлөвшүүлэхэд чухал нөлөөлөлтэй байна. Амьдрал дээр хүмүүс улс төр болон төрийн албан хаагчийн тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр л дамжуулан олж авдаг бөгөөд энэ тохиолдолд тэдний төсөөлөл нь ерөнхийдөө ойролцоо буюу ижил төстэй байх нь түгээмэл байдаг.

Өнөөгийн хэвлэлийн мэдээлэл уншигч олон түмний ухамсарт төрийн албан хаагчийн нийтлэг дүр төрх, имижийн талаар ямар ойлголт өгч байна вэ? Ер нь хэвлэл мэдээлэл, сонин сэтгүүлийн тухайд хүмүүс ямар сэтгэгдэлтэй байдаг талаар манай улсад тэр бүр доривтой судалгаа хийгдээгүй өдий хүрчээ. Гэтэл хоёр хөрш улс маань энэ талаар нилээдгүй судалгаа хийдэг нь нэг талаараа аливаа зүйлийг шинжлэх ухааны гүнзгий үндэстэй авч үзэх нөгөө талаас цаг үеийн нөхцөл байдалдаа дүн шинжилгээ хийж цаашид улам хурдтай хөгжиж боломжийг бүрдүүлж байна. Тухайлбал; Оросын судлаачдын судлаж үзсэнээр төрийн албан хаагчийн имижийг бүрдүүлэхэд хамгийн идэвхтэй нөлөө үзүүлж байгаа нь өдөр тутмын сонин, сэтгүүл байдаг аж. Харин манай улсын хувьд “Өдрийн сонин”, “Зууны мэдээ”, “Өнөөдөр” зэрэг өдөр тутмын сонингууд голчлон төрийн албан хаагчийн талаарх имижийг олон нийтэд таниулахын зэрэгцээ тэдний имижийг тодорхой хэмжээнд бүрдүүлэхэд нөлөө үзүүлж байна. Харин шар сонингууд голцуу имижийг нь саринуулах, хуваах талын сөрөг мэдээ мэдээллийг олон нийтэд голчлон хүргэж байдаг нь харагддаг. Гэхдээ манайд ер нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд имижийн асуудлыг боловсруулж, түүнийг тодорхой шугамаар, тайлбартай, нарийн илэрхийлсэн зүйл тэр бүр байдаггүй. Харин оросын судлаачид дээрх асуудлыг хөндөн дараах зүйлс анхаарлаа хандуулан судлаж үзсэн байна. Үүнд:

- албан үүргээ нэр төртэй биелүүлэхгүй байгаа;
- ашиг сонирхолын сөргөлдөөн;
- хутган үймүүлэх;
- удирдлагын ёс бус байдал;
- хөдөлмөрийн хөлсний шударга биш хуваарилалт;
- албан тушаалд томилох, халахад хууль зөрчих;
- авилга ба хээл хахууль;
- хөдөлмөрийн хүнд муу нөхцөл;
- албан хаагчийн хувийн амьдралын эрхийг үл тоомсорлох;
- ёс суртахууны шаардлагыг сахин биелүүлэхгүй байгаа зэрэгт анхаарлаа хандуулжээ.

Харин хэвлэлийн үнэлэлт, дүгнэлт шударга байна уу гэдэг бол өөр асуудал юм. “Аль ч тохиолдолд төрийн албан хаагчдын 60% нь хэвлэлд хүндэтгэлтэй хандан, мэдээлэлд итгэж, албан хаагчийн дүр төрхийг сонин хэвлэлийн тусламжтайгаар мэдэж болно, бодит байдалд ойрхон очдог хэмээдэг. Зөвхөн 4% нь энэ дүр төрх нь үйл ажиллагааны бодит байдалтай огт тохирдоггүй”²⁷² гэж үзсэн байна.

Төрийн албан хаагчийн имижийг бүрэлдүүлж байгаа олон нийтийн мэдээллийн хэрэгслийг дараах гурван бүлэгт хуваан үзэж болох юм. Үүнд:

1. Төрийн албан хаагчийн эерэг имиж бий болгодог бүлэг. Үүнд голчлон засгийн эрхийг барьж буй улс төрийн намын харъяалалтай гишүүдийн хувийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон төрийн өмчид хэвлэл мэдээллийн хэрэгсэл. Тэдгээрийн мэдээллийнх нь 60% орчим хувь улс төр, эдийн засгийн шинэчлэлийг явуулах үйл хэрэгт гүйцэтгэх засаглалын хийсэн бүтээлч зүйлсийг бодитой гаргах, мэдээллийн эх үүсвэрийн бүрэн сантай байдагаараа бусдаасаа давуу мөн хурдан шуурхай зэрэг онцлог шинж чанартай.
2. Төрийн албан хаагчийн сөрөг имижийг уншигчдад зонхилон мэдээлдэг сонинуудыг авч үзвэл ихэвчлэн шар сонин болон сөрөг хүчнийг дэмчигч хэвлэл мэдээллийн хэрэгслүүд юм. Эдгээрт гол төлөв шүүмжлэлийн шинжтэй материалууд гардаг агаад заримдаа ч сэтгүүл зүйн хэм хэмжээ болон нийтийн ёс зүйг зөрчдөг ажээ. Хэрүүл, шуугиан тарьсан мэдээлэл нь төрийн томоохон түшмэдийн нэр хүндийг унагах хэрэгсэл болдог бөгөөд эерэг зүйлээсээ ч илүү хүчтэй үйлчилдэг байна.
3. Төрийн албан хаагчийн төвийг сахисан имиж бий болгодог бүлэг. Эдгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь тэдний дүр төрх буюу имижийг нь нэгэн хэвийн байдлаар, нэг их сэтгэл татахуйц бишээр илэрхийлдэг байна.

Энэ бүхнээс эцэст нь дүгнэн үзвэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр төрийн албан хаагчийн эерэг болон сөрөг имижийг бүрдүүлэн, төлөвшүүлэх үйл явц тэдний өөрсдөөс нь голлон шалтгаалдаг гэж хэлж болно.

²⁷² “Средства массовой информации и образ гражданских служащих”. Социологические исследования. Красный: И.Д.Лаптев, Т.С.Иларионова. М., 1998. С. 78.

Манай улсын хувьд төрийн албан хаагчийн имиж бүрдүүлэлтийн үндсэн хэсэг болох тэдний ажил мэргэжлийн үйл ажиллагаа, өдөр тутмын амьдралын хэв маяг зэрэг нь улс төрчид болон дарга, удирдлага нарынх нь имижд үргэлж дарагдан улмаар олон нийтэд танигдахаар ил гарч чаддаггүй байна. Өөрөөр хэлбэл, энэ нь төрийн байгууллагын жирийн нэгэн албан хаагчийн тухай материал олон нийтэд төдийлөн сонирхолтой бус төдийгүй тэд өөрсдөө зарим тохиолдолд эерэгээр бичүүлэхээсээ санаа зовдогтой холбоотой байж болох юм. Харин тэдний нэр хүнд, имижийг дарга нар нь шууд тогтоодог үзэгдэл манай улсад цөөнгүй. Үүний уршгаар ажил үүргээ гүйцэтгэж явсан төрийн албан хаагч гэмгүй байж гэмтэн болж хувирах нь бий. Үүнээс гадна өөрсдөө хэвлэлтэй харилцах урлагийг төдийлөн эзэмшээгүй болохоор сонины өгүүлэл буюу телевизийн сурвалжлагийн баатар болохыг төдийлөн хүсдэггүйтэй бас холбоотой.

Харин төрийн албан хаагчийн хувьд албан тушаал ахих, имижээ өсгөн нэмэгдүүлэх нь зайлшгүй чухал юм. Иймд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг олон нийтэд ойлгуулах, тэдгээрийг сахин биелүүлэх, нөгөө талаас хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь тэдний талаарх эерэг имижийг олон нийтэд хүргэхэд ухамсартайгаар нөлөөлөн оролцох нь чухал байна.

НОМ ЗҮЙ

1. Батцэрэн У. “Улс төрийн имиж бүрдүүлэлт ба манипуляци”. УБ., 2006.
2. Вандангомбо Р. “Төрийн албаны ёс зүй”. УБ., 2007.
3. Довчин Ё. “Улс төрийн үг хэллэг нэр томъёоны толь”. УБ., 2005.
4. Дэмбэрэл Д. “Ёс зүйт төр”. УБ., 2011.
5. “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”. II боть. МУ-ын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн. Ред: Болд Л. нар, УБ., 2008.
6. “Средства массовой информации и образ гражданских служащих”. Социологические исследования. Красный: И.Д.Лаптев, Т.С.Иларионова. М., 1998.

Цахим хуудас

1. <https://prezi.com/>
2. <http://ulstur-tech.blogspot.com/>
3. <http://www.csc.gov.mn/>
4. <http://www.legalinfo.mn/>

“ПОЛИТОЛОГИ” МЭРГЭЖЛИЙН СЭТГҮҮЛД ХЭВЛЭГДЭХ ӨГҮҮЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг. Агуулгын шаардлага:

1. Өгүүлэл нь өмнө нь хэвлэгдэж байгаагүй, сүүлийн үеийн судалгааны ажлын бодит үр дүнг тусгасан эрдэм шинжилгээний бүтээл байна.
2. Авч үзэж буй сэдвийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх зохистой шийдлийг санал болгож, шинэлэг дүгнэлт, санаа дэвшүүлсэн судалгаа, танин мэдэхүйн ач холбогдолтой байна.
3. Гадаад дотоодын нэр хүнд бүхий эрдэмтэн судлаачдын ном бүтээлээс өргөн ашиглаж, харьцуулан шинжилж, ишлэл авсан байна.
4. Ашигласан ном, зохиол, бүтээл, эх сурвалжын жагсаалт гаргасан байна.
5. Сэтгүүлд хэвлэгдэх өгүүлэл шаардлага хангасан эсэх талаар сэтгүүлийн зөвлөлийн гишүүн уншиж, танилцаж, дүгнэлт гаргана. Дүгнэлтийг үндэслэн зөвлөлийн гишүүдийн саналаар тухайн өгүүллийг сэтгүүлд хэвлэнэ.
6. Шаардлага хангаагүй гэж үзсэн тохиолдолд өгүүллийг редакцийн дүгнэлтийн хамт зохиогчид буцаана.
7. Жич: Агуулга, хэлбэрийн шаардлагыг заавал хангасан байх шаардлагатай.

Хоёр. Хэлбэрийн шаардлага:

1. Өгүүлийн бүтэц:

Өгүүлэл нь дараахь ерөнхий бүтэцтэй байна.

а/ Зохиогч /зохиогчид/, Зохиогчийн албан тушаал, Гарчиг

- Түлхүүр үгс
- Товч тайлбар
- Үндсэн хэсэг
- Дүгнэлт
- Хураангуй /Гадаад хэлээр/

Формат:

- Зохиогчийн нэрийг шинэ мөрнөөс эхлэн баруун зах руу шахаж, налуу үсгээр бичнэ. Олон зохиогчтой бол зохиогч нэг бүрийн ард дугаар /1/ тавина. Зохиогчийн нэрийн доор, шинэ мөрнөөс дугаараа /1/ тавьж араас нь зохиогч болгоны зөвхөн байгууллагын нэрийг мөр тус бүрд бичнэ. Үсгийн хэмжээ 10pt байна.
- Гарчиг нь зохиогчийн нэрнээс доош 2 мөрний зайтайгаар өгүүллийн бичвэрийн төвд /Center/ байрлуулж, үсгийн хэмжээг 12pt, том үсгээр, тод хараар /Bold/ бичнэ.
- Товч агуулга нь өгүүллийн гол утгыг 200 үгнээс илүүгүй үгэнд багтаасан байх ба үндсэн хэсгээс ялгарах байдлаар, налуу үсгээр, 12pt хэмжээгээр бичигдсэн байна.
- Өгүүлэл нь Microsoft Word 97 болон сүүлийн хувилбар дээр бичгийн цаасны /A4/ босоо форматтай, үсгийн фонд нь Times New Roman, үсгийн хэмжээ 12pt, мөр хоорондын зай нь хэвийн /Single/, нэг баганад, бичвэрийн 2 тал нь тэгш /Justify/ байхаар бичигдсэн байна.

Хэл: Сэтгүүлд хэвлэгдэх өгүүлэл нь монгол, англи хэл дээр байж болно. Өгүүллийн товч агуулгыг 200-аас илүүгүй үгэнд багтаана. Үндсэн бичвэр нь монгол хэл дээр бол хураангуйг англи хэл дээр, харин үндсэн бичвэр англи хэл дээр бол хураангуйг монгол хэл дээр бичнэ.

- Өгүүллийн нийт хэмжээ 8-иас доошгүй хуудас байна.
- Өгүүлэлд багтсан зураг, график, схем, диаграмм зэрэг үзүүлбэр тус бүр нь уншигчдад ойлгомжтой байхаас гадна нэр, тайлбар, дугаар нь тодорхой байна.

(Footnotes)

1. Сайрус Бенсон, Викториа Орловски, Олон улсын хөрөнгө оруулалтын гэрэний арбитр, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, 2015 он
2. Гадаад харилцааны яам
3. <http://www.mta.mn/document/list?&type=6&page=2>
4. <http://www.nso.mn/content/235#.VIVmu3YrLIU>
5. <http://www.ubbirj.ub.gov.mn/images/doc/ndsss.pdf>